В. ЯН

ЧИНГИС ХААН

1950

В. ЯН

ЧИНГИС ХААН

“БНМАУ-ЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН” Улаанбаатар хотноо 1950 онд эрхлэн хэвлүүлсэн номыг

Цогт охин тэнгэр сангийн захиалгаар **Цагаан бамбарууш хэвлэлийн газарт** 2021 онд цахим хэлбэрт хөрвүүлэв.

ЦАХИМ НОМЫН САН: **www.e-nom.mn**

Уг номыг “Болор дуран” шалгууруар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу орно уу.



УНШИГЧИЙН АМРЫГ ЭРЬЕ

«Шонхор жигүүргүй болбол, огторгуйд чадалгүй, хүн морьгүй болбол, газарт хүчгүй» гэжээ.

Тохиолдорхог явдал бүхэн, цөм өөртөө шалтгаантай, олсонд эх үзүүр бий бол, сүүл бас байдаг. Зөв замыг барьсан тэнүүлч, орчлонгийн уудам цэлгэрийг туулан, зорьсондоо хүрч, цалгардан осолдвол үхлийн марзад тулгардаг гэдэг.

Хүн, цэцэглэж байгаа суурин тосгоныг эвдэн сүйтгэгч, галт уулын дэлбэрэх, мөн хүчирхэг эзнийг эсэргүүцэж, дарлагдсан ардын хөдлөн босох, тэрчлэн эх нутагтаа үзэгдээгүй харь хэрцгий улсын цөмрөн орж ирэх элдэв тохиол учралыг үзсэн байтал, түүнээ эрхбиш бичигт тэмдэглэн, хойч үедээ хоцроох ёстой. Хулсан үзгийн үзүүрээр туужийн үгийг хэлхэн найруулах эрдэм сураагүй бол хашир бичээчид дуртгалаа сайтар хэлж, бөх цаасанд тэмдэглүүлж, үеийн үед хоцроох хэрэгтэй.

Сэтгэл дэнсэлгэн хөдөлгөм явдлыг амсан үзээд, дув дуугай суудаг бол, үхлийн хүйтэн гар, толгойг нь шүргэж байтал, эрдэнэсээ нөмрөгтөө ороогоод, цөл газар булагч харам хявцаг хүнтэй үлгэр нэгэн бий.

Гэвч, би, хулсан үзгээ хурцалж, бэхэд дүрснээ: Ард амьтныг хайрлах сэтгэлгүй алан хядсан Чингис хаан, түүний догшин цэргийн тухай үнэн зөвөөр өгүүлэхэд үг чадал минь ер хүрдэг болов уу? гэж эргэлзэн бодлоо.

Цэргийн нь манлайд, шар сахалтай эзэн нь удирдан довтолж, догшин цэрэг нь, замдаа түмэн хүнийг цавчлан алж, хүүрийг хоцроон цуцаршгүй мориороо Маверанагр, Хоресмийн[1] энх тайван голоор довтолж, умард цөл талын тэр зэрлэгүүдийн довтлох нь үнэхээр аймшигтай байж билээ. Тэр үед агшин зуур аюул эмээл гарч, амьтан хүн «шатаж байгаа суурины утаанд бүрхэгдсэн тэнгэрийн хаяа дахин гийн цэлмэх болов уу? Ингээд л ертөнцийн эцэс болох нь уу?» гэж бие биеэс асууцгаадаг байж билээ.

Намайг Чингис хааны тухай сонссоноо, мөн монголчуудын довтолсон тухай сонссон, дуулснаа бичиж үзнэ үү? гэж олон хүн ятгадаг байсан. Удтал цааргалан түдгэлзсээр, одоо бодоход, миний удтал дув дуугай суудаг минь, өчүүхэн ч ашиггүй тул тийнхүү газар

дэлхий дээр, өдөр ч гэсэн, шөнө ч гэсэн, ер үзээгүй их аюул, хүн төрөлхтөн дээр, нэн ялангуяа, гамшиг зовлонд нэрвэгдсэн Хоресм чиний хөдөлмөрчин ард олныг дайран өнгөрснийг тодорхойлон бичихээр санаа шулуудлаа.

Хэтийн юмыг хэтэрхий хол өгүүлэхгүйн учир, үгээ үүгээр тасалбар болгосугай. Өвгөд настан, миний өгүүлсэн үүнийг үнэн гэж гэрчилж өгөх байх. Шаргуу тэвчээртэй хүн бол, үүсгэсэн хэргийнхээ сайн төгсгөлийг үзэж, эрдэм эрсэн хүн, сураглан зорьсноо олдог гэлээ[2].

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ : ДЕРВИШ НӨМРӨГТЭЙ ХҮН

АЛТАН ШОНХОР

Манай газар дэлхий, гандаж онгосон хуучин нөмрөг дэлгэн тавьсан юм шиг, эргэн тойрноос энгүй далайн усаар хүрээлүүлсэн нэгэн арал ажээ.
(Арабын хуучин сурах бичгээс)

Өгүүлэх нь, хучигдсан цасан шуурга, хавар эрт Хар-Хумын их талын чимээгүй элсэн манхан дээгүүр шуураад, элснээс цухуйсан армаг тармаг тахир мухир бутыг тас сэрвэлзүүлж, цагаан цасан лавсан, газар дээгүүр эргэлдэн, бөмбөгөр оройтой шавар гэрийн дэргэд арван хэдэн тэмээ, эмх замхгүй овооролдон хэвтэцгээж байв. Тэмээний хүн хаачсан бэ? Аянчин, юунд хүнд ачаагаа буулгаж хураасангүй вэ? гэмээр үзэгджээ.

Тэмээг цасанд хучигдсан сэгсгэр толгойгоо өргөцгөөж буйлцгаахад энэлэлтэй дуу нь шуугин салхилах салхины дуутай хөг нийлэн, сонстол, алсад хонхны жингэнэх чимээ гарч, тэмээ тэр зүг толгойгоо эргүүлэн харцгаав. Удалгүй, нэгэн хар илжиг гарч ирээд, хойноос нь биедээ урт нөмрөг, түрүүндээ Мекке балгадад очсон бадарчийн цагаан ороодостой, дервиш хүний өмсдөг өндөр шовгор халбан малгай өмссөн, сахалтай хүн илжигнийхээ сүүлээс барьж алхсаар гарч ирээд Яваад бай, яваад бай! Дахиад нэг арваад алхвал, атга сүрэл чинь олдох вий. Сайн нөхөр Бехир минь, бид хүнтэй тохиолдлоо шүү! Тэмээ байсан газар, эзэн нь амарч, зарц нь түүдэг галаа асаасан байх ёстой. Түүдэг галын дэргэд арван хүн цугласан байвал, арван нэгдүгээр надад атга цагаан будаа тутарга агшаасан нь олдолгүй дээ гээд, өндөр дуугаар хүүе, хүн байна уу? үнэн шашинтнууд минь, дугараарай гэж бархиртал, хариу дуу гарсангүй, гагцхүү түрүүлж явдаг тэмээний хүзүүн дэх хагархай хонх, хан хийх чимээ сонстов.

Тэгэхэд нь цасанд хучигдсан, аяны тэр хүн, илжгээ туусаар намхан шавар хашаатай гэрийг алгууруур тойрч үзээд, урлан сийлсэн угалзтай хаалгыг гадсаар түшсэн шавар гэрийн ард, хар цагаан чулуугаар хичээнгүйлэн чимсэн булш бумба, анир чимээгүй жигдрэн үзэгдэхэд нь,

— Багдадын Дервиш, Хажи Рахим миний бие, энэхүү чимээгүй хөндий дэх үүрд нойрссон эрхмүүдийн амгаланг айлтгая гээд, өнөөх аяны хүн, илжгээ зэгсэн саравчны дор уяад, бас өгүүлрүүн: Энэ дуугүй хуран чуулагсдын сахиул манаа нь хаана байгаа бол оо? Гэртээ сууж байгаа юм болов уу? гээд эрээн хүүдий дотор талх үйрүүлээд, илжигний толгойд хүүдийгээ зүүж, өгүүлрүүн:

— За нөхөр минь, би чамд хоолныхоо сүүлчийн үлдэгдлийг өгье. Чамд хоол тун чухал. Бид өнөөдөр хөлдөж үхэхгүй бол, чи маргааш намайг цааш нь чирнэ шүү дээ. Би ч, Арабын дал модны дор чи бид хоёр их л халууцаж байснаа дурдан санаж дулаацаж үзье дээ гээд, гэрийн үүд тулсан гадсыг авч хаяад, хаалгыг нээвэл, голомтод нь чандруутай нүүрс үзэгдэж, өрхөөр тусах гэрэлд үзвэл, ханын ёроолд дөрвөн хүн, явган сууж байх шиг үзэгдсэнд,

— Даяар амгалан гэж ёсолтол, огт хариу өчихгүй тул, дөтөлж үзээд тэр хэдэн хүний хөдлөхгүй дуугай сууж, зүс царай нь зэвхий болсон байдлыг үзээд, яаран сандран үүд тийш ухарч, гадагш гараад ийн сэтгэрүүн,

— Хажи Рахим надад гуньж гомдох юм алга аа. Энэ дөрвөн үхсэн хүн, даавуугаар ороон оршуулах хүнийг хүлээж байгаа юм байна шүү. Би хэдий хоосон нойтон боловч, орчлонгийн хязгааргүй замаар тэнүүчлэх чадалтай байна. Дэргэд минь өчнөөн төчнөөн ачаатай тэмээ, эзнээ алдаад байж байна. Баялаг ачаатай энэ олон тэмээний эзэн болъё гэвэл алга урвуулах мэт хялбар. Гэвч, үнэнийг эрж яваа Дервиш надад өчүүхэн ч эд хэрэггүй, харин амандаа араб дууг дуулж, хоосон үгээгүй чигээрээ замаа хөөсөн нь шулуун. Юу ч болсон, хөөрхий тэмээг асрах хэрэгтэй гэж бодоод, тэмээг эргэн тойрон үзэж, татлага дээсийг суллаад, зэрэгцүүлж сөхөргөн хэвтүүлээд, ачаан дундаас арвайтай шуудай олж, тэмээ бүрд хэдэн атга цацаж,

— Хэрэв, хүн, Хажи Рахим, энэ нэг насандаа буян үйлдсэн үү? гэж асуувал «хүйтэн шуурганд энэ Дервиш, биднийг тэжээж, осгож үхэх аюулаас аварсан гэж энэ хэдэн тэмээ нэгэн дуугаар буйлах сан байх даа» гэж тэмээг тэжээгээд, бэлхэн зэгсэн дээр хэвтээд хөлөө нугалж, аяархан үүргэлж байгаа илжгэндээ нуруугаа шахаж, шөнийг өнгөрүүлээд өглөө салхи, үүлсийг хөөн зайлуулж, дорно зүг наран мандахад бумбын дээгүүр нарны туяа гялс хийхийг үзмэгц, Дервиш даруй босож илжгэндээ,

— За, Бехир минь, одоо замаа хөөе дөө гээд, өчигдрийн үлдсэн арвайтай шуудайг ачаад, өнөөх гэрт шагайвал, ханын дэргэд сууж байсан дөрвөн хүний нэг нь л байж байв.

Тэр хүний хар нүд нь бүдэг болж, цавчилгүй ширтэн харж байхыг үзээд,

— Бусад үхсэн хүн хаашаа алга болсон бэ? Булш бумбад орж хэвтэв үү?

Үгүй, Хажи Рахим миний бие, энд үлдэхгүй. Мэргэдийн бал, сүй мэт сайн үг ундардаг, жаргалтай хүмүүс олон байдаг Хоресм хот орно гэж дугартал нь,

— Үнэн шашинт та, намайг тусал гэж өнөөх сууж байсан хүн сөөнгө дуугаар дуугарч намирсан сахал нь хөдлөв.

— Чи хэн бэ? гэж асуутал, тэр хүн,

— Би Махмуд гэдэг хүн...

— Чи Хоресмийн хүн үү? гэтэл,

— Надад алтан шонхор бий... гэж дуугарахад нь, Дервиш их л гайхжээ.

— Ээ, үнэн шашинт хүн үхэх гэж байтал, бас алтан шонхроо бодож үхдэг юм байх нь ээ!

Уснаас балга гэж гайхан, тэрхүү өвчтэй хүнд ташмагтай ус өгтөл, тэр хүн, арай гэж хэдэн балга ус уугаад, мэлмийрсэн нүдээр Дервишийг ширтэж өгүүлрүүн:

— Хар Хончирын[3] дээрэмчин намайг хүндэд шархдуулаад... гурван нөхөр минь гашуунаар үхэх цагаа хүлээж, бид хаалгаа гаднаас тулуулаад, зайлж гарч чадсангүй билээ. Хөлгөн сударт үнэн шашинтан хүн, үнэн шашинт нэгийгээ зовлонд учраад байхад, мэдсээр хаяад явбал, амь тасалснаас дор гэдэг... гэж хэлээд, шүд нь хавжигнаж, Дервишийн зүг гараа гуйн сунгатал, чадал тэнхээ нь доройтож, гар нь доошоо уналаа.

— Ээ тэгж битгий зов. Тэнэмэл Дервиш би, чамд тусална гээд, тэр хүний ноосон дээлийг тайлж үзвэл, хэнхдэгт нь шарх харлаж, цус шүүрч байгааг үзээд,

— Тогтоож үзэх юм сан. Юугаар боох билээ гэж, тэр хүний дэргэд эвтэйхэн гэгчээр ороосон том цагаан чалма[4] малгай байсныг үзээд авч задлахад нь чалмын нимгэн шаа дотроос, нэгэн дөрвөлжин, алтан пайз унасныг, авч үзвэл жигүүрээ дэлгэсэн шонхрыг их л урнаар

тавьж, жигтэйхэн үсэг сийлсэн нь жимээр цуван гүйж яваа шоргоолж шиг хачин үсэг байв.

Дервиш, түүнийг үзээд, бодлого болж, өнөөх өвчтөнийг анхаарсхийн харж,

— Хойч өдөр их хэрэг мандахын шинж бүрдсэн хүн байна даа, энэ амьтан. Үхсэн хүний амьдардаг нууц учир үүнд байна. Энэ пайз, Татаарын их хааны пайз мөн байна. Хадгалууштай алтан шонхор байна даа. Хожим энэ хүний ухаан тэнхээ орсон цагт эргүүлж өгье гэж шивнээд, пайзыг өргөн бүснийхээ хуниасанд далдлан нуугаад, шархтай хэнхдэгийн шархыг чалма малгайн нарийн шаагаар боох гэж нэлээд ноцолдоод, гадагш гарч нэг тэмээг босгож авчраад, шавар гэрийн үүдэнд сөгтгөн хэвтүүлж, тэр шархтай хүнийг дээсээр даруулан унуулж, манхан дээгүүр наран гарахад, хайлж байгаа цасан дээгүүр арай гэж үзэгдэж байгаа, талын зөрөг замаар алхалж, хойноос нь илжиг сайварлан алхалж, илжигний хойноос өндөр тэмээ тэгшхэн алхалж, тэмээний дээр дээсээр даруулсан өнөөх хүн ганхан, Дервиш илжгэндээ,

— За, Бехир минь, яваад бай! Мөдхөн Гурганж хотод хүрнэ. Тэнд чамайг нэг тэвэр хатаасан царгас өвс хүлээж байгаа вий. Энэ газар аюултай газар шүү. Манхан толгодын цаана Хар хончир дээрэмчин гарч ирээд, муу эзнийг чинь боол болгож, чиний хар арьсыг тас өвччихнө шүү. Эндээс бушуухан зайлж үзье! гэж илжгэндээ үглэж явлаа.

НҮҮДЭЛЧНИЙ ГЭРТ

Хоресм шагийн[5] сууриныг залгамжлах хөвүүн, хунтайж[6] Желал-Эд-Дин-Менг-Бурны, Хар-Хумын элсэн дундуур авлаж, хоёр зуун гавшгай сайн эр, шилдэг морио унацгааж, залуу хааны бараа болж, дотууpаа Желал-Эд-Динийг Хоресмаас зайлан оргуужин гэж, Шагийн нууц тушаалаар дагаж явсан юм байжээ.

Тэр эрчүүл, нуман жагсаалаар хол явж, зээрийг хэсэг толгодын дэргэд байгаа цагаан оройтой хар майханд хашин, олон зочдод хурим бэлтгэж байгаа газар тийш хөөн дөхүүлэх гэж аваачихыг оролдож явсан байжээ. Хавар болж, элсэнд энд тэнд ганц нэг цэцэг гарчээ. Гялбам хурц наранд цасан хунгараас үлдсэн нь доороо урсан хайлж байв. Авын гуравдугаар өдөр, тэнгэр бүрхэж, умар зүг, хивчаг[7] талын

зүгээс хүйтэн салхи салхилж, цасан шуурга тавьсан билээ. Желал-Эд-Дин, агсам хар аргамгаараа, шархадсан ооно нэхсээр, бараа бологчдоос холдоод, оонын чихээ сэртийлгэн эргэн эргэн харсаар доголж явахыг хараад дөхтөл, ооно, матгар эврээ сэгсрэн, уудам талын зүг дахин жирийлгэн яваад өгчээ. Уур нь хүрсэн үшүүн хаан, өмнө нь сүүдгэнэж яваа оонын хар сүүлээс нь нүд шилжүүлэлгүй хөөж, хөөс бурзайсан хүлгээ давхиулан намнасаар, харван алж ганзагалав. Тэр завсар, шуурга ширүүдэж, зөрөг зам, цасанд мэдэгдэхгүй болоод, Желал-Эд-Дин төөрснөө сая мэдээд, шуурга хэд хоног шуурвал, үхэх аюул тохиолдов гэж мэдээд, морио хөтөлж, салхи өөд алхсаар шөнө болгожээ. Тэнхээ тамир барагдаж, тохмоо дэлгээд мориндоо нэмнээ хийгээд, цасанд даруулан шөнө туж суусаар, үүр цайлгасан нь наран мандаж, салхи тогтоод, цас хайлж манхан дундуур шар ус урсаж эхлэв.

Желал-Эд-Дин, алсын барааг харж, модны гишүү, ясаар босгосон манааны овоо, далай мэт өргөн талын дунд зам зааж байгааг үзээд, тэр лүү зүглэж, ойртон очвол, наанги шороот голоор элсэн довцгийн дундуур, дөрвөн хар гэр үзэгджээ.

Нохойн боргон хуцах дуугаар гэрээс нэгэн өвгөн туркмен гарч, мөрөндөө нөмөрсөн ямаан дээлээ барьж, нохойгоо хорин, Желал-Эд-Диний дэргэд эрхэм ихэмсэг байдалтайгаар хүрч ирээд, зочныг тосох байдлаар цулбуурт хүрч өгүүлрүүн:

— Эрхэм беги, миний гэрийг ядуу гэж голохгүй бол морилон орно уу? гээд ирсэн зочны гоёмсог дээл, зузаан, улбар торгон өмд, ялангуяа Султаан хаан хүний унадаг сүрхий сайхан хар азаргыг их л бахархан гайхаж хартал.

— Салам гэж ёслоод, танайд арвай бий юү? Би давхар үнэ өгнө гэтэл, тэр өвгөн,

— Элчилгүй цөл газар тариа будаа, мөнгөнөөс үнэтэй байдаг гэвч ховор зочинд хүссэн бүгдийг нийлүүлье. Чиний моринд арвайн оронд сайн буудайгаар тэжээнэ... гээд, гэрийн зүг хандаж хүүе та нар, морь аваарай гэж, буудай татах гар тээрмийн чимээ гарч байсан гэрийн зүг хандаж хашхирмагц, өсгийдөө хүрсэн урт хүрэн улаан цамцтай, цээжиндээ зүүсэн мөнгөн чимэг зоосыг хангир жингэр дугаргасан хоёр хүүхэн гүйж гараад, толгойдоо ороосон сиймхий бүсээр нүүрээ халхалж, зочны морийг хөтөлж аваачив.

Хааныг гэрт ороход, давирхайтай үндсээр задгай гал түлж, гаднаас ороход их л дулаан байв. Ханын ёроолд нэгэн хүн гэдрэгээ

харж хэвтээд, хар сахалтай бор царай нь цусгүй зэвхий болж, гараа элгэн дээрээ тавьсныг үзвэл, удалгүй үхэх шинж орсон хүн ажээ. Амьсгал тасалдаж байгааг үзвэл, хүчгүй болсон биеийн гол нь тасрах тун ч дургүй шинжтэй.

Тэр өвчтэй хүний хөлийн дэргэд хажийн[8] тэмдэг цагаан ороодостой өндөр малгай өмссөн, сахалтай Дервиш сууж нүцгэн шахам биедээ эрээн мяраан нөхөөстэй өргөн нөмрөг нөмөрчээ.

— Салам алейкум! гэж амар мэндийг мэдээд, өвчтөний дэргэдэх эсгий дээр Желал-Эд-Динийг очиж суутал, нүдэндээ тултал нүүрээ бүтээсэн шивэгчин мөлхөж ирээд, хааны нойтон ногоон гутлыг тайлж автал, Желал-Эд-Дин махир сэлэмтэй суран бүсээ тайлж, дэргэдээ тавьж, Дервишээс,

— Чи хэн бэ? Хувцсыг чинь үзвэл, холын газраас явж яваа хүн юм уу даа гэтэл,

— Би орчлон ертөнцөөр бядан хэсэгч, худлын далай дунд үнэний арлыг олох гэж яваа хүн...

— Хэт нутаг хаана, хэт зориг хаашаа гэхэд,

— Миний нэр Хажи Рахим гэдэг. Бас Багдадад ном үзэж байсан учир, Багдадач гэж дууддаг. Миний багш нар, их номтой, юм мэддэг, тэгш эрдэмтэй хүмүүс байсан юм аа. Би олон ухааны аймгийг судалж, эртний пехлевийн үгээр бичсэн судар, араб, турк, персийн домог түүх олныг үзсэн нэртэй боловч, залуу явсан наснаас минь гэмшин гутрах, хилэнц хураахаас өөр ор мөр үзэгдэхгүй болжээ.

Гэтэл, Желал-Эд-Дин баахан үл итгэн, өрөөсөн хөмсгөө дээш болгож,

— Чи одоо хааш ямар хэргээр явж байгаа билээ? гэв.

Цаадах нь,

— Таван далайн хоорондох газрын хавтгай тосгуур дээгүүр зоригоороо явж, цөл, шанд, хот балгасыг хэсэн явж, жигтэй юмыг үзэж, үнэн баатар эр, шударга журамтны өмнө сөгдөн мөргөх хүсэлтэй.

Одоо би Гурганж хот орох санаатай. Сонсвол, Хоресм болоод, дэлхий дахины үзэсгэлэн баялгийн манлай болсон тэр хотод эрдмээр гийгүүлсэн мэргэд, уран их чадлаараа чимэглэгч, гайхамшигт урчууд байдаг юм гэнэ билээ гэхэд нь:

— Чи байлдааны газар сэлмийн үзүүрээр гавьяагаа тэмдэглэгч баатрыг эрж яваа юм уу? гэж баахан бодлого болж хэлээд:. Охид, хөвүүд хүсэн дуулмаар, баатар сайн эрчүүд байлдаанд орохдоо, өтгөс

хөгшид үхлийн зүг, эцсийнхээ алхмыг алхахдаа уншиж явмаар, тийм сайхан үгээр баатар эрийн гавьяаг магтан найруулж чи чадах юм уу? гэж асуутал, өөдөөс нь хариу шүлэглэсэн нь:

Эгшиг сайхан дуугаар, Эрхэм Рудеги баян боловч

Эгээ ч түүнээс би үгээр дутахгүй,

Нүдгүй тэр, шүлгээр дэлхийг дагуулсан бол, Нүүдэлчний галын өмнө би дуулдааг.

Гэтэл, гэрийн эзэн, хааны алсан ооныг оруулж ирснийг үзвэл, хэдийний арьсыг өвчиж, гэдэс дотрыг салгажээ. Тэгээд,

— Үүнээс хэсэг мах авч, чамд хоол хийлгэхээр өгвөл яана гэж асуутал,

— Цөмийг авч, бүгдээрээ идэцгээ. Би олзыг эзэндээ өгөх ёстой. Беги ноёны гөрөөчин биш, Бегийн хүү, өөрөө беги хүн шүү гээд, хуйнаас нарийн чинжаал хутга сугалж, оонын ууцнаас хэд нимгэн огтолж аваад, модны мөчирт шорлож, галын цог дээр шарав.

Гэрийн эзнийг оонын махыг эмст өгөөд, зочидтой зэрэгцэн сууж, сахлаа илэн, амар мэндээ мэдэлцэж,

— Мэнд сайн явж байна уу? Тэнхэл тамир сайн уу? Дулаацав уу? Эцэг эхийн бие мэнд сайн уу? гэж асуухад нь хаан, ёсыг дагаж, мөн амар мэндийг асуугаад,

— Миний үгийг бүү буруушаагаарай. Энэ хэнийх гэдэг вэ? Чухам ямар гэгч газар вэ? гэвэл өвгөн туркмен өчрүүн,

— Манайх, Нес хот орох их худалдааны замаас өдөрчийн газар. Би бол, их талд гээгдсэн эгэл нүүдэлчин хүн, намайг олон, Коркуд хоньчин гэдэг гэтэл, гэрийн гадна хурхирч байсан нохой гэнэт хуцаж, бархирах ёолох уйлах чимээ сонстож, морины төвөргөөн ойртон ирж, чимээгүй болоод,

— Гэрт ямар хүн хэн байна? Дуугараач ээ, Коркуд-хоньчин гэж нэгэн хүн өндөр дуугаар дуугарав.

ХЭЭРИЙН САЙН ЭР

Өвгөн босож гадагш гараад, ярилцах чимээ бүдэг бадаг сонсогдсон нь морьтой хүн сөөнгө дуугаар шивнэн,

— Юунд энд ирсэн бэ? Үхэх цаг нь болсон бил үү? гэхэд өвгөн,

— Гурвуулаа миний зочид шүү гэж нөгөөдөх нь,

— Би тэдний цайвар магнайд Аллах тэнгэр ямар гэсгээлт онооснығ үзүүлье гэтэл,

— Чи тэдэнд битгий гар хүр. Энэ таван боолчуудыг хаанаас олов? гэхэд нь,

— Тунжаан зэвсэгчин, сайн урчуул, худалдаачны аян жингийн хамт явж байсан билээ. Намайг, тэр худалдаачны «сахлыг хяргах» гэтэл, нэг беги ноёнд зээр хөөж явсан хоёр зуугаад эрчүүл гай болж дайралдаад, би худалдаачны тэмээг хаяад, жинчин нь сарниж, алга болоод энэ таван урчуудыг тууж явна. Одоо Мерв хотод аваачиж, сайн үнээр худалдана даа гэхэд нь,

— Аллах тэнгэр чамд тусална даа гэж хэлээд, өвгөн, тэр ирсэн хүнтэй гэрт орж ирэв. Тэр үл таних хүний овор залуу, бие өндөр, мөр тэгш, бэлхүүс маш нарийн. Ташаанаасаа ногоон сарьсан хуйтай урт хончир юлд зүүжээ. Тэмээний илгээр хийсэн, нарийхан өндөр товхтой шар гутал, хонины арьсаар хийсэн, өндөр дүгрэг малгай, хар өнгөтэй, этгээд маягтай дээлийг үзвэл туркмен хүн ажээ. Бас, түүний өндөр шанаатай зоримог хүрэн царайг үзвэл, гарцаагүй, туркмен хүн ажээ.

— Галд ойртож суу даа гэж гэрийн эзний хэлэхэд, тэр зочин, хивс дээр суулгүй, үүдний дэргэд зогсоод нүдээ ууль шувууны нүд шиг дүгрэглээд харж байхад нь, Желал-Эд-Дин тэр зүг харалгүй,

— Чи хэн гэдэг вэ? гэж асуувал,

— Хээрийн хүн... гэж.

— Малаа бэлчээн нүүж явдаг хүн үү? Өөр ажил төрөл хийдэг хүн үү? гэхэд нь,

— Би аян замын худалдаачны сахлыг хяргадаг хүн гэж хариу хэлсэн нь, говь талынхны ёсонд их л эвгүй санагдам үг байжээ. Аян замд гал түүдгийн дэргэд, танихгүй хүн уулзахдаа, дээл хувцас муутай хүнтэй уулзавч, доор үзэхгүй, эрх тэгш учирч, харилцан амар мэнд, мал сүрэг, алсыг зорьсон хэрэг зоригоо асуулцан ярилцдаг ёстой байтал, ингэж байхыг үзвэл, лав хэрүүл өдсөн хүн байжээ.

Желал-Эд-Дин, өөдөөс нь хармагц, доошоо харж, гагцхүү өрөөсөн завж нь үл мэдэг чацав хийгээд, сурвалжит хаан хүн, элсэн талын нүүдэлчин харц хүнтэй маргаад юу хийх вэ? гэж суув. Тэр туркмен,

— Гэрийн эзэн чамайг Гурганж орох зам асууж байна гэсэн. Би чамд зам зааж өгөх үү гэж нэг хэсэг дуугай байснаа хэлэв.

Желал-Эд-Дин, эр зоригтой боловч, морь нь эцээд, тэр айлд зочдыг хүндлэх ёсны хамгаалалд, айлтгүй байгаагаа бодоод, замд, харин энэ туркментэй ханилан явбал, зээр хөөж явсантай адил, өөрөө харин энэ туркменд гөрөөлүүлэх болно гэж бодоод,

— Би одоо Гурганж орохгүй гэхэд нь,

— Манай энэ гаслант ертөнцөөс ангижран одох гэж ёолон байгаа энэ ямар хүн бэ? гэж асуухад нь, Дервиш,

— Дээрэмчинд шархлагдсан хүн. Бодвол, лав өнөөх айхтар Хар хончрын гарт дайралдсан юм байлгүй дээ. Сонсвол, цөл газрын тэр барс хэнийг ч энэрч хайрлах сэтгэлгүй гэдэг гэхэд нь,

— Чи Хар хончрыг, бас, хүнд дээрэмдүүлсэнгүй гэж боддог уу? гэж тэр туркмений асуухад,

— Хэрэн тэнэхийн салхинд хээр туугдаж явдаг хоосон самартай адил надад, ийм тийм гэж бодох юу байх вэ? гэж

— Хар хончир, хүн амьтан хүршгүй цайдамд орогнодог юм гэнэ билээ. Элсэнд шургадаг гүрвүүл шиг, хулсанд шургадаг могой шиг баригддаггүй хүн юм гэнэ билээ. Хүн түүний байгаа газар хүрч чаддаггүй, тэр өөрөө харин хаана ч тогтож тордоггүй хүн юм гэнэ билээ гэж хэлэлцэхэд,

— Дээрэм хийдэг хүн ч, сүүлдээ Гурганжийн хэрэмд толгойгоо шургуулж, өндөр гэгчээр мандана даа гэж Желал-Эд-Дин, шарж байгаа махаа эргүүлэн, тоохгүй байдлаар хэлэв. Тэгэхэд тэр туркмен,

— Хар хончир бол, хортныг гүйцэгч шөнийн сүүдэр, өшөө авагч чинжаал хутга, хилэнгийн жад, өр төлөөсний юлд юм аа. Одоо тэр, гав ганцаараа ах дүү, үр хүүхэдгүй хүн. Үхэх цаг нь ирэхэд, гэр өрх нь баларч, голомт нь хоосорно. Тэгвэл, сайн уу? гэхэд, Желал-Эд-Дин,

— Юуны чинь сайн байх вэ? гэж.

Тэгэхэд нь, тэр туркмен,

— Урьд Хар хончир, буурал аавтай, зоригтон ах дүү нартай, гуа сайхан охин дүү нартай байсан билээ.

Гэтэл, Мухамед Шаг, зуун морины хэрэг гарахад, хивчаг цэргээ дагуулан, манай нутгаар явж, зуун морины оронд гурван зуун шилдэг азарга барьж, нүүдэлчин, хивчагийн их зантай хааныг тонов гэж гэсгээн залхааж байгаа нэрийдлээр бас эмсийн мөнгөн чимгийг мултолж авдаг зантай байна. Ордондоо гурван зуун эмтэй атал, хивчаг нартайгаа ирж, манайхны хамгийн сайхан хүүхэн гэж байсан Гюль-Жамалыг булааж аваачсан билээ. Тэр хүүхний төлөө манайхны зуугаад

залуу эр тэмцэн булаалддаг байсныг одоо сонсвол, Шаг, хар хүчээр ордондоо хорьж, гурван зуун нэгдүгээр эхнэр минь гэдэг гэнэ. Энэ бас сайн уу?

— Бас л сайн юу байх вэ дээ? Гэвч, зуун залуу чийрэг эр хүн, хүүхнийхээ сайныг нутгаасаа алдаад, булааж зүрхэлдэггүй нь бүр ч тусгүй хэрэг гэж Желал-Эд-Диний талбиун уужуу байдалтай хэлэхэд,

— Тэр цагт манайхны идэрчүүд эзгүй байж билээ. Хивчаг зальтай улс, хүний эзгүй хойгуур уулга хийдэг зантай юм даа гэхэд нь,

— Залуу эр, чи миний үгийг сонс, чи буурал эцэгтэй, ах дүүтэй байсан билээ гэж, яагаад тэднээ алдсан билээ? гэхэд нь,

— Буурал аавыг минь Шагийн зандалчин баривчлан аваачиж, Гурганжийн талбар дээр өлмийгөөс нь эхлэн хэсэг хэсэг огтчиж алсан. Ах дүү нар минь баруун зүүн тийш зугтаан, охин дүү нарыг минь морьтон хивчаг барьж аваад, алга болсон. Тэр бас сайн уу? гэхэд нь,

— Бас юуны чинь сайн байх вэ? гэж Желал-Эд-Диний хэлэхэд,

— Би, нарт ертөнцөд одоо хаана багтаж шингэх вэ? Юу хийвэл зохих вэ? гэж тэр туркмений хэлэхэд, Желал-Эд-Дин тэсгэлгүй өгүүлрүүн:

— Аймаг угсаагаа хамгаалах гэж, гэрэлт сэлэм, чиний гарт гялалзаж, аянчин худалдаачны их зам дээр дүрсгүйтэхээс байгаад гавьяа байгуулж, манай ногоон тугийн тушиг тулгуур болно гэвэл, Гурганжид манайд очоорой. Би чамд гавьяа нэр байгуулах арга зааж өгье гэхэд нь,

— Залуу эр Беги сонс гэж ханцуйгаар уруулаа арчиж, намайг Гурганж орвол, Шагийн тагнуулчин, цөөвөр чоно шиг миний мөрөөр хөөж, би тэдэнд бууж өгөхгүй, алалдаж байгаад үхнэ шүү дээ. Тэгсний хэрэг бий юү? гэхэд, Желал-Эд-Дин өгүүлрүүн:

— Чингэхгүй. Чи Гурганж хотны баруун хаалганд хүрээд, өндөр улиангар мод ургасан цэцэрлэгт хүрч, хаалгачаас «Тилялийн шинэ ордон цэцэрлэг гэдэг энэ мөн үү? Намайг гэрийн эзэнд учруулна уу? гээрэй тэгээд энэ бичиг үзүүлээрэй гээд,

Чалмын нугалаас дотроос нэгэн хуудас цаас гаргаж, эрхий хуруундаа зүүсэн алтан бөгжийг авч, шатаж байгаа мөчрөөр бөгжний үсгийг тортогдоод, шүлсээр цаасны үзүүрийг норгож, бөгжөөр тийздэж, цаасан дээр сайхан гэгчийн эвхмэл үсэгтэй нэрээ дарж цаасыг хуйлан, дундуур нь нэг нугалаад, өвдөг дээрээ илж өгсөнд нь,

тэр туркмен тосож аваад, уруул дух хоёртоо хүргэж, бүсэнд зүүсэн зэс хэтэвчиндээ хийж,

— Беги сайн эрийн үгийг итгэж очъё. Салам! гээд, үүд өргөн гарч явлаа. Гэрийн эзэн, хойноос нь дуугай харж, гэрийн гадна талын өмнө том зэс тогоотой юм буцалж, хайлж байгаа цаснаас нойтон болсон газар, уранхай, навтархай хувцастай, эцэж ядарсан таван боол гар нь ардаа хүлээстэй, хүзүү нь дээсээр ороолгож, дээсний үзүүр нь хялгасан бугуйлаас оосорлоотой, тавуул сууж байв. Тэдний дэргэд хүзүүндээ мөнгөн чимэгтэй, хад мэт хантарсан өндөр зээрд морь зогсож, эмээлийн бүүргэнээс тэр тавыг хүлсэн дээсэн бугуйлын үзүүрийг ороожээ. Өнөө залуу туркмен, мориндоо мордоод,

— Буруу номтой адгуус, явцгаа! Явахгүй салганалдаад байвал, хярамцаг болтол цавчаад, сэгийг чинь замдаа хаяна шүү гэхэд, тэр таван боол босоцгоож гэлдрэв.

Тэр туркмен, ташууpаа далайж туусаар, довцгийн ард орж харагдахгүй болов. Гэрийн эзэн гэртээ орж,

— Эрхэм зочин, зуугаад морьтой хүний бараа, наашаа айсуй бололтой гэхэд нь,

— А, Хоресм Шагийн эрчүүд, намайг эрж яваа нь тэр ээ. Надтай ярьсан саяны хүн хэн гэдэг вэ? гэхэд нь,

— Тэр үү? гээд, гэрийн эзэн өнөөх туркменийг эргэж ирнэ гэсэн юм шиг айсан маягтай, сэмхнээр өгүүлрүүн: Тэр бол Хар Хумын барс, аян замын аюулт эр, алдарт дээрэмчин Хар хончир гэгч шүү. Аллах тэнгэр түүний хар цагааныг ялгаг гэлээ.

ШУДАРГААР ЯЛГАГЧ ХАКИМ

Хажи Рахим, тэр айлаас мордож, хоёр хоног цөл дундуур, нарийн зөрөг замаар, умар зүг Жейхун мөрний адагт хүн олонтой Хоресмийн хот суурин байдаг бүрдийг зорин, илжиг нь гэлдэрч, хойноос нь өнөөх өвчтөнийг мэдээ ороогүй хэвээр ачсан тэмээ нь нэгэн жигд алхлан явж, Дервиш, араб, перс дуу дуулж, Хоресмийн олон сүмийн өнгөт ваар орой хэдийд үзэгдэх бол гэж, байн байн алсын бараа харж явсаар, гурав дахь өдөр, элсэн дундуур цувсан зөрөг зам нь дардан их зам болж, чулуурхаг өндөр өөд өгсөөд, тэндээс цэцэрлэг, хэсэг хэсэг зуун мод, дөрвөлжин дөрвөлжин ногоон тариалангийн газартай сэргэлэн сайхан тал үзэгдэж, модны завсраар, энд тэндгүй хавтгай оройтой

бяцхан байшин, утаанд харласан бөөн бөөн хар гэр Баян хивчаг ислам хаадын өнцөгтөө цамхагтай, цайз боомт мэт орд үзэгднэм бөгөөд, хааяа нэг, исламын жад мэт хурц цамхаг цухуйн, дэргэд нь лалын сүмийн эрээн паалантай ваар орой нь гялалзан, ус дүүрсэн тариалангийн дөрвөлжин газар, том толь мэт гялбалан, уранхай нооронхой хувцастай, хөлдөө тушаатай хүн, тариалангийн ажил хийж явах нь үзэгдэв.

Дервиш, товцог дээр зогсоод, аман дотроо шивнэн өгүүлрүүн:

— Жаргалангийн орон болох хувьтай заяагдсан орон, одоо, гашуун зовлон, хар нулимсны хөндий болжээ. Арван таван жилийн өмнө би ялтан шиг эргэн эргэн харж, айн эмээн, эндээс зугтаан гүйж явсан билээ. Тэгэхэд, их имамын[9] хараал хүртээд явсан тэр залуу, одоо, наранд түлэгдэж, хав хар болсон энэ Дервиш болоод эгж ирэв гэж хэн таних билээ? Бехир минь алхаад байгаарай. Дэлхийн нийслэлийн манлай болсон Гурганж хотын хаалганд хүрч хоноё. Энэхүү хотод (лалын) эздийн хамгийн хүчирхэг болоод, хамгийн харгис муухай Хоресм шаг Мухамед, хаан төрийг барьж байдаг хот шүү дээ гэж илжгэндээ хэлээд, цаашаа явахад нь, зам дээр, урт эвэртэй үхэр хөллөсөн, хоёр дугуйтай тэрэгтэй хүн, явган хүн, сайхан чимэгтэй морь унасан гангачуул, туранхай илжиг унасан, наранд гандаж хав хар болсон хөдөөгийнхөн байн байн дайралдах болж, энд тэндгүй, үхэр мөөрөх, хонь майлах чимээ сонстон, мал туусан хүний бархирах, хашхирах дуу сонстов.

Нэг айлд дөнгөж хүрэхэд нь, урт цагаан мод барьсан хүн тойрч,

— Чи юун хүн бэ? Эд мөнгөгүй бадарчин Дервиш хүн юм бол, юунд тэмээ хөтөлж явдаг билээ. Хаким ноёнд очъё. Чамд үхэх ял унагана даа гэж тууж, өндөр шавар хэрэм дотор оруулжээ. Үзвэл, өндөр тавцан дээр дэвссэн өргөн хивс дээр эрээн хувцас өмссөн хатангир өвгөн завилан сууж, түүний цас мэт цагаан том чалма, малгай тас самнасан буурал сахал, нэвт шувт хармаар ширүүн харц, хөдлөх барихын нь алгуур удааныг харсан хүн бүхний айдас хүрмээр өвгөн ажээ. Тэдгээр хүмүүсийг Хакимын дэргэд сөгдөхөд, тэр өвгөний хажууд бөгтийн суусан, гартаа хулсан үзэг барьсан залуу бичээч, харьяат ноёны юу хэлэхийг хүлээсэн, Хаким ноён, тэр Дервишээс,

— Чи хэн гэгч вэ? гэж асуув.

Дервиш өгүүлрүүн,

— Би ачит эхийн хилэнцэт хүү, нэр Хажи-Рахим аль багдади гэдэг. Багдадын шейк багш нарын шавь билээ. Булш бумбын харанхуй жихүүн далд орсон үнэн явдалтны мөрийг урт замаар талаар эрж явна гэвэл, өвгөн, үнэмшилгүй, хөмсгөө өргөж, Дервишийг ширтэн харж өгүүлрүүн;

— Тэмээн дээрх энэ өвчтэй хүн хэн гэгч вэ? Юунд чалмагүй юм бэ? Үнэн шашинтан мусульман уу? Тэрс буруу номтон хүн үү? Сонсвол чи энэ хүнийг шархдуулж, хамаг хөрөнгийг нь тонож дээрэмдээд, худалдан борлуулсан гэж сонслоо. Тэр үнэн үү? гэхэд, Дервиш гараа тэнгэр өөд өргөж өгүүлрүүн:

— Хамгийг тольдогч тэнгэр чи, миний ганц хамгаалагч мөн. Энэ худал хуурмаг үгнээс өөр юм мэддэггүй тэр ховч хүнийг нь үнэхээр гайхаж байна. Миний алжаасан зовсныг хүн юунд ч бодох вэ дээ гэхэд, өвгөн мөнгө мэт сахлаа шувтарч,

— Чи энэ өвчтөний үнэн учрыг ярьж өг гэсэнд, Дервиш хэрхэн дээрэмчинд тонуулсан аяныхантай дайралдаж, хэрхэн энэ шархадсан хүний амь авах гэж хичээснийг нэгд нэгэнгүй тоочсонд, өвгөн мөнгө мэт сахлаа байн байн шувтарч өгүүлрүүн:

— Энэ шархадсан хүн гар нь, наранд ч болов, хүрч чадах маш их хүн байж болзошгүй. Би өөрөө үзье гээд, суудлаас босож, шаахайг холхиндог өмсөж, тэмээний дэргэд очиход нь, тосгоны хүн тойрч, бие биеэсээ урьдан хэлэх гэж хашхиралдан, — Бид энэ өвчтэй хүнийг танина. Гурганжийн баян худалдаачин Махмуд-Ялвач мөн байна. Тэмээ нь түүний тамгатай байна. Махмуд-Ялвачийн хоёр гурван зуун тэмээ Таврис, Булигаар[10], бүр цааш ариун Багдад хүртэл явдаг гэцгээхэд Хаким, тэдгээрийн хэлэхийг сонсоод, дув дуугай уруул өмс өмс хөдөлгөөд, энэ хэргийг ихэрхэг дүрэм үзүүлэн тасалж бичээчээр тэмдэглүүлсэн нь шийтгэсэн тогтоолын үг нь:

«Сайн мэдэх, итгэл томоо бүхий хүний мэдүүлэхийг сонсвол, энэхүү өвчтөн хүн, даруй Гурганжийн хөрөнгөлөг худалдаачин Махмуд-Ялвачи мөн гэх тул, тушаах нь түүний биеийг тэмээнээс болгоомжтойгоор буулгаад, миний гэрт хэвтүүлэн, улмаар эмч ирүүлж, эмийн өвсөөр сувилуулсугай. Шархадсан үнэн шашинтныг асран сувилж, буян үйлдсэн Дервиш, цааш замнан явж болох үүнд, зүй нь, амиа авруулсан худалдаачин, энэхүү Дервишийг хөхиүлэн шагнавал зохино. Харин, энэхүү тэмээг, Дервишид олгож болохгүй. Тэмээний эзнийг илаарь болтол, түр миний энд үлдээсүгэй гэхийн дээр, энэхүү

хэргийг таслан шийтгэж тамга дарсны зардалд энэ Дервишийн хар илжгийг тус газар үлдээсүгэй» гээд, бичээчийн зүг хандаж,

— За, тэмдэглэн бичив үү? гэсэнд ноёнтон, түмэн зөв айлдлаа гэж шивнэн өгүүлжээ.

Засгийн ноён бас өгүүлрүүн:

— Эрдэмтэн Дервиш, өчүүхэн миний хөрөнгөнөөс нэгэн дирхем[11] зоос авна уу? гэсэнд Хажи-Рахим, зэс зоосыг аваад адис авч, уруулдаа хүргээд, гартаа атган өгүүлрүүн:

— Ай шударгаар ялгагч Хаким минь, чи их мэргэн ажээ. Чи намайг шархтныг сувилах, тэмээ, илжиг маллах төвөггүй болгож, одоо би илжиг унахаас өнгөрөвч, мөн тэжээх гэж чирэгдэхгүй боллоо. Хохирон сүйрч байгаа хүний хамгийн өчүүхэн хүн би, өгөөмөр хүний гараас сохор хүний модон аяганд өнхрөн унагч, хөнгөн жинтэй зоостой адил байна. Хэрэв чиний өгүүлэгч сэтгэл мөнгөн сахалтай чинь адил ариун цэвэр бол, энэ зэс зоос чинь алтан динар зоос болог гээд алгаа дэлгэвэл алган дээр нь алтан динар зоос гялалзан,

— Хүндэт засаг ноён танд үнэнийг хэлэхэд, таны гишгэсэн газар ганц зуд болдоггүй буянтан байгаа гээд, гараа атгаад зогсоход нь засаг ноён сэлт дув дуугай, амаа ангайлган, нэг бие биеэ харж, нэг Дервишийн атгасан гарыг харж зогстол, засаг ноён;

— Би энэ хүнд хар болсон зэс зоос өгснийг сайн мэдэж байна. Та нарын үзсээр байтал, алтан зоос болов гээд, хүний санаанд оромгүй хурднаар ухасхийж, Дервишийн гарыг шүүрэн, — Алтан динараа өг! Чи хэргээ таслан барагдуулсны зардлыг түүгээр төлөх ёстой гэж зоосыг нэхэхэд, Хажи- Рахим, гараа дэлгэж, засгийн ноён зоосыг нь шүүрэн авбал өнөөх хар зоос байжээ. Үүнд ихэрхэг Хаким, хоёр мөр тийшээ үлээгээд, суудал өөдөө ажиггүй алхав.

Хажи-Рахим, илжигнийхээ дэргэд очиж, ачмаг саваа аваад, эргэж ч харсангүй, Гурганжийн зүг амандаа Дервиш нарын уншлагыг Я-гу-у! я-хак! Ля илляхи илля-гуу гэж хар хүчээр хашхирсаар цааш оров.

ХҮСЭЛ БОЛСОН ХААЛГА

Өгүүлэх нь: Хажи-Рахим, Гурганж хотын хүнгүй нэгэн гудамж дахь өндөр шавар хэрмийг налан зогсож,

— Тэр жилийнхээс ердөө ондоо болоогүй, тэр хэвээр байна шүү. Хүйлс ялам модны дунд байсан хавтгай оройтой жижигхэн

байшингууд хэвээрээ, оюу мэт огторгуйгаар цагаан тагтааны сүрэг, мөн урьдах байдлаар нисэн, дээр нь хүрэн элээ урьд адил элэн халин, хашааны дээр хуайшуу модны цагаан цэцэгт мөчир унжин, дор нь бяцхан явган хаалга урьд адил нуугдсаар байна. Салхи бороонд борлосон самбар банзанд нь урлан сийлсэн угалзын хээ нь хүртэл мэдэгдэж байна. Урьд, энэ хаалганаас ягаан хувцас өмссөн улбар шар бүтээлгээр нүүрээ бүтээсэн залуу хүүхэн гарч ирдэг сэн. Одоо тэр хаана байгаа бол? Яасан бол? гэж сэтгэж байтал, тэр бяцхан хаалга нээгдэж, ягаан өнгийн хувцас, гүргэмийн өнгөтэй бүтээлэгтэй залуу хүүхэн, гартаа хүрз барьсаар гарч ирэв. Үл мэдэг тунтайсан шанаа, баахан зэрмэгэр нүд, өмссөн хувцас, алчууpаа зангидсан байдлыг үзвэл, турк аймгийн хүн бололтой. Амандаа дуу аялан, цэцэрлэгт ус оруулах татаалын амыг нээхэд, ус, шавар хэрмийн сэтэрхийгээр оров. Охин, гэнэт өндийгөөд, нарийхан бор гараарaа нүдээ саравчлан, гудамжны адгийг харж, тэр зүгт, нэгэн хүн, нарийхан хоолойгоор аялуулан дуулсан нь

Шөнө болоход нойр шилжээд.
Шөнөжингөө одот огторгуйг харж,
Хавирган сарыг харвал,
Хайртынхаа хөмсгийг санадаг.
Миний хувь зохиол ийм юм уу даа?
Мэддэг ч болоосой ирээдүйн явдлыг.

гэж дуулсаар, гудамжны цаанаас, нэгэн морьтой залуу хүн айсуй. Үзвэл, биедээ хар ногоон өнгийн чекмен дээл өмсөж, эрээн бүс шавхийтэл бүсэлжээ. Хонины арьсан малгайг баруун хөмсгөн дээрээ урагш духдуулан тавьж тэмүүлэн цовхчиж байгаа азарганы амыг татаж, алгууpаар сажлан явтал, гэнэт морио тас ороолгон, ухасхийгээд, хүүхний ойр ирээд, морины ам татаж гэнэт зогсоосонд, хүүхэн барьж байсан хүрзээ чулуудаж, даруй хашаан дотор гүйн ороод, хаалгаа тасхийтэл хаав. Өнөөх морьтой залуу, малгайгаа шилэн дээрээ тавьж, цааш аажмаар сажлан, удалгүй хаалга дахин нээгдэж, өнөөх хүүхэн, завсраар нь шагайн харж байгаад айсан байдалтай нааш цаашаа хараад, хүрзээ авч, дахин алга болов.

Хажи нарын ороодостой шовх өндөр малгай, эрээн нөмрөг дээлтэй, халуунд гандаж бов бор болсон Хажи-Рахим, урт таягаар сохор мэт чанга чанга тогшин явсаар, замыг хөндлөн гарч, сайх

хаалганы дэргэд хүрээд, хаалганд тээглэж тасарсан ягаан даавууны өөдсийг аяархан аваад, өвөртөө хийн аман дотроо дүнгэнэн өгүүлрүүн:

— Эндэх юм, цөм хэвээрээ байна. Ганц, ургасан мод нь өтгөн навчтай өндөр болжээ. Энэ хаалга, мөн л хэвээр, ганц өнгө нь хуучирч далжийжээ. Саяын миний хардаг хүүхэн, арван зургаатайдаа миний дурлаж байсан хүүхэнтэй адилавтар боловч, арай л тэр биш байна... Тэр гартаа сагстай хүйлс барьж зогсдог сон, өөрөө хүйлс мэт хүрэвтэр царайтай бөгөөд, хүсэх мэт сайхан байдаг сан. Тэр маань хаана байгаа бол?... юм бүхэн хуучнаар байна даа. Тэр эртний цамхгийн дээр урьдахын адил харцага шувуу эргэлдэн ниссээр байна. Харин, энэ завсар би өөр болж дээ гэж таягаар хаалга тогшив.

Удалгүй, хаалганы цаана нэгэн хөгшин хүний ханиах сонстож, цасан мэт цагаан чалмаар толгойгоо ороосон, бөгтөр нуруутай хатангир өвгөнийг хүрч ирэхэд Дервиш, Я-гуу-я-хак гэж өнөөх уншлагаа уншив.

Өвгөн нулимстай улаан нүдээр ширтэн харж, бүсний нугалаасыг тэмтрэн, хуучин арьсан хэтэвч гаргаж, цусгүй болсон хатангир цагаан хуруугаа оруулан, нэгэн хав хар зоос олоод, Дервишид өгөв. Дервиш, зоосыг аваад дух уруулдаа хүргэж, адис аваад, аллахум селля! гэж хэлсэн нь энэ гэрт хэн суудаг вэ? би уншиж явдаг ганц залбирлаа хэний төлөө унших билээ? гэсэнд, өвгөн өгүүлрүүн:

— Би энэ гэрт суувч угтаа миний гэр биш, энэ гэрийн эзэн Кари Максум гэдэг дархан хүн, одоо их зах дээр сууж байгаа түүний зэвсэг үйлдэх дархлах байрыг олон цөм мэднэ. Кари Максум, санваартанд өглөг өгөхдөө бэлэн хүн шүү гэхэд нь бадарчин Дервиш асууруун:

— Эрхэм шидтэний хувьтай сайхан алдар хэн билээ? гэхэд нь,

— Намайг тэгж бүү хэтэрхий өргөмжил. Би бол шагийн хөгшин сударч, Мирза-Юсуф гэдэг байна. Яруу найрагчийн шүлэг эш татаж, өөрийн тухай шүлэглэвэл

Ачааны мал мэт зүтгэсээр, энэ насаа дуусгалаа.
Алд бие, гэрийн сахиул, үр хүүхдийн боол боллоо.
Аль байдаг хөрөнгийг хуруу даран тоолж боловч,
Аяа, үгээгүй гэрийн зовол зүдлийг хэлэвч баршгүй,
Ангижирч, түүнээс мултрах горь үнэхээр үгүй[12]

гэжээ.

Үүнийг сонсоод Дервиш өгүүлрүүн:

— Юу ч болов, чи шидтэн хүн юм даа. Сайхан сэтгэлээр над нэг хар дирхем зоос өгсөн чинь, одоо цул алтан динар зоос болжээ гэсэнд, өвгөн Дервишийн шувууны савар мэт хар гарыг тонгойн үзвэл, үнэхээр товойлгон цохисон үсэгтэй алтан зоос гялалзан байгааг үзээд,

— Би өдий нас болтол, ариун номд өгүүлсэн гайхамшигтай зүйлийг ер үзээгүй бүлгээ. Дервиш чи, шидтэн хүн биз ээ. Эсхүл, зах зээлийн илбэчин болоод, сохор өвгөнийг дооглон наадаж байгаа биз ээ гэхэд нь,

— Чи энэ динарыг туршин үз. Зарцдаа өгч, зээлээс хуурсан кебаб мянтууз, бал, амтайхан гуа зэргийг сагс дүүрэн худалдаж авчруул. Тэгээд, алс холын Багдадаас аялан ирсэн ядуу надад ч тэр хишгээсээ хүртээх биз гэхэд нь.

— Юү гэнэ ээ? Чи Багдадаас ирсэн юм уу? Тийм бол, миний гэрт орж, Багдадад хэрхэн юу үзсэнээ ярьж өг. Тэр завсар чиний шидэт динар зоосны чадлыг тэнсэн үзье гэв.

ШАГИЙН СУДАРЧ

Түүний бие, манай гэрийн хол, замын урт, аюутайг үл хайхран миний зүг зорьжээ.
(Ибн Хазм,) (11 дүгээр зуун)

Өвгөн, шар илгэн гутлаа чирэн, хашаан дундуур явсаар, орж нэгэн өндөрлөг тавцан дээр гарч;

— За аяны хүн минь, яваад бай гэж, дагуулан явсаар нэгэн тоосгон шалтай, туурганы хажуугаар нарийхан хивс дэвссэн байшинд оржээ. Ташинга дээр хоёр мөнгөн домбо, иракийн шилэн бумбыг тавьжээ. Тасалгааны бөмбөгөр оройг элдэв өнгөөр алаглан будсан модоор солбицуулан, их урнаар үйлдсэн бөгөөд, яг дунд нь утаа гарах өрхтэй, голомтод нь дөрвөлжин зассан өр дотор цогтой хоовон тавьжээ. Хоймроор төмөрлөсөн гурван авдар нээлттэй харагдаж, дотор нь шар арьсан хавтастай том том ном үзэгдэв.

Дервишийг үүдний дэргэд таягаа, авч явсан юмтайгаа тавьж, шаахайгаа тайлан, өвгөний дэргэд өвдөг нугалан суутал,

— Бент-Занкижа! гэж өвгөнийг дарвих дуугаар дуудахад, эрээн дээл, хөх чалма өмссөн нэгэн бяцхан хүү орж ирээд, алга хавсран мэхийн, өвгөний үг хэлэхийг хүлээн зогссонд, өвгөн өгүүлрүүн:

— Чи энэ алтан динарыг өвгөн Саклабад аваачиж өгөөд, өвгөн ах Саклаб та, зах орж, мөнгө задлагч энэтхэгийн суудаг газар оч. Тэд тоглоомын дөрвөлж мэтийг зарж байдаг шүү дээ. Тэдний дундаас хамгийн буурал сахалтай өвгөнийг сонгож, энэ динар ёстой алтан динар мөн бусыг асуу. Ёстой алтан динар гэвэл, мөнгөн дирхемээр задалж, аянчны хоол цайны газар очиж, идэх юм худалдан авчир гэж хэл. Чухам юу худалдан авахыг энэхүү үнэнийг эрэгч эрхэм хүн хэлж өгнө гэсэнд, сайх хүүхэд, Дервишийн зүг хандаж,

— Зарц надад, чухам ямар юм авахыг тушаана уу? гэхэд нь, Дервиш хүүхдийг харвал, булбарай зөөлөн царай нь нэг л танимаар мэт тул, чухам хаана, хэзээ үзсэн билээ, гэж санаж ядан өгүүлрүүн:

— Зарцын бие, саг барин очоод, зээлийн газар өөрийн тааваар сонгож автугай. Олон жил уулзаагүй ахтайгаа учирвал, юу авч байна. Тийм л юм ав даа гэхэд нь өвгөн бас гараар дохин ирүүлээд, чихэнд нь шивнэж хэлсэн нь:

— Саклабыг зах дээрээс ирээд, өнөөх нооронхой дээлтэйгээ битгий ор. Миний хуучин дээл өмсөж ир гэж хэлээрэй. За, чи, энэ динарыг өгөөд, бэх цаастай хүрээд ирээрэй. Энэ хүний ярих үгийг бичиж авна гэхэд нь, тэр хүү гарч, удалгүй бичгийн хэрэгсэл, цаастай орж ирэв. Өвгөн, даруй Дервишээс асуууруун:

— Аяны хүн, таны алдар хэн гэдэг вэ? Уул нутаг хаана байдаг вэ? Алдартай Багдадад хэрхэн очсоноо ярьж өгнө үү? гэхэд нь,

— Намайг, олон хүн Хажи-Рахим аль багдади гэдэг. Басрын ойрх нэгэн бага сууринд төрсөн. Чиний асуусан бүхнийг хариулахад бэлхэн байвч, юуны урьд миний сэтгэл санаа зовоож байгаа нэг юм асууя гэсэнд тэгвэл түүнийгээ хэлтүгэй гэхэд нь,

— Би, Багдадын Медерес сургуульд нэрт эрдэмтнийг шүтэж, эрдэм сурч байлаа. Гэгээ гэрэл мэт мэргэдийн эрдмийг уламжлах гэж надтай хамт суралцаж байсан шавь нарын дунд, хичээл оролдлогоор бусдаас анги гарамгай хэзээд дуугай номхон нэгэн залуу байсан. Би тэнүүлчийн бүсийг бүсэлж, бядан явахын таягийг барьж, алдарт Гурганж, эрхэм Бухар, асар сайхан Самарканд хотоор явах хүслэнгээ тэр залууд хэлсэн чинь, Хажи-Рахим аль багдади чи, Хоресм шагийн Гурганж баян балгас орвол, захаас баруун хаалганд очих гол замыг

хөндлөн гарсан гуравдугаар гудамжинд очиж, зэвсэг хийж худалддаг дархан Кари-Мак-сумыг олж, миний ачит эх эцгийн амьд мэндийг мэдэж ирнэ үү? Намайг Багдадад сууж байгаа байдлыг нэгд нэгэнгүй ярьж өгөөрэй. Эргэж ирээд, үзсэн мэдсэнээ надад хэлж өгөөрэй гэсэн билээ. Би түүний захисныг тэгье гэж зөвшөөрч, аялан явснаас хойш элдэв санамсаргүй тохиолдлын салхи, зовлонгийн аянгад нэрвэгдэн хөөгдсөөр, зүг зовхис бүхэнд тэнэн явж, Энэтхэгийн шатам халуун наранд явж, Татаарын их цөлөөр ч явж үзлээ. Татаарын уулгалан дайрахаас хамгаалж босгосон Хятадын түмэн газрын их цагаан хэрэм хүртэл ч явж үзлээ. Хүрхрэн давлагаалагч далайн эргээр явж, цастай бэрх Тэнгэр уулыг давж, газар бүр мусульман хүнтэй дайралдсаар, олон жил тэнүүчлэн, одоо сая Гурганж хотод хүрч ирж, Багдад дахь нөхрийнхөө заасан ёсоор цас мэт цагаан хуайс модны дэргэдэх бяцхан хаалгыг олж, одоо шидтэн чамтай ярьж байгаа минь энэ бүлгээ. Бодвол, энэ гэрт сууж байгаад арван таван жилийн өмнө Гурганжаас гарч явсан тэр залуу дурсан санасаар биз ээ гэхэд нь өвгөн, Дервишийн үгийг сонсоод, тэр залуу хүний нэрийг хэн билээ гэж хүйтнээр асуусанд,

— Мэдлэгийн өндөр ордонд түүнийг (Хоресмийн) Али Жафар гэдэг сэн гэхэд нь,

— Муу заяат чи, ямар аймшиггүй түүний нэрийг дурдав? гээд уруулдаа хөөс сахруулан өгүүлрүүн: Тэр амьтныг туйлын их нүгэлт амьтан гэдгийг мэдэхгүй юү чи? мөртөө, биеэ, эцэг эхээ гутамшигт болгоод, ураг төрлөө гай гамшигт унагаан алдсан хүн шүү гэхэд нь.

— Тийм залуу бага хүн яаж тэгдэг юм билээ? Хүн алсан юм уу? Их Беги ноёнд халдсан юм бил үү гэхэд нь,

— Тэр аюулт Абу-Жафар, бага наснаас их авьяас хичээлтэй ном сайн уншиж, сайн бичих болж, их Коран номын гүн утгыг мэдэх гэж байсан юм аа. Эрдэм сайн сурч, Фирдоуси, Рудеги, Абу-Сайдыг дуурайн, шүлэг холбохдоо нэлээд сайн болж байсан боловч, зохиосон шүлэг нь бусдад сургамж болохоос харин, амархан итгэдэг гэнэн сэтгэлтнийг үймүүлдэг шүлэг байжээ гэж хэлээд өгүүлрүүн: Тэр золгүй, залуу тэгсээр чөлөөт сэтгэлтэн болж, өвгөн буурал улем багш, Имам хамба нартай марган булаацалдаж, гэнэн сэтгэлт эгэл шавь нарын сэтгэлд сэв оруулж эхлээд Имамыг «Чи энхжиний оронд очих замаар явахгүй, галт тамд унах замаар явж байна» гэхэд өөдөөс нь хэрцгийгээр хариуцан надаас зайл, намайг энхжиний оронд бүү урь.

Чамайг эрих барьж, уншлага мөргөл хийж элдвийг тэвч гэж номлоход чиний Мухамедын сүм, хонхны дуу жингэнэг ч Есүсийн хийд, Мосейн шашинтны сүмийн алинд нь очсон адилхан юм байна даа гэж санагддаг боллоо. Тэнгэрийг хааяагүй эрэвч, надад олдсонгүй. Ер тэнгэр гэдэг байхгүй. Харин тэнгэрийн нэрээр худалдаа хийдэг хүн, тэнгэр бий гэж санаагаараа зохиожээ. Миний замыг заагч гэрэл бол, Абу-Али Ибн Сина[13] мөн» гэсэнд хутагт Имамууд, түүнийг хараал хийж бариулаад, хотын талбар дээр, халдварт шүлэг зохиохоо зогсог гэж хорт хэл, хоёр гарыг нь огтлохоор тушаал гаргасанд нь, могой мэт суга үсрэн зайлсан билээ. Анхан, түүний эцгийг гэмт хүүгээ энэрэн хайрлаж, нуун далдалсан биз ээ гэж санацгааж байсныг Хоресм шаг Мухамед, Имамуудаас сонсож мэдээд, эцгийг нь баривчлан авч, бясаатай земдан гянданд хориулж «үхтэл нь үүрд» гэсэн бичээстэй гинж зүүлгээд, гянднаа үхвэл, Абу-Жафарыг сайн дураар эргэж иртэл ойр төрлөөс нь суулгахыг тушаасан билээ гэвэл, Дервишийн царай үхсэн хүний царай шиг шарлаж, нүдээ бүлтийлгэн гялалзуулж:

— Эцэг нь одоо болтол гянданд бий юү? гэж нам дуугаар асуусанд,

— Эцэг нь харанхуй чийг, нүхэн гяндангийн аймшигтай хачиг хувалз, бясаа хорхойг дааж чадсангүй үхээд, Хоресм шагийн тушаалаар зандалчин, отгон хүү Тугааныг баривчилж, хүзүүнд нь гинж зүүж, мөнхүү бат гүнд хийсэн билээ гэхэд нь,

— Юутай муухай хэрэг вэ гэж Дервиш шивнэн хэлээд, өнөө өвгөн, үгээ үргэлжлэн,

— Би тэр, бяцхан Тугаан хүүг их л өрөвддөг. Түүнийг хүн болгох гэж би их л санаа тавьдаг байсан юм. Замаа алдсан ахынхаа мөрөөр бүү ороосой гэж сургаж хүмүүжүүлэхийг оролдож, ном унших бичихийг зааж байсан боловч, уран дархан, мөн цэргийн цэнгэл наадамд дуртай байхад нь би түүнийг Кари Максум дархныг дагалдуулан, юм сургахаар өгч дархан ч түүнд сайн зэвсэг хийх арга зааж байсан бүлгээ. Одоо Тугааны оронд өнчин охин дүү нь, шивэгчний хүүхэд Бент-Занкижа, миний дэргэд байж, унших бичих дуу шүлэг цээжлэхдээ маш авьяастай юм аа. Одоо би нас хөгширч нүд минь сохрох тийшээ хандаж, нэг юм хоёр болон үзэгдэж, нэг сар даруй гурван сар болон харагддаг болов. Тийнхүү Бент-Занкижа надад тусалдаг бичээч болж, миний хэлснийг тэмдэглэн бичиг хуулдаг болов. Одоо энэ чиний өмнө үзэг барин сууж байна шүү гэхэд Дервиш тэр хөх

чалматай бичээч охиныг тун саяхан хаалганаас хүрзтэй гарч ирсэн охин мөн байна гэж таниад, түүнийг ширтэн харж, үүнээс арван зургаан жилийн өмнө байсан өнөөх бүсгүйг асуухаа зүрхшин, нүдээ доош хандуулан сэтгэл хөдөлснөө дарж, дуу алдан өгүүлрүүн:

— Чи шидтэн биш гэнэ үү? Энэ охинд бичгийн нарийн эрдэм сургасан ачаар энэ хүн, турбанаа бичээч нарын гоёж өмсдөг маягаар толгойдоо маяглан зангидах эрхтэй болжээ. Би үзвэл, чиний гэрт үнэхээр эрдэм мэдлэгийг эрхэмнэх ажээ гэсэнд, өвгөн, нарийхан хуруугаа зөрүүлэн холбож, өөдөөс нь ширтэн хараад,

— Чи одоо өөрийнхөө явдлыг өгүүл. Чи хэдий болтол тэнүүчлэх хүн бэ? гэхэд нь, Дервиш, сэгсийсэн толгойгоо сэгсрэн, галтай хар нүдээр өвгөнийг харж өгүүлрүүн:

— Элчилгүй цөл газар намайг хөөсөн өлсгөлөн миний эцэг болж төрсөн хүүхдээ тэжээх сүйгүйдээ гашуудсаар, нулимсаа бартал уйлсан ядуугийн зовлон миний эх болж, яргачны сэлмээс айдаг минь багш минь болсон. Гэвч, «Дервиш чи бүү гашууд, чиний бүтээсэн бүхэн цөм чамайг гутаахгүй юм» гэх дуу надад сонсогддог гэхэд нь өвгөн бичээч, толгойгоо гэгж өгүүлрүүн: Чи эрдэмтэй тул, аль ч цөлгийн засаг ноён буюу шүүгч түшмэл, дуртайяа бичээч болгон авна. Би ч чамайг Шагийн номын санд ном сийрүүлэх бичээчээр авах юм сан. Тэнд хэний ч мэдэхгүй ховор чухаг ном бий.

Хойч өдрийн хүнд үрэгдэлгүй уламжлах гэж сийрүүлж хувь үлдээх нь хэрэгтэй бий. Чиний талаар тэнүүчилсний хэрэг ер байхгүй. Шороо тоосонд даруулан, чулуунд хөлийнхөө ул нухлуулан хэрж явахдаа дуртай юм уу чи? гэхэд нь, Дервиш бөглүү дуугаар үг өгүүлрүүн;

— Хүн намайг гэрээ эрээн хивсээр чимэглэн засахыг яасан юм бэ? гэдэг гэтэл, «гэтэл баатрын хашхиран дуудах уриа сонстохыг дуучийн дуугаар юу хийх вэ?» «хөлөг морийг байлдаанд довтлоход, дэлгэрэн байгаа тэргүүлэгч цэцгийн дунд хэрхэн хажуулан хэвтэж болох вэ?»[14] гэхэд нь, өвгөн машид гайхаж, гараа дэлгэн асуусан нь:

— Чи ямар байлдаан хийж байна даа? Мусульманы эзэн хамгийн хүчирхэг цог жавхлант султанд хэн халдах бил ээ? Султан өөрөө байлдахыг хүсвэл сая харийн цэргийн хүрээнд гал нь дүрвэлзэнэ гэхэд нь,

— Дорно зүгээс аймшигт гал айсуй. Тэр гал бүгдийг үнсэн товрог болгоно гэхэд, өвгөн толгойгоо сэгсрэн:

— Ээ тийм биш, Хоресм шаг илдээ хуйнаасаа сугалаагүй байсан цагт Мавераннагрын[15] гол хөндий, Хоресмийн зах хилээр хэзээ ч энх тайван байна гэж хэлж байтал, гаднаас хөлдөө хүнд гинж зүүсэн нэгэн өвгөн боол сагстай элдэв зүйлийн амттаныг сайх шидтэн динар зоосоор худалдан авч ирэв.

Тэр өвгөний бие өндөр, бас л зүдэрч ядрахын туйлд хүрч, биед өмссөн нь богинохон эрээн хувцас, үс нь буурал болж, мөрөн дээрээ сэгсийн буужээ. Хивс дээр торгон алчуурыг дэвсэж, бин, бүйлсний идээтэй боорцог тавиад, бал чавга, бүйлс, үзэм, бас чихэрт чанасан амттайхан гуаны зэрэг зүйл бүрийн амттантай аягыг өрсөнд Дервиш, өвгөнөөс,

— Би энэ өвгөн боолтой үг сольж үзье гэсэнд,

— Хүндэт зочин минь, тэгтүгэй гэсэнд, Дервиш, тэр боолоос,

— Өвгөн таны нутаг хаана билээ гэвэл,

— Уул нутаг хол. Орос газар, эндэхээр Ижил гэдэг, оросоор Волга гэдэг их мөрний эрэг дээр загасчин эцгийн хамт сууж байсан, миний нутаг залгаа Суздалийн ноёны сайн эр намайг уулгалан олзолж билээ. Манай тэндхийн ноён, танай эндэхийн хаан Беги гэсэн үг. Манай ноёд, өөр хоорондоо байлдаж дийлсэн нэг нь дийлдсэнийхээ харьяат эр эм, охид, хөвүүдийг олзлон авч, харь газар хонь мэт авчирч худалдаалдаг билээ.

Намайг ч охин дүүтэй минь Булигаарын худалдаачинд худалдсан нь Биляр гэдэг наймаа хотдоо авчраад, олзлогдсон хүмүүсийн хамт бид хоёрыг цөл талчлан туусаар Гурганжид авчирсан билээ. Охин дүүг чухам хаана худалдахаар явуулсныг мэдсэнгүй. Энэ ч аль эртний хэрэг юм даа. Үс минь хөгшин ямааны сахал мэт цайран унжиж явагч, мөрний хөвөө дээр өссөн төрсөн гэрээ үзээсэй гэж мөрөөдөн санасаар явдааг. Би энэ завсар туркмен, перс хэл сурсан. Энд, манай нэгэн үндэс ясны хүмүүсгүй бол би эх хэлээ ч аль эртний мартчих байсан. Хаяа зах зээлийн газар манай нутгийн олзлогдсон хүнтэй уулзахдаа бид, өөрийнхөө хэлээр ганц нэг үг хэлэлцээд авдаг юм даа. Хөлдөө гинж хангинуулж явдаг тийм хүн энд олон доо гэхэд нь,

— Нэр чинь хэн гэдэг вэ? гэвэл,

— Энэ газар намайг Саклаб гэдэг. Олзлогдож ирсэн манайхан, намайг хуучин хэвээрээ Слабка өвөг гэж дууддаг. Миний зүрхэлж хэлснийг уучлаарай гээд, Дервишид гүнээ мэхийн ёслоод, би чамайг алс хол газраар бядан явж, шидтэн адил, зэс зоосыг алтан динар

болгодог гэж сонслоо. Тийм бол намайг худалдаж авах чинь, алга урвуулах мэт хялбар хэрэг биз. Намайг худалдаж аваач. Би чамайг үнэн шударгаар үйлчилье. Бас ч, манай зүг Орос тийш явбал, намайг дагуулж яваарай гэхэд нь, гэрийн эзэн, хөмсгөө зангидан,

— Чи миний боолыг аргадан татаж авах нь уу гэж, Дервиш,

— Надад боол санах тийм тэнхээ хаа байх вэ? Өөрөө үгээгүй ядуу болоод, өгөөмөр хүнийг атга будаа өгвөл, түүгээр нь амь улжиж явдаг хүн шүү дээ би чинь гэхэд нь,

— Харийн хол газар ясаа тавих амьтан даа би гэж Саклаб сүүрс алдаж, амандаа үглээд, хивсэн дээр аяархан алхаж зэс гадар, устай угалз хээтэй хумх авчирч,

— Манай зочлох зоогийг барина уу? гэж өндөр дуугаар хэлэхэд нь, Мирза-Юсуф Дервиш хоёр, гадар дээр гараа угааж, хатгамал оёсон алчуураар арчаад, дув дуугай идэж ууж эхлэв. Дервиш, тавагтай идээ бүгдээс амсан идээд элдэг үгээр тал өгч, чөлөө айлтгаад,

Дервиш, хүнгүй гудамжинд модны сүүдэрт удтал зогсож, тэр нэгэн хуучин бяцхан хаалгыг харан харан сэтгэрүүн:

Гарт минь хулсан үзэг бариулж, номын үсэг бичихийг сургаж өгсөн сайхан сэтгэлт өвгөний энэ гэрийг одоо дахин үзэж чадахгүй боллоо. Би түүний энхрий дотно дууг нь сонсох гэж ганц алтан динараа хайрласангүй билээ.... За, дахин замдаа оръё...» гэж цааш явж одов.

Түүнээс, өвгөн бичээч, хаалганы цаана гарч явсан жигтэй зочны хойноос үүд тийш удтал харж байтал, гаднаас Бент-Занкижа орж өгүүлрүүн;

— Сайхан сэтгэлт Мирза Юсуф өвөг минь! саяын Дервиш Хажи-Рахим аль багдади, манай оргож одсон чөлөөт сэтгэлт ах Абу Жафартай маш адилхан байна гэж сэтгэлд ороод болж өгөхгүй байна. Сахал нь ургаж, царай нь гандаж хөхөрснөөс та түүнийг таньсангүй бололтой гэхэд нь,

— Чи гай чирэх гээгүй бол, дуугай бай. Би хутагт Имамын хараал хийж зүх гэсэн, шашингүй амьтантай юу гэж юм ярих бил ээ? Үүнээс хойш надад тэр агшин зуур үзэгдээд өнгөрсөн зочныг бүү дурд. Одоо цаг болбол, бидний шивнэж ярьсан үгийг туурганы цоорхойгоор хортон этгээд хулуун сонсох цаг мөн. «Дуугай байх нь юунаас ч чадалтай түүнээс бусад нь цөм үхээнц»[16] гэсэн шүлгийн үгийг өдөр шөнөгүй санаж явах хэрэгтэй гэхэд нь,

— Үерхсэн нөхрийн өмнө ч, дув дуугай байна гэж үү? «үерхсэнээс бусад хүн бүхний өмнө амаа хамхиж яв» гэж тэр их яруу найрагч бас хэлсэн биш бил үү. Нэг насаар дуугай явна гэж, яаж болох вэ? Үгүй, үхэвч, дуулж, шог үг хэлж яваад үхсэн шулуун! гэхэд нь өвгөн,

— Дуугай бай, дуугай бай. Ээ тэнгэр минь, намайг өршөө! бие ганцаар шөнө урт, их Хоресм шагийн намтар дуусгах болоогүй. Тэр хүнийг Рахим гавьяат үйлийг үйлдэхийг горилон хүлээтэл хүн алах цаазлахаас өөр юм үзэгдэхгүй нь шив дээ. Баатар эр маань, алтан хүйр нисэж, хорт хилэнцэт хорхой дотор дүүрсэн хөндий чулуун хүн шиг болчих нь уу даа? Аллах намайг хялайн үзэж ивээн гийгүүлнэ үү?.. гэжээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ : ХОРЕСМИЙН ЭЗЭН ШАГ ХҮЧИРХЭГ

ДОГШИН ОО

ӨГЛӨӨ ОРДНЫ БАЙДАЛ

Хааныг үйлчлэхэд хоёр тал бий.
Нэг нь, аяга хоол олохыг горьдох.
Нөгөө нь, амь алдахаас айх.
(13 дугаар зууны үеийн яруу найрагч Саади).

Өгүүлэх нь, үүр бүрийж байхад гурван хөгшин Имам[17] Гурганж хотын нэгэн давчхан гудамжаар явж, өмнө нь зарц, тостой цаасан бүдэг дэнлүү барьж замыг нь гэрэлтүүлэн, өвгөд, өргөн дээлийнхээ урт хормойг өөд нь татацгаан шуржигнан урсаж байгаа устай нарийн шуудуу дээгүүр харайж явав. Харанхуйд, хаалттай дэлгүүрээс нэгэн үе поваарь, гаа, будгийн хурц үнэр гарч, морины эмээл, савхин гутал зэргийг агуулах байшингийн хажуугаар өнгөрөн гарахад нэгэн үе арьс ширний сүрхий үнэр ханхлав. Талбарт хүртэл

— Зогс, ямар хэрэгтэй харанхуй шөнө явцгааж байна? гэх зэрэг зандрангуй дуу гарч,

— Ихсийн өршөөлөөр бид их сүмийн санваартан Имамууд Падишаг эзний ордонд өглөөний мөргөл үйлдэхээр яаравчлан явцгааж байна гэхэд нь,

— За, тэгвэл яв даа гэж, тэндээс гурван Имам явсаар, ордны өндөр хаалганд хүрээд тогшвол, хаалга нээгдэж, хэдэн морьтой хүн харанхуйгаас гарч ирээд талбарын дундуур давхилдан одсон нь «шашныг хамгаалагч, үнэнийг эрхэмлэгчийн» тушаалаар, явуулсан эзнээс өөр хүний үл мэдэх зүг элч мордсон байжээ.

Хөгшин имамууд, чулуу дамжин гишгэсээр, их шалбааг туулж, хаалганы дотор ортол, өргөн их хашааны дотор Шагийн цэрэг, зүг бүр сүлжилдэн явцгааж, манааны хоёр хүн, лал лам нарыг таньж, зам тавин өгвөл, гурван хөгшин, цааш явж, хэд хэдэн бяцхан хашаа дамжтал, нойрт дарагдсан манаа, төмөр түлхүүр харжигнуулан, хүнд нүсэр хаалгыг нээж зам тавьсаар, гурван имам, хоёр самбартай хаалганд хүрвэл хаалганы хажууд төмөр хуяг дуулгатай хоёр цэрэг

түшин, хөдлөлгүй зогсож, цаанаас нэгэн зарц, гартаа тортогтой голтой шавар дэн барьж ирээд, дэнг дээш өргөж өгүүлрүүн:

— Шашны сахиулсан, арай дээшлээгүй гэсэнд, гурван өвгөн,

— Бид хүлээзнэе гэж шаахайгаа тайлж, хивс дээр сөхрөн сууж, өмнөө арьсан хавтастай, зэс товчлууртай том ном дэлгээд нэгэн Имам:

— Өчигдөр, самууран боссон дөрвөн хаад, бага хүүхдээ барьцаа болгон хүргүүлсэнд, Шаг хурим хийж, арван хоёр хонины мах шарсан шүү гэхэд нь нэг имам,

— Өнөөдөр яадаг бол доо гэж шивнэн, бас нэг имам,

— Түүний хэлсэн бүгдийг зөрөлгүй дагах нь хамгийн чухал бий гэж сүүрс алдав.

* * *

Өгүүлэх нь Хоресм шаг Мухамед, нэгэн зүүд зүүдэлжээ.

Зүүдэндээ хээр талд нэгэн довцог толгой дээр зогсоод, түмэн хүн тойрон зогсож, тэнгэрийн хаяа, шингэх нарны хүрэн өнгөт туяагаар татаж, нүд гялбам элсэн талын хаяа руу нар хурднаа ташин орж байв. Цугласан олон, Падишаг мандтугай! Урт насалтугай! гэж хашхирах дуу нь цаад захаас хүрхрэн сонстож, хүн аажмаар нуруугаа бөхийн ёсолцгоож, толгой дахь цагаан чалма малгайд царайг далдлан, олны сөгдөн байгааг үзвэл, өмссөн хувцас нь үүрд давлагаат Хоресм тэнгисийн долгио адил хөдөлж Падишаг мандтугай! гэж хашхирах дуу нь, цуурай мэт сонстон, чимээгүй болоод, нар шингэж, элсэн тал, хөх бүрэг, нам гүм болж, бүдэг бадаг дундуур довцог өөд бөхийсөн олон нуруу мярааж байхад нь,

— За, одоо ухарцгаа, ухарцгаа гэж тушаавч, улбар шар бүстэй, эрээн дээлтэй бөхийсөн олон нуруу, улам улам айсуй. Шаг, түүнийг үзээд, цөм хурц хутга өвөртөлсөн бололтой. Эзнээ хутгалан алах нь гэж, Шаг урагшаа ухасхийн, дэргэд нь дөхсөн нэгийг хөлөөр нэгэнт өшиглөвөл, дээл нь шувуу мэт хөвөлзөн дэгдэж, дээл дороо юу ч үгүй, бас л хэдэн дээл өшиглөвөл, мөн хоосон дээл байжээ.

Үүн дор лав нэг хүн бий. Тэр гэтэн ирж, алдарт Хоресм шагийн зол завшаан, сүр жавхлангийн төлөө цохилж байгаа миний зүрхийг хутгалах гэж байна гээд,

— За, за, боллоо, буц гэж хэлэхэд нь, тушааж байгаа дуу нь арай гэж сонстоод, тэр юм завхран үгүй болов. Орчин тойронд цөл хоосон, чив чимээгүй тал борлон үзэгдэж, өвсний хатуу иш, огторгуйд зурайн

харагдаж, Шаг, цөл талын дунд ганцаар явган зогсоод, бор толгодын нэгний улбар хонхор дотор өнөөх хутгалах гэсэн хүн нуугдаж байгаа бололтой... Бүгдээр Шагийг үхээсэй гэж, олны дотроос тэр нэг хүн Шагийг хорлох гэж зорьсон бололтой. Тэр чухам, хэн бол? гэж бодтол, алсад Желал-Эд-Дин мандтугай! Хоресм шагийн ширээ залгамжлагч эрэлхэг зоригт хүү Желал-Эд-Диний алдар мандтугай! гэж олны хашхирах цуурай сонсогдсонд, Хоресм шаг, дотроо сэтгэрүүн;

«... Намайг хэдийн мартаад, миний хүүгийн гараас адис авах нь бэлхэн байна. Үүнийг эцэс болгоё. Миний явах мөрийг хэн ч хөндөлдсөн, багдадын халиф ч тэр, миний номгоршгүй хүү ч тэр, би даран сөнөөнө. Ингэж байдаг хэрэг биш гэж Шагийн зүүрмэглэн зүүдэлж байхын дунд, биеийн ойр чимээ гарч, ямархан нэг хүйтэн юм нүүрт нь хүрсэнд, аминдаа хайртай сэтгэлд айдас нь хүрч, хамаг хүчээ гаргаж, босон харайгаад, нүдээ нээж, тасалгааны харанхуй буланг цочин харвал, туурган дахь их зуухнаас цогийн нөлөө мэдэгдэж, дэргэд нь нэгэн хүн сууж байв. Нарийвчлан харвал, өчигдрийн авчирсан хөдөөгийн зэрлэг хүүхэн ажээ. Тэр хүүхэн айсан байдалтай, гэдрэгээ ухарч, гараар нүүрээ халхлан бөхийж,

— Чи хэн бэ? гэж асуувал.

— Аллах их ээ! Би цөл газрын туркмен хүүхэн Гюль-Жамал гэдэг. Өчигдөр орой, нойрмоглосон чамайг энд сугадаж түшин авчирсанд, чи ирмэгц унтчихсан. Тэгээд, аймшигтайгаар хурхирч, үхэж байгаа юм шиг ёолон зүүдлэхэд чинь, би их айлаа. Чамайг «шөнийн ад» зэтгэрлэн багалзуурдсан биз ээ? Ад, харанхуйд гэр дээгүүр нисэж яваад, хүн алсан хүнийг тарчилган зовоох гэж өрхөөр орж ирдэг юм гэдэг гэхэд нь, Шаг, тэр охины бяцхан гарыг атгаж,

— Чиний наадах гарт чинь юу вэ? гэхэд нь,

— Ёо гэм! Тавиач! гэтэл,

— Гарт чинь юу байсан бэ? үзүүл гэхэд нь,

— Юу ч байгаагүй, би чамд тэргүүлэгч цэцэгт бахархан дурласан алтан гургалдайг дуулсан манай хөдөө газрын дууг дуулж өгье. Үгүй бол, толинд хятад гүнжийг харчихсан Перс хаан хүүгийн үлгэрийг ярьж өгье. Тэгэх үү? гэхэд нь, Шаг, Тэргүүлэгч цэцэг, хаан хүүгийн үлгэр аль нь ч надад хэрэггүй. За, хутганы хуйг оллоо. Чи яах гэж хутгатай миний дэргэд ирсэн бил ээ? гэхэд нь,

— Сал аа надаас! «Морио бүү зод, ханиасаа хагацдаг» гэж настан өвгөд сургадаг биш бил үү? гээд, Гюль-Жамал, гараа алдуулан зайлж

өгүүлрүүн:

— Эвий! Чи намайг алах нь ээ! Би чамаас айж байна гэж хоёр самбартай намхан хаалгаар гартал, чагнаж байсан хоёр шивэгчинтэй мөргөлдөв.

Шаг, амьсгаа давхцан, галын дэргэд очиж, үхрийн нүд мэт бүлтгэр нүдэнд нь улаан оч гэрэлтэж, хулсан савхаар зэс сав тогшмогц, хоёр самбарт хаалганы цаанаас ямаан сахалтай өвгөн зарц орж ирээд, Шагийн өмнө дөрвөн мөчөөр газар хүрч ёсолсонд,

— Саяын хүүхнийг орой хивст тасалгаанд аваач. Ордны дарга их везир сайд хоёр энд үү? гэхэд нь,

— Гэгээн эзэн минь, цөм энд байна. Жич, «шуудан» бичгийн дарга, бас гурван имам хүлээж байна гэхэд нь,

— Желал-Эд-Дин хаан, одоо болтол ирээгүй юү? гэхэд нь,

— Хаан төрийн түшиг хараахан ирээгүй гэхэд нь,

— Тэгвэл, цаадуул хүлээж байг. Угаалын тасалгаанд үсчнийг ирүүл. Сахлаа будъя. Угаалчийг, бас, ууц нурууны хуянг барь гэж хэл гэж тушаагаад зэргэлдээ тасалгаанд орсонд, жартгай улаан нүдтэй, хатангир бөгтөр нуруутай өвгөн зарц, дээр, хөвөнтэй хөнжлийг туурганы хажуугаар хурааж таталтал, хивсэн дээр нэг юм гялсхийхэд бөхийж, зааны ясан иштэй маш хурц иртэй хутга олж аваад, амандаа үглэн

— Туркмен хутга шив дээ, туркмен хүүхэн хэцүүеэ. Уур нь, хөдөлбөл, хар хорт аалзнаас аюултай улс шүү. Үүнийг ордны даргад өг юү, нуу юу? Өгөөд ч одоо яах вэ? Намайг хүн өг гаж шахаж байгаа юм биш гэж тасалгааг гатлах завсар, нөгөө өрөөнд Шаг, өргөн торгон өмдний тэлээг чангалан татаж, цүдгэр гэдсээ эрээн бүсээр ороож мөнгөн хуйтай хутга бүсэндээ хавчуулаад, таж магнаг булган нөмрөгөө нөмрөөд, туурганы хөндийгөөс маш сайхан ороосон цагаан чалма малгай гаргаж, бууралтсан үсэн дээрээ сурамгай тавиад, хаалганы дэргэд амьсгалаа барин, хутганы хүйтэн ишийг атгаж, түр чагнан,

«Болгоомжтой хүн, дайсны халдахыг хэзээд няцуулна. Ордны мухир тахир, харанхуй хонгилд, миний өшөөт дайсан багдадын халифын явуулсан Исмайлын алуурчин гэнэт халдан хорлох юун магад...» гэж чагнасхийгээд, сэмээр,

— Ордны дарга, энд байна уу? гэхэд нь,

— За, эзнээ, энд хүлээсээр байна гэжээ.

— Шаг, модон хөшүүрийг түлхээд, үүдийг нээсэнд хоёр тосон дэнгийн сүүмэлзэх гэрэлд шадар сайдууд мэхийн зогсож байв.

Шаг, шөнө хүйтэн болсон хатуу шаахайг холхиндог өмсөж, тэр тасалгаа дамжин нэг тасалгаанд ортол, зарц хүлээцгээж, нэг нь ваар дэн, зарим нЭг нь мөнгөн гадар, нэг нь нарийхан тахир хоолойтой бумба барьж, чулуун шалын нүхээр ус гарах угаалын газар угаал хийхэд нь үйлчилж, нэг зарц урт торгон алчуурыг гар сунган барьж, эзнийхээ цулцгар хөлд хээтэй унгасан оймс өмсгөв.

Хоресм шагийн хувцаслаж байх завсар, ордны дарга шинэ мэдээг сонсгон айлтгаж,

— Гадна маш хүйтэн, хамаг юм цагаан цан болжээ. Гурван имам, ордонд ирээд, зарлигийг хүлээж байна. Бас зандалчны дарга Жихан-Пехлэван мөн ирээд, хүлээж байна. Өчигдөр орой, булигаар нутгаас гурван зуун тэмээтэй худалдаачин, булигаар нутгийн сайран гутал, нэг зуун олзны оростой ирсэн гэнэ. Замд нь агшаасан будаа, гүнждийн тосоор тэжээсэн боловч, хоёр зуугаад нь үхэж гэнэ. Түүний өмнө аяны хүнийг туркмен дээрэмчин дээрэмдсэн гэнэ. Аанай Хар хончир биз гэхэд нь,

— Би Туркмений нутагт үнсийг нь хийсгэнэ. Гэвч хамгийн хэцүү нь Багдадын бадарчин нар юм даа. Багдадаас ирсэн араб Дервиш бадарчин үзэгддэггүй биз ээ? Тэд, цөм Багдадын халифын туршуул, цөм намайг хорлохыг хүсэцгээж бий гэхэд нь,

— Шашны их сахиулсан хаанд, ямар өөдгүй улс хор хүргэх гэдэг юм бол доо? гэхэд нь,

— Мусульманчууд нар цөм тийм болсон шүү гээд, Шаг хувцаслаж гүйцээд, хуучин замаараа байшингийн хонгил гудамжаар явж, эргэмэл чулуун шатаар өөдөө гарахад, өмнө нь ордны дарга, гартаа бамбар барьж, хаалга нээж, Шаг, ордны чулуун цамхгийн орой дээр гарав.

ИХ ИСКЕНДЕРТ МАГТУУ ХӨГЖИМ ӨРГӨВ

Хайст хэрмийн ёроол дахь тэгш талбарт хорин долоон залуу хаан Гүр, Газна, Балх, Бамьяан, Термесийн зэрэг мужийн эзний хүүхэд хавиргалан зогсож байв. Шаг, тэдний эцэг, феодал хаадыг бослого гаргуужин гэж, дэргэдээ барьцааны хүн болгож, чандлан харгалзуулдаг байжээ. Тэдгээр залуу, цөм хэнгэрэг, цахилзууртай хэц барьж, бас үхэр

бүрээ, зэс бүрээ, цан зэрэг хөгжмийн зэвсэг барьсан хөгжимчин зогсож, цаана нь Хоресмийн цэргийн хэдэн жанжин зогсоцгоож, Шаг гарч ирмэгц, бүгдээр,

— Шашныг хамгаалагч, буруу номтныг айлган дарагч, ялагдашгүй Падишаг урт насалтугай! гэж хашхирцгаахад, Шаг олныг хүйтнээр харж,

— Төмөр Мелиг бий юү? гэхэд нь,

— Жа, би энд байна гээд, аян дайнд Мухамедыг салалгүй дагагч, өндөр чилгэр биетэй, зугаатай Төмөр Мелиг, хоёр хүүхэд хөтлөн урагшаа гарч ирэв. Тэр хоёрын нэг нь Хоресм шагийн сүүлчийн эхнэр хивчаг хатнаас төрсөн отгон хүү, нөгөөдөх нь, Желал-Эд-Диний туркмен гэргийгээс гарсан ач нь ажээ.

Төмөр Мелигийг хүүхдийг Шагийн ойр зогсоцгооход, Шаг бөхийж, хүүгийнхээ хацрыг нь чимхэн эргүүлээд, ач хүүгээсээ хүйтнээр асуууруун;

— Желал-Эд-Дин хаан яасан бэ? гэхэд нь

— Аав, начин шонхроо авч, авд мордсон гэж хэлээд, жижигхэн хүү, цагаан чалма малгайн доогуур хар нүдээрээ сэрэмжилсэн маягтай харав. Шаг өгүүлрүүн,

— Төмөр Мелиг чи, морьтой хүнийг дөрвөн зүг мордуулж, Желал-Эд-Дин хааныг олж авчруул! Туркменчүүд, аяны хүн дээрэмдсээр байна. Хүүд минь халдаж болзошгүй гэхэд нь,

— Ерөөлт эзний зарлигийн ёсоор гүйцэтгэе! гэж Төмөр Мелигийн хариу хэлтэл, хүүхдийн хоолой мэт нарийхан дуу үүлнээс дуулдаж байгаа мэт, дээрээс сонстсон нь,

Сэрэмжтэй хүн сайхан аа!
Сэргэлэн сонор хүн жаргалтайяа!

гээд, сүмийн өндөр гонх, лааны адил тэнгэр өөд шовойн үзэгдээд, алсын уулын цаанаас гарч байгаа нарны ягаавтар туяанд орой нь гэрэлтээд, хотын байшин барилга, гэрэл тусаагүй бүдэгтэн үзэгдсээр байв. Залуу хаадын ахмад нь, Хоресм хэнгэргийг баривал, Мухамед өндөр дуугаар өгүүлрүүн:

— Их Искендерийн[18] алдар мандтугай. Ертөнцийг байлдан дагуулагч түүний алдар мандтугай! Искендер, Ираны бүх нутгаар Жейхун Зеравшан хүртэл шувт явж, бидэнд дуурайл болсон манай багш

юм аа. Алдар нэрийг нь хүндэтгэн, гурван удаа магтаал хөгжим өргө өө гэсэнд хэц хэнгэрэг нижигнэж, зэс цан хангинан, үхэр бүрээ бүдүүн дуугарч, үлээвэр нарийн дуугарч, баатар Македон эрийг гурван удаа ёслон, бүгд их чимээ шуугиан гаргав. Хөгжмийн чимээ намдаад, хүнгэнэсэн цуурай нь ордны өндөр цамхагт цуурайлсаар гүйцээгүйд, Төмөр Мелиг, өндөр дуугаар өгүүлрүүн;

— Бид сая Грекийн хоёр эвэрт малгайт их Македоны алдрыг хүндэтгэж ёслолыг гүйцэтгэв. Энх алдар нь мандаг даа. Тэр хүн, нас залуу учир, хийвэл зохихынхоо дөнгөж хагас хувийг гүйцэтгэжээ. Одоо бидний шинэ Искендер, их дайчин Мухамед жанжин, Хоресмийн их улсыг байгуулсан Мухамед эзэн мөн. Ислам улсын хүчит эзэн Мухамед Алла, Эд-Дин Шагийн нас төрийг Аллах өнө үүрд мандтугай! Их Шаг эзэндээ гурван удаа магтуу хөгжим өргө өө гэж хэлмэгц, дахин хэц хэнгэрэг цан нижигнэн, үхэр бүрээ сүртэй өтгөн дуугаар пар пар дуугарав.

Мухамед, хэнгэргийн дэргэд бодлого болж, айм сүртэй өргөн мөрөө тэнийлгэн зогсож, цасан цагаан чалма малгайт толгойд нь их бодлого орж байгаа шинжтэй зогсож,

— За, энх атугай. Одоо явагтун гэхэд нь алга хавсран, жижиг алхмаар Шагийн дэргэд цувран ирээд, дээлийн хормойд уруулаа хүргэж адис аваад, гэдрэг ухарцгаан шатны харлан үзэгдэх нүхээр буун гарцгаав.

Хамгийн сүүлд Төмөр Мелигийг хоёр хүүхэд хөтөлж одоход, Шагийн ач нь,

— Аав, надад амьд зээр авчирч өгнө гэхэд нь, нөгөө нь,

— Падишаг надад гөрөөчин ирвэс бэлэглэнэ гэсэн, тэр чиний зээрийг, бас могойн зулзага чамайг барьж иднэ гэжээ.

Тэндээс, Шаг, хайс дээр тохойлдож, доош үзвэл, олон байшингийн хавтгай орой, энд тэндгүй овооролдон харагдах бөгөөд орд нь олон намхан байшин хоорондоо дамжих хүзүүвчээр холбон холбосоор, нэг том, хамаагүй барьсан байшин болсон байдалтай үзэгдэж, манаяны цүрдгэр цамхагтай хуучин өндөр хэрэмтэй бөгөөд түүний дээр нь жад барьсан манаа, хөдлөлгүй зогсоцгоож байгаа нь, гэрэлтэй болж байгаа огторгуйд тодхон зурайн харагдав.

Шаг хавтгай дээвэртэй байшингийн дээр, суунаглан байгаа утаа униар татуулж, өглөөний нойрноос сэргэж байгаа их хотыг удтал харж, ордны нэгэн хашааны доторх өндөр хөгшин улиасны дэргэд байгаа

цагаан гэрийг үзвэл, дотоод ордны шинэ сувд эрдэнэ болсон улаан бор царайтай туркмен хүүхэн Гюль-Жамал, сая Шагийн тэндээс зугтан гүйж гарсан тэр хүүхэн сууж байгаа ажээ. Тэр хүүхэн ордны харанхуй танхим тасалгаанд дургүйцэж, аргалын утаа шингэчихсэн туркмен хүүхний яг адил, хөдөө бага наснаасаа сурсан зангаараа гэрт сууя гэж гэр тавиулаад "энхжиний" орны чимэг болсон бусад гуа хатны адил, дотоод ордонд суух дургүй ажээ. Биеэ засаж байвал зохихыг одоо хүртэл гүйцэд мэдэхгүй байгаа хүн шүү дээ гэж бодоод, тэгээд Шагийн Турхан хатан түүнийг нүдэндээ үздэггүй шүү дээ.

— Дэндчихсэн хүүхэн, эзэндээ халдах гэж байх. Одоо миний хайрт ирвэсийг хивст тасалгаанд дээрээс нь орж ирэхэд нь, чарлаж өнгөрөхийг чинь үзье дээ гэж бодов. Тэгтэл, доор, цамхгийн ёроолоос хашхирах чимээ гарч, өглөөний нам гүмд хашхирах үг тун тодхон сонсогдсон нь,

— Үнэн шашинтан, сонсоцгоогтун! Шаг Мухамед, Исламын суртлаас урваж, Аль шафи[19] таны тэрс суртлыг дагав. Буруу номтой хивчагаар биеэ тойруулж тэрсүүд Персийг дотнолдог болов. Эцэг нь, Текеш Шаг, шударга туркмен хүн байсан бүлгээ. Мухамед, Туркменийг хүн гэж үздэггүй болов. Түүнийг бүү итгэтүгэй гэж сонстоход.

— Тэнд хэн ульж байна? Ордны дарга чи, юунд горимгүй байдлыг үзсээр, зүгээр суудаг юм бэ? гэж асуухад нь, ордны дарга, Шагийн өмнө уучлахыг эрж байгаа мэт гүнээ мэхийн ёсолж өгүүлрүүн:

— Тэр цамхгийн зооринд хоригдсон Дервиш Шейхи Меж-Эд-Дин хашхирч байна. Тэр хүн, гяндангийн харанхуй гав гинжний алинаас ч айхгүй хүн юм аа. Чиний эрхэм мэргэн эх Турхан хатан, түүнийг онц нигүүлсэн үздэг байна. Тэр Шейхи, Падишагийн эсрэг ичгүүргүй үгээ ямагт донгоссоор байна. Өчигдөр, хотын бүх Дервиш, талд цуглаад, гянданд бүлэглэн очиж, зооринооос тэр тэнэг Шейхи Меж-Эд-Динээ суллана гэж андгайлан ам алдсан гэнэ билээ гэхэд нь Мухамед, ордны даргын мөрийг шүүрэн сэгсэрч, зандран өгүүлрүүн:

— Эргүү тэнэг чи, зандалчны дарга Жихан Пехлеванд бушуухан очоод, тэр урвагчийг чанга гарт тушаалга гэж хэл. Ухаангүй Дервиш гүйж ирээд, суллан тавихаас нь урьдаж, учрыг нь ол гэж хэл гээд, цамхгаас бууж, туургыг улаан цэмбээр бүрсэн бараалхлын танхимд оров. Тэнд Падишагийг гурван имам хүлээж байгаа ажээ. Шаг, үүдний дэргэд шаахайгаа тайлж тасалгааны дунд очиж, хивсэн дээр суугаад,

цогтой хоовон тавьсан нүхийг бөглөсөн хөвөнтэй торгон хөнжилд хөлөө шургуулаад, гурван имамын зүг хандаж,

— За, багш нар минь, ойртон ирж суутугай! гэсэнд хивсний захад өвдгөө нугалан сууж байсан гурван имам ойртон очиж, тал өгөх үгийг арабаар амандаа шивнэн, Шагийн дэргэд сууж хөлөө, бас, хөнжил дор шургуулсанд Шаг,

— За, эхэлнэ үү? Би ислам газрын хамгийн хүчит эзний хувьд Багдадын Халифыг надад захирагд гэж шаардах минь зөв үү? Бас Халифыг эс дагахад яадаг бил ээ? Үүнийг тайлбарлан сургах ажаамуу? гэсэнд, имамууд авч явсан хуучин том судар дэлгэцгээн, Коран ном дотроос ээлжлэн, өндөр дуугаар эш татаж, Хоресм шаг Мухамед бол дэлхий дээр Аллахын дараа орох, дээд эрхийг барих эзэн мөн тул, хэзээд зөв буулгасан зарлиг, хэлсэн үг нь ариун бат гэх зэргээр тайлбарлав.

Тасалгаа харанхуй, бүдэг гэрэл, гагцхүү туурганд адар тушаа гаргасан дүгрэг гэгээвчийн сараалжаар тусаж, хүрэл тавиуртай дэнгийн сүүдгэнэсэн гэрэл, тасалгааг сүүмэлзэн гэрэлтүүлж байхад, имамууд, судрыг харалгүй, араб ном цээжээр эш татан уншицгааж, Шагийн ар талд буурч тушаалт, зоогийн сайд, ихэрхэг байдалтай зогсож, ганц үг хэлж, хөмсөг хөдөлгөх төдийгөөр зарц нарт тушаалаа өгч, хивс дээгүүр чимээгүй явах зарц нарыг захирч байв. Сөнч сайд, их тогооч далай замаас, мөнгөн тавагтай идээ авч, сайд ноёд Шаг эзний хишиг хүртэх гэж бөөгнөрөлдөн, үүдийг шагайн үзэгдэв. Хамартаа мөнгөн цагаригтай хар арьст боол, Шагийн өмнө намхан өргөн ширээг хөнжил дамнуулан тавиад, буурч сайд, достархан гэдэг торгон бүтээлгээр маш чадамгай бүтээв.

Сөнч сайд, Шагийн өмнө мөнгөн аягатай хонины өөхөн тос, давс хольж самарсан халуун цай, өөх шигтгэн хайрсан нимгэн бин, хайлуулсан шар тос, зөгийн бал, зөөхийтэй сав ширээн дээр өрөв.

Шаг, имамын үгийг сонсож, цай ууж, бин идэж суусаар, хоовонд жигнэгдэж, цай уусандаа дулаацаж, бие нь талбираад, бэлтгэн тавьсан дэрийг дэрлэн хурхиран унтчихсан нь, имамын тайлбарыг таалсны тэмдэг ажээ. Бүгдээр чимээгүй гарч одоцгоов. Достархантай ширээ, зарц нар цөм алга болж гагцхүү хар арьст боол, үүдний дэргэд цөмцийн сууж, ислам газрын, их эзний найраас сэрэхийг хүлээн үлдэв.

ХИЛЭНГИЙН ЭЗЭН

Гурганж хотод өргөн чөлөөнд Шагийн ордны дэргэд байдаг «үүрд умартахын цамхаг» гэдэг өндөр бөгөөд нүдэнд хүйтэн цамхгийг мэдэхгүй хүнгүй билээ.

Төмөрлөсөн намхан хаалга нь том цоожоор цоожлоостой, түлхүүр нь зэвэрсэн богино жадаа тоосгон хэрэмд түшүүлэн, шатны гишгүүр дээр суудаг, манаачийн хүзүүнд зүүлттэй байдаг байжээ. Манаачийн өмнө, хивсний өөдсөн дээр замын хүн, модон аягатай ээдмэг, боорцог, багц сонгино, атга зэс зоос зэргээр хоригдолд өглөг өгдөг байжээ. Манаач, заримдаа, юм ихээхэн өгсөн хүнийг цамхгийн дэргэд ойртуулж ялтантай яриулдаг байжээ.

Цамхгийн дор сарааλжтай хэдэн дүгрэг нүх харлан үзэгдэж, зоорь дотроос бүдэг дуу сонстон, ялангуяа, зоорины хажуугаар өнгөрөн гарах хүний хөлийн чимээ сонстоход бархирах нь улам чанга болж, нүхнээс хий самардаж байгаа яс арьс болсон гар цухуйн үзэгддэг байлаа. Толгойгоо онгосон цэнхэр даавуугаар ороосон, зурвас алаг дээлтэй хөдөөгийн хүн, цав цагаан том малгайтай молда лам, манаачид зоос хаяж өгөөд, үг дуугүй тэр хэрмийн нүхэнд ойртоод, төмөр сарааλжны завсраар сарвайсан хар хир болсон туранхай гарт талх түгээн өгдөг байжээ. Тэгэхэд нь сарааλжны цаанаас чимээ улам ихдээд, цонхонд хүрч чадахгүй, хоцорч байгаа хүний хараах хашхирах нь сонстон,

— Харанхуй тамынханд юм хайрла аа!

— Хуучин цамц байвал хайрлана уу? Бясаа хувалзад бариулж үхлээ!

— Ёо ёо, нүдэн дээр минь гишгэчихлээ гэж хашхиралддаг байжээ.

Нарийн гудамжны цаанаас олон хүний дуу сонстон, удалгүй, талбар дээр өндөр халбан малгайтай, урт таяг барьсан Дервиш, өндөр дуугаар ном уншицгаан гарч ирээд, зарим сониучхан хүн, тэдний хойноос дагаж явтал, Дервишүүд гяндангийн хаалгыг дайран, чулуу таягаар цоожийг эвдэх гэж цохин, зарим нь зоорины нүхээр шагайн, өндөр дуугаар,

— Шейхи Меж-Эд-Дин Багдад, чи амьд байна уу? Шашин ном, үнэн ёсны төлөө тарчлан зовсон чамайгаа магтан өргөмжлөх гэж ирлээ. Бид одоо чамайг суллана гэж хашхирцгаахад, зоорины дотроос

уртаар татаж хашхирах дуу сонстоод олон цөм чих тавин, дув дуугай чагнавал,

— Ард олныг хяхан дарлагч харгис хаадыг Аллах тэнгэр зүхэх болтугай! Халифын өөдөөс мэс барьсан бүхнийг хилэгнэх аянга ниргэтүгэй! Дээрэмчин зандалчин бүхэн сөнөтүгэй! гэсэн үг сонсогдтол Дервишт түрэгдсэн манаа, ордон тийш гүйж, тэндээс морьтон хивчаг, хар хурдаар давхилдан, цугласан олныг ташуурдаад, Дервишүүд хашхиран зүг бүр тархан гүйцгээв.

Ордны хүрээлэнгийн өндөр хаалган дээр хэрмийн хайсны завсар хэдэн хүн үзэгдэж, өндөр биетэй улбар эрээн дээлтэй нэг нь өмнө зогсож, бусад нь дув дуугай, алга хавсран, түүний тушаахыг хүндэтгэн хүлээж байв. Энэ бол Хоресм шаг, ордны хэрмийн хаалга дээр гарч ирсэн байжээ. Хүнийг цаазаар аваачихад тэгдэг тул, энэ удаа Шагийн бие тэгж гарч ирсэн нь, сайныг зөгнөсөн шинж биш байжээ.

Хэрмийн хаалганаас, Шагийн зандалчин, хос хосоор жагсан гарч, цөм хөх цамцтай, ханцуйг мөрөндөө шууж, улаан утсаар оёсон угалзтай өргөн шар шалбуур өмд өмсөж, бяр хүчтэй, сүртэй бөгөөд мөрөн дээрээ хорасан газрын том илд тавьж цугласан хүмүүсийг ухруулан, талбарт хүрээлэн зогсов. Тэдний хамгийн сүүл «хилэнгийн эзэн» гэдэг цолтой Махамед Жихан Пехлеван, монголчилбол, газрын бөх гэгч хүн, бие эцэнгэр өндөр, нуруу бөгтөр, гарыг дэлгэн, дээлээ шар илгэн шалбуурт хормойг хийж, өргөн суран бүс бүслээд, хивс уутанд чухал ялтны толгойг Шагт өргөх гэж мөрөвчлөн явж байгаа нь, хүнийг багалзуурдан алдаг амьтан гэж алдаршсан хүн ажээ.

Талбарын дунд дөрвөлжин нүх харлан үзэгднэм бөгөөд хажууд байгаа нэгэн индрийн дэргэд хөндлөвчтэй дөрвөн багана зоолттой үзэгдэн, хоёр нүцгэн шахам боол, гинж хангинуулсаар том бургасан саг авчирч индрийн дэргэд тавив.

Гяндангийн манаач, гяндангийн төмөрлөсөн намхан хаалга нээсэн хойно зандалчны хэдэн туслагчийн хамт нүхэн гянданд ороод, тэндээс гэнэт тэсгэлгүй бархиран чарлах чимээ сонстоод, төдхөн чимээгүй болж, зандалчин, тэр нүхэн дотроос арван таван хоригдлыг гаргав. Үзвэл, баруун хөлийг цөм нэгэн гинжээр холбон гинжилжээ. Буртагт дарагдсан, удтал хоригдсоор сахал үс нь ширэлдэн ургасан, уранхай навтархай тамтаг болсон хувцастай хоригдол, удтал харанхуй зооринд сууж байсан тул, нарны гэгээн гэрлийг харж чадахгүй гялбаж, бие биеэсээ зууралдан талбарын дундуур гэлдрэн явцгаатал,

гяндангийн хаалга тас хийтэл хааж, том цоож өлгөв. Нүхэн гяндангаас орилох, чарлах дуу үргэлжлэв. Сахих цэрэг, цаазаар аваачих, тушаа гавтай хоригдлын хоёр талаар хашин дагаж явтал, ширэлдсэн үстэй нэгэн их наст, тэнхэл буурай өвгөн бүдрэн ойчиж, дэргэдэх хоёр нөхдөө унагаасанд, занчин босгож, элдэн хөөсөөр хороох газар аваачиж, индэр дээр сөхөргөн суулгаад, нэгэн зандалчин, алах хүний үснээс шүүрээд их зандалчин хоёр гараар дам илд далайн өргөж нэгэнт цавчмагц, амьсгалаа хурааж чимээгүй зогсон байгаа олноо, тас цавчсан толгойг үзүүлээд бургасан саван дотор чулуудаж, цаазаар аваачихад цугласан хүмүүс Шейхи-Меж-Эд-Дин Багдад аль нь вэ? гэж бие биеэсээ асууцгаах боловч, өлсгөлөн, өвчин хоёрт баригдаж туранхайлан эцсэн ялтны дотор тэр гэж танихын аргагүй ажээ. Арван дөрөвдүгээр хүний толгой ойчмогц, талбар дүүрэн, Падишаг үг айлдаж байна. Падишаг зарлиг болов гэх өндөр дуу сонсогдсонд, бүгдээр тэргүүнийг эргүүлж ордны хаалганы зүг харцгаавал, Хоресм шаг, эрээн алчуураар даллаж «цаазлахаа зогс. Алах ялаас хэлтрүүлэв» гэж байгаа ажээ. Их зандалчин, цус болсон урт илдээ улаан даавуугаар шувтран арчиж, «төмрийн дархныг авчиртугай» гэж хашхирав. Цаазаар авхуулахаар ирсэн арван тав дахь хүн нь өөр хүн биш, өнөөх Юсуф гэдэг өвгөн бичээчийн шавь Туган ажээ. Нас бага хүүхэд тул юу ч болж байгааг сайн мэдэхгүй, дэмий л нүдээ бүлтийлгэн зогсож байтал,

— Падишагийн их хишигт мөргө гэж зандалчин, түүнийг ордны зүг эргүүлэн, газарт тонгойлгон мөргүүлж барсан хойно засаж бэлтгэсэн төмрийн дархан, Туганы хөлийн гинжийг салгав. Туган хөлдөө гинжгүйг үзээд, индэр дээрээс үсрэн, олон хүний дунд шурган оров. Төмрийн дархан яаран дуудруун,

— Байз, байз чи хаачих нь вэ? Болоогүй шүү гэвч, Туган дуу чимээ гаргахыг сонсоод нуруугаа бөхийж, бушуухан зайлах гэж олны завсар чихэж шургалав.

Түүнээс, гяндангийн орчим тийш талбарт хүн амьтангүй болсон хойно манаач, зэвэрсэн жадыг тулж үүдний дэргэд зогстол, урт алчуураар нүдэндээ хүртэл нүүрээ ороосон нэгэн бяцхан охин, хэрэм дагаж гүйсээр, цамхгийн доорх нүхний дэргэд очоод аяархан Тугаан! Зэвсгийн дархан Тугаан! гэж дуудав. Нүхнээс туранхай хатангир гар цухуйж, нэг хүн сөөнгө хоолойгоор,

— Чиний Тугаан толгойгоо авхуулсан. Бидэнд идэх юмаа өг. Түүний хойноос маань унш аа гэхийг сонсоод, өнөөх хүүхэн, нүхний

дэргэд улам ойртож бачимдсан дуугаар хашхиран асууруун:

— Тугаан чи амьд байна уу? Дуугараач гэхэд газар дороос орилох чарлах дуу дахин сонстож,

— Авчирсан юмаа бидэнд өг өө! Одоо Тугаанд чинь юу хэрэггүй. Тэр чинь одоо энхжиний оронд их богдын хамт жаргаж байгаа биз гэсэнд, охин, юм гуйж байгаа гарт авчирсан талх, амтайхан гуаг өгөөд, манаачийн дэргэд очиж,

— Назар баби, Тугаан хүү үхсэн гэх нь үнэн үү? гэхэд нь,

— Цаазаар аваачих хүнтэй хамт авч явсныг бодвол, үхсэн биз ээ гэж талбар өөд заан харуултал, нэгэн хөгшин Дервиш, манаачийн гарт хэдэн зоос хийж, чихэнд нь шивнэн асууруун

— Цаазаар авхуулагсдын дунд манай хутагт Шейхи Меж-Эд-Дин Багдад үл үзэгднэм. Цаазаар аваачихыг хойшлуулав уу? эсхүл Хоресм шаг хэлтрүүлэв үү? гэхэд нь манаач зоосоо бүсний хуниасанд далдлан хийгээд, амандаа бавтнан өгүүлрүүн:

— Сонсвол, дээд эзэн Шейхид ихэд хилэгнэж Дервиш ирж булаан аваачихаас өмнө хурдан цаазаар аваачих хэрэгтэй гэж сонссон гэхэд,

— Одоо Шейхи амьд уу? гэвэл,

— Хаанаас даа. Их зандалчин Жихан Пехлеван алах хүнийг гаргаж байх үеэр өөрөө Шейхийг багалзуурдаж алсан... гэв.

ШИДЭЭСТЭЙ СҮҮДЭР

Учирсан хүнээ сайн үгээр
Баясуулахыг шамд.
Уулзахгүй ч байж юуны магад.
(Дорно дахины сэцэн үг).

Тэндээс Тугаан, олны дундаас гарч шавар хэрэм ханаран зэрэглэсэн үймээн шуугиангүй гудамжинд орж, яв явсаар шуудууны хажууд хүрч ирлээ.

Овоолттой өндөр эргийн дундуур булингартай ус аажмаар урсаж баглаатай юм модны гишүү, өвс овооролдсон, ачсан урт болхи онгоц чимээгүй хөвөн явахыг үзээд Тугаан дотроо сэтгэрүүн: «Ийм онгоцоор харь газар аялан явах юм сан. Уранхай нооронхой цамцтай шарх сорвинд идэгдсэн бузар булай намайг хаанаас хавьтуулах аж!» гэж бодоод эргийн хавьд элстэй газар шарлан харагдахыг үзээд, тэнд очиж

хувцсаа угаасны дараа биеэ угааж наранд шарж хэвтэхдээ элдвийг бодож гиюүрэн,

«Гяндангаас тавигдсан үхэх ялтан би, хаа явах бил ээ? Хэн намайг ажилд авах аж, хот багадаж, хүн олдож, амьтан бүр ажил хийж аяга будаа олж, амиа тэжээхийг бодоцгоон хэцүүеэ гэж элдвийг сэтгэх зуур «үхтэл нь үүрд» гэдэг бичээстэй цагаригийг хөлдөө байхыг хараад манай өвгөн бичээч Юсуф гяндангаас гарсан хүнд ялтай хүнтэй үг ярих дургүй биз. Харин ганц Бент-Занкижа намайг өрөвдөх магад. Би энэ уяман өвчтэй хүн шиг яр шарханд бариулчихсан хэвээр хэрхэн түүний өмнө үзэгдэх билээ? Юу ч болсон, гэрийн эзэн Кари-Максумынд очъё, тэр хүн энэ цагаригийг салгаж чадна гээд босож, урт гудамжаар өнгөрөн явахад үзвэл, гудамжны хоёр талд байгаа дэлгүүрт хивсээр бүрхсэн сандал дээр худалдаачин сууцгаан, барааг нээлттэй үүдний дээр өлгөж туурга дагуу тавьсан жааз дээр хураажээ.

Гудамжны дээгүүр чийрс тавьсан тул нарны гэрэл нэвтрэхгүй сүүдэртэй. Нарны нүд гялбам гэрэл ташуу тусахдаа энд нэг ягаан ногоон мяндсан утсаар хээлэн угалзалсан хос шар гутал тэнд коран номоос эш татсан мөнгөн үсэг товимол дүгрэг төмөр бамбай энд нэг чонон малгайтай хөдөөгийн хүн, тэнд нэг бүлэг эрээн мэрээн хувцастай эхнэрүүд алаг бөс торгомсгийг худалдаачны дэлгэн үзүүлж байгаад нь тусаж байв. Төмөрчний захад Кари-Максумын дархны газар хамгийн захад нь байдаг байжээ. Төмөрчний захад алх балтын цохилох, төмрийн хангинах нь зүг зүгээс сонстон, олон дархан, тахир сэлэм, охор хутга, жадны гилбэр зэргийн зэр зэвсэг хийж, перс орос боолчууд, өргөн өмд, дан ганц шалбууртай, элгэндээ сацуу цоргиулсан арьсан хормогчтой ажиллаж, дөшин дээр тонгойн, зэс төмпөнд бяцхан алхаар уран хээ угалз товин цохиж, зарим нь улайссан төмрийг амьсгалаа шихнэтэл түрэн, төмрийг хүнд лантуугаар лантуудаж, хар хөө болсон эрэгтэй хүүхдийн зарим нь хөөргөөр хясааны цог хөөрөгдөн, зарим нь шуудуунаас модон хөнөгөөр ус зөөж, дархны газрын эзэн Кари-Максум гэдэг өргөн мөртэй, буурал сахлын үзүүрийг улаан будгаар будсан бүдүүн тарган хүн, хивсний өөдөс дэвссэн шавар хашаас дээр суугаад, ажилчныг аашлан, дэргэдүүр нь ёслон өнгөрсөн хүнд хариу, самбаачлан ёсолж, хажууд нь хоёр боол дархалж байв. Залуу нь духан дээрээ тамгатай, оргох гэзд тэгүүлсэн байжээ. Нөгөө хөгшин нь тортогт даруулсан юу ч хайхрахгүй болсон царайтай ажээ. Хоёул бяцхан алхаар төмөр утсыг жигдхэн гэгчийн цохилж, их нарийн

ажил хийж байгаа нь галд уяруулан улайтгахгүй хүйтэн төмөр давтаж, алдарт мисир болд давтаж байв. Төмөрчний эзэн Тугааныг үзээд,

— Чи юунд энд ирэв? Буц, гянданд хоригдож байсан хүнд ялтныг энд ажиллуулна гэж санав уу? гэхэд нь,

— Та надад ядахдаа алхаа өгнө үү? Би энэ төмөр гархинаас хагацъя гэхэд нь,

— Ээ, чиний ялтны гараар алхаа бузарлуулахгүй юм сан, хавчуураар шавхуурдахаас өмнө үтэр тонил гэсэнд Тугаан арга буюу цээж дүүрэн хорсон тачаадаад, тогтоосон газаргүй тул толгой хазайсан зүг явах гэж бэлхэн байв.

Алмайран зогсож байтал, хэрмийн ёроолд сууж байсан нэг Дервишийг ширтэн харвал нарны гэрэл чийрсэн саравчийн нүхээр тусаж, Дервишийн өмссөн өнгө бүрийн үртсээр зүйж, нөхөөслөн оёсон дээлд нь тусаад, Дервиш, амандаа аяархан ном уншиж, том гэгчийн тэвнээр дээлийн ханзарсан хөх, улаан, ногоон нөхөөсийг оёж сууснаа, Тугааны гомдон бачимдаж, биеэ ганзагалан зогсоход хар сүүдэр нь Дервишийн өвдөг дээр туссанд, Дервиш өгүүлрүүн,

— За хүү минь харав уу? Би сая дээл дээрээ нэг шинэ нөхөөс тавьсан нь намайг дээлийн нөхөөсийг оёж байтал, чиний сүүдэр тусаж, нөхөөсөндөө сүүдрийг чинь тэвнээр шидэж орхилоо. Одоо, чи надтай хэлхээтэй болж, миний хойноос сүүдэр мэт дагаж явах болно доо гэхэд нь, Тугаан даруй Дервишийн дэргэд ирж суугаад, өгүүлрүүн:

— Чи үнэн хэлж байна уу? Наадаж байна уу? Би чиний тушаасан бүхнийг гүйцэтгэж, чамайг үйлчилье. Ганцхан чи намайг бүү гадуурхан түлхээрэй! гэхэд нь Дервиш, толгойгоо сэгсрэн,

— Чамайг их зантай, гэрийн эзэн хөөж байхыг сая сонсов. Чи юунд ийнхүү гуниглах вэ? Орчлон цухал болсон гэж үү? Чи миний нөхөр бол, хоёул эндээс «эрхэм Бухар» хүрч очно. Хөөгдөж байгаа энэ газар байгаад юу хийх вэ? Далласан хүнийг итгэн дага, чи нэгэнт Дервишийн нөмөрт шидээстэй болж, одоо бядан тэнүүчлэх цаг чинь ирж. За дүү минь намайг дагаад яв гээд таягаар газар түг түг гэж явахад нь хойноос нь тамирдсан Тугаан явж гэлдрэв. Хэдэн төмөрчнийг өнгөрөөд гудамжны өнцөгт зогсоод бяцхан талбар дээр, хөө тортогт даруулчихсан тэнэмэл дархны гар хясааны дэргэд бөгцгөнөн ажил хийж байхыг харав. Тэр дархны бие маш туранхай, арьсаар хучсан амьд хэлхээ яс шиг хүн байв. Тэгэвч нав нарийн гар нь сурамгайгаар хөдөлж алх бахь хоёроор барин дөшин дээр жижигхэн

хар хадаас хийж, бал болсон хадаас нь устай модон савд хойно хойноосоо цувран унаж байв.

— Дархан авгай, энэ хүүхдийн маханд гэм болохгүйгээр, энэ төмөр цагаригийг салгаж чадах уу гэж Дервишийн асуухад,

— Хоёр хар дирхем өгвөл хийе гээд, цагаригийг үзмэгц гяндандаа төмрийн сайныг гинжиндээ хэрэглэдэг юм байна даа. Чи дахиад нэг мөнгөн дирхем нэмбэл, би энэ цагаригаар сайхан гэгчийн хутга хийж өгье гэхэд нь Дервиш, бүсний цаанаас хэтэвчийг гаргаж мөнгөн зоос үзүүлээд,

— Тэгье, гагцхүү тэр «үхтэл нь үүрд» гэдэг үсгийг хэвээр нь үлдээгээрэй гэхэд дархан өвгөн аман дотроо тэгье гээд, Тугааныг түлхэж, дөшин дээр хөлөө тавь гээд бас сэмээр шивнэрүүн:

— Шагтай, зандалчинтай нь үхтэл нь үүрд тэмц гэв.

ӨГӨӨМӨР

Эрхэм Хажи-Рахим, таягаа тулж, Гурганжийн их зээлийн нарийн гудамжаар явахад, гялалзтал арчсан, элдэв янзын хэсэг угалз сийлсэн, зэс сав төмпөн, гадар хумхын зах, бас сийлбэрт зэс дэнлүү, ваар сав, таваг аяганы зах, цэнхэр цагаан хоёр өнгөтэй хятад нарийн сав шаазангийн зах, сайхан дуутай ирак шил савын зах, элдэв зүйлийн ховор сайхан үнэртэн амттаны зүйлийг худалдаалах тусгай захаас сайхан үнэр ханхалж байв. Тэнд Тангад гишүүнэ, сарнай цэцгийн тос, тосон туулга, арьс буйл ходоодонд тустай марз өвсөөр нухаж хийсэн хөөсрөх нунтаг, халуун усанд бие угаахад хэрэглэхээр үнэртэнтэй хольсон үнэтэй шороо, үсийг агшин зуур унагаагч перс ногоон наанги шороо, үс тогтоогч бухаар тос, төвөд заар, энэтхэг гиваан, мэнэрүүлэн согтоогч гашишийн хар үрэл зэргийн зүйл бүрийн юм худалддаг байжээ.

Захыг үерийн ус мэт дүүргэсэн олны дундуур цуван явахдаа Хажи-Рахим, бадар баригчид яваа юм шиг, дэлгүүрийн өмнө зогсоцгоон худалдаачин бүрийг хүн хайж яваа юм шиг ажиглаж явав. Бөс цэмбийн захад хүрвэл, ихэрхэг байдалтай завилан суусан худалдаачин зэс зоос хаяж өгөөд,

— За, мөрөө хөөгөөд яв гэж Дервишийг «симчуж» гэдэг мөнгөлөг торго, сурвалжит их Беги ноёдод бэлэглэн өргөдөг үнэтэй алтан хоргойд гараа хүргэх вий гэж айдаг байжээ. Хажи-Рахим, тэр

захаар явсаар, эрж явсан хүнтэйгээ төсөөтэй нэг хүнийг олж үзвэл, тэр хүн торгон олбогоор түшүүлэн, олон худалдаачны дунд сууж, туранхай цанхир царай нь Самаркандын цаас мэт нимгэн цайвгар болж, хар нүд нь ёнхойсныг үзвэл, хүнд өвчин тусаж тун сая илаарь болж байгаа шинжтэй. Дэргэд нь байсан худалдаачин, хүндэтгэн сувилж, бүйлсний идээтэй боорцог, балд чанасан боов, самар, чавгаар хүндэлж, тэр хүний өмссөн нь их үнэтэй цайвар саарал унгасан даавуу дээлтэй, эрээн торгон ороомол турбан малгайтай ажээ. Цэнхэр өнгөтэй хятад шаазан аягатай цай бариад, ядам хуруунд нь биед сайн гэдэг том оюу шигтгээтэй бөгж гялалзан үзэгдэв.

Дервишийг дэлгүүрийн дэргэд зогсоход тэдгээр худалдаачин хэдэн зоос хаяж өгсөнд явахгүй дув дуугүй зогсоод байжээ.

— Чамд мөнгө өгсөөр байтал, явахгүй яасан юм бэ? гэж хөөхөд нь сайх өвчтэй худалдаачин хараад хар нүдээ гайхсан мэт бүлтийлгэн,

— Чи надаас юу хүсэв? гэж асуужээ.

— Хүнээс сонсвол, чамайг чадалтай хүн юм. Газар сайгүй аян арилжаа хийж олныг үзсэн гэдэг, надад нэгэн юмны хариу хэлж өгөхгүй юү? гэхэд нь,

— Хэрэв чи надаар ариун ном тайлбарлуулахыг хүсвэл, надаас эрдэмтэй улем хутагт имам нар энд маш олон шүү. Худалдаачин би мөнгө тоолж, цэмбэ хэмжихээс өөр юү ч мэдэхгүй гэхэд, бусад худалдаачин хашхиран өгүүлрүүн:

— Хутагт Дервиш ээ! Одоо яв аа яв. Бид чамд чадлын хэрээр өглөг өглөө. Одоо болно гэж, Дервишийн бадар аяганд бүйлсний идээтэй боорцог самар нэмж хийж өгсөнд, анзааралгүй өгүүлрүүн:

— Эрхэм худалдаачнаас асуух үг, эрхмийн биетэй холбогдолтой юм. Тэгээд, би хариу сонсохыг хүснэ гэхэд нь,

— Тийм болбол хэлтүгэй гэхэд нь,

— Чамтай гашуун зовлон хүнд ундаасах өлсөхийг хамт эдэлж, бөгнөм халуун, тэсгэм хүйтнийг хамт хүлцэн дагаж явсан нөхөр бий юү? Чи тийм хүнийг эрхэмлэж үздэг үү? гэхэд нь,

— Тийм хүнийг яалаа гэж эрхэмлэхгүй байх вэ? Цааш нь тэгээд юү вэ? гэж худалдаачны хэлэхэд, Дервиш, олны зүг харж,

— Эрхэм та, өглөө бүр баясгалантай, таны унд бүр амттай болж, цэнгэлдэн жаргах болтугай! Эд уурсаар баялаг, ааш зангаар эелдэг, гэр орон, тансаг сайхан цэцгийн хүрээлэн, үзэсгэлэн хурим найрын хундага үргэлж бялхам дүүрэн байсан, энэ биеийг үзнэ үү? Заяаны

хилэнт ташуурыг биеэс зайлуулан чадалгүй, гай дайрах атаатны хорлохоос зайлж чадсангүй, хар зовлонд ташуурдуулж хөөгдсөөр гар хоосон, орон сууц ханхай хөндий болж, цэцгийн хүрээлэн минь гандаад, найрын нөхөд минь сарниж билээ. Байдал хувиран өөрчлөгдөж, сэтгэл санаа минь шаналан зовоод, гэдэс минь ардаа наалдаж, зэвхий царайг минь сэргээгч нойр хүрэхгүй болж, ганц нөхөр үлдсэн нь намайг хавчил хөндийгөөр гэр хийж хад чулуугаар дэвсгэр хийж, өргөст сундуу гишгэн тэнүүчлэн явахад минь дагасаар алдарт Багдад, Мекке балгасанд хүрч үргэлж миний хүчийг хэмнэн хөнгөлж, богцыг минь авч яваад, жихүүн шөнө намайг дулаацуулж явдаг юм сан. Аз дайрах өдөр тохиолдохгүй түдсээр намайг Хоресмийн баян талыг хүрэхэд, гэнэт нөхрөөс хагацуулах гай гарч, одоо би орох оронгүй, үгээгүй гуйлгачин боллоо гэхэд нь өвчтэй худалдаачин асууруун:

— Чамайг яагаад хань нөхрөөс чинь хагацуулсан юм бэ? Их богдын мэндэлсэн газар хүрсэн түүний бие, бадарч Хажийн тэмдэг цагаан малгай өмсөж болох байж л дээ, тэр чинь. Дархан та хоёрыг хэн аймшиггүй хохируулан гомдуулсан бэ? гэхэд,

— Нэг худалдаачнаас болж хагацсан юм аа гэж хэлмэгц,

— Тэр ямар худалдаачин юм бэ? гэж асуув.

— Би хувь муутайн адаг нь боловч, дээрэмчинд шархдаад, асрах хүнгүй хөсөрдсөн бүр ч хувь муутай нэг худалдаачинтай дайралдсан билээ. Би чадлаараа сувилж, шархыг нь боож өгөөд, Гурганжид хүргэж өгөх санаатай яваад, алтан шонхорт пайзыг нь хүртэл хадгалсаар байна гэхэд нь, чих тавин сонсож байсан худалдаачин, гэнэт хирдхийн цочиж, үгийг таслан,

— Одоо боль боль, тэгээд яасныг мэдэж байна. Тэр хүн би мөн шүү дээ. Чиний ачийг хариулах гэж аль хэдийн эрсээр бүлгээ. Чиний саяын хэлдэг сайн нөхөр гэдэг чинь хэн гэгч вэ? Би түүнийг аюулаас аварч чадахгүй юм болов уу? гэхэд нь,

— Миний тэр нөхрийг ганц чи олж өгч чадна. Тэр миний энд анахай шиг ардаа сүүлтэй учраас Хажи нэр зүүж, цагаан малгай өмсөх эрхгүй хөөрхий юм аа. Миний илжиг юм шүү. Цөлөг (мужийг тэр үед захиргааны талаар хуваасан хувиар)-ыг ховдог засаг ноён чамайг эмчлүүлнэ гэж хоцроохдоо илжгийг минь булаан авсан билээ. Чи надад бас нэг илжиг өгвөл миний хүсэл ханах нь тэр гэхэд нь,

— Чи илжгээ аваарай. Би Хакимаас илжгийг чинь авсан. Одоо энд хашаан дотор бий. Сонсов уу? Илжиг лав чиний ирснийг мэдээд

баярлан орилж байх шив. Энэ ч бага хэрэг. Одоо чи энэ дэлгүүрт байгаа бараанаас сайн хувцас, савхин гутал, бөс даавуу аль дуртай, юу хэрэгтэй бүхнээ ав гэхэд нь:

— Би бадарчин Дервиш хүн, надад бүдүүн ноосон нөмрөг бий. Түүнээс илүү юм хэрэггүй. Харин миний нүцгэн шахам сүүдрийг хувцаслаж өгнө үү? гэж хишгээс чинь хүртэхийг хүснэ. Сүүдэр намайг хаа явсан газар даган явавч, туранхай биеэ халхлах хувцасны тамтаг ч үгүй болжээ гэхэд нь худалдаачин инээлцэн бид хэрхэн чиний сүүдрийг хувцаслах вэ? Дандаа хошигнодог ямар бадарчин бэ? гэхэд нь,

— Та нар үз, тэр зогсож байна гэж Дервиш туурга түшин зогсож байсан гуйлгачин хүү Тугааныг заав. Өвчтэй худалдаачныг үзээд алгаа ташихад нь, удалгүй нэгэн зарц ирсэнд өгүүлрүүн;

— Хасан энэ хүүхдийг бэлэн хувцас худалддаг дэлгүүрт дагуулан аваачиж, алс замд аялан явах хүний дүрмээр хувцаслаад ир гэхэд, зарц асууруун:

— Бүрэн хувцаслах уу?

— Өвч бүрэн хувцасла. Энэ хүүхэд дээл, цамц, өмд, оймс савхин гутал, бүс, малгай бүгдийг авч өг гээд Дервишийн зүг харж, бас өгүүлрүүн: Эрхэм «Бядан явагч» өнөөдөр орой манайд очоорой. Хасан манай гэрийг зааж өгнө гэв.

Төдий, Хасан Дервиш хоёр эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхдийн элдэв янзын хувцас дэлгэсэн дэлгүүрт ичгүүрэн зовсон Тугааныг дагуулж очоод, хувцас авч өгөхөд, аль гоё сайныг авах гэтэл, Дервиш аянд зохимжтой бөхийг нь сонгож, Тугаан, Гурганж хотны хүний хүүхэд мэт хувцаслаж, хөх чалмаар тэргүүнээ ороож, дэлгүүрээс гарав. Хасан, Дервишт, арьсан хэтэвчтэй зоос өгч өгүүлрүүн:

— Миний эзэн, хүндэт Махамуд-Ялвач чамд энэ таван алтан динарыг[20] замын хэрэглэлд нэмэр болгож хүргүүлсэн бүлгээ. Үүнээс гадна, хашаан дотор чиний илжиг эмээлтэйгээ чамайг хүлээсээр байна. Чи дуртай цагтаа аваарай. Манай эзэн ер тийм сул гартай хүн биш юм сан. Чамайг ингэж байхыг үзвэл, чи манай эзэнд их л тус болсон хүн бололтой гэжээ.

Орой Хажи-Рахим, тэр Махмуд-Ялвачийн гэрт орвол, худалдаачин, нэгэн их цэцэрлэгийн дунд нуугдсан мэт сэхээвчийн дотор сууж, хэдийний хүлээн ажээ. Алтан өнгөтэй цайнаас нэг аяга уусны дараа, зарцаа явуулж, сэм асууруун;

— Чи өнөөдөр надад ямар алтан шонхорт пайзыг хэлсэн билээ гэхэд, Дервиш бүсний хуниас дотроос шонхор товьж сийлсэн алтан пайз гаргаж, Махмуд-Ялвачид өгвөл, яаран мэгдэн авч, өвөртөө хийгээд хэлрүүн;

— Галав юүлэх цаг боловч, намайг бий гэж сонсвол, миний гэрт зоригтой иртүгэй. Би хэзээд чамайг тэтгэн тусалъя. Гурганжид юу хийх гэж бодож байна? гэхэд нь,

— Маргааш би эндээс Бухар орно. Зөв бурууг ялгахгүй далайсан илдтэй энэ газар байхаа айж байна. Надад бядан явагчийн таяг, алсын аян дээр санагдаж байна гэв.

ТУРХАН ХАТНЫ ХУЙВАЛДСАН ХЭРЭГ

Турхан хатны адил сэцэн эмээр удирдуулсан цэргийн хивчаг язгуургүй эрхшээн, удалгүй хааны алдар хүндийг бууруулж, хивчагууд эрх чөлөө олгох нэрийдлээр нэвтрэн орж, эзэлсэн газар орныг зориг мэдэн бусниулж, цөлбөн талж эзнээ нэрийг нутгийн ардад жигшүүртэй болгоход хориггүй болгожээ.
(В. Бартольд)

Өгүүлэх нь: Ёслолын гулдан хаалга, хоёр тийш цэлийн нээгдэж, цагаан хурган малгай, улаан эрээн дээлтэй, алт гялалзсан тахир сэлэмтэй, тарган тарган азарга унасан хүн хос хосоор жагсан гарцгааж, Хоресм Шаг Мухамед гарч ирэв.

Үзвэл, бие махлаг мариатай, ихэмсэг жавхлантай, очир алмаасын эрих гялалзсан цагаан торгон малгай өмсжээ. Алтан эмээл хазаартай, өргөн хэнхдэгтэй халтар морь унажээ. Шагийн хүрэн хоргой дээл, эрдэнийн чулуу шигтгэсэн бүс, сэлэм нь наранд нүд гялбам гялалзаж, Хоресмийн эзний хойноос хоёр залуу хүн дагаж, нэг нь хүрэн царайтай шавхийсэн залуу эр мөнгөн хөмөлдрөгтэй туркмен хар азаргыг чадамгай гэгчээр унажээ. Энэ бол, туркмен хатнаас төрсөн хунтайж Желал-Эд-Дин ажээ. Түүнтэй зэрэгцэн урт хар дэлийг олон хэсэг гөрлөө болгосон цоохор жороо морьтой хоргой дээлтэй бяцхан хүү явж байгаа нь Шагийн хивчаг хатнаас төрсөн хамгийн хайртай отгон хүү ажээ. Тэр хоёрын хойноос Хоресмийн их сайд, гал улаан нөмрөгтэй морь унаж, Шагийн сахиул мянган цэрэг, хоёр тасарч, нэг хэсэг нь, жагсаалын өмнө түрүүлэн зээлийн гол гудамжаар явж, сонирхон

шаваараалдах олныг ташууpаар ороолгон зам гаргаж, нөгөө хэсэг нь жагсаалын хойноос явж, замд тохиолдсон хүн цөм хөсөр өвдөг сөхрөн мөргөж, исламын их улсын эзний өөдөөс харж болохгүй ажээ.

Худалдаачин, урт арьсан бүрээний сөөнгө бүдүүн дуу, хэнгэрэг нижигнэх чимээ авмагц, яаран дэлгүүрээс хивс гаргаж, шавар шавхай дундуур дэвсэж тоссонд, Шаг Мухамед уулаас өргөн магтахад дассан тул халтар морины туурайн дор сөгдсөн, эрээн дээлтэй олон хүний нурууг ажиггүй ширвэн харж, хавагнасан царайд нь огт сонирхох сэтгэл хөдлөх байдалгүй, тэргүүнд өмссөн малгайн цагаанд хав хар сахал нь улам ч тас хар мэт үзэгдэн явсаар, Шагийн эх Турхан хатны харшийн өмнөд хаалганд хүрвэл хоёр хажуугаар Хоресм газрын сум үл нэвтлэх цуутай хуяг дуулгатай шилдэг хивчаг цэрэг, уяхан урт иштэй жад барьж зогсоцгооно.

— Ялагдашгүй Шаг Мухамед, үүрд төр барьж жаргах болтугай! гэж өндөр дуугаар хашхирсанд амьтан түрэн ирж ерөөцгөөж нарийн гудамж зээлээс гүйн гарцгааж, байшингийн орой, шавар хэрэм дээр авиран гарцгаасанд, Шаг, хивчаг цэрэг ерийнхөөс хэтэрхий олон бөгөөд түүний бие хамгаалагчаас хэдэн хувь илүүг үзээд, дотроо ширвээдэн, ямар учир эднийг энд цуглуулсан бил ээ? Заль арга үүсгэсэн биш байгаа? Эртхэн буцах юм бил үү? гэтэл, юунд ч сэжиглэх билээ дээ. Төрсөн эх нь хүүгээ хөнөөх ёс хаа байх ажээ. Эцгийнхээ нас нөгчсөнөөс хойш, эхдээ өөртэйгөө адил эрх олгосон биш бил үү? Түүний төрхөм Ханхил овгийн хивчаг цэрэг аян дайн бүхэнд явалцаж, эцэг өвгөдийнхөө зүүдлэгдээгүй их олзтой омогтой нутагтаа буцдаг биш бил үү? Ура гээд хаалганы өмнө тогтосхийсэн морио ташуурдан ухасхийж, дотоод хүрээнд ортол ёслолын хувцас өмссөн хивчаг өвгөд морийг тосон авч, Хоресм Шаг мориноос бууж, хилэн дэвссэн замаар насан зүг болсон боловч, бие чийрэг шулуун, шаламгайлан алхаж, нарийн сийлбэртэй баганат тавцан шат өөд гарч, ёсолж байгаа олны дундуур өнгөрөн, сэрүүн ордонд ортол, өмнө нь хамартаа алтан гархитай негр хүрч ирээд,

— Хатдын их хатан угтан заларч айсуй. Хааны сүр жавхлан бадартугай гэж хөшиг сөхөөд, өндөр дуугаар хашхиран өгүүлрүүн;

— Ертөнцийн цог жавхлан, шашны сахиулсан, исламын юлд залрав! гэсэнд урагш хэд алхаж, зүлгэмэл модон туургатай сараалжин цонхтой тасалгаанд орвол, бүдэг харанхуйд алтан хоргой дээлтэй нэгэн бяцхан хүн үзэгдэж, хоёр хажууд нь хивчагийн сурвалжит хорин

хаад, хагас дүгрэглэн цөмцийж чив чимээгүй сууцгаасныг үзээд, элэг тэврэн мэхийн ёсолж, эхийн өмнө багахан багахнаар алхлан очоод,

— Буянтны манлай, үнэн шударгын үлгэр болсон Турхан хатан эхийн амгаланг эрье гэж шивнэн өгүүлсэнд хоргой дээлийн хуниас хөдөлж, тэмээн хяргуулын өдөн цацагт дүгрэг малгай, шалд хүртэл тонгойсноо дахин дээш болж,

— Заяа муут бэлэвсэн ядуу эх чинь орчлонгийн агуу их эзэн чиний амрыг эрье. Надтай зэрэгцэн сууж, намайг баясган хүндэлнэ үү? гэсэнд мэхийснээ өндийж, эхийн зүг харвал өмнө нь улаан цагаан оо будаг тавьсан бяцхан нүүртэй хурц хар нүд улаан оч мэт гялалзаж, Турхан хатан, найман талтай тосгуур мэтийн хэлбэртэй алтан ширээнд завилан сууж, улсын эзнийг хамт зэрэгцэн сууя гэвч зайгүй бөгөөд хатны хоргой дээл ширээг бүрхсэн тул, арга буюу, ширээний дор хивсэн дээр суусанд, Турхан хатан хивчагтаа түүнийг үзүүлэх гэж зориуд тэгсэн байжээ. Мухамедыг, алгаа дэлгэж, залбирлыг уншаад, хурууны үзүүрээр сахлаа шувтрахад, сууж байсан бүгдээр, тэр залбирлыг шивнэн уншицгаав.

Турхан хатан, толгойгоо хөдөлгөн, малгайн өдийг чичрүүлэн овоорсон элбэг дээл нь оволзон, дотночлох дуугаар өгүүлрүүн:

— Би чухал хэрэг зөвлөн тогтоох гэж, эрхэм их энхрий хүүгээ дуудсан билээ. Алдарт Хоресм Шагийн үр угсаа, энх амар, чиний өмнө шударга зоригийг гүйцэтгэгч хивчаг хаадын хувь зохиол хэтдээ ямар болохыг зөвлөх чухал хэрэг байна. Манай хаан төрийн эрх, хаан ширээ, хань нөхдийг хамгаалах нь чухал байна! гэхэд нь, тасалгаа чимээгүй нам гүм болж, гагцхүү цонхны торын цаанаас Хоресм Шаг урт насалтугай гэж гадна хашхирах холын анир сонстож Мухамедыг,

— Мэргэн эхийн үгийг хичээнгүйлэн сонсъё гэсэнд,

— Чамайг харь газар орон, аян дайнд мордох нь гэж сураг сонслоо.

Чи хүлэг морио унаж, дайны газар дахин довтлох нь ээ.

«Заяаны судар»-т хамгийг чадагчийн заасан насны хэмжээг урьдаас мэдэхүйеэ бэрх. Чи, үнэн шашны төлөө байлдан явж, нэгэн цагт амь хохирч, сүнс чинь жаргалант орны цэцэрлэгт цахилгаан мэт одвол, энд засгийн жолоо барих чиний хатуу гаргүй, төр самууран үймж болзошгүйд Аллах тэнгэр бүү хүргүүлсүгэй!

Манай омог ихт ач Желал-Эд-Дин, бидний хивчагийг хүйс тэмтрэх гэж туркментэй нам нийлж сүлбээлэх дуртай тул, одоогоос

Хоресмийн газар орныг захирахад Желал-Эд-Дин-ээс өөр хүнийг урьдаас олж сонговол эрхэм биш үү? гэхэд нь хивчаг хаадыг,

— Хатны айлдаж байгаа нь тун ч мэргэн, очир алмаасаас эрхэм үг байна гэтэл, хатан үргэлжлэн өгүүлрүүн:

— Учир иймд би манай ураг угсааны сурвалжит хаадтай хууль нийлэн зөвлөөд, хаан ширээг залгамжлах хунтайжид чиний янаг гэргий, хивчаг хатны отгон хүү Кутб-Ад-Дин Озлаг Шагийг өргөн сонгож Желал-Эд-Динийг маш алсалсан зах хязгаар газрыг тохинуулан захируулахаар явуулсугай гэнэ. Тэр хүн чи бид бүхэнд хэзээд аюултай хүн гэхэд нь, бүгд дув дуугай сууж, Шагийн юу хэлэхийг чагнан суув. Шаг, мяндсан адил сахлын үзүүрийг чичирхийлсэн хуруундаа бодлого болон, дув дуугай ороож, хатан тэр байдлыг үзээд, бас өгүүлрүүн:

— Чи миний үгийг дагахгүй бол, бүгд хивчаг Хоресмаас агшин зуур хөдөө газар зайлан одоцгоож, би ч хойноос нь дагаж, адгийн гуйлгачин мэт тэнүүчлэн явна гэж хэлээд хааныг мөн л тэгнэгэлзэн байхыг үзээд, залуу Мухамед, Бен Салихыг үзэсгэлэн гуагийн учир, зарцаас бойдоо өргөмжилсөн нь цав хийж, хатны ард зогсож байсныг гараар тохимогц, тэр хүн, даруй учрыг мэдэж, гадагш гараад түдэлгүй хоргой дээлтэй долоон настай бяцхан хүүг хөтөлж ирэв. Хатан захирангуй хатан дуугаар,

— За, танай хунтайж энэ байна. Хоресм Шаг түүгээр хаан ширээний түшиг болгохыг таалсан тааллыг хивчаг хаад, Беги ноёд, цэрэг эр, албат, харц нийтэд зарласугай гэмэгц, олон хаад даруй босоцгоож, бяцхан хүүг тосон авч хэдэн удаа дээш өргөөд,

— Манай нэгэн яс махны хивчаг Султан урт насалж, удаан жаргах болтугай гэж ерөөцгөөв. Үүнд, Мухамед босож, хүүгээ авч, эмэг эхтэй зэрэгцүүлэн суулгаад,

— Беги ноёд, сонсогтун! Би та, нарын хүсэлд нийлүүлсэн тул, одоо та нар миний хүслийг гүйцэтгэтүгэй. Миний хуучин дайсан Багдадын Насир Халиф, аанай намайг эсэргүүцэн хуйвалдаж, миний хайрт улсыг дахин хатган самууруулж эхлэв. Хорт Насирыг устгахаас нааш Хоресм энх төвшин болохгүй тул, бидэнд үнэн шударга санваартныг Багдадын Халиф өргөмжлөлтэй. Иймд би Халифын цэргийг даран сөнөөж, Багдадын ариун газар жадын үзүүрийг хатгахаас нааш би сэтгэл амрахгүй гэжээ.

Хивчагийн дундаас анигар нүдтэй, буурал сахалтай хатангир өвгөн босож хариу өгүүлрүүн?

— Бид бүхэн, нэгэн хүн мэт, чиний хүчит гар сунган заасан зүг морио залахад бэлхэн. Гагцхүү юуны урьд, нутгаа тохинуулж амар жамар болох нь чухал. Сонсвол, хивчаг нутгаас ирсэн элч, дорно зүгээс өмнө зүг үзэгдээгүй исламын ариун шашныг чихэндээ сонсоогүй буруу номтой зэрлэг аймаг, манай нутагт халдан орж, тэрэг тэмээ, мал сүрэгтэйгээ ирж, манай орон бэлчээрийг зоригоор эзэрхэн, нутгийн ардыг хөөн зайлуулж байгаа гэнэ. Иймд үтэр түргэн тэр тэрс номтныг даран сөнөөж, эд малыг олзлон эмс хүүхдийг нь манай цэрэгт боол шивэгчин болгон түгээвэл зохино гэхэд хивчаг хаад,

— Манай нутгийн зүг цэргээ удирд гэж хашхирав. Тэр завсар бичээч, гартаа хулсан үзэг барьж, Хоресм шагийн өмнө ирээд, бичиг, сөгдөн өргөөд Мухамедыг энэ юу вэ? гэвэл өгүүлрүүн:

— Суурийг чинь хайрт бага хүү Кутб-Ад-Дин Озлаг Шагт залгамжлуулах зарлиг. Хунтайжийг эрийн цээнд хүртэл эмэг эх Турхан хатан төрийг барих бага эзнийг сурган жолоодож, Хатадын бойдоо Мухамед Бен Салихыг их визар сайд өргөмжлөх тухай зарлиг гэсэнд Турхан хатан бас өгүүлрүүн;

— Миний хүү, ялагдашгүй Хоресм шаг-Мухамед чи одоо цэргээ дагуулан хотол дэлхийг эргэн хандсан тийшээ байлдахад чөлөөтэй боллоо гэв.

Мухамед, зарлиг бичгийг уншилгүй, гарын үсэг зурж, хулсан үзгийг эхэд өгвөл үзгийг авч их л шамдсан байдалтай хэдэн том үсэг зурсан нь

Дэлхий дахины эмсийн эрхэн хатан,
Ертөнцийн эзэн Турхан хатан

гэжээ.

Мухамед Шаг, тэргүүнийг эргүүлэн, ахмад хүү Желал-Эд-Динийг юу гэх бол гэж, сэтгэл зовнин эргэж үзвэл, байхгүй ажээ. Үүнд, ордны дарга Хоресм шагийн чихэнд сэм шивнэн өгүүлрүүн;

— Желал-Эд-Дин хаан, хивчагийн өдий төдий олон цэргийг хараад, «би хивчагийн мал нядлах газар туугдан очих хонь биш» гэж хэдийн зайлсан гэжээ.

Ордны дарга, Хоресм шагийн гурван зуун хатны санаа сэтгэлийг тэнүүн сайхан байлгах их үүрэгтэй ажээ. Тэгээд, тэдгээр хатны зан авирыг ажиглан шинжиж, сэтгэл санаа долгин хөнгөмсөг болсны түгшүүртэй шинж мэдэгдвэл, шууд Хоресм шагд айлтгах үүрэг бүхий билээ.

Тэгээд, Туркмений нутгаас авчирсан хүүхний сүүрс алдан уйлахын учрыг мэдэж ол гэсэн тушаал сонсож, төлөгч эм Илан-Торч (монголчилбол, могойн хайрс) гэдгийг дуудуулав. Тэр эм, аливаа эмсийн хуурамч башир залийг илрүүлэн гаргахдаа сүрхий чадамгайн дээр, мэргэ төлөг тавьдаг ийм инээм үлгэр ярьдаг хүн бүлгээ.

Могойн хайрс эмгэн, ордны даргын битүүлэг үгийг сонсоод даруй гурван зүйл түүний сэтгэлийг зовоож байгааг мэдлээ. Ямар гурван зүйл гэвэл, Туркмений хөдөө талд залуу Гюль-Жамалын сүүрс алдан хүсдэг залуу эр бий үгүй, мөн хүүхэн Туркментэй харилцдаг эсдэг, жич тэр шөнө Шагийн дэргэд байхдаа чинжаал хутгатай байсан эссэн ажээ.

Төдий, Могойн хайрс эмгэн, алгаа тосоод, учрыг ухлаа гэсэнд хэдэн зоос хаяж өгснийг аваад могойн хайрс надад энэ зоос дунд нэг ч алтан зоос үзэгдэхгүй байна гэв. Ордны дарга өгүүлрүүн;

— Чухал мэдээ хүргэж ирвэл алтан зоос олдоно гэж явуулсанд, бие туранхай, царай хар хүрэн, чихэнд нь том мөнгөн сүйхтэй тэр төлөгч эмгэн, дотоод ордны сувд эрдэнэ байгаа хүрээний бяцхан хаалгаар ороод зогсож онигор хар нүдээр өндөр хэрэмтэй бяцхан хүрээг үзвэл Шагийн бусад хатны суух хүрээний адил нэгэн талд цонх гэгээвчгүй, ганц давхар урт байшин байнам бөгөөд, хошоод далавчтай, нээлттэй таван хаалгатай тавцан үзэгдэж, усан урсгал хүрээний дундах дүгрэг цөөрөмд цутган орж, хоёр этгээдэд хоёр бут тэргүүлэгч цэцэг үзэсгэлэнтэй сайхнаар цэцэглэж, хүрээний гүнд хэрмийн дэргэд өндөр баглагар мөчиртэй улиангар модны дор ганц том цагаан туркмен гэр байхыг үзээд, эмгэн эрээн дээлээ засаж, цөөрмийн зүг очив. Цөөрмийн чулуун гишгүүр дээр жирвийсэн хар нүдтэй, бов бор царайтай охин сууж гартаа кашгар газрын цэнхэр аяга барьж, чанасан тутаргыг бяцхан мөнгөн зоодой загастай ширхэг ширхгээр сацаж сууснуг үзээд, чулуун шалд сөгдөн, охины улбар шар дээлийн хормойноос адис авч, нам дуугаар өгүүлрүүн;

— Үзэж ханашгүй «цэцгийн мишээлт» чиний амрыг айлтгая. Гэрэлт гарыг чинь үнсэж, сүүдэрт чинь хүртэхийг соёрх гээд, охины

дэргэд сууж, шагшин магтаж бялдуучлан зусардаж сурсан үгийг ус шиг урсган өгүүлэхийн далимд дотроо сэтгэрүүн:

— Манай Падишаг, үүний юунд болж дурласан бэ? Царай нь гүйлс мэт хүрэн, бие маш бяцхан, ер Шагийн дотоод ордны махлаг гоо сайхан эмсийг бие бялдраар хэрхэвч үл гүйцэх ажээ. Үнээр манай эзний сонин жигтэй нь хязгааргүй ажээ гэж бодтол охин,

— Хөдөө юү хэлэлцэж байна гэж асуув.

Хөгшин эмгэн өгүүлрүүн;

— Говийн нэгэн хаан, хайрт охиноо санаж уйтгарлан байгаа сэтгэлийг сэргээж өгнө үү гэж надад тэмээн хөсөг явуулсан билээ. Тэр нутгийн олон бүхнээр чамайг дурсан ярьж, жаргалтай хувьтай хүн гэцгээж байна. Тэдний ярилцах нь, Хоресм шаг, хатан хатнаас манай сайхан туркмен хүүхэнд илүү янаг болж, арван хуруунд нь хөх оч гардаг эрдэнийн чулуун шигтгээтэй бөгж зүүлгэж, перс газрын хивст цагаан гэрт ганцаарыг нь эрх дураар нь суулгаж, элдэв амттаны зүйлийг өөрийн зоогийн гэрээс хүргүүлдэг юм гэнэ гэж ярилцаж байна гэхэд нь, Гюль-Жамал үгийг сонсоод,

— Би Падишагийн гэргий гэвч гурван зуун нэг дүгээр нь бүлгээ. Ингэж байснаас энгийн нэг залуу баатар эрийн гэргий болсон дээр юм сан. Манай нутагт намайг их хувьтай гэж үзэж байхад би Хар-Хумд агь гангийн сайхан үнэрийг ханхлуулагч хонгор салхийг мөрөөдөн сууж, Шагийн тогооны гэрийн тасардаггүй хэншүүнээс толгой өвддөг болов. Энэ буюу хэрэм, хэрэм дээрх манаатай харуулын өндөр цамхаг хөгшин улиангараас өөр юү ч үзэгдэхгүй энэ газар, дун цагаан энэ гэрээр би юу хийх вэ? Сая тэр модонд авирч алсын цэнхэр талын барааг үзэх гэтэл, тайган чирч буулгасан. Тэгээд дүүжингийн олсыг ч огтолж авсан. Ингэж суухыг жаргал гэдэг юм уу? Чи юү бодож байна? гэхэд нь Могойн хайрс хэлрүүн:

— Хэрэв надад чиний энэ байдлын зууны нэг хувийг олох хувь байсан бол би жаргалтай байх сан. Пистаки[21] жимстэй нугасны махыг надад өгөх хүн олдохгүй байна шүү дээ гэхэд Гюль-Жамал охидыг дуудаж; ширээ зас гэж тушаагаад хөгшин эмийг надад нэг юм мэргэлж өг гэлээ.

Хоёр шивэгчин, цагаан гэр өөд гүйн, мөнгөн зоос хадсан улаан алчуураар толгойгоо боосон хөгшин Туркмен эхнэр ирж суугаад, төлөгч эмийн мэргэлэхийг ширтэн хартал, Могойн хайрс, хавтгай чулуун дээр гүргэмийн өнгөт алчуур дэвсэж бяцхан улаан хүүдийнээс

атга хар цагаан боорцог гаргаж асгаад нарийхан ясан савхаар боорцгийг цагариглан зурж, амандаа Люлю гэдэг нүүдэлчин аймгийн үл ухагдах үгсийг шивнэн уншиж, гялалзсан хар нүдээ бүлтийлгэн нүдээ цагаанаар эргэлдүүлж сөөнгө дугаар шивнэн,

— Хөгшин настны заасан ёсоор төлөг тавьж үзвэл, буусан нь хөдөө нутагт идэр залуу боловч, их баатар нэгэн эр байна. Тэр хүн барстай учравч халтиралгүй харваж, арван дээрэмчинтэй тохиолдовч, алалцан дайрч, арвуулыг цавчдаг сайн эр юм байна. Тэр залуу эр, чамайг мөрөөдөн санаж, шөнө үл унтан, хуурчийн янагийн дуу аялахыг үргэлж сонсож, тэнгэрийг ширтэн миний амраг бүсгүйн нүд тэнгэр дэх одтой адилхан гэдэг хүн байна. Чи санаа алдаж байх чинь, би лав оносон биз ээ? гэхэд нь Гюль-Жамал хирдхийн цочиж, дээлд нь зүүсэн алтан мөнгөн зоос жингэр жингэр дугарчээ. Охин нэгийг нь тастан авъя гэвч, хүч хүрсэнгүй, зарцыг хонгор эжий минь хайч авчир гэлээ. Могойн хайрс, тэр самбаанд сэмээр асуууруун:

— Чиний цагаан иштэй бяцхан хутга хаана вэ? Чи, тал газрын хүүхэн хүн, хэзээд бүсэндээ хавчуулан авч явах ёстой шүү дээ гэтэл, охины царайд цочих байдал агшин зуур үзэгдэн, хөгшин туркмен эхнэр томоотой аажуухнаар босож, гэрээс хивс нэхэхэд утас хайчилдаг том хайчийг авчирч өгөв. Охин дээлийн нимгэн алтан зоосыг хайчаар салгаж аваад, бяцхан бор гартаа атгаж,

— Чи сая мөрөөдөн уйтгарлаж байгаа залуугийн тухай үлгэр зохиож хэлсэн атал, юунд түүний нэрийг эс хэлэв? гэж асуув.

Төлөгч эм,

— Боорцгоор төлөгдөхөд нэрийг мэдэж болохгүй. Чиний сэтгэл чамд ухаангүй дуртай тэр хүний нэрийг юу андах вэ гэтэл, охин,

— Хивчагууд намайг Падишагийн ордонд хүчээр авчирсан бүлгээ. Тэр цагт хөдөө газрын олон залуус надаас болж хоорондоо тэмцэж байсан билээ. Бидний зэрэг охидоос сэтгэл чинь хэнд татагдаж байна гэж хөгшид настан хаанаас асуух билээ гэв.

— Энэ ховч эрээн шаазгай, дэмий донгосож байна. Падишагийн хатны сэтгэлд ганцхан Рустем мэт гоо, Искендер мэт баатар манай эзэн Мухамед Хоресм Шагийн нэр орж байх ёстой. Ордны эмс, цөм ганцхан түүний төлөө амьд явж ганц түүнийг санаж явдаг юм биш үү? Гюль-Жамал, энэ бачит эмийн үгийг бүү сонс гэж туркмен эхнэрийн хөндлөнгөөс ундууцан хэлтэл, бяцхан хаалгаар цагаан чалматай, тарган тайган орж ирээд, төлөгч эмийг даллав. Төлөгч эм, ордны

хамгаас их эрхшээлт сахиулсан түүний зүг гүйн очиж, шивнэлдэн ярилцаад, эргэж ирэн чулуун шал дээр сөгдөж, Гюль-Жамалын дээлийн хормойд хуруугаа ёслон хүргэж өгүүлрүүн;

— Эгэл эм намайг уучилна уу? Шинэ бага эзэн хунтайж Озлаг Шагийн эх хатан; төлөг тавиулах гэж дуудуулж байна. Зүгээр суух цаг нэг ч олдохгүй юм аа гэж олсон алтан зоосоо дахин нэг үнсэж, адис авааД, тайганы хойноос дагаж, хаалганы цаана далд оров.

ЭМГЭНЭЛТ ЭЛЧ БАЯРЫН МЭДЭЭ ХҮРГЭЖ БОЛНО

Өгүүлэх нь, Хоресм шаг, ордны нэн алсалсан нэгэн танхимд төрийн хэрэг шийтгэж сууВ. «Туурганд бас чих байж болно» гэдэг боловч, хивс хөшиг татсан цонх гэгээвчгүй, адаг дахь нүхээр шөнө од үзэгдэх төдий, худаг адил тэр тасалгааны туурганд чих байх нөхцөлгүй тул, Шаг, тэр танхимд их зандалчинтай үг хэлэлцэж, уйтгарлан байгаа олон хатны элдэв хэрэг тариг гарсныг ордны даргаас хүн сонсоно гэж сэтгэл зоволтгүй яриулан хэлэлцдэг байжээ. Бас, хурим той цээр эзнээ муу хэлсэн хааныг сэм боомилон алах тушаал, мөн эзэн санд алтан зоос дүүргэсэн цар тавгийг хүргэж ирэхийг удтал тасалдуулсан хэрэг харамч Беги ноёны өргөөг уулгалахаар зүс буруулан, нүүрээ бүтээсэн морьтой хүнийг явуулах нууц тушаалаа шивнэн хэлж, тэр хивст тасалгаанаа Шагийн сэм хэлэлцсэний маргааш үүрээр нэр зүс үл мэдэгдэх хүн өндөр цамхгаас мэгдэн бархирсаар чулуун дээр хэмх унаж үхдэг байжээ. Бас хавирган сарны бүдэг гэрэлд зандалчид, ширүүн урсгалт Жейхун голын харлан мэлтэлзэх усанд Шагт нүүргүй болсон, шуудайд чихэн хийсэн хүнийг годгонуулан онгоцон дээрээс хаяад, сүүлд нь өргөн их голын мандал дээгүүр,

Хаврын цаг, чиний цэцэрлэгт алтан гургалдай донгодоод,
Цэцгийн хүрээлэнд улаан тэргүүлэгч цэцэг унждаг

гэж дуулахад нь, сэлүүрчин түрэн эгшиглэж

Аяа, үзэсгэлэн гоо Хоресм

гэж түрэн дуулцгаадаг билээ.

Тэр үдэш Мухамед, царайгаа барайлган, үг дуугүй сууж, ордны сайд, хаан хүү Желал-Эд-Диний гэрт тийм тийм хүн ирж байсан гэж

айлтгаж,

— Урт хөлтэй сайхан азарга унасан гурван туркмен ирж нэг нь алчуураар нүүрээ далдалж, байдал нь нас залуу, нуруу чилгэр, нүд нь харцагын нүд шиг хурц хүн билээ гэв. Шаг түүнийг сонсоод,

— Юунд чи түүнийг барьсангүй вэ? гэж асуув.

— Тэр хавьд, зуун модон дотор гань галзуу дөчөөд залуу туркмен эр түүнийг хүлээж байсан дээрээс халдаж чадсангүй. Гэвч, туркмений явдаг Мерданы зах дээр Хар Хончирыг дурдан хэлэлцсэнийг манай нэгэн хүн, хэдэн удаа сонсож гэнэ ээ гэтэл,

— Худалдааны аянчинд аюултай Хар Хончир уу? гэж асуувал,

— Жа, тийм ээ, эзэн минь, гэвч, хунтайж хааныг түүнтэй... гэтэл,

— Тэр ч одоо хунтайжаа хэдийн больсон гэж хэлэв.

Ордны сайд, үүнийг сонсоод,

— Эзэн Шагийн зарлиг, Аллах тэнгэрийн зарлиг даруй мөн! Гэвч, хэдий энгийн ноён Беги ч гэсэн, нэг замын дээрэмчинтэй үг хэлэлцэхэд хүрэх ёсгүй биз гэж хэлэв. Чингэхэд нь Шаг,

— Манай энэ түгшүүрт цагт юу ч болж болно шүү гэв.

— Эзний бие, тэр Желал-Эд-Дин, ариун Мекке Балгад дахь их богдын шарилд мөргөхөөр алс газар явбал, туркментэй сүлбээлэхээ зогсох сон болов уу гэж ордны сайдын хэлэхэд,

— Би түүнийг Энэтхэгтэй зах нийлсэн алсалсан Газна хотын засаг ноён болгосон, тэр тэнд очоод, тэрслүү хаадыг хуралдуулан, Хятадыг байлдах гэж ятгах байлгүй дээ. Тэгээд, Хоресм, хутгаар хага цавчсан тарвас шиг хагаран эвдрэх юм байлгүй дээ, үгүй дуртай цагтаа санааг нь мэдэж байх гэж, эндээ хормой доороо байлгасан дээр гэхэд нь ордны дарга,

— Тэр мэргэн арга гэв.

— Гэвч, сүүлээ шарвагч чи сонс! Хэрэв, дээрэмчин, Хар Хончирыг Гурганж хотод дахин явна гэж сонсвол, чиний ширгэсэн нүдтэй толгойг Желал-Эд-Диний ордны өмнөх гадсанд шорлон өлгөнө гэж Шагийн хэлэхэд,

— Аллах тэнгэр, биднийг тэр аюулаас сахин авар! гэж ордны дарга аман дотроо хүнгэнэн, үүд тийш ухран гарав.

Хөгшин тайган орж ирээд,

— Дээрхийн зарлигийн ёсоор Гюль-Жамал хатан, таны танхимд ирээд, зарлигийг хүлээж байна гэж айлтгав. Шаг дуртай дургүй маягтай босож,

— Чи түүнийг нааш нь энэ хивст тасалгаанд авчир гээд, нарийхан хаалгаар бөхийн гарч, мушгимал шатаар авирч, нэг бяцхан тасалгаанд ороод, хавчиг нарийн гэгээвч, сийлмэл сараалжин торын завсраар хивст тасалгаанд юу болохыг харж хүлээв. Атгар зоогоо хач алчууpаар ороосон бөгтөр нуруутай, сахалгүй өвгөн тайган сийлбэрлэн чимсэн хаалга нээгээд, мөнгөн хатгууртай, тос гоожсон дөрвөн лаа барьж, эрээн бөсөөр бүтээсэн бяцхан хүүхнийг хараад, өрөвдсөн байдалтай сүүрс алдаж, нарийхан дуугаар,

— Жа, цаашаа явъя гээд хүнд үүдийг өргөж, лааг дээш нь өргөн зогсов. Гюль-Жамал, дээрээс цохиулах гэж байсан юм шиг годхийгээд, яаран дотогш ороод, шаахайгаа тайлж, урагш хоёр алхаад үзвэл, жижигхэн тасалгааг бухар улаан хивсээр бүрсэн нь, тоглоомын бяцхан тасалгаа мэт харагдаж, адар нь дээшээ бүндийсээр, харанхуйд харагдахгүй байдалтай үзэгдэв.

Тайган, тэр завсар гараад хаалгыг тас хийтэл цоожилж, туурган дахь их маягтай угалзалсан торон цонх гэрэлтэн үзэгдсэн нь, тайганы барьж явсан лаагаа тавьсан болов уу даа. Тэр цонхны тушаа, нөгөө талд, мөн тийм цонх харлан харагдаж байгаа нь, хүн сэм харж байгаа юм биш байгаа даа гэж бодоод, охины сэтгэлд хивст танхим гэж авир шивэр хэлэлцдэг үг орж, дотуур ордны журам батыг алдсан эмсийг Жихан Пехлеван зандалчин багалзуурдан алдаг юм. Шаг туурган дээр байгаа гэгээтэй туурган цонхоор түүнийг харж суудаг юм гэж хэлэлцдэгийг санаад өнөөх тасалгаа нь биш байгаа даа гэж гайхаж, эргэн тойрон явж үзвэл, шал дээр хэдэн бага хивс дэвсээтэй байгаа нь, мөргөл хийхэд дэвсдэг хивс байжээ. «Алах эмэгтэйг ордноос авч гарахдаа ийм хивст ороон гардаг юм байлгүй дээ» гэж бодоод тасалгааны буланд цэцэгтэй торгон олбог дэрийг овоолон, өчүүхэн чимээ гарах бүр цочин хажуулдав.

Гэнэт, хивснүүд хөдөлж, цаана нь нэг араатны толгой цухуйн үзэгдээд, бүдэг бадаг гэрэлд дүгрэг нүд нь ногоон оч мэт гялалзсанд охин ухасхийн босож, туурганд наалдаад хар цоохор шарыг чимээгүй орж ирээд урьдах хөл дээрээ хошуугаа тавьж хэвтээд, урт сүүлээ мушгилзуулан шалыг цохилсонд, ирвэс байна шүү, авд тавьдаг махчин ирвэс байна. Туркмен хүн үүнд зүгээр байж идүүлэхгүй дээ гэж дэвссэн хивсний захаас шүүрвэл, ирвэс хүрчигнэн мөлхөж ойртов. Хүүхэн, эвий, амь авар! гэж бархираад, хивсийг сөхөв. Ирвэсийн

дүүлж, охиныг унагаасанд, биеэ атиран хивсний дор шургаж, амиа хаацайлан, ирвэс зузаан хивсийг хага татах гэж маажлан ноцолдсоор,

— Үхэх цаг минь ирлээ! Амь авар! гэж охины хашхиртал, хаалгыг ихэд тогшиж, цуугилдан хэрэлдэх чимээ, ирвэсийн архирах нь улам их болов. Тэгээд, чимээ нь, нэгэн хүн хивсийг сөхжээ. Үзвэл, ирвэст чамархайгаас эрүүгээ хүртэл хага маажуулсан өндөр туранхай биетэй залуу баатар эр, охины дэргэд зогсоод, хивсний захаар хончир илдээ арчиж байв. Өвгөн тайган, тэр залуу эрийг чирч гаргах гэж ханцуйнаас зууралдаж,

— Чи цаазтай танхимд ямар аймшиггүй орж ирээд, Падишагийн хайрт ирвэсийг алав! Эзэн чамайг гадсанд шорлон суулгана даа гэж загнав. Тэр залуу эр,

— Сахалгүй амьтан чи, зайл, эсхүл, чиний толгойг ирвэсийн нэгэн адил болгоно гэж байв. Охин өндийгөөд, хүчин тамир барагдаж, дахин олбог дээр унав. Өнөөх ирвэс, тасалгааны дунд урд хоёр хөл дээрээ тас цавчуулсан толгойгоо барьж байсан юм шиг хэвтэж, бие нь мөн татвалзсаар байв. Тэр залуу охины зүг,

— Хатан чи амьд уу? гэхэд нь,

— Зоригт залуу чи, их хүнд шархдаж уу? Чиний нүүрээр цус урсаж байна гэхэд нь,

— Зүгээр, хөндлөн сорви олсныг эр хүний чимэг гэдэг гэтэл, харуулын дарга Төмөр Мелиг гүйн орж ирээд, үүдэнд хэдэн цэрэг бөөгнөрөн үзэгдэв. Төмөр Мелиг, тэр залуугийн дэргэд хүрч очоод,

— Чи хэн гэгч вэ? Яаж энд орж ирсэн бэ? Манааг ямар аймшиггүй занчив. Зэвсгээ хурдан хураалга гэсэнд, тэр залуу, сэлмээ хуйд яаралгүй дүрж, тайван хариулруун,

— Чи харин хэн гэгч вэ? Манааны дарга Төмөр Мелиг биш биз ээ? Тэгвэл чиний амрыг эрье. Би Хоресм Шагтай нүүр учирч уулзах маш эрхэм хэрэгтэй билээ. Самаркандаас муу мэдээ ирсэн гэтэл,

— Энэ хэрцгий хүн, хэн гэгч вэ? гэж захирч сурсан хүний дуу сонстож, удалгүй Хоресм шаг, чинжаал хутганы иш дээр алгаа тавьж, их алхмаар хивст тасалгаанд орж ирэв. Өнөөх залуу хүн түүнийг үзээд, гараа цээжний тус барьж, бяцхан мэхэсхийн, их Шагийн амгаланг айлтгая гээд, шулуухан зогсож өгүүлрүүн:

— Чи энд наадам шоглоом хийж, хээрийн ирвэсээр ядуу эмийг айлгаж байдаг. Гэтэл дэлхийд их хэрэг гарч байдаг. Аян худалдааны их замд би Самаркандаас явсан нэгэн элчтэй тохиолдов. Морио

түгшээгээд, явган гүйсээр унажээ. Учрыг асуувал, ухаангүй юм шиг, амь тэмцэн давтаж хэлэх нь, Самаркандад бослого гараад, бүгд хивчагийг алж, хонины мах яргачны дэлгүүрт өлгөдөг шиг модноос дүүжилж байна гэж хэлэв. Бослогыг чиний хүргэн Осман Султан толгойлж, охиныг чинь алахыг оролдсон боловч зоригтой зуун баатрын хамт цайзад хоргодож, өдөр шөнөгүй тулсаар гэнэ. Охины чинь захиа энэ гэж өгвөл, Хоресм шаг тэр сайн эрийн гараас улаан дугтуйт захиаг угз татан авч чинжаал хутганы үзүүрээр задалж, бүдэг гэрэлд захиаг унших гэж аман дотроо,

— Бослого гаргасан гэнэ ээ? Самарканд хэзээний бослогочны үүр нь байсан юм даа. Төмөр Мелиг ээ! Хивчагийн цэргийг үтэр зарлан дууд! Би биеэр Самаркандыг дайлъя. Дэлхийд аллах тэнгэрийн[22] сүүдэр болсон эзний өөдөөс гар хөдлөгсдийг боомилон цаазлах дээс сүхээр тасалдахад хүрнэ байх. Энэ эмийг цагаан гэрт нь аваачиж эмчирүүлэн эмчлүүл. Сайн эрийн нэр хэн билээ гэсэнд;

— Асуугаад юу хийх нь вэ? Их говийн нэгэн өчүүхэн эр ээ гэхэд,

— Чи надад эмгэнэлт мэдээ хүргэж ирсэн хүн. Эртний заншлаар би «эмгэнэлт элч»-ийг цаазаар аваачих ёстойн дээр, чи бас миний хайрт ирвэсийг алжээ. Чамайг чухам яаж ямар цаазаар аваачъя даа гэв. Төмөр Мелиг,

— Би мэднэ. Эзэн үг хэлэхийг соёрхоно уу? гэв. Хоресм шаг үүнийг сонсоод хэлрүүн:

— Миний зоригт Төмөр Мелиг чи, миний өмнөөс түүнийгээ сөс ихт энэ эрд сонсго гэсэнд,

— Цэргийн явдалд өдөр цагийг осолдвол, ялахыг осолдуулах гэдэг. Энэ сайн эр, дээд эзэн танд баяр төгөлдөр чухал мэдээг хүргэх гэж ихэд хичээжээ. Захидалд чиний охиныг амьд бөгөөд дайсны халдан байлдахыг цэргийн эр адил, эрэлхгээр няцааж байгааг өгүүлжээ. Одоо, их Падишаг, чи биеэр яаравчлан Самаркандын зүг мордож, баатар охиноо сөнөх аюулаас авран завдах байна. Ийм учраас зүтгэлийг үзэж, Шаг энэ сайн эрийг есөн ялаас хэлтрүүлэх дархан болгож, Хоресм шагийн бие, алагдсан ирвэсийн оронд түүнээс улам хэцүү ирвэс, энэ баатар сайн эртэй болж, түүнийг дагуулж ирсэн зуун туркмен цэргийн зуут болгов гэхэд нь,

Шагийн гайхаж, очир алмаас шигтгээтэй бөгжтэй хуруугаар хар сахлаа имэрч байтал, тэр сайн эр,

— Шонхор шувуу, замаасаа хазайдаггүй. Хоресм шаг хоёр зарлиг буулгадаггүй гэдэг. За, энэ охиныг одоо хааш аваачих вэ? гэж томоотойгоор хэлээд, хөсөрт хэвтэж байсан Гюль-Жамалыг аяархнаар өргөөд, босгон дээр түр зогсож туранхай биетэй тэр залуу хүн царайгаа барайлган, Хоресм шагийн зүг эрх чацуу мэт өгүүлрүүн:

— Чиний аян худалдааны догшин аянга болсон Хар Хончир амрыг чинь эрье гээд, ихэмсгээр гарч одов.

Шагийг Төмөр Мелигийн өөдөөс харж түүнд уурлах талархах алиныг ч мэдэж ядан зогстол, Төмөр Мелиг тачигнатал инээж,

— Юутай зоригтой самбаатай эр вэ? Эзэн чи, Туркменийг итгэж болохгүй гэж айлддаг, үнэндээ ийм сайн эр цэрэгтэй болбол дэлхий дахиныг дагуулахад зовох газар юу вэ? гэв.

Түүнээс хойш хэдэн хоног өнгөрөөд, шөнийн харанхуйд хавирган сарыг сүмийн өндөр цамхгийн дээр гарахад, хэдэн хүн сүүдэр мэт чимээгүй явж, ордны хажуугаар яаран өнгөрөөд, нарийхан гудамжинд орж, хөгшин улиангар модны гишүү мөчир унжсан хэрмийн дэргэд зогсоод, төмөр дэгээтэй дээсэн шатыг хэрмийн орой дээр хаяж, дэгээгээр нь тогтоогоод нэг нь шат өөд авирч, цагаан гэрийг үзвэл, өрхөөр нь утаа суунаглан, хана туурганы завсраар гэрэл үзэгдэж байв. Ууль мэт дуугармагц, гэрээс юм нөмрөн бүтээсэн эм гарч ирэхэд,

— Бид цөм туркмен ах дүү нар байна. Сайн биз дээ та нар? Гюль-Жамал хатан эсэн мэнд үү? гэж хэрмийн дээрээс асуухад тэр эмэгтэй өгүүлрүүн:

— Би, түүний зарц байна. Бид сүйд болсон. Хоресм Шаг, Самаркандын бослогыг дарахаар цэрэгтэй явсаар гурав хонож байна. Ордны бүх хэргийг Турхан хатан эрхэлж, тэр хорт эмгэн «манай цэцгийн мишээлт»-ийг чулуун цамхагт хориод манааг хоёр давхар болгов. Тэр ч байтугай, охиныг үхэн үхтэл нь тэр цамхагт хорино гэж хэлсэн гэхэд нь хэрмийн дээрх хүн өгүүлрүүн:

— Чи, энэ нэгэн алтан динарыг тайганд, энэ хоёр динарыг манаанд тус тус хахуульдан өгч, Гюль-Жамалтай уулзаж үз. Тэгээд, хотын гадна, их зам дээр байгаа гэгээн Шейхийн шарилд очиж мөргөе гэж Турхан хатанд хэл гэж хэл. Мөргөе гэхэд болохгүй гэж хэлэхгүй байх. Тэгээд, хотоос гарч чадвал, Хар Хончир учрыг олно гэж уламжилж үз гээд, хар сүүдэр мэт бүрэлзсэн хүн даруй хэрмээс бууж харанхуйд завхан одов. Зарц эм ганцаараа үлдээд амандаа шивнэн өгүүлрүүн:

— Энэ дэлхийд Турхан хатнаас хортой мэхтэй амьтан байхгүй. Хүнийг хорлох гэвэл, түүнд нь хэн ч хориг хийж чадахгүй дэг ээ гэжээ.

ЯЛТ ХУНТАЙЖИЙН ЦЭЦЭРЛЭГТ

Энэ морь минь, энэ зэвсэг минь байна.
Цэцэрлэг дэх хуримыг орлож чадна.
(Ибраасим Монтесер, X зуун)

Өгүүлэх нь, Төмөр Мелиг, байлдаан тулалдаан олон үзсэн цэргийн хашир хүн аж, айхыг мэддэггүй билээ. Дайсны сэлмийг толгой дээрээ далайхыг үзэж, бамбайгаа нэвт жадлуулж, хуягаа цоо харвуулан, ирвэст уруулан, барст хөөгдөж, үхлийн босгыг хэд алхаж, нүд нь хар үүлээр бүрхэгдэж үзсэн тул, бас юунаас айдаг бил ээ? гэж Хоресм шагийн хилэгнэхээс айлгүй, түүний ялт хүү Желал-Эд-Динтэй уулзах гэж хотын гадна байдаг Тиллялын цэцэрлэгт очиж билээ.

Төмөр Мелиг, залуу хааныг нягц цэцэрлэгийн гүнд байхад нь дайралдаж, Желал-Эд-Дин, хивс дээр ганцаараа их бодлого болж сууснаа, зочныг үзээд, яаран босон угтаж,

— Зоригт Төмөр Мелигийн амрыг эрье! Өнөөдөр хэдэн нөхдийг урьсан минь, олонх нь өвчтэй учир, ирж чадахгүйдээ «гашуудна» гэж хариу ирүүлжээ. Гагцхүү, хөдөөгийн гурван хүн, бас чи, Төмөр Мелиг, алс Газна хотоо хэзээ ч олж үзэхгүй, ялт эзэн намайг айлтгүй эргэхээр ирсэн байжээ гэхэд нь,

— Шагийн тааллыг давахуйяа бэрх гээд, Төмөр Мелиг хивсэн дээр суужээ. Желал-Эд-Дин бодширсон маягтай уул яриаг үргэлжлэрүүн:

— Хивчаг бүхнийг хивчаг хунтайжтай байхыг хүстэл миний туркмен хатнаас төрсний минь буруу гэж үзэж болох уу? Хивчаг хүн хунтайж болог л доо. Намайг л эцэг, эгэл цэрэг эр болгох зөвшөөрөл өгч, дандаа тулалдаан болж байдаг зах хил газар явуулаасай. Би агсам хүлэг унаад, гялалзсан сэлэм зүүгээд, эзгүй хээрийн хонгор салхинд явахыг дурлахаас, өвгөдийн үлгэр дуу сонсож, хивс дээр тэрийж хэвтэх уулаас дургүй гэж хэлэв. Төмөр Мелиг тэр үгийг сонсоод,

— Одоо манай эргэн тойрон дайн болж байна шүү дээ. Хивчаг ноёд, тэдний нутагт их цэрэг мордуулахыг Шагаас гуйцгааж, сонсвол, тэр нутагт дорно зүгээс үл мэдэгдэх нэгэн улс түрэн ирцгээж, нутгийг

булаан Хивчагийн малыг сайн бэлчээрээс хөөн зайлуулж байгаа сурагтай гэв. Желал-Эд Дин хариуд,

— Эцэг Хоресмоос хивчагийг үлдэн гаргаж, тэдгүйгээр төрийг баривал сайн сан. Хивчагууд жаргалдаа ташуурч садар самуун болгожээ. Хүнд бэрх цагт миний эцгийг дайсанд барьж өгөхөөс буцахгүй болсон дог оо гэж хэлээд,

— Чи юунд тэгж бодно? гэж Төмөр Мелигийн асуусанд өгүүлрүүн:

— Эзэн, халууны Хоресмийн ард түмнийг итгэхгүй, харь хүйтний хивчагт засаг төрөө даатган мэдүүлж байгаа нь хонио хөдөөгийн хөх чоноор мануулах гэсэн малчинтай адил удалгүй, хонь ч үгүй, унгас ноос ч үгүй болж, өөрөө чонын зууш болно гээд, баахан зайс зогсож байсан ахмад зарцын зүг хөмсгөөр дохисонд, юу тушаахыг бөхийн чагнавал,

— Бидний олон зочин ирнэ гэж их хурим зассанд хүн ирсэнгүй, зам дээр боомт хүн тавьж, зорчиж явсан хүн бүхнийг сайн шинжин асууж, миний сэтгэлийг сэргээн баясуулах хүн байвал, дагуулж авчруул. Миний хайртай азаргыг энд авчирч уяцгаа. Урьсан зочин эс ирэвч, хүлэг морь, их замын гуйлгачныг зочилъё гэж хэлтэл,

— Ир гэхэд чинь ирлээ, гэж тайван дуугарах чимээ сонстож, төдхөн, цэцэрлэгийн бутан сөөгийн цаанаас, хонины арьсан малгайтай, өндөр нарийхан нуруутай туркмен гарч ирээд, гараа цээжин дээрээ тавьж, мэхийн ёслов. Желал-Эд-Дин, түүнийг үзээд, «элчилгүй цөл газрын барс, эрхэм Хар Хончрын ирсэнд баярлалаа. Нааш ирж бидэнтэй суу» гэв.

* * *

Үүнийг үл өгүүлэн өгүүлэх нь зүүн хил тийш бяцхан цайзын арват Али-Жан, таван цэргийн хамт аяны их замаар довтолж мориндоо юм идүүлэх гэж түр зуур буухаас биш, огт сааталгүй хурдавчлан довтолж яваа учир болбол, олзны жигтэй хүнийг Гурганжид амьд хүргэж чадахгүй болуузай гэж яарсан байжээ.

Замд тохиолдох аяны хүн, ямар аюултай дээрэмчнийг барьсан бэ? гэж асууцгааж, хүлээстэй тэр хүний царайг харах гэж ойртон ирцгээхэд Али-Жан ташууряар ороолгон хөөж давхидаг байжээ.

Тэгж явсаар, хоёр суваг олмоор гарч, гишүү сургаагаар барьсан намалзсан гүүр өнгөрч, улиангарын цаанаас Гурганж хотын сүм,

сүмийн гонхны цэнхэр ваар алсаас үзэгдтэл, замын бэлчир дээр цагаан эмээл хазаартай хар морьтой, хүрэн улаан дээлтэй зургаан хүн, зам хөндөлдөж, зогс гэтэл, Али-Жан хашхиран өгүүлрүүн:

— Зам тавь! Шашныг хамгаалагчийн өмнөөс сануулъя. Диван-Арз (төрийн хэрэг шийтгэх газар) чухал мэдээ хүргэх хүнийг битгий саатуул гэтэл,

— Бид, та нарыг л хүлээсэн юм аа. Хоресм шагийн хүү Желал-Эд-Дин, та нарыг одоо дайрч уулз гэж тушаасан гэхэд нь,

— Бид энд саатаж болохгүй, шууд Гурганжид хүрээд, Төмөр Мелиг даргадаа бараалхах улс байна гэтэл,

Тэр боомтын хүн, Али-Жангийн морины цулбуурыг тавилгүй,

— Төмөр Мелиг, манай эзний цэцэрлэгт ноёнтой зэрэгцэн сууж, хоёулаа дуу дуулахыг сонсож байна. Хурдан дага. Чамд хэлж байна шүү! Зодоо хийгээд яах нь вэ? Чиний олзолж авсан хүн чинь, энэ завсар үхэхгүй байх. Харин Желал-Эд-Дин, чамд дээл хувцас шагнаж, пилав хоол идүүлээд, атга мөнгөн дирхем зоос өгнө. Чамд энэ насанд чинь тийм амттай пилав олдохгүй гэж мэдээрэй гэхэд нь, Али-Жан, тарган хонины өөхтэй хаа, сайхан үнэр ханхалсан шиг дотор аятайхан болоод, нөхдөдөө,

— Зогсоцгоо. Тэр газар дайрч, хишиг хүртэцгээе! гээд, дагаж явсан цэрэгтэй, өнөөх хүлээстэй олзныхоо хүнийг хөтөлж явсаар, өндөр хаалганы дэргэд зогсож байгаа хүйтэн царайлсан манаачны цэргийн дэргэдүүр өнгөрөөд, анхдугаар хүрээнээ орвол, бүдэг харанхуйд зэрэглэсэн долоон хэсэг галын улаавтар дөл өндөр гэгчээр дүрэлзэн, дэргэдүүр нь хүрэн улаан дээлтэй эмэгтэй нааш цааш явах нь гал түүдгийн гэрэлд галын өнгөтэй хүн мэт үзэгдэв.

— Мориноосоо бууж, шонгоос уяад, олзны хүнийг хүлээстэй хэвээр морин дээр нь үлдээвэл, морь нь хөлөө ээлжлэн гишгэж, толгойгоо хаялан, цэргийн моринд тэвэр тэвэр өвс өгсөн зүг тэмүүлж байхад, өнөөх эмэгтэйчүүд гүйн ирцгээж, олзны хүнийг зүг зүгээс тойрч, түүний жигтэй байдлыг гайхалцав.

Морин дээр дээсээр хүлээстэй тэрхүү хүн, урт хөх дээлийн ханцуйд улаан бөс зурваслан хадсан байтал, саравч нь дээшээ нугарсан хавтгай эсгий малгайг үзвэл, харь аймгийн хүн ажээ. Чамархайд нь усны үхрийн эвэр шиг хоёр хар гэзэг[23] эвхэж унжуулсан нь мөрөн дээр унжжээ.

Нэгэн зүг гөлрөн ширтсэн нүд нь их л догшин зэрлэг байдалтай үзэгдэж, цугласан улс шивнэлдэн зарим нь,

— Үхсэн хүн бололтой гэж зарим нь,

— Үгүй, амьсгалж байна, буруу номт бүгд, амь бөхтэй шүү гэж ярилцах завсар, зарц Али-Жанг,

— Миний хойноос наад муухай амьтнаа аваад яв гэж, Али-Жан, тэр хүлээстэй хүнтэй морины уяаг тайлж, тооройн залуу мод, өндөр харгай модны нэвтэршгүй нягт хар ногоон навчтай алаглан хольцолдсон сүүдэр ихт цэцэрлэгийн засмал замаар хөтөлж явсаар, түргэн урсгалт устай шуудуу, сэхээвчийг тойрон мушгиралдсан газрыг хүрвэл сэхээвчийн өмнө мяндас шиг гялалзсан үстэй, намиртал самнасан дэлд нь хүрэн улаан тууз сүлжин гөрсөн 6 хар, 6 хонгор зээрд, бүгд 12 азарга эгнүүлэн, гинжээр намхан шонгоос уяад хоёр идэр эр, зэс цар барьж, зүссэн амтайхан гуа жимсээр тэжээж байсныг үзээд, Али-Жан, галт сайхан нүдтэй, хун шувууны хүзүүтэй ямар сайхан хүлэг вэ гэж харсаар, хөгшин том харгай модны дор сууж байсан хэдэн хүнийг анхлан ажиж харсангүй.

Тэнд бяцхан талбарт перс хивс дэвсэж, мөнгөн таваг, Иракийн шилэн сав өрж, таваг саваар дүүрэн чихэртэй, эрээн боорцог идээ, чихэр, шинэ жимс, хатаасан жимсний зэрэг амттаныг тойрон хэдэн хүн сууж, түрүүнд нь Энэтхэгийн чалма малгай өмссөн, хар дээлтэй, хүрэн царайтай залуу хүн онцгой шиг сууж, бусад нь түүнийг гэрийн эзний ёсоор хүндэтгэн, тэр хавьд бас хэдэн хөгжимчин зарим нь хуурдаж, зарим нь үлээвэр лимбэ үлээж, хоёр хүн хэцийг түчигнэтэл цохих зэргээр сэтгэлийг мэнэрүүлэх хөг нь цэцэрлэг дүүрэн сонстож байлаа.

— Гелюбсен, гелюбсен (хүрээд ир, хүрээд ир!) гэж тэр хүрэн боровтор царайтай залуу, суусан газраасаа шаламгайлан босож, бусад нь дагалдан босоцгоож, өнөөх үл хөдлөх олзны хүний дэргэд очиход, Али-Жан, залууг Шагийн ахмад хүү Желал-Эд-Дин гэж мэдэв.

— Чи барьсан уу? Хаанаас олж барив гэж асуухад нь,

— Би үүнтэй Отрарын орчим хээр дайралдаад тун шөрмөслөг тэнхээтэй юм билээ. Арай гэж хүлсэн шүү гэхэд нь,

— Хэн гэгч вэ? Ямар аймгийн хүн бэ? Юу гэж хэлдэг хүн бэ? гэхэд нь,

— Ер үг дуугарах дургүй юм аа гэж хариулахад нь,

— Амь нь тасрах гэж байх шив дээ. Үхэж байна уу даа энэ чинь? гэтэл,

— Жа, бүү мэд, хаантан минь. Би, Хоресм шагийн мэлмийн өмнө амьдаар хүргэх гэж, хар хурдаараа довтолсон юм даа гэхэд нь,

— Чи давхисаар наадахыгаа алах нь ээ. Яриулж үзэх юм сан гээд, алгаа ташиж, зарцыг дуудаад,

— Чи эмч Заваан гэгчийг эм домтой хүрч ир гээ. Хүн үхэж байна гэж хэл гэхэд нь,

— Жа, хаантан минь гээд, зарц гүйн одлоо.

Тэр завсар, өнөөх олзны хүн, ухаан орж нүдээ бүлтийлгээд, амаа ангайлган урхирч, хүлээсээ тайлах гэж тийчгэнэн бархирав. Энэ юу гэж хашхирч байна гэж Желал-Эд-Диний асуухад Али-Жан хэлмэрчилж,

— Энэ хүн чиний хүлгийг хараад «Юутай сайхан хүлэг вэ? Яасан сайхан аргамаг вэ? Гэвч, эндээ тогтож чадахгүй дээ. Бүгдээрээ ялагдашгүй Чингис хааны адуун сүрэгт хураагдаж, ганц Чингис эдлэх болно» гэж байна гэхэд нь,

— Чи энэ буруу номтны хэлийг хэрхэн мэддэг болсон бэ? гэж асуусанд:

— Би урьд, хятад газар аян хийж явахдаа, татар нутгаар явж, хэлийг нь сурсан гэж хариулжээ.

— Ялагдашгүй Чингис хаан гэгч хэн бэ? Тэр ямар учраас ялагдашгүй болсон бэ? Энэ буруу номтон ямар аймшиггүй ийм хэрцгий үг хэлэв. Ганцхан Хоресм Шаг, хотол олны ялагдашгүй эзэн даруй мөн. Тэнд энэ мэт чалчвал, үүнийг цавчин алсугай гэж Төмөр Мелигийн хилэгнэсэнд Желал-Эд-Дин, хөндлөнгөөс өгүүлрүүн:

— Яривал яриг, бид үүнээс үг туршиж, Татаарын ялагдашгүй эзний тухай бага сага юм мэдэж авъя гэтэл, цэцэрлэгийн модны цаанаас нэгэн нарийхан хоолойтой хүн,

— Аллах тэнгэр, мусульман бүхнийг гэрэлтэй илдтэй, хосгүй сайхан хүлэгтэй, эр их зоригтой, эрхэм гэгээн Желал-Эд-Диний эрдэм чадалтай адил чадалтай болгох болтугай! Желал-Эд-Диний илд, Исламын дайсан бүхний тэргүүн дээр гэсгээн шийтгэгч аянга мэт ниргэн буутугай! гэж аман дотроо уншсаар айсуй.

— Үзвэл, нэгэн том чалма малгай өмссөн, бяцхан биетэй урт сахалтай хүн, цэцэрлэгийн нарийн замаар гартаа арьсан уут, том маалуу барьж бүснээс элдэв зүйлийн зэс хэрэглэл, хутга, шилэн сав

өлгөсөн нь хөдлөх бүрд хангир жингэр дуугарсаар ирж, Желал-Эд-Диний өмнө газар хүртэл мэхийж ёслон,

— Өчүүхэн хүн, чиний өршөөлөөр гамшиг аюулын уурхайнаас ангижирсан билээ. Чиний өгөөмөр хишгийг хүсэж, үүдэнд чинь хүрч ирсэн миний биеийг амь хагацах гэж байгаа хүнийг тэнхрүүл гэж дуудсанд хүрч ирлээ гэж олон юм тоочин үглэтэл, Желал-Эд-Дин, түүний айварлахыг гараар тохиж, нэг мөсөн зогсоон өгүүлрүүн:

— Эмч Заваан, чи хэлээ түр амраа. Наадах өвчтэй хүнийг үзэж чадлаа гаргаж эмчил, эрхбиш амьдруул гэв.

— Би, чиний зарц, чиний боол, эзэн чамайг юу гэвэл, гүйцэтгэхийг бодно гээд, тэр бяцхан эмч зарц дуудаж, олзны хүнийг мориноос буулгаад, хүлгийг тайлуулбал, тэр хүн агсагадсан тул, алцайгаад арай гэж зогсон ядаж байв.

Зарц нар, эмчийн тушаасан ёсоор тэр харь хүний биед жигшин хүрч, амандаа уншлага шивнэн уншсаар, хувцсыг нь тайчин, эсгий дээр хэвтүүлбэл, тэр хүн ер хөдлөхгүй, мэдээ алдаж нүдээ цагаанаар нь харж хэвтэв.

Эмч, таринь урьж өвчтөний хэнхдэгт тунгалаг тос шүршиж хатсан шархыг цагаан будаа мэт дүүрсэн өтийг ясан халбагаар хусаж хэлсэн нь:

— Өтчихсөн байна. Гэвч ариун сударт өгүүлсэн нь, «Аллах олон өвчнийг заясан боловч, тэр өвчний тоогоор их мэргэн Аллах, бас, эм заясан гэдэг» гээд, шархнаас цус гармагц, тостой хөвөн тавьж, бүх биеийг бөсөөр ороо гэж тушаагаад, Желал-Эд-Диний зүг өгүүлрүүн;

— Аяа гэгээн хаан минь, аяа эзэн минь ээ, би Арабын маш их эрдэмтэй эмч, оточ, нүдний өвчин цагаа анаахад мэргэжээд Ромын Гиппорытын зохиосон номыг судалж, булгарсан хугарсныг барих, үхлийг зайлуулах чадалтай оточ билээ. Би чиний зарц боол, ганц чиний хишиг өршөөлд шүтэж явдаг хүн. Одоо надад нэгэн хувин хуучин дарс өгнө үү? Эм найруулъя. Миний эмнэлгийн сүүлээр энэ өвчтөн юм ярьж нэг хоёр хоног яриад, үхэх сэхэх нь тэнгэр мэднэ гэж архийг аваад, элдэв эмтэй хольж амсан үзээд, тэр өвчтөнд уулгасанд өнөөх хүн сэргээд ярьж эхлэв.

Царай нь гэнэтхэн халууран улайж, анхандаа дуу дуулснаа үл мэдэгдэх үг хэлж хашхираад, сүүлд нь шүлэг хэлж байгаа юм шиг, хэмжээт шүлэглэл мэт үгсээр аятайхан хүүрнэн ярьж, халуунтай хурц

харцтай нүдээр алсыг ширтэн өгүүлснийг Али-Жан чих тавин сонсож орчуулсан нь,

— Хосгүй сайхан жаргал төгс нутаг минь, гучин гурван элсэн говь тал нь ягаан өнгөт шилийн нэг захаас нэг зах хүртэл нь мэлийгээд, хурдан хүлэг мориор давхисан ч захад нь гаршгүй уудам нутаг минь атар талын ганхсан өвсөнд нь ан араатан цувж, далан зүсний зээр сүрэглэн бэлчиж, яруу дуутай жигүүртэн шувуу зүйл зүйлээр донгодож, оюу номин өнгөтэй огторгуйд нь хун галуу дэвэн нисэж, хүн бүхэн жаргалтай боловч, хөөрхий манай аймагт хөл гишгэх газар олдохгүй, хүчирхэг олон аймаг түрэн ирж, шунахай хаад ноёд нь манай бэлчээр нутгийг булаан эзлээд хур таргатай адуун сүрэг, үхэр, хонио бэлчээж, буурай бидний хөл гишгэх газар гэвэл, хайр чулуутай говь, хад хавчлаас өөр газар олдохгүй болжээ. Хайр чулуу, элсэн манханд мал сүрэг минь турангилан хорогдож, хүлэг морь маань эцээд, өргөдөг адасга болов. Ертөнц дахиныг дээрэмлэх гэж Монгол улсыг удирдан дагуулагч шар сахалтай, ялагдашгүй Чингис хаан, түүний харьяа хатуу сэтгэлт хаадын гайгаар ийм зовлонд уналаа гэж эгшиглэн хүүрнэхэд нь Желал-Эд-Дин,

— Энэ чинь Чингис хаан гэж юугаа дурсаж байна гэж асуув. Али-Жан, тэр үгийг олзны хүнд орчуулж хэлж өгөөд тэр хүн дуу алдан өгүүлрүүн:

— Тэмүүжин Чингисийг хэн эс мэдэх бил ээ? Би түүнээс зугтаан зайлсан хүн. Чингис хаан өмнө нь боол мэт нуруугаа бөхийлгөхгүй хүнийг өршөөн хэлтрүүлдэггүй, эсэргүүцэж эс дагагсдаас өшил нэхэж, хүйс тэмтрэн хяддаг юм аа гэж хэллээ. Тэгэхэд нь, чи өөрөө ямар хүн юм бэ? Яагаад, Чингис хааны эсрэг ийм зүрхтэй үг хэлдэг билээ гэж асуувал,

— Би Гур хаан мэргэний баатар гэгч байна. Би өөрөө өөртөө хаан, өөрөө өөртөө цэрэг болоод, тэр ярвагар өвгөн миний эцэг, ах дүү нарын нурууг хуга татуулж, шар сахалт тэр хаан, хамаг үзэсгэлэнт охидыг дураар хураан авч, шивэгчин болгохоор барахгүй, дэлхий дахинд түүний эрхийг дагахгүй, өөрийн эрх дураар явдаг хүнийг үздэггүй дээрээс би Чингисийн цэргээс босож зайлсан хүн билээ. Би эндээс орчлонгийн адагт хүртэл явж, ан гөрөөстэй газар миний адил эрх чөлөөг эрхэмлэгч анчин байдаг газар хүрч, хорт Чингис хааны цэрэг хүрч чадахгүй хол газар нутаглана гэж хэлээд:

— Одоо Чингис хаан, хаана байгаа вэ? Яах санаатай байна? гэж Желал-Эд-Динийн асуухад,

— Одоо Чингис хааны улс, ус бялхаж, боомт даландаа багтаж ядан халих гэж байгаа их нуур бялхмал шиг болж, Чингис хаан, зэхээстэй цэрэг нь илдээ хурцалж, баруун зүгийг байлдах тохиог хүлээж байна. Танай газар дээрэмдэхээ ирнэ дээ гэхэд нь Төмөр Мелиг,

— Бид энэ сайн эрийг эндээ үлдээж, туркмен хүүхэнтэй гэрлүүлж, Хар Хончрын нутагт гэрээ бариад Хар Хумаар дураараа гөрөөлөн нутаглаг гэж хэлээд Желал-Эд-Дин асууруун:

— Чингис хаан гэгч чухам хэн бол, энэ хүний уг сэтгэлийг зовоож байна. Чингисийн сураг мэдээг гаргаж авах юм сан гэв. Төмөр Мелиг босож өгүүлрүүн:

— Их хаан та намайг өршөөнө үү? Би энэ олзны хүнийг авч, Диван-Арзад толилуулъя. Чингис хаан гэдэг нүүр нүдгүй дайрдаг эрийн учир, энэ хүнээс мэддэгийг нь асууж авъя гэхэд нь, Али-Жан мөн өгүүлрүүн:

— Эрхэм эзэн намайг өршөөнө үү? Миний хань нөхөд цөм чиний хайрласан амтат идээг хүртээд унаа морь ч цадтал юм идэв. Бид таны хишгийг хүртээд, сэтгэл бахдан ханав. Одоо энэ нүгэлт буруу номтныг цааш Гурганжид хүргэж, цааш цайзад нэвтрэн орохыг соёрхоно уу гэсэнд, Желал-Эд-Дин, за гээд ахлах зарцад чи энэ цэргийн эрд хонины арьсан шинэ дээл олго гэж тушаав.

Али-Жан мэхийн ёслоод,

— Жигүүртэнд нисэх, зочдод амрыг эрэх, гэрийн эздэд хүндэтгэх сэтгэлийг илэрхийлэх, аяны эрийг замаа хөөх нь зүйтэй гэжээ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ : ИРГИС ГОЛЫН БАЙЛДААН

ХИВЧАГ НУТАГТ ДАЙЛААР МОРДОВ

Афросиаб дуудан өгүүлрүүн:
«Би аян дайнд мордлоо. Миний морины сүүлийг ал[24] *улаанаар будтугай» гэжээ.*
(Персийн эртний дуунаас)

Хоресм шаг Мухамед, Гурганж хотноос Самаркандын зүг их л хилэнтэй довтлон мордож, эзэн өөдөөс аймшигүй сэлэм өргөсөн хүргэн Османы тэр хотын ардын хамт занаж, хайр найргүй өшөөгөө авна гэж шийджээ. Чингээд, эс дагагсдыг нялх хүүхэд, насанд хүрэгсэд гэж ялгахгүй, гадаадын хүнийг ч хүртэл алан сөнөөнө гэж зарлаж, хотыг бүслэн байлдаж эхэллээ. Самаркандын нарийн гудамжийг дүнзэн модоор хашиж удтал тулалдаад эцэст нь Осман хаан, ясаа ороох цагаан даавуу, толгойгоо авах мэс барьж, дагасан сэтгэлээ илэрхийлэн Шагд бараалхаж, сөгдөн мөргөсөнд, Шаг, тавнангаа[25] чингэж мөргөсөнд сэтгэл зөөлөрч, ялыг хэлтрүүлэхээр болоод байтал, хотыг бууж өгсөн хойно, баатар зоригтой байлдсан охин нь ирж эцэгтэйгээ уулзаад эр нөхрөө уучлахгүй цаазаар аваачихыг шаардсан тул, шөнө Османы цаазаар аваачжээ. Осман тавнангийн төрөл төрөгсдийг хүйс тэмтрэн хядсан тул, Самарканд хотын засаг ноёдын эртний хар хааны угсаа сурвалж тасран мөхжээ. Хоресм Шагтай хамт ирсэн хивчаг хаад, Самарканд хотын ард иргэдийг харгис догшноор зовоож, түм илүү хүнийг алаад, бас дээрэмдэн хядах гэснийг харгис боловч, хянуур болгоомжтой Турхан хатан эх хориглон зогсоожээ. Тэгээд Хоресм Шаг, Самаркандад нийслэлж, их ордон барих ажлыг үүсгэжээ.

Хивчаг хаад, нутагтаа цэрэг удирдан дорнод цөл говиос түрэн орж, бэлчээр нутгийг нь эзэлсэн Татаарын мэргэд аймгийг дайлж өг гэж, Хоресм Шагийг шаардаж, Шаг төрийн үйл их, бас ордон байгуулах ажил үлэмж гэж шалтгаалж байсан билээ. Тэгэхэд нь эх Турхан хатан, хивчаг хаадад нэг мөрний хүч хавсран гуйлцав.

Хөгшин бүргэд, хүн амьтан халдахгүй хадны оргил дахь үүртээ нүцгэн хүзүүт ангаахайгаа асарч, алсын барааг ширтэн хардагтай адил, эм бүхнээс бач ихтэй, холч хар санаатай тэр хатан, Шагийн хаан ширээг сэтгэл алдагдсан албат ардын самууран босох, зальхай хаадын

нууцаар хуйвалдах, сэмээр хорлохоос арчлан хамгаалж, түүний хүү, ялагдашгүй Хоресм Шагийн эсрэг аймшиггүй гар хөдөлсөн бүхнийг үгүй хийх гэж Гурганж дахь, хүнийг хавьтуулдаггүй сүртэй ордноос итгэлт хивчаг цэргийг баг багаар явуулж байдаг тул Хоресм Шаг, болгоомжит эхийнхээ сануулсныг хайхрахгүй байж яахан болох ажээ.

Чингээд хойтон хавар нь эртэлж Мухамед, Гурганж хүрч, тэндээс морьт их цэрэг дагуулан аянд мордоод арван баг цэрэг, арав хоногийн дотор хотоос гарч, баг тутам, зургаан мянган морьт цэрэг хөтөлгөө морьдодоо арвай, будаа, тутарга тос, хөхүүртэй айраг ачиж мордсон байжээ.

Хоресм Шаг, цэргийн сүр, дайны хэнгэргийн нижигнэх, цэргийн мордох дохио өгөх бүрээний хүнгэнэхэд дуртай байжээ. Хэдэн түмэн цэргийн өмнө өргөн цээжтэй, сүүлийг нь ал улаанаар будсан, хээр морины алтан эмээл хазаар, эрдэнийн чулуу гялалзан давхиж, унасан эзний нь гутлын бяцхан мөнгөн хонх жингэнэн дуугарч, очир алмаасын эрхээр сүлжин ороосон цав цагаан малгай, хар сахлыг нь хармагц, Хоресмд танихгүй хүн үгүй байжээ. Тэр морьтой хүн бол Исламыг хамгаалагч, үнэн шашныг тэтгэгч, буруу номтныг айлган сүрдүүлэгч Хоресм Шаг Ала-Эд-Дин Мухамед бөгөөд хилэгнэхийн аянгыг Вивангирид[26] богдын ач, Багдадын Халиф Насирт буулган, харьяат улсын хилийг орчлонг байлдан дагуулагч, ялагдашгүй Искендерийн хүрч чадаагүй элчилгүй цөл хүртэл тэлсэн хүн билээ.

Түүний их цэрэг арван хоногийн газар үргэлжлэн цувж, нэгэн цуваа цэргийн хэдэн мянган морьд нь зам гудасын худгийн усыг шавхтал уух тул нэг хонож сая дахин устай болдог байжээ.

Тэргүүнд явах багт хайгуулын цэрэг явж, дараах цэрэгтэй Хоресм Шаг, майхан тогоо, зоог шүүсний арвин хэрэглэл ачсан хурдан тэмээ явалцаж, сүүлчийн 10 дугаар багт хэзээд дагаж өгдөггүй төвөгтэй Туркмений хамт Шагийн ялт хүү Желал-Эд-Дин явалцаж, Туркмен, хивчагийн ховдог омголон зантай гэж эв муутай явдаг байжээ. Туркмен орой түүдэг гал дүгрэглэн асааж, гал тойрон гялалзсан махир сэлмээ хурайлж, цэргийн бүжиг бүжиглэн дуулцгааж хатиран наадах бүлгээ.

Их цэрэг, Хоресм тэнгис гэдэг байсан Арал тэнгисийг хөвөөлөн явж, Сайхун гэдэг Сердарья мөрнийг гаталж, Шар Чинанагийн булан хүрч, Хоресм Шаг, цэргийг буудалхийлгэж, урьд явуулсан тагнуулын мэдээ хүлээх завсар оюу өнгөт тэнгисийн эрэг дагуу начин шонхортой авлан явж, нугас, тогорууг багц багцаар авчирчээ.

Тэр завсар тагнуулын хүн ирж, Иргис голыг Чилхар нуурт цутгах адгаар хойд зүгт мэргэдийн адуун сүрэг үзэгдэв гэх мэдээ хүргэж ирсэнд, Хоресм Шаг, хойдох цэргийн хүрч ирэхийг хүлээгээд цэргийн даргыг хуралдуулан давшин байлдах бодлогыг хэлж өгөв. Цэргийг гурван анги хуваан гол ангид Хоресм Шаг биеэр явалцаж, дайсныг эцэст шийдвэртэй цохих зорилготой, зүүн гарын цэргийг хивчагийн Торгай хаан, баруун гар жигүүрийг Хоресм Шагийн хүү Желал-Эд-Дин жанжилж байлдана гэж төлөвлөсөн нь байлдаанд дуулгаваргүй дур зоригоор явагч хүүгээ хэрхэн тулалдахыг турших санаатай байжээ.

Цэргийн хүрээнд Гурганжаас элч довтлон ирж, Шагийн эх Турхан хатны захиа хүргэж ирсэнд, ордны дарга бичээч ноёнтой Шагийг дагаж цацарт нь ороод, Шаг, боодлыг чинжаал хутгаар задалж дотроос нь улаавтар торгон бяцхан хүүдий гаргаад, лал ёсоор дух уруулдаа хүргэн адис аваад нээвэл, дотроос нь хуйлмал урт цаасанд том гэгчийн үсгээр бичсэн захидал гарсан нь,

«Шашин ном, үнэн шударга ёсны адистидат их өмөг түшээ, Ала-Эд-Дин Мухамед Хоресм Шагт илгээв. Хаан төрийг нь Аллах тэнгэр ивээтүгэй. Амрыг эрнэ. Имам лам нар, өдөр бүр сүм бүхнээ хамгийг чадагч дээд заяат тэнгэрт таван удаа залбиран, чиний насан хутгийг уртатгаж атаатан дайсныг ялах болтугай гэж мөргөж байнам. Тэр ёсоор болтугай!

Багдадын Халифын явуулсан нэгэн Дервишийг зээлийн газар барив. Тэр хүн, Хоресм Шагийг персийн буруу номд орсон учир, Аллах тэнгэр манай хайрт Шагийг хэсгээж, буруу номт Яжуж Мажуж гэдэг хоёр улсыг явуулж, манай улсыг мөхөөнө гэх зэргээр ухвар мөчид хүмүүст номлож явсан байна.

Тэр чалчаа Дервишийг зандалчны тэргүүн Жихан-Пехлеван барьж аваад улайсгасан төмрөөр хайрч, эрүү шүүлт тулгаад зээлийн талбарт хэлийг огтлоод дүүжилж алав.

Тэрхүү цээрлэлийг үзээд олон их л сүрдэн айх биз ээ. Үүнээс өөр зүйлгүй, цөм тайван сайхан байнам. Чиний төр олон он амгалан тайван байх болтугай.

Бүх дэлхийн эмэгтэйчүүдийн эзэн Турхан хатан,

гэжээ.

Манагаар эрт олон цэрэг гавшгайлан хөдөлж, нэг буудаллаад Иргис мөрөн хүрчээ.

Өргөн талаар хаврын хөх ногоо халиурч, шар, цэнхэр, ягаан цахилдаг, улаан алтан зул цэцэг, ерийн цагт гандуу хахир талын элсэнд эрээлэн ургаж, наран заримдаа нүд гялбам гийж, заримдаа борооны үүлний далд орж, Иргис гол хөвсгөр нимгэн мөстэй хэвээр боловч, мөсний дээгүүр ус хальж, энд тэнд мөсний ан завсар үзэгдэж, цэрэг гаталж хараахан болохгүй байжээ. Хоресм Шаг, цэргийн мэргэд мэдэж, тал тийш зайлуужин гэж болгоомжлон хотгор газар хулс зэгсэнд сэм бүгтүгэй гэж тушаагаад цэрэг, хоёр хоног гал ноцоолгүйгээр амарч, хоёр дахь шөнө учир нь үл мэдэгдэх гэрэл огторгуйд үзэгдэж, тэнгэр улаан цог шиг өнгөтэй болоод одод харагдахгүй, оройн туяа, өглөөний гэгээ шарлахтай авалцан үргэлжилсэн юм шиг болсныг их цэргийг дагалдан яваа Шейхи уль ислам гэдэг лалын шашны их ламд Хоресм Шаг Мухамедын их алдар мандахын бэлгэ тэмдгийг Аллах тэнгэр заяажээ гэж тайлбарласан билээ.

Тэгээд голын мөс алга болмогц, тагнуулын цэрэг олом олж, бүх цэргийн олон баг цөм ус гаталж, голын тэртээ гараад, хааяа дов толгодтой, чив чимээгүй, учир нь үл мэдэгдэх тэр цөл талд дөнгөж мэдэгдэх нарийн зөрөг замаар дорно зүгийг чиглэн аялж явахдаа мөд байлдана гэж бөөгнөрсхийн явлаа.

Чулуурхаг ухаа гүвээний хоорондох нэгэн хоолойд хэдэн хар гэр үзэгдсэн нь дүрвэж зайлахдаа орхиж явсан бололтой. Зам гудас ширдэг, эсгий, эм хүний хувцас хунар хуучин хивс хаялж, бас чихэн дээрээ хоёр хар гэзэгтэй, онигор нүдтэй, шар царайтай хүн хэвтэж өсгийд хүрэм урт, онгомол цэнхэр дээл нь энд тэнд тасар цавчуулж, цаана нь хажуугаар унасан хоёр дугуйтай тэрэг хэвтэв.

Туршуулын цэрэг довцог дээр гарч хажуу тийш дохин заасанд их цэрэг тэр зүг нуман жагсаалаар эргээд хатируулснаа морины амыг дахин татаж, их талын захад хүрсэнд хар цохоор юм болсон бор тал цэлийж, эмээлтэй морь эзэнгүй дэмий л явахыг үзээд,

— Дайн болсон газар байжээ. Мөнх Аллах тэнгэрийн хүчээр энэ олон дайчин цэргийн насан эцэс болж дээ гэж ярьцгааж, зарим цэрэг,

— Хэн эднийг хядан алж дуусав? Хэн манай олзыг завдан булааж орхив? Энэ дарагдсан цэргийн адуу тэмээ нь яаж орхив? гэж гайхацгааж; хүүрээр дүүрсэн талыг туулан явахад мэсэнд цавчуулж, жад суманд, хатгуулж үхсэн хүний хүүрийг холоос харахад новш хаясан юм шиг, зарим газар ганц нэгээр, зарим газар арваад арваадаар хэвтэж, зарим нэгний гутал хувцсыг тайчин авсан байжээ.

Цэрэг, тэр байлдааны газар эрийн нэг тарж, зарим нь хаясан сэлэм, зарим нь дүгрэг бамбай буюу жад түүж, Хоресм Шаг их л бодлого болсон шинжтэй, хар сахлаа мушгин явж, дэргэд нь шадар бараа болон явагчид, хоорондоо сэмээр шивгэнэлдэн хэлэлцэж,

— Энд тун сүрхий байлдаан болсон юм байна даа. Хэдэн мянган мэргэд алагдаад, ер амьд амьтныг үлдээсэнгүй, шархдагсдыг нь ч цохин алж хиар хяджээ гэж ярилцаж явтал нэг морьтой хүн давхиж ирээд,

— Би нэг амьд мэргэд хүнийг оллоо, үг хэлэх тэнхээтэй юм шиг байна гэхэд нь, Хоресм Шаг тэр зүг давхин, бараа бологсод хойноос нь дагалдан очиж үзвэл, нэгэн мэргэд хүн, довцог толгойн ёроолд цөмцийн сууж, Хивчагууд тойрцгоон энэ тэр юм асууж байлаа.

Тэр мэргэдийн үсээ зүйлсэн толгой нь хага цохиулж, цус нөж болжээ.

Хоресм Шаг асуууруун:

— Энэ хүн юү хэлж байна? Ямар аймгийн хүн бэ? Хэнд хутгалуулчихаа вэ? гэхэд, тэр мэргэд ёолон уйлан өгүүлрүүн:

— Манай улс их улс билээ. Одоо үндэс нь тасарлаа. Мэргид гэдэг улс билээ. Маний хаан Тогтох хаан гэж байсан билээ. Алдарт анч мэргэн Холт хаан хүүтэйгээ зугтан оргоод, харц мэргэдтэй, та нар бидний хамт шар сахалт Чингис хааны өшин хилэгнэхээс зайлан явъя. Чингис, мэргэд аймгийг хүйс тэмтэрч үгүй хийнэ гэсэн шүү. Баруун зүгт Давст нуурын тэртээ тэнгис хүртэл Хивчаг нутаг бий. Бид тэнд очиж нутаглая. Тэнд үхрийн дуртай өвс ногоо иттэй, өтгөн зэгс хулстай сайхан газар. Манай мал тэнд очоод үржин өсөх вий. Хивчаг бидэнд нутаг олгож, нэгэн тогооноос хооллож, нэгэн хөхүүрээс цэгээ ундаалж, биднийг элэгсгээр үзнэ гэж манай хаад захисан билээ. Бид юу гэх вэ, ард маань үхэх аюул, өмнө маань эрх тааваар цэнгэн амьдрах горьдолтой байжээ. Манай хойноос Чингисийн хоёр догшин нохой, мөрийг мөшгөн хөөж, шар сахалтын ахмад, хүү 3өч хаан, тэр хоёрыг тухирч явуулсан билээ. Тэр хоёр нохойн нэг нь Сүбээдэй, нэг нь Тогоочир ноён гэдэг. Бид, чадал мэдэн хурдалж, чулуурхаг говь, улаан элсэнд мөр сураг алдуулан зайлах гэж оролдовч, морьд эцэж туйлдаад, туурай нь хагарч ер явж чадахгүй болоод хоёр түмэн монгол цэргийн догшноор дайрахад амь хаацайлж зайлах газаргүй болж, Иргис гол халиад дээгүүр нь мөс хөвж, морь шаварт шигдээд, явахын аргагүй болж, мэргэд их улс сөнөжээ. Нэг хэсэг нь энд Монголчуудад хядуулж,

нэг хэсэг нь олзлогдоод шар сахалт Чингис хаан, шар гэрийн дотор олон давхар эсгий дээр сууж инээж байгаа биз ээ. Мэргидийн эртний алдар нэр мөхөв. Ганцхан урвагч залуу гоо Хулан хатан амьд үлдэж, Чингис түүгээр хамгийн сүүлийн эхнэр болгож авлаа гэхэд Хивчаг түүнийг сонсоод:

— Биднийг тэр дээрэмчний зүг удирдана уу? Бид хядан сөнөөе. Тэд холдоогүй бий. Олзны мал хүнийг туугаад, юуны хурдлан явах аж. Тэдний олз зүйлийг булааж авъя гэхэд Хоресм Шаг,

— Бид мөд гүйцнэ гээд алагдсан мэргэдийн хувцас шувтчин, талаар тарж олзорхон явсан цэргээ цуглуулах бүрээ тат гэж бүрээчинд тушаажээ.

ҮЛ ТАНИХ АЙМГИЙН ХҮНТЭЙ ТУЛАЛДАВ

Аав, та, Рустам баатарт «Дайсныг чадалгүй өчүүхэн гэж бүү басамжил» гэж Залийн хэлснийг сонссон уу?
(Персийн эртний дуунаас)

Цэрэг шөнө дүлэн яваад, морио өллүүлэх гэж хоёрхон удаа түр буудал хийж явтал, өглөө нь манан татаж баг цэрэг бие биеэ харахгүй тасрав. Туршуулын хүмүүс чоно цөөврийн улихыг дуурайн гунилт нарийн хоолойгоор мэдээ авалцан явтал, салхи хөдөлж мананг сөхөөд, тэнгэрийн шарлан туяарсан хормойд дов толгод завсарлан харагдаж, хормойгоор нь тоо томшгүй олон түүдэг гал сүүмэлзэн үзэгдэж, ойртох тутам морьтой хүн, ачаатай хасаг тэрэг, тэмээ үзэгдэж, үл мэдэгдэх аймгийн хүрээ буудал ажээ. Хоресм Шагийн цэрэг айсуйг хэдий мэдсэн шинж илрэв. Замхран арилж байгаа манан дотроос гучаад морьтой цэрэг гарч, арав арваар жагсаж ойртов. Нарны ташуу гэрэл тэдний урт хөх дээл, төмөр хуяг, дуулганд тусаж, унасан морь нь бие бага, дэл урт, хөл бүдүүн ажээ. Өмнөх арвантай хамт өндөр Туркмен азарга унасан цагаан малгайтай, хүрэн улаан дээлтэй, цагаан сахалтай лал хүн явж, дэргэд нь цагаан морины сүүлээр хийсэн цацагтай жад барьсан морьтой хүн явалцаж, тэр лал өвгөн,

— Амрыг эрье. Би бас лал хүн шүү. Таны их жанжинтай ярих хэрэг байна. Аллах тэнгэр танай их жанжныг ивээтүгэй! гэхэд нь,

— Манай цэрэгт жанжин олон боловч, бүгдийг исламын илд, орчлонг айлгагч аянга, Хоресм Шаг Ала-Эд-Дин Мухамед мэддэг гэж

хариулсанд, тэр өвгөн мориноос бууж, гараа цээжний тус нугалан ёсолж мэхэсхийгээд гоёмсог хаадын дугуй хүрээлж байсан маш сайхан морьтой Хоресмийн Шагийн өмнө очоод,

— Дорно зүгийн эзэн Чингис хааны хүү, монгол цэргийн эзэн их ноён Зөч хааны тушаалаар баруун зүгийн хүчит эзэн Ала-Эд-Дин Мухамед таны амрыг эрнэ. Аллах тэнгэр чиний төр барих насыг зуун хорин он уртатгах болтугай! Зөч ноён чиний амрыг эрэв гэсэнд Шаг сонсоод,

— Амрыг асууя гэж хариу өгүүлбэл, өвгөн өгүүлрүүн:

— Зөч хаан, Шагийн баатар цэрэг юуны учир, монгол цэргийн мөрөөр шөнөжингөө нэхсэн билээ гэж асуулгасан гэвд хариу хүлээвэл, Шаг, хар сахлаа шувтран, Монголын элчийг догшин харцаар ширтэн дув дуугай харав. Тэгэхэд өвгөн өгүүлрүүн:

— Зөч хаан, бас ялагдашгүй, эзэн эцэг Чингис хаан Сүбээдэй Тогоочоор хоёр жанжиндаа тэрслэн урвасан мэргэдийг хэсгээн залхаа гэж тушаасныг уламжил гэж надад захисан. Монгол цэрэг одоо мэргэдийг хүйс тэмтрээд нутагтаа буцаж явна гэж хэлээд өвгөн нэг хэсэг дуугай болж, Шагийн ажиггүй байдалтай хатан сүрт царайг ширтээд өгүүлрүүн;

— Эсгий туургатан бүхний эзэн Чингис хаан биднийг лал цэрэгтэй тохиолдвол элэгсэг найртайгаар харилц гэж захисан билээ. Энэ учраас Зөч хаан найртай сайхныг илэрхийлж олзны эд хүнээс эрхэм Шагийн цэрэгт хувь гаргаж өгнө гэсэн билээ гэхэд нь Шаг хээр морио ташуураар ороолгож, морь нь Мухамедын чийрэг гарт жолоогоо тас бариулан, дороо бүжиж, Шагийн хариу хэлсэн нь:

— Чи ноёндоо очиж хэл. Чингис хаан надтай бүү битгий байлд гэсэн бол Аллах тэнгэр намайг танай цэрэгтэй байлд гэж бошиглосныг хэл. Би танай зэргийн тэрс буруу номтон та нарыг хядаж, хамгийг чадагч Аллах тэнгэрийн хишгийг хүртэхийг хүсэж байна гэсэн алдарт үгийг шадар сударч түшмэл Мирза-Юсуф «Шагийн айлдсан үг, байгуулсан гавьяа зүтгэлийг тэмдэглэх, аяны дэвтэр»-т зогсоогоор тэмдэглэж авав.

Хэлмэрч өвгөн үүнийг цочин сонсоод, Шагийн хэлсэн үгийг эргэцүүлэн бодож, бие хөших мэт хөдлөлгүй зогстол, Мухамед байлдахаар шаламгайлан жагсаж байгаа цэргийн зүг морины жолоог залав.

Түүнээс хэлмэрч монгол, цэрэг дээр эргэж мориндоо мордоод бүгдээр цэргийнхээ зүг хэдэн алхам алгуур явснаа, тонгойн ухасхийж, хар хурдаар давхилдан байлдаан хийж эхэлж хөөрцөг хөөмий болов.

Өвгөн лалыг дөнгөж монгол цэргийн хүрээнд хүртэл, тэндээс хэдэн баг цэрэг, Хоресм Шагийн цэрэг тийш алгууураар давшиж налуу довцог газрын уруу хандан зогсоцгоов. Хоресм Шаг харьяат хаадад тушаан их цэргийг зүүн баруун гар, гол болж, гурван анги хуваан, хоёр жигүүрийн цэрэг монгол цэргийн хүрээг бүслэн, дайсны зайлах замыг хаа! Миний байгаа гол цэрэг дэмжих цэрэг болж, туслан хүчилж, эрслэн дарах газар би биеэр захиран хөдөлгөнө. Дайсан манай, зүг арай шуудаар халдахгүй, халдавч марц балчигт шигдэх нь бидэнд нэн сайн гээд, довцгийн орой дээр гарч үзвэл байлдах тал газар нь нүд алдам цэлийн харагдав.

Шагийг мориноос бууж, хивс дээр суусан хойно, зоог баригч, хатгамал торгон алчуур дэвсэж, бин, үзэм, хатаасан амтайхан гуатай таваг өрж Шагийг дагаж, цэргийн эрдэмд сурч яваа залуу Беги ноёдод айраг аягалж өгөөд, зоог ачсан хурдан хурдан тэмээ сөгдмөгц, зарц нарын хамт, алтан домбо, таваг, цар, нарийн хоол гаргаж, аянд бие чилсэн Шагийг тэнхрүүлэх гэж зарц нарыг зонхилов.

Баруун жигүүрийн цэргийг Хоресм Шагийн гадуурхаж үздэг хүү Желал-Эд-Дин захирч, хар азарга давхиулан, манхан дээр гараад бяцхан гараар жирмэгэр хар нүдээ нарнаас халхлан саравчилж, байлдах газраа үзээд, Хар Хончирыг дууд гэж, нэгэн цэрэгт тушаасанд, улаан дээлтэй зузаан залуу туркмен, майхнаас ухасхийн давхиж, удалгүй хонины арьсан малгай, хар дээл өмссөн нэгэн хатангир хүнтэй хүрч ирэв. Тэр бол, Хар Хончир ажээ. Желал-Эд-Динийн дэргэд хүрч ирээд мэхэсхийж, түүний үгийг хичээн сонсож, харцага мэт царайд нь тэвдэх байдал ергүй, гагцхүү уулийн нүд шиг дүгрэг том нүд цогтойёо гялалзан Желал-Эд-Диний,

— Тэрхүү марзыг үзэв үү? Манай мөхөх завших үүнд бий. Татарыг үзвэл, тийм олон биш, бид тэднээс гурван хувь их хүчтэй боловч, олон цөөнөөр болохгүй хэрэг. Би цэрэгтээ найдаж болох уу? Үгүй юү? Тэр үхэж байсан мэргэдээс сонсвол, монгол цэрэг, бүгд хоёрхон түм гэнэ билээ. Түүний хагас нь, манай жигүүрийг дайрвал, ганцхан түмэн хүн дайрах юм байна. Манай Туркмен зургаан мянган, Хар хятад таван мянга бий. Гэвч, Хар хятад, өлсөх ядрахын эрхэнд Шагийг дагаж орсон тул байлдахыг хүсэхгүй, гагцхүү, эд олзыг завших

санаатай мордсон хэрэг. Би тэднийг манлай болгон явуулъя. Татаарын ачаа бараанд бушуухан хүрэх гэж дуртай ч явах байх. Гагцхүү, тэр мэргэд Татарыг галзуурсан барс гэж нэрийдсэнийг үзвэл, Татар, лав, Хар хятадыг дараад, биднийг дайран орох биз ээ. Тэр цагт хүчлэн байлдаж хажуугаас нь дайраад марз балчигт шахаж оруулаад хядъя. Тэгээд, миний эцгийг аврахыг бодъё. Өнөөдөр манай Падишаг санаа амар цэнгэлдэж, хайрсан нугас амтлахыг түр мартахад хүрнэ байх гэж хэлээд, цэргүүд ээ, та нар туркмен хаадад давхиж очоод өнөөдөр байлдаанд тэднийг Хар-Хумын барс Хар Хончир удирдана гэж хэл гэхэд нь, зургаан цэрэг, толгодоор таран бутарсан туркмен баг цэргийн зүг давхицгааж, цэрэг эр, Хар Хончирын нэрийг сонсмогц ихэд зориг орж шуугилдан, хорасан Астрабадыг айлгагч Хар Хончирын сүрт нэрийг хүн бүхэн сонссон байжээ. Гагцхүү, өндөр урт зээрд морьтой, хар дээлтэй үг дуугүй тэр хүнийг, Хар Хумын уудам талын үл айгч үл баригдагч, сайн эр мөн гэж хэн ч тэр болтол мэдсэнгүй байжээ.

Хар Хончир, туркмен цэргийн өмнө давхиж ирээд, хэдэн морьтой хүнийг дуудан, байлдах аргыг товч хэлж өгөөд гурван мянган морьт цэргийг довцог толгойн ард бүгшүүлж, Татаарын ирэхийг хүлээн байв.

Желал-Эд-Дин, хар азаргаа хуй салхи мэт довтолгон, Хар хятадын өмнө хүрч ирээд, сахлаг үстэй морьтой, эсгий малгайтай, олон богино жадаа арзайлгаж бөөгнөрөн овооролдож зогссон Хар хятад цэрэгт хашхиран өгүүлрүүн;

— Эрэлхэг Хар хятад цэрэг ээ! Та нар уулын барс мэт зүрхтэй байлдахад эр зоригтой цэрэг билээ! Одоо та нарын өмнө аймтгай тэнүүлчдийн хүрээ тэр байнам. Тэр дайсан манай баялаг олзыг шөнийн хулгай мэт дээрэмдэн авчээ. Тэр олз нь энэ газрын эзэн болсон бидний олз байх ёстой. Та нар дайран довтолж, дайсны хүрээнд байгаа аль дуртай юмыг зориг мэдэн автугай гэж өндөр дуугаар өгүүлэхэд Хар хятад хөдөлцгөөж, Татаарын хүрээний зүг хатиран, тоос бужигнаж, хурдлах тутам бархиран хашхирах нь улам сүртэй болсоор байлдаар давхижээ.

Хоресм Шаг Мухамед, булган дээлийн урд хормойг сөхөж, хивс дээр аятайхнаар суугаад, бэх цагаан шүдээрээ зэрлэг нугасны хөл мөлжиж, нугасны нөгөө хөлийг Падишагийн дэргэдэх хивс дээр ганцаараа хүндлэгдэн суудаг Шейхи-Уль-Ислам лам идэж, Шагт дотно хайртай «эзний юлдийн иш амгалангийн бамбай» болж, дайн байлдаанд салалгүй бараа болон явагч Төмөр Мелиг ч элгээ тэврэн

зогсоод, Мухамед эзний аян дайнд бараа болж цаг үргэлж, Шагийг дайснаа дарах болтугай гэж Аллах тэнгэрт залбиран даатгаж явахыг хүссэн, шашны их лам, цагаан сахалт өвгөнтэй гүн утгатай үг хэлэлцэхийг чагнан зогсож байлаа.

Хоресм Шаг, талд дайсны цэрэг баг багаар жагсаж байгааг хааяа харж, шог үг хэлж суув. Өглөөний тунгалаг агаарт морьт хүн, цэргийн баг багаар жагссаны завсар хоорондуур гавшгайлан довтолж, дүгрэг төмөрлөг бамбай гялалзах нь тов тод үзэгдэн, нэгэн бүлэг гавшгай баатар монголчууд, урагшаа ухасхийж, Хивчагийн сайн эрчүүдтэй тулалдаад, матгар сэлэм гялалзан цавчилдаж, нэгэн цэрэг унаад эмээлээ гэдэс дороо оруулсан морь нь урагшаа үргэн давхиж арагшаа тангарсаар давхиж, цэрэг урагш давшин байлдаад хэдэн баг Хивчаг цэрэг, шар талаар шаламгайлан дайран орсныг үзээд, Шаг нугасаа хойш тавьж,

— Беги ноёд довтол! Довтол! Аллах тэнгэр та нарыг ивээнэ гэж бархираад, хивчаг цэргийн олон багийг нуман жагсаалын хоёр үзүүрийг хумин довтол гэж тушаасанд, их цэргийн от довтлов[27].

Монголчууд, дайсны цэргийн от авалцахыг огт юмнаа тоохгүй, монгол цэргийн хүрээнээс нэгэн баг цэрэг урагшаа давшсан нь, зуу зуугаар эгнэн жагссан мянган цэрэг, сахлаг үстэй бяцхан морио довтолгон, зэллэн жагссан хивчаг цэргийн замбараагүй жагсаалыг зайлшгүй сэт дайрахуйяа, уухай, уухай, уухай гэж сүртэйеэ хүрхрэн хашхиралдаж давхитал, монгол цэргийн хүрээнээс бас нэгэн мянган цэрэг урагш давшиж, наранд болд дуулга, төмөрлөг бамбай матгар илд сэлэм нь гялс гялсхийж, довцгийн орой дээрээс Шагийн харж байхад Монголын их цэргээс баг багаар цэрэг урагш давшин, Уухай! Уухай! гэж хүрхрэн хашхиралдаж торох тогтохгүй довтлон давшиж хивчаг сандран үймэлдэж, захын баг цэрэг нь Монголын ачаа хөсгийг тэр самбаанд дээрэмдэх гэж давхитал, монгол цэргийн хүрээнээс, бас нэгэн мянган цэрэг урагш давшин урьдахын адил маш эмхтэй гавшгай хөдөлж агшин зуур зам хөндөлсөн хааж монгол хивчаг хоёр баг цэрэг зууралдан байлдаж их тоос манаран бужигнаад тэр тоосон дундаас хивчаг цэрэг ганц нэгээр ухасхийн гарч бүүргэн дээрээ бөхийн давхиж хөдөө тийш зугтаах нь үзэгдсэнд Шаг алсыг ширтэн, сахлын үзүүрийг тэвдэхдээ хуруундаа имрэн ороож босон харайж өгүүлрүүн:

— Би ийм юм ердөө үзээгүй билээ гэв.

Дөрвөн баг монгол цэрэг тэр завсар дараа дараагаар урагш давшиж, маш журамтай чанд нарийн жагсаалаар довтолж, Шагийн жигдрэн жагссан цэргийн гол тийш чиглэв. Мухамедыг бараа бологчидтой хамт зогсож байсан толгойн зүг давхилдан, Уухай, уухай! гэж нижигнэн хашхиралдах нь улам улам ойртон сонстоход хэн энэ их хүчийг хориглон зогсоож чадах билээ гэж Мухамед сандран тэвдэж гэдрэг эргэж харвал, Төмөр Мелиг хэдийн алга болжээ. Үзтэл мориндоо үсрэн мордож, тулалдааны зүг давхин одсон ажээ.

Хивчагийн шилдэг шилдэг сайн баг цэрэг, монголчуудыг угтан байлдаар давштал, монголчууд, зам гарган цавчиж төдхөн хоромхон зуур саатасхийгээд, улам ахин давшиж Мухамедын зогсож байсан довцогт ойртсонд Шаг байдал биш болохыг үзмэгц,

— Морь, морь! гэж сандран бархирч, түүний үгийг дуулах чөлөө өгөлгүй, сандран шаламгайлж, довцог руу гүйж буугаад, хоёр хөтчийн барьж байсан, улаан сүүлтэй хээр азаргаа мэгдэн унаж, өргөн талын зүг ухаан амьгүй довтлон зугтвал бараа бологчид нь хударга, хөмөлдрөг, гоёлын хонх, хуяг дуулгаа хангир жингэр хангинуулан, хойноос нь тэнхээ мэдэн буруулав.

Довцог дээр зэс цар, таваг, алтан аяга, амттан идээ асгаран бутарч, хуниран хаягдсан хивс үлдээд, салхинд эрээн торгон бүтээлгийн сэжүүр дэрвэлзэн хийсэж, Шагийн бараа бологчдоос ганц хүн зайлж завдсангүй нь өнөөх буурал сахалтай Шейхи-Уль-Ислам лам ажээ. Мухамедыг бараа бологчдын хамт буруулан зугтаахад, мориноос ойчоод, дахин довцог толгой дээр гарч, хивсийг засаад, сөхрөн сууж, цасан цагаан шаа ороомол малгайн шааны эвхээсэн дотроос зууван алтан пайзыг[28] гаргаад суув.

Тэр үед Монголчууд довцгийн зүг давхилдан ирээд цэргийн гурван дарга, өвгөн хэлмэрчтэй довцог толгой дээр гарч ирэв. Тэдний нэг нь барайсан хүйтэн царайтай, хар нүдтэй, нарийхан хар сахалтай залуу хүн, сахлын үзүүрийг гөрж зүүн чихэн дээгүүрээ тавьжээ. Нэг нь баруун гар хатангир настай зузаан хүн, нүүрт нь хөндлөн хүрэн улаан сорви, нэгэн нүдийг аньж, нөгөө нүд нь бүлтийн, орчин тойрныг ажиглан харах нь тун сүрхий, бас нэг нь бие өндөр хатангир, өвч болд ялтсан хуягтай энэ гурав Чингисийн ахмад хүү Зөч, Хятадыг байлдан алдаршсан өрөөсөн нүдтэй Сүбээдэй баатар, Тогоочир ноён хоёр байжээ. Имам тэднийг үзсэн боловч, залбирал хийж байгаа дүрэм үзүүлэн, мөргөж байлаа. Хэлмэрчийн түүнийг үзээд, энэ хүн

тэнгэрийг тахигч хүн гэж хэлэхэд, Имам босож, элгээ тэвэрч мэхийн, жижиг жижгээр алхан ойртож ирээд,

— Би орчлонт ертөнцийн эзэн Чингис хааны шударга боол болсоор, даруй гурван жил болж байнам гэж номхноор өгүүлж, алтан пайзыг тэр монгол хүнд өгөөд, би сар бүр аяны хүнээр Хятад орох их замд байгаа захын харуулын монгол даргад захидал явуулсаар байсан бүлгээ. Одоо хүсэх минь, намайг монгол цэргийн ямар нэгэн ажилд авна уу. Би Хоресмд буцах дургүй... гэсэнд хэлмэрч, түүний хэлснийг уламжилж, Зөч хаан, пайзыг тоомсоргүй байдалтай авч, зүг бүр морьтой хүн давхиж байсан байлдааны газрыг ажин харах завсар, шонхор начинтай бяцхан пайз шив дээ гэж хэлээд, буцааж өгөөд хэлрүүн:

— Үгүй, чамайг эзнийхээ өвөрт нь байвал бидэнд илүү ашигтай. Чи, тэр гэнэн сэтгэлт Шагтаа эргэж буцаад урьд ёсоор бидэнд шударга мэдээ захиа явуулж бай гээд, монголчууд тэр имамыг дороо хайхрахгүй болж, байлдааны газрыг ширтэн ажиглав. Тулалдаан, довцгийн дэргэд ойртсон байжээ. Желал-Эд-Диний туркмен, Монголын зүүн жигүүрийг цохиж зарим цэргийг нь алж, заримыг нь балчигт хавчин, бүсэлсэн тул, Монгол цэргийн гурван тэргүүлэгч, үүнийг үзээд, довцог толгойгоос яаран бууж, харьяат цэргийн зүг довтолж цэрэг үдэш болтол тулжээ. Туркмен, Хар хятадын цэрэг, Монголын зүүн жигүүрийг дайран байлдаж, баг багаар байлдаж байсан монголчууд бутран, зугтааж сарниад, давхиж явтал, гэнэт эргэж, сүрхийгээр дайран байлдаж байгаад, дахин эргэж зугтаан, дахин дайрах зэргээр байлдсаар, бүрий барай болохын үеэр монгол цэрэг, нэгэн зэргээр хүрээндээ давхилдан эгжээ. Хоресм Шаг довцог толгой дээрээ эргэн ирж, нэгэн шөнийг тавгүй өнгөрөөв.

Хивчаг цэрэг, Шагийг тойрон морио аргамжаад, дэргэд нь хэвтэж, алсад монголчуудын цэргийн галын туяанд тэнгэр улав улав гэрэлтэж, шөнө турш их цэргийн олон гал дүрэлзсэнийг Хивчагууд, — монголчууд өглөө байлдахад бэлтгэж байна гэж ярьцгааж, хивчаг цэргийн хагас хувь алагдах нь алагдаж, шархдах нь шархдаж, өргөн талын энд тэндгүй хэвтсэн тул, шөнийн харанхуйд ёолох, аврах тэнхрүүлэхийг гуйн дуудах нь сонстов. Желал-Эд-Дин,

— Монголчууд, манай цэргийг давж чадсангүй энэ үеэр ухарвал, нэр төрөө бузарласан хэрэг. Одоо монгол цэрэг хүрээндээ бэхлэн баталж байгаа тул, энэ шөнийн харанхуйд санамсаргүй сэмхэн

ойртоод, гэнэт дайран орж сөнөөе гэж ятгавал, Хоресм Шаг, булган дээлээ дулаалан засаж, маргааш би байлдана гээд, өглөөний нарны ташуу гэрэл өргөн талд тусаж, довцог толгойн урт сүүдэр татмагц Хоресм Шагийн цэрэг дахин гурван анги жагсаж, монгол цэргийн зүг хөдлөн давшвал, монгол цэргийн хүрээ хов хоосон, утаа баагьсан галын цаана юу ч байхгүй. Монгол цэрэг, нэг ч үзэгдэхгүй, гагцхүү харгисаар цавчилж алсан мэргэдийн хүүр, энд тэндгүй хэвтэж, хэдэн доголон тэмээ үзэгдэв.

Монголчуудын хойноос нэхэн хөөсөн нэгэн баг туркмен цэрэг, үдэш эргэж ирээд,

— Монголчууд зүүн зүг маш хурдлан зайлсан тул, бид гагцхүү алсаас цэргийн тоос үзэв гэхэд Хоресм Шаг, Монголчууд байлдахдаа бахтай улс байна. Тийм цэрэг би ер үзээгүй гээд, цэргээ эгүүлэх тушаалыг гаргасанд Желал-Эд-Дин эцэгтээ өгүүлрүүн:

— Саяын цэрэг бол, өмнөх туршуул цэрэг билээ. Одоо мөд их цэрэгтэй эргэж ирнэ. Бид, одоохон хойноос нь хөөж юу хийхийг нь мэдэж аваад, бас, өөрсдөө байлдахыг яаравчлан бэлтгэх нь чухал болов гэсэнд Мухамед,

— Чи хашир суугаагүй залуу хүний үг хэлж байна. Монголчууд хэзээ ч миний өөдөөс халдан зүрхлэхгүй гэжээ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ : ДАЙСАН ХИЛ ДЭЭР ХҮРЧ ИРЭВ

МОНГОЛ ЦЭРЭГ УУЛГАЛАН ДАЙРАХАД БЭЛЭН БОЛОВ

Энэ хаан, туйлын харгис болоод, бас, хурц ухаантай, мөн дайнд ялан дийлдэг байжээ.
(Персийн үлгэрээс)

Хар Эрчисийн эхээр, хөх талын дундах ганц овооны дэргэд, нэгэн шар торгон асар босжээ. Чингис хаан, Хятадын хуандийгаас түүнийг хураан авсан байжээ. Асрын ард, дун цагаан эсгий хоёр гэр барьсны нэгэнд нь, Чингис хааны хамгийн сүүлийн эхнэр Хулан (Монголын алсан мэргэдийн хааны охин) бяцхан хөвүүн Хөлгөнтэй, нөгөө гэрт нь Хятадаас авчирсан долоон шивэгчин эмс байдаг байжээ.

Асрын өмнө чулуугаар үйлдсэн сангийн ширээн дээр гал ноцож, их хаанд бараалхах хүн, тэр хоёр галын дундуур өнгөрч, биеэ ариутган бараалхах ёстой байжээ. Бөө нар «Гал бол элдэв хорт сэтгэлийг ариутгаж, өвчин тахал, гай зэтгэрийг үгүй болгоно» гэдэг билээ.

Ахмад өвгөн Беги бөө, дөрвөн залуу бөөтэй, цөм тэргүүндээ шовх оройтой эсгий малгай, биедээ цагаан өнгөтэй уужим дээл өмсөж, сангийн ширээг тойрон явж, хэцийг цохин холбогоо хангир жингэр сэгсрэн дуугаргаж, дуудлагаа дуудацгаан, галд давирхайтай мөчир, сайхан үнэрт хатаасан цэцэг хийж асрын нэгэн талд алтан шонгоос сэтэр нэртэй цагаан азаргыг аргамжжээ. Тэр азарга нүдэндээ галтай, хар арьс нь мөнгөн цагаан үстэй бөгөөд эмээл тохуулж үзээгүй, хоёр хөлтийг нуруун дээрээ гаргаагүй, эмнэг адуу бүлгээ. Бөө нар, Чингисийг дайн байлдаанд явахад энэ дун цагаан азаргыг дайны тэнгэр, үл үзэгдэх сүлд гэгч хөлөглөж, монгол цэргийг үргэлжид сахин ивээж, дайсныг даралцаж өгдөг гэж хэлэлцдэг байжээ.

Асрын нөгөө талд найман гэдэг нэртэй үргэлжид эмээлтэй байдаг, өргөн цээжтэй, хурдан тахийн угсаа, нуруундаа хар голтой, хөл сүүл нь хар, хул морь уяатай байнам. Чингисийн дайнд унадаг хайртай морь энэ байжээ.

Сэтрийн дэргэд босгосон өндөр хулсан иштэй хуйлаастай цагаан туг байгаа нь Чингис хааны туг ажээ.

Довцог толгойг торгууд гэдэг бие хамгаалагч нар тойрон сахиж, нэг ч амьд амьтныг хааны шар асарт ойртуулахгүй, гагцхүү барсын

толгойтой алтан пайзтай хүн, торгуудын дэргэдүүр өнгөрч, шар торгон асарт ойртох эрхтэй байжээ.

Асраас нэлээд зайтай, Татаарын хар өнгөт гэр, Тангадын шар банаг[29] майхан үзэгдэж, энэ шар асар, олон гэр банаг даруй Чингисийн хүрээ бөгөөд цагаан морьт мянган шилдэг цэрэг, түүний бие хамгаалагч нар суудаг байжээ. Чингисийн бие хамгаалах хишигтэнд их их ноёдын агул[30] хөвүүд орох эрхтэй бөгөөд хаан тэдний дотроос аль сэргэлэн, зоригтойг нь сонгон авч, баг цэргийн дарга болгодог байжээ.

Түүнээс нэлээд цаашилбал, цэргийн бусад хүрээ үзэгдэн цувсаар, их модтой уулын хормойд хүрчээ. Эдгээр хүрээний завсар, тэмээ, зүсэм зүсмийн адуу бэлчиж, адуучин, уургаа барьцгаан, бугуйл хурайлан, агтыг унага гүүтэй нийлүүлэхгүй гэж, хашхиран давхицгааж байлаа.

Лалын орны зүг хөдлөхийн өмнө, Монголын эзэн Чингис, Хоресм Шаг Мухамедад тусгай элч, их бэлэг сэлтийн хамтаар Бухарт явуулж, элчийн тэргүүнд өөрийн сэтгэл зүрхний хүн болсон, Гурганж хотын баялаг лал худалдаачин, урьд Дундад Азиас Хятадад худалдаа нэвтрүүлж байсан Махмуд-Ялвачийг тавьж, баруун газрын байдал, цэрэг хүчин, жич, Хоресм Шагийг байлдаанд бэлэн байгаа эсэхийг заншлан мэдэж ир гэж явуулахын хамт, баруун зүг нууц тагнуулчдыг олноор явуулжээ.

ДОРНО ДАХИНЫ ЭЗНИЙ ЭЛЧ НАР

Тэдний хувцасны хуниасанд, алс холын орны цэцгийн ариун үнэр бас ханхалсаар байнам.
(Перс үлгэрээс)

Өгүүлэх нь: Бут ниргэгдсэн Самарканд хотод Хоресмийн сүүлийн Шаг түр нийслэллэж, эрх чөлөөнд дуртай Самаркандыхныг ялснаа алдаршуулах гэж Мухамед шаг, тэнд өндөр сүм байгуулж, бас, их ордон барих ажлыг үүсгээд, бие сэтгэлээ өгсөн хивчаг цэргийг дагалдуулан мордож, орчлон ертөнцийн зах хүртэл байлдан явж, Хоресм улсын зах хилийг харанхуйн зааг болсон адгийн далай хүртэл тэлж өргөтгөхийг бодож, биеийг хоёр эвэрт Искандертэй адил ихэд байлдан дагуулагч гэж боддог байв. Бас, бүх лалын эзэн гэх цолыг найр тавьж өгөхийг үл дурлагч Багдадын халиф Насирыг хамгийн аюултай

гол дайсан гэж үздэг байжээ. Үүнд, урьдаар Насирыг дарж, Багдадын ариун газарт гол сүмийн үүдний өмнө жадын үзүүрийг хатгалж, тэндээс морины жолоог, эд эрдэнээр маш баян гэж алдаршсан алс холын Нангиад Хятадыг байлдаар мордох юм сан гэж, их цэргийг хуралдуулж, ногоон тугаа хөдөлгөж, Иранаар дамжин Араб, халифийн нийслэх Багдад хотыг чиглэн мордтол, урагшлуур цэргийн анги нь дулаан хувцас хунаргүй учраас Ираны өндөр уулсын цасан шуурганд осгож үхээд, хүчин чадал мохсон үлдэгдлийг шашингүй курдүүд хядчихсанд, Мухамед арга буюу урагш давшихыг түдгэлзэж, дотроо «Тэнгэр хилэгнэсэн болов уу», ер нь, халифтай байлдах хэрэг байна уу гэж сэтгэл хоёрдоод, аяныхаа таягийг Бухар хотод түшүүлээр эгжээ. 1219 оны туулай жилийн намар Татар, Монгол, Хятад зэрэг дорно зүгт нутагтай улсын их хаан Чингисийн элч, Бухарт ирж, Хоресм шаг, дахин Татаарын холбогдол бүхий хэрэгт санаа тавих болжээ. Шагийн ордны өндөр хаалганы өмнө Чингисийн элч, хурдан монгол морь унацгааж ирсэн нь, гурван лал хүн, Хоресм шагаас Ази тивийн зүг зовхис бүхэнд худалдаа нэвтрүүлж байсан баян худалдаачин, угтаа Гурганж, Бухар, Отрар гурван их хотын хүн аад, Чингис хааны албанд орсоор удсан хүн ажээ. Энэ мэт баян худалдаачин, хоорондоо хоршиж, худалдаа арилжаанд азаа турших гэсэн хүний мөнгийг хувь нийлүүлэн авч наймаа хийхдээ, алс дорно өрнийн аль ч алсалсан тасархай хязгаарт, хэчнээн ч их мөнгийг тийм хүнд төл гэж эл худалдаачны тушаасныг саадгүй зохигчдод төлцгөөж, өр нэхэхэд нь хүн, засаг ноёны санд татвар хураалгахаас урьтаж өгдөг байжээ.

Хоресм Шаг Мухамедад явуулсан бэлгийг зуун тэмээнд ачиж, бас сахлаг үстэй хоёр сарлаг хөллөсөн гоё эрээн будагтай хасаг тэргээр хүргэж ирсэнд, Бухарын олон сонирхоцгоож, элч нарын буусан хотын гаднах ордноос Шагийн яамлах харш хүртэл жагсан цуглажээ. Худалдаачин элчийн туслах ижил ижил хятад торгон дээлтэй, гоёмсог бичээч нар, тэмээний ачааг буулгаж, ордны бараалхах танхимд оруулан задалсныг үзвэл, ховор сонин бэлэг ажээ. Түүний дотор хүний үзээгүй эрдэнийн төмөрлөгийн зүйл, хирсийн эвэр, заартай хүүдий, улаан ягаан шүр, хас тэнэгэр сийлмэл цом хундага, хаадад бэлэг барьдаг, шөрмөсөн чулуугаар нэхсэн эрдэнийн эд бүс, алттай торго, аалзны шүлс мэт нарийн сиймхий шаа тэргүүтний дээр, Хятадын уулнаас гарсан тэмээн толгойн чинээ алт дамнан оруулав. Тэр алтыг сарлаг хөллөсөн хасаг тэргээр ачиж ирсэн байжээ.

Хоресм шаг, Хар хааны угсааны сүүлчийн хаан Осман Султаны эртний өндөр ширээн дээр сууж, элчийг бараалхуулахад, бараа бологчдын нэгэн адил хоргой дээлийг өмсөж хаан ширээнээ бодлого бодсон байдалтай, нүдээ аньсхийж, ихэмсгийг үзүүлэн суугаад, хүний толгой дээгүүр алсыг харж, ширээний дэргэд, их сайд түшмэд, төрийн дээд тушаалтан шахцалдан зогсжээ.

Гурван элч мөргөн сөгдөөд, хэт зоригоо өчиж, ахмад элч өндөр тарган Махмуд-Ялвач,

— Бүх Монголын эзэн Чингис хаан, бидний онц элчийг тусгайлан зарж, найртай сайхны харилцаа, айл зэргэлдээгийн найрамдлыг зузаатгаар явуулав. Их хаан, Хоресм шагийн амрыг эрж, захиа бэлэг сэлтийг хүргүүлэв гээд, нөгөө нэгэн элчид хөх лавын дээр тамга дарсныг цагаан утсаар зүүсэн хуйлмал пергамен саарин бичгийг нөгөө элчдээ өгсөнд, дэд элч Али Ал Божаал бухари, тэр бичгийг дуудсан нь:

— Би чиний эрхэм цол, их улсыг хэдийн сонслоо. Дэлхийн олонх улсад Шаг чамайг сүсэглэн бишрдгийг мэдэх тул, чамайг хайрт хөвүүн адил үзэж, найртай харилцаа байгуулахыг хүсэв гэж уншгал,

— Хөвүүн гэнэ үү? Чи сая юу хэлэв. Хөвүүн гэв үү? гэж гэнэт сэргэсэн шиг, Шаг дуу алдаж, бүсэнд хавчуулсан хутганы ясан ишийг атгаж, цээжээ урагшаа болгож элчийг ширтвэл, элч огт ажиггүй цааш уншсан нь,

—... Чи ч бас намайг Нангиад хятадыг байлдан дагуулж, умард нийслэлийг нь эзлээд, чиний газартай зах нийлсэн учрыг юун андах аж. Чи намайг өөртэйгөө чацуугаа мэдтүгэй...» гэхэд Шаг сонсоод, толгойгоо сэгсрэн, алмаас шигтгээтэй бэлзэг зүүсэн хуруугаар хар сахлаа имэрч эхэлтэл, элчийн уншсан нь:

— «... Миний харьяат газар, манай ялагдашгүй цэрэг оршин сууж, мөнгөний уурхайгаар маш баялгийг нь чи хэн хэнээс ч илүү сайн мэднэм билээ. Манай агуу их газар нутагт зүйл бүрийн эд элбэг дэлбэг гарах тул, гаднаас эд олз хайхын хэрэг надад үгүй бүлгээ. Их Шаг чи, хэрэв учрыг мэдэж, бидний хоёр этгээд худалдаачны чөлөөт замыг нээж харилцан найрамдан харилцвал алин бүрд ашигтай болж, бидний сэтгэл машид ханах байх нь ээ» гэжээ.

Бичиг дуудмагц гурван элч, дорно зүгийн нүүдэл улсын эзний бичгийн хариуд, баруун лал газрын эзэн ямар хариу хэлэхийг дуугүй

хүлээвэл, Хоресм шаг хөдлөлгүй суусаар, их сайдын зүг харж алтан бугуйвчтай гараар алгуурхан зангав.

Их сайдыг Чингис хааны бичгийг ёсолж аваад, Шагийн өөдөөс харахад, цаадах нь эгдүү хөдөлгөн, байн байн суух ялааг үргээж байгаа мэт, мөн л гараа сэжиж зангав. Тэгэхэд нь их сайд, ахмад элч Махмуд-Ялвачид тонгойж, нам дуугаар,

— Дээрхийн бие, элчийг нэгэнт бараалхуулж гүйцэв. Одоо хойшилшгүй чухал хэрэгтэй бусад хүнийг бараалхуулан, өндөр хишгээ хүртээнэ гэсэнд, гурван элч босож ухарсаар гарч, хүлээх тасалгаанаа ороод, их сайд хойноос нь ирж, Махмуд-Ялвачийн чихэнд шивгэнэн,

— Шөнө дунд намайг хүлээ гэжээ.

ШАГ ЭЛЧТЭЙ ШӨНӨ ЯРИЛЦАВ

Хүчтэйгээ бүү гайхуул, чамаас хүчтэй хүн гарч ирнэ.
Аргатайгаа бүү гайхуул, чамаас аргатай хүн гарч ирнэ.
(Хиргисийн цэцэн үг)

Шөнө Махмуд-Ялвачийг дуу цөөнтэй нэгэн зарц, хотын гадна, элч нарын буусан ордноос дагуулж гараад, хөгшин чанар модны дор хэдэн морь зэхсэн газар аваачив.

Махмуд-Ялвач, сарны гэрэлд тэр морины хамт их сайдын байхыг үзэж таньтал, их сайд өгүүлрүүн:

— Мориндоо мордоод, миний хойноос дагаж яв! гэж, Махмуд-Ялвач, чив чимээгүй болсон Бухар хотын харанхуй гудамжаар явсаар, төмөр хаалгатай битүү хэрмийн өмнө хүрч, хаалгыг болзсон ёсоор тогшмогц, чимээгүй нээгдэж, хаалгаар ортол, дуулга саадагтай нэгэн цэрэг хөдлөлгүй сүртэй зогсож байсан нь сарны гэрэлд мөнгөн хүн хөшөө мэт үзэгджээ.

Махмуд-Ялвач, их сайдын хойноос дагаж, хун шувуу үүрэглэн унтаж, усны дээрх сэхээвчийн дотор эм хүний шивгэнэн ярих дуу сонстож байсан цөөрөмтэй цэцэрлэгийг өнгөрөн, нэгэн чамин сэхээвчийн довжооноо гарч үзвэл, хүнд хөшигний ард угалзтай эдээр бүрхсэн нэгэн бяцхан өрөө байх бөгөөд, өндөр мөнгөн хатгуур дотор бүдүүн лав лаа сэрчигнэн ноцож, торгон олбог дээр Мухамед шаг, Хач газрын эдээр хийсэн эрээн дээлтэй сууж байв. Шаг, зочны ёслон мэндэлсний дараа,

— Чи нааш суу! Би чамтай чухал зүйлийг ярилцах санаатай. Чи миний албат хүн. Бодвол, Хоресмийн Гурганж хотод төрсөн биз. Чи ямар нэгэн тэрсүүд буруу номтон биш, үнэн шашинт лал хүн мөний тул, чи одоо исламын дайсанд биеэ худалдаагүй, бие сэтгэл явдлаар үнэн шашинтны талд бийгээ надад үзүүлэх хэрэгтэй болов гэв. Махмуд-Ялвач үүнийг сонсоод, Мухамедын хөлийн өмнө өвдөг нугалан сууж өчрүүн:

— Тэр үнэн. Би Гурганжид төрсөн хүн. Их Шагийн үгийг эмээн хичээнгүйлж сонсон, Ислам орны эзэн танд насан эцэслэтэл зүтгэхийг хүснэ гэхэд нь,

— Хэрэв, чи, миний асуусан бүхнийг үнэнээр хариулбал, би хүндэт шагнана. Би нэгэнт ам өгснөө үүгээр баталчихъя гээд алтан бугуйвчинд шигтгээтэй том гэгчийн сувдыг ховхлон авч өгөөд, хэрэв чи, урваж худал хуурмаг мэдүүлбэл, маргааш өглөөний нарыг үзэж чадахгүй гэхэд нь,

— Би юу гэх вэ? Зарлигийг дагасугай. Падишаг аа! гэв.

— Би, чамаар дамжуулж Татаарын Чингис хааны учрыг бүрэн мэдэх гэсэн юм. Чи миний нүд чих болж, Чингис хаан, чухам юу хийж, хааш байлдаар мордохоор байгаа зэргийг мэдсэн даруй захидал бичиж, итгэлтэй сайн хүнээр хүргүүлж бай. Чи үүнийг гүйцэтгэнэ гэж тангарагла гэхэд нь,

— Падишагтаа үнэн сэтгэлээс хүчнийг өгч, хойшид ч үйлчлэхийг Аллах тэнгэр гэрчлэх болтугай гэж Махмуд-Ялвач өгүүлж, гараа сахалдаа хүргэж тангараглав.

— Чи энд хэд хоног сууж, миний сударч түшмэл Мирза-Юсуфэд, Чингис хаан чухам хаанаас гарч ирээд, хэрхэн байлдаж явсан, хэрхэн бүх Татаарын эзэн болсон зэргийг нэгд нэгэнгүй хэлж өг гэхэд,

— Би цөмийг ярьж өгье, эзэн минь гэв.

Шаг өгүүлрүүн:

— Чингис хаан, биеэ хүчирхэг Хятадын эзэн гэхийн дээр, Хятадын нийслэлийг эзэлсэн гэж байгаа нь үнэн буюу, сагсууран бардамнаж байгаа нь тэр үү? гэхэд нь,

— Тэр яах аргагүй үнэн. Тийм их явдлыг нууцгай хэвээр дарагдуулж яаж болох ажээ. Эзэн та, удалгүй тэр бүгдийн үнэнийг мэднэ гэхэд нь,

— Тийнхүү болтугай. Гэвч, чи миний харьяат газар орны хэмжээ асар их, эр цэргийн тоо цаглашгүй олныг мэдэх биз дээ? Тэгтэл, тэр

буруу номт, оморхог малчин, ямар аюулгүй лал бүхний хүчирхэг эзэн намайг хөвүүн гэж аймшиггүй дуудна гэж хүчирхэг гараар элчийн мөрнөөс атгаж, биедээ ойртуулан татаад, ширтэн харж, — Түүний цэргийн хүч ямар вэ? Хэл! гэж зандрав.

Махмуд, Хоресм шагийн хэлж байгаа үгэнд далдуур хилэн хүрсэн шинж бийг ажиглаад, хилэгнэн цаазлахаас айж, хичээнгүйлж элгээ тэврэн өчрүүн:

— Эзний ялагдашгүй хүчирхэг цэрэгтэй Чингис хааны цэргийг жишээлбэл, харанхуй шөнө суунаглах утаа мэт биз ээ гэхэд нь Шаг,

— Зөв гэж өндөр дуугаар хэлээд, элчийг гэдрэг түлхэж,

— Миний цэрэг тоо томшгүй олон, сүр хүчин дарагдашгүй, үүнийг орчлон даяар мэднэ. Чи энэ тухай надад гайгүй сайн хэлэв. Нэг өнжөөд Татаарын Падишагт явуулах хариу захидлыг хүлээж ав! Чамд, мөн дагалдаж яваа монгол нөхдөд чинь арилжаа наймаа хийх, лал газраар саадгүй нэвтрэх зэргийн бүхий л хөнгөвчлөл олгоно. Одоо чи миний ордны даргатай яв. Чамтай манай сударч түшмэл өвгөн Мирза-Юсуфийн сууж байгаа дүгрэг өрөөнд хүргэж өгнө гээд өршөөлтэй мэт байдал үзүүлэн, толгойгоо дохиж, алгаа хэдэн удаа ташив.

ЧИНГИС ХААНЫ ТУХАЙ ЭЛЧИЙН ЯРЬСАН НЬ

Эзгүйд хэнийг ч битгий муу хэл.
Газар дэлхий ч түүнд тэр үгийг нэвтрүүлж болно.
(Дорно дахины зүйр үг)

Ордны дарга Векил, Монголын элчийг дагуулан, ордны хэр мурий хонгилоор дамжсаар, нэгэн дүгрэг оройтой тасалгаанаа орвол, төмөрлөсөн хар авдрыг туурга түшүүлэн хурааж, туурганы нарийхан нарийхан хөндий дэх тавиур дээр тоосонд дарагдсан хуйлмал бичиг судар үзэгдэж, Махмуд-Ялвач шагийн номын сан гэж мэдэж сая сэтгэл амраад, чийгтэй зооринд орж эрүүдүүлэн байцаалгах биз ээ гэж айснаа, дотор нь онгойж, хивсэн дээр бөгтөр нуруутай, цэл буурал сахалтай, нулимс гүйсэн улаан нүдтэй, хатангир өвгөн, дэргэд нь охин хүн мэт, булбарай царайтай нэгэн залуу бичээч, боодолтой бичиг дэлгээд, тонгойн сууж байхыг үзэв. Тэр завсар ордны дарга, яаралтай ажил хэрэг бий гэж зайлан одов.

Уран гэгч нь ороосон ороомол малгай, улаан торгон дээлтэй, өндөр тарган биетэй, өнөөх элч маань босгоны дэргэд ногоон шаахайгаа тайлж, өмнөөс ёслон угтсан өвгөний дэргэд ихэмсгээр очиж, өвгөнийг урьсны дараа хивсэн дээр суугаад, сэмээр залбирал уншиж, алгаар сахлаа илээд, харилцан амар мэндийг мэдэлцээд, элчийн хэлсэн нь:

— Их Падишаг Татаарын эзний тухай мэдэхээ ярьж бичүүл гэж тушаалаа. Би, Чингис хааны дэргэд хэлмэрчийн үүргийг гүйцэтгэдэг боловч, энэ удаа элчийн үүргийг гүйцэтгэж байна гэхэд нь,

— Хүндэт ховор зочны үгийг хичээнгүйлэн сонсохыг хүснэ. Миний их Падишаг, танаас манай эх нутагт тусгай мэдээг дуулж, сонссон бүхнээ ордны нууц бичиг, он дараалсан тэмдэглэлд бичиж ав гэж надад, бас, зарлиг буулгасан билээ гэв.

Махмуд-Ялвач, нүдээ доош хандан, түр зуур дуугүй болж сэтгэрүүн: Хэрэв, хамаг бүгдийг үүнд тоочвол, хэд хоноход ордны урт хошуутан цөмийг задруулан мэднэ. Нарийн чухал юм эс хэлж өгвөл, Шагийн хилэгнэхээс яаж зайлъя? бас, Татаарын их хаан, миний энэ шөнийн яриаг сонсвол, аюултайг яаж аргалъя? Чингис хааны туршуулын хүн, одоо газар бүр бий. Ер, энэ хоёр аюулаас хэрхэн хэлтрэх билээ гэж бодлого бодсон гуниг царай гаргаж, зүүн гартаа ороон зүүсэн тана эрхийг дэмий л шувтран,

— Би, жирийн юмнаас этгээд, ер, хүний ухаан санаанд оршгүй олон юм ярья. Заримдаа, би өөрөө ч түүнийг сонсоод итгэдэггүй юм даа. Тэр бүгдийг цөм худал гэвэл, та яагаад худал юм бэ гэж бодох биз ээ. Тэгээд, би, сонссон бүхнээ ярьж өгье. Хүн бүхэн эндүүрдэг, өөрийгөө огт эндүүрдэггүй гэж үздэг хүнтэй ярьсны ч хэрэг алга! гээд, түр зогсож, хөмсгөө өргөж, залуу бичээчийг нэг ч үг орхилгүй тэмдэглэж байсныг харж, их л гайхав. Тэр залуугийн хулсан үзэг нь цаасан дээгүүр дэгдэлхийлэн, Арабын татлах үсгээр үг дараалан, тун гоё сайхнаар бичих нь бахдалтай үзэгдээд,

— Энэ залуу, юунд миний хэлсэн бүхнийг бичиж байгаа юм бэ? Би Татаарын тухай яриагаа эхлээгүй байна гэхэд нь,

— Энэ чинь, хүү биш, Бент-Занкижа гэдэг охин юм. Миний нүд муудаж, гар чичиргилэх болоод, миний энэ ач охин, надад тусалдаг болсон. Энэ охин, Арабын хичээнгүй үсгийн бичээчтэй адил, тун түргэн сайхан бичиж чаддаг юм шүү. Гэвч «Хар нүдний хужир» «Хацар Дээрх мэнгэ» гэж дуу зохиодог болсныг үзвэл, надад удтал

дэмжлэг болж өгөхгүй, хаяад явах цаг нь айсуй шинжтэй... Тэгвэл, элгээ тэврээд, Мекке балгасны адистидат чулууны зүг түрүүлгээ хэвтэхээс дээ гэхэд нь тэр охин,

— Би чамайг үл орхино гэж бичихийн завсар нүдээ дээш харалгүй хэлээд, өвгөн, дахин элчийн өөдөөс харж өгүүлрүүн,

— Эзэн, таныг бидэнд хэрэгтэй чухал зүйлийг хэлбэл, өндөр их шанг хүртээнэ гэсэн билээ. Ганц болгоомжлох нь бидний сэрэмжгүй осол цалгараас Ислам оронд хүчирхэг дайсан халдвал, үнэхээр хайран болно. Чи, бидэнтэй адилхан үнэн шашинт хүн шүү дээ. Бидэнд урьдаас мэдээ өгч чадах уу? Тэгвэл, чамд их шан хиших хүртээнэ... гэхэд нь

— Надад юу ч хэрэггүй, миний орчлонд тэнүүчлэн явж, элдэв бэрх зовлон үзсэнийг санаж, үнэн шашинт сүсэгтэн, хар цагааныг ялгах цагт, намайг хутаг буян төгөлдөр хувьтны зэрэгт орог гэж залбирвал барав гэхэд нь, охины уруулд элэглэн инээмсэглэх байдал илэрч, элчийн махлаг бие, алтан бэлзэгтэй гарыг үл үнэмшсэн байдалтай харсанд элч хэлэх үг бүрийг эргэцүүлэн бодож, дуугай суув.

Өвгөн сударч ойшоох мэт байдлаар, болтугай гэж, урт буурал үстэй, туранхай боол, элдэв амттантай мөнгөн тосгуур зочны өмнө авчирч тавиад, шавар хумхаас мөнгөн аяганд харавтар улаан дарс аягалав.

— Ордны зоорины он удсан хуучин дарс амсана уу. Бид юуны урьд татар монгол чухам ямар улс вэ. Хаана суудаг хэчнээн хүн амтай, аль хэр олон улс вэ, дайнд ямар улс вэ гэж мэдэхийг эрхэм болгож байна. Газар тэнгэрийн савсалганаас бачит шуламс эблисийн[31] түрэн гаргасан аюулт Яжуж Мажуж шиг, манай нутгийн захад гэнэт гарч ирсэн шүү дээ гэж өвгөн сударчийн хэлэхэд, элч тайлбарларуун;

— Монгол татар, цөм хээр талын нүүдлийн аймаг. Алс дорно зүгт зэрэгцэн нутаглаж, ер суурьшин тогтож чаддаггүй улс. Уудам их нутаг нь өвс элбэг, ус бага тул, адуу, хонь, тэмээнд зохистой, элчилгүй цөл газар юм.

Өвгөн сударч, хөндлөнгөөс үгийг тасалж асуууруун:

— Тэд цэргийн талаар манайд аюултай эсэхийг мэдье гэхэд нь,

— Монгол Татарыг айл хөрш улсдаа аюулт Яжуж Мажужаас хор хөнөөлөөр бага гэвэл, би Исламаас урваж, худал хэлсэн хүн болно гэхэд нь өвгөн сударч,

— Биднийг Аллах тэнгэр авартугай гэж дуу алдав.

— Тэд, уулаас дайнч улс. Зуун жил завсар зууpаа дайсагнаад, нэгэн аймаг нь нөгөө аймагтайгаа байлдсаар Татаарын нэг хаан нь мянган адуу, олон хоньтой, бас, өөрийн бие, үр хүүхдээ тэжээж чадахгүй хоосон нойтон эхнэр хүүхэдтэй, сэтгэл санаа нь хэзээд дундуурхан явдаг зуугаад адуучин хоньчинтой байтал, тэднийхээ тэсэж ядан, урхирах бархирахаас эмээж, «Зэргэлдээ аймгийг байлдацгаая. Гэдэс цатгалан, олз омогтой буцаж ирнэ» гэж адуучин хоньчноо дагуулан, аян дайнд мордоод, эцэс сүүлдээ цэрэг нь дарагдаж, хааны бие хүзүүндээ дөнгө зүүж, мал сүрэг адуучин хоньчинтойгоо хамт олзлогдож, дөрөв дөрвөн дирхем зоосоор худалдуулж, ондоо нэг зэргэлдээ аймгийнхан юм уу, боол худалдан авагч наймаа, тэднийг худалдан авдаг байжээ гэхэд нь

— Чи түүнийг яриад юу хийх нь вэ? бид Татаарын хааны цэргийн эр чадал, зэвсгийн тоог чухал болгохоос биш, боол моол, аар саар зүйлийг чухалд үзэхгүй гэж өвгөн сударчийн үл ойшоон өгүүлэхэд, элч, яаралгүй, архинаас балгаад өгүүлрүүн:

— Ууланд гарахдаа, зам дахь гол нуур, цайдмыг тойрч гардаг байх... гэхэд нь,

— Эрхэм зочин, нуур цайдмыг урьдал болголгүй, Татаарын Падишагийг урьдаар ярь гэхэд нь,

— Хоресм шагийн зооринд хадгалагдсан архи, үнэхээр таатай сайхан, төгөлдөр амттай архи ажээ. Гай зовлон үзэлгүй, насан эцэслэтэл хаан төрөө энх тайвнаар барих болоосой гэж Махмуд-Ялвач ажиггүй хэлээд, Татаарын дайчин хаадын дотроос Тэмүүжин гэдэг нэгэн эр, байлдаанд азтай, харь дайсандаа хатуу, өөрийн талын хүнд өгөөмөр, уулгалан довтлохдоо гавшгай хүн байжээ. Багадаа нэлээд зовлон үзэж, сонсвол, багадаа дайсан аймгийн төмрийн дарханд боол болж, хүзүүндээ дөнгө зүүж, элдэв хүчир ажил хийж явсан гэдэг юм билээ. Тэгээд, сахисан манаагаа гинжээр цохиж унагаад, оргож, бусад хааныг эрхэндээ оруулах гэж олон жил дайн хийсэн гэдэг. Тавин настайд нь олон хаад, Тэмүүжинийг тэдний хүслийг дагаж байх болно гэж горьдож, их хаан гэж цагаан эсгий дээр өргөж ёсолсон боловч, Тэмүүжин, өөрөө «Тэнгэрээс заяат» гэсэн «Чингис хаан» гэдэг шинэ цол өргөмжлөөд, үл дагах аймгийг бут ниргэн боолчлоод, удирдах эздийг нь амьдаар нь тогоонд чанаж орхисон билээ гэхэд нь,

— Юутай аймшигтай юм бэ? Чи аймаар үлгэр ярихаас биш, Татаарын их эзний цэрэг дайн хийснийг ер дурсахгүй байнам гээд,

өвгөн сударчийн санаа алдсанд элч, бас, нэгэн аяга архи залгилав.

Сударч, түүнд эмээн, ордны архи хатуу... энэ элч уу уусаар ер нь, Хоресм шагт чухал юмыг ярьж чаддаг болов уу, согтоод унтчихдаг болов уу? гэж байтал, туранхай хөгшин зарц, мөнгөн аяганд нь дахин архи дүүргэжээ. Элч, огт санаа зовохгүй,

— Би чухам Чингис хааны цэргийг л ярьж байгаа юм шүү дээ. Түүнийг их хаан болсноос хойш хоорондоо дайсагнаж байсан бүх Татар, цөм түүний үгийг дагах нэгдсэн цэрэг болж, Чингис тэднийг арван, зуун, мянганаар хуваан зохиож, омгийн хаадын итгэлгүй нэгийг огцруулж, өөрөө аравт зуут, мянгат гэдэг дарга нарыг тохоож, шинэ хууль зарласан нь, эсгий туургатан хүн, нэг нь нэгнээ мэхлэх, тонох, дээрэмдэх дайсагнах ёсгүй, хэрэв тэгвэл алах ял унагана гэжээ гэхэд нь өвгөн сударч,

— Чингис хааны хууль нь Татараас өөр аймгийн хүнийг дээрэмдэх мэхлэхийг юу гэж үздэг вэ? гэв.

— Ээ, тэр хамаагүй. Татараас өөр аймгийн хүнийг алах дээрэмдэхийг харин ч нэгэн зүйлийн ид хав болгон үздэг юм шүү гэхэд нь, сударч шивгэнэн өгүүлрүүн;

— Ухлаа. Эгэл малчин юу гэж хэлэлцдэг болов? Өлсөх даарах нь бага болж уу? Үгүй юү? гэхэд нь,

— Чингис хаан, харьяат аймгаа ертөнцөд хосгүй, тэнгэрээс заясан аймаг мөний учир, үүнээс хойш «Монгол» гэдэг нэртэй болно гэж тунхагласан бүлгээ. Монгол гэсэн нь, ялан дийлэгч гэсэн үг ажээ... Дэлхийн олон улс бүхэн, Монголын боол болох ёстой, үл дагах аймгийг шарилж хамхаг мэт үгүй хийж, дэлхий дээр ганцхан Монгол үлдэнэ гэж хэлдэг юм аа гэж хэлэхэд нь, сударч хирдхийн гайхаж,

— Үүнийг бодвол, Татаарын хаан, манай нутгийн захад хүрч ирсэн нь, үнэн шашинтан бүгдийг дагаар ор гэж шахах санаатай болох нь уу? Манай Падишагийн их цэрэг, Исламын ариун ногоон тугийн дор арслан мэт баатар зоригтой байлдана даа. Хоресм шаг Алла-Эд-Дин Мухамед мэт ийм алдарт жанжин, лалын тийм эрэмгий зоригт цэрэг, ер нь өтөл малчны ухаан муутай нэг хаанд буун дагаж өгнө гэдэг чухам хүний санаанд оршгүй, хүүхдийн үлгэр шиг дэмий бодлого биш үү? Их богд Вивангиридийн ариун номын бие, манай цэргийг ивээн заларч, дайсныг даран удирдана гэхэд нь элч, булцгар гараа тарган гэдэс дээрээ соливчиж, сүүрсэн алдаад, нүдээ аньж өгүүлрүүн;

— Миний ярьсан үгийг хүн үнэмшихгүй, дэмий юм гэж үзнэ гэж би эс хэл лүү? гэхэд нь

— Үгүй, үгүй, эрхэм зочин минь, та яриад бай. Хүний санаанд оршгүй жигтэй юм яривч, би сонсохыг хүснэ гэв. Элч, нуруугаа тэнийлгэн, охиныг үзэхэд, нүд нь цог зальтай харагдтал, дахин ядран чилсэн дүрэм үзүүлэн, нүдээ аньж, сулхан намуунаар үргэлжлэн өгүүлрүүн;

— Татаарын хаан, хаадын шунал бага болоогүй. Энгийн малчны өлсөх зүдрэх нь улам нэмэгдэж, урьдах хоорондоо эвдрэлцэж, хүчээ талаар сүйтгэж байсан Татар улс, хүч чадал төгөлдөр болсныг үзээд, эгэл малчныг харьяат хаадыг эсэргүүцэн тэмцэх болуужин гэж, тэр хуралдсан хүчийг өөр зүгт чиглүүлэхээр шийдэж, ихэс хаадын хуралтайг зарлаж «та нар, мөд их аян дайнд мордоно. Дайснаа дараад, алт мөнгө, адуу мал, урчууд боолчуудыг өдий төдийгөөр олзолж ирнэ. Би үгээгүй ядуу малчны араанд нь амтатыг зажлуулж, ард нь алт торго өмсгөж, хүн тутамд нь олзны хэдэн эм өгнө. Бид, их баян газар орныг эзэлж, та бүхэн харьж ирэхдээ ачиж баршгүй олз омогтой баян болно гэсэн билээ. Хавар нь хөх ногоо цухуймагц, өлсгөлөн цэргээ удирдан, эртний баян Хятад улсыг байлдаар мордож, зам гудасын хятад цэргийг бут сарниулж, хятад газар догшин салхи мэт довтлон, мянгаад хотыг үнсэн товрог болгоод, Хятадын хагасыг дагуулан оруулж, даашгүй их олз омогтой, гурван жил болж сая хөдөө нутагтаа эгсэн билээ гэхэд нь, сударч өвгөн шивгэнэн,

— Аллах тэнгэр биднийг тэр аюулаас өршөө гэж шивгэнэв. Элч өгүүлрүүн;

— Миний хэлсэн энэ үг, бас л, итгэшгүй байна уу? гэтэл, цөм үнэн шүү дээ гэхэд нь,

— Эрхэм Махмуд-Ялвач, тэр ер бусын жанжин Чингис хаан гэдэг, ямар царай байдалтай хүн бэ? гэж асуув.

— Миний энэ ярьсан зүйл, чамд мөн л итгэшгүй санагдавч, яах аргагүй үнэн юм шүү гэхэд нь,

— Тэр ер бусын жанжин Чингис хааны биеийн байдал дүр нь, чухам ямар шиг хүн бэ? Эрхэм Махмуд-Ялвач авгай гэж сударчийн асуухад, өгүүлрүүн:

— Бие өндөр, хэдий жар илүү настай боловч маш тэнхлүүн, алхах нь нүсэр, хөдлөх нь дүй муутайг үзвэл, баавгай шиг, мэхтэй нь үнэг шиг, хортой нь могой шиг, шаламгай нь барс шиг, эцэх цуцахгүй нь

тэмээ шиг, өгөөмөр нь зулзагаа хайрлагч махчин эм барс шиг, магнай өндөр, урт нарийн сахалтай, муурын нүд шиг, цавчдаггүй шар нүдтэй, хаад цэрэг бүхний түүнээс айх нь аянга түймрээс илүү айдаг. Хэрэв, Чингис, арван цэргийг мянган дайсантай байлд гэвэл, дийлнэ гэж үг дуугүй дайран орно. Чингис хаан ямагт дийлж явдаг дээрээс тэгж боддог болчихсон юм гэхэд нь өвгөн сударч өгүүлрүүн;

— Би их насалж, алдартай баатар жанжин олныг үзэвч ер чиний хэлж байгаа тийм хүнтэй дайралдаж ч үзсэнгүй. Чиний үг тун итгэмгүй жигтэй үг байна. Ер нь Татаарын хаан, малчин бүрийг баян болгоод, нутгаасаа тийм хол, манай зах хязгаарт хүрч ирсэн учир нь юу билээ. Мэдэх бол хэлж өгнө үү? гэхэд нь, элч аягатай архиа шавхан уугаад нүдээ аньж, хазайсхийгээд, өвгөн сударчийг дахин архи нэмж хийх гэсэн зарц руу муухай хартал, элч сэргэж, зарцыг архи хий гэж дохиж, цаадах нь мөнгөн аяганы амсар дүүртэл хар хүрэн архи хийв.

— Миний их уухад бүү гайх. Эрхэм Мирза-Юсуф, туслагч залуу хүүхэнтэйгээ та хоёрыг нэг ч дусал архи амсахгүй байхад, би гурван хүний төлөө ганцаараа ууж байна... гэж хэлээд хундага барьж, баахан гуйвалзан байж, өгүүлсэн нь:

— Их хаан, нутагтаа гурван жил амраад, цэргийн хагасыг Хятадад газар орноо хамгаалж байгаа Хятадын ард түмнийг байлдаар хоцроон, хагас цэргээ дагуулж, өндөр уул, өргөн тал туулаад, баруун зүг зорьж ирсэн бүлгээ гэхэд нь өвгөн, тэр үг сонсоод, чихээ таглаж, хирдхийн өгүүлрүүн:

— Их хэцүү хэрэг гарах нь ээ! гэж гаслав. Элч ажиггүй өгүүлрүүн:

— Олон хааны шунахай, эгэл нүүдэлчний өлсгөлөн нь үнэхээр туйлдаа хүрчээ. Цэрэг, харьяат хаадаа олзны сайныг аваад, ядууст аль муу шаарыг үлдээсэн гэж гомдсон учир, Чингис, тэднийг хоорондоо алалцаж, аягүй бол харьяат хаадаа эсэргүүцэх болуужин гэж болгоомжилж, холхон зайлуулах гэж арга сэджээ. Өвгөн асууруун;

— Одоо Татаарын цэргийн тоо хэчнээн бэ?

Элч нойрмог залхуу дуугаар өгүүлрүүн:

— Чингис хаан, баруун зүг арван нэгэн түмэн цэрэгтэй мордсон. Түмэн бүрд арван мянган морьт цэрэг бий. Цэрэг бүр нэг хоёр хөтөлгөө морьтой гэхэд нь,

— Тэгвэл, Татаарын хаан, дөнгөж арван нэгэн түмэн цэрэгтэй юм уу? Манай Падишагийн цэрэг, дөрвөн хувь илүү ажээ. Хэрэв,

Падишаг, даян улсаа ариун дайнд хөдөлгөвөл, лалын их цэрэг ер ядагдашгүй байнам гэхэд нь

— Би Хоресм Шаг Алла-Эд-Дин Мухамедад тэгж эс хэл лүү? Татар цэрэг, Падишаг Мухамедын цэргийн өмнө харанхуй шөнө дэх суунаг утаа мэт бий! Падишаг, зуун хорин нас наслах болтугай! Татар цэргийг баруун зүг зам зуур хээрийн тэнэмэл уйгур, алтай нар, хиргис, хар хятад нийлэн дагаж, Чингис хааны татар цэргийн хүчин их л түргэн зузаан болсныг хоосон үг гэж болохгүй шүү гээд найгасхийгээд, хивс түшин унасанд, охин толгойд нь ногоон савхин дэр хийж өгөөд, өвгөн Мирза-Юсуфийн чихэнд шивгэнэн,

— Энэ зальт амьтан үнэнийг хэлэх дургүй байна шүү гэхэд нь өвгөн,

— Элч хүний зан юм даа. Шулуун сэтгэлтэй элч хаана байх вэ? гэв. Тэр завсар ордны дарга орж ирээд, бүгдээр дув дуугүй сууж, өнөөх үүргэлсэн элчийн сэрэхийг хүлээж, хэрхэхээ мэдэхгүй байтал, Махмуд-Ялвач гэнэт сэрж, ухасхийн босоод,

— Би согтоод, та нарт юу хэлснээ мэдэхгүй боллоо. Та нар дэмий бичиж тэмдэглэснээ галд шатаа гэв. Ордны дарга түүнийг дагуулж нарийхан харанхуй хонгил дамжин явсаар цэцэрлэгийн явган хаалганд морь байгаа газар хүргэж өгөв. Тэнд, гуйвсан Махмуд-Ялвачийг идэрчүүд моринд нь чүү чамай унуулаад, хүн амьтан унтсан Бухар хотын чимээ аниргүй гудамжаар үүрийн бүрэнхийгээр явсаар Шагийн хотын гаднах ордонд хүрэв.

Нэг өнжөөд Татаарын элч нар, Шаг Мухамедын хариу захидлыг авч, дорно зүг бүх Татаарын их хааны цэргийн хүрээнээ эгэв.

ИХ ХААН МЭДЭЭ СОНСОВ

Чингис хаан, нуруу өндөр, бие чийрэг, мийн нүдтэй бүлгээ.
(13 дугаар зууны түүхч Жусжани)

Гурван морьтой хүн, татар гэрийн дундуур нарийн замаар түргэлэн явж, хэвнэг нь ноцолдож байгаа бүргэдийн жигүүр мэт дэрвэлзэн хийсэж явсаар, хоёр манааны дэргэд ойртмогц манааны цэрэг хөндөлдөж замыг хаасанд мориноос бууж, цагаан элсэн дээр шороо дарсан хэвнэг нөмөргөө хаяж нэг нь улаан судалтай дээлээ засаж, өндөр дуугаар өгүүлрүүн:

— Хааны нэр хутагтай болтугай! Маш чухал мэдээ хүргэж ирэв! гэтэл, ойрх гэрээс ханцуй дээрээ улаан тэмдэгтэй хөх дээл өмссөн хоёр цэрэг гарч ирэхийг үзээд, Махмуд-Ялвач,

— Бид, их хааны зарлигаар баруун газар зорчсон элч, бидний эгж ирснийг мэдэгдэнэ үү. Би элч Махмуд-Ялвач гэдэг гэхэд нь, удалгүй шар цацрын торгон үүд нээгдэн, нэгэн хүний тушаасан үгийг зам дээр байсан найман манаа нэг нэгээрээ давтаж, их хаан оруултугай гэсэн гэж зам тавин, гурван элч мэхийн ёслоод, цацрын зүг ойртмогц, хятад зарц дотогш оруулав. Толгойг өндийлгүй орж, хивс дээр суутал,

— Үг байвал өч гэж өтгөн дуутай нэгэн хүний өгүүлэхэд, Махмуд-Ялвач нүдээ өргөн үзвэл, хатуу шар сахалтай, харавтар сүртэй царай харав. Хоёр салаа болгон гөрсөн буурал гэзэг[32], өргөн мөрний дээр унжжээ. Хар будгаар ширдэн будсан малгайн дороос ногоовтор шар том нүд, индранил чулуу мэт гялалзан ширтжээ.

Махмуд-Ялвачийн өчсөн нь:

— Хоресм шаг Алла-Эд-Дин Мухамед, бэлэг авч найрамдах гэсэн захидлыг үзээд, их л талархан, чиний худалдаачинд элдэв зүйлээр хөнгөлөлт үзүүлэхийг дуртай зөвшөөрсөн ганцхан нэгэн зүйлд хилэгнэсэн буй.

— Намайг, түүнийг хөвүүн гэсэнд үү?

— Их хаан, чи урьд адил, учрыг хэдийн мэджээ. Шаг ихэд хорсон хилэгнэхэд миний тэргүүн, мөрөн дээрээ арай чүү тогтож үлдэв гэхэд нь, хаан нүдээ аньсхийж,

— Чи ингэнэ байх гэж санав уу? гэж бүдүүн хуруугаар хий зурсхийсэнд, Чингис хааны чингэж дохидгоос хүн бүхэн айдаг байсан нь цаазаар аваачихдаа тэгж дуугүй дохидог байжээ. Махмуд Ялвач өгүүлрүүн:

— Би Хоресм шагийн хилэнг тайтгаруулж, Шаг одоо чиний амрыг асуун, захидал хүргүүлсэн гэхэд нь,

— Чи хилэнг нь юугаар тайтгаруулсан бэ аа? гэж итгэхгүй байдалтай асууж, нүдээ нэг нээсхийж, нэг аньсхийж элчийг ширтэн харахад, Махмуд-Ялвач, Шаг Мухамед хэрхэн хүлээж авсан, хэрхэн ордны дарга ирж шөнө нууц үг хэлэлцэнэ гэж дуудуулсныг нэгд нэгэнгүй тоочиж, Чингис хааны өргөн алга дээр Хоресм шагийн шагнасан сувдыг тавиад нүдээ дээшээ Чингисийн зүг харалгүй суувч, хаан түүний биеийг ширтэн харж, нууц санааг мэдэх гэж байгааг хэдийн мэджээ. Тэгтэл,

— Чиний олж сонссон энэ үү гэж Чингисийн асуусанд

— Би юм орхиж мартсан байвал, ой муутай намайг өршөөн хэлтрүүлэхийг өчье гэхэд Х-Х-Х гэж зөвшөөрөх аялгуу сонстож, хааны сэтгэлд нийлэлцсэн нь мэдэгдээд, хүнд гараар Махмуд-Ялвачийн мөрийг цохиж,

— Махмуд, чи зальтай лал байна даа. Миний цэргийг харанхуй шөнө дэх суунаг утаатай адил гэж хэлсэн чинь тун болжээ. Шаг тэгж л бодож байг. Орой гурвуулаа над дээр хоол идэхээр ирээрэй гээд элч нарыг цацраас гарахад хаан сууринаас босов. Бие өндөр, нуруу бөгтөр, биед бүдүүн даавуу дээл өмсөж, өргөн алтан бүс бүсэлжээ. Цагаан илгэн гуталтай, бүдүүн майга хөлөөр хүнд нүсэр алхлан, цацрын үүднээ очиж үүдний чигийг сөхөсхийж, цагаан малгай, эрээн дээлтэй гурван элч хөлс тоос болсон мориндоо мордоод явахыг нь хойноос нь хараад

— Их зарлигийн цаг айсуй. Сарын сайныг саатан хүлээе гэжээ.

ЧИНГИС ХААНЫ ТАВГҮЙ ШӨНӨ

— Чингис хаан, эрх танхи хятадын хэвтдэг халуун ханз буюу лал худалдаачны хэрэглэдэг ноолуур өдөн дэвсгэрт дургүй, хатуу газар хэвтэхэд дуртай учир, хятад зарц сайн зузаан эсгий давхарлан дэвсэж өгөв.

Угтаа, хаан хэвтсэн дороо унтаад зүүдэлж зүүдээ бөө буюу зөвлөх Елюй Чуцайгаар тайлбарлуулж сонсоод тэр бүр тайлбарыг итгэдэггүй тул өөрийн бодсоноор явдаг байжээ. Үүрээр сэрээд дулаан булган дээл нөмрөн хэвтэж, хэдэн түмэн эр цэрэг, агт морио бодож, цэрэг давших замд ханаж цадашгүй их цэргийг тэжээж чадахуйц хүн амьтантай замыг бодож монгол нутагт үлдэх таван зуун хатан хөвүүн, шивэгчин, зарц нарын хэрэглэх зардал, бас, байлдах газар урьдаас явуулсан олон туршуул, мэдээг эргэцүүлэн бодсоор бие биедээ атаархан тэмцэлддэг хөвүүдээ санаж, хөл гар янгинадаг болсноо бодохдоо үхэхийг мөн бодож хэвтлээ. Дээд талдаа сормуусгүй, үл цавчигч нүдээ нээж цацрын завсраар ширтэв. Тэнгэр хөхрөн одод бүрэлзэн, зогссон байрнаасаа эргүүл хийж, дахин гэдрэг яаралгүй буцаж ирэх харуулын цэргийн сүүдэр харж хэвтсээр, сэтгэлээс нь нэг бодол гарч өгөхгүй, баруун зүг дайлаар мордохын өмнө Чингисийн авааль гэргий, махлаг хөгшин

Бүртгэлжин, урьд адил мэргэн үг сануулан хэлж, Чингисийн өмнө тэргүүнээ бөхийлгөж, амьсгаадан өчсөн нь:

«— Аяа их хаан минь, чи их цэргийн хамт урьд өмнө үзээгүй газар өөр өөр аймаг улстай аюулт дайн хийх гэж, өндөр уул өргөн талыг туулан явах нь, дайсны сум чиний зоригт зүрхийг нэвт цоолж, харийн цэрэг чиний болд дуулгыг хага цавчиж мэдэшгүйг ер нь бодов уу? Түүнээс болж засаж болшгүй аюулд (үүнд Бүртгэлжин цээрлэж, үхэх аюул гэж шууд хэлсэнгүй) тохиолдож, энэ дэлхий дээр чиний хутагт нэрийн төдийхөн хоцрох бол, тэр цагт дөрвөн хөвүүний чухам алинаар сууриныг залгамжлагч болгож, ертөнцийн эзэн өргөмжлөх вэ? Манай хүүхэд, ах дүү нар сүүлд эвдрэн байлдах болзошгүй тул, зарлиг тааллаа нийтэд урьдаас тунхаглах болов уу» гэсэн билээ.

Тэр хүртэл хэн ч Чингисийг насан зүг болж, үхэх өдөр нь ойртож байгааг сануулах хүн олдсонгүй байжээ. Бүгдээр түүнийг, их хүн, хувьсахгүй, өтлөхгүй ижилгүй, суут хүн, ертөнцийн ганц тулгуур гэж байдаг сан. Ганцхан үнэн сэтгэлт эмгэн буурал Бүрт нь үхэх цагийг дурдан суужээ.

Үнэхээр, би насанд дарагдав уу? Арай ч үгүй байх аа. Далдуур атаархдаг өстөндөө, зайдан моринд үсрэн мордож зэрлэг бодонг хар хурдаар давхин жадалж, хорлох гэсэн алуурчныг хүчит гараар багалзуурдах чадалтайгаа үзүүлж, доройтон өтлөв гэгсдийг хатуу ширүүнээр залхаан... гэвч, цэцэн зоригтой Бүрт, сууриныг залгамжлах гэж сануулсан нь түмэн зөв. Дөрвөн хөвүүний алинаар суурийг залгамжлуулах вэ? Ууган хүү Зөч догшин зоригоор бөгөөд эцгээ бушуу үхээсэй гэж бусдаас илүү хүсдэг хүн. Одоо дөчтэй, лав эцгийнхээ төрийн жолоог булааж, өвгөн эцгээ өтөлсөн хөгшдийн гэрт суулгахын хүсэл болоод байдаг байна.

Түүнийг мэдээд, Зөчийг, улсын алсалсан бөглүү тасархай хязгаарт зориуд суулгаж, Зөчийн хөдлөх бүр мэдээ хүргэж бай гэж нууц тагнуул явуулсан билээ.

Хоёрдугаар хөвүүн Цагаадай, эцгээ үхүүлэхээс атаат ах Зөчийн үхлийг илүү хүсдэг тул, бие биесийг дайсагнан занаж, тэмцэж байгаа үедээ надад аюулгүй хэрэг гэж бодоод гуравдугаар хүү Өгөөдэйг сэтгэл зөөлөн, хар санаагүй, найр наадам, хурим тойд дуртай, начин шонхортой, ав шувуу, хурдан моринд бахтай. Лав эцгийг далдуур хорлох санаа өвөрлөхгүй гэж Өгөөдэйгөөр суурийг залгамжилна гэж тогтжээ. Дөрөвдүгээр хүү Толуйн зан байдал мөн тийм бөгөөд эрх

ашгийг тэмцэхгүй, архи дарсанд дуртай гэж Чингис, аян дайнд мордохдоо суурийг гуравдугаар хөвүүн Өгөөдэйгөөр залгамжлахыг зарласнаар хоёр ахмад хөвүүний сэтгэл улам хорсож, амь хорлох болуузай, харанхуй шөнө хорт сумаар харваж алах болуузай, цацрын чихийн цаанаас жадлах болуузай гэж үргэлж сэргийлэн явах болжээ.

Өгөөдэйг суурь залгамжлахаар зарласан тэр цагаас хойш гомдох сэтгэл төрсөн Зөч, ноогдол түмэн цэргийн хамт, алс хол газар хулжин хөндийрсхийгээд, олны дунд онц гарамгай болж, түмний дотроос түрүүлэх гэж, алдар гавьяа байгуулахыг хүсэн, эр цэргийн сэтгэлийг биедээ татахыг оролдох болов. Насан залуу, чадал ихтэй эр, аяа! Залуу явах мөн сайхан аа! гэж бодсоор цааш нааш хөрвөж хөгшин тарган Бүртийн хэлсэн үгийг дахин дахин санаж, үхэх цаг ойртож байгааг бодширон хэвтэхдээ махир эвэртэй бөхөнгийн давхиж, огторгуйд нь бүргэд хальж нисдэг уудам талын өндөр хиргис хүүр санаанд нь ороод, тийм хиргис хүүрт их баатар эрийн яс тавьдаг гэдэг. Улс бүгдийн сүр хүчин ихт эзэд, хүчирхэг хаад цөм үхдэг байсан. Гэвч, Чингис хаан би, бүгдээс хүчин чадал ихтэй. Хэдий тийм боловч, Чингис надтай адил тийм их уудам газар орон эзэлсэн хүн ер байна уу? Үхэх гэдэг, чухам юу юм бол? Сонсвол ерэн есөн зүйлийн усаар хүний биеийг мөнх болгодог гайхамшигт их эм найруулан чаддаг эрдэмтэй эмч домч, илбэчин бий гэдэг...

Хүзүүндээ дөнгөтэй боол байсан жирийн цэрэг эр Тэмүүжин миний биеийг эцэстээ хуралтайгаар тэнгэрээс заяат Чингис хаан гэж өргөмжилсөн биш үү? Хэрэв, Хөх тэнгэр мөнх бол, түүнээс заяат миний бие мөнх байх ёстой биш үү?

Хятадын эрдэмтэн зөвлөх Елюй Чуцай маргаашийн дотор улсын зүг зовхис бүхэнд чанд зарлаж, Хятад, Бомбо, Төвөд илбэчин, Алтайн бөө нарын зэрэг аливаа ид шидтэй, эрдэмтэй мэргэн хүнийг хааны өргөөнөө залан ирүүлж, ор залуу, тэнхлүүн, мөнх наст болгогч эм домоо авч ир гэж яаравчлан зарлууллаа. Гайхамшигт эм дом авчрагсдад их хаан миний бие ертөнцийн эзэд хаадын өгч үзээгүй их шан өгнө... гэж бодож, эргэж хөрвөсөөр унтаж, сая үүрэглэхэд хөлийн эрхий хурууг чанга гэгч нь чимхсэн шиг өвдөхөд цочсонгүй, нүүдэлчин улсын ердийн тохио тул, даруй тэргүүнийг өндийлгөн харвал, харанхуйд юу ч үл үзэв.

Хээрийн алаг даага мэт гуалиг, башуу биетэй янаг сүйт Бүртийн хөлийн эрхий хурууг чимхэж байсан нь сэтгэлд нь ороод, тэр үед

Бүртгэлжиний эцэг Дай сэцэний харанхуй гэрт эсгий дээр гэрийн хотлоор унтдаг билээ. Одоо миний хөлийн өмнө хэн сууж, хэн дуудаж байгаа юм бол? гээд, гарыг аяархан сарвайж тэмтэрвэл, нарийн торгон дээлтэй, бяцхан мөртэй эмэгтэйн хачин самнасан үс баригдаж, биедээ ойр татаж үзвэл, тэр эмэгтэй, хэл буруу хазгай музгай үгээр шивгэнэн,

— Чиний хүсэлт Хулан хатан үхнэ. Чи ирэв. Чи санаа засав. Чи нар ба хүсэлт сар ба гэжээ. Тэр бол, Чингисийн хүсэлт гэдэг залуу хатны гар доорх хятад шивэгчин байжээ. Хятад шивэгчин хулгана мэт сэмээр шургаж орж ирсэн юм байжээ. Хулан хатан дуудуулжээ гээд, эсгий оймст уужим гутлаа өмсөж, бусад дэргэд нь унтаж байсан Өгөөдэй, Толуй хоёр хөвүүнээ гишгэж сэрээхгүй гэж их хичээн алхсаар цацраас гарав.

ХУЛАН ХАТНЫ ГЭРТ

Хосгүй үзэсгэлэнт эмс бий, нүд нь уурласан шилүүсний нүд мэт жирмэгэр.
(Монгол дуунаас)

Шөнийн нам гүмд, цаст уулсын жавар сэнгэнэн, сар, балар үүлний цаана орж, огторгуйд энд тэнд одод сүүмэлзэн, хятад эм, Чингисийн өмнө малига цэцгийн сайхан үнэр ханхлуулан явтал, хоёр хүн сүүмэлзэн үзэгдэж,

— Зогс, хэн бэ? гэв.

— Хар Ирчис гэж хятад эм шивгэнэхэд,

— Дагасан дэлхий дахин гэж хэвтүүл манаа, нууц болзлын үг хэлээд, зам тавьж өглөө. Цагаан гэрт ойртож явах зуур хаан, өнөөдөр хүсэлт, бас, ямар шинэ маяг үзүүлэх бол? гэж дотроо бодож явлаа. Цэргийн дарга нартай үг хэлэлцэх завсар чөлөөндөө хатны гэрт орох бүр, Хулан хатан, янз бүрийн дүрээр угтаж, заримдаа хятад эхнэр мэт ер бусын цэцэг хээтэй торгон дээл өмссөн байдаг, заримдаа булган хөнжлөөр хучаад, үхэх гэж байна аа гэж ёолж, Чингисийг чийрэг гараараа бяцхан зүрхийг минь барьж үз гэдэг байжээ. Заримдаа нүд алдам элчилгүй цөл талын дунд байдаг ганц айл, Хэрлэн голын хөх ногоо өвс ургасан эргийг магтсан Монголын эртний дууг хөгшин монгол ахын дуулахыг сонсон, толгойгоо гараар тэврэн, нулимс гоожуулан суудаг байжээ.

Хятад эм, цагаан гэрийн үүдийг сөхөж ортол, бударганаар гал түлж, утаа мушгиралдан цагариглагдаж, гэрийн тооноор дээш гарч, Хулан хатан, өвдгөө тэврээд, нүдээ аньсхийн, галын очны үсрэн бууж байгааг ширтэн, гэрийн дотор урьд дэвсээтэй байсан торгон хивсэн оронд гурван эрээн ширдэг дэвсэж, гэрийн нэгэн талд хамаг юмаа хэдэн ачмагт жин тан гэтэл хураажээ.

Хаан, гэрт оруут зогсож, мийн нүд мэт гялгар нүд цогтойёо гялалзан, шинэ маяг гаргасан нь энэ байжээ гэж үзтэл, Хулан хатан сэргэж, чамархайгаа тултал будсан хөмсөгтэй нүдээ алгаараа арчаад босож толгойгоо гэдийлгэн Чингисийн хөлийг тэврэн сөгдөж өгүүлрүүн:

— Үе улиран хосгүй эрхэм их, түмэн наст чамайг нойр бодлого, цэргийн явдалд саад хийж үймүүлсэн түмэн бурууг уучлан хэлтрүүлнэ үү?

Би энд байж чадахгүй боллоо. Энд зүг бүрээс миний бие, миний нялх хөвүүнийг хорлох аюултай байна. Нэгэн итгэмжит шивэгчин дагуулан гуйланчийн дүрээр намайг хүн танихгүй хээр талд хэрэн бядаж явъя гэж гуйхад нь хаан,

— Чи баахан хүлээ. Надад нэгэн аяга хятад цай өгтүгэй. Чиний дэргэд сууж хаанаас юу хорлох гэж байгааг сонсъё гээд галыг тойрон, ширдэг дээр сууж, дэвсээтэй байсан торгон дэвсгэр, шувуу, цэцэг, навч хатгамал оёсон зах хөшиг хаана орчихоо вэ? Ханхай гэрийн байдал 40 жилийн өмнө байсан миний гэртэй адил энгийн нэгэн нүүдэлчний гэрийн шинжтэй болжээ гэж бодож суутал, Хулан хатан, биеэ хурааж атираад, уурласан шилүүсний нүд шиг ууртай нүдээр Чингисийг харж дэргэд нь бие нүцгэн бяцхан хүү Хөлгөн хэвтжээ. Хүрэн үсээ хяргасан толгойд нь хоёр бяцхан сэвлэг тавьж чихэн дээгүүрээ унжуулжээ. Хулан хатан, эмгэнэсэн яруу дуугаар надад горьдох өмөг алга. Эцэг эх, ах дүү нараас минь ганцхан дүү үлдээд одоо энгийн нэгэн цэргийн алба хааж явна. Урьдын цагаар өөрөө харин мянган цэрэгтэй явах юм сан даа.

Миний тэр дүү ч мөд үхэх байх даа гэхэд нь,

— Тэр чинь яагаад үхэх юм бэ?

— Манай заяа муут мэргэд аймаг, барсын нүдтэй хатуу сэтгэлт, чиний хөвүүн Зөчийн цэргийн мэсэнд сөнөж, одоо мөд Зөчийг ирэхэд би эцэг омог төрлийнхөө хүнийг түүнд алуулаад, өстөн түүний царайг яаж харах билээ. Намайг дарж унах гэж байгаа чулуун хадын дор

байгаад би юу хийх вэ? Намайг явуулж өгнө үү. Би хамаг юмаа бэлэн зэлэн болгосон гэж гуйв.

— Зөч хаан, ирэхгүй. Иргис голын тэнд дахин аян дайнд мордох гэж байгаа. Намайг амьд байгаад, ертөнцийг жолоодож байтал, надаас өөр ямар өмөг түшиг чамд хэрэгтэй юм бэ? гэхэд нь, Хулан хатан бөмбөрөн унаж байгаа нулимсаа нарийн хуруугаараа арчив. Чингис бас өгүүлрүүн;

— Чиний дүү Жеман-Хажийг миний мянган цэргийн зургаадугаар зууны даргаар болгоод, мянганы дарга Цагаанд тушааж, зургаадугаар зуунаар чиний гэрийг чинь, чиний биеийг, чиний бяцхан баатар хөвүүнийг хамгаалуулсугай. Намайг түшсэн хүн юунаас айх вэ? гэхэд нь, Хулан нүдээ доош даран чичирхийлсэн нам дуугаар өгүүлрүүн,

— Чамай өөрийг чинь нууц хүн хорлох гэж байна гэхэд нь,

— Ямар хүн бэ? Хэний хүн бэ? Хэл! гэж Хулангийн мөрөн дээр гараа тавьж асуухад нь, хөмхийгөө зуугаад, мултран сугарч зайлтал, урт хар гэзэг нь ширдэг дээгүүр могой мэт гозосхийснийг хаан хөлөөрөө гишгээд, шивгэнэн,

— Хэн намайг хорлох гэж байгаа юм бэ гэхэд нь, Хулан арааараа хананд наалдан өгүүлрүүн:

— Аугаа их зүйрлэшгүй эзэн минь ээ, чамд ямар ч улс, ямар ч цэрэг аюулгүй, ширүүн салхи намрын навчийг хийсэгдэг адил чи тэднийг бут ниргэнэ. Гэвч, чи, нэгэн цацарт чамтай хамт сууж, чамайг өдөр шөнөгүй дагаж явдаг дайснаас биеэ хамгаалж чадах уу? Ганцхан би чамайг үнэнч сэтгэлээр үйлчилж, гялтганасан цаст Алтайнхаа уул мэт хайрлан санаж явдаг биш үү. Чи миний ганцхан өмөг түшиг, чамгүй бол намайг зам дээрх чулуу мэт авч хаях байсан билээ. Миний хэлж байгаа үг үнэн шүү. Чи салхины шуугих, шувууны донгодох, могойн шихнэхийн учрыг мэддэг хүн, учрыг ухамсарлаж мэдэлгүй дээ. Миний үг үнэн гэхэд нь хаан гэзгийг нь тавилгүй,

— Мэддэгээ хэл гэж хоолойгоо хяхруулан хэлэв. Хаан, Хулан хатны нүд, бахархан гялалзаж, хааны төрийг залгамжилж голомтыг сахидаг нь отгон хүү гэж өвгөд мэргэдийн ёс тогтжээ. Ахмад хөвүүд, гараа ганзаганд хүрмэгц эцгийн гараас жолоог мултлах гэж оролддог шүү дээ. Тийм дээрээс эцэг нь ахмад хүүгээ өрх тусгаарлаж, өмчийг нь гаргаж өгөөд отгон хүүгээ өсөж торнитол санаа амар, адуу малаа өсгөн явдаг гэдэг. Чи, хөвүүддээ хувь хувьд нь улс гаргаж өгөөд, юунд отгон

хүүгээ хаан ширээ залгамжлах болгосонгүй вэ? гэхэд нь хаан, Хулангийн гэзгийг тавиад шахинаж, шахинаж,

— Би хөвүүн та хоёрыг хайрлан хамгаалаад... отгон хүүгээрээ ширээ залгамжлуулахыг зарласангүй. Монголчууд, хэзээ ч мэргэд овогт эхийн хөвүүнд захирагдан дотнолж өгөхгүй гэхэд нь Хулан хөхөрч өгүүлрүүн;

— Хүний гайхамшигт ижил хосгүй эзнээ, тэнгэрээс заяасан чамайг би мэргэд омогт эхийн хүү гэж айхгүй энхрийлэн санадаг шүү дээ. Чиний өөлд эх, угтаа монгол омгийн хүн биш, манай мэргэд омгийн хүн шүү дээ гэхэд нь Чингис эрхрэн босоод,

— Чи зүйтэй үг хэлэв. Түүнийг бүгдээр мартсан билээ. Мартсанаа улс, санаад ч яах вэ. Би чиний үгийг цээжиндээ хадгалав. Чиний зайлж явсны хэрэггүй, юмаа гаргаж дэлгэ. Би ноёдтой цэргийн хэргийг зөвлөх завсар чөлөөгөөр ирж байя. Миний бяцхан шилүүсэн мэт хүсэлт минь ээ гэж их алхмаар гэрээс гарав. Хулан, Чингисийг гарсан хойно босож, хөмсгөө атируулан бодлого болж, урт хар гэзгээ гартаа ороож байгаад, шивэгчнийг дуудаад хятад хүүхнийг ханын ёроолд үхширтэл унтсаныг үзээд бяцхан хөлөөрөө өшиглөн сэрээж,

— Тэр бүдүүлэг амьтан миний гарыг золтой хугалсангүй. Чи дахин хивсээ дэвс. Адууны хялгас авчирч гэзгэнд минь нэмэн сүлж. Тэр зэрлэг амьтан гэзгийг минь арай тасалсангүй. Маргааш гадаадын элчийг будаална. Чи мөнгөн цэцэг хатгамалласан хятад хөх дээл гаргаарай гэжээ.

ХААН ХУРУУ ДАРАН ТООЛОВ

Хаан, «уурласан шилүүс»-ийн хэлсэн үгийг эргэцүүлэн бодож, хиргис хүүрийг аяархан эргэж явтал, дахин нэг хүн сүүтэлзэн өндийж, «Хар Ирчис», «Дагасан дэлхий дахин» гэж харилцан манааны цэргийн нууц болзооны үгийг хэлэлцтэл, дайсныг уулгалах бүхэнд явалцаж байсан хуучин цэргээ таньж,

— Юу сонсов? Юу үзэв? гэв.

— Алсын ууланд олон гал байна. Од шиг тэр гялалзаж байгаа нь мал сүрэгтэйгээ ууланд дүрвэсэн нутгийн олны түүдэг буй. Эндэхийн хүн, манай цэргээс айн дүрвэжээ гэхэд нь,

— Цэргүүд хоорондоо юу хэлэлцэж байна гэж асуув.

— Хонио идэж бараад, агт ч өвсийг идэж гүйцээд үндсийг зулгааж байна. Илд сэлэм цусаар мялаахыг хүлээж байна. Манай их хаан биднээс мэргэн, бүгдийг угтаж мэддэг тул, мөд хүн малын гэдсийг цатгах газар биднийг удирдан явна байх гэж байна даа гэхэд нь,

— Зөв! Би, бүгдийг үзэж мэдээд, бүгд юмны учрыг олж байгаа. Мянганы ноён Цагаанд бушуухан очиж, зургаан зуун цэргийг биеэр удирдан гарч ир гэсэнд,

— Жа, хаантан минь гэтэл нь,

— Байз! Чи бас Цагаанд намайг энэ хиргис дээр хуруугаа даран тоолж хүлээнэ гэж хэл гэхэд нь, тэр монгол, майга хөлөөрөө алцганан гүйж, довцгоос буугаад одсон хойно нь хаан цөмцийн суугаад, чих тавин харанхуйд сонсогдох чимээг чагнаж нэг, хоёр, гурав, дөрөв гэж тоолсоор зуу хүрмэгц нэг хуруугаа нугалж байтал, сар нэг үүлний цаагуур орж, нэг харанхуй тэнгэрт гарч ирэхэд нь товцгийг тойрон барьсан цэргийн гэр маш тод ойрхон үзэгдээд, сарыг далд ороход бүдэг толбо мэт харлан харагдсаар, хааныг хоёр зуу хүртэл дараалан хоёр хуруугаа дартал, гэрийн хоорондуур хар хар сүүдэр гүйцгээж, хэдэн цэрэг манан татсан талын зүг давхилдан удалгүй цэргийн хүрээнээ, түргэлцгээ гэж хашхиралдсаар хаан, ажиггүй сууж, гурав, дөрвөн, зуу хүртэл тоолсоор байтал адууны төвөргөөн гарч улам улам ойртсоор мянган агт айсуй нь мэдэгдэв. Агт довцог толгойн ёроолд хүрч ирээд морины хөлс ханхалж, цэргийн хүрээг хоромхон зуур бөглөсөн шиг тоос дэгдэв. Хаан, хуруу даран тоолж л суув. Адуун дунд өшиглөлдөх, унгалдах нь сонсогдтол хаан, сөөнгө өтгөн дуугаар хашхируун:

— Цагаан! Хүүе! Цагаан! гэжээ.

Харанхуйгаас,

— Жа гэж нэгэн хүний хариу дуугарахад,

— Би одоо зургаан хуруугаа дараад байна. Яасан уддаг юм бэ? гэхэд нь,

— Дахин хоёр хуруу дартал бид мордоно гэж хэлэх нь сонстов. Саран дахин үүлний цаанаас гарч, хүрээлэн буусан олон гэрийн дунд чөлөөний зүг энд тэндээс монголчуудын шаламгайлан гүйж, зарим нь эмээл тохмоо бариад, зарим нь морио хөтлөөд, зарим амжсан нэг нь жагсах газар тийшээ давхилдан одож байв.

Хаан, тоолсоор долоон хуруугаа нугалтал, араасаа хүний ирэх чимээ сонсоод, эргэж харвал хоёр цэрэг, эмээлтэй морийг нь хөтөлж

ирснийг үзээд, дэлээс барьж мордоод, довцгийн хажуу дээр гарахад нь хойноос нь долоон цэрэг бараа болж, нэг нь дэрвэлзсэн бүчтэй туг барьжээ.

Хааны өмнүүр, зүг бүрээс морьтой цэрэг өнгөрч, найм гэж хуруугаа дарахын өмнө зуу зуугаар зургаан эгнээ жагсаад тэргүүнд мянганы ноён Цагаан дэргэдээ хэдэн бие хамгаалагч торгууд дагуулжээ.

— Цагаан хүрээд ир! гэж Чингис хааны хашхирахад, Цагаан довцгийн дэргэд давхиж ирээд гурван алхмын өмнө зогссонд,

— Чи олон харц, талын дэлдэн чихт туулай мэт аймхай нарын дүрвэсэн тэр ууланд хүрч, хамаг малыг нь тууж, нэг ч хонь орхилгүй авчир. За явтугай гэхэд нь, Цагаан баг цэргийн зүг давхиж очоод,

— Намайг дагаад явцгаа гэж зам удирдан давхив. Тэр нэгэн баг цэрэг нь эгнээ эгнээгээр, зуу зуугаар хойноос нь дагаж, сарны гэрэлд цайран харагдаж байгаа замд ороход нь хаан, довцог толгой дээр хуруугаа даран тоолсоор, алсад хамгийн сүүлчийн цэрэг бүртэлзэн үзэгдэхгүй болоход,

— Бардам амтай Хоресм Шаг, ийм цэрэгтэй болж чадсан бол уу? Бухарын тэнд байлдахдаа үзнэ дээ гээд аравдугаар хуруугаа дарав.

СУРАГГҮЙ БОЛСОН АЯНЧИН

Чингис хаан, Хоресм Шагийн нутаг, элдэв бараа худалдуулах их аян жин явуулахыг лал элчдээ даалгаж худалдуулах зүйлийн дотор хятадаас дээрэмдэж авсан эрдэнэсийн ихэнхийг өгөөд, зарсан мөнгөөр нь шалгарагсдыг хөхиүлэн шагнах торго бүсийн зүйлийг аль болох ихээр захижээ.

Махмуд-Ялвач, их эд барааг ачиж явуулсан боловч, өөрөө явахгүй гэж, хоёр нөхөртэйгөө Бухарт хор идүүлсэн гэж гэртээ ёолон хэвтэж байлаа. Аянд явах улс, таван зуун тэмээн ачаатай, дөрвөн зуун тавин хүн, бие биеэ худалдаач, бичээч гэж тэдэнд бүгдийн даргад Чингис, Усан гэдэг монгол цэргийг томилжээ. Аяны улс Тэнгэр уулыг давж, лалын нутгийн захын хот Отрар гэдэгт хүрч, аянчны дарга Усан, хотын даргад Шаг Мухамедын гарын үсэг, тамгатай бичгийг үзүүлэв. Тэр үед Шаг Мухамед, Монголын худалдаачинд «Хоресмийн олон хотод гааль түрээсгүй явж худалдаалах эрхийг олгосон» гэжээ.

Ер нь, Отрар хот, эртнээс худалдаачны талаар алдартай хот тул, хавар намар цаг, алс зэлүүд хөдөө газрын хүн, хонь мал, боол, давстай арьс шир, элдэв ангийн үс, нэхий, хивс авчирч гутал, зэв, сүх, хайч, зүү, хадаас, зэс сав, ваар арилжин авдаг байжээ. Тэр бүх зүйл, Хоресмийн Маверанагрийн олон хотын урчууд боолтойгоо хийдэг байжээ.

Отрар хотод ирсэн монгол худалдаачны бараа, урьд үзэгдээгүй сонин юм байжээ. Худалдаачин нь хивс дээр Отрар хотын хүмүүсийн энэ насандаа үзээгүй хачин, жигтэй үнэтэй тансаг зүйлсийг дэлгэж, хотын хүн багсартал бөөгнөрч, цул алтаар цутган үйлдсэн мэт уран сайхан алтадсан бяцхан төмөрлөг бурхан, хасаар үйлдсэн өлзийт артай бумба, хаш тэнэгэрээр хийсэн хүн амьтан, бойпор, Хятадын нарийн шаазан, аяга данх, эрдэнийн чулуу шигтгэсэн алтан бариул, алтан хуйтай илд, хар үнэг, минж, эр эм хүний булган хажаастай торгон дээл зэрэг үнэтэй ховор эд дэлгэснийг хотынхон гайхаж, бахархан хоорондоо ярилцах нь,

— Энэ бүгд эрдэнийн зүйлийг Татар, цөм хятад газар хааны ордноос дээрэмдсэн биз ээ. Энэ гоё сайхан дээл хатсан цустай байж магадгүй. Цэрэг дээрэмдсэн олзоо худалдаачинд сул үнээр өгөөд, худалдаачин, дам худалдаж их ашиг олж дэлбэртэл баяжих санаатай биз гэж ярихад зарим нь,

— Манай цэрэг юунд Хятадыг дайлдаггүй юм бэ? Бид ч ийм эрдэнэсийг олж чадах сан билээ. Зарим нь,

— Татар худалдаачин, энэ гоё сайхан барааг хагас үнээр ч худалдсан Отрарын худалдаачин хэцүүдэж, манайхны эд барааг хэн ч тоож авахгүй болно гэж хэлэлцэв.

Хөдөөгийн мал туугчид ойшоохгүй байдалтай, толгойгоо сэгсрэн,

— Ийм эд хэнд хэрэгтэй юм бэ? гээд, ноёд, шүүгч, түшмэд, улем лам нарт л хэрэгтэй биз. Одоо, энэ гоё хувцас худалдаж авах гэж биднээс давхар алба татвар татаж тарчлаах биз гэцгээв.

Отрар хотын дарга, Хоресмийн хааны хатан Турханы ач Иналчиг Кайр хаан байжээ. Тэр хүн, дагалдагсдын хамт, зээлээр өнгөрөн гарахдаа, элдэв бараа дэлгэн тавьсан монгол худалдаачны дэргэд зогсож, худалдаачнаас бэлэг аваад боомтдоо буцаж, шинэ ирсэн худалдаачны байдалд сэтгэл зовнин, Хоресм шагт мэдээ өргөн явуулсан нь,

«Отрар хотод худалдаачны хувцас байдалтай ирсэн эдгээр хүний байдлыг хянавал Татаарын хааны нууц тагнуул болохоос худалдаачин биш бололтой. Зан ихэрхэг бардам. Тэдний нэг энэтхэг худалдаачин намайг хаан гэж дуудалгүй миний нэрээр дуудсан тул, түүнийг ташуурдуулав. Бусад худалдаачин нь худалдаа наймааны хэрэгт огт дайралдахгүй элдэв юмыг хүнээс асууж, энгийн хүнтэй ганцаараа ярилцахдаа,

— Та нарын ард юу болж байгааг та нар мэдэхгүй байна. Мөд та нарын эсэргүүцэвч чадахгүй их хэрэг гарна гэж занаж ярьдаг байна» гэжээ.

Тэр захиаг үзэж цочсон Хоресм шаг, Монголын худалдаачдыг Отрар хотноо барь гэж тушаасан тул, удалгүй дөрвөн зуун тавин худалдаачин, дарга Усантай хамт цайзын нүхэн гянданд бараа туруугүй алга болж, Монголын барааг хотын дарга хураан авч, Бухар хотод худалдуулаар явуулж, орлогыг Хоресм шаг Мухамед авчээ. Худалдааны аяны олон хүнээс ганц тэмээчин амьд үлдээд оргож, Монголын захын харуулд хүрч ирээд, тэндээс өртөөний морь унаж, Чингис хаанд аюултай мэдээг хүргээр довтлон одов.

ЭЛЧИЙГ БООМИЛДОГГҮЙ, ЗУУЧИЙГ АЛДАГГҮЙ

Шинэ сар хуучрахын өмнө Татаарын хаан Бухарт бас элч явуулав. Тэр шинэ элч Иби Кефреж Бограгийн эцэг нь урьд Хоресм шагийн эцэг Текешийн дэргэд эмирийн тушаалыг хүлээж явсан бүлгээ. Тэр элчтэй хамт хоёр их тушаалтай монгол хүн иржээ.

Хоресм шаг Мухамед, Монголын элчийг бараалхуулахын өмнө Хивчагийн цэргийн эрх баригчидтай зөвлөлдөж, тэдний үгээр монгол элчийг их сүр бадруулан бараалхуулж, Чингис хааны бодлогыг мэдэх гэж, үгийг сонсъё гэж боджээ.

Тэгээд, ахмад элч толгойгоо гэдийлгэн орж ирээд ордны даргын тогтоосон дүрмээр зэвсгийг гадна үлдээсэн боловч, байлдах гэж байгаа мэт сөгдөлгүй зогсон хэлрүүн:

— Баруун зүгийн эзэн ээ! Манай Чингис хааны улсаас танай Отрар хотноо ирсэн худалдаачин, чиний олгосон гарын үсэг бүхий тамгатай жуух бичиг баримталж ирснийг чамд сануулаар ирэв. Чи, тэр бичигтээ, манай худалдаачинд чөлөөтэй худалдаа хийхийг зөвшөөрөөд, тохиолдогсдод эв найрамдалтайгаар харилцахыг тушаасан билээ.

Гэтэл, чи зүй бусаар мэхэлж, манай худалдаачныг цөмийг алуулж, эдийг дээрэмджээ. Хэрэв урвах гэдэг жигшүүртэй хэрэг гэвэл, Исламын толгойлогчоос гарсан энэ хэрэг нэн ч жигшүүртэй болно биз ээ гэхэд нь Хоресм шаг их л тачаадан,

— Ичгүүргүй амьтан! Чи ямар аюулгүй надад энэ мэт үг хэлэв. Миний зарцын үйлдсэн буруу хэргийг чи ямар аймшиггүй надад түлхэж, намайг буруушааж байна гэхэд нь,

— Их Шаг аа! Хэрэв Отрар хотын дарга чиний зарлигийг зөрчиж тэгвэл сайн биз. Тэгвэл, тэрхүү ялт боол Иналчиг Кайр хааныг бидэнд тушааж өг. Манай их хаан, түүнийг цээрлүүлэн шийтгэнэ. Хэрэв чи хүлээхгүй бол даруй байлдаанд хүрнэ. Тэгвэл, хамгийн баатарлаг зоригтон амь хохирч, Татаарын хатан жад хэзээд алдахгүй жадална гэхэд нь, Хоресм шаг тэр хатуу үгийг сонсоод, бодлого болов. Дэргэдэх олон цөм, «байлдах уу? үгүй юү?» гэдэг асуудлыг шийдвэрлэх болж гэж ухацгааж дув дуугай болов. Хивчагийн хэдэн бардам хаан өндөр дуугаар,

— Бардам амьтныг алагтун! Биднийг айлгах санаатай юу? Их хаан аа, Иналчиг Кайр хаан, чиний эхийн ач шүү дээ. Үнэхээр чи, түүнийг буруу номтонд тас татуулахаар өгөх гэж үү? Хортон энэ жигшүүрт амьтныг алах зарлиг буулга. Эс бөгөөс бид өөрсдөө тонилгоё... гэж хашхирцгаахад,

Хоресм шагийн царай үхсэн хүний мэт үнсэн хөх болж, уруул нь чичирхийлэн байж, нам дуугаар,

— Иналчиг Кайр хаан, миний шударга боол, би түүнийг өгөхгүй! гэсэнд Хивчагийн нэгэн хаан босож, Монгол элчийн дэргэд ирээд, сахлаас нь шүүрэн, хутгаар хяргаад нүүр өөд нь шидэв. Ибн-Кефреж, төрөлхийн чадалтай зоригтой эр боловч, ер эсэргүүцэн тэмцэлдсэнгүй, ганц хашхиран хэлсэн нь,

— Ариун номд «зарсан элчдийг зодохгүй, алахгүй» гэсэн биш бил үү гэв. Хаад, нэгэн зэргээр хашхиран,

— Чи, элч түшмэл биш, харин Татаарын хааны гутлын тоос мөн! Чи лал хүн атал, ямар учраас манай дайсныг үйлчилж байна? Чи, Татаарын хааны хог, урвамтгай амьтан, чи эх орноос урвасан этгээд гээд элчийг зүг бүрээс довтлон орж, хутгаар энд тэндээс бүлж алаад хоёр монгол нөхдийг нэвсэртэл жанчаад Хоресмийн Шагийн нутгийн захад хүргэж сахлыг нь шатааж, морийг нь булаан аваад, явган явуулжээ.

ЧИНГИС ХААН ХИЛЭГНЭВ

Хаан, өдөр бүр цацраас хэдэн удаа гарч алсыг ширтэх нь ямар нэгэн юм ирэхийг хүлээсэн бололтой. Цацарт ороод торгон дэвсгэр дээр сууж, ерөнхий зөвлөх сайд Елюй-Чуцайн тайлбарлахыг сонсон авай. Елюй-Чуцай, бие өндөр, туранхай, хөдлөх нь алгуур соргог хурц нүдтэй, хятад хүн.

Дэлхий дахиныг морин дээр байлдан дагуулж болно. Морин дэл дээрээс дэлхий дахиныг удирдан жолоодож үл болно. Муж бүрд нэн даруй тусгай дарга тохоон томилж, амуу тарианы сан хөмрөг байгуулж, албат ардаас албан татварыг татаж, «шүүх таслах газар» байгуулж, албан татвар тушаагаагүй этгээдийг үхэх ялаар залхаан шийтгүүлж байх явдлыг эрхлүүлбэл зохино. Мөн «шүүх таслах газар»-т эрдэмтэн хүнээс шалгаж, итгэл бүхий хоёр хоёр хүнийг суулгаж, нэгээр даргалуулж, нөгөөгөөр туслуулбал туйлын тустай. Жич ашиг орлогыг нэмэгдүүлэхийн тулд худалдаачнаас гааль авах, архи, цуу, давс, төмрийн зүйл, алт, мөнгө, мөн тариалангийн газрыг услах зэргээс татвар хураавал зохино гэсэнд Чингис, чиний хэлдэг цөм хэрэгтэй зүйл гэлээ.

Түүнээс тамга хадгалагч уйгур Исмаил Хожа, хаанд тамгыг өргөн, хасаар үйлдсэн, барс бариултай, шунх түрхсэн дүгрэг алтан тамга ажээ. Чингис, тамгаа аваад, Елюй-Чуцайн эртхэн бэлтгэсэн зарлиг дээр дарав.

Үдийн халуунд, талын дээгүүр наранд халсан агаарын хий, долгио жирвэгэнэн Чингис хааны цэргийн хүрээнийхэн бүгдээр халуунд нозоорч, талд бэлчин идээшилж байсан адуу бөөгнөрөн хөдлөлгүй зогсож, толгойгоо нэгэн жигд хаялан дэргэдүүр нь эргэлдэн байгаа шумуул ялааг үргээж байтал, гэнэт алсаас ялаа гүнгэнэж байгаа мэт нарийхан дуу сонсогдсоор удалгүй жижиг хонхны түргэнээр жингэнэх дуу ойртсон тул, Чингис хаан сонсоод бүдүүн богино хуруугаа гозойлгож, дөрвөлжин нүүрээ гэрийн үүд өөд хандуулж, хүнд алтан ээмэг зүүсэн дэлдгэр том чихээ тавин сонсов.

— Элч ирж байгаа бололтой, нэлээд хэдэн хүн байна гэж гэрээс гарав.

Үзвэл, замаар тоос манаран, гурван морьтой хүн давхилдсаар хар гэрийн дэргэд хүрч иртэл, нэгийн нь морь ойчиж, морины толгой

дээгүүр алс өнхрөн унав. Харуулын хүн, морийг тосон харуулын боомтноо аваачив. Нөгөө хоёр хүнийг харуулын цэрэг дагуулан, морины хашааны дэргэд сууж байсан Чингис хааны дэргэд авчрав.

Үзвэл, Чингис хаан, цагаан гүүний дэргэд явган сууж, бяцхан бор унага эхийнхээ ягаан хөхийг нудчин шимж байгааг үзэн ажиж суув.

Ирсэн хоёр хүн, биеийг даавуугаар ороожээ. Нүүр нь хавдаж хөх булуу болжээ. Царай зүс нь маш өөр болсноор Чингис анхандаа таньсангүй, хараад,

— Та нар хэн гэгч вэ? гэж асуужээ.

— Их хаан аа! Бид чиний мянгатын ноён байлаа. Одоо үхлийн хөндийгөөс арай чүү тонилоод ирэв.

Хоресм Шаг, биднийг доромжлон дарлаж, эр хүний чимэг болсон сахлыг маань хуйхлан шатааж, энэ мэт болгов гэхэд нь,

— Ибн Кефреж Богра хаана вэ? гэвэл,

— Шагт чиний зарлигийг хатуугаар хэлэв гэж түүний биеийг Хоресмийн гахайд дуугаа нийлүүлэн ульдаг ноход хэдэн хэсэг болгон цавчиж алав гэхэд нь Чингис,

— Юу гэнэ ээ. Миний элчийг алсан гэж үү? Миний үнэнч зоригт Ибн Кефреж-Бограг уу? гэж маш хилэгнэсэн байдалтай хашхиран хэлж, хөсрөөс атга элсийг авч, толгой дээрээ цацаад, нулимс гоожин байгаа нүүрээ гараар арчиж байснаа гэнэт босож, замаар урагш ухасхийн гүйв. Түүний хойноос ойр дэргэд нь байсан хүмүүс дагалдан гүйв. Бас их чимээ гарахаар ямар учрыг мэдэлгүй сандарч, цэрэг мөн тэдэнтэй нийлэлдэн гүйцгээв. Хаан амьсгал давхцан гүйсээр морины уяан дээр очоод, зайдан морийг дэлдэн мордоод, хөх уулын зүг үсэргэн давхисанд Елюй-Чуцай, Чингисийн хөвүүн сандран мэгдэн мөн мордож, хойноос нь нэхэн одов.

Хад хавцгай болсон ууланд хүрч ирвэл, хаан, оргил хадны дээр, нарс модны дунд зогсож байгаа нь холоос үзэгдэн малгайгаа авч бүсээ хүзүүндээ зүүж, гялтганасан том нулимс, шороо түрхсэн хүрэн хар царайгаар нь бөмбөрөн унаж байлаа.

Чингис өндөр дуугаар,

— Мөнх тэнгэр! Чи зөвтнийг аварч, буруутныг залхаадаг билээ. Чи шударгагүй лал нарыг залхаа.

— Миний зоригт баатар дуулж байна уу? Лал нар, үүний урьд худалдаа хийхээр очсон элч Усун, 400 гэмгүй худалдаачныг хүйс тэмтэрч, хамаг эдийг дээрэмдэж, тэднийг доромжилсны дээр одоо, бас

миний элч зоригт Ибн-Кефраж Богpаг алж, нөгөө хоёр нөхрийн нь сахлыг гахайн гулууз утаж байгаа мэт шатаагаад, унасан морийг нь булаан, биесийг нь золбин хүн мэтээр хөөн гаргажээ. Бид үүнийг тэсвэрлэж болох уу? гэхэд нь татаарууд,

— Бид лалыг байлдъя. Удирд! Бид балгадыг товрог болгож, эхнэр хүүхдийг ч үлдээлгүй хядаад хамаг адуу малыг нь тууж авчирсугай гэж хашхиралдав.

Чингис хаан, зориуд тэгэхээс тэгэх гэсэн байдалтай,

— Тэнд дулаан, салхи шуургагүй, өвөл гэж байхгүй, зун байдаг, амттай гуа, хөвөн, усан үзэм ургадаг, зуны цагт гурван удаа ногоо хэнзэлж ургадаг. Ийм сайхан оронд лал мэтийн гэмт этгээдийг суулгаж болох уу? Бид, тэдний газар нутгийг булаан авч, хотыг нь товрог болгоод, арвай будаа тарина. Тэнд хааны бэх чийрэг хүлэг морьд бэлчээрлэж, манай эхнэр хүүхэд сууцгаах ёстой бий. Иймийн тул та нар, лал газрыг дайлаар мордоход бэлхэн байна уу? гэхэд,

— Ганцхан тэдний байгаа газрыг зааж өг. Бид огтчихыг мэдье гэж Татаарууд нэгэн зэрэг хашхирцгаав. Чингис хаан бас хэлсэн нь,

— Би, бөө удгангүйгээр «өлзийт сар» болж, баруун зүг дайнаар мордох цаг ойртсоныг мэдэж байнам гэж өндөр дуугаар хэлээд, эргэж аажмаар уул өөд өгсөн явахад түүний хойноос амь сахигчид, дагалдан явсаар Чингис хаан ганцаараа бодлого бодох гэж үлдсэн тул түүний байгаа газрыг хүрээлэн зогсож хамгаалан сахина.

Түүнээс Чингис хаан улам дээш авирсаар явтал нэгэн хэсэг талбай газарт түүдэг гал ноцож байх ба дэргэд нь нэгэн хүү бяцхан гар хөөргөөр нүүрсийг улайтган хөөрөгдөж байнам. Галын дээр хэдэн улайссан хэсэг төмрүүд хэвтэж байна. Хясааны дээр нэгэн хөгшин монгол, явган сууж, хэсэг төмрийг бахиар хавчиж, алхаар цохиход бэлтгэн байхыг үзээд, хаан дэргэд нь очиж асуусан нь;

— Чи хэн бэ?

— Зэв ноёны түмний Хорь гэдэг дархан.

— Чи энд юү хийж байна?

— Би сумны хатаасан зэв үйлдэж байна. Барагтай цохиход гулзайхгүйн дээр, ямар бат дуулгыг ч нэвт цоолно. Би ийм сайн сум үйлдэж байгаа тул, чамд тусалж байгаа биз ээ.

— Чиний хэлдэг зөв. Харин чи юунд энд уулан дээр ажилладаг юм бэ гэж Чингис еглөсөн байдалтай асуувал,

— Энд халуун дөл гарагч давирхайтай, үндэс мөчир элбэг, үнэнээ хэлэхэд би энэ өндөр уул дээрээс манай төрөлх нутаг алс холын талыг бараадан үзнэ.

— Чи чалчиж байна. Эндээс манай нүүдлийг үзэж үл чадна. Маш хол!

— Тал газрын хол нь адил биш гэж үү? Би төрөлх нутгийн зүг хармагц, зүрх хөнгөн болно.

— Энэ хүүхэд чиний хөвүүн үү?

— Багадаа хятад хүүхэд байсан юм. Одоо би хөвүүнчлэв. Үүний урьд их хаан чамтай Хятадад байлдаар явахдаа эцэг эх нь хаяад явсныг олж аваад эмээл дээрээ авч яван, хүн болгон өсгөж билээ. Одоо энэ хөвүүн надад туслалцана.

— Чиний дархлах багаж хаана байнам?

— Цөм надтай хамт эмээл дээр бий. Алх нь энэ. Тэнд хясааны дор хэсэг төмөр бий. Би сэлмээ хүүдийд нуун хийж, миний хөвүүний унаж байгаа морин дээр авч явдаг.

— Чиний морьд чийрэг сайн уу?

— Миний морьд, одоо тун хөгшин болжээ. Хэчнээн удаа дайн байлдаанд надтай хамт явалцсан гэж санана. Бухар газарт хүрсэн хойно тэндээс сайн морьд ба бас төмрийн хэдэн дархан боолыг шилэн олж авсугай гэж санаж байнам.

— Сайн зодолцвол чинь, азаргаар адуу олно, чи.

— Би ч ямар цэрэг байх вэ дээ! Айхтар сүрхий шархадсан юм. Дайн байлдаанд тохирохгүй. Харин энэ дадсан ажлаар оролдож, хутга, сумын зэв үйлдэж суувал дээр, их хаан танаас лавлах нь бид хэдий удтал энд байх вэ? Манай Зэв ноёны түмэн өлсөцгөөж, морьдоо алж идэх боллоо. Одоо хөдлөх цаг болжээ...

Чингис хаан хамраа шуухинуулан амьсгаадаж эхлэв. Энэ муугийн тэмдэг ажгуу.

— Хорь дархан чи, Зэв ноёны бүх түмэн урагш явсан, Зэв өөрөө арван хоёр өдөр энд үзэгдээгүй гэнэ үү? Чи түүнийг нэхэн олж ир! Тэгэхдээ замд тохиолдсон тэнүүлчнээс Зэв ноёныг харсан эссэнийг асуугаарай. Хэрэв бүх нөхөд энэ мэтээр зоригоор лагериас гадуур гарч тэнүүчилбэл, бүх цэрэг тарж барагдах хэрэг болно.

Дархан айн эмээн, чичрэн дагжиж, хөсөрт унав.

— Энэ дархан Хорийг миний мянганд аваачиж, хүрээний дунд загатнасан хонгыг нь 12 мод жанчиж залхаасугай. Жич, нэн даруй

тусгай хүнийг томилон одуулж, өөрийн харьяат зуунаас зориуд ангижран салж, үүгээр түүгээр хэсүүчлэн яваа нөхдийг баривчлан авахын дээр, мөн тэдний зуут мянгатын дарга нарын нэрсийг надад мэдэгдсүгэй. Би тэднийг шийтгэнэ гэж Чингис тушаал гаргасанд дархан, түүний майга том хөлийг хоёр гараараа тэврэн гуйвал, Чингис түүнийг нэгэн этгээдэд хүлээлгэж орхиод аажмаар чулуурхаг зөрөг замаар дээш өгсөж яваад зогсож,

— Би энд тэнгэртэй байлдааны бүтэмжийн тухай ярина. Уулын эргэн тойронд манаа гаргаж, хэнийг ч миний цэрэгт ойртуулж бүү саад болгосугай! гээд уулын оройн зүг цааш алхан явлаа.

ЗАХИДЛЫГ ХЭРХЭН БИЧИХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Чингис хаан, монгол хэлнээс өөр хэл мэддэггүй бөгөөд бичиж чаддаггүй,
(В. Бартольд)

Орой, хаан, цацартаа эргэж ирээд, цэргийн их ноёдыг дуудуулав. Удалгүй, Чингисийн залуу үеийн нөхөд болох ялалт дийлэлтийн алдраар биеэ чимсэн, бөгтөр нуруутай, хатангир, үрчгэр хацартай буурал өвгөчүүд ба гавьяа нэрийг умдаассан мэт хүсэх залуу идэр хаад цугларав. Эд цөм дор бүрнээ байлдахад бэлхэн болсон дөрвөн мянган морьт цэрэгтэй.

Бүгдээр хивс дээр, хагас дүгрэглэн, шахалдан сууна. Ганцхан Чингис хаан, бүхнээс дээр алтан сууринд сууж үзэгдэнэ. Суурины түшлэгийг сувдаар тоглож байгаа далайн медуз мэт урт хөлтэй, орооцолдсон «Өлзийт луу»-г маш урнаар сийлсэн бөгөөд суурины бариулыг хэрэлдэж байгаа барсаар дүрслэн үйлджээ. Энэхүү түшлэгт сандлыг алтаар үйлдсэн бөгөөд үүнийг Чингис, Хятадын хуандийн ордноос олзолж авснаас хойш аян байлдаанд мордох тутам өөртэйгөө авч явдаг байжээ.

Хаан, ширээний баруун талд, Чингис хааны хоёр дүү, хоёр бага хүү Өгөөдэй Толуй хоёр, зүүн талд хааны бага хатан Хулан, гарын хуруунаас мөрийг хүртэл үнэт сувдын эрих, алтан бугуйвч бүлзэг зүүж, гялалзан гялтганан сууна. Зарц хятадууд суугчдын араар чимээгүй явцгааж, алтан тавагт хийсэн амтат идээ хоол ба айраг, улаан архи агуулсан алтан цом зэргийг энд тэнд өрөн тавина. Хааны зүүн гарт,

залуу гэргийтэй зэрэгцэн, гаднаас ирсэн хоёр элч сууж, нэг нь Ашгаанбуу гэдэг бөгөөд Тангадын хүчирхэг хаан Бурхны зарлигаар иржээ. Нөгөө нь Өмнө Хятадын Сүн улсын хуандийн илгээсэн Хятадын жанжин Мин хун байжээ. Уулаас Сүн улс нь Умард Хятадын Жин улсыг дайсагнан үздэг тул, тийнхүү монголчуудтай харилцан найрамдаж холбоо байгуулахыг хүсжээ.

Энэ хурим дээр Чингис, зочдыг гоёмсог алтан хэрэгсэл ба элдэв зүйлийн идээ ундааны амттай сайхан, элбэг дэлбэгээр гайхуулжээ. Том алтан таваг дээр залуу гүү ба зэрлэг бугын махыг тавьж зочилсны дээр үүний хажуугаар хятад тогооч нарын хийсэн гайхамшигт амттай зуушны зүйлээр хамтад зочилсон буй. Айраг цэгээ, перс газрын улаан архи, тарвасын үрээр нэрсэн Хятадын архи, мөн өмнөд газрын ховор жимсээр нэрсэн сайхан амттай, зүйл бүрийн архиар зочилсон бүлгээ. Ийм архийг тусгай элч хөтөлгөө морьтой, цөл талын дундуур туулан явж авчирсан бөгөөд, энэхүү цөл талд зэрлэг адуу ба түүний мөрийг шиншлэн хөөсөн барсаас өөр юү ч үл дайралдах ажгуу.

Торгон хөшигний цаанаас Хятадын дуучны нарийнаар дуулах, хулсан бялар, бишгүүрийн уянгалах сонстов. Хэдэн жигтэй хачин хувцасласан бүжгийн хүмүүс, гөрөөс, талд гэнэн сэрэггүй бэлчиж ахуйд, шилүүс гэтэн очоод, харин өөрөө, нуугдаж байсан анчны сумнаас үхдэг болохыг үлгэрлэн үзүүлэв.

Чингис хаан, хурим найр зүгээр болсонд сэтгэл хангамжтайгаар алтан ширээн дээр завилан сууж тусгай тавагт тавьсан шарсан мах шал шул гэж тамшаан идэж байлаа. Тавгийг түүний өмнө нэгэн хятад зарц сөгдөж барин, Чингис, зочдын дотроос зарим нэгэн өршөөж таалсан хүний аманд махны аль сайнаас хэсгийг авч үмхүүлэв.

Найрын дунд, Чингис хаан, Хулан хатны дэргэд, Тангадын элчин шадарлан сууж, түүнд, хэрхэн цөл талд зам төөрч яваагүйгээ Хятадын нэгэн нарийн гудамжинд төөрч самгардсанаа Хуланд ярьж өгөхөд Хулан ажиггүй инээн байхыг үзээд, дотроо хардах сэтгэл төрж, хонины дал мөлжиж байхын зуур, Тангадын элчийг муухай нүдээр хялайн байж хэлсэн нь,

— Чиний эзэн хаан, Бурхан үүний урьд аян байлдаанд миний баруун гар болсугай гэж ам алдсан билээ. Одоо лал нар миний элчийг зүй бусаар алсан тул, би Хоресмийн шагаас ял асуухаар цэрэг авч мордох гэж байгаа. Иймд чи хаан Бурхандаа миний цэргийн баруун гар болж байлдах цаг болж гэж мэдүүл.

Үзэсгэлэн Хулан хатантай хүүрнэлдэж ухаан заяагүй байсан Тангадын элч, Чингис хааны хэлэхийг сонсоод, тоомсоргүй байдалтай,

— Хэрэв, байлдахад цэрэг чинь үл хүрэлцэх аваас, битгий хаан болтугай гэв.

Чингис хаан мөлжиж байсан хонины далыг нэгэн тийш чулуудаж, тостой гараа цагаан сарьсан гуталдаа арчиж, сахлаа булган дээлийн хормойгоор арчихад, олон цөм дув дуугүй болцгоов. Чингис амьсгаадаж, хоолой нь чичирхийлэн Тангадын элчийг харан байж хэлсэн нь,

— Чи өөрийн эзний нэрийн өмнөөс ярьж байгаа боловч, чи ямар аюулгүй миний хэлсэнд хэрцгийгээр хариулна. Тангадын хаант улсын зүг их хүчирхэг цэргээ авч дайлаар мордох нь бэрхшээлтэй гэж санаж байна уу? Ганцхан надад өөр бодсон газар байгаа тул одоо чиний мэтийн зальхай хорт тагнуулыг үл ниргэнэ. Хэрэв мөнх тэнгэр намайг дайсны сумнаас ивээвэл Хоресм Шагийг бут ниргээд, буцах замдаа чиний үнэнч биш хааныг ял асуун дайлаар ирнэ. Тэр цагт би чиний саяны хэлсэн үгийг дурсан санаж, та нарт хаан байж чадах эсэхээ жич үзүүлнэ! Елюй-Чуцай, чи үтэр морь гаргуулж олго. Энэ Тангадын гөлгийг миний цацраас чирэн гарга.

Тангадын элчин Ашгаанбуу ээрэн хэлэх нь,

— Би ер доромжлох үг хэлсэнгүй билээ гэж байтал, хятад зарц нар ирж, түүний гараас барьж цацраас чирэн гаргав. Чингис хаан хөмсгөө атируулан Хятадын элчин Мин хунг хуруугаар зааж, түүнийг маш бага архи ууж байнам гэж есөн том хундагаар шахаж цээрлэлийг үзүүлсэнд элчин, арга буюу хатамжин ууж байлаа. Энэ үед цугларсан зочид тэрхүү Хятадын элчнийг хүндэтгэж магтаалын дууг дуулцгаав. Зургаадугаар хундагыг уусны дараа Мин хун тэссэнгүй унаж, дороо унтсанд Чингис хаан дахин эелдэг хөгжилтэй болж хэлсэн нь,

— Миний зочин согтууртал уужээ. Бодвол энэ миний нөхөр бөгөөд надтай нэгэн адил сэтгэлтэй байв. Миний нөхрийг та нар аятайхан, сууж байгаа цацарт хүргэн хэвтүүл. Маргааш эх нутагт нь хариулна. Иймд зам тохиолдох хот боомтын дарга нар түүнийг архи цайгаар зочилж, юу хүсвэл бэлтгэн нийлүүлэх хэрэгтэй. Мөн замд сайн хөгжимчдийг дагалдуулан явуулж, бишгүүр хөгжмийг эгшиглүүлэн түүнийг баясуулбал зохино.

Бид чухам манай хятад нөхдийг ямар ч зүйлээр гачигдуулахгүйг хүснэ.

Унтсан зочныг гаргасан хойно Чингис хаан, Елюй-Чуцайн зүг харж асуусан нь:

— Чи миний элчийг алсан Хоресм шаг Мухамедад явуулах бичгийг бичив үү?

Хааны их зөвлөх сайд, сэмээр хариулсан нь:

— Хоёр зоригт жанжин харилцан байлдах гэж байгаа үед би хаанаас олигтой бичиж чадах вэ? Би ганцхан мэдэх нь байлдан дагуулсан орныг засах жолоодох, чиний зарлиг тушаал ёсчлон гүйцэтгэгдэж байгаа эсэхийг хянах мөрдөх нь билээ. Тиймийн тул явуулах бичгийг чинь хашир бичээч уйгур Исмаил-Хожа бичсэн билээ.

— Тэр хаана байна?

Удалгүй, хааны эрдэнийн тамга хадгалагч бөгөөд нарийн бичгийн даргын тушаалтай, нас хөгшин болсон Исмаил Хожа, хаан ширээний дэргэд ирж сөгдөн толгой дээрээ илгэн ороодсыг өргөн баривал,

— Унш гэж Чингис тушаасанд, Исмаил-Хожа ингэж уншсан нь:

— "Мөнх тэнгэр, миний биеийг бүх улс ардын хаан гэж өргөмжлөв. Өнгөрсөн долоон жилийн дотор би гайхамшигт үйлсийг бүтээв. Миний хаант улсын адил улс эрт цагаас байсангүй, надад дагаж ороогүй хаадыг аянга мэт ниргэх тул тэд надаас сүрдэн айдаг билээ. Гэтэл, чи ямар учраас намайг хүндэтгэн үзэхгүй байнам. Сайтар эргэцүүлэн бод! Чи миний хилэнгийн цохилтыг амсахыг хүсэж байна уу?...» гэж уншиж байх зуур, Чингис хаан ширээнээс хөлөө буулгаж, Исмаил-Хожагийн зүг ухасхийн босож, түүний гараас уншиж байсан бичгийг шүүрэн аваад хараан хэлсэн нь:

— Чи хэнд бичиж байгаа нь энэ вэ? Эзэн хаан би тэр нохойн хүүтэй ингэж ярилцах нь зохилдох уу? Дайсантай ингэж ярьдаг юм уу? Чи өөрөө лал тул, ийнхүү лалын хааны өмнө сүүлээ шарвалзуулан бялдуучилж байгаа биз. Чи намайг айж байнам гэж шаг Мухамедад бодогдуулахыг оролдож байгаа биз.

Исмаил-Хожа, нүүрээ хивсэнд шигтгэж чичрэн дагжин хэвтэв. Хаан, түүнээ бүснээс шүүрэн цацраас гаргаж хаяад, хөлөөр өшиглөсөнд, зөвлөх Елюй-Чуцай дэргэд нь ирж хориглон хэлсэн нь:

— Чи бичээчийнхээ буурал сахлыг бод, олон жил зүтгэсэн гавьяаг бод, энэ чиний үр ач нарт бичиг үсэг сургасан биш үү? Үнэнч боолоо ийнхүү хатуугаар шийтгэж үл болно гэсэнд Чингис хаан ер хилэн буурахгүй хэлсэн нь:

— Исмаил-Хожа ёстой боолын бичиг бичсэн байна. Энэ хүн эрэлхэг омогтой үг хэлж чадахгүй тул үүнээс хойш миний үр ачийг бичигт сургавал сургаг, харь улсын эзэнд үүгээр үг залгуулж үл болно гээд эргэж цацарт ороод ширээн дээр гарч цөмцийн суугаад, хоёр гараар баруун өвдгөө тэврэн, удтал зүүн хөлийн өсгий дээр суув. Түүний ногоон нүд нь нэгэн үе нээгдэж, нэгэн үе онийв. Ширээний дэргэд өөр нэгэн бичээч, бичиг бичих цэвэрхэн сийрс барьж, Елюй-Чуцай түүнд хулсан үзэг өгөв. Чингис хаан, нойрмог нүдээ онийлгон нэгэн зүг дув дуугүй ширтэн сууж байснаа сөгдөн суусан бичээчид,

— «Чи байлдахыг хүссэн тул байлдъя» гэж бич гээд гэнэт сэргэсэн мэт, Елюй-Чуцайн гараас хөх будаг түрхсэн алтан тамгаа авч бичигт дарав. Тамга дахь үсгийн үг нь:

Дээр нь тэнгэр бий.
Дэлхийд тэнгэрийн сүр хүчин нь хаан билээ.
Гараг тохиохын эзэн,
Хүн бүхний эзний тамга

гэжээ.

Чив чимээгүй суусан зочдын дунд довтлон орж байгаа Монголчуудын Уухай! Уухай! Уухай! гэж уриалан хашхирах нь сонстов. Эзнийхээ дууг таниад, асрын дэргэд уяатай Чингисийн хайрт азарга янцгааж, агшин зуур цэргийн хүрээний зүг бүрээс монголчуудын морь унгалдан янцгаалдах нь сонстож эхлэв.

Елюй-Чуцай, хоёр гараар бичгийг хичээнгүйлэн авсанд, Чингис огцомхон ширүүн дуугаар,

— Лал нутгийн захад бичгийг нэн даруй хүргэ! Элчийг хамгаалах гурван зуун морьт цэргийг гарга! гэж хэлээд сууж байгаа зочдын зүг харж, эелдэг дуугаар,

— Бид найр хуримаа үргэлжлүүлж тавтай сайхнаар ярилцан сууцгаая. Удалгүй, лалын хотод манай сэтгэл баясна. Бид тэнд цэнгэлдэнэ. Хагалсан тариалангийн газар будаа татаж, морины хөлсөнд хэлмэгдэн цочсон хүн дүрвэн зугтаж, уургалагдсан эмс араатан мэт чарлах болно. Голын ус энэ архины адил ув улаан болж, түймэрдсэн тосгоны галын утаанд тортогдсон огторгуй улайсна гээд богино бүдүүн хуруугаа гозойлгон, цэргийн хүрээнээ азарга унгалдахыг чагнав.

Суугчид хоорондоо «мордох ойртсон бололтой» гэж сэмээр ярилцан суунам бөгөөд, цэргийн ихэс ноёд, ихэмсгээр алтан хундагыг бие биедээ барьж, харилцан бүтэмжтэй явахыг ерөөцгөөж, ирээдүйн их цагийг хүүрнэлдэв.

ТАВДУГААР БҮЛЭГ : ҮЗЭГДЭЭГҮЙ УЛС ЦӨМРӨН ОРЖ ИРЛЭЭ

ЭСЭРГҮҮЦЭХГҮЙ БОЛ ҮХДЭГ

Монголын цөмрөн орж ирснээс хойш дэлхий дахин, этиоп хүний үс шиг ширэлдэн, зангиралдаж, хүн амьтан, чоно шиг болжээ.
(Саади, 13 дугаар зуун)

Өгүүлэх нь: Хоресм шаг Мухамед, Чингис хааны зургаан үгт хатуу бичиг авмагц, шинэ нийслэл Самаркандыг урт нь 12 фарсах[33] буюу 84 километр орчим болохоос үл бэрхшээн, бат хэрмээр хүрээлэн, хэрмийг яаран цогцлон босгохыг тушаажээ. Албан татварчинг зүг бүр явуулж, тэр жилийн татварыг чүү чамай хураасан боловч, бас, ирэх гурван жилийн албан татварыг хураалгаар явуулжээ.

Мөн, нумтан цэргийн баг байгуулахыг тушааж, нумтан, морь зэвсгийн хамт, хэдэн хоногийн хүнс авч, цэрэг татах газар цуглах ёстой байжээ. Чингээд, Сейхун (гэдэг Сердарья) мөрний баруун гарын этгээд дэх бүх айл сууриныг хар хятадтай зах нийлсэн газар хүртэл шатаан үгүй хийж, монгол цэргийн явах газар, орох орон, идэх хүнсгүй болго гэж, тэр нутгийн айл хунарыг цөм хөөн зайлуул гэж тушаасанд, гэр орноо шатаалгасан ардууд хорсож, хар хятадад дагаж ороод эрчүүд нь Монголын цэрэгт оржээ.

Хоресмийн, зүг бүрээс цэрэг эр хуралдан ирж бүхий үед Шаг Самаркандад сууж байв. Заримдаа бялдууч дагалт нараар хүрээлүүлэн, сүмд очиж, исламын Сейх-улийн гоёмсог наманчлал тааллыг сонсохын дээр, сүмийн талбар дээр жагсан зогсож байгаа үй олон үнэн сүсэгт нарын нүдэнд их л сүсэгтэй байдлыг үзүүлэн залбиран, наманчилна. Тэр тэдний хамт өвдөг дээрээ сөхөрч, имамын залбирал уншихыг дагалдан уншдаг байлаа.

Луу (1220) жилийн эхээр Мухамед, цэргийн дээд эрх баригчид, сурвалжит Беги, дээд сайдуул, өвгөн имам лам нарын их зөвлөгөөнийг зарлан хуралдуулав.

Бүгдээрээ, шинэ Искендер «Мухамед жанжин»-ны урамтай, найдвартай зоримог мэргэн шийдвэрийг хүсэн хүлээцгээнэм билээ. Мухамедыг Самаркандын бослого даран, Хивчагийн талыг дайлаар мордож ирснээс хойш, шинэ Искендер гэж дуудацгаах болжээ.

Цугласан бүгдээр хивс дээр шахцалдан сууцгааж, шаг Мухамед, түүний цэргийн дадлага туршлагатай болохыг ба улс орноо аюул гамшгаас эрс хурднаар ангижруулан гэтэлгэж бардаагаар чадна гэж хоорондоо ярилцацгаана.

Төмөр Мелигийн хэлсэн нь:

— Өнөөдөр Падишаг, Самаркандын бэхлэлтийг тойрон үзэж, ажлыг шалган хянав. Нуруугаа бөхийлгөн нүх ухаж байгаа хэдэн мянган боолчууд ба харц ардуудыг удтал харав. Газар хөлдсөн учир, зээтүүгээр хагалахад бэрхтэй байлаа. Үүний урьд Шагийн хилэгнэж «Хэрэв та нар энэ мэт удаан ажиллавал, зэрлэг Татаарууд довтлон ирж, хотын гуу нүхээр ташуурууддаа хаяж дүүргээд гарна» гэхэд нь ажиллаж байсан хүмүүс сонсоод, зүрх нь үхэж «Чингис хааны цэрэг тийм олон юм уу» гэж хоорондоо ярьцгаав гэж хэлжээ.

Чуулах танхимд Хоресм шаг дув дуугай бөгөөд, төв царайтай орж ирээд, алтан ширээн дээр хөлөө ачиж суусан хойно, ерөнхий имам охорхон залбирал уншиж, «Аллах, Хоресмийн цэцэглэн бадрагч орны үнэн сүсэгт нарыг Падишаг таны алдар нэр ба ашиг тусын тул хамгаалан сахих болтугай» гэх үгээр уул залбирлыг дуусгав.

Бүгдээр алгаа өргөж, гарын хуруугаар сахлаа илцгээв. Шаг хэлрүүн:

— Би, та бүхнээс дэмжиг тусламжийг хүсэж байна. Та бүхэн өөрийн ашигтай тустай гэсэн санал бодлогоо бүгдээрээ гарга.

Цугласан хүмүүсийн дундаас хамгийн түрүүнд олон зүйлийн ухааны мэдлэгээр биеэ чимсэн, өндөр настай «төрийн түшээ, шашны түшиг» цолтой шихав Эд Дин Хиваки гэдэг их имам лам бодсоноо илтгэн өгүүлрүүн.

Түүний хэлэх нь:

— Би, энд их сүмийн өндөр суурин дээрээс үргэлж ярьж байсан зүйлээ давтан хэлнэ. Заяагч тэнгэрийн үнэн намтрын дотор айлдсан байдаг нь: «Хэн өөрийн амь, эд хөрөнгөө хамгаалан хамгаалсаар алдвал, гашуун зовлонт бөгөөд, жакид болно» гэжээ. Аллах түүний алдар улам дэлгэрэн батжих болтугай! Иймд одоо бүгдээр орчлонгийн үйл хэргийн будангуйгаас ангижран номготгон дагуулахын зам дээр гарч, эрмэлзэл шунахайрлын отрядыг идэрхэг хав, идэвх хичээнгүйллийн сэлмээр бут цохих хэрэгтэй байнам.

— Бид бүхэн байлдааны талбарт тэргүүнээ тавихад бэлхэн байнам гэж суугчдаас нэгэн зэрэг хашхиралдав.

— Чи ямар арга ухааныг гаргаж байнам? гэж Шаг, Имамаас асуувал, хөгшин Имамын хэлэх нь,

— Чи аугаа их жанжин шинэ Искендер болъюу. Тоолшгүй олон цэргээ Сейхун мөрний хөвөөн дээр аваачиж, тэд буруу номтон Монголчуудыг шийдвэртэй тулалдаанаар угтан тулалцвал зохино. Азийн цөл талыг туулан, алжааж зүдрэхийн туйлыг үзэж ирсэн Монголчуудын цэрэгт түр амрах, сэхэх чөлөө өгөлгүй, өөрийн бие амар цэргээр урьдчилан дайран орж сөнөөвөл зохино.

Мухамед, нүдээ доош буулган нэг хэсэг дуугай байгаад дараачийн хүнийг хэл гэж тушаавал, нэгэн хивчагийн хааны хэлэх нь:

— Миний саналаар бол монголчуудыг тус улсын хязгаарт гүнээ оруулж ирвэл зохино. Учир нь, бид өөрийн газар орны байдлыг сайн мэдэх тул, тэднийг бут цохиход хялбар гэж бодно гэжээ.

Бас Хивчагийн хаад, Самарканд, Бухар нь өндөр бат бэх хэрэм бүхий тул зовох явдалгүй, харин Монголын цэргүүдийг Иранд оруулахгүйн тулд их уст Жейхун (Амударья) мөрний олмыг сайтар бэхлэн хамгаалах хэрэгтэй гэцгээнэ.

Хивчагийн нэгэн хааны хэлэх нь:

— Би эдгээр хөдөх нүүдэлчний байдлыг сайн мэднэ. Тэд зөвхөн газар орноор сэлүүцэн дээрэмдэн гүйцээд удтал энд үл оршино. Учир нь цаг улирлын халуунд дургүйн дээр, морьд нь өвлийн тэсгэм хүйтэнд дасаж зохилджээ. Монголчууд, манай газар орныг эзэмшин сүйтгэвэл сүйтгэж л байг. Бид өөрийн хайрт Падишагаа арчлан хамгаалж, Гиндукуш нуруу ба бүр цааш Казан хүртэл ухаръя. Тэнд шинэ цэрэг элсүүлэн хуралдуулж болно. Хэрэв аргагүй хэрэг тохиолдвол бүр Энэтхэг хүртэл ч зайлж болно. Энэ үест Монголчууд олз омогт ханатал цадаж, уг тал нутагтаа буцацгаах биз ээ. Падишаг, түүний засаг төр зуун хорин жил удирдах болтугай.

Төмөр Мелиг үүнийг сонсоод,

— Чиний хэлж байгаа үг, өчүүхэн сэтгэлт хүний үг гэж Төмөр Мелиг унтууцан дугарсанд Мухамед, хөвүүн Желал-Эд-Динийг харж,

— Чи юү хэлэх вэ?

— Би чиний цэрэг тул гагцхүү тушаалыг хүлээнэ гэжээ.

— Аа Төмөр Мелиг чи?

— Дайрсан бүхэн дийлнэ. Хамгаалсан бүхэн өөрийгөө үмхүүлэхийн салхинаас арчилж чадна. Иймийн учир, дорой номхон эр, баатарлаг зоригтой довтолж, улангассан хүчит барсыг дийлсэн гэдэг

айсан нохой мэт сүүлээ хавчиж, дайсантай нүүр нүүрээр учрахаа халирах тийм амьтан уулын цаана бүгшин нуугдана. Чи надаас асуух юун? Намайг Татаарын түрүүчийн туршуул ангийн зүг илгээхийг эртнээс гуйсаар биш бил үү? Би, тэдэнтэй зууралдан байлдаж, харвах сумын онолт, гэрэлт сэлмийн даацыг сорих хүсэлтэй байнам.

— Тэгтүгэй. Тэгтүгэй. Удалгүй мөс хайлах бөгөөд Монголчууд, уулнаас бууж, Ферганы хөндийд буух бий. Тэнд чи, Монголчуудын толгойгоор сэлмийн хурцыг сорьтугай. Чамайг Хожент хотын цэргийн тэргүүнээр томилсугай.

Бүгдээр нүдээ доош буулган, хурууны үзүүрийг нийлүүлэн сууцгаана. Байлдаанд зориг барагдашгүй, үг хэл нь хурц зоримог, шударга сэтгэлт Төмөр Мелигт Шаг хилэгнэсэн нь илэрхий байлаа. Төмөр Мелиг, Хоресм шагийн гоёмсог үсэнд хичээж бялдуучлалын пялыг сэмээр юүлж байсан удаагүй билээ. Гэтэл, Төмөр Мелигийн үгэнд шоолох байдал бийг үзээд, Мухамед, дахин нэмэн хэлсэн нь:

— Төмөр Мелиг, сая довтолсон бүхэн ямагт дийлнэ гэж баталж байв уу? Цэрэгт сохор зориг хэрэггүй, харин болгоомж хэрэгтэй. Би, нэг ч хотыг хамгаалалгүйгээр орхиж гомдоохгүй. Хонины арьсаар хучсан монгол буюу татаарууд, манай эндэхийн халуунд тэсэлгүй, төдий л удахгүй тонилох биз гэж би бас санаж байна. Энгийн тайван ардын сайн хамгаалал нь манай боомтын эвдэршгүй хэрмүүд мөн бөгөөд... гэтэл бялдууч хаад ам амандаа,

— Чиний хүчирхэг гар! Чиний мэргэн ухаан гэж хашхирцгаана.

— Миний жолоодсон цэрэг нь Татаарын явах зам дээр гуйвшгүй аймшигт хадан халил болно. Бас эр зоригт Иналчиг Кайр хаан, энэ үеэр Монголчуудын цэргийн довтолгоог няцааж дайсанд бүслэгдсэн Отрар хотыг таван сар шахам хамгаалан сахиж чадах уу? Тэр, дайсны довтолгоо дайралтыг ягштал цохин буцааж байгаа нь миний зохих цагт хорин мянган хивчагийг түүнд туслуулаар явуулсны ач болно.

— Кайр хаан ч зоригтой эр юм гэж хаад зэргээр магтан шагширна.

— Татаарын цэргийг манай Исламын цэрэгтэй чацуулбал харанхуй шөнийн дундах ганц зурвас утаатай адил гэж, юм мэдэх итгэлтэй хүн хэлсэн бий. Нэгэнт ийм бол бид юунаас айх билээ. Би Самаркандад зуун хорин мянган цэргийг үлдээнэ. Мөн сайн дурын цэргүүд ба аймшигтай дүрт байлдааны хүчит хорин зааныг үлдээнэ.

Бухарт хорин мянган зоригт эрс бий. Мөн түүнчлэн бусад хотод хорь буюу гучин мянган цэргийг явуулсан бүлгээ. Хэрэв Чингис хааны татар цэргүүд, боомт бүрд хаагдвал тэдгээрээс юу үлдэх ажээ. Шинэ цэрэг ирэхгүй нь лав. Чадал хүч нь зун цагт цас хайлдаг адил барагдана биз ээ.

— Иншалла! Иншалла! (Аллах хайрла!) гэж бүгдээр өндөр дуугаар хашхирцгаав. Шаг бас үргэлжлэн хэлсэн нь:

— Би, энэ үесээр Иранд байж, тэндээс үнэн сүсэгт нарын шинэ цэргийг элсүүлэн авч, тэдний ачийн ач, үүнээс хойш манай Исламын газарт зүглэхээ цээрлэн айх болтол шинэхэн хүчээр Татаарын үлдэгдлийг дуустал хядсугай.

— Иншалла! Иншалла! Ялагдашгүй жанжны цэцэн үг ёстой үнэн байнам гэж хаад амдан бархирцгаана.

Гэтэл, Шагийн дэргэд, Дивен - мэргэн (Шагийн бичиг хэргийн газар)-ний тэргүүлэгч ирж түүнд хуудас бичгийг өргөсөнд авч үзвэл, уул мэдээг нэгэн ядуу Дервиш Монголчуудын постыг арай чуу гэж нэвтрэн явж авчирсан бөгөөд, мэдээний дотор Шагаас Отрар хотноо туслуулаар илгээсэн хорин мянган хивчагууд урваж, Монголчуудын талд орсон гэжээ.

Шагийн дэргэд сууцгааж байсан олон, муу буюу сайн мэдээ ирсэн эссэнийг Шагийн царайгаар тааварлахыг оролдож, түүний өөдөөс эмээн үзэцгээнэ. Шаг хөмсгөө өргөж амандаа шивгэнэн хэлрүүн:

— Алгуурлаж болохгүй боллоо гэж хэлээд төдий босож имамын залбирал уншихыг сонсож, ордны амрах тасагт зайлан одов.

КУРБАН КИЧИК, ЦЭРЭГ ЭР БОЛОВ

— Хүүе! Курбан Кичик! Хүүе, Алячаа, чи үүнээс хойш газар сэндийчихээ больсон шүү. Хоресм Шаг чамайг өөрийн баатарлаг цэргийн тэргүүн даргаар томилон тохоосон гэж нэгэн цэргийн эр мориноос буулгүй, ташуурын бариулаар Курбаны суух овоохойн намхан тахир үүдийг балбахад үүнийг Курбаны эх бөгтөр нуруутай хатангир биетэй эмгэн сонсоод, амандаа «бас ямар шинэ гай хүрээд ирэв» гэж үглэж, ногооныхоо хашаанаас майжганасаар гарч ирсэнд тэрхүү цэрэг эр зандран өгүүлрүүн:

— Курбаныг хурдан гаргаж өг. Юунд өдөр унтаж байгаа юм. Бас буза[34] уусан биз...

— Буза бодох зав чөлөө хаанаас гарах вэ? Курбан, бүхэл шөнөдөө татаал дээр манаа манаад, бас ногооны газраа услав. Сая ганцаараа дөрвөн хүнтэй жанчилдаж хөх булуу болтлоо зодолдоод ёолон хэвтэж байна. Тэр дөрвөн хүн өөрийн тариалангийн газарт бусдаас урьтаж ус татах гэсэн тул тийнхүү зодолдсон гэнэ гэж хэлээд эмгэн овоохойдоо орсонд тэндээс Курбан гарч ирэв. Үс гэзэг нь сэгсийсэн бөгөөд нүдээ арчиж, бор морь унасан гоёмсог гавшгай хүнийг айсан байдалтай харна.

— Баатар эрийн амрыг эрье. Хязгаарын даргад бараалхах юм уу?

— Хоресм шаг чамайг морь, сэлэм, жадтайгаа ирж, урьд үзэгдээгүй яжуж мажуштай байлдахыг шаардаж байнам.

Урт хүзүү, сэрвээгээр бөгтөр Курбан, таван хуруугаар ууцаа маажин байж хэлрүүн;

— Баатар эр, надаар дооглохоо зогс. Би яаж цэрэг болж чаддаг юм бэ? Гартаа сэрээ халбага хоёроос өөр юм барьж чаддаг ч үгүй.

— Үүнийг чи бид хоёр шиг нь шүүмжлэх хэрэг биш. Намайг Хаким явуулж, түүний тушаалыг бүх тосгоны даргад зарлахыг тушаасан. Энэхүү тушаалыг яаравчлан гүйцэтгэх нь чухал тул морьтой нь морио унаж, тэмээтэй нь тэмээгээ унаж, заасан газар очих хэрэгтэй байна. Чи маргааш өөрийн беги ноёндоо очсугай. Танай ноён, чиний мэт байлдаанд гавшгай эрчүүдийг дагуулан байлдаанд мордуулна. Тушаалыг зөрчиж, эс очдог хүний толгойг авна. Мэдэв үү?

— Түр хүлээ баатар эр. Яжуж Мажуж гэсний учрыг хэлж өгнө үү гэж Курбан гуйсанд тэрхүү цэргийн эр бор морио гуядаж огт хайхарсангүй давхин одов. Ганцхан тоос нь замын дээгүүр үүл мэт тунаран аажмаар тариалангийн газрыг бүрхэн бүтээж байлаа.

— Курбан, миний хүү, тэдгээр ноёд бас ямар шинэ зүйл гаргаж чамаас юу аль гэж байна гэж эмгэн босгоны дэргэд сууж хүүгээс асуухад,

— Лав галзуурсан байх, зээрд гүү минь үхсэн болоосой. Тэгсэн бол Хаким намайг дуудахгүй сэн гэж Курбан зээрд гүүний дэргэд очив. Курбаны бяцхан хөвүүн өвдгөө хүртэл шуусан өмдтэй, нүцгэн шахуу, ногтноос барьжээ.

Зэргэлдээ тариалангийн газар ажил хийж байгаа хүмүүс гүйн ирцгээж,

— Хүүе Курбан Кичик юу болов? гэж хашхиран асуусанд Курбан юу ч хэлсэнгүй. Хамаг бие нь зодуулснаас шархиран өвдөнө. Гүүгээ гараар илж, шингэн дэлийг нь засаж, хэрдийсэн хавиргатай эцэнхий нурууг нь шувтран байхад,

— Бидэнд бүү уурла, Курбан, ноход ч болов яс булаацалдаж хэрэлдээд сүүлд нь зэрэгцэн хэвтэцгээж наранд ээдэг шүү. Чи өөрөө мэднэ шүү дээ. Хар усны төлөө сайхан байсан ах дүү араатан мэт болох гэж байх уу? Хязгаарын даргаас тэр Жигит ямар хэрэгтэй ирсэн бэ?

— Дайн... гэж Курбаны дутуу хагас хэлбэл,

— Юун дайн? гэж дөрвүүл нэгэн зэрэг дуугарч, дув дуугай болоод сүүлд нэг нь сая сэхээ орж,

— Ямар дайн байх билээ. Хоресм шаг бол дэлхий дахины хамгийн хүчирхэг эзэн бөгөөд, түүний сүүдэр орчлонг бүрхэн бүтээж байгаа тул хэн түүнтэй зүрхлэн байлдах вэ?

— Тэд биднээс юү хүсэж байна? Бид цэрэг биш шүү дээ. Бид тариа таривч, беги ноён хамгийг нь эзэрхийлэн авдаг биш үү. Одоо дахин биднийг бүү зовоогоосой.

— Жигит юү хэлж байна?

— Түүний хэлэх нь бүгдээр манай газар орныг хамгаалж байлдаанд явах хэрэгтэй. Морьтой нэг нь морио унаж, тэмээтэй нэг нь тэмээгээ унаж, беги ноёнд очиж бараалхах хэрэгтэй юм гэнэ.

— Тийм юм бол би ч эхнэр хүүхдээ авч ууланд, эсхүл намагтай газар зугтан явъя. Надад хамгаалах юу байх вэ? Энэ газрыг уу? Энэ газар беги ноёны болохоос биш, ямар биднийх биш, иймд беги ноёд Жигиттэйгээ газар усаа хамгаалан байлдаг цаашаа.

Хоресм шаг, хивчагаас хөлсөлж авсан хөлсний цэрэгтэй. Сая болтол тэд бидний тариачинтай голдуу байлдаж зовоож байсны харгайгаар бид гэр орон ч үгүй болоод байна.

— Мэдэж ядах юу байх вэ. Юмаар гачигдаж дутагдаад, бидэн дээр ирж байгаа юм.

— Хараач бас нэг аюул нэмэгдэв.

Бүгдээр тэргүүнийг заасан зүг эргүүлэн харвал замаар хэдэн морьтой хүн тоос хадаан давхилдан айсуй. Тэдний ард өндөр дугуйтай дөрвөн тэрэг түрчигнэн явна. Тэдгээр морьтой хүн Курбаны гэрийн дэргэд зогсов. Тэрэгнээс урт цагаан мод барьсан хэдэн зарлага харайн бууцгаасан хойно нэгэн морьтой хүн Курбан нарын зүг харж, нааш ир

гэвэл Курбан бусад нөхдийн хамт ирж, нуруугаа бөхийлгөн, гараа гэдсэндээ солбиж зогсон байлаа. Тэр хүний хэлэх нь,

— Та нар намайг мэдэх ёстой. Би эндэхийн хашив тушаалтай албан татвар цуглуулагч мөн. Ерөнхий нярав Мустафа бидний хашив нарт тушаал илгээсэн нь, манай эх нутаг дайн байлдааны аюулд тохиолджээ. Учир нь буруу номт Татаарууд, манай зүг довтлон айсуй. Хэрэв тэд манай нутгийн дотор цөмрөн орвол хөгшид настан, хөвөө нялхыг ялгалгүй цөмийг огтчин алахын дээр, адгуус мал талх тариаг юүртэл уулгалан дээрэмдэж авах тул бид эцэстээ шалдан үлдэцгээх болно.

— Бид ч хэзээний нүцгэн шүү гэж Курбаны хөгшин эх хэлбэл, хашив цааш үргэлжлэн хэлсэн нь;

— Дайсан ирвэл бид толгойгүй болно шүү. Таван зуун мянган цэргийг тэжээж бүрэн зэвсэгтэй болгоход их мөнгө, их тариа будаа орох тул тийнхүү Шаг та нараас алба татвар татах хэрэгтэй гэж бидэнд тушаасан билээ.

— Бид тун сая алба татварыг барьсан шүү.

— Та нар үүний урьд энэ жилийн албыг барьсан бол одоо эсэргэн жилийн албыг барих хэрэгтэй. Гагцхүү түргэвчлэх нь чухал. Одоо эхэлье. Энэ хэний гэр вэ?

— Их дарга аа! Энэ миний гэр, надад юу ч байхгүй. Би албан татвар барих юм огтгүй, ганц эм тахиа байвч, өндөглөдөггүй юм.

— Чамайг мэдэхгүй биш, та нар ямагт ингэж ярьдаг. Хүүхэд ээ! Гэр орон ба ялангуяа саравчийг нь сайн нэгжин үзээрэй.

Дөрвөн цэргийн эр үүгээр түүгээр хэсэн явж, саравч ногооны хашаа зэргийг нарийвчлан үзээд юү ч олсонгүй эгж ирэв. Нэг нь өнөөх эм тахиаг авч ирэв.

Би чамд хоёр өдрийн хугацаа өгсүгэй. Өнөөдөр чамайг таван мод жанчина. Хэрэв шуудай будааг тогтоосон хугацаанаа эс олж баривал өдөр бүр жанчина. Түүгээр үл барам, чиний энэ тариалж байгаа газрыг баатарлаг цэрэгт туслахаас үл зугтагч өөр нэгэн хичээлтэй тариачинд шилжүүлнэ.

Курбан Кичик газар унаж,

— Шаг тан, юу айлдвал, би түүнийг гүйцэтгэхийг хичээнэ... Би муу гүүгээ унаж, яжуж мажуж нартай байлдахаар явлаа. Би зам гүүр засах сэлбэх зэргээр ажил хийе. Гагцхүү гуйх нь, намайг битгий үр хүүхдийн минь дэргэд зодож жанч. Талх тариа байхгүй цагт гарга гэж

битгий тулган шаардах ажаамуу. Надад хорхой мэт дөрвөн нялх хүүхэд, ганц, настай эх бий. Эднийг тэжээх гэвч хэрхэн тэжээхээ мэдэхгүй байна. Их хашив та өршөө! Өршөө! гэж албан татвар цуглуулахаар явж байгаа хүний морины хөлийг тэврэн гуйж байхын завсар өөрийн хэлсэн зүрхтэй үгэндээ гайхаж, нөгөөтээгүүр өөрийн биеийг хорхой мэт доод өчүүхэн ба зээрд гүүгээ өлсгөлөн нохой мэт зол заяагүй амьтан гэж дотроо сэтгэсэн билээ.

— Курбан Кичик, би чамайг үзвэл, үнэхээр бачтай амьтан аж. Дээд Аллах, хүний орчлонг бүтээгсэд, хүнийг хамгийн түрүүнд Шаг, тэгээд беги ноёд, тэгээд худалдаачид, хамгийн сүүлд тариачид гэж хэдэн зэрэг болсон насад тогтоосон тул Шаг бол зарлиг буулгах, тушаах эрхтэй ба бусад нь түүнд захирагдаж байх ёстой болой. Иймийн тул боол тариачид юу хийх вэ? гэвэл Шаг беги нарыг үйлчлэн зүтгэж, тэдний юү даалгавал тухай бүрд гүйцэлдүүлж, талх тариагаа өргөдөг юм. Үүний ёсоор чи ч шуудай будаа бэлтгэх хэрэгтэй шүү. За, өнөөдөр зодохыг хэлтрүүлье. Харин маргааш арьсыг нь өвчинө гэж хашин морио ороолгож, цааш өөр айлд очихоор явлаа.

* * *

Албан татвар хураагчдын буцаж, тэдний морины хөлөөр боссон тоос намдсан хойно, гиюүрэн зовсон хүмүүс, гэр гэртээ харьцгаалаа. Курбан Кичин ч мордохоо төхөөрөв.

Сүмд очиж, молда ламтай учраад, их замын дэргэд дэлгүүр нээсэн худалдаачныд очив. Замаар өнгөрөгчдийн ярилцахыг сонсвол, энд тэндгүй дайн байлдаан босож, ямархан нэгэн урьд үзэгдээгүй аюул ирэх чимээ бий гэх тул Беги ноёд маань, үнэн хэлжээ гэж дотроо үнэмшив. Бас бодвол тэдгээр аюулт хүмүүс зүүн зүгээс ирж байгаа гэх тул лав энэ нүүдэлчин, Киргис, Хар хятад буюу Уйгар, Татар зэргийн аймаг биз ээ гэж санав.

Олны ярилцацгаах нь энэ үндэстний цэргүүд, бие богино намхан, сэлэм жаданд автагддаггүй айхтар амьтан юм гэнэ. Гагцхүү тэднээс амь хамгаалахад хотуудын өндөр бат хэрмийн ард бэхлэн суух буюу эсхүл намаг газар дүрвэн очихоос өөр аргагүй гэцгээнэ.

Курбан, их л бодлого бодсоор гэртээ ирэв. Сүрлийн жугарын шилбийг жижигхэн хэрчиж гүүндээ өгөөд, зэв идсэн хадуурын хэлтэрхийг олж, сургааг модонд бэхлэн уяж, жад болгов. Бас төмрийн дарханд очиж ажлаас туслалцан элбэлцэж, есөн зэс зоосны олз олоод,

түүгээрээ дэлгүүрээс алгын чинээ хонины мах худалдан авлаа. Ганц ч Курбан биш, Шагийн зарлигаар мордох хүмүүс замын хүнсээ бэлтгэхийн тул тэрхүү дархныд очиж ажлаас туслалцан байж, хэдэн зоосны хөлс олно.

Тэр орой Курбаны эхнэр нь ирлээ. Газрын эзэн беги ноёны тарианы талбар дээр өдөр туж ажил хийгээд ирж байгаа нь энэ байжээ. Ажлаас ирээд амарсан ч үгүй даруй гал тогоотой уулзаж, будаа агшааж хонины өөхтэй бин хийсэн хойно гэртхэн нь шавар хувинг тойрон сууж дув дуугай хоолоо идэхэд, Курбан өрхийн тэргүүний ихэмсэг байдлыг үзүүлэн, гэрийн хүмүүсийг үл мэдэгчнээр харвал ажил хөдөлмөр их үйлдсэнээс ууц нуруу нь уртай бөгтөр болсон, буурал толгойтой эмгэн эх нь сууж байна. Курбан эхийн залуу байх цагийг санав. Үзэсгэлэн хүрэн улаан царайтай, гэрэлтэй хар нүдтэй, зэвүүн хөөрхөн инээдэг байсныг нь санав. Одоо гал шиг нарны доор усаар дүүрсэн тариалангийн газар, насны ихийг насалтал ажиллаж, модны хүнд гишүү мөчрийг дамжуурлан зөөх зэргээр эцэж зүдэртэл ажилласны уршгаар ууц нурууг нь бөгтөр болж, мөр нь шувтайн буужээ.

Эхнэрээ үзвэл, эелдэг булбарай царайд тод гэгч нь атираа үрчлээ зурайн гарчээ. Өдрийг өнжин нэхэх суурины дэргэд шал дээр сууж, их бөс нэхэх гэж шамдан ажиллана. Одоо гар нь хатуу ширүүн бөгөөд, хөгшин эмгэний хуруу мэт сарвайсан мойног тахир болжээ.

Дөрвөн хүүхэд нь зэрэгцэн сууж, бантангаас илүүхэн идэх гэж бие биеэсээ өрсөлдөн тэмүүлэхэд эх нь тус бүрд бяцхан хэсэг мах хувааж өгнө. Ахмад хүү Гассан 11 настай. Эцгээ дагаж гайхамшигтай сайхан гэж алдаршсан Бухар хотыг үзэхээс гадна эцгийгээ агсам морин дээр нарийн шаламгай жад, сэлэм дүгрэг гялгар бамбай хэрэглэн байлдахыг үзэх юм сан гэж түүнээс шалан гуйна. Үүний дараах охин нь алчуурын сэжүүрээр нүүрээ бүтээж, их л ичсэн байдалтай сууна. Бүр хоёр нялх нь зэрэгцэн сууж, бантангаас атган авч хагасыг нь амандаа хийж, хагас хувиар хацар амандаа түрхэн сууна. Ийм амьдралыг хэрхэх ч билээ.

Курбан эхнэртээ өөрийгөө явсан хойно хэрхэн айлаа авч явах ба тариаланд хэдийд ус оруулах, хадах хураахад айл хөршөөс туслалцахыг хэрхэн гуйх, тэднийг өдөр хэрхэн зочлох зэргийг зааж сурган, тэр шөнөдөө бараг унтсангүй.

— Хэрэв, Яжуж энд хүрч ирвэл бид хаашаа зугтах вэ? Бид чамтай яаж уулздаг билээ.

Курбан эхнэрийн сэтгэлийг тайвшруулж хэлсэн нь, Исламын зүрх болсон Бухарт тэдгээр муусайн дайсан яаж ирж чаддаг юм бэ? Хоресм шаг өөрийн биеэр их цэрэг элсүүлэн авч, Хивчагийн нутагт дайсныг угтан очиж хөнөөх тул би нэг сайн морьтой болоод ирэхийн дээр, гэр орондоо бэлэг болгохоор байлдаанд явж олсон элдэв олзоо нэг моринд ачиж авчирна гэжээ.

Маргааш өглөө Курбан босож, ойрх жалганд очиж, муу гүүн дээрээ дааж ядтал гишүү мөчир ачиж ирсэн нь дөрвөн хөл нь дөнгөж үзэгдэнэ. Курбан гишүүг хагачиж хашааны дэргэд хураагаад, дотор талыг нь шавардаж сүрэл зэргийг дэвсэн нүхэн дотор нөөж хадгалсан их биш тарианы үр будааны тухай хэнд ч үг алдаж болохгүй гэхийг гэргий нартаа үхэн хаттал захисан бөгөөд түүнийг эгж иртэл бардаагаар хүрэлцэнэ гэж санана.

— Чи тийм хол газар яаж явдаг билээ. Замдаа идэх хүнс, зарах мөнгө зоосгүй яаж болох вэ? Замдаа харангадан унаж, гуу жалганд морьтойгоо унаж үхнэ. Зүгээр тэр жугараас авч яв гэж ижий эхнэр хоёр нь зэрэг зэрэг гуйсан боловч, Курбан хэрэгсэлгүй хэлсэн нь;

— Та нар бүү зов. Эр хүний хоол замд бий гээд явав.

БАЙЛДААН ЭХЛЭВ

Түүнээс Курбан Кичик өнөө үйлдсэн муу жадаа авч гэрээс мордов. Замдаа Беги ноёны өргөөнд очиж чухам хааш очихоо лавлах гэж очтол, гэрийн даамал нь, Инанч-хаан беги ноёнтны морьт цэргийг авч мордон явсан атал, чи хожимдов. Бушуу Бухарт очих их зам дээр гүйцэн очих хэрэгтэй гэж түүнийг хараан загнав.

Зөрөг замаар морьтой явган хүмүүс ба настай хөгшид, нялх нярай хүүхдийг тээсэн хоёр дугуйтай тэрэг тасралтгүй цуван явах нь үзэгдэнэ.

Өвгөд эмгэд, орилон чарлан уйлан явна. Ачаатай тэргэд зарим нь бут руу, зарим нь бүүр өмнөх уул өөд явж байгаа ажээ.

Хаврын эхээр билээ. Тал хээрт нялх хэнз ногоо гарч, нар хүчтэй шаран халаана. Зам харгуй эвдрэн хатаж, ийш тийш дүрвэн явж байгаа хүмүүсийн хөлөөр тоос шороо үүл мэт манарна. Суурины дэргэд хэдэн төмрийн дархан алхаар юм дархалж, хэдэн зэвсэгтэй хүмүүс морио

тахлуулах ба сумны зэв, жадны үзүүр, сайн давтсан төмөр сэлэм зэргийг олж авах гэж бие биеэс өрсөлдөн бархиралдана.

Маргааш орой нь Бухар хотын түүргийн шавар хашаа үзэгдэж бүхий үед замдаа хар илжигт ачаа ачиж хөтөлсөн хар нүдтэй, сахалтай дервиштэй танилцав. Түүний дэргэдээс арван гурван насны орчим нэгэн хүүхэд салалгүй дагалдан явна. Тэрхүү Дервиш амандаа дуу дуулж, буруу номтныг дайлаар мордож байгаа баатарчуудын дайснаа дарахыг ерөөн явна. Хэдэн цэргийн хүмүүс, Дервишийн барьсан аяганд атга будаа, боорцог зэргийг хийж өглөө.

Шөнө болж, хотын эргэн тойрон хэдэн мянган түүдэг гал нодож байгаа нь гялалзан үзэгдэв. Курбан, Дервишийн хойноос даган явсаар нэгэн намхан байшингийн дэргэд ирвэл түүний дотроос «хөө-хөө-хөө-хөө» гэж уянгалж бархирах сонстоно.

Тэр бол Дервиш нарын «Ханаки» гэдэг нийтийн баяр байжээ. Хашааны дотор маш олон хүн цугларч, өвчин зовлонгоос анаах гэтэлгэх ба одоо болох гэж байгаа дайн байлдааны аюулаас аврахыг гуйцгаана. Дервиш нар эдгээрийг адислах, тарнидах ба бичигтэй сахиус зэргийг зүүлгэнэ.

Курбан, хашааны дэргэд морио уяж, түүдэг галыг тойрон явж, газар гишгэгдсэн сүрлийг өөрийн гүү ба Дервишийн илжгэнд өгөхөөр цуглуулав. Дервиш түүнд бин өгч, төмөр тогоонд чанасан бантан өгөлцөв. Курбан, «эр хүний замд хоол бий» гэдэг нь үнэн ажээ гэж сэтгэв.

Курбан, морины цулбуурыг гартаа ороон барьж үүр цайлгав. Унтахгүйг хичээж сонсвол түүдэг галын дэргэд хүмүүсийн ярилцах нь ямар муу доголон хазгар морийг ч их үнээр худалдан авч бий бөгөөд учир нь хүн бүхэн Бухараас зайлж, Персийн уулс буюу Энэтхэг зэрэг газар очиж, үзэгдээгүй буруу номтноос холдохыг хичээцгээж бий гэхийг сонсоод Курбан, өглөөгүүр Курбаны үхширтэл унтсан нь түүний зээрд гүүний жолоог нь огтлон хулуун авч явахыг мэдсэнгүй:

— Ариун байлдаанд мордож байгаа цэргийн морийг хулгайлсан ичгүүргүй хулгайчийг Аллах тэнгэр гэсгээнэ гэж ярилцдаг билээ. Өнгөрсөн шөнө ядуу Хажи-Рахим миний муу илжгийг бас аваад явчихжээ. Гагцхүү сайн язгуурт Бухар хотыг үзэхэд унаа морь гэх төвөгшөөлгүйгээр тавтай сайхан үзнэ ээ гэж сэтгэлээ хуурахаас өөргүй боллоо гэж Дервиш хэлжээ.

Курбан, арга буюу урт жадаа мөрөн дээрээ тавьж Дервиш ба залуу хөвүүн нартай ханилж, «эрдэм соёлын огторгуй дахь гэрэлт од», «сайн язгуурт Бухар»-ыг сонирхон үзэхээр явлаа.

Тэндээс гурван хүн, «найрамдлынхаа бүснээс барилцаж» Бухар хотын зүг цувсан хүн амьтны дундуур гэлдрэн явцгаав.

Дээр цагт барьсан өндөр хэрэм, өргөст өвс, луульд бүрхэгдэж, энд тэндээс өмөрч эмтэрч нуржээ. Арван нэгэн хаалганы дундуур, худалдаачдын жин цувж, Ислам орны түшиг болсон энэхүү их балгасыг дэлхий дахины өнцөг бүртэй холбожээ.

Нэгдүгээр хаалганы дэргэд олон улс бужигналдан байна.

Хаалганы манаа, өнгөрөн гарагчдыг зогсоон байцаж, дараа нь уриалан дуудах нь:

— Хотыг бэхлэх ба цэрэг тэжээх, зэр зэвсэг бэлтгэхэд эд мөнгө эрэх, тусал, гараа бүү харамчаар атга, агуу өглөгч сэтгэл чинь пид дүүрэн түрийвчийг чинь дэлгэх болтугай гэцгээнэ.

— Хөгшин эрдэмтэн нар, хүүдий сав барьж, олны цугларсан газраар явж, эх нутгаа хамгаалах ариун үйлд санаа харамгүй баясалцан туслалцахыг шаардан гуйна.

Хотын хаалганы цаана худалдааны газрууд зэрэглэн оршжээ. Бяцхан дэлгүүр цоорхой, элдэв янзын бараа таваар өрөн дэлгэж, шаваараалдан нэгэн дор орших бөгөөд худалдаачид, аян замд авч явахад бөх бөгөөд хямдхан сайн эсгий буюу удаан цагт үл муудах бал чихрээр үйлдсэн идэш хүнсний зүйлийн зэрэг ер одоогийн дайн байлдаантай цагт хэрэгтэй зүйлсийг өндөр дуугаар дуудан худалдана.

Энд тэндгүй хотын цаанаас өмөг түшиг, унд хоолыг эрж ирсэн эр эм хүмүүс, нялх нярай үр хүүхэдтэйгээ гайхшаа барагдан бөөгнөрөн байна.

Хоёрдугаар хэрмийн их хаалгыг өнгөрөв. Энэ нь Шахаристан гэдэг хотыг тусгаарласан хаалга болно. Тэндээс манай гурван хүн шуугиантай хөлтэй гудамжийг тойрч өндөр хаалгаар хүрээлэгдсэн лалын ёсны мецет гэдэг сүм ба медресе гэдэг мусульман нарын шашны дээд сургуулийн байгаа талбай дээр хүрч ирэв. Чив чимээгүй байнам. Энэхүү медресе гэдэг сургуульд арван хэлний бурхны сургаалын гүн нарийныг ухаж, мецет сүмийн имам болох гэж хамгаас хагацаж, олон жилээр удтал шамдан оролдож байгаа хэдэн мянган хөгшин залуу оюутан нар суралцдаг байнам.

Тэр өдөр, талбар дээр их ёслолт мөргөл болж байгаа нь эгнэн мөргөж байгаа хүмүүс нь ариун номын мөр мэт тэв тэгшхэн бөгөөд буурал сахалт ихэмсэг имамын хөдлөх аашлахыг дуурайн үйлдэнэ.

Тэрхүү имам лам сөгдөж, газарт тонгойх буюу гараа чихэнд хүргэхэд хэдэн мянган үнэн сүсэгт хүн имамын хөдөлгөөнийг алдалгүй давтан үйлдэнэ. Нэгэнт унаж, нэгэнт босож мөргөл үйлдэн байгаа тоолшгүй олон хүмүүсийн чимээ нь чулуу дэвссэн талбарын дээгүүр салхин шургаж байгаа мэт сонстоно.

Мөргөл дууссаны дараа мецет сүмийн өндөр гишгүүрийн өмнө алтан цэцэг хатгамаллан оёсон гал улаан өнгөтэй, хилэн нөмрөгтэй улаан сүүлтэй хээр морийг хэдэн хүн хөтөлж авчруулна.

Сүмээс өтгөн хар сахалтай, өндөр биетэй Хоресм шаг гарч ирэв. Тэргүүнд алмаас чулуу мэт гялалзах утсаар нэхсэн сүүл цагаан тюрбан малгай өмсжээ. Шаг, цугларсан олны зүг харж хэлсэн үг нь:

— Исламын олон улс цөм нэгэн улс гэр. Манай чухал эрхэм хамгаалал нь билүүдсэн сэлэм билээ. Их богд үнэн шашинт нарыг хэлэхдээ «би, ертөнцийн бүтээлийн эрхэм, исламын цэрэг татаарыг заяаж, чухам тэнгэр дэлхий дээрх хамаг юмны эзэнд лал та нарыг тоосон» гэжээ. Иймд үнэн шашинт бид, орчлонгийн эзэн байх ёстой тул та нар бүү айгтун. Ариун ном бас биднийг сургах нь: «Аллах өөрийн өршөөлийг түүний зарлигийг дагагсдад хайрлана» гэжээ. Иймийн тул бид, үл айхын мэсээр дайсныг цочоохын тулд хамаг хичээлээ гаргавал зохино... зөн бэлгэтийн айлдсан үгийн төлөө хамаг сэтгэлээ өгсөн, үнэн сүсэгт нарын хилэнг ямар юм зогсоож хориглож чадах билээ. Дайсныг үзсэн цагт алж, үлдэн зайлуул. Буруу номтныг гэсгээхэд Аллах туслан ивээх болтугай...

— Буруу номтныг алцгаа. Харийн дайсныг зайлуул гэж олноор хашхирцгаана.

Хоресм шаг зээрд мориндоо мордож, бас хэдэн үг хэлсэн нь:

— Манай зорилго бол та нарт сайн сургамжийг өгөх гэсэн бөгөөд бид нэгэнт та нарт сургамжийг хэлсэн тул одоо Самаркандаас мордож, Тэнгэр уулын цаст даваанаас буун ирж ахуй дайсныг угтан байлдаар... дайсан гашуун төгсгөлийг үзнэ биз ээ. Тэд, манай өгүүлшгүй баатарлаг цэргийн аймшигт эгнээтэй тохиолдож түдэлгүй мөхнө... Та нарыг Аллах ивээнэ гэж хэлээд, даруй хөдлөн явахад цугларсан олон хүмүүс, Шаг ба түүний бие хамгаалагчид, гоёмсог хувцастай хивчагуудад зам тавьж өгч, хойноос нь,

— Цэрэг Мухамед мандтугай. Буруу номтныг ялагч Хоресм шаг мандтугай. Чи бол манай ганцхан түшиг тулгуур мөн гэж хашхирцгаана.

ЦЭРЭГ ЭРИЙГ ТҮҮНИЙ ИЛДИЙН ИР НЬ ХАМГААЛДАГ

Өгүүлэх нь: Хоресм шаг Мухамед Бухараас мордон гарч явж атал, гэнэт морио залж, Самаркандад очих замд биш өмнө зүг Калифид хүрэх замаар чиглэн явлаа. Шаг нүүрээ торгон алчууураар бүтээж, юуг ч үл өгүүлэн, заримдаа хатируулан, заримдаа морины хар хурдаар давхиулан явахад бараа бологчид хоцролгүй хойноос нь дагалдан явцгаана. Замд тохиолдогсод замаас зайлан гарч, татаал шуудуунд орж, нүүрээ доош хандуулан аюулт эблист хөөгдөж байгаа мэт довтолж яваа хэдэн мянган морьтныг гайхан үзэцгээнэ. Их визир сайд Падишагийн хөвүүн Желал-Эд-Динд эзэн зам эндүүрэв бололтой гэж элдэвчлэн хэлсэн боловч талаар болов.

Желал-Эд-Дин түүнд хариу хэлсэн нь:

— Надад ямар хамаа байх вэ? Падишаг эцэг хэдий галт тамын аманд оровч би дагалдан орно гэжээ.

Тэндээс Хоресм шаг довтлон явах зуур хөлс нь цутгасан зээрд морио зогсоож, өндөр нарийхан улиас модод ургасан хазайсан цамхагтай хэрмийг ташууураар зааж,

— Хэний хүрээ вэ гэж асуухад,

— Энэ Төмөр Мелиг хааны авын хүрээ. Хуучны цэцэрлэг, ховор чихтэй зэрлэг адгуус гөрөөс их л бий гэж алдаршжээ.

— Би үзэхийг хүсэж байна. Зоригт Төмөр Мелиг хааш очсон бэ? Юунд над үл харагдана.

— Төмөр Мелиг, тэр өдөр Хожентийн гарнизоныг толгойлох зарлигийг хүлээн авмагц тийшээ давхин одсон билээ.

— Би түүнийг яаруулаагүй атал, тийнхүү явсан нь юутай зөрүүд билээ. Тэр байхгүй нь уйтгартай байна.

Шагийг хамгаалах зуут, Шагийн буух газар хүлээж авахаар урьдчилан давхин одов. Мухамед агсамнан хөөрсөн морины амыг татаж, аажмаар алхуулсаар авын хүрээний зүг ирэв.

Нүсэр хаалгыг нээв. Зарц нар хүрээний дотор түлхүүр хангинуулан нааш цааш гүйж, орд руу хандсан үүдийг нээлээ. Боолчууд шуудайтай арвай, тэвэр хуурай өвсийг зөөн авчирна. Жигит

өөр суурин тосгонд довтлон очиж, гайгүй сайн шилдэг хоньдыг эмээл дээрээ бөгтрөн ирнэ.

Аяны тогоочид гал утаа баагиулж хоол унд бэлтгэн эхлэв. Шаг, цэцэглэгийн хашаануудын дэргэдэх хөнгөн сэхээвчид түшүүлэн тавьсан шатаар авирч гарахад түүний араас хөвүүн нь Желал-Эд-Диний хүрээний сахигч өвгөн дагалдан гарав.

— Сэхээвчийн дотор навчис нь хөвж унаж, нүцгэрсэн цэцэрлэг харагдав. Хэдэн зэрлэг ямаа, тогтмол усны дэргэд наранд биеэ шарж хэвтэцгээх бөгөөд, дэргэд нь урт эвэртэй уулын ямаа, нэлээд болгоомжтой зогсон байнам.

Цэцэрлэгийн гүнд, хоёр үүлтрийн зэрлэг гахай зулзагын хамт, мөн торын дотор саявтар уулнаас авчирсан хоёр маш догшин ирвэс бий. Миний зоригт эзэн Төмөр Мелиг, энэ сэхээвчид сууж, ирвэсийн, зэрлэг гахай, ямааг хөөн барихыг бахархан үздэг. Заримдаа өөрөө бууж, гөрөөсний чухам хаана нь онохыг урьдаас хэлж, алдалгүй харвадаг билээ гэж хүрээг эрхлэн мэдэгчийн хэлэхэд Шаг,

— Яв гэж, янзгүйгээр өгүүлэн хөвүүнтэйгээ үлдэж сэмээр хэлсэн нь

— Элч дөрвөн зүгээс мэдээ хүргэн ирсэн. Би их л цочин айв. Хар үүлс зүг бүрээс ойртон айсуй.

— Дайн ч яах вэ дээ гэж Желал-Эд-Дин санаа төвшин хэлэв.

Нэгдүгээр элчийн ирж хэлсэн нь: Улаан барс Чингис хаан Отрар хотыг эзэлж, Иналчиг Хайр хааныг барьж хорсголоо тайлахын тул, нүд чихэнд нь хайлсан мөнгө цутгах тушаал гаргасан гэхийн дээр одоо Чингис хаан тэндээс хөдөлж, чухам намайг эрэн айсуй гэнэ ээ.

— Ирвэл иртүгэй. Бид хүлээсүгэй. Чи аюултай хэцүү үест аанай ажиггүй хэвээрээ байх юм аа? гэхэд нь,

— Бидэнд цэрэг бий тул, ер айх хэрэггүй гэв,

— Хоёрдугаар элч, өмнө зүгээс ирж хэлсэн нь: Тэнд Татаарын туршуул цэргийн ангийг үзэв гэжээ.

— Ямар нэгэн бяцхан отряд биз ээ. Одоо хавар эрт их цэрэг цастай даваануудад хэвтээсэй.

— Татаарын цэрэг уулнаас бууж, Энэтхэгт ухрах замыг боовол хэрхэх вэ?

— Бид тийшээ ухрах хэрэг юү вэ. Бас мэдүүлсэн нь: Монголын туршуулын ангиуд Кзыл Кумийн элсэн манхаар үзэгдэв гэнэ ээ. Тэр зүг Туркмений арван мянган морьт цэргийг явуулсан бий.

— Энэ Туркмен, Монголчуудыг хориглож үл чадна.

— Хэрэв тэгвэл, Чингис хаан, ойрын өдөр Бухарын хаалганд ирэх болзошгүй болжээ. Урьдаас сэргэмжлэн бэлтгүүштэй байнам.

— Тэрхүү улаан сахалт адгуус, харин Бухарт ирчхээд сэмхэн гэтэн хүлээж, отрядоо үүгээр түүгээр явуулж, биднийг эрүүлж бий юуны магад. Эндээс хурдан зайлах нь чухал гэж Мухамед бутны цаанаас дайсан гарч ирэх гэж байгаа мэт эргэн тойрныг харж амандаа бавтнан хэлбэл Желал-Эд-Дин дув дуугай байлаа.

— Чи юунд хариу үл өгүүлнэм.

— Чи намайг тэнэг гэсэн тул би юү хэлж чадах билээ.

— Би чамд тушааж байна. Чи хэл.

— Тэгвэл би хэлсүгэй. Чи намайг өршөөж ч чадна. Толгойг минь авч ч чадна. Хэрэв тэр золигийн Чингис энд ирвэл бид өндөр хэрмийн цаана орж нуугдан суухгүй, харин гарч түүнийг эрэх хэрэгтэй.

Би л бол номхон иргэний арьсыг өвчихдөө зүрхтэй, байлдаантай түгшүүртэй цагт модны навчис мэт чичрэн дагжигч Хивчагийн бүх хаадыг хээр талд хөөн гаргаж, Монголчуудтай байлдуулна. Ер нь байлдаанаас хамгаалах хамгаалал хурц сэлмийн ир, хурдан морь биш үү. Улаанбарс ирвэл иртүгэй. Ирвэл нэн сайн. Учир нь бид түүний явах замыг сайн мэднэ. Морьдын замыг эргүүлж, гэзэг даран нэхэж, замыг нь хаан бүсэлж, зүг бүрээс нь довтлон ороод тэмээдийг нь нэвсэртэл жанчиж, түүний улаан арьсыг махтай нь хамт хэсэг хэсгээр дүүжилсүгэй. Түүнээс биш, Самаркандын хэрмийн ард зуун мянган морьт цэрэг, талаар бүгшин нуугдаад ямар хэрэг байх вэ. Харин, Татаарууд хамаг хонийг нь цөлбөн идэж бүрэлгэн сүйтгэнэм зээ.

— Чи эцгийн үгийг шүүмжлэх санаатай байна уу, Би үүнийг аль эртний мэдсэн билээ. Чи намайг үхүүлэхийг хүсэж байна.

Желал-Эд-Дин нүдээ доош буулган гунигласан дуугаар хэлрүүн;

— Миний хэлсэн буруу болбол хэрхэх вэ? Би орчлон донслом, хүнд хүчир ажилд ч чамайг үл ухраана. Би чиний хайрт Искендерийн дуртгалаар тангараглах нь би уулын ухаан мохдог тул тийнхүү хүлцэнгүй бөгөөд эрс тэсгүй, чиний энэ их цэрэг хэрэв байлдааны лагерь болохгүй, чиний заасан ёсоор дайсантай байлдахгүй ахул байсны тус юу вэ? Өндөр хэрэм байгаад ямар тус байх вэ. Хэрэв түүний цаана манайх эмс охид, багачууд хүүхэд хоргодохгүй, харин бүрэн зэвсэгтэй хүчит эрс чичрэн дагжих эмсийн хөнжлөөр биеэ

бүтээж хэвтвэл огт хэрэггүй бус уу. Чи намайг албал алтугай. Гагцхүү миний үгийг дагахыг гуйна. Эцэг минь Самаркандад очъё. Одоо явъя...

— Иран буюу Энэтхэг хоёроос бусад зүг үл явна...

— Тийм бус, Бид, зөвхөн хоёр зүйлийн нэгийг нь шилэх болсон үүнд эсхүл баатарлаг байлдах, эсхүл хөөгдөн, шившигтэй үхэх, энэ хоёр байнам. Миний саналаар бол, бид хамаг цэргээ авч уудам талд гарч, Татартай байлдсугай. Бид Цахилгаан цахилт мэт эрчимтэй, шөнийн сүүдэр мэт баригдахгүй болтугай. Чи, их жанжин гэдэг нэрээ алдаршуулна... Алгуурлаж болохгүй боллоо. Түргэлье.

Шаг, алмаас шигтгээтэй бэлзгээр чимсэн хуруугаа ёдойлгож ихэмсгээр хэлсэн нь:

— Чи жанжин биш, нэгэн зоригт баатар эр. Чи, дайсанд харилгүй дайрах хэдэн мянган баатар эрийг даргалж чадна. Би зүрхтэй зоригтой хөдөлж чадахгүй боловч, ухамсаргүй тэнэг Жигит биш, юу ч болсон боловсортол бодож тогтоох хэрэгтэй... Миний бодлого, чинийхээс өөр. Би чамтай Калифид очиж, Жейхун мөрний олмыг хамгаалан сахисугай гэнэ.

— Төрөлх орноо хаях уу тэгээд, хэрэв тэгвэл албат ард Хоресм шагийн угсаа удмыг, алба татвар авахдаа чаддаг атал, аюултай цагт Татаарын хядлагад хаяад явлаа гэж зүхэн хараахад зөв гэхээс буруу гэхгүй гэхэд,

— Би Иранд очиж, тэнд шинэ цэргийг хуралдуулна гэв.

— Тийм биш, эзэн минь. Юуны урьд, өөрийн гарт байгаа хүчээр байлдах нь эрхэм. Хэрмийн ард хамаг цэрэг чинь удирдах толгойлох эзэнгүй, нуугдан хэвтэж байхад шинэ цэрэг элсүүлж, түүнийг сургах гэдэг нь хэтэрхий оройтсон хэрэг юм аа. Нэгэн дор дийлэхийн тулд цэргийг хорин жил хүлээв гэжээ. Самаркандад очъё. Би энгийн цэргийн адил чамтай мөр зэрэгцэн байлдъя гэвэл,

— Үгүй, үгүй, чамд тушаасугай. Чи Балхад очиж, шинэ цэрэг элсүүл. Миний аз харьжээ.

— Аз завшаан, аз завшаан гэгч юү вэ? Аз завшаан, зоригт эрийг ухрааж болох уу. Түүнчлэн аз завшаанаас зугтаж болохгүй. Харин аз завшааны хойноос хөөцөлдөж, үснээс нь шүүрэн авч, өвдөг дороо хийх хэрэгтэй. Аз завшааныг ингэн олдог шүү гэж Желал-Эд-Дин их хилэгнэсэн байдалтай эцэгтээ хэлбэл, Шагийн хэлсэн нь:

— За, за, чи ямагт ухамсаргүй эр хэвээрээ шив дээ. Чи их Хоресмийг хөмрөх аюулаас нэвтрүүлж үл чадна... гээд Хоресм Шаг

сэхээвчээсээ бууж, байшингийн урдах тавцан дээр амьсгаадан түргэн гэгч нь ирэв. Тэнд хэдийн ширээ зассан байжээ. Шаг уншлага уншаад зам гаталгааг сураглан асууж, хоол идэх зуур унаа авчир гэж тушаав.

МОХОШГҮЙ ЗОРИГТ ТӨМӨР МЕЛИГ

Чингис хаан, Отрар балгасанд Өгөөдэй, Цагаадай хоёр хүүгээ нэгэн хэсэг цэрэгтэй үлдээгээд, та нар Отрар хотыг байлдаж, Яналчиг Кайр хааныг барьж гинжлээд надад хүргэ. Би цээрлүүлэн шийтгэнэ гэж захиад, ахлах хөвүүн Зөчийг Женд Енгикенд хоёр хотыг байлд гэж тушааж, бусад цэргийг зүг зүг явуулав.

Алаг ноёнд таван мянган морьт цэрэг өгч, хивчаг цэрэг байсан Бенекет хотын зүг мордуулсанд, гурав хоног байлдахад хотын олон дагаж орохыг хүсэж өвгөдийг явуулсанд Алаг ноён, хотын хүн амьтныг гадагш гаргаж, цэрэг, урчууд, энгийн хүн цөм тус тус ялгаран жагстугай гэж тушаажээ. Цэргийг зэвсгээ зааж өгсөн газар хурааж зайлмагц, Монголчууд харвах нь харван, сэлэм, бялуугаар цавчин цохиж алахыг нь алж хядаад, бусдын дотроос аль чийрэг залууг сонгож, арав, зуу, мянгаар хуваж дарга тавиад, байлдах хотын хэрмийг эвдэн, монгол цэргийн өмнө явуулна гэж хөөн авчрав. Замд Алаг ноёны цэрэгт бас монгол цэрэг, жич дагасан цэрэг нийлж бүгд найман түмэн цэрэгтэй болоод, Сайхун гэдэг (Сердарья) их мөрний эрэг дэх Хожент хотод хүрвэл, хотынхон, хэрмийг бат гэж найдаж, бууж өгөхгүй гэв.

Хотын даргаар шударга баатар зоригт Төмөр Мелигийг саяхан томилсон байжээ. Төмөр Мелиг, их мөрний бэлчирт өндөр цайз хаан босгож, зэвсэг хүнсний нөөцийг хадгалж, дайсныг тосож байтал, монгол цэрэг, олзны хүнийг тууж ирээд жанчин ташуурдаж, хотыг байлдаар авируулсанд, хотын ард олон аргагүй ах дүү нартайгаа алалдахыг үл хүсэн бууж өгөхөөр тогтжээ.

Төмөр Мелиг, мянган баатар эрийг дагуулан, мөрнийг гаталж, бүх онгоц завийг эзлээд, арал дээр батлан хориглосонд, хотын ард, сурвалжтан хүнийг монгол цэргийн хүрээнээ явуулж, хэрмийн хаалгыг нээтэл, Монголчууд, хотыг талан дээрэмдэв.

Монгол цэрэг, чөдөр оньсоор арал дахь цайзыг том том чулуугаар харваж, сум чулуу нь цайзад хүрсэнгүй. Чингэхэд хотын бүх залуусыг бусад олзны хүмүүстэй хамтатган, мөрний хоёр эрэгт таван түм шахам

хүнийг хуралдуулж, арав, зуугаар хувааж, гурван фарсах буюу хорин нэгэн километрийн газар байгаа нэгэн уулнаас чулуу зөөлгөж, мөрнийг хаах далан цогцлов.

Тэр завсар Төмөр Мелиг, арван хоёр сал хийж, Монголын галт сумнаас биеэ хамгаалах нойтон эсгий, шавраар дээрээс нь халхлах саравч босгож, харвах нүх гаргаад өдөр бүр зургаа зургаан салыг мөрний хоёр этгээдэд явуулан, Монголтой үхэн байлдахад, Монголын галт зайт сум нь салд хор хүргэж эс чадав.

Шөнийн цаг Төмөр Мелиг, сэм дайран орж түйвээх тул, монгол цэрэг өдөр шөнө амарч чадахгүй болов.

Тэр завсар, монгол цэргийг дагаж явсан хятад инженерүүд холын тусгалт чөдөр оньс хийцгээж, том чулуу, сум харвах болсон нь төмөр Мелигийн цэрэгт их хохирол учруулж, төмөр Мелиг, хэрэг нэгэнт биш болсныг үзээд, харанхуй шөнө далан онгоц сал засаж, цэрэг юмаа ачаад, олон онгоц салд гэнэт гал самбар барьж, мөрний ширүүн урсгал даган явсанд монгол цэрэг, мөрний хоёр захаар дагаж хөнөөв. Төмөр Мелиг, онгоц салыг монгол цэрэг үзэгдсэн зүг залж, ихэд харван хөөж, дагасан онгоцондоо зам гаргасаар Бенектэд хүрээд, онгоцны зам хааж дадсан Монголын төмөр гинжийг тас цавчаад өнгөрчээ. Чингээд, мөрөнд бас хаалт тавьсан байгуузай гэж болгоомжлон Бархалыг кент хотын хавьд олон агт байхыг үзээд, сал онгоцноос бууж, агтыг барьж, цэргээ морь унуулахаар тогтсонд монголчууд хойноос хөөн нэхэх тул, хэсэг яваад хэсэг байлдаж, дахин цааш довтолсоор, цэргийн эрс ер бууж өгөхийг хүсэхгүй байлдсаар монгол цэргийн дундуур шөнөжин гарч, амьд зайлсан нь нэн цөөн болов.

Төмөр Мелиг, хэдхэн цэрэгтэй үлдсэн боловч, тулалдаж явсаар сүүлд морины хурданд дулдуйдаж, хөдөө тийш хурдлан давхив.

Чингэсээр, Төмөр Мелигийн дагагсад цөм алагдаж, Төмөр Мелигийн хоромсгонд гурван сумын төдийхөн үлдээгээд, хойноос нь гурван монгол үлдэж хөөв, Төмөр Мелиг, нэг монголын нүдийг харваж унагаад, нөгөө хоёр өөд дайран орсонд тэр хоёр, морио эргүүлж зугтаав. Чингээд, Төмөр Мелиг, хоёрхон сумтайгаа Хар Хончирын харьяа туркмен цэргийг манхан элсэн дэх худгийн дэргэд буусан газар хүрч, унаагаа зэхүүлж, Хоресм ороод тэнд Чингис хаантай байлдах ажлыг бэлтгэн эхлэв.

МОНГОЛЧУУД, МАНХАН ЭЛС ТУУЛАВ

Энэ гайтай улс, морь унавал давхих нь нүдээрээ үзээгүй хүмүүсийн итгэшгүй хурдан давхидаг улс.
(Клавиго)

Өгүүлэх нь, үнсэн товрог болсон Отрар хотын шатсан байшин барилгын эвдэрхий нуранхайгаас утаа баагьж бүхий үест шулуун зоригт Яналчиг хаан хэрмийн цаана шивээлэн хоргодож хэрэм дээр авиран ирж байгаа монгол цэргийг хориглон байлдаж байв. Чингис хаан, есөн хөлт цагаан тугаа босгож, цэргийг хөдлөхөд бэлэн байхыг тушаав.

Хөвүүд их жанжныг дуудан ирүүлж, тэд бүгд том эсгий дээр тойрон суугаад, хүн бүхэн ямар зүг явж, ямар хот байлдахыг хэдийн сонсож мэдсэн боловч, Чингисийн цагаан туг, аль зүг хандахыг зүрхлэн асуух хүнгүй байжээ.

Чингис өгүүлрүүн: Миний эзгүйд бүх цэргийг болгоомжит Буурч ноён захираг. Манлайн цэргийг шаламгай Зэв ноён, хотыг бүслэн байлдахад чадамгай Сүбээдэй баатар тэргүүлэн яваг. Тариалангийн газрыг моринд бүү гишгүүлэгтүн. Сүүлд агт тэжээх юмгүй болно шүү. Бид, Мухамед шагийг Бухар Самаркандын хоорондох талд амдаж, гурван талаас дайран ороод гол цэргийг нь сөнөөе. Чингээд, бүх лал орны эзэн болно гэжээ.

Айргаас ууж, дайчин сүлд оршсон цагаан тугтаа цацал цацаад мордож, бүх цэргийг хөдөлгөв. Нэг хэсэг цэрэг, Сердарья мөрнийг өгсөн, нэг хэсэг нь уруудан, Чингис хаан, замд орж, цаашлан Кзыл кумын элс өөд одлоо.

Өдөртөө, хоёрдугаар сарын наран, нүд гялбам гийж халаах бөгөөд шөнөдөө шалбааг ус хөлдөж, шавартай цайдмаар гарсан зөрөг зам хатуу болдог байлаа. Цэрэг дуу чимээ гаргалгүй явж, морины янцгаах, зэвсгийн хангинах чимээ үл гарган дуу дуулахыг хориглон баг багаар хоорондоо ойр зайтай багсран явж, буухдаа түр зуур буудаллаж яаран давшсаар цэрэг шөнийн цагт мориныхоо өмнө хэвтэж баахан дуг хийгээд, шөнө тагнуулд гарсан цэрэг, гартаа галтай бамбар барьж, өмнө цэргийг зам төөрөх, самгардуулахгүйн тул, өндөр газар дээр гарч, галт бамбараар дохио өгч явав. Дайсан лалын цэрэг дотор хөл урттай түргэн морь унасан туркмен тун сүрхий гэцгээж, тэднийг манх довын цаанаас бэрс мэт харайлган гарч жагсаалын дунд шууд цөмрөн орж

үймүүлэн сандруулаад хүнийг бугуйлдан чирсээр хоромхноо алга болдог гэж хэлэлцэв.

Монголчууд, элсэн талыг туулж, шууд Хоресмийн нийслэл Гурганжийг чиглэн явж байна гэж анхандаа бодож байсан нь хоёр хоноод булингар уст Сердарья мөрнөөс холдсоны сүүлээр, наран, өглөөгүүр ард мандахгүй, харин зүүн талд мандах тул баруун зүг, чиглэн явсангүй өмнө зүг Самарканд Бухар гэдэг хоёр алдарт хотын зүг явж байгааг сая мэдэцгээв.

Чингис хаан, цэргийн дунд бөх хөлт, хар шийрт зээрд жороогоо унаж, бүх цэрэг хатируулан явав.

Их хаан, жолоог сулавтархан барьж, хэнэггүй байдалтай явах бөгөөд нүд нь онийж хаяа нарийхан завсар гарах боловч чухам зүүрмэглэн унтаж яваа буюу нүдний завсраар хол ойрыг соргогоор ширтэн харж, алмайтах мартахгүй яваа алин ч үл мэдэгдэв.

Тэр аянд, Чингис хаан, шаламгайлан явах тул, хоног буудалд гэр барилгүй, эсгий давхарлан дэвсэж унтдаг байв. Унтахын өмнө арьсан дуулгаа тайлж, буурал толгойгоо хар булга хадсан чихтэй малгайгаар бүтээн, дэргэд нь дөрвөн үнэнч, бие хамгаалагч, бороо цаснаас эсгийгээр нөмөрлөн халхалж хөдлөлгүй суудаг байжээ.

БҮСЛЭГДСЭН БУХАР ХОТОД

Чангалах газар зөөлөн байсны хэрэггүй. Зөөлөн номхон байснаараа дайсныг нөхөр болгохгүй, харин улам толгой дээрээ гаргахад хүрнэ.
(Саади, 13 дугаар зуун)

Хажи Рахим, Туган хүү, Курбан Кичик гурвуулаа, өдөр туж Бухар хотоор тэнүүчилж хонох газар эрж ядав. Орой дэлгүүр пүүсийн хаалга тас няс хаах чимээ сонстож, амьтан яаран тарцгааж, гудамжинд хүнгүй болж өндөр өндөр битүү хашаа хэрэмдээ орцгоов. Манай гурван хүн энд тэндээс хоног гуйвч зочин олонтой байна, өөр газар оч гэж ер оруулах айл олдсонгүй.

Дүрвэж ирсэн хүмүүсийн дунд шахцалдан сууж нэгэн шөнийг өнгөрөөхийн хөлсөнд нэг атга дирхем авна гэдэг буудлын газар, цайны газар цөм хаагдаад, ёс журмыг сахигч райс цагдаа урт мод барьсан манаачтай эргүүл хийж, гудамж зээлээр тойрон явж, тохиолдсон

хүнийг гудамж гайгаар зүй бус сэлгүүцэн явлаа гэж «өр төлөөсний зоорь»-д хаяна гэж сүрдүүлж, ер олон нийтийн үзэл санал, хэв журам хэрхэн байгааг хянан шалгана.

Курбан Кичик, нэгэн нарийхан гудамжны хэрмийн ёроолд нурахад шахамдсан хэдэн овоохой байхыг хараад, хавтгай оройтой байшингийн дээр гарч сүрэл, модны гишүү мөчир дотор хоргодон хоноё гэв. Курбан Кичик, тэргүүлэн гараад бусад нөхдийг туслан гаргав. Гурвуул бие биедээ шахцалдан сууж Дервишийн өргөн нөмрөгөөр хучив.

Шөнө хүйтэн салхи салхилж, цас шуурав. Хотын чимээ шуугиан удтал дуурьсаж, улам улам намхарсаар бүрмөсөн дарагдлаа.

Ганцхан манаачийн тогшуур цохиж, энд тэнд нохой, дуу дуугаа авалцан хуцах нь сонстоно.

Манагаар өдөр болж, бүрээчин, лалын шашны өндөр нарийхан давхарлаг цамхаг дээрээс өглөөний мөргөлийг зарлан, өндөр дуугаар залбирал унших үеэр манай гурван хүн, хотын өндөр хэрэм дээр гарцгаав. Тэр зүг айж сандарсан хотынхон яаран явцгааж, дорнод хаалганы гаднах талын дунд, нэгэн бяцхан толгой дээр урьд үзэгдээгүй том шар цацар харагдаж, учиргүй олон морьтой хүн тойрон бужигналдаж, баг багаар давхилдан явсаар хотын хэрмийг бүсэлж давхив. Байдал нь бухар хүний хэдэн хүү хачин өөр үзэгдэж, унасан морь нь бие бага, шаламгай нь уурласан бодон гахай адил түргэн довтлох бөгөөд ийш тийш гавшгайлан эргэж, гэнэт зогсоод дахин өөр тийш довтолж явах нь үзэгдэв. Тэдгээр морьтой хүний өмссөн дуулга ялтсан хуяг нь тоосыг нэвтлэн тусах нарны гэрэлд гялалзан, морьтой хүмүүс олон болж, уурга шилбүүр зэргийг барьсан тосгоны олон мянган хүнийг бүлэг бүлгээр өмнөө тууж явав.

— Энэ жижиг морьд унасан хачин улс хэн гэгч вэ? гэж Курбан Кичик асуувал, нэгэн урвагар цэрэг, жадаар газар дэлдэж өгүүлрүүн;

— Юу гэнэ ээ. Эд чинь манайхны лал бус, өнөөх Татар гэдэг Яжуж Мажуж ирээд явж явна шүү. Тэр шар асарт тэдний их хаан биднийг хараад элэглэн сууж байна. Аллах тэнгэр түүнийг ниргэтүгэй гэхийг сонсоод, Курбан Кичик, дуу алдаж өгүүлрүүн;

— Хотын хаалга хаалттай, одоо намайг гаргахгүй. Муусайн хүүхэд минь яах бол доо. Би ч энд бүтэн жил суух вий дээ.

Гэтэл, болд дуулга өмссөн мөнгөн хуягтай нэгэн ихэмсэг даргын хүрч ирэхэд Курбан түүний дэргэд элэг тэврэн ёсолж дээлийн хормойг

үнсэж өгүүлрүүн;

— Их ноён, Инанч хаантан, намайг таних уу. Би таны газрыг түрээслэн тариалагч боол Курбан Кичик байна. Ноёны амгаланг эрье гэвэл,

— Чи зуундаа байхгүй, энд юу хийж байгаа юм бэ гэж тэр ноёны хэлэхэд Курбан Кичик өгүүлрүүн:

— Падишагийн зарлигаар буруу номтонтой байлдах гэж Бухарт явган ирэв. Замд явсан гүү морио бол хулгайд алдсан. Тэр хулгайчийг тэнгэр ниргэх болтугай. Би энд ирээд зууны даргыг олох гэж хоёр хоног тэнэв. Таних хүнгүй, асуухад хэлж өгөх хүн олдохгүй байна. Падишагийн төлөө амь хайргүй ирсэн цэргийг хэрэгсэхгүй бол хэн, энэ Яжужтай байлдах юм гэвэл, Янанч хаан өгүүлрүүн:

— Курбан Кичик минь би чиний энэ зоригтой үгийг сонсохдоо баярлаж байна.

Чамайг үзвэл гартаа тэнхээтэй. Тариалангийн хатуу ажилд нухлуулж нуруу бөгтөр болсон байна. Чи дайсантай байлдаж баатар болж чадмаар байна. Би чамайг баг цэрэгтээ элсүүлье. Намайг дагаад яв гэжээ.

Курбан, тийнхүү цуг явсан Дервиш, Туган нараас салав.

* * *

Тэндээс, Курбаныг Янанч хааны хойноос дагаж талбар дээр ирвэл олон морьд уяатай өдий төдий цэргийн хүн, гал түлж тогоонд цагаан будаа чанаж, хонины өөхний сайхан үнэр ханхалж байв. Үүнийг үзээд Курбан баярлаж, энд чинь хүнийг ганц аллагын газар хөөхгүй, бас тэжээдэг юм байна шүү гэж бодов.

Янанч хааны ирэхийг үзээд нэгэн хар сахалтай өндөр баргар туркмений мэхийн ёслоход Янанч хаан;

— Хүй Чауш Ураз, чиний захиргаанд Курбан Кичик гэдэг энэ зоригтой цэргийг өгсүгэй. Тариалангийн газар сайн ажиллаж байсан хүн, тулалдаанд мөн сайн байлдагч болно байх гэвэл тэр өвгөн өгүүлрүүн:

— Морь өгөх үү. Явган байлдах юм уу гэвэл,

— Морь, зэвсэг, бүхий л хэрэгтэй зүйлийг өг. За, тэнгэр та нарыг ивээтүгэй гээд одов.

Чауш Ураз, өвгөн арван цэргийн дарга ажээ. Түүний цэрэг галын дэргэд сууж, нэгэн том модон халбага барьсан цэрэг, Курбаны

мэндлэхэд:

— Ийм том жад авчирсан чинь сайн. Будаа чанах түлээ хүрэхгүй байсан юм гээд Курбаны хүнд жадыг авч, сүхээр хугачаад галд хийлээ. Ураз Курбанд нэгэн том саарал азарга зааж,

— Чиний унаа энэ дээ. Агсам азарга юм шүү. Бөгсөнд нь бүү ойртоорой. Ална шүү. Толгой талаас очиж, жолооноос нь бариад мордоорой. Байсаар чамд дасна биз ээ. Нэг гэм нь жагсаал дотор тогтдоггүй, авч давхидаг юм шүү. Жолоогоо тавивал наадах чинь байлдааны цагт Татар луу давхиж орчино шүү гэвэл, Курбан, азарганы дэргэд баахан айсаар ойртов. Тэр азарга чихээ хулмайлгаж, шүдээ ярзайлган тангарав. Курбан түүнийг үзээд «Ээ тэнгэр минь» гэж галын дэргэд эргэж очвол Ураз, хуучин том сэлэм, нэлээд элэгдсэн ширэн гутал өгөөд хоол ид гэлээ. Курбан Кичик бусдын адил жинхэнэ цэрэг эр болсноо мэдэж, үдэш цэргийг мориндоо арвай цадтал өгөөд, бас тусгай саванд хийж базаахад Курбан мөн чингэв.

— За одоо халуухан ажилд орно доо. Мордоцгоогтун гэж Чауш Ураз хашхирахад бүгдээр мордоцгоолоо. Курбан Кичик өнөөх догшин азарга дээрээ арай гэж мордож, бусад цэргийн хамт Бухар хотын нарийн гудамжаар явлаа.

— Хотоос гарч байлдах нь дээ. Биднээс хэд нь буцаж ирэх бол гэж Курбантай зэрэгцэж явсан нэгэн хүн хэлэв. Хотын хаалганы дэргэд цэрэг түр зогсож, бас өөр цэрэг нэмэгдэн ирсээр таван мянга орчим морьт цэрэг цугларав. Цэргийн дарга нар, Янанч хаанд очиж, тушаал авсан нь:

— Татаарын их хааны шар цацар өөд дайр, тохиолдсон бүгдийг цавч. Олзолж авсны хэрэггүй. Татар цэргийн хүрээг сандруулж чадвал бусад цэрэг, буруу номтныг хялбархан сөнөөж чадна. Зоригт цэрэг та нарыг Аллах туслах болтугай гэжээ.

Удалгүй төмөрлөсөн хүнд нүсэр хаалга нээгдэж, цэрэг хотоос гарлаа. Курбаны явахад харуй бүрийн дотор өмнө явах морьт цэргийн сүүдэр Татаарын хүрээний тоолшгүй олон гал алсаас гялалзаж, цэрэг хатируулан явснаа улам түргэлж давхицгаав. Курбаны саарал азаргыг хазаар дарж давхихад амыг татаж ядан явав.

Тэгээд, таван мянган морьт цэрэг, Татаарын хүрээ өөд, сүртэй хашхиран дайрч, морины хөлд хүнийг гишгүүлэн ачаа бараа, мал дотор харайн давхиж ороход татаарууд мориндоо мордоцгоож, зүг бүр зугтаав.

Курбан цэргийн дундуур хуучин хүнд сэлмээ зурайлгаж, өндөр дуугаар хашхиран давхиж явахдаа нэгийг цавчиж, бас нэгийг унагаагаад, юу боловч Татаарын хааны шар асарт хүрэх сэн гэж тэмүүлэн явлаа.

Цэрэг, татаарыг хөөлгүй өөр тийш давхисанд Курбаны гайхаж байтал саарал азарга нь тэр зүг авч давхив. Курбан дотроо морьтойгоо шуудуунд бүү унаасай гэж тэнгэрт залбирч явав.

Цэрэг нэлээд давхин, яваад, сая морины амыг татаж, Бухараас баруун тийш чиглэсэн их замд ороод шөнө дүлэн тайван явсаар өглөө болгов. Нэг газар буухад нь Янанч хаан, зарлан өгүүлрүүн:

— Бид морийг түр амруулаад, Жейхун мөрнийг гаталж Хоресм шагийн цэрэгтэй нийлнэ гэв. Тэгж байтал, сүрхий дуу чимээ гарч, удалгүй Татар давхин айсуй. Татарыг аймшигтайгаар хашхиран саяын амарч байгаа цэрэг дээр ирэхэд бухарын цэрэг арай гэж мордож айн сандран үхлээ эрж, зугтахад нь Татар тэр хэсэг цэргийг бараг хядав.

«Үхэхээс айдаг хүн, айн зугтаж, тэнгэр дээр гаравч үхнэ» гэж нэгэн шүлэгчийн өгүүлснийг энд дурдалтай.

БУХАР БАЙЛДАЛГҮЙ БУУЖ ӨГӨВ

Худаг усаа сайн хамгаалахгүй бол, хүн түүнийг эвдэнэ.
Хүнийг довтлон дайрахгүй бол, хүн түүнийг доромжилно.
(Арабын эртний үг)

Өгүүлэх нь: Янанч хааны таван мянган цэрэг, «тансаг сайхан Бухар»-ыг хамгаалж, баатарлан байлдахын оронд жигшүүртэйгээр зугтсанд хотын гол сүмд беги ноёд, имам, эрдэмтэн, улемийн зэрэг ихэс цугларч зөвлөлдөөд,

— Эсэргүүцэн тэмцсэнээс толгойгоо гудайлган дагавал амийг хамгаалж болно. Тиймийн тул Чингис хаанд очиж түүнийг үйлчилье гэжээ.

— Хаанах газрын боловч, хүн харилцан адил. Татаарын хаан бидний гуйлтыг сонсохын дээр, буурал өвгөдийг ойшоон үзэж, «гэгээн огторгуй дахь гэрэлт одон» гэж алдаршсан манай эртний хотын гуйн дагаж байгаа ард иргэнийг өршөөх биз ээ гэж харилцан ярилцаж, нэгэнт тогтсон тул хоргой торгон дээлээ өмсөцгөөж, мөнгөн тавагт хотын арван нэгэн хаалганы алтан түлхүүрийг тавьж, беги имам, улем

худалдаачныг хотоос гарч, шар асрын зүг чиглэн одоход өмнөөс нь хааны их хэлмэрч морьтой хүрч ирэв. Өвгөдийн зарим нь тэр хүнийг даруй таньж, урьд Гурганж хотын баян худалдаачин Ялвач Махмуд байна. Олон жил харь газар явж, харь улсын хэл сурсан алдартай хэлмэрч гэж танив. Өвгөдийн дотроос хамгийн хүндтэй нэг нь өгүүлрүүн;

— Манай хотын хуучин хэрэм, өндөр болоод бэх, байлдан эзлэх гэвэл олон жил их хүчийг хэрэглэж сая туулж болно. Иймд олон амьтныг цус асгарах аюулаас ангижруулж, их Падишаг Чингис хааны зоригт цэрэг илүү хор хохирлыг учруулахгүйг бодож, хэрэв Монголын эзэн дагаж орогсдыг уучилбал хотыг байлдалгүй өргөн дагасугай гэж бид хэлэхээр ирэв ээ гэвэл:

— Хүлээцгээж байгтун гээд хэлмэрч яаралгүй шар цацрын зүг явж тэндээс айн чичрэн хүлээн байгаа өвгөд дээр мөн яаралгүй хүрч ирээд,

— Их хааны хэлсэн үгийг буурал өвгөд сонсогтун. Манай хааны айлдах нь «Цайз халдашгүй хэрэм нь хамгаалагчдын зориг хүчтэй чацуу байх ёстой. Хэрэв, байлдалгүй хотыг өргөх гэж байгаа бол хаалгыг нээж, хүлээ» гэж байна гэвэл,

Их зантай сурвалжит өвгөд тэр үгийг сонсон, сахлаа шувтарч, бас биеэ харж, толгойгоо сэжээд хотын ард иргэн, ямар аюулд эрсдэхийг үл мэдэн, нэлээд зүрх шантарсан байдалтай эргэж, хотод ирэв.

Бухар хотын хэрмийг дээр цагт байгуулсан нь маш өндөр бат. Хотын ард олон түүнийг олон сар хамгаалж чадах байжээ. Гэтэл, тэр өдөр, зүрхгүй этгээд, дайсантай тэмцье гэгчдийг тэнэг гэж хараж, бууж өгөхөөр тогтон үймэлдэж байв.

Хот хамгаалах цэргийн дарга үлдсэн цэрэг, хотын цэрэг, хотын хаалганы түлхүүрийг буруу номтонд өгсөн имам ихэс өвгөдийг зүхэж, юу боловч амьсгалыг хураатал тэмцэлдэн байлдахаар шийдэцгээж шахаристны дунд өндөрлөж байсан бяцхан цайзад орж, батлан сахиад, дайсныг хүлээв.

Удалгүй, Бухар хотын арван нэгэн хаалга нэгэн зэрэг нээгдэж хэдэн мянган татар цэрэг, нарийн гудамжаар давхилцан орж, маш эмхтэй явцгаах бөгөөд зарим цэргийн анги чухал чухал газрыг даруйхнаа эзлэв.

Хотын хүмүүс хавтгай оройтой байшин дээрээ гарцгааж урт дэлтэй, жижигхэн морь унасан, сахалгүй цэргийг айн үзэцгээж, хот

даяар чив чимээгүй, гагцхүү улаан нүдтэй, аржгар үстэй, шантгар хоншоортой шар ноход, урьд үзэгдээгүй хүмүүсийн аягүй үнэрийг аваад байшингийн орой дамжиж, сүрхий чанга боргон хуцав.

Монгол цэрэг, бүх гол гудамжаар ороод, цагаан морь унасан хааны бие хамгаалагч жардын цэрэг хүрч ирэв. Хүн морь нь цөм өвдгөө хүртэл ялтсан хуяг өмсжээ.

Мянган шилдэг цэргийн дунд, Хар Хум элсэн цөлөөс галын шуурга мэт гарч ирсэн, дорно дахины эзэн явж байгаа харагдав. Түүний өмнө баатар шинжтэй нэгэн монгол, есөн сүүл намилзуулсан том цагаан тугийг өргөж хойноос нь тас хар нүдтэй, эмээлгүй дун цагаан морийг хоёр морьтой цэрэг хөтөлж, урт хар хувцастай их хаан, хул морь унаж, эмээл, хазаар, хөмөлдрөг нь ангийн арьс ширээр үйлдсэн ажээ.

Бөгтөр том биетэй Чингис хаан, царайгаа барайлган суран бүснээсээ хар хуйтай том махир сэлэм зүүж, шилэвчтэй хар дуулга нь хамрыг хамгаалсан болд савхтай бөгөөд үл хөдлөх хар царай, урт буурал сахал аньсхийсэн нүд нь алтан эрдэнээр гоёмсоглон чимсэн Хоресм шагаас хачин өөр үзэгдэв.

Чингис хаан, хотын гол талбарт хүрч ирээд бие хамгаалагч цэрэг гурван талд жагсаж, үймэлдэн шахцалдах олныг хориглов. Өндөр сүмийн шатан дээр том лам нар, шүүхийн түшмэд, хотын сурвалжит хүн зогсоцгоож байв.

Монголын эзнийг сүмийн дэргэд ойртож ирмэгц, хуучин өөрийн Падишагт ёсолдгийн адилаар цугласан олон ард цөм хул морины хөлд сөгдөн, гагцхүү хэдэн хөгшин улем эрдмийн хувиар сөгдөх албанаас хэлтрэгдсэн учир, алгаа хамтатган зогсож байв.

— Падишаг Чингис хаан урт насалтугай. Дорно дахины наран Чингис хаан мандтугай гэж нэгэн өвгөний нарийн хоолойгоор чахартан хашхирахад цугласан хүн нэг зэрэг бүдүүн нарийн хачин дуугаар түрэн хашхирав.

Чингис хаан, нүдээ онийлгож, сүмийн том дүгрэг хаалгыг харж, морио гуядан сүмийн чулуун шатаар дээш авирах зуур,

— Энэ өндөр гэр, хотыг захирагч ноёны гэр үү гэвэл имамууд,

— Үгүй. Энэ тэнгэрийн сүм гэр гэж хариулав.

Чингис хаан, бие хамгаалагч жардаар хүрээлүүлж, сүмийн дотор дэвссэн үнэтэй өргөн том хивс дээгүүр явсаар босоо хүнээс өндөр, чулуун тавцан дээр дэлгэсэн маш том хэмжээний коран номын дэргэд

мориноос буугаад бага хөвүүн Толуйн хамт имамын мөргөл унших тавцангийн хэдэн гишгүүрийг дамжиж гарав. Цагаан ногоон малгайтай өвгөд шахцалдан зогсоцгоож, улсыг мөхөөгч аржгар шар сахалтай, пад хар царайтай аюулт түүнийг нүдээ бүлтийлгэн ширтэж аврах болов уу, өршөөх болов уу, уурсан хядах болов уу гэж эмээн хүлээв.

Чингис хаан, нэгэн өвгөн имамын тэргүүнд өмссөн малгайг хуруугаар зааж асууруун;

— Энэ юунд ийм их бөсөөр толгойгоо ороосон юм бэ гэсэнд хэлмэрч, их хаанд тайлбарлан хэлрүүн:

Энэ Имамын хэлэх нь урьд, магумет богдын шарилд мөргөж, тэнгэрийг залбирах гэж Арабистан Мекка балгадад явсан учир, ийм том ороомол малгайтай болсон гэнэ гэвэл, Чингис, бас асууруун:

— Чингэж явсны хэрэг нь юу байсан юм бэ. Тэнгэрт хаана ч залбирч болох юм биш үү гэв.

Хирдхийн цочсон имамууд амаа ангайлган дув дуугай зогсов. Чингис хаан бас өгүүлрүүн:

— Таны Падишагийн ял уул мэт их. Би түүнийг номготгох тэнгэрийн цааз, ташуур. Үүнээс хойш Мухамедад өчүүхэн ч мах, атга гурил ч өгч үл болохыг тушаасугай гээд тавцан өөд хоёр гишгүүр ахиж гараад өндөр дуугаар хашхируун:

— Миний ялагдашгүй цэрэг сонс. Энд тариалангийн газар тариа будааг хадаж авсан тул морийг бэлчээх газаргүй болжээ. Харин тариа будааг дүүргэсэн байшин сав, та нарын нээхийг хүлээгээд байна. Тариагаар мориныхоо гэдсийг дүүргэцгээ гэж тушаав.

Өргөн чөлөөнд Монголчуудын хашхиралдах нь:

— Бухарын тариа будааны сан хөмрөг бидэнд нээлттэй энэ. Их хаан, морио тэжээ, гэж тушааж байна хэмээлцэв.

Чингис хаан, индрээс бууж,

— Эдгээр өвгөдийн хамт хэдэн баатар томилон явуулж хотын баян айл, пүүс наймаа тариа будаа хадгалсан сан хөмрөгийг чухам хаана байгааг заалгаж ав. Бичээч нар, өвгөдийн хэлсэн ёсоор, баян худалдаачдын нэрсийг тэмдэглэж, Отрар хотод миний худалдаачнаас булааж авсан эдийг тэднээс эргүүлж ав. Баячууд, архи, хоол элбэг дэлбэг авчирч, миний цэргийг цадтал хооллож баярлуул. Дуу бүжиг өргөж цэнгэлдүүл. Би өнөөдөр Бухарыг эзэлсний их баярыг энэ лалын тэнгэрийн сүмд хийнэ гэв.

Өвгөд, монгол цэргийн хамт явсан нь удалгүй зэс тогоо, шуудайгаар цагаан будаа, хонины мах, бал, тос, хуучин архитай ваар сав ачсан тэмээдтэй хүрч ирэв

ХЭРЛЭНИЙ ТАЛ НУТАГ САЙХАН АА

Лалын шашны сүмийн өмнөх чөлөө дээр түүдэг гал дүрвэлзэн ноцож, олон цэрэг, тогоонд хонины мах, цагаан будаа чанаж байв.

Чингис хаан, сүмийн үүдний өмнөх нэгэн өндөр тавцангийн торгон олбог дээр сууж, түүнийг бие хамгаалагч цэрэг дарга нар хүрээлэн зогсжээ.

Өвгөдийн авчирсан Бухарын хөгжимчин олон аймаг угсааны дууч охид, нэлээд зайтай зогсоцгоож, янз бүрийн хөгжим үлээн дэлдэж, хэц хэнгэрэг цохино.

Сурвалжит имам, улемууд Монголчуудын морийг харгалзаж, тэвэр тэврээр өвс авчирч тэжээж байв. Чингис хааны хэлмэрч Махмуд Ялвач, хааныг бараадан, хамаг бүхнийг ажиглан харж суув. Ард нь пүүсийн гурван бичээч сөхрөн сууцгааж, өнгийн цаасан дээр зар, тушаал, монгол харуулыг нэвтрэх бичиг таталган бичиж байв.

Урт дээлтэй энд тэндээс зэвсэг зүүсэн нэгэн монгол цэрэг, сууж байгаа олон хүний дундуур өнгөрч, Махмуд Ялвачийн дэргэд ирээд чихэнд нь шивнэн;

— Миний туршуулын цэрэг, нэг өндөр малгайтай, бөө байдалтай хүнийг нэг жаал хүнтэй хамт барьж ирэв. Алах гэтэл, тэр бөө «бидэнд гар бүү хүр. Махмуд Ялвач манай анд» гэж монголоор хэлжээ. Бөө, тариачныг ер нь уучлах гэсэн тушаал бийн дээр, таны анд гэх тул би, тэднийг түр хүлээлгэв. Хэрхэх вэ гэвэл,

— Авчир гэж хэлэв.

Удалгүй, тэр монгол Хажи Рахим, Туган хөвүүн хоёрыг дагуулж ирэв.

Махмуд Ялвач, тэр хоёрыг бичээч нарын хамт хивс дээр суу гэж гараар дохиод, Чингис хаан, ямар их найрт боловч, ер согтож, ухаан балартахгүй, сэргэг байдаг тул Рахим нарыг үзээд, Махмуд Ялвачийг нүдээр дохиолон дуудаад ойр нь очвол,

— Юун хүн бэ гэвэл Махмуд өгүүлрүүн;

— Намайг урьд таны зарлигаар цөл говийг туулж явтал дээрэмчинд шархтуулаад энэ хүн миний амийг аварсан билээ. Би

түүний ачийг хэрхэн мартах билээ.

Чингис хаан өгүүлрүүн;

— Чингэвэл, түүнийг хүндлэх нь зүйтэй. Харин ийм өндөр малгай өмсөж явдаг нь ямар учиртай вэ гэвэл;

Махмуд өгүүлрүүн;

— Эрдмийг эрхэмлэгч тэнүүлч лал хүн ийм байдаг юм аа. Энэ хүн ээрүүл мэт эргэлдэж чадна. Бас үнэн үгтэй хүн шүү.

Ийм хүнийг эгэл ард хүндэтгэж өглөг өгдөг юм аа, гэхэд,

Чингис хаан асууруун;

— Чингэвэл, тэр хүн миний өмнө ээрүүл шиг эргэлдэн бүжиглэг. Лал нар яаж бүжиглэдгийг үзье гэвэл,

Махмуд Ялвач Дервишид очиж,

— Манай эзэн, Дервишийн хэрхэн бүжиглэдгийг чамайг биеэр үзүүл гэж тушааж байна. Чингис хааны зарлигийг дагахгүй бол толгойгоо алдана гэдгийг чи өөрөө мэднэ. Би хөгжимдсүгэй. Хичээ, хичээ гэлээ.

Хажи Рахим, авч явсан аяга сав, дулдуйгаа хивсэн дээр тавиад хүрээлсэн олон галын дотор талбайд гараа дэлгэж Багдад хотын Дервишийн адил, баруун гарын алгыг доош хандуулж, зүүн гарын алгыг дээш хандуулж, Махмудын хөгжим үлээхийг түр хүлээтэл, Махмуд Ялвач, лимбэ авч, уяралтай дууг эгшиглэн аялгуу нь заримдаа хүүхэд уйлж байгаа мэт, заримдаа бялзуухайн шовшрох мэт лимбэдэв.

Хөгжимчин, хэц хэнгэргийг намуухан цохиж, Дервиш, хуучин чулуун шал дээгүүр чимээгүй тойрон гулгаж байгаад эргэлдэж анхандаа аяархан эргэлдсээр улам хурдсаж, урт дээлийн хормой нь шүхэрлэн эргэлдээд, лимбэ заримдаа энэлэнтэй мэт, заримдаа айсан мэт эгшиглэн, заримдаа дуугай болж, ганцхан хэцийн дуу дүнгэнэн, чингээд, дахин лимбэ эгшиглэж, Дервиш нэг дооров ээрүүл мэт түргэн эргэлдэн алгаа дэвсэж, ядран унасанд цэрэг ирж, тэтгэн босгоод, бичээч нарын дэргэд суулгав. Чингис хаан өгүүлрүүн;

— Бухарын бүжигчинд, толгойн эргээг гаргах аяга архи шагнасугай гээд, манай монгол бүжигчин үүнээс илүү үсэрч, илүү чанга, зугаатай дуулна. Одоо, бид, монгол дуучны дуулахыг сонсъё гэвэл, талбарын дунд, хааны өмнө нэг залуу, нэг хөгшин монгол гарч ирээд, өөд өөдөөсөө харж суугаад залуу нь эхэлж,

Эмнэг сайхан гүү маань

Ижил сүргээ санаж,
Газар цавчлан дэвхцэж,
Гуньхран янцгааж байна.
Түмэн олон бэрээд маань
Төрсөн эхээ дурсаж,
Галт нүдэндээ нулимстай
Гашуудан гиншиж сууна гэхэд

Тойрон шахалдаж суусан монголчууд

Зээ миний алдар, баялгаа

гэж түрж,
Хөгшин монгол дуулруун;

Дов толгодын дундуур
Догшин хуй мэт давхивал,
Хээр талын морины
Хэр чадал хурд нь мэдэгдэнэ.
Хаан эзнийг дагаж,
Хагас ертөнцийг туулбал,
Хээр талын цэргийн
Хэр чадал баатар нь мэдэгдэнэ

гэхэд
Бүгд монголчууд,

Зээ миний алдар, баялгаа,

гэж түрээд, залуу дуучин дуулруун:

Сайн морио унавал,
Саруул тал ойрхон
Самуун дайсныг дарвал,
Сарних дайтах зогсоно

гэхэд нь
Монголчууд дахин түрлэг хийсний дараа хөгшин монголын бас дуулсан нь:

Хаан Чингисийг
Харсан бүхэн танина.
Хамаг дэлхий дээр
Харин ч ижилгүй баатар даа.
Чингис хаанд бид
Чимээтэй дуу бэлгээ өргөе

гэхэд,

Монголчууд дуу бэлгээ өргөө гэж хашхиралдав. Цугласан

— Өнөөдөр бид сайн цэнгэлдэнэ гэж хашхиралдаж, бүгдээр алгаа ташиж, хашхиран гууглаж исгэрэлдэв.

Олны дундах чөлөө дээр бүжигчийн гарч ирээд, өөд өөдөөсөө харж хоёр эгнээ болж, хэц цохин дуулахад: Бүжигчин нар бүжиглэн эхлэн ноцолдох баавгайг дуурайн хөлийн улаар харилцан бие биеэ чадамгайгаар цохиж, бас сэлмээ суга татан, ноцож байгаа галын улаан дөлөнд болд сэлэм гялалзуулан өндөр өндөр харайлган бүжиглэв.

Чингис хаан, хатуу шар сахлаа, атгаад, цог мэт нүдээ цавчилгүй дув дуугай хөдлөлгүй сууж байв.

Бүжиглэх, бархиралдах чимээ гэнэт зогсож, нэгэн дуучин, Чингис хааны дурладаг сүрлэг дууг дуулруун:

Алтан өнгөт Онон
Ариун уст Хэрлэн
Саруул тал нутгаа
Сайхан монгол нутгаа
Санан санан дуулъя.
Ерэн улсыг юүлгэж
Ертөнцийг товрог болгоно.
Хаан Чингисийн хөвүүд
Хамаг олныг эзэлж,
Гал мэсийн аюул үхлийг
Газар бүрд буулгав.
Дөчин элсийг туулж
Цусан замыг нээж
Их багыг ялгалгүй.
Ирт мэсээр цавчиж
Урт монгол бугуйлаар

Орчлон дэлхийг бугуйлдав.
Тэнгэрийн догшин ташуур
Тэргүүн баатар Чингис
Түймрийн галын дунд
Түргэн зарлиг буулгасан нь:
Араанд нь чихэр зуулгана.
Ард нь алт өмсгөнө.
Хамаг бүгд минийх,
Халтирч айхыг мэддэггүй би
Газар дэлхий бүхнийг
Ганзагандаа торгоно.
Хөл сайт морьд минь
Хөөрөн урагшаа хөдөл,
Хар сүүдрийг чинь үзээд,
Хамаг амьтан сүрдэнэ.
Адгийн далайн долгионд
Аргамаг хүлгээ угаатал
Шуурган ширүүн довтолгоогоо
Шууд зогсохгүй...

гэхэд

Чингис хаан, дуртай дуугаа сонсоод биеэ займарч, бүдүүн сөөнгө хоолойгоор дагаж аялан, нүднээс нь том нулимс ширүүн шар сахал дээгүүр нь бөмбөрөн унаж, булган дээлийн хормойгоор нулимсаа арчиж, нэг алтан динар зоос дуучинд хаяж өгөхөд нь сурамгай тосож авааД хөсөр сөгдөв.

Чингис өгүүлрүүн:

— Алс холын Хэрлэнг дуулахыг сонсоод, элэг минь эмтэрч уярав. Одоо баясахыг хүснэ гээд Махмуд Ялвачийг дуудаж, чи энэ дуучин охидод хэлж, надад аятайхан дуу дуулуулж, намайг баясуул гэвэл, Махмуд өгүүлрүүн;

— Би эзний ямар дуунд дуртайг мэдэх хойно эдэнд хэлж өгье гээд Махмуд Ялвач, бөөгнөрөн зогсож байгаа Бухарын эмэгтэйчүүдийн зүг их зантайгаар очоод,

— Та нар бэлтрэгээс салсан өлөгчин чоно шиг улин дуул. Өвгөд мөн дагаж гингэнэж гинш, эс тэгвэл таны шинэ эзэн хилэгнэж, үстэй толгойг чинь салгана... гэвэл, эмэгтэйчүүд цурхиртал уйлав.

Махмуд Ялвач, төв байдалтай эргэж ирээд, Монголын эзний дэргэд суув.

Эмэгтэйчүүдийн дотроос хөх чалма малгай, эрээн судалтай урт дээлтэй нэгэн бяцхан хөвүүн гарч: «Битгий ай! Би дуулъя!» гэж хонгор сайхан хоолойгоор дуулж эхлэв. Тэр дуу нь шажигнан ноцож байгаа галын чимээ, агт морин хуухираан, хэцийн хүнгэнэх дуун дундуур нам гүм болсны талбарт уяралтай сонстож,

Баяр цэнгэлийн туйл
Бадарсан цэцгийн орон минь
Сайхан цэцэрлэг чинь шатаж
Сайр цөл болон хоцров хө.
Хотол сайхан орныг минь
Хонин дээлт монгол захирч
Хоресм чи шархдаад,
Хохирон цус урсгаж сөнөв хө

гэж дуулахад олон эмс түрэн дуулсан нь:

Олзны эмс хүүхдийн
Орилон уйлах нь сонстон оо

гэхэд талбарт байсан Бухар өвгөд бас Эвий Хоресм минь, эвий Хоресм минь! гэж гиншин гасалж, тэр залуу хүү,

Цаст уулын оргилоос
Цалгилах Зеравшанд орсон гол
Хар нулимс, халуун цусанд
Гашуун амттай болов хө.
Ах дүү, эцэг өвөг минь
Хурмаст тэнгэрийг бүрхэв хө.
Хуйларсан хар утаа
Алалдааны газар үрэгдэв хө

гэхэд эмэгтэйчүүд мөн түрэн,

Олзны эмс хүүхдийн
Орилон уйлах нь сонстоно оо

гэж дуулсанд Бухарын өвгөд

Эвий Хоресм минь,
эвий Хоресм минь

гэж энэлэнтэйгээр тосож гашуудан бархирав.

Үүнд Махмуд Ялвач, өвгөдийг хялайн харж, дув дуугай ажигланхан суув.

— Энэ хүүхэд юу гэж дуулж байна. Өвгөн ямар учраас хайлан гиншиж байнам гэж Чингис хааны уяран уйлагнаж асуувал Махмуд-Ялвач,

— Таны хүсэн дурладаг ёсоор л дуулж байна. Дуулахдаа улсаа мөхөж сөнөснийг гашуудан дуулж, өвгөд цөм, Хоресмийн нэр төр хоосоор болов гэж уйлж, «эвий эвий Хоресм минь» гэж байна гэхэд нь, Чингис хааны хар царай үрчийн, том гэдсээ алгадан, чоноч том нохойн хуцах мэт тачигнатал хөхрөн инээж өгүүлрүүн;

— За, энэ дуу чинь надад сайхан байна. Тэр жаал хүүхэд бүр уйлж байгаа юм шиг, тун сайн дууллаа. Их Чингис хааныг инээж байхад ертөнц даяар уйлж байх болтугай! Өстнийг өвдөг дооров дарж байхад миний дайсан, эцэнхий хатанги хацар дээгүүрээ айсан нулимсаа гоожуулж, амь аврахыг гуйж байхыг харах дуртай билээ. Би ийм гашуудалтай дууг дахин дахин сонсох дуртай. Энэ хөвүүн хаанаас ирсэн бэ гэвэл,

— Энэ бол хүү бишь, Бухарын Бент Занкижа гэдэг охин буй. Бичиг номтой тул эрдэмтэй бичээч нарын адил чалма малгай өмсөж явдаг юм. Урьд Шагийн сударч түшмэдийн бичиг хуулах бичээч байсан билээ гэвэл, Чингис өгүүлрүүн:

— Тийм бол хосгүй олз байна даа. Үүнээс хойш миний найр дээр үргэлж энэ гашуун дуугаа дуулж, лал нарыг уйлуулж, намайг баясгаж байг. Бухараас олзолсон охидыг миний цэрэгт хуваан өг. Энэ охиныг үргэлж миний дэргэд байлга... гэжээ.

Махмуд өгүүлрүүн:

— Хаантан, чингэе гэв.

Тэндээс Чингис хааныг босоход тойрон суусан монгол цэрэг нэгэн зэрэг босоцгоож, дутуу уусан архиа дайчин тэнгэрт өргөн цацав. Чингис хаан өгүүлрүүн:

— Би явъя. Морь авчир. Таир хаан, энэ хотыг захиран суутугай. Түүнд бүгдээрээ захирагдвал зохино гэв.

Тал сарны зэвхий гэрэл задгай галын дөлийн туяанд Чингис хаан, өргөн цээжит хул мориндоо мордож, бие хамгаалагч жардын цэрэг нь, галын хооронд гүйж, Бухарын өвгөдийн сахиж байсан морин дээрээ мордоод удалгүй, олон морьтой хүмүүс, харанхуй гудамж руу орж чулуун шалтай их чөлөө дундуур тачигнатал давхилдан цував.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ : ХОРЕСМД ДОГШИН САЛХИ САЛХИЛАВ

Бууж өгөгсөд зовлонд учирдаг.
Бид, тэдний толгойг чулуунд мөргүүлэн хага цохино.
Эсхүл, тэд, биднийг
Хотын хэрмээс дүүжилнэ.
(Персийн эртний шүлгээс)

Өгүүлэх нь: Морьт цэрэгт Чингис хааны тогтоосон нарийн цааз журам байж, цэрэг тутам, арван зуун, мянганд жагсах байраа мэдэж, мянган цэрэг нийлж зүүн баруун жигүүрийн дарга буюу монгол хаанаас тушаал авдаг түмт ноёнд захируулах том баг цэрэг болдог байжээ.

Хөлтэй баян Бухар хотын зүг зовхис, гудамж бүхэнд монгол цэрэг давхилдан, Бухарын өвгөд, зууч болж дагалдан, худалдаа хийж явсан лал худалдаачин хэлмэрчлэн давхилдаж, гэр орондоо эмээн хоргодсон хотын олонд Бухар хотын шинэ эзний тушаалыг өндөр дуугаар хэлмэрчлэн зарлаж, гудамжны уулзарт эмх замбараатай байдлыг хянан сахих монгол цэргийн харуул гарч ирэв. Бухар хотын монгол дарга Тайр хаан, гол сүмд буугаад, Чингис хааны тушаасан ёсоор Бухар хотын тэргүүлэгч нарыг зарлан дуудаад, Ошаг хотын баячуудын бүртгэлийг гаргуулж, Хоресм Шагийн цэрэгт хэрэглээр базаасан хоол хүнс агуулах нууц газар, энгийн хүмүүсийн эд бараа бүхий дэлгүүр, бараа агуулах газар зэргийг хэлүүлж авав.

Хотын зүг бүхнээс ачаатай тэмээ, морь тэрэг гол чөлөөний зүг цувж, айн сүрдсэн хотынхны шуудай шуудайгаар будаа, тэвэр тэврээр бүс бараа, хувцас хунар, хивс, үнэтэй сав суулга зэргийг авчран тушааж, сүмд хураахад нь гурваны нэгэн хувийг Монголын эзэн Чингис хаанд ялгаж байв. Хотынхноос ажил хийж чадахуйцыг нь утасны чинээ улаан голоо тасран тасартал алалдан, бууж хэрхэвч өгөхгүй гэж шийдсэн зоригт Ихтиар Кушлугийн батлан суусан цайзыг тойруулан ухсан гүнзгий гууг булуулахаар явуулжээ. Цайзыг хамгаалагсдын дунд Чингис хаанаас оргож, Хоресм шагийн талд орсон Гүр хаан гэдэг монгол баатрын зэрэг хаад байжээ.

Монголчууд үй олон хөгшин залуу бухарыг тэр гүн гууг хэрхэн мод шороогоор булж байгааг харж шавдав. Хоёр хоноход цайзын

хамгаалагч цэргийн байсан өндөр хэрмийн дэргэд хүрч болохоор болж ирэхэд Бухарчууд,

— Бид, ажлаа түргэн хийсэн. Одоо монголчууд, өндөр хэрэм дээр аль хэр түргэн гарахыг үзье гэж ярилцав.

Монголчуудын тушаалаар Бухарын мужаан олон урт шат хийгээд, монголчууд, олон Бухарыг ташууураар нүүр нүдгүй ороолгож, та нар, аль цагийг хүлээж байна. Юу харж байна. Шат тавиад хэрэм өөд авирцгаа гэж хавчив.

Доош нь тоосго туйпуу унагааж, буцламгай ус, давирхай асаж байгаа хэрмийн дэргэд ойртохоос Бухарыг бэрхшээж байтал Монголчууд, хойшоо ухарсан Бухарыг илдээ суга татан мориор шахаж, хэрмийн зүг түрээд тархи толгойгүй цавчив. Бухар нар, гараараа толгойгоо халхлан ухасхийж, хойноос нь монгол цэрэг хөөж, гар хурууг нь тас цавчлав. Хэлмэрч нарын Бухарыг хэрэм дээр авиран байлд гэж ятгахад зарим бухар хүн,

— Хэрэм өөд авирсан ч үхнэ, эндээ байсан ч үхнэ.

Хэрэм өөд авирч өөрсдийн цэрэгт ойртож үзье. Биднийг өрөвдөж байлдахаа зогсож магадгүй гэж шат авч, хэрмийг түшүүлэн тавиад авиран гаргахдаа,

— Бид, та нартай адил, лал хүн байна шүү. Зэвсгээ хураалгаж бууж өг өө гэж хашхирцгаан авирав. Тэднийг, хэрэм дээр байсан цэрэг ойр ирүүлээд том мод өнхрүүлэн шатыг унагааж, чулуугаар цохилоо.

— Та нар зүрхгүй нохой. Буцацгаа. Монголчуудыг балба. Бидний бууж өгөхгүй, журамт эрийн ёсоор байлдсаар үхэхийг үз. Дайсныг бүү дага гэж хашхиран, хэрэм дээр зогсож байсан монгол баатар Гүр хаан, том том чулуу чулуудаж, — Танай монгол энэ номхон хонь шиг амьтны ард нуугддаг нь ямар учиртай юм бэ. Эр чадлаа үзүүлэхээ яасан юм бэ. Хүүхдийг иддэг шар нохой, хүйтэн царайтай өвгөн Чингис хаан, хаана хоргодсон бэ гэж хашхирч, сэлмээр үхэн цавчилдаж, хугарахад нь сүхээр цавчилдаж, дороос шатаар авиран гарагсдыг унагааж байлдсаар, монголын суманд оногдож унав.

Тэр завсар, Монголчууд, Хятадын чөдөр оньсыг хэрмийн ойр ирүүлж, олс давирхай түрхсэн галт том том сум, шатаах юмтай ваар бөмбөг, чөдөр оньсоор харваж, цайзад гал гаргав.

Цайзыг арван хоёр хоног бүслэн байлдаж, цэргийг нь бараг хядаад, цөмрөн орж, түймэрт хуйхлагдан амьд үлдсэн хэдхэн цэргийг

барьж аваад, дөрвөн зуухан хүн, Монголын төчнөөн их цэргээс цайзаа хамгаалж байсныг мэдэж, их л гайхаж билээ.

Тэр дөрвөн зуун хүн, байлдсаар үхэвч бууж өгсөнгүй билээ.

Хэрэв Бухар хотыг бүх хүн, хотын өндөр бат хэрэм дээр гарч, хатуу зоригтой байлдсан бол Монголчууд, эртний Бухар хотыг хагас жил байтугай, бүтэн жил боловч байлдан эзэлж чадахгүй асанжээ. Бухарчууд, өөрсдийн муугаар гашуун зовлонг эдлэхгүй асанжээ. Үүнийг үл өгүүлэн өгүүлэх нь: Бухар хотын ард олон, өөрсдийн өргөх юмыг авчирч, сүмийг дүүргэвэл бас шинэ тушаал гарсан нь:

«Бүх хотын хүн, гэр хөрөнгөө орхиж, эхнэр хүүхдийн хамт өмссөн хувцаснаас өөр юү ч авалгүй хотын гадна гарцгаа» гэжээ.

Олон хэлмэрч, хотынхонд тушаалыг тайлбарлахдаа:

— Та нар гэр хөрөнгөндөө битгий зовцгоо. Харуул манаа гаргаж, танай гэр хогшлыг хамгаалан, алба татварыг зөв тэгшитгэн ноогдуулахын тулд та нарыг бүртгэх гэж гаргаж байгаа юм шүү.

Харин тушаалыг зөрчиж хоцорвол зогсоогоор ална шүү гэжээ.

Бухар хотынхон өглөөнөөс бүгдээр цувж, эцэг нь багачуудаа хөтөлж, эх нь хүүхдээ тэвэрч, олон жил, байшингийн мухраас гадагш гарч үзээгүй, уналуудтаа хүрсэн өвгөд эмгэд хүртэл бие биеэс зууралдан гэлдэрцгээв.

Монголын морь эргүүл, гудамж зээлээр давхилдаж, хашааны хаалгыг дэлдэж, бэр халь, хош халь! бушуул, хурдан хөдөлцгөө гэж шаардан хашхирч, хотынхон, арван нэгэн хаалгаар гадагш гараад хотоо тойрон хүрээлж, харуулын цэрэг, хүнийг гэдрэг нь хотод оруулахгүй байв.

Хотын гадна цугласан тэр олныг үзвэл «эрхэм Бухар»-ын хүн амьтан, Монголчуудаас хоёр гурван хувь илүү олон байсан нь мэдэгдэв.

Монголчууд хэлмэрчтэй явж, цугласан олноос уран дархан хүн бий эсэхийг асуугаад, сайн урчуудыг ялгаж аваад залуу чийрэг эрсийг бас тусгай ялгаж, морьтой цэргээр хүрээлүүлэв.

Чингээд гуа эмс охид, хүүхдийг ялгаж авахад нь төрөл садан, эцэг эхээсээ үүрд ангижрах болсноо олон сая мэдэж, уйлан хайлан чарлаж эхлэв.

Малын зах дээр яргачин, мөөрч байгаа үхэр, өрөвдмөөр майлж байгаа хонь ямааг ажиггүй сонгон авч, тас няс ороолгон нядлах газар аваачдаг шиг Бухарын шинэ эзэн нь явахгүй гэсэн хөөрхий хүмүүсийг

ташуурдан жанчиж, хүзүүнээс нь бугуйлаар оосорлож, морио гуядан чирч, олны дотроос суга татан аваачихад,

Бухар нар монголоос маш айн бэгдэрсэн тул, ер эсэргүүцэж чадсангүй. Зарим хүн, эхнэр охидоо Монголд чирүүлэн, тоос товрог болж явахыг үзээд, ухаан амьгүй, хойноос нь ухасхийгээд, морины хөлд гишгүүлж, төмөр бялуугаар тархи толгойгоо цохиулан унаж байв.

Бухараас хөөгдөн гарсан олны дунд медресе сургуульд олон жил сууж, шавь нартаа их эрдэм мэдлэгээ уламжилж байсан эрдэмтэн бас үзэгдэж, тийм хоёр эрдэмтэн, олны дотор зогсож, орчин тойронд ийм ёс бус хэрэг гарсныг үзээд, сэтгэл түвдэхгүй,

— Энэ буруу номтныг сүм дуган дээрэмдэж, ном судрыг мориныхоо хөлөөр гишгүүлж, нялхсыг булаан алж, эцэг эхийн дэргэд охиныг нь хүчирхэж байхад, би үүнийг хэрхэн тэсвэрлэх билээ гэж эрдэмтэн хэлэв. Нөгөө Рукн-Эд-Дин Имам-Задэ гэдэг алдар нэр нь хотод их алдаршсан эрдэмтэн тайтгаруулж,

— Дугуй бай. Тэнгэрийн хилэнгийн салхи дэгдэв. Салхинд хийссэн сүрэл болсон бид юү хэлэх вэ гэв.

Гэвч, өвгөн Рукн-Эд-Дин удтал хүлцэж чадсангүй. Эмэгтэйчүүдийг хэтэрхий хэрцгийлж байгааг хараад, биеэ барьж чадалгүй, хөвүүний хамт тэднийг өмгөөлөх гэж ухасхийгээд алагджээ.

Гэрийнхээ хүнийг доромжлуулан дарлуулахыг үзээд, мөн л хамгаалах гэж ухасхийж, Монголд нидрүүлсэн хүн олон гарав.

Тэр өдөр, ганц үхэж байгаа хүний бархирах, ёолох дуу, эцэг, нөхөр, ах дүү нараас үүрд ангижирч байгаа эм, хүүхдийн гашуудан уйлах дуунаас өөр юм сонстохгүй бэрх өдөр байжээ. Эрчүүд тусалж, тэнхрүүлэх аргагүй болсныг үзэхэд «илдийн хар ишийг сайн атгахгүй бол хурц ирийг нь барихад хүрнэ» гэсэн яруу найрагчийн үг санагдам байжээ.

Монголчууд эргэж ирээд, эзэнгүй болсон хотын гудамжаар явж, орон байшинг тэмтрэн нэгжиж, олсон дээрэмдсэн юмаа моринд ачаад, хотыг түймэрдэв. Эртний Бухар хот улаан дөл дүрвэлзэн улалзаж, хар утаа, гэрэлт нарыг халхлан баагив. Хотын барилга ихэвчлэн мод, шавар тул удалгүй их гал болж, ганцхан гол сүм, ганц нэгэн ордны тоосгоор барьсан хэрмийн төдий үлджээ.

Монголчууд, дүрвэлзэж байгаа галаас зайлж дээрэмдсэн олзоо гээж, хотоос давхиж гараад, Бухар хот олон жилийн турш ууль шувуу, цөөврийн орших хар хөө тортог болсон эвдэрхий балгас болсон билээ.

САМАРКАНДЫН ДАРГА НАР УРВАЖ, ХОТОО ИДҮҮЛЭВ

Хамаг бүхэн, таны ужид цэнгэлд үрэгдэж,
Хуруу хумсны будаг тань, будаг биш, цус.
(Рац Девпик)

Чингис хаан, (1220) луу жилийн хавар эрт Бухараас хөдөлж, Самарканд зүглэв. Их цэрэг, Зеравшан мөрний хоёр эргээр явж, энэ удаа Чингис хаан үл дагагсдыг төдий л хяхалгүй явсаар Серипуль, Давусие хоёр хот эс дагасныг бүслэн байлдах хэдэн баг цэрэг үлдээж, Самаркандад хүрээд, хотын гаднах Хоресмийн шагийн ("Хөх Сарай") буюу «ногоон ордон» гэдэгт бууж, удалгүй Чингисийн дөрвөн хөвүүний цэрэг хүрч ирэв. Бас ташууураар ороолгож, мал мэт туулгасан олзны хүн хүрч ирэв.

Монголын их цэрэг, хотыг завсар зайгүй хүрээлэн буув. Хоресмийн олон хотын дотроос, Самарканд хот хамгийн бэх бат нь билээ. Хотын хэрэм нь маш зузаан өндрөөс бас зүг зүгт хараатай өндөр цамхагтай төмөр хаалгатай ажээ. Хотыг хамгаалах цэрэг нэгэн бум нэг түмээс зургаан түм нь турк хэлтэн, их төлөв хивчаг, бусад нь Тажиг, гур, хар, хятад зэрэг аймгийн хүн ажээ. Бас догшин сүрт хорин заан байсныг Хоресм Шаг их л сүрхий болгодог байжээ. Түүнээс гадна, урчууд, тэдний боолын зэрэг энгийн олны сайн дурын цэрэг байгуулж болох байжээ.

Хэрэв Самарканд хотыг хамгаалахад Кайр хаан буюу Төмөр Мелиг мэтийн хашир, зоригтой жанжныг тавьсан бол хүнсээр тасраагүйд лав нэг жилээс наашгүй байлдан тогтож болох байсан билээ. Гагцхүү, Хоресм Шаг, Самарканд хотын цэргийн жанжинд олны сэтгэлд хүйтэн болсон эх Турхан хатны дүү, дээрэнгүй омогт бөгөөд жанжны эрдэмгүй авга Тугай хааныг тавьжээ.

Чингис хаан, хоёр өдөр хотыг эргэж, хэрэм далан, бялхмал устай гүн гууг нарийвчлан үзэж, сул газрыг ажиглан эрж, дайрах аргыг бодож явав.

Монголчууд, цэргийн үнэн хүчийг нууж, бүслэгдсэн хотынхныг айлгах гэж тууж ирсэн олзны хүнийг жагсааж, арван хүн тутамд нэг туг өгсөнд хотынхон холоос харахдаа дайсны тоо томшгүй олон цэрэг бүслэжээ гэж үзжээ.

Турк жанжин, Алп Эр хаан, Сиюнж хаан, Балан хаан, хивчаг цэргээ авч, хотын хаалгаар гарч, Монголыг дайран байлдаж тулалдав. Лал, нар, хэдэн Монголыг олзловч, мянгаад хүнээ алдаж, хэрэмдээ буруулан ороод, маргаадар нь хивчаг цэргийн зүрх үхэж, хотоос гарахгүй гэв. Самарканд хотын ард сайн дураар гэнэт гарч байлдахад, Монголчуудыг зоримог буруулсанд хойноос нь хөөн явсаар бүгсэн цэрэг дээр орж, зүг бүрээс бүгсэн монгол цэрэг гарч, буцах замыг хаан байлдаж хядаад, цөөн хэдэн хүн амь гарч, хотдоо эргэж ирсэн билээ.

Нөгөөдөр өглөө нь Чингис хаан, морь унаж, Самаркандыг байлдах цэргийг биеэр удирдаж, бүх цэргээр хотын хэрмийг бүслүүлж, хаалга бүхний тушаа, цэрэг жагсааж, хотоос байлдаар гарагсдыг маш хол харвадаг том хатуу нумаараа харван хядаж, Самаркандын зоригт эрстэй өдөржин байлдаад, орой хоёр этгээдийн цэрэг, тус тусын цэргийн хүрээнд эгэв.

Тэр шөнө, Самаркандын хамгийн их ямбатан тушаалтан их шүүгч (кади), хуврагийн тэргүүлэгч, Шейхи Уль-Ислам, сүмийн тэргүүлэгч ихэс имам, шөнийн турш зөвлөлдөн, үг дуугүй бууж өгөхөөр шийдэцгээж, өглөө нь хотоос гарч, Чингис хааны хүрээний зүг чиглэж, бүслэгдсэн хотыг өршөөхийг гуйсанд Чингис хаан, хилэгнэсэндээ эрсдүүлэхгүйг батлан хэлж, гэр гэртээ буцахыг соёрхож, элч нар баярлан хотдоо буцацгаав. Зоригтой эрсийн баг цэрэг, цайзад батлан орж бусад хивчаг хаад бүх цэргийн жанжин Тугай хааж тэргүүлэн, Монголчуудад яаран мөргөөр очиж, Монголын албанд орохыг гуйсанд Чингис хаан, өршөөнгүйгээр инээмсэглэж зөвшөөрчээ.

— Зургаа хоносны өглөө, хотын их «мөргөлийн хаалга» гэдэг их хаалга нээгдэж, Монголчууд, Хоресм Шагийн нийслэлд нэвтрэн ороод олзлогдогсдыг хөөж ирээд хэрмийг нурав гэж тушаав.

Чингис хаан, Самарканд хотод ямар ч хор хийхгүй гэж амлавч, Монголчууд, хотын эр эмийг зуу зуугаар салгаж, гадагш гаргаад, тас тонож дээрэмдэж, хүчирхэцгээв. Үүнд ганцхан кади Шейхи-Уль Исламын төдий урвасан цөөн этгээдэд гар хүрсэнгүй.

— Хотын олныг хотоос гарахгүй, гэртээ нуугдан үлдвэл алахад ял хэлэлцэхгүй болго гэж зарлаад Монголчууд тэр тушаалыг далимдуулан, энгийн номхон ардыг их л алж билээ.

Хоресм шагийн авга Тугай хаанаар толгойлуулсан Хивчагийн гучин мянган цэрэг, эхнэр хүүхдийн хамт дайсныг үйлчлэхээр хотоос гарч, зэвсгээ хураалгаж, монгол зэвсэг олгохыг түр хүлээсүгэй гэж

тушаасныг дагаад, бас, Монголын албанд нэгэнт орсон учир, монгол янзтай байх ёстой гэж толгойн үсийг нь хагас сарны хэлбэртэй хусаж, нэгэн хөндий зааж буулгав. Тэнд асар майхныг шааж, эхнэр хүүхдийнхээ хамт сууж байтал нь хойд өдөр нь гэнэт монгол цэрэг дайран орж цөмийг хядаад эд хөрөнгийг нь талан авсанд амьд үлдсэн нь алагдсан Хивчагийг байлдах байтугай, зугтах ч зүрхгүй байсан» гэжээ.

Тэр шөнө, цайзад батлан суусан Алп Эр хаан тэргүүтэй нэгэн мянган зоригтой эрс, Монголын бүсэлсэн цэргийг сэтлэн байлдаж, шөнийн харанхуйгаар монгол цэргээс зайлж, сүүлд Желал-Эд-Диний цэрэгт нийлсэн билээ.

Цайзын бусад цэрэг, дайсантай тулалдсаар Монголчууд тугалгаар урлан үйлдсэн гулдрал бүхий Жакердиз гэдэг сувгийн хашлагыг эвдсэн учир, ус, цайзын орчин тойронд үерлэж, хэрмийг нураасан энэ үесээр Монголчууд нэвтрэн орж, тохиолдсон бүхнийг хяджээ.

Хотын гадна гаргасан олны дотроос алс хол монгол нутагтаа аваачих гэж, чадамгай урчуудыг ялгав. Гар урчууд, даавуугаар хийдэг цагаан цаас, бас хоргой, торгомсог, майхан, элдсэн шир, эмээл хазаарын хэрэглэл, том зэс тогоо, мөнгөн төмөрлөг хундага, хайч, зүү, зэвсэг нум, хоромсого зэрэг үнэтэй эдлэл хийдэг алдартай урчууд байжээ. Шилдэг уран хүнийг Чингис хааны хөвүүд ураг төрөлд нь боол болгож, монгол газар явуулсан учир, хожим урад айл суурин бий болжээ. Бас хожим Самаркандаас элдэв зүйлийн уран дархан, чийрэг залуу ажилчныг байн байн авчирсаар Самарканд хот, түүний харьяа муж нь хүн амьтангүй шахам болжээ.

Самаркандын цайзыг эзэлж аваад, Чингис хаан, газар сайгүй үхсэн хүний хүүр болсон хотоор явж үзээд, хотын гаднах ордондоо буцаж, тэсэхүйеэ бэрх халуунаас сүүдэр ихт цэцэрлэгт нь хоргодон суув. Самарканд хотын олон хүүр өмхийрч, аймшигтай үнэр гарахад амьтны суухын эрхгүй болж билээ.

ХОРЕСМ ШАГ, АМАР ЗАЯАГАА ҮЗЭХЭЭ БАЙЖЭЭ

Хүний зориг мохоход,
Морины хөл цуцна.
(Дорно дахины цэцэн үг)

Өгүүлэх нь; Монголыг Хоресмийн газар орныг дээрэмдэж бүхий үес, Шаг Мухамед, хөндий хол байж, Жейхун мөрний эрэг дэх Келиф гэдэг хотыг цөөн цэрэгтэй эзлэн сууж, хэрэг хааш болохыг хүлээж,

— Би монголыг Жейхун мөрнийг гатлуулахгүй. Мөд Иранд их цэрэг элсэж, аюултай тэрсийг үлдэн зайлуулна гэдэг байжээ.

Мөрний дундах мөргөцөг хадны орой дахь нарийхан цамхагт жижигхэн хавтгай овоохой шахцалдаж, эртний чулуун хэрэм, түүнийг муруй сарий тойрчээ. Хоресм шаг, тэр газар уйтгарлан санааширч суудаг байв. Цамхгийн орой дээр үргэлж харуулын цэрэг сахиж умар зүгийг ширтэн хардаг байв. Шөнө алсын толгодоор гал улалзаж, өдөр утаа баагьж, Дайсны цэргийн явах мэдээ нэвтрүүлдэг байжээ.

Заримдаа Мухамед, шантайсан өндөр хамартай болхи онгоц шахцан дүүрсэн мөрний дэргэд очиж, хадан халил эргийн дундуур багтаж ядан сүрхий ширүүнээр урсах булингар усыг үздэг байлаа. Шагийн цэргийн ихэнх нь Жейхун мөрний нөгөө талд уван цуван гарч тэртээ толгод дээрээс эртний Келиф хотын барилга харагдах ажгуу. Эрт урьд ялагдашгүй баатар хоёр эвэрт Искендер цэрэгтэйгээ, элгэндээ хий оруулсан ямааны тулам уяж, ширүүн урсгалт мөрнийг гаталсан гэдэг билээ гэж хардаг байжээ.

Тэндээс Хоресм Шаг, Самаркандын бүслэгдсэнийг сонсож, хоёр удаа туслах цэрэг явуулсан нь анх нэг түм, дараа нь хоёр түмэн морьт цэрэг явуулсан боловч, тэр цэрэг нийслэл Самаркандад хүрэх зүрхгүй Келиф хотод эргэж ирээд Самаркандын бууж өгөх нь өнөө маргаашгүй болсон тул тусалсан эссэний ялгаагүй боллоо гэж ирсэн билээ.

Нэгэн өдөр Келиф хотод Инанч Хаан, Бухараас шөнө гарч мордсон, шархдаж зүдэрсэн хоёр зуун цэрэгтэй давхиж ирэв. Татар цэрэг, тэднийг хөөж, Жейхуны эрэг дээр бараг бүгдийг хядсан учир, цөөн хэдэн хүн амь гарч ирсэн нь тэр билээ. Тэр амьд ирэгсдийн дунд өнөөх Курбан Кичик ирэлцжээ.

Хоресм Шаг, Бухарыг хамгаалахаар үлдээсэн төчнөөн их цэрэг, ямар ч тус нэмэр, нэр сүргүй хядуулсныг сонсоод, тун ч хирдхийж, хэчнээн болтол бодох тушаах тэнхээ нь тасарч билээ. Чингээд, бас, шадар хаад тушаасныг нь дагахгүй, дуудахад нь ирэхгүй зайлсхийх байдал үзэгдэж, урваж, Чингис хаанд дагаж орсны мэдээ энд тэндээс ирэх болж, Хоресм Шагийн тогтоосон цааз суларч, засгийн эрх мэдлийн үндэс эвдэрч, харьяат олны шударгуу дагамтгай нь тоос мэт хийсэн арилах болсныг мэдэв.

Чингээд, Хоресм Шаг, том онгоцонд сууж, эр цэрэг, ширэн хайрцагтай алт мөнгө, эрдэнийн зүйлийг онгоцонд нь ачиж, хайрт хээр морийг онгоцонд хөтөлж гаргаад, дасаж дотно болсон өөрийн эргээс онгоцыг хөдөлгөж, мөрний урсгалын дагуу, маш түргэн явахад сэлүүрчин, онгоцыг нөгөө зүгт залж, сэлүүр хатгуур мод хэрэглэн хүчлэн сэлүүрдэж залав.

Тэр том онгоц, усан доорх чулуунд тээглэж, Ираны эрэгт хүрч чадсангүй. Чингээд, ордны сайд, онгоц сэлүүрдэж байсан өндөр горзгор цэрэгт Шагийг үүрч эрэг дээр гарга гэж тушаажээ. Тэр цэрэг, тарган Мухамедыг үүрч усан дотор янцаглан явсаар эрэгт хүрээд Шаг, чулуун дээр буугаад асууруун:

— Чиний нэр хэн гэдэг вэ? Хаана суудаг вэ гэвэл,

— Би, тариачин барлаг Курбан Кичик гэдэг. (Кичик гэж алиа гэсэн үг)

Би Инанч хаанаас түрээсэлж авсан алгын чинээ газар эхнэр хүүхдээ орхиж, цэрэгт мордоод Бухараас Инанч хааны хамт зугтаж гарсан. Тэр шөнө, хотоос сэмхэн гарч, Монголын хүрээг дайрахад би, Татаарын хааны шар цацрын яг урд тулж ирээд, хааныг цавчиж алъя гэтэл, манай цэргийг юу болсныг бүү мэд, айцгааж Жейхун мөрний зүг эмээн давхихад нь миний бор азарга намайг авч давхиад, бид дөнгөж, амь мэнд гарсан гэвэл, Шаг асууруун:

— Чамайг юунд Курбан алиа гэсэн юм бэ. Чамайг харахад тийм алиа хүн биш байна гэхэд нь Курбан:

— Намайг алиа гэж нэрлэсний учир гэвэл, би юмыг үнэнээр хэлэхийг хүсэвч, цагийг олж хэлж чаддаггүй, юуг нь хэлэх, юуг нь хэлэхгүй байвал зохихыг олж чаддаггүй дээрээс намайг амьтан алиа гэж бас үнэн үг хэлэв гээд зоддог хүн ч байдаг, би ч бас хариу зодолдоод байдаг хүн юм даа гэв.

— Чи намайг урьд ер нь харсан уу гэхэд,

Курбан өчрүүн:

— Хараагүй нь ч хараагүй дээ. Харин дурсаж явдаг сан. Хожим түшмэлийг «Шагт хэрэглэл нийлүүлнэ» гэж алба татвар гувчихад бид чамайг дурсдаг байсан даа... гэв.

Хоресм Шаг инээмсэглэж, Ордны сайдаас алтан динар зоос авч Курбанд өгөөд,

— Энэ цэрэг Курбан, надтай хамт яваг. Нүх шуудуу дээгүүр үүрч гаргахад чадамгай юм байна. Тэгээд бас над үнэн үг хэлж яваг гэвэл,

Курбан өгүүлрүүн:

— Эзэн таны зарлигийг дагая. Таныг үүрэхэд том шуудай будаа өргөхөөс ялгалгүй. Гагцхүү эргэж усыг гатлан гутлаа авах зөвшөөрлийг олгоно уу гэвэл, Шаг,

— За болно гэв.

— Мухамед мориндоо мордоод, туранхай урт хүзүүтэй, өндөр бөгтөр биетэй Курбан нойтон өмдөө өвдөгнөөс дээш шууж, эрдэнэс бүхий ширэн хайрцгийг эрэг дээр гаргахад туслалцаж байсныг харав.

Чингэтэл, онгоцныхон Курбаныг суулгаж, нөгөө эрэг өөд зүглээд, Хоресм Шагийг хээр морио унаж, эгц замаар өгсөж явтал, мөрний эрэг дээр үймээн шуугиан болж, алс умар зүгт таван хэсэг утаа суунаглаж, цөм тэр зүг зааж, дайсны их цэрэг айсуйг мэдэгдэж байгаа түгшүүртэй тэмдэг ажгуу.

Мухамед, үзмэгц хашхиран,

— Байдаг онгоцоо урсгаж зайлуул. Татарыг энэдтээ битгий гарга гээд хээр морио шавдан гуядаж зугтав.

* * *

Зэв ноён Сүбээдэй баатрыг хоёр түмэн цэрэг дагуулж, Хоресм Шагийг нэхсээр Жейхун мөрний эрэгт хүрч гатлахад нь хэн ч хориг хийсэнгүй.

Эрэг хавьд хүн амьтангүй. Келифийн хүн цөм дүрвэн зугтжээ. Мөрний захад онгоцгүй боловч «зогсолгүй давш» гэсэн Чингис хааны тушаалыг дагаж Татаарууд, модоор том том тэвш шиг онгоц хийж, үхрийн ширээр бүрээд, хамаг зэр зэвсэг, хувцас хунараа ачиж, морио усанд хөөн оруулаад өөрсдөө сүүлээс нь барьж, бас онгоцоо биеэсээ холбож, морь нь хүнийг, хүн нь онгоцоо чирч, ганцхан өдөр татар цэрэг цөмөөр түргэн урсгалт Жейхуныг гатлав.

Тэр завсар Хоресм Шаг, нэлээд хол зугтан зайлж, Мухамедыг дагаж явсан цэргийн их дундуур нь хивчаг билээ. Шагийг хорлох гэж сэмхэн хуйвалдсаныг нэгэн хүн сэрэмжил гэж Шагт сануулсан учир, шөнө бүр унтах асраас мэдэгдэлгүй гарч, өөр газар унтдаг байжээ. Нэгэн өглөө үзэхэд асрын эсгийг хивчаг сум учиргүй сийчсэнийг үзээд, Хоресм Шагийн айх нь улам их болж, хааш явж амь гарахыг мэдэхгүй, дэмий л ийш тийш явж, зам гудасын ард олныг хотоо бэхэлж, хэрмийг түшиглэ, бүү гадагш гарч байлд гэж явсан учир, ард олон нэн ч айж, ууланд дүрвэж гарах хүн олон болов.

— Мухамед, уул түшсэн Нишапур хотод хүрч ирээд, сая уйтгараа сэргээх гэж, хурим той, найр зугаа хийв.

Татар, Мухамедын мөрөөр нэх нэхсээр Нишапурт ойртсон мэдээ ирэхэд Мухамед, авд мордоно гэж хуурмаглан хэлээд, нэгэн бяцхан баг цэрэг дагуулж буруулан зугтжээ.

Татар, Нишапурт хүрч ирэх зуур Тус Зава, Рейн зэрэг хэдэн хотыг идээд... Нишапурээс хэд хэдэн баахан баг цэрэг зүг зүг гаргаж, Хоресм Шагийн чухам хааш зугтсаныг сураглан явуулж, зам тохиолцсон хот тосгон бүрийг дээрэмдэж, талан түймэрдээд эхнэр хүүхэд, өвгөд хөгшид гэж ялгалгүй хядав.

Мухамед, тэр завсар, ихээхэн цэрэг элсэж, Хаматаны орчим, мөн Даулетабадын тал газар хоёр түмэн морьт цэрэгтэй болсноо Татарт гэнэт бүслүүлж, цэргийн их дундуурыг хядуулаад, Мухамед, тариачны хувцас өмсөж, нэгэн баз, чийрэг морь унаж байлдсан нь, Хоресм Шагийн Татартай сүүлчийн уулзан байлдсан нь байжээ. Татаарын хүч лалынхаас илүүгүй боловч, Шаг гагцхүү хар амиа бодоод дайсныг ялж чадсангүй.

Хэдэн татар, Шагийг танилгүй харваж, морийг нь шархдуулсан боловч, давхиж, ууланд гараад нуугдсан тул, Татаарууд, Хоресм Шагийг бараа туруугүй алджээ.

Тэндээс Татар, баруун тийш явж, Зенжан, Казвин тийш хандаж, Беги-Текин, Хүч бух хааны хоресм цэргийг дараад Азербайжан, Муганы тал тийш чиглэж, гүрж нартай байлдав.

Татар, хүрсэн газартаа түдэлгүй, хэрэглэх хүнс, хувцас авч, алт мөнгийг олзолж аваад, цааш замнаж, Чингис хааны чухал захиаг санаж, өдөр шөнөгүй түр буудаллан явсаар, Хоресм Шаг, Мухамедын мөрөөр мөшгөн хөөжээ.

Хүн нутагласан газраас Татар, сайн морь дайчилж, унаа залгаад, цэрэг бүхэн хөтөлгөө морьтой, зарим нь хэд хэдэн морьтой ч явж, морины гүйдэл дундуур, хөтөлгөө морио явуут юүлэн унаж, саадгүй яван нэгэн хоногт маш хол газар явж, Монголын цэрэг ирнэ гэж зүүдлээгүй байсан газар, санамсаргүй гэнэт хүрч ирдэг байжээ.

АБЕСКУН ТЭНГИСИЙН АРАЛ ДЭЭР

Хэн, цэргийг минь эгүүлж, дарагдсаны өшөөг авч өгөх вэ?
Хэн, газрыг минь дайснаас эгүүлж авч өгөх вэ?

(Турк домгоос)

Мухамед Шагийг Дианууйн цөллөгт хүрч, Амол хотын хавьд сэмхнээ нуун буудаллахад нутгийн ноёд ирж хүндэтгээд, хүчнээ өгөхөд бэлхнийг илэрхийлэв. Шагийн цэргүүд урьдын олон бараа бологчдоос бараг үлддэггүй. Ихэд ядарч өвдсөн хаан, ахмад их ноёдтойгоо зөвлөж, мохож цөхрөн:

— Надад Монголчуудын аянгаас амсхийх тийм амгалан газар энэ дэлхий дээр олдох уу? гэж асуувал, бүгдээр зөвлөлдөж, хаантан, өөрөө завинд сууж, Абескун тэнгис (гэдэг Каспийн тэнгис)-ийн нэгэн арал дээр хоргодох орон олохоос өөр сайн аргагүй гэсэнд хаан Мухамед тэр саналыг дагаж, Абескун тэнгисийн хүн амьтны мөр ул ч үгүй, нэгэн өнчин арал дээр очив.

Удалгүй тэр арал дээр Мухамед хааны хөвүүд Озлаг-Шаг, Ак-шаг, Желал-Эд-Дин гурав ирэв.

Хоресм Шаг Мухамед, тэнд бага настай Озлаг-Шагийн оронд урьд хавчин доромжилж агсан Желал-Эд-Динийг дахин хаан ширээ залгамжлуулах зарлиг буулгаад,

— Одоо ганцхан Желал-Эд-Дин, улсыг аварч чадна. Желал-Эд Дин, дайснаас айхгүй, харин дайсантай тулах гэж явдаг эр. Желал-Эд-Диний ялахад Аллах тэнгэр миний сүр хүчнийг дахин бадруулбал, би өөрийн газар дан ганц өршөөл үнэнийг дэлгэрүүлсүгэй гэж тангараглаад, өөрийн алмаас эрдэнийн бариулт илдээ Желал-Эд-Диний бүсэнд зүүж, «Султан» цол шагнаж, дүүд нь ахдаа морь нохой мэт хүчнээ өгч үгийг дагаж явахыг тангарагла гэж тушаав.

Султан Желал-Эд-Дин, Хоресм шагийн илдийг авч өгүүлрүүн:

— Би Хоресмийн төрийг Монголд эзлэгдсэн цагт хүлээн авлаа. Би, Хоресмийн их цэргийг их салхинд сарнисан шар навч мэт зүг бүр сарнин тарж, ганцхан нэр нь үлдсэн үед цэргийг захирах тушаалд орлоо. Хэдий тийм боловч, лал нутгийг бүрхсэн энэ харанхуй шөнө би уулсын завд байлдах гал асааж, сөс ихт зүрхтэн эрсийг цуглуулсугай гээд, эцэгтэйгээ салахын ёсыг гүйцэтгэж, нөхдийн хамт байлдааны газар эгж, Мухамед хаан ганцаараа Абескун тэнгисийн элст арал дээр хоцорлоо.

Болхи хийсэн завийг эргээс хөдлөхөд Хоресмийн хаан Мухамед элсэн дов дээр зогсож, уйтгартайгаар сэлүүрчин туркмен том бор далбааг босгож, хан хөвгүүд, Астрабадын ноёд, онгоцноо зогсож,

хараахан их хааны ширтэн харж байгаа тул элгээ тэврээд хааны зүг харж байв.

Онгоцны далбаа салхинд хийсэж, онгоц хөдлөн, тэнгисийн давлагааг хагалсаар манан будан татсан хөх уулсын зүг хурднаа холдон одож, Хоресмийн хаан Мухамед, эх нутаг, өнө эртнээс үймэн самуурсан албат ардаасаа бүрмөсөн тасарч, Монголчуудын довтлох шар үст Чингис хааны ширдхийн зэвүүцэм сүүдэр үзэгдэх алинаас ч айлтгүй болж, Мухамедын мөрөөр хөөсөн мохошгүй Зэв, Сүбээдэй хоёр ч хүрч ирэхгүй болжээ.

Чингээд, хязгааргүй мэлтийсэн тэнгисийн дунд өнгөрснийг гашуудан дурсаж, одоогийнхыг амгалангаар шүүмжлэн, ирээдүйг алгуурхнаар бодож болно. Астрабадын ноён Хоресмийн хаан Мухамедад элсэн толгодын хоорондэсгий гэр барьж өгөөд, шуудай цагаан будаа, хонины өөх, ширэн хөхүүр, сүх, тогоо зэрэг чухал хэрэглэх юмыг хүргүүлж, бүхэл сар хүрэлцэх хүнс бэлтгэж өгсөн тул одоо Шаг хаантан, гуйлгачин Дервиш болж, хоол ундаа өөрөө хийж идэх болно гэж бодтол онгоц хэдийн холдсон боловч, Мухамед уйтгартай бодлого бодож, нэлээд гөлрөн зогсоод, далайн зөөлөн салхинд үлээгдэж, наранд шарагдан, халуун элсэн дээр хэвтэж зүүрмэглэтэл гэнэт сүржигнэх чимээ гарсанд сэрээд чагнавал; «том биетэй... бяртай дагаа...» гэж хэлэлцэх үг сонстов.

Энэ эзгүй цөл аралд юун хүн ярилцах бил ээ? Аанай, дайсан бол уу? гэж бодож өндийн харвал гүвээ дээгүүр ургасан бор бут өвсний хоорондуур хар нэхий малгайтай хүний толгой цухасхийгээд далд оров. Мухамед, биедээ ямар ч зэвсэггүй, нум сум, сүх нь гэрт байжээ. Хурднаа тэр гүвээ дээр гарч харвал, хэдэн нооронхой салбархай, хөл нүцгэн хүн, нэгэн зурвас шавартай газрыг туулан гүйлдэж, тэдний дунд дөрвөн мөч нь мухар нэгэн муухай амьтан бас хазганан явахыг үзээд, би Астрабадын ноёнд огт хүнгүй цөл арал олж өг гэж тушаасан билээ. Энэ хаанаас ирэв гэж дотор аягүй болж, даруй гэрийн зүг алхтал, гэрээс нь утаа багсарч, гэрийн өмнө хачин муухай арваад амьтан хагас дугариглан сууж, бараг хүн дүрсээ алдсан, онгойсон яр шарханд баригдсан улаан хоншоортой амьтан байдаг нь юу бил ээ? гэж гайхтал тэдгээрийн нэгний,

— Чи хэн бэ? Юунд энд ирсэн бэ? Биднийг хараагүй хөөх тул, энэ арлыг ирж бид эзэлсэн билээ гэхэд нь Мухамед;

— Та нар хэн гэгч вэ? гэж асуувал, тэдний өгүүлэх нь: Бид Аллах тэнгэрийн хилэнг хөдөлгөж, авралаас хагацсан хүмүүс. Өнөө өдөр бид энэ арал дээр загасчлахаар ирэв. Чи харахгүй байна уу? Бид цөм уяман гэдэг анааж болдоггүй хүнд яр өвчнөөр өвдөж, амьд боловч үхсэн адил болсон хүн. Харахгүй байна уу? Үүний хамаг хуруу нь унажээ. Түүний хөл нь өвдгөөрөө, гар нь тохойгоороо унажээ. Бас үүний нүд сох ширгэжээ. Түүний хэл нь тасраад, үг хэлж чадахгүй болжээ... гэхэд нь Мухамед, дуугай зогсож, алс эргийн зүг дурайж харласаар бараагүй болсон завиа бодов.

Тэд бас өгүүлрүүн: Бид Аллах тэнгэрээс аврал гуйн залбирснаар тэнгэр биднийг өршөөж, чамайг илгээжээ гэсэнд Мухамедыг би та нарт юугаар тус хүргэх вэ? гэсэнд сууж байсан тэр хүний дундаас бусдаас илүү өндөр бөгөөд хүчтэй нэг нь сүх барьж босоод өгүүлрүүн;

— Би энэ ах дүү нарын дотор шейхи ахлагч нь байна. Манай энэ муу заяатын аймагт бүхий хэн бүхэн миний үгийг дуугай дагах ёстой. Миний тушаалыг эс гүйцэтгэвэл ална. Чи эрүүл чийрэг хүн. Бид чамайг өөрийн аймагт багтаан чамаар тор чирэх, ус түлээ зөөх ажил хийлгэнэ.

Энэ бүгдийг манайхан бүгдээр хийж чадахгүй. Энэ гэрт Аллах тэнгэрийн авралаар бидэнд олдсон цагаан будаа гурил, тогоо шанагатай тос, хонины өөх байна. Одоо чи үүнээс хойш бидэнтэй хамт аж төрөх болно. Хувцсаа тайл. Чиний хувцсыг бид ээлжээр өмсөнө. Чамд одоо хувцас хэрэггүй гэсэнд Мухамед, урт сүүрс алдаад эргийн зүг эргэж гүйв. Энэхүү уяман өвчнөөр өвдөгсөд түүний хойноос хөөж, нэгэн гүвээ дээр гараад Шагийн юу хийхийг ажиглан харцгаав. Хоресм Шаг Мухамед, элсний дов дээр тэнгисийн долгионд эрэг дээр хаягдсан мөчир гишүү овоолж, гал түлж бөөн хар утаа багшран, огторгуйд мушгиран суунаглав.

«Энэ утаа, тэртээ эрэгт үзэгдэж онгоц ирэн намайг буцааж аваачих биз», «Тэнд дайн болж, Монголын морьт цэрэг давхиж явдаг боловч, эрүүл амьд хүн байдаг. Харилцан дайсан бололцож, гаслах зовох инээх хутгалдавч, энэхүү амьд үхдэлийн арлаас гарч, тэдний дунд суувал юутай сайхан бэ» гэж ганцаараа гүнгэнэн, гагцхүү өнөө манан татсан алс эрэгт явсан онгоцоо бодлоо.

Арван тав хоносны дараа урьд хэлэлцсэн ёсоор арал дээр нэгэн онгоц ирж, хэдэн сайн эрсийн хамт Хоресмийн хааны жанжин Төмөр Мелиг ирээд Шагийг нэлээд эрж, олбол, эрэг дээр чармаа нүцгэн

хэвтэж, толгой дээр нь хэрээ суугаад нүдийг нь ухжээ. Төмөр Мелиг, арлыг тойрон явж, айн нуугдсан өнөө уяман өвчтэй хүмүүсийг олж, энэ арал дээр юу болсныг асуувал, үүний урьд онгоцоор ирсэн улс, манай арал дээр орхисон энэ хүний өмнө газар сөхрөн мөргөж, Падишаг гэж өргөн дуудаж байхыг сонссон. Бид уяман өвчнөөр өвдсөн хүн, хаан Султаны өмссөн дээл өмсвөл, өвчин нь эдгэж, яр шарх нь анадаг гэж өвгөдийн хэлэхийг сайн мэдэх тул энэ хүний дээлийг тайлж авсан билээ. Бид энэ хүнийг хоол ид гэж дуудсан, мөн хоолноосоо өгсөн, идэхгүй ямагт гал түлж, энэ янзаар үг дуугүй хэвтдэг байсан. Энэ хүний хувцас цөм бүтэн бий. Бид ээлжлэн өмсөөд ер эдгэрсэн хүн алга. Бодвол энэ хаан хүн биш бололтой гэсэнд, Төмөр Мелигийн дагалт нэг сайн эр,

— Эднийг алж үгүй хийе гэж дуугарав. Нөгөө нэг нь гагцхүү өөрсдийн сэлмээр болохгүй, эдний хортой цусан сэлмийн сайн ирийг бузарлана гээд уяман өвчтөний ахлагчийн гэдсийг нэвт харвав. Тэр хүн муухай дуугаар хашхираад дутаав. Бусад уяман өвчтөн мөн түүний хойноос дагалдан зугтав. Төмөр Мелиг, тэднийг битгий хөө. Орхи! Тэд бол Аллах тэнгэрээс нэгэнт шийтгэл хүлээсэн хүмүүс гэж хашхираад би эднээс дор золгүй хүн байна. Би бүхэл насаараа Хоресмийн хааны сүр жавхлангийн төлөө тэмцэж, Хоресмийн Шаг Мухамедыг жардад гашуун зовлон тохиолдсон энэ цагт лалын эрэлхэг баатар их цэргийг захирч гайхамшигт ялалтад хүргэх ялагдашгүй Искендер гэж итгэж, цусаа урсгаж явлаа. Гэтэл одоо үзвэл цөл говийн хоосон зэрэглээг хамгаалах гэж дэмий хүчин сүйтгэжээ. Хайран биеийн шарх, хайран залуу нас. Надад их ичгүүртэй байна. Хараач. Бүх дэлхийг дагуулж чадах маш их цэрэгтэй байсан хүн, одоо харин толгой дээрээ буусан хэрээг гараар үргээж чадахгүй, хүн бүхэнд мартагдаж, нүцгэн биеэ халхлах өмдгүй, хүүрээ оршуулах төрсөн нутгийн алд газаргүй хэвтэж байна. Би цэрэг байж ханалаа. Миний дотрыг хорсгосон гашууныг угаах нулимс хүрэхгүй байна гээд Төмөр Мелиг, тахир сэлмээ хөлөөр гишгэн хугалаад өөрийн биеэр Хоресмийн хааны биеийг толгойнхоо алчуураар ороож, хойдын буянд нь ганц мэддэг богинохон уншлагаа уншиж, сайн эрс хутгаараа элсэнд нүх ухаж, лалын олон эзний хамгийн хүчирхэг гэгдэж байсан боловч, яргачны далайсан хутганд чичрэх ишиг шиг урамгүй эцэслэсэн Хоресм Шаг Мухамедын хүүрийг оршуулав.

Тэндээс Төмөр Мелиг, сайн эрсийнхээ хамтаар Желал-Эд-Дин Султаныг олж, эцгий нь үхсэнийг хэлэхээр одов.

Чингээд, энгийн бядан явагчийн дүрээр Араб, Иран, Энэтхэгийн орноор олон жилийн турш хэрэн тэнүүчилсэн гэдэг.

КУРБАН КИЧИКИЙН БУЦСАН НЬ

— Сайн сэлүүрд! Уухай, дахиад! гэх дуу сонстон, нэгэн онгоц Жейхун мөрний ширүүн урсгалыг сөрж, алгуурхнаар эрэгт ойртов.

Курбан сэтгэрүүн: «Хүний нутагт Шаг хааны морь харснаас төрсөн нутагтаа өлсөж байсан нь дээр биш үү! Ингэж байх нь гуанзны хаалган дээгүүр татсан торгон тор дотор суугаа бүднэ шувууны жаргалтай адил байна. Падишаг надад алтан динар зоос шагнасан. Тийм аз, хүний нэг насанд нэг л дайралддаг даа. Гэвч энэ динараа гэртээ яаж аваачих билээ. Ганцхан завжиндаа хийгээд аваачиж болох байх. Шаг онгоцыг гол уруудан Хоресм хүргэж тушаасан. Үгүй. Би тийшээ явахгүй. Курбан, би үүнээс хойш хааны төлөө ч байлдахыг хүсэхгүй, дүрвэж зугтаахыг ч хүсэхгүй. Зугтан зугтсаар адаг мохоолын тэнгисийн зах хүртэл зугтаж болно. Тэндээс бас хаашаа зугтах билээ гэж бодсоор тариалангийнхаа газарт эгж үр хүүхдээ үзэх сэн гэж мөрөөдөж хойно үлдсэн хадат эргийг харвал, Мухамед Шаг хээр морио унаад, гүвээ дээр зогссоор харагдсанд Курбан, ус руу харайн орж эрэг дээр гараад цайзаас газрын уруу боодолтой юмс мөрөн дээрээ эгэлдрэглэж, хүн ухаан алдтал айн гүйлдэж шахцалдан бие биеэ түлхэн онгоцноо орж,

— Хурдан амь гарахыг бод. Монголчууд ойрхон болов гэж хашхиралдан, Курбаныг ер хэрэгсэх хүн нэг ч үгүй тул Курбан эргийг дагаж гүйн өмнөх онгоцочтой сууж байсан овоохойд хүрч, сүрэл өвсөн дотроос шуудайтай гутлаа олж, мөрний эрэг рүү дахин эргэж харвал олон онгоц дараа дараагаар эргээс хөдлөн явж харагдав. Чингэхэд нь Курбан түдэлгүй, шинэ шинэ бэрх явдлын нарийн замаар орж, цайзыг чиглэж, толгой өөд авиран гарч, тэндээс үзвэл хайргатай шаталаар улаан эрээн дээл өмссөн олон хүн амь зулбан гүйлдэж, цаагуур нь цагаан тоос дэгдэн айсуйг үзээд, лав монголчуудын тоос биз гэж хэдий нүцгэн хөл өргөс чулуунд шалбаравч, хайхрахгүй хуурай тал дундуур урагш гүйж, «Тэнд өмнө минь нэг довцог байх, түүний цаана ганга байх ёстой. Монголчууд, лав, цайз гатлага хоёрт хүчээ тавиад, муу

Курбанаар юу хийх билээ» гэж гүйсээр өндөр модтой онцгой ганц булшинд хүрээд, түүний ард нуугдан түр амсхийгээд харвал, бөөн тоосны дунд шар үстэй дээл өмсөцгөөж, бөхийн довтолж яваа олон морьтой хүн харагдаж зарим нэгний ялтсан хуяг гялалзан. Монголын дуу сонстож «хурай, хурай, хурай» гэж аймаар хашхиралдан тоосонд дарагдсан намхан биетэй, түг түмэн морины туурайн төвөргөөн сонстов. Зарим цэрэг бусдаас салж давхисаар, тал дундуур зугтагчдын урдуур хөндөлсөн давхиж, илд гялалзан гозолзоод, хүн унаж, монгол цэрэг унасан хүн дээр эргэж очоод боодолтой юмсыг нь морин дээрээс шүүрэн авч, дахин их цэрэгтээ нийлэн давхих нь үзэгдэв.

— Курбан мөлхсөөр, ганга руу орж, тэндээс цааш дахин гүйв.

Өдөржингөө цөл талаар явахад нь заримдаа хаясан тариалангийн газар тохиолдож, зам дагуу ганц нэгээр, хэсэг бүлгээр тэнэх хүмүүс үргэлж тохиолдон, бүгд Курбаныг «гаслан зовлонгийн далай»-гаас мултарч ирснийг мэдээд уулзсан бүр Бухар хот юу болсон, Хоресмийн хааны яаж оргосныг асууж, гал дээрээ урин, нурамд булж болгосон боорцгоо өгөлцөж, Курбаны үгийг чих тавин сонсов.

Курбан, ганцаараа хэд хэдэн монгол цэрэгтэй тохиолдож, хэрхэн бүгдийг алж, морио алуулсныг яриад, одоо ондоо юу ч хүсэхгүй, ганцхан гэртээ харьж, тариалан руу суваг эргэж орсон газар байх хөгшин улиангар модоо харж, үр хүүхдээ дахин нэг эрхлүүлэх сэн гэж гэлдэрч явна гэж ярив.

Чингэ чингэсээр Курбан өөрөө ярьсан үгэндээ өөрөө итгэх болсон боловч, Мухамед Шагийг их зовлон тохиолдсон цагт төрсөн нутгаа орхиод улсаа Монгол Татаарын эрхэнд огоорч, баатар эр шиг байлдан үхэхээс айдаг өөдгүй муу эр гэж хүн бүхэн хараах тул их хааныг онгоцоор эрэг дээр гаргаж өгснөө ер цухуйлгаж ярьсангүй. Нэгэн газар ганга дотор олон хүн байхыг үзээд, дэргэд нь очвол Курбаныг галын дэргэд суулгаад бүгдээр монголчуудыг ярьж, тэдэнтэй тохиолдсоноо дурдалцав. Тэдний өгүүлэх нь: Бид нэгэн тосгоны улс. Манай тэнд нэгэн ийм хэрэг тохиолдсон. Бидний арваад хүнийг баахан ярилцах гэж гудамжинд цуглараад байтал, нэг монгол цэрэг орж ирэв. Бидний өөдөөс давхиж, захаас минь цавчилж эхэлсэн гэв. Чингэхэд ганц морьтой цэргийн өмнөөс гар хөдлөхийг зүрхлэх нэг ч хүн гарсангүй. Хашаан дээгүүр бидэн шиг авиран зугадаж гарсан ганц нэг хүн л амь гарав гэж нэгний ярихад, бас нэгний ярьсан нь: Би ийм нэг үг сонссон. Тарианы газар ажиллаж байсан нэг хүн дээр нэг

монгол цэрэг давхиж ирээд, тэр хүнийг алах зэвсэггүй учир, монгол цэргийн хүн аймшигтай дуугаар, «толгойгоо газарт хүргээд хөдлөлгүй хэвт» гэж хашхирсанд яая гэх вэ, тэр хүн хэлсэн ёсоор нь хэвтжээ. Тэр хооронд мөнөө монгол цэрэг дээрэмдсэн юм ачсан хөтөлгөө морин дээрээ давхиж очоод, илдээ гаргаад эргэж ирж, тэр хүнийг алсан гэнэ билээ гэж хэлэлцэж, галыг тойрон сууцгааж, төрсөн нутгийнхаа ард түмний хэрхэн зовж зүдэрч байгааг гашуудан ярьцгааж, Курбантай бяцхан боорцог, гурил хольсон аяга халуун усаа хуваан идэж ууж суутал, гэнэт ганга дээрээс нь аймшигтай сөөнгө хоолойгоор нэг хүн, та нар нэг нэгнийхээ гарыг ард нь хүл гэж хашхираад, цочин харвал гангын гүвээ дээр зээрд морь унасан нэг монгол цэрэг зогсож байв. Ганга доторх хүн, за дүүрлээ. Одоо бидний үхэх цаг иржээ гээд бүсээ тайлж, бие биеийнхээ гарыг зөрүүлэн хүлэх гэтэл, Курбан өгүүлрүүн: Байз нөхөд өө. Тэр цэрэг ганцхан хүн байна. Бид түүнийг алаад зугтаж чадахгүй гэж үү? гэвэл бусад нь бид айж байна гэхэд Курбан бас өгүүлрүүн: Чингэхүл бид өөрсдийн гарыг хүлбэл тэр бас биднийг ална нөхөд өө! Түүнийг алахаас өөр мэхгүй:

Чингэвэл сая амь гарч магад гэвэл, тэд, бас үгүй, үгүй үүнийг хэн зүрхэлж чадах вэ гээд бүгдээрээ чичрэн дагжин бие биеийнхээ гарыг хүлэв.

Нэгэнт шийдвэрлэсэн Курбан, боодолтой юмаа авч бэлэг барих гэж байгаа юм шиг бариад эргээс өөд авирч монгол цэргийн дэргэд очив.

Тэр монгол цэрэг, тармаг буурал үстэй, сахал нь унжсан, нүүр нь салхинд гандаж атирсан их настай хүн байв. Морьтой монгол цэрэг, анигар нүдээр ширтэж, энэ чинь юу вэ гэж Курбаны өгч байгаа боодолтой юм руу бөхийсөнд Курбан түүний толгой гараас шүүрэн барьтал морь нь үргэж, хажуу тийш зайлсхийв. Курбан, түүнийг тавилгүй, мориноос унатал газраар чирэгдэн зуурсан тул сая газар унав. Чингэхэд нь түүнийг Курбан хонь алдаг шиг хутгаар огтолж алаад босож харвал мөнөөхөн галын дэргэд байсан хүмүүсээс нэг нь байдаг чадлаар зайлан зугтаж явна. Бусад нь гангын дотор нуугдан харж байв. Дараа нь хоёр нь хүрч ирээд нэг нь монгол цэрэг рүү бөхийгөөд бүр амьсгалгүй болсон уу? гэнэ. Нөгөө нэг нь үүний юмыг тэн адил хуваах хэрэгтэй гээд үхсэн цэргийн нүцгэн бөөрөнхий биед цамцгүй өмссөн нэхий дээлийг тайлж эхлэв. Чингээд бүгдээрээ морь луу нь очиж, Курбанд түүнийг барихад нь туслав. Тэнд Курбан өгүүлрүүн: Та нар юу

дуртайгаа цөмийг авагтун. Харин энэ зээрд морийг нь би авъя. Харж байна уу та нар. Энэ чинь монгол морь биш. Манай тариачдаас булаан авсан манайхны морь байна шүү дээ. Би үүгээр чинь газар хагалъя гэв. Гэтэл нөгөө нэг нь морины цулбуураас гараа ороон барьж, шавх татаж, хэнд оногдвол, тэр хүн авбал зохино гэв. Тэгэхэд Курбан, хараач. Өнөө монгол цэрэг чинь амьд босоод ирлээ гэж хашхирсанд айсан хүн морины цулбуурыг хаяад зугтав. Курбан, морин дээр байсан боодолтой юм богцыг тайлж, хамгийн хүнд нэгийг үлдээж, бусдыг газар авч тавиад эмээл дээрээ харайн мордож тэдний зүг өгүүлрүүн:

— Та нарыг ямар сайн эр гэх билээ. Харин та нар бол өргөсөн саваанаас айж зугтах цох хорхойнууд байна. Хэрэв та нарт арслангийн зүрх байсан бол бид хамтарч гагцхүү бүх монгол татаараар барахгүй, бүх манай газрыг түрэн эзэлсэн Хоресмийн хаан, Султан, Беги хаан нарыг хүртэл цөмийг хөөх билээ. Гэтэл та нар бол, банзны ан завсраар хоргодох жоом хорхой шиг өчүүхэн чимээ сүрчигнэвэл айдаг амьтад байна. Ийм амьтдыг үнэхээр Монголын ямар ч адгийн эр тас цохилгүй яах вэ. Мэнд сайн сууж, бүх ертөнцийн баатар Курбан Кичикийг санаж яваарай гэж гараар нэг даллаад тал дундуур давхин одов.

КУРБАНЫ АР ГЭРЭЭ ЭРСЭН НЬ

Курбаныг тэндээс Бухар хотноо ойртох тутам эвдэрсэн тосгон суурин олширч, нохой шувуунд идэгдсэн хүний хүүр элбэг болж цадсан нохой, чоно шиг сүүлээ буулгаж, гэдсээ унжуулаад хүүрээс алгуурхнаар зайлж хуцалгүй хэвтэв. Курбан, нэгэн цөл газар мориноосоо бууж, ганзаганд байгаа монгол цэргийн ширэн богцонд лав дээрэмдэн цуглуулсан алт бий биз ээ гэж найдаж уудалж үзвэл дархны янз бүрийн хэмжээ бүхий ерийн гурван алх, хуурай, өрөлбө, хэсэг болгосон мах, арваад боорцог байлаа. Алт байхгүй юм уу гэж цааш эрвэл нэг алчууураар ороосон юм гарлаа. Түүнийг задалж үзвэл нэг ширэн хавтагатай юм байна. Түүний дотор алт байсангүй. Харин нэг атга зэс, мөнгөн зоос байлаа. Түүнийг бас ч аж ахуйд хэрэгтэй юм. Бас завжинд Хоресм шагийн өгсөн алтан динар бий гэж бодов.

Хэд хэдэн тосгодын дэргэд хүн, тарианы ажил хийж, Курбантай уулзаад гашуудан ярьсан нь;

— Одоо суваг эвдэрч, ус нь буруу урсаад, бас ус багатай болсон учир, зарим тариалангийн газар хатаж байна. Зарим газрыг ус аваад

энд тэндгүй шинэ гуу жалга бий болгожээ гэв.

Гэртээ ойртож яваад, нэг газар Курбан, урьд таних Кувонч гэдэг нэг тариачинтай уулзав. Тэр хүн, нэг хэсэг утаа үнс болсон бөөн чулуу зааж, миний гэрээс үлдсэн юм энэ гэж уйтгартайгаар толгойгоо сэгсэрч, би эргэн тойрон явж хүүхдээ дуудлаа. Нэг ч хүн ирсэнгүй. Монголын дайрсан тэр өдөр би тариалангийн газар байсан. Утаа гарч, манай айлынхны ухаангүй сандарч зугтахыг үзээд, гэрийнхнийг тэдний хамт явчихсан болов уу гэж хойноос нь очоод шөнө орой болсон хойно гэрээ эрж эгж иртэл энэ чулуу, халуун нурмаас өөр юу ч үлдсэнгүй билээ. Миний хүүхдийг монгол аваад явсан юм уу, байшин дээрээ түлэгдэж үхсэн юм уу, Би алиныг ч мэдээгүй байна. Гэвч нэг газраас хүрээд ирж магад гаж бас горьдох юм гэхэд нь Курбаныг сэтгэл зовнин, гэрийн зүг явж, тариаландаа суваг эргэж орох хөгшин нарсан модны дэргэд хүртэл нэгэнт харанхуй болов. Сувгийн дундуур ус урсаж, чимээ аниргүй харанхуй шөнө цайвар сарны гэрэлд гэрийн дэргэд хүрч ирвэл, хашааны хаалга нь цэлийтэл нээлттэй байв. Мориноос бууж саравчинд уяад, байшингийнхаа хаалган дээр очвол хаалганд банз хөндөлсгөн хаджээ. Хаалганы цаана өчүүхэн ч чимээ аниргүй, ороход, нохой ч дайралдсангүй.

Сүрэл өвсний хог хамж, мориндоо тавьж өгөөд байшингийнхаа орой дээр гарч, дэрсэн дээвэр дээр нь хэвтэж, мөнөөхөн Кувончийн бас ч эргээд ирж магадгүй гэж хэлснийг бодсоор унтав.

Өглөө эрт хүйтэн салхинд биеэ эргэж урваж хэвттэл бөглүү газраас ёолох мэт нэгэн аягүй дуу сонстож, чих тавин чагнавал, ёолох дуу дахин гарав. Энэ чимээ дор байшин дотроос гарах мэт. Хэн ёолж байгаа вэ. Шархтай монгол цэрэг үү. Үхэж байгаа монгол цэрэг болов уу гэж байшин дээрээс бууж, мориныхоо дэргэд очвол, морь нь тавьж өгсөн өвсийг дуустал идчихээд хөлөө дэвслэн холхиж байв.

Ширэн богцноосоо алхаа авч, муу байшингийн хаалгыг онгойлгож, дотор орвол хав харанхуй, ханзан дээгүүр гараар тэмтэрч үзвэл, нэгэн хүн хэвтэж байв. Нүүр толгойг тэмтэрч үзээд, эхээ танив. Эх нь үхсэн юм шиг хэвтэж, дорой дуугаар ёолон, хүү минь ирэв үү. Чи биднийг битгий орхи гэв. Бусад чинь хаана очсон бэ гэвэл, эх хэлсэн нь: Бүгд ууланд дүрвэн явсан. Би, ганцаараа байшингаа харж хоцорсонд, бүр чадалгүй болов. Ер нь тэд намайг үхсэн гэж бодоод хаалгаа мод барьж хадаад явж шүү. За хүү минь ирсэн тул, одоо ч, нэг арга нь олдох биз гэв.

Курбан, ваар олж, сувгаас ус авчран, зомгол түүж, гал түлээд, гал дээрээ ваартай усаа тавьж, шар будаа хийв. Муу байшингийн дотор гэрэлтэй, дулаан болов. Эх нь хөдөлж ч чадахгүй маш дорой хэвтэж, хамар нь хавчийгаад хатангир уруулаараа шивнэн хүү минь ирж ингэж гялайх гэж гэв.

Курбан, морио хөтөлж, нэгэн сул газар идээшлүүлэхээр чөдөрлөөд, тэр газрын ойр байсан алгын чинээ тариалангийн газрыг үзвэл бас хог өвс ургажээ. Энэ бяцхан газраар гэр бүлээ яаж тэжээх билээ дээ. Бас үүний тал хувийг газрын эзэн бегид өгнө гэж түүний цаанаа таних айлын тариалангийн газар байгааг үзвэл тэнд мөн хог өвс ургажээ. Эзэн гэмээр торойх ч амьтан алга. Нэлээд холхон ээрүү дархан өвгөн Сакоу-Кулийн саравчтай жижигхэн байшин шатчихсан, туурга нь утаа тортог болж, дэргэдэх модны навч түймэрт шатагдаж үрчийсэн харагдав.

Чингэтэл, нэгэн хүн тариалангийн газраар аажимхан алхаж, хааяа зогсон, зээтүүгээ далайн алдалж, суваг засаж яваа бололтой харагдав.

Тэр хүний зүг хүүе! гэж хашхиртал, зогсож, нүдээ гараар саравчлан хараад, хүүе, Курбан Кичик! гэж хашхирч, суваг уруудан яаран ирсэн нь Курбаны айлын Сакоу-Кули гэдэг, олон ач үртэй өвгөн ажаэ. Өвгөн нүдээ арчиж өгүүлрүүн; Ямар айхтар цаг болов гэв.

Курбан, таны гэр бүл сайн уу, үнээ чинь амьд уу. Илжиг чинь бий юү. Хонь чинь хургалж байна уу гэж асуувал, өвгөн өгүүлрүүн:

Үстэй дээлтэн ирж, манай айлын малыг хөөгөөд, миний дөрвөн хонь, нэг ач хүүхнийг минь эмээл дээрээ дүүрээд явчихсан. Бусад нь ууланд зугтсан. Өлсөж үхэхгүй амьд явж ирвэл үнээ илжигтэйгээ үлдсэн байх гэхэд нь:

Манай гэрийнхэн яасан бол гэж асууж, ямар сураг чимээ сонстох бол гэхээс тэсэж ядан амьсгалаа барьж хүлээвэл, өвгөний өгүүлэх нь: Таны гэрийнхэн сайн. Чиний гэргий өчигдөр эргэж ирээд миний муу байшингийн эвдэрхий дотор хоноод явсан. Одоо тэр тарианы газар дундуур айсуй гэсэнд нээрэн гэргий нь улаан дээлээ өмссөн ирж явав. Юунд шарваж найгаж яваа юм бэ гэж бодоод өрхийн тэргүүлэгч хүн тул бүгдийг гартаа цуглуулж, эвдэрсэн аж ахуйг дахин сайжруулах явдал маш чухал гэж сайтар мэдэрч, за Сакоу-Кули ээ гээд өвгөний зүг өгүүлрүүн; Чамд үнээ, илжиг байна. Надад морь бий. Хоёулаа тэр гурвыгаа хөллөж бяцхан газраа хагалж боловсруулъя. Эргэн тойрон

дайн довтолгоо, урьд Хивчагийн беги довтолдог байсан бол, одоо Монголын хаад довтолж байна. Бид эднээс хэзээ салах юм билээ. Гэвч бид тариалангийн хүн тул хүлээж зүгээр сууж болохгүй. Манай гол ажил, амуу тарих ажил. Бид өөрсдийн төлөө санаа зовохгүй бол хэн биднийг тэжээх вэ гэвэл, Сакоу-Кули Зөв. Цагийг алдаж болохгүй. Газар бол үр, анжис, ус шаардаж байна гэв.

ТУРХАН ХАТНЫ ЗУГТСАН НЬ

Тэр аюултай луу жил (1220 он) намар нь бүх Маверанагр нэгэнт Чингис хааны эрхэнд орж, монгол хаан өөрийн мэдэлд бүхий өв газрыг эзэлж аваад хичээнгүй эзний ёсоор эмх журамтай тайван байдлыг тогтоох талаар санаа тавьж. Их хааны үл үүрэглэх нүд бүгдийг харж, бүгдийг мэдэж байх ёстой тул Чингис хаан, хот бүхэнд монгол цэргийг суулгаж, нутгийн Хаким ноёдыг томилон, тэдний дэргэд монгол захирагчийг хавсарган суулгав.

Бас ч айсаар хараахан итгэхгүй байсан зарим тариачид, алгуурхнаар тосгон сууриндаа эгж, тариалангийнхаа ажлыг оролдож эхлэв. Гэвч, улс даяар өлсгөлөн хүмүүс, гэр оронгүй дүрвэж зугтагсад хэсэг бүлгээр хэрэн тэнүүчилж, монголчуудын дараагаар хоол унд эрэн нэгэнт үгүйрэн сарнисан тосгон сууриныг дээрэмдэх тул бүр эмхэрч тогтнотол нэлээд удав.

Гагцхүү, Хоресмийн хааны баялаг нийслэл Гурганж хот байгаа Хоресмийн үндсэн газар Жейхун мөрний адаг хараахан эзлэгдээгүй үлдэв. Тэр газар Монголын эзэлсэн газрын дунд үлдсэн тул бүслэгдсэн гэр мэт болжээ. Чингис хаан, тэр газар өөрийн гарыг оруулахаар шийдвэрлэж, тэр мужийг эзлэн ав гэж Зөч, Цагаадай, Өгөөдэй гурван хөвүүндээ даалгаж, цэргээс үлэмжхэнийг гаргаж өгөв. Цагаадай Өгөөдэй хоёр Жейхун мөрний гүвээ дагаж, Хоресмийн өмнөөс орохоор хөдлөв. Гэтэл хэнд ч ялагдаж үзээгүй Зөч цэргийн хамт Женгийн орчим үлдэж, тэх агнан тэндхийн нүүдлийн аймгаас хааны дуртай дан ганц цагаан хул хоёр зүсмийн морь албадан цуглуулж, байлдаанд орохыг алгуурлав.

Чингис хаан, өөрийн их цэргийн гол хүчнийг дагуулан, Жейхун мөрний хөвөөнд өвөлжихөөр шийдэв.

Гурганжид Хоресм Шагийн шадар ноёдоос Данисмед хажиб ноёныг явуулав. Тэр ноён нас өтөлсөн Турхан хатанд ирж өгүүлрүүн;

Их хаан, тантай байлдаж байгаа бус. Таны хүү Мухамед-Хоресм Шагийн ял асуун байлдаж, төрсөн эхийг доромжлон, үгийг дуулахгүй үл бүтэх зан гаргасан явдалд зохих гэсгээлтийг үзүүлэхийн тулд түүнтэй байлджээ. Хэрэв, Турхан хатан, та бууж өгвөл, Чингис хаан, таны мэдлийн газар орныг сүйтгэхгүйг батлав, гэсэнд, муу санаат Турхан хатан монголчууддаа шударга үнэнч боловч, урамдахын дуугаар гөрөөсийг хууран авчраад алж иддэг гөрөөчинтэй адилаар бусдыг үздэг монголын эзнийг итгэсэнгүй.

Данишмен-Кызигийн биеийг Гурганжид хүрэлцэн ирэхийн чацуугаар Келифээс онгоцоор дутаасан хүн ирээд, тэдэнтэй ядуу хүний хувцас хувцаслаж, зүс буруулан Хоресм Шагаас захиа авчирсан Инанч хаан ирж, түүний авчирсан захиа дотор Падишаг, Жейхуны эрэг дэх харуулыг орхиж, цааш их цэрэг элсэхээр Хорасны зүг одсоноо эхдээ мэдэгдэж, Турхан хатанд Чингисийн үгэнд оролгүйгээр олон хатныг минь дагуулан миний хойноос явах болов уу гэх зэргээр бичжээ.

Үүнийг сонсоод Турхан хатан сандарч, ер нүдээ сайхан болгох гэж нойтон жин тавьдгаа ч больж, Хоресмд хөл гишгэх газаргүй болсныг мэдээд, их хөсөг хөдөлгөхийг тушааж, Хоресм Шагийн бүх хатан хүүхдийг цуглуулаад, тэмээнд эд эрдэнээ ачиж, урагшаа Хар Хумын элс дагуу Копет-Даг ууланд гарахаар хөдлөв.

Хөдлөхийн өмнө, ач нарыг хойшид гарч болох атаа тэмцлээс болгоомжлож, их зандалчныг ордонд байгаа бүх залуу барьцааны тайж нарыг нас бага ихийг ялгалгүй онгоц дээр суулгаж, Жейхун мөрний гүнзгий газар, хөлөөс нь том чулуу уяж, хая гэж тушаажээ.

Хоресмийн ихэс том том ноёдын хөвүүд, нийт хорин долоон багачуудыг ингэж усанд хаяж алсан билээ.

Тэдний дотроос ганц Туркмений Яжер захирагчийн хүү Омар хааныг амьд үлдээв. Учир нь, Турхан хатан зөвхөн өөрөө тэр зүг явах гэж мөн Омар хаан, түүний бараа бологчид, цөл говийг гатлах замыг сайн мэдэх тул тийнхүү эс алжээ. Чингээд Хар Хумын элсийг туулсан 16 хоногийн хүнд бэрх аянд Омар хаан, хөгшин хатанд шударгаар ямар ч үг эсэргүүцэлгүйгээр зүтгэсэн боловч, хатан, Яжерьн нутгийн хил ойртож, элсний цаанаас өндөр уулсын хад чулуун орой үзэгдэхтэй зэрэг, Омар хааны нойрсмогц толгойг нь ав гэж тушаажээ.

Хоресм Шаг-Мухамедийг эрэлхийлсэн монгол цэргийн манлай баг нь хараахан хол яваа далимаар хатан хөсгөө нэгэн онцгой хад хавцгайд байгуулсан Илал гэдэг бэх цайзын зүг хандуулж, тэнд

хүрмэгц, бүх бараа бологчдын хамтаар буув. Үүнд хатны торгон цэргийн нэгэн дарга айлтгаруун:

— Эндээс даруйхан зугтаж, Иранд монголчуудыг эсэргүүцэх их цэргийг хуралдуулан цуглуулж байгаа ач хүү Желал-Эд-Динийг түшвэл дээр болов уу. Хүн бүхэн түүний цэргийн хүч, эр зоригийг гайхалцан ярилцаж, дайсныг үлдэн хөөж чадна гэдэг байна гэхэд нь Турхан хатан өгүүлрүүн,

— Хэрхэвч үгүй гэж хилэгнэж бас өгүүлсэн нь; Чингэснээс Монголын ирт мэсэнд үхсэн минь дээр. Намайг хамгийн заналт дайсан туркмен эхнэр Айжижигийн хөвүүнээс өмөг гуйхад хүрсэн гэнэ үү, та нар? Би өөрийн ариун хивчаг ураг элэгний ач нартай байтал, тэр хүнийг түшиж амьдрахыг хүснэ гэж үү. Тэгснээс Чингис хаанд олзлогдон, түүний дарлах доромжлохыг хүлцэж явсан минь дээр гэж билээ.

Удалгүй монгол цэрэг ирж, цайзыг бүслээд, хадыг тойруулан, шивээ босгож, гадагш харилцахыг таслав. Дөрвөн сар бүслэн хаасны эцэст цайз дахь ус унд тасарч, Турхан хатан, арга барагдаж бууж өгөх болов.

Чингээд, монголчууд, эх хатны хамт Хоресм Шагийн бүх эмс хатад, бага хөвүүдийг олзолж хөвүүдийг нь дор нь алаад, Шагийн хатад, охидыг эх Турхан хатны хамт Чингисийн цэргийн хүрээнд хүргэж, бусад бараа бологчид, торгон цэргийг цөм үгүй хийв.

Монголын дээд эзэн, Хоресм шагийн эмс охидыг хөвүүд, шадар ноёддоо хуваж өгөөд, хорт хар санаат Турхан хатныг хурим тойд хүн амьтанд үзүүлье гэж үлдээжээ.

Турхан хатан, өргөөний үүдэнд уйтгарт дуу дуулж суух үүрэгтэй болж, Чингис хаан, түүнд мөлжсөн яс хаяж өгдөг байжээ.

Урьд Хоресмийг хэмжээгүй эрхтэйгээр эзэрхэн захирч, биеэ «дэлхийн бүх эмэгтэйчүүдийн эзэн» гэж байсан Турхан хатан ингэж яс мөлжиж амь зуух болжээ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ : ИХ ХОРЕСМИЙН МӨХӨХИЙН ӨМНӨ ҮЕ

ЖЕЛАЛ-ЭД-ДИН, ЧИНГИС ХААНД БАЙЛДАХЫГ ДУРТГАВ

Үр цацахгүй болбол тариа үл ургана
Амиа үрэхгүй болбол дайсныг үл дарна
(Саади. 13 дугаар зуун)

Хоресм Шагаас салаад, Желал-Эд-Дин, нөгөө эхээс төрсөн дүү Озлаг-Шаг-Акшагтай далан морьт дагуултай Мангишлаг хүрч нутгийн айлаас морь юүлж унаад, Хар Хумыг туулж, Хоресмийн нийслэл Гурганжид хүрэв.

Тэнд нэртэй их их беги ноёдод Хоресм Шаг Мухамедын шинэ зарлигаар урьд тогтоосныг өөрчилж, Султан Желал-Эд-Динийг хаан ширээ залгамжлах зарлиг буулгасныг тунхаглан зарлав.

Урьд хаан ширээг залгамжлах хунтайж агсан Озлаг Шаг тэр зарлигийг баталсан боловч, хивчаг ноёд хивчаг омгийн бус, өөр Султантай болсондоо дургүйцэж, далдуур Желал-Эд-Динийг алахаар хэлэлцэн тогтов.

Чингэж хуйвалдсаныг Келифээс ирсэн Инанч хаан, Желал-Эд-Динд сэргийлэн мэдэгдвэл, Желал-Эд Дин гуньхран өгүүлрүүн: Аюул, нүдний өмнө ойрхон ирээд байхад санаа хүчин нийлж чадахгүй, аалз хилэнцэт хорхой мэт хүнээр дүүрсэн хотод суугаад би юү хийх билээ гэж, шөнө, Төмөр Мелигийг гурван зуугаад туркментэй дагуулан Гурганжаас сэм гарч урагшаа Хар Хум туулахаар мордож, 16 хоног арай чармайн явдаг бэрх замыг хэдхэн хоногийн дотор туулж, Нес хот хүрчээ.

Түрүүлэн мордуулсан тагнуулын мэдээлж ирсэн нь «Копетдаг уулын бэлээр ногоон зүлэг дээр хачин гэр үзэгдэв. Түүний дэргэдүүр үзэгдээгүй угсааны чөдөртэй морь бас харагдсан, Монголчууд бололтой. Долоон зуугаас доошгүй хүн байна» гэсэнд:

Төмөр Мелиг өгүүлрүүн: Бэрх аянд морь маань ядарсан боловч, Монголын хүрээнд дайран орох чадал бий. Бидэнд дайсныг цавчих чадал байна гэв. Желал-Эд-Дин өгүүлрүүн;

— Зоригт баатрыг зол завшаан дагана гэж элсний цаанаас Желал Эд-Диний туркмен цэрэг гэнэт гарч ирээд монгол цэргийн хүрээг зоригтой дайран довтолсонд хоёр талаас амь өрсөн цавчилцсан сүрхий

тулалдаан болж, монголчууд тэсэлгүй зүг бүр тарж, ус гүйх цоргоны шуудуу дундуур нуугдан зугтацгааж, хэдхэн хүн амьд гарчээ.

Энэ бол, Монголыг Туркмений дийлсэн анхдугаар тулалдаан ажгуу.

Үүний урьд монголчууд, хүн бүгдийг айлган сүрдүүлсэн учир, Монголыг хэн ч дийлдэггүй юм гэж байсан цаг билээ. Ингэж дийлээд Желал-Эд-Дин, цэрэгтээ сурган хэлсэн нь,

— Хэрэв монголчууд, задгай талд хүрээгээ байгуулалгүй, Несийн хэрмийн цаана байсан бол бид өөрсдийн ядарч зүдэрсэн мориороо яасан ч мэнд өнгөрч чадахгүй байсан билээ. Иймд та нар бушуухан тэдний морийг барьж эмээллэгтүн. Бидний зам хол шүү гэж сургахад бүгдээрээ шаламгайлан Монголын амар цатгалан морийг барьж унаад, уулын нарийн жимээр өмнө зүг Нишапур хот чиглэн мордоцгоов. Хивчаг хаадын урвахаас айж, хэдэн хоногийн сүүлээр Гурганжаас Хоресм Шагийн нөгөө хоёр хөвүүн Озлаг шаг, Ак шаг хоёр бас Несийн хавьд ирж явтал, олон бараа бологчид дагаж явсан тул, хэдий монгол харуулын цэрэгт мэдэгдэхгүйгээр өнгөрөхийг оролдовч мэдэгдэн бүслэгдээд цөм алагджээ.

Тар завсар, Желал-Эд-Дин, зуур хаана ч зогсолгүй Нишапур хотыг дамжин Зузан Герат муж орохоор улам цаашлан явж, нэгэн уулын боомт захирсан даргыг цайзынхаа зузаан хэрмийг дайсанд автагдахгүй гэж итгэж, Желал-Эд-Динийг үлдэнэ үү гэж гуйхад нь цэргийн жанжин хүн, хээр талд байлдахаас бус, хэрэм дотор хаалттай хэвтэж зохихгүй. Хэдий таны хэрэм бэх сайн боловч, монгол цэрэг эзэлж авах аргаа хэзээд олж чадна гэв.

Бүстэд хүрэлцэн ирэхдээ Желал-Эд-Дин, Хоресм Шагийн сарниж бутарсан цэргийг цуглуулсаар, нэлээд ихээхэн цэрэгтэй болжээ.

Эндээ Амин-Ал-Мулкийн цэрэгтэй нийлж, Нандагарыг бүсэлсэн монгол цэргийг хөөгөөд, мөн Хоресм Шагаас урьд өгсөн нутгийн төв Газна хотод хүрч, тэндэх олон беги ноёдоосоо шударга журмыг гүйцэтгэх тангаргийг авав. Тийнхүү Желал-Эд-Дин, гурван түм шахам туркмен цэрэгтэй болж, бас тэр хэр тооны Авган, Харлаг зэрэг аймгийн цэрэг нийлэв.

Морьтой явган 6 түмэн цэргээ удирдаж, монголтой байлдаар Кабулд цутган ордог Лугар голын эхэн дэх Перван гэдэг бяцхан хотын дэргэд хүрээлэн буугаад, туркстаныг уулгалж, Варияны цайзыг бүслэн

хаасан Монголын Мухажигийн мэргийг бут цохиж, монголчууд, мянга шахам хүмүүсээ алуулаад, даруйхан Пяндшир голыг гараад, гүүрийг эвдэлж, Чингис хаандаа эгжээ.

Желал-Эд-Дин, Чингис хаанд: «Байлдах газраа болзон зааж өг. Чиний заасан газар очиж хүлээе» гэсэн товч захиа явуулжээ.

Чингис хаан, тэрхүү захидалд хариу бичсэнгүй боловч, Мухажигийн цэрэг дарагдаж, Желал-Эд-Диний зүрхэлснийг гайхаж, түүнийг байлдаар өргөмөл дүү Шихихутаг ноёноор дөрвөн түмэн цэрэг явуулав.

Желал-Эд-Дин, монголчуудыг зоригтойгоор угтан тосож, Перванаас нэг фарсаг буюу одоогийнхоор 7 километрийн газар байгаа нэгэн хөндийд тулалдахдаа, байлдахын өмнө цэрэгтээ «Баатрууд аа! Хэнгэрэг дугарахаас өмнө, мориныхоо хүч тэнхээг гамнаж, цулбуураа ардаа бүснээсээ уяад явган байлд. Хэнгэрэг цохимогц мориндоо мордож байлд» гэж тушаагаад хоёр өдөр байлдахад монгол цэрэг эцэж, хүчин чадлаа барахын туйлд хүрсэн боловч, дайснаа ялж чадахгүй байгааг Шихихутаг ноён үзэж, хоёрдугаар өдөр эсгийгээр хүний дүрстэй айвали өлзийхүү хийж, хөтөлгөө моринд унуулсныг лал нар, шинэ цэрэг ирэв гэж сандарсан боловч, Желал-Эд-Дин, цэргийнхээ зоригийг сэргээж, дахин хатуужин байлдсаар, хэнгэргийн дуу сая гармагц бүгдээр мориндоо мордож Желал-Эд-Диний хойноос дайсныг дайран оров.

Желал-Эд-Дин, өөрөө монгол цэргийн дунд цөмрөн ороод хоёр хэсэг болгосонд монголчууд эргэж (морины туурайгаас оч үсэртэл) давхилдан дутаав.

Желал-Эд-Диний эцэж зүдрээгүй морьтой цэрэг, дутаасан дайсныг амархан гүйцэж хядсаар, иШихихутаг ноён, дарагдсан цэргийн амь гарсан цөөн эрийг дагуулан, Чингисийн хүрээнд эгж ирээд,

Урьд дарагдаж үзээгүй монголчуудыг Перваны тулалдаанд дийлсэн мэдээ, уул хөндий дүүрэн цуурхаж, монгол цэргийн эзэлсэн зарим хотын ард бослого гаргаж, монгол цэргийг хядах болов.

Ийнхүү хөдөлж байхад Чингис хаан, туршлагат аргаа хэрэглэж, Желал-Эд-Диний хань холбоо болсон хаадад төлөөлөгч явуулан, та нар зоригт Султаныг хаяж холдвол хэдэн тэмээ алт өгнө гэсэнд удалгүй Желал-Эд-Диний цэрэг олзоо хуваах үес, ялимгүй юм дээрээс хэрүүл маргалдаан гарч, нэгэн араб морийг булаалдах зуур нэгэн хивчаг хаан,

их цэргийн багийг удирдагч Аграгийн толгой руу ташуурдсаны улмаас их хэрүүл болж, Желал-Эд-Дин, хоёр этгээдийг эвлэрүүлэхийг оролдсон боловч чадсангүй.

Дараагаар нь авган цэргийн жанжин Музафар-Малигжич харлаг цэргийн Азам-Мелиг Келзийн цэргийн ноён Аграг тус тус цэргээ дагуулан салж, хивчагийг бусад аймгийн цэргийг ташуурдах зэргээр их зан гаргаж доромжилсонд гомдол гаргах, Чингис хааны аргад унаад, Желал-Эд-Диний цэргээс тасарсан бүлгээ. Тэдний шалтаг зааж хэлсэн нь,

«Энэ турк хивчаг, урьд монголоос айн сүрдэхдээ Монголыг энгийн хүнтэй адилгүй улс юм аа. Сэлмээр цавчивч шархтахгүй тул, хэнд ч дийлдэшгүй улс юм аа. Тэдэнтэй хүч тэнцэх буюу мөн дийлэх улс, орчлонт ертөнцөд үгүй гэдэг байсан.

Харин одоо биднийг монголчуудыг бут цохиж, монгол хүмүүс бусад хүнтэй адил шархаддаг. Мөн нэгэн адил цус нь урсдагийг хүн бүхэн үзсэн хойно хивчаг сагсуурч, байлдахад хүчин тусалсан биднийг дарлах болов гэхэд нь... Желал-Эд-Дин, бидний тасарч бутрах тусамд Чингис хаан биднийг амархан дарна гэж учрыг сэнхрүүлэвч, тус болсонгүй, цэргийн хагас нь тасарч одоод Желал-Эд-Динтэй хамт дөнгөж Амин-Ал-Мулкийн туркмен цэрэг үлдэв.

Шихихутаг ноёныг Чингис хаандаа буцаж ирээд, Перванд байлдсаныг нэгд нэгэнгүй зүйлчлэн хэлэхэд нь Чингис хаан төв царайгаар өгүүлрүүн: Шихихутаг чи үргэлжид дийлж дадсан билээ. Одоо дарагдахын гашуун зовлонг амссан чинь хойшид дайн цэргийн үйлст хашир суухад тустай болжээ гэв.

Гэвч Чингис хаан, түдэлгүй энд тэндээс цуглуулж болохуйц бүх цэргээ татаж авчраад, их цэрэг хөдөлгөн, зам зуур хоол чанах завгүй яаравчлан давхиж, шууд Газнаг чиглэн явж, тэрэг явах замын төгсгөлд хүрээд тэрэг тээврийг орхиж, нарийн жимээр уулыг давахаар зорьжээ.

СИНД МӨРӨНД ТУЛАЛДАВ

Дүүгээс минь илүү ачтай чамайг морь гэж нэрлэхээ байгаад,
дүү гэж нэрлэе.
(Китаби коркуд бичгээс)

Желал-Эд-Дин, холбоотон цэргийн явчихсанаас хойш, урьд хүсэж байсан ёсоор монголчуудтай шууд байлдаж чадахгүй болж, өмнө зүг чиглэсээр хад хавцгайд хавчигдсан их уст, ширүүн урсгалт Синд мөрөнд саатав.

Султан, хэдий цэргээ гаргах онгоц сал эрэвч, ширүүн урсгалт долгион, ямар ч онгоцыг хавцал хад болсон эрэгт мөргүүлэн бут цохих тул арай чармайн нэгэн онгоц олж ирснийг Желал-Эд-Дин, Эх Айжижиг, эхнэрээ хэдэн эмэгтэйчүүдтэй суулгаж гаргахыг оролдсон нь үл бүтэж, онгоц нь хад мөргөж хэмхэрсэн учир, бүсгүйчүүд цөм цэргийн хамт эрэг дээр үлэв.

Тэгж байтал, гэнэт, монгол цэрэг айсуй гэж, элч давхиж ирээд, шөнө болж, эргэн тойрныг хар бүтээлгээр бүрхсэн мэт харанхуй болов.

Желал-Эд-Диний бие, Синд мөрний гармыг эрж байгаа гэхийг сонсоод, Чингис хаан түүнийг амьдаар барих гэж, тэр шөнөдөө цэргээ удирдсаар, үүр цайх хэрд дайсны барааг харж, Султаны цэрэгт гурван талаас ойртон, хэд хэдэн нуман жагсаалаар айсаж Синд мөрнөөр хөвчлөн бүсэлсэн хойно, Үнэр хүлч, Хөхөс хүлчийн баг цэргийг Султаныг эргээс холдуул гэж явуулаад, бусад цэргээ Султаныг сумаар харваж болохгүй, амьдаар барьж ав гэсэнд Желал-Эд-Дин, долоон зуун эрэлхэг цэргээр тойруулан, лал цэргийн дунд байснаа Чингис хааны бие нэгэн гүвээ дээрээс байлдааныг удирдан жолоодож байгааг үзээд, Султан тэссэнгүй шилдэг сайн сургуультай цэргээ дагуулан, монголчуудыг сүрхий хавчин орсноор монгол цэрэг ухарч, Монголын эзэн хаан ч морио ташуурдан зугтахад хүрчээ.

Гэвч, хашир Чингис хаан байлдахын урьд түмэн шилдэг цэргээ бүгүүлсэн нь гэнэт Желал-Эд-Динийг хажуу талаас нь дайрч гэдрэг цохиод, Амин-Ал-Мулкийн захирсан туркмений баруун гар өөд цөмрөн орж түүний эгнээг эвдлэн, дотогш хавчиж цохисон учир, туркмен цэрэг эмх замхгүй зугтаж эхлэв.

Чингээд, монголчууд зүүн гарыг нэгэн адил бут цохив. Үүнд, Желал-Эд-Дин, шилдэг сайн цэргийн хамт үд болтол байлдаад, тогтвороо алдаж улайрсан барс мэт баруун, зүүн гар өөд ийшээ ч, тийшээ ч давхиж, монголчууд, Султаныг харваж болохгүй гэсэн тушаалыг дагаж Желал-Эд-Динийг бүслэн хавчсаар Желал-Эд-Дин байдаг хүчээ шавхаж, дайсныг сэтлэн гарахыг оролдож ядаад хайртай туркмен мориндоо мордож, хуяг дуулгаа орхиж, ганц илдээ аваад жолоог мөрний зүг залж, өндөр хавцгай дээрээс ширүүн урсгалт

Синдийн давлагаалсан хар долгио руу үсрэн, мөрний тэртээ нөгөө эгц эрэг дээр гармагц, Чингис хааны зүг илдээр занаад, өвс бургасан дундуур давхиж далд орсонд Чингис хаан гайхан, амаа барьж хөвүүддээ; «Эцгийн хүү ийм л байх ёстой» гэж хэлж билээ.

Монгол цэрэг Султаны хойноос усчлан гараад, түүний хойноос нэхэхийг завдаж, Чингис хаан хориглон зогсоов. Чингээд монгол цэрэг, Желал-Эд-Диний бүх цэргийг хядаж, ганц Желал-Эд-Диний эх, эхнэр хоёрыг Монголын олз бүү болог гэж цэрэг нь бодож, усанд хаяж амжаад. Ганц Желал-Эд-Диний долоон настай хөвүүн монголд баригдаж амьд үлдэж, Чингис хааны өмнө аваачихад нь хажуу талаараа хаан өөд эргэж, түүнийг дайсагнасан зүрхтэй нүдээр хялайн харсан тул Чингис хаан өгүүлрүүн: Манай дайсны үндсийг таслууштай. Үгүй бол зоригт лалын хойчийг залгамжлагч нар, миний ач нарыг хядна. Энэ хүүгийн зүрхээр миний гөрөөчин нохойг тэжээ гэж билээ.

Монгол зандалчин, их хааны өмнө чадлаа үзүүлэх болсондоо баярлан маасганаж, ханцуйгаа шамлаж, тэр хүүгийн дэргэд нь очоод, өөд нь харуулж унагаад, монгол ёсоор өрлөж, уур савссан жижигхэн зүрхийг суга татан, Чингис хаанд өргөн барив.

Чингис хаан, хөгшин бодон шиг, уухай, уухай, уухай! гээд бөгтийж, бор хул морио эргүүлж, чулуурхаг нарийн жимээр өгссөн билээ.

Синдийн тэр байлдааны дараа, Желал-Эд-Дин, газар газар тэнэж, зүрхтэй эр цэрэг элсэж, олон жил монголтой амжилттай тэмцсэн боловч, Монголыг ялж чадмаар их цэрэгтэй болж чадсангүй.

ХАЖИ- РАХИМ БИЧЭЭЧ БОЛОВ

Тэр үдэш, Бухар хотод Махмуд Ялвач, монгол харуулын ирт мэснээс Хажи-Рахимыг авраад хишиг хүртээл дуулснаас хойш Махмуд Ялвачийг сүүдэр мэт дагаж, мөн Дервишийн хойноос бас дүү Туган дагаж явдаг болж билээ.

Махмуд Ялвач, Маверанагр мужийн шинэ эзэн, Чингисийн хөвүүн Цагаадай хааны ерөнхий зөвлөх болоод Цагаадай өөрөө үргэлжид найр хурим хийж, ав шувуу тавьж, зөвлөх Махмуд-Ялвачийн бие, алба гувчуур татаж, Татаарын олзолсон эд хөрөнгийг бүртгэн, Монголд боол шивэгчнийг явуулж, беги ноёдын орхиж оргосон орон байшин, газар хөрөнгийг бүртгэн тэмдэглэж, шинэ алба татвар тогтоон

зарлаж, тусгай татварчинг элч явуулах зэрэг зүйл зүйлийн ажилтайгаас гадна, орон нутгийн ардыг газар нутагтаа буцаж, тариа, хөвөн тариалахыг зарлан сонсгож, хуучин беги ноёдыг хуучин хэвээр суулгаж, ардаас алба түрээс татуулахгүй гэж ятган зарлаж, айж сандрахдаа сарнин тарсан олныг тохинуулан тогтоож, хэрмэл хоосон нойтон амьтан бүлэглэн нийлж, аянчныг дээрэмддэгийг зогсоох арга хийжээ.

Сүүл сүүлдээ, тэр сайхан үг нь цөм худал болж, туркмен, тажиг хивчаг ноёдын оронд Монголын хаад, агул тайж нар эзэд болж, буцаж ирсэн ардууд тэдний зарц барлаг болж, авсан хамаг тариагаа өгдөг болов.

Махмуд Ялвач, Хажи-Рахимыг тамгын газрын бичээч болгосон нь шүлэг зохиодгоо түр боловч орхихоос өөр аргагүй болжээ.

Тамганы дэргэд өглөөнөөс аваад харанхуй болтол бусад бичээч нарын хамт нэгэн том элэгдсэн хивс дээр сууж, эд хогшлын дансыг өвдөг дээрээ цаас тавин бичиж бүртгэх, тушаал хуулах зэрэг олон зүйлийн чухал бичгийн эх зохиох ажил мундахгүй байв.

Махмуд Ялвач, Хажид ямар ч цалин өгдөггүй байснаа нэгэн өдөр,

— Чи цалингаар юу хийх вэ? Баялаг эд эрдэнийн дэргэдүүр явдаг хүний гарт алтан тоос наалддаг биш үү? гэхэд Хажи-Рахим хариу өгүүлрүүн; Яруу найрагч Дервишийн гарт бузар юм үл наалдана. Миний хуучин дээлд олон замын тоос цугларснаас өөр миний гарт юу ч наалдсангүй гэлээ.

Чингэхэд нь Махмуд Ялвач, өнгөтэй шинэ дээл шагнаж бас албан бичигт нь орчлонт ертөнцийн хязгааргүй замаар явж цуглуулсан тоос нь бүү унаг гэж ариун хишигт Баасан гарагийн өмнөх Пүрэв гарагийн өглөө бүр ирж, аяга хоол олж авах, халуун усанд ороход хэрэглэх гурван мөнгөн зоос авч бай гэв.

Хажи-Рахимын оронд өөр хүн байсан бол биеэ хамгийн азтай хүн гэж байх сан биз ээ. Хажийн бие, эзэнгүй бяцхан байшинг өөрийн мэт эзэмшиж, ажил дээрээсээ ирээд, үзмийн хүрээлэнгийн өмнө, шатны довжоон дээр сууж, хуван өнгөт болсон үзмийн хонгорцгийг бахархан үзэж, эзний нэгэн жилийн хэрэгцээнд хүрэлцэхээр ургасан үзэмд сэтгэл баясан, байшингийн дэргэд ургасан их өндөр чанар модны сүүдэр нь, дэргэдэх сүм дээр хүртэл тусаж, Дервишийн бяцхан байшинг сүүдэрлэн, халуунаас хамгаалдаг бахтай сайхан орон сууцтай болсон байжээ.

Бас, тэр хавьд нь үзмийн хүрээлэнг услах шуудуугаар ус урсах бөгөөд үдшийн сэрүүнд Хажи-Рахим, дүү Тугандаа томьёоны бодлого - алгебр, араб бичиг сургадаг байлаа. Гэвч Хажи-Рахим бол жаргалыг эрэгч биш, элдэв жигтэй явдлыг эрэгч бүлгээ. Хэдийнээс түүний дотор зовнин цог мэт цохилон, удалгүй хийж байгаа ажилдаа дургүй болов.

Өдөр бүр хэдэн зуугаад хүн ирж, Монголчууд номхон суугаа иргэнийг дарлаж хавчдагийг гомдол мэдүүлж, улс нь бүгдээрээ түрэмгийлэн эзлэгчдийн захиргаанд орсон учир, ард иргэнийг хонины хотод орсон чоно мэтээр захирч байхад Хажи-Рахимын бодсон нь: «Дотно элгэн ард олныхоо дайсанд захирагдаж явах этгээд, сайшаал хүртэхгүй, хараалыг хүртэх нь зүйн доторх хэрэг тул одоо больё» гээд Махмуд Ялвачид очиж, сэтгэл дотроо чухам юу бодож байгаагаа нэгд нэгэнгүй үнэнээр хэлэх гэж шийдэв.

Махмудын бие, үзмийн хатсан мөчрийг хайчилж, бие сэтгэлээ амардаг зантай тул их харшийн цэцэрлэг дотор үзмийг засаж байхад нь Хажи-Рахим олж очоод хэрэг учраа хэлэв.

Махмуд, Дервишийн үгийг сонсоод өгүүлрүүн:

— Чи зовлонд баригдаж, шархаар дүүрсэн төрсөн эхээ орхиж явахыг хүснэ үү? гэж асуухад Хажи-Рахим хариу хэлсэн нь: Өөрийн ард түмнийг боолчлогчдын ашиг тусын тулд зүтгэхийг би үл хүснэ гэв.

Үүнд Махмуд өгүүлрүүн: Үүгээр бол чи намайг нэгэн адил ард түмнээ дарлан зовоож, боолчлогчдын тулд зүтгэдэг хорт этгээд гэж үзэж байгаа биз ээ. Тиймийн тулд би чамд хариу тавья гээд өгүүлсэн нь: Манай эзэн их Чингис хааны ерөнхий зөвлөх Елюй-Чуцай гэдэг хятад хүн бий. Тэр хүн үргэлжид Чингис хаанд эмээлгүй үнэнийг ярьж, олон хот балгадыг сүйтгэн бусниулахыг хориглон зогсоосон гавьяатай хүн юм аа.

Тэр хүн, Чингис хааныг хүн ардыг хүйс тэмтрэн хядвал чамд, чиний ач нарт хэн алба өгөх вэ гэдэг юм.

Тэгэхэд нь Чингис хаан, бум түмэн олзлогдогсдод өршөөлийг үзүүлдэг билээ. Би тэр Елюй-Чуцайн нэгэн адилаар, Чингисийн хөвүүн Цагаадай хааны дэргэд лалын ард түмнийг хядуулан устгахаас аврахыг оролддог.

Чи Цагаадайн нүүрийг харахдаа, түүний нүд аль зэрэг хилэнтэй догшныг үзсэн биз ээ.

Өдөр бүр хүнийг хуруугаараа зааж, барьж ав-алып барын гэж сүрдмээр үг хэлэхэд тэр заасан хүнийг нь цаазаар аваачдаг шүү.

Мөн өдөр бүр би түүнээс өршөөл соёрхохыг гуйж оролддог гэхэд Хажи-Рахим өгүүлрүүн:

«Би өөрийн эх орондоо үлдье. Харин та надад өөр нэгэн ажил өгнө үү. Би цус нэвтэрсэн хувцас тоолж, хүний нулимсыг үргэлжлэн үзэж байх чадалгүй боллоо гэж хэлэхэд Махмуд өгүүлрүүн: За, чингэвэл, би чамд чухал даалгавар өгье гэвэл.

Хажи-Рахим өгүүлрүүн; Эзэн минь би ямар даалгавар байгааг сонсъё гэв.

Үүнд Махмудын өгүүлсэн нь: Хойд ба баруун зүгийн олон улсыг захиран шийтгэгч Чингисийн их хөвүүн Зөч хаан, Хоресмийн хойд талыг дагуулахаар мордсон гэж би сонсов гэсэнд Хажи-Рахим өгүүлрүүн: Гурганжийн төмөрчин, зэсчин, Бухар, Самаркандын ирсэнтэй адил байлдалгүй бууж өгөхгүйг, би баттай хэлж чадна гэхэд нь Махмуд өгүүлрүүн, Би Зөч хаанд нэгэн захидал явуулах хэрэгтэй юм сан. Гэвч зам зуур Кызыл Кумийн элсэнд Монголчуудыг алдаг цэрэг (Хар баатар) гэж алдаршсан нэгэн хээр морь унасан хүнээр удирдуулан үзэгддэг нь ер баригддаггүй, гэнэт энд тэнд Кызыл Кумийн хоёр үзүүрт үзэгдээд, мөн гэнэт ор мөргүй алга болдог гэнэ. Лав чөтгөр түүнд тусалдаг биз ээ гэж ардуудын дунд цуурхал тарсан байна гэвэл, Рахим өгүүлрүүн:

— Тэр «хар морьт баатар» байгаа нь лал нарын дунд зоригтой, сайн эр хүн үлдсэнийг гэрчилж байгаа гэсэнд Махмуд өгүүлрүүн: Зөч хаанд өөрт нь өгөх захиаг би чамд өгье. Чи монгол харуул буюу тэр хар морьтой баатрын аль алинд ч алдалгүйгээр нуун далдлах хэрэгтэй. Хэрэв түүнийг алдвал намайг, өөрийгөө ч алсантай адил болно гэсэнд,

Хажи-Рахим доошоо харж (явуулсан хүн нь сүйдэж болох ямар захиа юм бэ) гэж бодоод, өөдөө хартал үдшийн алтан тэнгэрийн наагуур, усан үзмийн навч сүлжин зурайж, Махмуд Ялвач ер хөдлөлгүй зогсож, түүний харц нь Дервишийн санааг нэвт харж байгаа мэт, мөнгөн буурал болсон сахал дээрээ гараа тавьж, ам нь инээмсэглэсэн мэт боллоо.

Хажи-Рахим өгүүлрүүн: Би тэр захиаг Зөч хаанд хүргэе. Түүнийг завсраас хэн ч олж үзэхгүй, би өөрийн таягт нүх хийгээд дотор нь захиагаа хийгээд, мэдэхийн аргагүй бөглөж битүүлье.

Гэвч, их хаанд хүрэлцэн очиж чадах болов уу. Энэ хэр дайралдсан бүхнээ алдаг тийм дээрэмчнээр дүүрэн хивчагийн талд байлдаж байгаа сурагтай гэнэ. Би энд чиний хөлийн дэргэдүүр мөлхөгч цох

хорхойтой адил байна. Чиний хүчит гарын хамгааллаас гарахдаа би яах бол. Тэр (хар морьт баатар)-аас би айхгүй. Монголын харуул дайралдвал намайг барьж аваад хэсэг хэсэг хэрчиж хаях нэг аюул бий гэхэд нь,

Махмуд Ялвач бөхийж, явган зам дээрээс нэгэн цох хорхой барьж аваад, нарийхан цайвар алган дээрээ тавив.

Тэр хорхой, хурууны үзүүр хүртэл гүйж, далавчаа дэлгэж нисэв.

Махмуд Ялвач хэлсэн нь: Энэ хорхойн адил, чи мянган цэргийн орж чаддаггүй газар луу нэвтэрнэ. Чи лалын шашны ариун Дервиш лам мэт мөн л хуучин дээлээ өмсөөд, номхон илжгээ хөтөлж, судар номоо ачаад яв.

Чамайг Монголын боомт дээр саатуулахгүйн тул би чамд шонхортой алтан пайзыг өгнө гэсэнд, Хажи-Рахим хэлсэн нь: Би дүү Туганаа яах вэ гэсэнд, чи дүүгээ шавь ёсоор хамт аваад яв. Тэр чинь Зөч хааны тэнд цэргийн эрдэм сурч, хашир цэргийн эр болно. Чингээд чиний явах зам дөхөм хялбар болно гэхэд Хажи Рахим хэлрүүн: За, тэгвэл, бүү зовоорой. Би бүгдийг гүйцэтгэе гэв.

Махмуд Ялвачийн өгүүлсэн нь: Чи аялах замаа дууссан цагт миний төлөө мөргөөрэй. Би чамд сайн санадаг хөгшин хүн билээ гэв.

ХАР МОРЬТ БААТАР

Хажи-Рахим, Туган хоёр оройхон мордож, зээлийн газраас хоосон арагтай буцаж яваа хөдөөгийн хүмүүсийн цуваанд нийлэв.

Замын хань нь цөм уван цуван хажуу тийшээ эргэж, замаас гарч өөрсдийн суудаг шатсан тосгон руу гарч одов.

Хажи-Рахим, хуучин заншлаараа араб дуу дуулж, нэгэн жигдээр алхаж явав.

Туганыг үзвэл их том болжээ. Залуу эрийн ёсоор толгой ороосон цэнхэр алчуурын доогуур мушгирсан урт хар үс цухуйж, мөрөн дээр нь буужээ. Туган, үүргэвч шуудайг нуруун дээрээ хаяж, урт гэгчийн мод тулж, тохиолдсон дов довцог дээгүүр хөнгөхөн гүйгээд, алсад цэнхэрлэн зэрэглээтсэн уулс руу ширтэн, орчин тойрныг ажигласаар бүгдийг тэмдэглэж, цөмийг мэдэхээр хичээж, Гурганжийн гяндангийн харанхуй нойтон зооринд өнгөрүүлсэн хэцүү цагийн дараа онц баясгалантай, дүүрэн жаргалтай байдлаар цэнгэж явах болжээ.

Урт чихтэй хар илжиг хатуу туурайгаараа пад падхийн явж, илжгэнд ачсан шуудайд ном судар, араб персийн яруу найрагчийн зохиол, хэдэн өдрийн хүнс явжээ. Аялан явахад заримдаа алсын тоос манаран харагдаж, модны цаанаас дээд даргаа хүрээлсэн буюу шуудай будаа ачсан, аажимхан явж байгаа тэмээг хамгаалан явж байгаа морьтой монгол хүмүүс үзэгдэж, Монголчуудын нэг нь бусдаасаа тасарч Хажи-Рахим руу давхиж ирээд, чи хэн гэгч вэ? Хаашаа яваа вэ? гэж, Хажи-Рахим хариуд нь дув дуугай малгайгаа хойш шил рүүгээ түлхэн, нисэж яваа шонхрыг дүрсэлсэн, нарийхан хүрээтэй, алтан пайзаа харуулахад тэр монгол ташуурtай далайсан гараа аяархан буулгаад, «баяртай, сайн яваарай» гээд морио эргүүлж, цэргээ гүйцэх гэж давхидаг байв.

Дервиш, гозгор оройтой малгайгаа цохдуулаад, дахин алхалж, шинэ дуу аялан,

Амьтан бүгдийн сөнөх
Аюулт тэр зүгт
Ачаат хар илжиг минь
Алхаад бай урагшаа.
Олон хүн
Ор дэр дээрээ үхжээ.
Онц зарим аймтгай нар л харин
Улаан элсэнд ойчихоос айдаг

гэж дуулдаг байжээ.

Чингэж явтал нь цөл газар довын цаанаас санамсаргүй дөрвөн морьтой хүн давхиж ирээд, зам хөндөлдөн зогсож, наранд түлэгдсэн пад хар нүүртэй, үрчгэр царайтай нэг өвгөний зогсож бай, чиний нэр хэн бэ? гэж хашхирахад, мэнд амгаланг эрье гээд мөнөөхөн Дервиш, бадарчин чи миний нэрээр яах нь вэ? гэвэл өвгөний өгүүлсэн нь:

— Би чамайг мэдэж байна. Чи надаас гарахгүй. Чи лал Махмуд Ялвачийн дэргэд байсан бичээч билээ. Монгол болохыг оролдсон чинь ичгэвтэр биш үү.

Чи түүнд ардыг дээрэмдэхэд тусалж явсаар, одоо түүнийхээ төлөө миний сэлмийн хурц ирийг амсана гэхэд нь Хажи-Рахим хэлсэн нь:

— Чиний үгний дотор шударгуу үнэн хоёрхон дусал байна. Харин үлдсэн хувь нь хар худлын булингарт урсгал гэмэгц юү, худал

гэж үү гээд өвгөн догшрон хашхирч, даруй махир сэлмээ хуйнаас суга татав. Үүнд Хажи-Рахим хэлсэн нь: Лалын шашинтан хүндэт Махмуд Ялвачийн дэргэд бичээч байсан минь үнэн. Миний үхвэл зохих нь ч мөн үнэн. Үхэхээ би үзнэ. Ер үхэхээс хэн зайлж чаддаг билээ. Харин, би ер хэнийг ч дээрэмдсэнгүй, гагцхүү, Монголын дээрэмдсэн тухай урт хуйлмал цаасан дээр бичиж авсан бөгөөд Махмуд Ялвачид гомдол хүсэлтийн хамтаар ирсэн хэн нэгэн этгээдэд буюу гомдсон бүхэнд өргөдлийг бичиж өгдөг байсан гэсэнд мөнөөхөн өвгөн өгүүлрүүн: Хэрэв, бадарчин Дервиш, чи энд байран дээрээ алчуураар ороосон толгойгоо гээх дургүй ахул, даруй бидний хойноос дага. Харин зугатаахыг битгий оролдоорой гэж зандрав. Үүнд Хажи-Рахим өгүүлрүүн;

— Хэн намайг уривал, би тэр зүг очдог билээ. Харин, чи надад нэрээ хэлсэнгүй. Хэрэв чи биднийг үхлийн далайд живүүлэх ахул, Аллах тэнгэрт би хэн намайг ингэв гэж гомдол мэдүүлэхийг мэдэхгүй болно гэсэнд тэдний нэг нь өгүүлрүүн: Чамайг Аллах тэнгэр шийтгэхээс урьд, хар морьт баатрын илд шийтгэнэ. Манай даргатай чи инээдмийн үг хэлэлцэхэд хүрэхгүй гэв. Тэр хэдэн морьтой хүн, замаас гарч эргээд, чанх хойш хандаж, улайдсан шар элсэн дундуур лав оров. Энд тэнд армаг тармаг ургасан харгана, сухай, яаруу гүйж яваа гүрвэлээс өөр юү ч үзэгдэхгүй тул газрын байдал уйтгартай бэрх мэт үзэгдэв. Туганыг Хажи- Рахимд шивгэнэн ер бидний эцэслэх цаг ирсэн буюу? Юунд чи энэ тусгүй аянд явахыг зөвшөөрсөн бил ээ? Бид Самаркандад ямар тайван, жаргалтай амьдарч байв гэсэнд, цагаас өмнө гашуудах хэрэггүй. Өдөр бас өнгөрч гүйцээгүй, харин ирээдүйд юү ч болж болно гэж хариулжээ.

Цөм хойд зүгийг барьж нэлээд удаан явцгаав. Эцэст дөнгөж мэдэгдэх төдий хоёр замын уулзарт хүрээд, өнөөх морьтой улс зогсож, нэг нь довцог дээр гарч, эргэн тойрон зүг бүр харж харж, гараараа баруун тийш зангаж, тийшээ түргэн яв, түргэн яв аа. Нар жаргах боллоо гэжээ. Тэгээд бүр харанхуй болоход Хажи-Рахим, дүрэлзэн байгаа задгай гал тийш ойртож, бүгд хуурай гангын ёроолд сууж, Дервиш Туган хоёрын гар нь ардаа хүлээстэй, хүзүү нь аргамжаар оосорлоотой, харанхуйд оргох магадгүйгээс болгоомжилжээ. Өнөө хоёрыг барьсан өвгөн, хоёулыг галын дэргэд авчирч, сөгд гэж тушаагаад хажууд нь илжгийг нь зогсоов. Задгай галын дэргэдэх бяцхан хивс дээр туранхай дүнсгэр туркмен завилан сууснуг үзвэл, наранд шарагдаж,

хүрэн царайтай, гялалзсан дүгрэг нүдтэй хүн байв. Бас түүний хажууд хивс дээр илд нь дамналдан хэвтэж байсныг хараад Дервиш,

— Энэ омогт эрийг би хаана үзэв? гэж бодсоор нөгөө туркменийг ажиглаж, лав энэ бол өнөөх «Хар морьт» болов уу? гэж бас бодов. Тэр хүн туркмен хар дээлтэй, хар малгайг шилэн дээрээ хойш унагаж, тэрүүхэн дэргэд нь өндөр хар морь нь уяатай байв.

Задгай галыг тойрон, уранхай хувцастай боловч, харин зүйл бүрийн мөнгөн зэвсэгтэй хориод хүн сууж байв.

Манай хоёрыг тэдний зарим нь шогтой, зарим нь өшөөтэйгөөр харж, нэг нь хар илжгэн дээрээс хивсэн уутыг буулгаж, дотроос нь хэсэг жаврай, үзэмтэй боодол, гуа, бяцхан бяслагийг сэгсрэн гаргаад, гурилтай хүүдийг аятайхнаар гаргаж тавиад, гуравдугаар хивсэн уутыг сэгсэрсэнд дотроос нь бэх үзгийн сав, хэдэн ном судар, хуйлмал бичиг, зэмсгийн дархны хэрэгсэл үзэгдэв.

Дүгрэг нүдтэй хүн, нэгэн номыг авч хэдэн хуудсыг эргүүлж өгүүлсэн нь: Энэ лав, урт сахалтай бүдүүн имам лам нарын туранхай өлөн шавь нарынхаа толгойг эргүүлдэг элдвийн номлол сургаал байгаа биз ээ гэсэнд, тийм биш, эрхэм цэрэг авгай, энэ ном бол ертөнцийг дагуулсан их Искендерийн тухай ном гэж Хажи-Рахимын хариулахад тэр дайч эрийн түүхийг сонсох юм сан. Гэвч, чамд түүнийг хэлж өгөх цаг эс үлдэв. Одоо чиний сүнсийг эрлэг авч одно гэв.

Хажи Рахимыг авчирсан өнөө өвгөн, илжгийг хажуу тийш зайлуулж, яргачны хонь алдаг нарийхан урт хутгыг аажимхнаар бүснээсээ авч, Дервишийг эрүү дээрээс ширүүн гараар барив. Чингэтэл:

— Өвгөн хутгалахаа түр хүлээ гэж нэгэн хүний өгүүлэх нь: Манай дарга бусад номд юу бичсэнийг мэдэхийг хүсэж байна гэсэнд үхэн алдтал багалзуурдуулсан Дервиш сөөнгө хоолойгоор өгүүлрүүн; Нэгэн номд цөл говийн алдарт хар бүргэд, аянчны аянга болсон эрийн баатарлаг явдлыг бичжээ гэсэнд, тэр хэсэг цэргийн дарга нь

— Байз, наадахыг тавь, өвгөн! гээд тэр номын хуудсыг хичээн эргүүлж, байлдаж байгаа цэргийг дүрсэлсэн зургийг харж эхлэв.

Өвгөн Хажи-Рахимыг түлхэж орхиод, хараан зайлав.

Хажи-Рахим, харанхуй огторгуйд гялбалзан байгаа одод, задгай галын дүрэлзэн байгаа улаавтар туяа суугчдын ширүүн царай, орчин тойрны цөл говийн элс, энэ бүгдийг харж, «Хэн миний амь аврах бол? Хэрэв тэнүүлчин намайг хэн ч хайрлахгүй болж гэм, саяхан шаг хааны

харанхуй зооринооc мултран гарсан зэвсгийн дархан энэ хүүг эд өрөвдөх ёстой билээ. Дервиш, хүн нүхэн тамд унасан ч, гуних ёсгүй. Унах зуур дээл нь хадны сэртгэрт тээглэх магадгүй эсхүл нисэж яваа ямар нэгэн бүргэдийн далавч түших юуны магад гэж бодтол, Туган хажуугаас шивнэж бидний үхэх цаг ирж байгааг чи мэдэхгүй гэж үү? гэв. Дервиш, өдөр бас өнгөрөөгүй байна. Бидний өмнө урт шөнө бий. Энэ шөнө юү болохыг хэн ч урьдаас хэлж чадахгүй гэж хариулжээ.

Хар морьт баатар, шар илгэн хавтастай номыг өмнөө тавиад, үүрийн цолмон гарахыг хүлээхэд удахгүй боллоо. Буруу номтны энэ зарцыг алахад яарах хэрэггүй. Бид энэ тэнүүлчний үгийг сонсох юм биш үү. Бидэнд зүрхтэй баатрын эрэлхэг явдлыг ярьж өг гэсэнд Туганы шивнэсэн нь үнэхээр дандаа ингэж хөл дээрээ бохирч байж, чи эдэнд ярьж өгөх юм уу? нэг ч үг битгий ярь. Яана, биднийг эд даруй албал, үүнээс дээр гэхэд хүлцэж бай гэж Туганд хэлээд Хажи-Рахим бас өгүүлрүүн: Шөнө урт. Ирээдүйд бас санамсаргүй явдал болж болно... гэв.

Яриулъя. Алтан гургалдай торонд донгодохдоо дурaараа явсан цагийнхаасаа илүү донгоддог гэжээ.

Чингэхэд Хажи-Рахим сонсоцгоо гээд, өгүүлрүүн: Бид одоо та бүгдэд хоёр эвэрт Искендрийн тухай ч биш, Рустем зоравийн тухай ч биш, харин цөл говийн алдарт дээрэмчин хар бүргэд туркмений хүүхэн Гүль-Жамалын тухай ярьж өгье гэтэл,

Дээрэмчний дарга «Гүль-Жамал» гэхийг сонсмогц, Дервиш хөмсөг сөхөн гайхан хараад зөв тийшээ хажуулдан хацраа алгаараа тулаад хөлстэй үлгэрчийг галтай хар нүдээрээ ширтэв.

ХАЖИ-РАХИМЫН ҮЛГЭР

Хүүхэн түргэн алхаж, миний хажуугаар өнгөрөхдөө
хормойгоороо намайг шүргэв.
(Дорно дахины үлгэрээс)

«Туркмений уудам цөл дэх нэгэн хоосон айлд Гүль-Жамал гэгч нэгэн ядуу малчин охин байж гэнэ ээ, гэж Хажи-Рахим аялан өгүүлж эхлэв. Гүль-Жамал олон дуу мэддэг байж гэнэ ээ. Хурга услахдаа дуулдаг тусгай дуутай, бас хургаа тогтоон бэлчээж, хол тараан явуулахгүй гэвэл, тайван сайхан аялгуутай нэг дуу дуулдаг байв.

Хүйлэн хөх чоно айсуй гэж огцом аягүй дуутай нэг дуугаар хоцорсон хургаа шавдан түгшүүртэйг мэдэгдэх нэг дуу дуулахад нь бутны сүүдэрт тайван унтаж байсан хурга нь сандран босож, урт шилбүүр барьсан Гүль-Жамалын зогсож байгаа довцог өөд тэвдэн гүйж, сагсгар үстэй гурван нохой хуцаж, хоцорсон хургыг ижилд нь нийлүүлдэг байв.

Тэр олон дууг Гүль-Жамал олон жил мал хариулж, урт лимбэнд дуу оруулж сурсан хоньчин Коркудээс сурчээ. Өвөг эцэг нь их ядуу хүн, айлын мал хариулж, амиа тэжээж явсан билээ. Хэдийгээр хот айлынхаа захад өөртэйгөө адил хуучин муу гэртэй боловч, айлд дараалан хэсэж, амь зууж явдаг билээ. Эхнэр нь үхээд хоёр хүүгээ Хоресм шагийг уулын дархан чөлөөт афганчуудтай байлдахад амь үрэгдсэнээс хойш өвгөн цор ганц болсон билээ. Чингэтэл, нэгэн охиноо урьд алс нутгийн хүнд өгсөн нь хумсын чинээ бяцхан охиныг элгэндээ тэвэрч, нүүр ам нь хөх няц цус хурсан амьтан хүрч ирээд, хэд хоног өвдөөд, нас барахад нь тэр хүн юунаас тэгснийг хэн ч эс мэдсэн билээ. Хөгшин хоньчин Коркудээс асуухад, Аллах тэнгэр лав чингэх гэсэн биз ээ. Хүүхэн хүнд тэр бүр сайн эр тохиолддоггүй шүү дээ гээд өргөн ханцуйгаар үрчгэр хар нүүрээ дардаг байжээ.

Коркуд, анх ач хүүхнээ тэжээвэр хурга мэт бөөцийлөн энхрийлж, хонио хээр хариулж явахдаа охиныг илгэн уутанд хийж, нуруун дээрээ үүрч, заримдаа охинтой уутандаа өвчин туссан хургыг дээрээс нь хийж авч явдаг билээ.

Гүль-Жамал өсөж, өвгөнтэй зэрэгцэн дагаж явах болж, өвгөнөө лимбэдэхэд нарийхан хоолойгоор дагаж дуулаад, хоцорсон хургыг нохойн хамт гилж явлаа. Гүль-Жамалыг том болмогц Коркуд, өөрөө хариулж чадахгүй, хуучин муу гэрийнхээ ойр эсгий дээр хэвтэнэ. Миний оронд хургыг ач охин хариулж яваг гэж билээ. Тэр үед өвгөний эгч эмгэн, үсгүй нүцгэн илжгээ унаж, хүрч ирээд, хамт нэгэн гэрт амьдрах болов.

Коркуд, ач охиноо хээр буг чөтгөртэй уулзаад, эхнэр болгон худалджээ гэж бүх айл цуурхан хэлэлцэх болов. Зарим хүн, өвгөнийг булшнаас эрдэнэ олжээ гэж элдэв цуу үг хэлэлцэх болов. Үнэнийг хэлбэл, Коркудэд үнэхээр гэнэт эртний зэс тогоо бий болж, өрхөөр нь үргэлж утаа баагьж, ядуу хоньчин өвгөн ирсэн зочныг цайгаар хүндэлдэг болжээ. Чингэсээр, нэгэнт насанд хүрсэн ач охиноо эрд өгөх чухал цаг тулгарч ирэв. Тийм хүүхний сүйд тэмээ, морь, үхэр, хонь зэргийн өдий төдий юм хэн ч дуртай өгөх болно. Чингэвэл, тэр

өвгөний санаа бүр амарч, ширдэг дээрээ хэвтээд, дураараа айраг ууж, өдөр үүлийг харж, шөнө одыг ажиглаж байхаас өөр ажилгүй болох болно. Коркуд, ач охиноо хүнд өгөхийг яарахгүй, Гүль-Жамалыг гуйж ирсэн бүгдэд өндөр их сүй шаарддаг тул хүүхнийг гуйгч бүхэн мохож, тэр хоньчин өвгөний хомхойг гайхаж буцдаг болов. Гэвч, дахин дахин ирж, цөхрөлтгүй гуйх нэг хүн гарав. Тэр нь их замын алдарт барс, аянчныг сүйтгэгч аянга болсон дээрэмчин Хар бүргэд билээ.

Хар бүргэдийн өгүүлсэн нь: Хүүхэнд дурлавал, сүйг хайрлахгүй. Өвгөн Коркуд, хэчнээн юм хүсвэл, төчнөөнийг өгнө гэжээ.

Гэвч, тэр дээрэмчнийг шөнө ирэх бүрд өвгөн ер шийдтэй үг хариу өгөхгүй, бодож байна гэж хэлдэг байв. Өвгөн тэнгэрийн од харж байгаад тэмээ, морь, хонио цөмийг нэгмөсөн алдаж чөтгөрт шоглуулсан бололтой. Юу гэвэл, Хоресм Шагийн тахар (зарлага) ноднин эсэргэн энэ гурван жилийн татвар хамтатган татахаар ирж, адуу, үхэр цөмийг хөөж аваачсанаас гадна, харьяат албат нь хамгийн сайхан хүүхнээ, хамгийг чадагч Шагтаа өгөх үүрэгтэй гэж Гүль-Жамалыг авч одсон билээ. Шөнө дунд Коркудийн гэрт дээрэмчин Хар бүргэд давхиж ирээд, өвгөний ширдгийн үзүүрт шөнө турш сууж, тэр ирсэн хүний дарга нь хэн бэ? Ямар ямар морьтой, ямар эмээл тохомтой вэ? гэх зэргээр нарийвчлан асууж, бүгдийг лавлаж мэдээд, одоо би тэднийг цөмийг шөнө боловч олж чадна. Хоресмийн далайн ёроолд нуугдавч, би тус бүрийг дараалан цөмийг хамтруулж өшөөг авч чадна. Харин Гүль-Жамалыг олж, өвгөн Коркуд чамд авчирч өгнө. Чингээд их хуримыг хийж, би тэр хүүхнийг гэртээ эхнэр болгон аваачна. Би чамд тэмээ, унагатай гүү, тугалтай үнээ, есөн хонь өгнө гэсэн билээ. Харин одоо би чамд бүгдийг ес нугалж өгөхийг баталъя. Гагцхүү чи ач охиноо надаас өөр хүнд өгөхгүй гэж над бат үгээ хэл гэв. Чингээд, өвгөний өвдөг дээр дэнчин болгож нэгэн хүүдий мөнгөн зоос хаяад, моринд алавхийн мордож, шөнийн харанхуйд далд оров» гээд үлгэр хэлж байсан Хажи-Рахим дуугүй болж, амьсгаадсаар хажуу тийшээ унажээ. Задгай галыг тойрон сууж байсан хүн амьтан, чингээд юү болов? Дээрэмчин тэр хүүхнээ олох болов уу гэх зэргээр асуусанд Хажи-Рахим өгүүлрүүн: Эвий! Зүрхтэй дээрэмчин сайхан хүүхэн хоёр үнэхээр жигтэй явдалд учирсан юм. Гагцхүү би үлгэрийг үргэлжлэн хэлж чадахгүйд хүрэв. Хүлээс минь бие рүү шигдсэн тул тэсэх аргагүй болов гэв.

Түүний хүлээсийг тайл гэж «Хар морьт баатар тушааж, чингэтэл Хажи-Рахим,

— Миний дүүгийн гар нь бас хэцүүдэж байгаа, хүлээсийг тайлна уу гэж хэлээд, ар тийшээ эргэж, нүдээ анив.

Өнөө өвгөн туркмен, их л гомдолтойгоор тэр хоёрын гарын хүлгийг тайллаа. Чингэхэд нь элсэн дээр аятайхан засаж суугаад, Дервиш үлгэрээ үргэлжлэн хэлж, үүр гийх үеэр хар бүргэд, хээр яв явсаар хан хөвүүн Желал-Эд-Динтэй дайралджээ. Тэр хар хөвүүн, буга хөөсөөр, дагалт нь хоцорсон учир, төөрсөн байжээ. Морь нь эцээд эзэн нь өлсөж, цангаж үхэхэд хүрч явтал, өвгөн Коркудийн гэр харагджээ. Өвгөнийд буухад нь өвгөн аятай сайхнаар угтаж, хөвүүн морь хоёрт хоол өгч амруулж билээ.

Тэр үед Хар бүргэд ирж, гэрт санамсаргүй оржээ. Чингээд дайсныхаа хөвүүнийг мэдэлгүйгээр их л удаан ярилцжээ.

Хан хөвүүн, Хар бүргэдтэй салах ёсыг гүйцэтгэхдээ хотын зах дахь Тиллялы гэдэг ордонд минь уулзъя гэж урив. Чингэхэд өнөө дээрэмчин өст хааны хөвүүнтэй ярьснаа сая мэдэв. Гэвч, зочдыг хүндлэх журмыг баримталж, түүнийг хүндэтгэж, хааны хөвүүнд заавал айлчлан очихоор ам өгөв. Чингээд, удалгүй хааны хөвүүнтэй уулзахаар нийслэлд очвол, цөл говийн нүүдэлчин, тэнүүлчин, бадарчин, алс газраас ирдэг аянчныг хотын зах дахь ордонд ирүүлж уулзах зэргээр эгэл дорд хүнтэй нөхөрлөв гэж Шаг хаан дургүйцэж, залуу хан хөвүүнийг гадуурхдаг болсон байжээ.

Шаг хаан, хөвүүнээ эцгийг эсэргүүцэн хуйвалдаж болзошгүй гэж сэжиглэж, түүний хөдлөх бүрийг хянаж байх болсон учраас хөвүүний ордон, цэцэрлэгийн орчин тойронд нууц манаа тавьж, ирсэн гарсныг цөмийг харж байх болжээ. Хар бүргэдийг Тиллялы ордонд ирэхэд Шагийн хөвүүн баяртайгаар угтан тосож, амтат идээгээр ихэд хүндлээд, хөгжимчнийг хөгжимдүүлж, эртний байлдааны дууг дуулуулжээ. Шөнө Хар бүргэдийг мордъё гэж хүссэнд хан хөвүүн өгүүлрүүн: Өглөө болтол байзна. Өглөө болмогц хотын гадна хамгаалан гаргаж өгөх хүнийг томилж хамт явуулъя гэж хэлсэнд тэр дээрэмчин өгүүлрүүн: Хар бүргэдэд халдах зүрхтэй хэн байх бэ? Миний илд хорин морьтой хүнийг ч буцааж чадна гээд цэцэрлэгийн хаалгаас гарчээ. Гэтэл, тэр дор нь дээрээс нь загасны бөх тор хаяж, илдээ ч шүүрэн авах завдал өгсөнгүйгээр түүний гарыг хумхиж авлаа. Чингэж хүлж аваад, шүүх эрүү шүүлтийн байшинд хүлээстэй хэвээр нь

аваачиж, Шөнө зандалчны ерөнхий дарга «хилэнт ноён» гэгч Жихан Пехлеваныг Хар бүргэдийг байцааж, түүний бие дээр халуун цог тавьж, юунд хан хөвүүний цэцэрлэгт оров гэж байцаасанд Татаарын хааны адуунаас хамгийн сайн морийг хулгай хийж бегид аваачиж өгөхөөр би амласан билээ гэж батлан хэлжээ. Эцэст Жихан Пехлеван, тэр зоримог эрийг зодож асуусаар ядарсан учир, ялын цамхагт аваачиж хийхээр тушаажээ. Хар бүргэдийг олон зандалчин бүслэн тойрч, харанхуйд өндөр цамхагт аваачин явтал чихэнд нь гэнэт нэгэн хүн сэм шивгэнэж, «Чи баруун талдаа тэмтэрч, төмөр гохноос бариарай» гэжээ. Чингэж хэлэхийн хамт гарын хүлээсийг үл мэдэгдэх сайн сэтгэлт нөхөр султган огтолсонд Хар бүргэд одоо биеэ хамгаалж чадахуйц болсон боловч, мэдэгдэлгүй дуулгавартайгаар цамхагт орж, өндөр нарийхан шатаар дээш гарвал, бамбарын сүүмэлзсэн гэрэлд, дээр бяцхан хаалга нээгдэж, тэр хаалга руу Хар бүргэдийг түлхэж оруулахад, явж өгөхгүй чирүүлсээр байтал, бамбар гэнэт бөхсөн тул, дээрэмчин Хар бүргэд даруй гараа суллан, баруун талдаа байсан том төмөр гохыг дороо тэмтрэн байв. Гэтэл, «нэг нохой хорогдов» гэж нэгэн хүний өгүүлэх нь сонстоод, хаалга тавхийн хаагдаж, Хар бүргэд хав харанхуйд хоцорч, хөлд гишгэх газаргүй, гохыг барьж өлгөгдсөнөө мэдэв. Тэр төмөр гохоо барьж байгаад арайхийж, солгой гараа олсноос суллаж аваад хоёр гараар гохноос барьж дүүжлэгдэн байхад арай дээр болов. Чингэсээр өглөө болж, үүрийн туяа хуучин цамхгийн ангархайн завсраар тусахад цамхгийн дээвэрт байсан гохноос дүүжлээстэй байгаагаа сая мэдэв. Доош харвал гүнзгий хар нүх харагдаж, бүдэг архирах чимээ сонстож, бас хар сүүдэр хөдөлж, овоолоостой яс үзэгдэв. Хэрэв тэр нууц нөхөр эс тусалбал тэр төмөр гохноос барьж төдий л удаан дүүжлэгдэн тогтох чадал хүрэхгүй нь гээд Хажи-Рахимыг дахин дуугүй болж, задгай гал руу ажиггүй харж суухад нэгэн хүн цааш юу болсныг хурдан хэл. Хар бүргэд чингээд яасан бэ? Гүль-Жамал яасан бол доо, түргэн ярь гэж хэлэв. Үүнд Хажи-Рахим хэлсэн нь: Энэ хөвүүнд бяцхан ус унд, талх боорцог өгч болох болов уу. Мөн надад амны цангаа гаргах юм хэрэгтэй байна. Би өглөөнөөс хойш балга ч юм уугаагүй гэхэд нь жаврай, үзэм зэрэг юм байгаа бүгдийг энэ хүнд өг гэж мөнөөхөн «Хар морьт» тушаав. Чингээд нар гарахад ойртож байна. Өвгөн Дервиш ээ, үлгэрээ хэл гэв. Хажи-Рахим, аяга таргийг аажимхан уугаад, «Шаг хааны хөвүүн, тэр үед цэцэрлэгтээ байгаа саглагар хар модны сүүдэрт сууж цэнгээд хайрт морио амтайхан

гуагаар тэжээж байв. Чингэтэл, шадар нөхдийн нэгэн бөгөөд газар бүр явж юм бүгдийг мэддэг нэгэн хүн нүдээ дөнгөж ил гарган нүүрээ боож ирээд, хан хөвүүнд шивгэнэсэн нь; Цөл говиос ирсэн зочныг цэцэрлэгийн хэрмийн дэргэдээс барьж, хааны торгон цэргийн даргад аваачиж, тэндээс «ялын цамхаг»-т хүргүүлжээ, гэсэнд хан хөвүүн маш ихэд уурлаж, нөхдийг мориндоо морд, байлдахад бэлхэн бай гэж хэд хэдэн морьтой зэвсэглэсэн хүмүүсийн хамт хот руу давхин орж, тохиолдсон гудамжны харуулыг хөөн сандраасаар шууд хүнийг алдаг газрын дэргэж байгаа эртний өндөр цамхагт хүрч ирэв.

Дүнсгэр манаач нь айж зугтаагаад, тэдгээр зэвсэглэсэн эрс цамхгийн хаалгыг сүхээр хэмх дэлдэж орвол Желал-Эд-Дин, шатаар дээш явсаар цамхгийн оройд нь хүрч, тэнд бас нэг хаалга байсныг хэмх дэлдэв. Хаалгыг нээвэл хав харанхуй худаг мэт нүх ангайж, баруун туурганд байгаа бяцхан төмөр гохыг нэгэн хүн тас шүүрэн дүүжлээстэй байв. Тэр хүнийг болгоомжтойгоор авч, шат дээр авчирвал, Желал-Эд-Дин, бамбар шатааж, нүхийг гэрэлтүүлэн харав. Нүхний ёроолд гялалзсан нүд харагдаж, архирах дуу сонсогдсонд ноцож байгаа бамбар хаявал тэр нь эргэлдсээр хүн барьдаг сагсгар үстэй том том махчин нохой босож, гаслан зайлах нь үзэгдэн. Түүнийг үзээд, Желал-Эд-Дин өгүүлрүүн; Хэрэв, би хаан ширээнээ суувал, эдгээр аюулт нохдыг үлдээгээд, энэ цамхгийг бариулсан хүнийг идүүлэх сэн гээд бууж мориндоо мордов. Хоёрдугаар эмээлтэй морийг Хар бүргэдэд унуулав. Чингээд, тэдгээр морьтой хүмүүс, нэгэн бүлэг болж, хот дотуур явсаар чулуун хаалгыг өнгөрмөгц, хэмжээгүй өргөн тал алсад үргэлжлэн харагдав.

Желал-Эд-Дин, хотын захад чингэж гараад, Хар бүргэдэд өгүүлсэн нь: Чамайг зориуд ордонд урьж, Шаг хааны зандалчны гарт оруулав гэж чи намайг муу санасангүй биз. Би чамайг бас Тиллялы ордны цэцэрлэгт дахин урихыг хүсэх боловч, бас л яргачин Жихан Пехлеваны зарц нохойн саварт дахин орчих болов уу гэж айж байна гэхэд нь Хар бүргэд, тийм муу санаа, миний сэтгэлд ер орсонгүй. Намайг цөл нутагтаа буцахыг зөвшөөрнө үү. Хэдийгээр миний нутаг нүцгэн элс, тачир өвс, давслаг устай боловч эндэхийн үзэсгэлэнт ордон, өндөр цамхаг, бат хэрмээс илүү чөлөөтэй жаргалтай билээ гэсэнд,

Хаан хөвүүн өгүүлрүүн; Би чамайг бас энд саатуулахыг хүсэхгүй. Чи миний өмнөөс зовсон тул би чиний ямар нэгэн хүслийг дуртайяа

гүйцэтгэхийг хүснэ гэхэд нь,

Хар бүргэд өгүүлрүүн: Би гагцхүү, нэгэн зүйлийг гуйя. Загасны тороор намайг бүрхээн барьж, миний биеийг зовоогчид, миний алдарт Хончир гэдэг илдийг надаас авчээ. Тэрхүү илдийг түр зүүж яваа сайрхаг этгээдээс илдээ олж авах хүртэл, өөрийн нөхдийн нэгнээс гялалзсан сэлмийг түр над олгохыг гуйя гэсэнд хан хөвүүн даруй бүснээсээ оюу, чон, нал эрдэнээр чимэглэсэн сэлмээ мултлаад, хар бүргэдэд өгч, үүнийг зүүж алдраа бадруулж яваарай. Энэ сэлмийг номхон аянчинд далайж болохгүй. Гагцхүү манай аймаг угсааны дайсны өмнөөс сугалж байвал зохино. Чиний унаж яваа энэ сайн хар морь бас чинийх болтугай. Үүнийг унаж, чи эх орны эсэргүү дайсныг дарах дайнд морд гэсэнд Хар бүргэд, өгүүлрүүн: Надад чамаас бас нэг гуйх юм байна гэвэл хан хөвүүн сонсъё гэв.

Хар бүргэд өгүүлрүүн: Шаг хааны ордонд манай туркмен аймгийн Гүль-Жамал гэдэг нэртэй нэгэн хүүхэн юу болсныг сайтар мэдээд, надад хэлж өгнө үү? Түүнийг Шагийн дээрэмчин, хүчээр хөгшин Шагийн таалалд нийлүүлэх гэж ордонд авчирсан бололтой гэсэнд хан хөвүүн, би мэднэ. Тэр хүүхэнд Шаг хаан тусгай гэрийг ордны нэгэн цэцэрлэгт бариулж өгсөн билээ. Тэр хүүхэн омогтой, дагаж өгдөггүй гэж манай Шаг, аливаа зоримог этгээдийг зовоодгийн адилаар түүнийг тарчилгах болов уу? гэж зовж байна гэхэд, Хар бүргэд өгүүлрүүн!

Миний амийг аварсан сайн нөхөр чамдаа баярлав гээд Хэлсэн нь:

Хэрэв чамд миний бие хэрэгтэй болбол, намайг дуудаарай. Би уул хавцлыг гатлан ирэх боловч, түргэн ирж чадна гээд хар мориныхоо жолоог цөл нутаг руу залж давхив.

Хар бүргэд бяцхан яваад, жолоогоо бас эргүүлж, хотын хамгийн үзэсгэлэнтэй бөгөөд цэцэрлэгээр дүүрсэн Самарканд, орох замд орж, мориныхоо аажим алхлахад дуулсан нь:

Сайхан янагийн мэндийг
Салхи над уламжилна.
Зөөлөн салхины чимээнд
Зөндөө байх аргагүй.
Өмнө байгаа хаданд
Өнөө үхэл хоргодож

Явах замын өмнөөс
Яг угтаж байна.

гэж дуулаад, санаашран явтал хэдэн морьтой хүн дайрчих шахаад, морьдынхоо гүйдэл дунд хашхиран зам тавь, зам тавь. Их хаанд мэдээ хүргэх буухиа элч явж явна. Их Шаг хааны мутарт өргөх чухал бичиг хүргэж явна элчид зам тавь гээд бугуйлын нэгэн үзүүрийг элчийн эмээлийн бүүргэнээс ороож, нөгөө үзүүрээс хэдэн морьтой хүн татаж, тоос хуйлруулан давхижээ. Буухиаг морьтой нь олсоор хүлсэн тул буухиа нь бэх унтаж, толгойгоо санжгануулж явав. Буухиагийн морь эцсийнхээ чадлаар явж, дөнгөж хотын хаалгыг хүрмэгц, аахилж, сүүлээ шарвалзуулан, хэдийн цочсон боловч нэг тосгоноос нөгөө тосгон хүртэл буухиаг хүргэж өгдөг морьтой хүн бугуйлаар чирч давхисны хүчээр элчийн морь явж байв. Чингэж явтал өнөөх морь нь гэнэт пидхийтэл ойчоод, чирч явсан улс, мориноосоо буугаад эцэж түгшсэн морийг өндийлгөхийг оролдвол тоост зам дээр тэр морины хамраас цус садарч, буухиа хүн, бас унаад, босож чадалгүй хэлсэн нь: Цайзын цамхагт самуун хулгайд хаагдсан гүнжээс Шагт явуулсан чухал бичгийг авчрав. Самарканд хотынхон цөмөөрөө хааны зандалчин, татварчинтай эсэргүүцсэн бослого гаргаж тэднийг огтчин алаад, биеийг улиангар модонд өлгөж байна. Надад хаана ч үхсэн хамаагүй гэж хэлээд тэр буухиа хүн гараа дэрлэмэгц нүдээ анив. Хар бүргэд тэр буухиа элчийн дэргэд хүрч очоод өгүүлрүүн: Арьсан хавтагаа надад өгөгтүн! Падишаг хааны мутарт би чиний төлөө биеэр захидлыг хүргэе. Чи энэ үхсэн морины дэргэд битгий хэвт. Тэнд модны сүүдэрт очиж хэвтээд ханатал унтагтун.

Шаг эзэн бол, муу мэдээ хүргэж ирсэн элчийн толгойг авдаг тул, чи тэр захиа хүргэхийг төдий л яарахгүй, хүн чамайг хар хүчээр чирэхэд хүрч байгааг би мэдэж байна гэвэл тоосонд дарагдсан элч өгүүлрүүн:

— Би ч мөн амарч үлдсэн минь дээр гэж бодож байна гэж хавтагаа Хар бүргэдэд өгөөд, хажуу тийш зайлж, модны сүүдэрт ногоон дээр хэвтээд, хурхиран унтжээ. Хар бүргэд эмээлийн бүүргэнээс бугуйлыг өлгөж, урагш давхи гэж олон морьтон цугаар давхилдаж, Шагийн нийслэл орох замаар дахин замнан довтолж явсаар Хар бүргэд олон дагагсдын хамтаар ордны өндөр хаалганы өмнө хүрч ирвэл, Падишагийн гүнжээс чухал мэдээ хүргэж ирсэн элч

гэж хаалга бүхнийг саадгүй нээжээ. Өвгөн тайган... түлхүүрээ хангинуулсаар, муруй хонгилуудаар элчийг дагуулан явсаар, Хар бүргэдийн бие, улсын эзний Догшин сүртэй нүдний өмнө зогсох ёстой байв. Гэтэл гэнэт туурганы цаанаас нэгэн эмэгтэй хүн, амь авар миний үхдэг цаг ирэв гэж хашхирах дуу тов тод сонсогдсонд, айн эмээж, нигүүлсэн тэнхрүүлэхийг гуйгч тэр ядуу дууг Хар бүргэд яахан танихгүй ажээ. Манай сайн эр Желал-Эд-Диний бэлэглэн өгсөн хурц сэлмийг яаран суга татаад, өвгөн түлхүүрч тайганы тэргүүний дээр далайлган, хаалга нээ гэж тушааж, дан хивс болсон тасалгаа дотор барс мэт үсрэн ороод туркмен охиныг дарлагч Шаг хааныг цавчин алсугай гэж ийш тийш үзвэл, тасалгаа дотор хүнгүй. Гагцхүү нэгэн буланд олон перс алчуурын дээр хар эрээн барс хэвтэж, хумсаар хивсийг маажлан ноцоход, түүний дороос бөглүү дуу хашхиран сонстов.

Манай сайн эр үүнийг үзмэгц сэлмээр хоёр цавчтал барсыг алж, хивсийг сөхвөл, Гүль-Жамал охин царай зэвхийрэн хэлмэгдэж үхэтхийн хэвтэж байв. Хар бүргэд үүнийг үзмэгц, ямар муухай амьтан, энэ араатныг буурай охин дээр оруулав гэж хашхирч, сэтгэл зүрхийг нь төчнөөн удтал татаж байсан тэр охины дээр бөхийтөл, Шаг хаан, хол хол алхалсаар орж ирээд, хайртай барсыг нь алсан тэр сайн эрийг галзуу ууртаа болж, дор нь цаазаар аваачсугай гэтэл, Хар бүргэд захидлыг гаргаж, ихэмсэг дүрмээр өргөв. Үүнд Шаг хаан, Самарканд хотод бослого гарч, охиныг нь дайран довтолсон мэдээнд цочин хэлмэгдэж, цэргийн жанжныг даруй мордож, бослого гаргагчдыг дарж, цаазаар аваачин цээрлүүлэх аянд бэлд гэж тушааж, өнөө сайн эрийг огт хайхрахгүй болов. Үүнд Хар бүргэд, Гүль-Жамал охиныг өөрөө өргөж, цэцгийн хүрээлэн дэх цагаан гэрт аваачаад, шивэгчин эмст хэлсэн нь: Маргааш цөл говиос өвгөд өтгөс хүндэт хөсөгтэй ирж, Гүль-Жамалыг нутагт нь аваачна гэжээ. Гэтэл, маргааш нь тэр өвгөдийг Гүль-Жамал охинд ойртуулсангүй, ордноос хөөж хэлсэн нь; Гүль-Жамал бол, их Падишаг хааныг хорлоор завдсан учир, «үүрд умартахын чулуун цамхаг»-т «үүрд бөгөөд үхтэл» хоригдоно гэжээ гэсэнд, нэгэн хүн Хажи-Рахимаас асуурууи:

— Тэр охин, тэнд үхсэн үү? гэсэнд Хажи-Рахим алгууpаар өгүүлрүүн:

— Үгүй. Гүль-Жамал, Гурганж хотын чулуун цамхаг дотор хориостой одоо хүртэл амьд бий. Түүнийг Шаг хааны хар сэтгэлт эх

Турхан хатан хориулсан нь тэр хөгшин эм, одоо Хоресмийн нийслэлээс аймтгай ийнэ (чонын төрлийн араатан) мэт зугтаасан боловч, тархигүй ухвар мөчид заргач түшмэл, ёсыг сахигч Раис, хуяг манааны хүн, тэр заналт хатан Шагийн тушаалыг зөрчин өөрчлөх зүрхгүй Гүль-Жамал охиныг бусад олон хилс хоригдогсдын хамт гянданд хорьж бий гэсэнд «Морьт хар» гэгч, хивс дээрээс өндийн босож асууруун: Бадарчин Дервиш чи энэ бүхнийг хаанаас олж мэдэв. Надад хэлж өгнө үү. Чиний саяын хэлсэн бол үлгэр зохиол биш, үнэн хэрэг биз ээ гэсэнд Дервиш лам өгүүлрүүн:

— Орчлон дэлхий дээгүүр хэрэн явагч бид, олны дотор хэсүүчлэн явж элдэв үг сонсоно. Бас, цөл говийн салхич энэ үлгэрийг надад олон удаа хэлж байсан гэв. «Морьт хар» бусдын зүг хандаж өгүүлрүүн: Сайн эрс беги нараа бэлтгэгтүн. Би үүрээр Гурганжийн цамхгийн зүг мордоно гэвэл Хажи-Рахим өгүүлрүүн: Чи Гурганжид хүрэхийг хүсвэл түргэл. Татаарын хааны хөвүүд үлэмж их цэрэг дагуулан, Гурганж хотыг гурван талаас байлдаар ирж бий. Тэд хотыг бүсэлбэл, чи хэрхэн нэвтрэх билээ гэсэнд, «Морьт хар» өгүүлрүүн:

— Дервиш чи надтай хамт яв. Чиний нөхөр та хоёрт би хоёр морь өгсүгэй. Бид гурав хоноод, Гурганжид хүрч чадна. Миний нөхөд, та нар нутагтаа буцацгааж, миний дуудахыг хүлээгтүн.

Миний эгж ирэх, асрайл тэнгэр намайг галт голын хөндийд аваачих алин болохыг Аллах тэнгэрээс өөр хэн мэдэх вэ? гэжээ.

ГУРГАНЖ ХОТЫН ТӨЛӨӨ ЧИНГИСИЙН ГУРВАН ХӨВҮҮН ТЭМЦЭН МУУДАЛЦСАН НЬ

Чингис хааны отгон хүү Толуй хаанд эртний Мере хотыг байлдан авч талагтун гэж Зөч, Цагаадай, Өгөөдэй гурван ахад нь Хоресмийн нийслэл Гурганжийг их цэрэг дагуулан очиж байлдан эзэл гэжээ. Үүнд, монгол хүн бүхэн, нарийн нэхмэл, торго, алдартай сайн хөө хуягийн зэрэг үнэ ихтэй эд барааг зүг бүр тэмээн хөсгөөр явуулагч Мусульман газрын маш баялаг тэр хотыг байлдах аянд явах дуртай билээ. Тэр дайнд явагсад, багаар хэлэлцвэл, торгон хувцас, маргад эрдэнэ, биндэрьяа чимэг, эрдэнэсийн хундага зэрэг сонин ховор зүйлийг ачсан хоёр морь буюу тэмээний ачаа хүртэхээс гадна, хүн бүр нутагтаа хэд хэдэн уран боолчуудыг хөөн авчирч, торго нэхүүлэн, гутал хувцас оёулах болно. Тэр үес эзэн нь дайнаас олзолж ирсэн хивс

дээрээ жарган хэвтэж, мөн гурганжаас олзолсон хуурчийн чин хуур хуурдахыг сонсон хэвтэх болно гэж хүсэн хүсэцгээж, Монголын цэргүүд Хоресм улсын умардад орших өн баялаг тал газар Жейхун мөрний эргийн зүг замнан явахдаа бодоцгоох бүлгээ. Чингис хааны хөвүүн Цагаадай, Өгөөдэй нар, энэхүү хотыг ах Зөчөөс өрсөж эзлэхийг шамдан зорьжээ. Учир нь, их хааны гэрээсээр хивчаг нутгийн хамт бүх Хоресмийг Зөчид өгсөн билээ.

Зөч хаан, түүний харьяат газрын ирээдүйн нийслэлийн баялгийг хуваан авахад дүү нараа оролцсонд уурлаж, Гурганж хотыг байлдан дагуулах аянд мордохыг түр хойшилж, тэхийг авааж өгүүлрүүн; Тэд, надгүй хэзээ ч Гурганжийг эзэлж үл чадна. Тэд, урьдаар духаа хага мөргөвөл мөргөж байг гэжээ. Ховдог хомхой сэтгэлт Цагаадай, архи уугаад согтуурахдаа:

— Зөчийн улс дааанч их болов. Ганцаараа хамгийн сайныг эзлэнхэн суух дуртай байна. Би түүнд Гурганжийг өгөхгүй, урьдаар үнсэн товрог болгоно гэж ам алдах бүлгээ.

Гурганж бол, Хоресм Шагийн нийслэл бөгөөд их зантай хивчаг хаад, баян худалдаач, уран дархнууд, олон овогтон боолчуудын хуралдсан газар билээ. Маверанагрт Монголчуудын нэвтрэн ирснээс хойш энэ Гурганж хотод цаг түгшүүртэй болжээ.

Хотыг бас атгаж байсан Турхан хатан зугтаж, Хоресм Шагийн төрлийн олон вангууд явцгааснаас хойш олны хөл үймээнтэй их нийслэл хот хивчаг ноёдын эрхэнд оров. Нэг сар ч болов, нэг хоног ч болов, мусульман газрын эзэн болох санж гэж хаад, беги ноёдын эвдрэлдэн тэмцэлдтэл, Хивчагийн Хумар Тигин беги ноён, цагаан эсгий дээр хаан өргөмжлүүлэхийг хүлээлгүй, биеийг Хоресмийн султан хаан гэж өргөмжилсөнд бүгдээр үг дуугүй дагаж, цагаан сахалтай имам лам нар сүмд түүний бат оршлын залбирлыг хичээнгүйгээр унших болжээ.

Хоресмийн шинэ эзэн Хумар Тигин, хамгаас урьдаар өөрийн бүх засгийн эрхийг лал исламын шашныг хамгаалах зүг тийш хандуулж, хэн хүн өдөр тутам сүмд мөргөл хийхийг тасалдуулбал цамхагт хоригтун гэж тушаасанд ёсыг сахигч райсууд зэвсэг бүхий хамгаалагч нарыг дагуулж, Хотын дотуур хэсүүчлэн явцгааж сүсэг муутай хүнийг цээрлүүлэн шийтгэж, банз туйвангаар ёсыг дагуулав. Шинэ султан хаан, хотыг хамгаалагч ерөнхий даргад нэг нутгийн Желал-Эд-Дин, Эл Хаадыг томилж, шөнийн харуул манааг олшруулаад, түүний зардлыг

шинэ алба ноогдуулан гаргуулжээ. Гэтэл, хотын дотор хулгай дээрэм намдсангүй, амуу будааны хөмрөгийг дээрэмдэх нь хэвээр байжээ. Айх эмээх, цочих түгших нь улам нэмэгдэж, аймшигтай Монголын морьт цэрэг хүрч ирвэл их хотын олон ардын амь бие юү болох бол гэж нийтээр айн эмээж байв.

Үүнд, Хумар Тигин, Монголчуудыг Гурганжид хэрхэвч халдахгүй, Бухар, Самарканд, Мерейг дээрэмдэж олз омгоор ханасан тул тал говь нутагтаа буцахаар бэлтгэж байна. Имам лам, зарлах зарц нараар ухуулан, хотын олны сэтгэлийг тайтгаруулж байв. Гурганж хот хуучин тайван хэвээр байгаа мэт үзэгдэн, өглөө Азанчи нар сүмийн өндөр гонх дээрээс, сүсэгтэн лал нарыг мөргөл үйлдэхийг дуудах нь урьдын адил бөгөөд зээлийн газар олон худалдаачин эд бараагаа дэлгэж, дэргэд нь суугаад, хүнийг дуудах нь хуучин хэвээр үзэгдэнэ. Нарийхан гудамжаар олон хүн тасралтгүй цувалдах нь мөн урьд хэвээр боловч, хотын наймаа, уран дархан, өдрөөс өдөрт хомсдон муудаж байсан билээ.

Худалдаачин, наймаа муу болов, зарим худалдаачид огт гүйлгээгүй сууна гэж гомдол гаргах болов. Эдийн үнэ, нэгэн дундуур хорогдовч худалдан авах хүн үнийг дэмий л асууж, толгой сэгсрэн, шагшина. Худалдан авах хүнгүй болжээ. Харин, идэш уушны зүйл улам их үнэ нэмэгдсэнд хотын хүн, хүнс тэжээл гаднаас ирэхгүй болж тасалдуужин гэж гурил, шар будаа, үзмийг яаран худалдан авцгааж, зам зээлийн уулзар дээр цугларагсад шивнэлдэн хэлэлцэх нь: Татар айсуй. Татаарын их цэрэг ойртож байна. Татар, манай хотыг бүслэн байлдана. Хотын хэрэм өндөр бөх, удтал эсэргүүцэж чадна. Тэр завсар бид бүх хонь морьдоо идэж дуусна. Чингээд хэрхсүгэй. Хаашаа зайлан дутаая! гэцгээх болов. Янз бүрийн цуу үг, хотын олны сэтгэлийг үймүүлэн заримдаа баярлуулан, заримдаа зовцгоож байв. Цуурхалд Желал-Эд-Динийг таван буман цэрэг хуралдуулав. Одоо тэр цэрэг Гурганж хотын зүг хөдлөв. Татаарын их цэрэг дарагдаад, зүүн тийш буруулав гэцгээнэ.

Бас зарим нь өгүүлэлдрүүн:

— Татаарууд, хэрмийг тойрон эргэлдэж байгаад хотыг авч чадалгүй буцна. Гурганжийг яагаад авах билээ. Татар, умар зүг тийш одно. Өвгөд, их настан үүнийг хэдийн мэджээ гэж хэлэлцдэг байлаа.

Хотоос гадагш тэмээн жин гардаг болов. Ачааны оронд тэмээний хоёр хажууд эмс, хүүхдийг арагт тэгнэж Мангишлаг дахь туркменд явуулах болов. Үүний хажуугаар хотод морьтой тэрэгтэй, илжигтэй хүн

ирцгээх болов. Энэ нь Гурганжийн өндөр бэх хэрмийн батад шүтэж, орон гэрээ орхиж зугтсан сурвалжтан беги нарын гэр бүлийн хүн билээ. Зах зээлийн газар бин худалдагч нар алга болж, талхны газар хаагдаж байв. Хонь, морины үнэ нэмэгдэж, энгийн илжиг, сайн морины үнэтэй болжээ.

Монголчууд, хотын өмнө гэнэт гэгээн цагаан өдөр дунд үзэгдэв. Эхлээд хэн хүн юү ч болсныг мэдсэнгүй байлаа. Өмнөд хаалганы орчимд нүүдэлчин хөдөөгөөс сүрэг мал тууж ирээд, хонь үхрийн сүрэг суваг гарах гүүрний дэргэд зогсож, харуулын хүн, хот орох зөвшөөрлийн бичиг олгож, мөнгө хураан авч байтал гэнэт Монголын хоёр зуу орчим морьт цэрэг тоосны цаанаас гарч ирсэн нь туркмен ч биш, хивчаг ч биш, ер бусын хувцастай хүн гарч ирээд, унасан морь нь бие бага боловч, гавшгай, хурдан. Чингээд хониноос нь эмээл дээрээ дүүрч, малчинтай хэрүүл тэмцээн гаргаж малыг хөөн тууцгаахын завсар, эсэргүүцэн хэрэлдсэн хэдэн малчныг цавчин алаад, ташууpаа тас няс дуугаргаж исгэрэлдсээр малыг хотоос холдуулан яаралгүй хөөж, их сувгийн гүүрийг гараад, аажмаар цаашлав.

Хотын дотор үймэлдэн сандарч Султан хаан Хумар Тигин, нэг мянган хивчаг мордуулж, аймшиггүй тэр дээрэмчнийг амьдаар барьж ирээд, цаазал гэж мордуулжээ.

ХАР ХОНЧИР ҮЛГЭРИЙН ТӨГСГӨЛИЙГ ЭРЭВ

Хайварс хайварс алхахыг чинь дахин үзье гэж мөрөөдөж,
Хавтай үгийг чинь сонсохын төлөө зүрхээ өгье би.
(Персийн дууллаас)

Хар Хончир, Монголчуудаас дутааж, Жейхун мөрний зүг элс манхныг дамжин чиглэв. Алс холд Монгол цэргийн баг, заримдаа зэл татсан мэт цувалдан үзэгдэж, цөм Гурганж хотын зүг умар тийш замнан явах тул, тэднээс буруулан элс манхны зүг буцаж, холуур тойрон явахад тал бүрээс хавчин орж ирэх Монголчуудаас Кызыл Кумийн элсэн дундуур сандран дутааж явсан нүүдэлчин аймгийн хүн тохиолдвол зам сураглан явахад хүрэв.

Наранд гандаж харласан хоёр туркмен хүн том гэгчийн нэхий малгай өмсөж, Хар Хончирын хамтаар явав. Нэг нь гөлтгөр царайтай хүүхэд, нөгөө нь сахалтай Дервиш байжээ.

Шөнө алман сарны бүдэг гэрэлд замнан явсаар, бялхан хальсан мөрний эрэгт мэдэгдэлгүй хүрч, бодон гахайн жимээр хулсан дундуур явсаар, усны дэргэд хүрч ирвэл хэдэн том эв хавгүй, цээж тал нь дээш өргөгдсөн завь дэргэдүүр нь өнгөрөн гарав. Онгоцонд хүн, морь, хонь үзэгдэж, Хар Хончир нар онгоцондоо суулгана уу гэж хашхиран гуйвал Аллах тэнгэр танд тус болтугай. Манай онгоцонд та нарыг суулгах зай байхгүй гэв. Харин нэгэн онгоцны хүн,

— Үнэн шашинт лал нар үнэн шашинтнаа гай зовлонд орхидоггүй гэж онгоцны хитгийг барьсан хүн, эргийн зүг онгоцыг залж, Гурганж хүртэл авч явахыг зөвшөөрөв.

— Үүнд хөлс юү авах вэ? гэж Хар Хончир асуусанд онгоцны хүн хэлсэн нь: Үүнийг яриад юу хийх вэ.

Одоо мөнгө, эд мал цөм үнэ цайгаа алдаж юм болгон учир нь олдохгүй хутгалджээ. Одоо чи аюулд учраад би ч мөн нэгэн адил аюул зовлонд учрав. Миний гэрийн хүнийг хүйс тэмтэрч, хамаг юмыг цөлбөн талжээ. Би мөнгөөр юү хийх вэ. Хэнд гэж хураах вэ? Суугтун гэж, том гэгчийн бөх завь онгоц эргийн хөвөөнд хүрч ирээд, манай аянчныг унаа хөсгийн хамтаар авч, өргөн Жейхун мөрний булингартай давлагаан дээгүүр дайвалзаж, хурдан одов.

Мөрний баруун эрэгт хааяа монгол хүний явах нь үзэгдэхэд, онгоцыг зүүн эрэг тийш нь залж, аргацаан явсаар дөрөв хоноод, Гурганж хотыг өндөр хэрэмт хуучин хот ба ялмын модны цэцэрлэгийн хүрээлэнд нуугдсан байшингуудтай түүрэг[35] болгон хоёр анги хуваасан өргөн сувагт оржээ. Чингээд, Хар Хончир, бүснээсээ хуниастай бяцхан арьсан хавтага тайлан авч, арван алтан динарыг тоолж аваад, онгоцны эзний өргөн том алга дээр тавин өгүүлрүүн:

— Чи бид хоёр дахиж уулздаг бол уу, үгүй бол уу. Ядахдаа нэрээ хэлж өгнө үү гэвэл, онгоцны хитэг баригч хүн инээмсэглэж, улаан турбан малгайг шилэн дээрээ болгож өгүүлрүүн:

— Би төмрийн дархан Керим Гулим гэдэг. Чи нэрээ хэдий хэлсэнгүй боловч, би чамайг танина. Хөнгөн хөлтэй, хун шувуун хүзүүтэй хар морь чинь үлгэр дуунд орсон хүний морь байлгүй дээ. Хэрэв, чи буруу номтонтой дайн хийх бол би чиний цэрэгт элсэнэ гэвэл,

Хар Хончир түүний хэлснийг сонсолгүй бөөн их тоос дэгдэн ойртож байгааг холхиос ширтэн харж үзвэл, их тоосон дотроос, морины толгой сүүмэлзэн дэл хүзүүн дээр нь бөхийсөн хивчагууд

үзэгдэж, морио хашхиралдан ташуурдаж, холхиос олны цуугиан, сөөнгө хоолойгоор бархирцгаах чимээ сонстов.

Нэг том цагаан морь унасан хүн, олныг түрүүлж эмээл дээрээ ширвэлзэн, арайхан гэж тогтож давхих нь цагаан турбан малгай, шар дээл нь цус бялдан цоохорлож, улаан нэлээ болсон морины шилэн хүзүүнд нь урт гэгчийн сум шигджээ.

Хивчагууд, гүүр дээгүүр хуй салхи мэт давхилдан гарч ирээд,

— Бидний ард тэд ойртон ирж байна. Амь бүтэн зайлж гарахыг бодоцгоо гэж сандран хашхирцгаав. Хар Хончирын хар азарга олон морины давхилдахыг үзээд, тогтож ядан тэмүүлэхэд хотын хаалганы өмнө азаргынхаа амыг татвал, хивчагууд хаалгаар давхилдан, Хар Хончир нөхдийн хамтаар дагаж оров.

Манаач, хаалгыг хахинаж дуугартал түлхэн хааж хүнд дүнзэн модоор тулсанд, нэг морьтой хүн манаачийн дэргэд зогсож өгүүлрүүн:

— Шинэ султан хаан, Хумар Тигин хоёр зуун монголчуудыг барь гэж биднийг явуулсан билээ.

Тэд, манай малыг хөөж аваачсан. Чингээд биднийг үзмэгц, айсан үхэр хулгана шиг, дээрэмдэн авсан сүрэг малаа гээж дутаан давхисан нь биднийг аргадаа оруулан унагаж баллахыг хэн мэдлээ. Тиллялын цэцэрлэгийн орчим бүгсэн галзуу буруу номтны хоёр мянгаад хүн гэнэт биднийг тал бүрээс бүслэн авч, холоос урт сумаар харваж унаган, морьдыг барилан эхлэв. Манай зоригт эрчүүд, цөм тэнд үхэв.

Манай нэгэн баг цэргээс өдийхөн хүн үлдэв.

Султан хаан, биднийг юунд ийм хэцүү алуурын газар явуулав гэвэл, Хар Хончир өгүүлрүүн:

— Та нар юунд гахайн торой шиг ийм султан хааныг сонгож авав гэвэл, Султаныг хэн аймшиггүй муу хэлэв гэж олон, гайхан үзвэл, Хар Хончир, Аллах тэнгэр аймхай сэтгэл хоёр, Хоресмоос муу өлөгчин гичий Турхан хатныг түүний сүрэглэсэн олон бялдуучтай хамт үлдэн хөөжээ. Бүдүүн бөгст Шаг Мухамед зугтааж, түүний хүүрийг одоо ноход урж байна. Цөөврийн сүргийг их салхи шүүрдэн арилгасанд та нар шинэ мануухай Хумар Тигинийг сонгож авав уу. Сайн эзэн хүн, түүнд хэдэн ухнаа итгэж өгөхгүй байтал, та нар харин хотоо хамгаалахыг даалгажээ.

Та нар боол угсаатан, банз туйвангүй сууж үл чадах улс биз гэтэл, Хар Хончирын хамт явсан хоёр сайн эр, түүнийг биеэр халхалж өгүүлрүүн:

— Чимээгүй бай, Хар Хончир. Энд дан хивчагууд байна шүү. Эд Шаг хаантай нэгэн омог хүн билээ. Бид явцгаая гэв. Үүнд, хаалганы дэргэд байсан цэрэг манаач цөм «Морьт харын» үгэнд цочирдон бахардаж, дуугай зогсоцгоов. Нэгэн хүн өгүүлрүүн:

— Юутай зоригтой сайн эр билээ. Түүний хэлсэн бүхэн түмэн үнэн:

Хумар Тигин, урьд байлдаанд хэзээ гарамгай баатраа гайхуулж явсан бил ээ? Хэзээ өгөөмөр сайхан сэтгэлтэй цэцэн ухаантай гэж хэлүүлж явсан бил ээ? Турхан хатны хойноос дагаж явснаа гавьяа чадал болгосон хүн биш үү.

Ийм Султантай байвал, бид цөм балчина гэжээ. Хар Хончир, Гурганж хотын гол гудамжаар яаралгүй алхлуулан явж, догшин хар нүдээр дайралдсан олныг ширтэн ширтэн явж, нөхдөдөө өгүүлрүүн:

— Та нар, зах дээр очицгоож, Мирданы цайн пүүсийг эрж ологтун. Түүнийг цөм мэднэ. Чингээд, тэнд намайг хүлээж байгтун. Би одоо ганцаараа явна гэв.

Захын олон пүүсийн бараг хагас нь хаалттай байв.

Урьд торго, нарийн ноосон нэхмэл овоолоостой худалдаж байсан газар, авах хүнийг даллан дуудах худалдаачин үзэгдэхгүй болов. Пүүсийн хүн, бухимдан гуньхарч, дугуйлан сууцгааж, одоо юу болох бол гэж ярилцах нь,

— Дайсан, хотыг бүслэн байлдвал, бид нэг тохой торго бөсийг ч авах эзэн олохгүй. Буруу номтон, манай хотыг араатан мэт довтлон орж, юм бүхнийг үнэ өртөггүй авах гэж байтал, ямар хүн аймшиггүй наймаа хийж, юм худалдан авна. Тэр ч байтугай манай толгой мөрөн дээрээ тогтох болов уу? гэлцэн суув.

«Үүрд умартахын цамхаг» бол Хоресм Шагийн ордны орчим бий билээ. Түүний нэгэн өнцөг нь өргөн чөлөө тийш гарчээ. Хар Хончир цамхагт ойртон очиж, цонхыг орлосон бяцхан дугуй нүхийг үзэж сэтгэрүүн: Цөл говийн цэцэг болсон тэр охин хаана, аль цонхны цаана байгаа бол? Амьд бол уу? Үгүй бол уу? Амьд бол охины сайхан царай, гэрэлт тунгалаг нүд, зөөлөн сайхан гар нь хэвээрээ бол уу? Энэ аймшигт цамхаг дотор хүн галзуурч, эмэгтэйчүүд хөгшин болж өтөлдөг. Гүль-Жамал охин туурганаас гинжлэгдэж, одоо хүн таньшгүй болсон бол уу? гэж бодмогц, айн цочиж, энэ насны гэрэл болсон түүнийг тийм үзэшгүй муухай, галзуу солиотой болсныг үзсэнээс шууд байлдаж яваад үхсэн дээр гэж бодов.

Цамхгийн ёроолд намхан төмөр хаалганы шатан дээр тахир хуучин сэлмийг өвдөг дээрээ тавьсан сахалтай өвгөн манаач унтаж байна.

Түүний дэргэд хивс дээр хатсан хэдэн бин хэвтэж, модон аяга дотор хоёр хар зэс дирхем зоос байлаа.

Одоо хоригдогсдын хамаатан садан, санаа зовохыг болив. Гагцхүү хар амиа бодно. Туурганы цаанаас хатангир гар үзэгдэж, хашхирах чимээ сонстох нь:

— Зовлонтон биднийг хайрла. Харанхуй нүхэнд суугч бидэнд үмх боорцог хаяж өгнө үү гэв.

Хар Хончир манаачийн дэргэд очиж, хүүе өвгөөн, цааш ир гэвэл, өнгөн унтсанаа сэрж, буурал сахлаа шувтран, морьтой хүн тийш босож очих байдалгүй,

— Чамд юу хэрэгтэй вэ? гэв. Үүнд: Хар Хончир, өвгөний дэргэд ойртвол, өвгөн босов. Хар Хончир асууруун:

— Май. Энэ мөнгө ав. Гяндан дотор энэ өдөр хоригдогсод олон уу? Надад хэлж өг гэвэл,

— Олон цөөн нь чамд хүртээлгүй гэж хариулав.

— Хуучин ялтан бас олон бий биз ээ гэвэл,

— Өлсгөлөн, бөөс, хир буртгаар үхээгүй нь хялгасанд торж амьд байна гэсэнд,

— Май бас нэг динар зоос, хоригдогсдын дотор эмэгтэй хүн байгаа, үгүйг надад хэлж өгнө үү гэвэл,

— Хоёр хөгшин бий. Шинэ султан хаанд илбээр өвчин тусгах гэсэн учраас хоригдов гэв.

Хар Хончирыг асууруун

— Залуу эмэгтэй бий юү гэхэд,

— Чи надаас асуугаад яана? Чи хэн бэ? Байцаагч уу, зандалчны дарга уу, сүмийн их имам лам уу? Би чамтай ярихгүй, хэн мэдэх вэ. Чи дээрэмчин ч байх магадгүй, бусад хулгай дээрэмчнээ суллахыг хүсэж байна уу? Өгсөн мөнгөө эгүүлж ав. Эндээс зайл гэжээ. Үүнд Хар Хончир ташууараа далайж, манаач өвгөнийг цохин завдтал хажуугаас нэг хүн гарыг барин, тосож зогсооход эргэн харвал, уранхай хувцастай, мөрөндөө хүрсэн урт үстэй өндөр өвгөн, Хар Хончирын уурсан ширтэхийг гялалзсан нүдээр үзэж өгүүлрүүн:

— Чи эндэхийн ёсыг мэдэхгүй болоод, энэ манаач өвгөнтэй ингэж байна. Эндээс холдож явъя. Би учрыг тодорхой хэлж өгнө.

Чиний цуугилдахад султан хааны арваад зандалчин гарч ирээд, чам тийш дайран орохоор бэлэн байгааг үзэв үү. Эндээс бушуу зайлж явъя. Миний үгийг дагаж, миний хойноос яв гэвэл,

Хар Хончир, морио залж, сонин өвгөний хойноос дагав. Өвгөн нарийхан гудамжаар явахдаа алхлах нь улам түргэсэн, хүнгүй гудамжинд хүрч зогсоод, намайг чамтай ярьсанд, чи битгий гайхаарай. Би гянданд хоригдож, зоорь нүхэнд байгаа эзэндээ хоол өгч, бүтэн жил шахам явж байна. Миний эзний нэр Мирза-Юсуф гэдэг. Шаг Мухамедын ганц түүхч байсан билээ. Шаг хаан түүнийг өршөөн үзэж, хайр хишиг хүртээсэн билээ. Гэтэл, хөгшин ина[36] Турхан хатан Хоресмд «Хилэнгийн их илд, хүчирхгийн жад» болоод, Мирза-Юсуфийн нас их, тэнхэл буурай болсныг өрөвдөлгүй нүхэн гэрийн зооринд хийсэн билээ гэвэл Хар Хончир асууруун

— Юунаас тиймд хүрэв, гэвэл өвгөн Мирза өөрийн зохиосон номын дотор хатныг «хүчирхэг Хоресмийн дээл нөмрөг дээрх хар толбо» гэж түүний хамаг муу гэмийг уудалсан дээрээс чингэв. Хутагтан имамууд хатанд түүнийг ховлож хориулав. Чингээд одоо би хотын дотор гуйлга гуйж, гянданд хоригдон зовж байгаа өвгөн эзнийг тэжээнэ. Миний хүсэх нь: Харийн нүүдэлчин, энэ хотыг эзлэн орж, хотын олныг эзэлж эхлэхэд гяндангийн зандалчид зүг бүр тийш хулгана шиг дутаан зайлна. Тэр цагт би гянданд гүйн орж, энэ муу манаачийг багалзуурдаж алаад, олон хоригдлыг суллаж, өвгөн эзэн Мирза-Юсуфээ гаргана. Чингээд, би нутагтаа буцна гэвэл, Хар Хончир асууруун;

— Нутаг чинь хол уу гэвэл.

— Хол! Би орос газрын хүн, нэр Саклаб. Манай орос хүн, намайг өвгөн Славко гэдэг гэвэл, Хар Хончир бодлого болов. Өвгөн асуусан нь:

— Сайн эр беги, чи хэнийг эрж байгаа билээ. Би чамд тусалж магад гэвэл, Хар Хончир асууруун:

— Гяндан дотор эмэгтэйчүүд олон уу? Тэр өвгөн манаач хоёрхон хөгшний төдий бий гэсэн билээ гэвэл, өвгөн өгүүлрүүн: Тэр оргүй худал. Цамхгийн дээвэр дор олон бяцхан нүх байсныг чи ажигласан уу? Тэнд олон бяцхан өрөө бий. Түүн дотор Шагийн дотоод ордноос хааныг эс дагав гэж хорьсон нэлээд эмэгтэйчүүд хадгалагдаж бий гэвэл, Хар Хончир асууруун;

— Тэдний дотор туркмен эмэгтэй бий юү гэвэл, өвгөн, бодож байгаад өгүүлрүүн:

— Би мэдэж өгье. Энэ манаач, мөнгөнд их дуртай хүн, өмссөн хэдий муу боловч, их баян хүн билээ. Олон хоригдолд өгсөн эд мөнгөний их дундуурыг хураан авч, баганхи хувийг өгдөг тийм ховдог хүн. Гэртээ байшин, цэцэрлэгтэй, найман эхнэртэй, элбэг аж төрнө. Би чамд туслахыг бодъё. Энэ модон дор байгаа хуучин бага хаалгыг үзэв үү? Урьд, миний эзэн түүхч Мирза-Юсуф, энд сууж байсан билээ. Би түүний гэр орон, ном судрыг нь хадгалан сахиж байна. Түүний хүмүүжүүлэн тэжээсэн Бент Занкижа гэгч нэгэн охин, өвгөний ном хуулж тусалдаг билээ. Одоо Бухар хот ороод, сураггүй болов. Чингээд би энд ганцаараа үлдэв гэсэнд Хар Хончир өгүүлрүүн;

— Өвгөн Саклаб, би чамд итгэж байна. Чи намайг үхэг гэж санахгүй байлгүй дээ. Маргааш өглөө би энд хүрч ирье гэв.

ГУРГАНЖИЙГ ЭЗЭЛЖ АВЪЯ ГЭВЭЛ, УРЬДААР ТҮҮНИЙГ ЭВДЛЭХ ХЭРЭГТЭЙ

Өгүүлэх нь: Монгол цэрэг, Хоресмд ирээд нийслэлийг зогсоогоор бүслэн байлдсугай. Монголчууд, урьдаар Гурганж хавийн айл гацаанд буудаллаж, хуаран хүрээндээ олзолж авсан гацааны хүнийг хөөн цуглуулав. Чингисийн хөвүүн Өгөөдэй, Цагаадай хоёр, хотын гаднах Тиллялын ордонд бууж, цэргийн жанжин Кадан буурч, төлөн чарви, Тэжибеги нар, хотыг байлдах чөдөр оньс, дугуйтай «яст мэлхий» гэдэг оньс яаран хийлгэж, их л завгүй байв. Холоос авчирсан Хятад инженер, хотыг гавшгайлан байлдаж эхлэхэд дөхөмтэй болгох, дайран байлдахын оньс машин бүтээж өгнө гэцгээжээ. Гагцхүү, ойр хавьд харвах чулуугүй нь баахан саад болсон. Үүнд, хятадууд, иламын мод огтолж, усанд удтал дэвтээн, хүнд хатуу болговол, харвах оньсны сум болгож болно гэжээ.

Монголын зарим баг цэрэг, хотын зүг бүрээс үзэгдэж, хаалганаас гарсан морьтой цэргийн багтай авцалдан байлдаж түргэнээ буруулан, тэднийг бүгсэн газар аваачихыг оролдоно. Үүнд, Гурганжийн цэрэг энэ аргыг сайн мэдэх болсон тул, сэрэмжилж хэрмийн дотор буцаж орцгоох бүлгээ. Хотын цэргийг султан хаан Хумар Тигин тэргүүлэн захирч, ойрын туслах нарыг (Бухарыг хамгаалагч) Агул Хажив эр-бух бигливан, Али-Дурог нар бүлгээ.

Цэргийн чуулган нийлэхэд султан хаан Хумар Тигин, монголчуудаас харван ирүүлсэн захидлыг үзүүлэв. Түүн дотор нийт ардыг хотын хаалга нээж, монголчуудад итгэмжлэн дагавал, ямар ч хор хүргэхгүй гэж бичжээ. Султан өгүүлрүүн: Тэдэнтэй тохирон хэлэлцвэл, үл болох газаргүй. Их алба бэлэг барьж, эв найрамдлаар хэргийг дуусгавал, хотын олныг алан хядах, галдан шатаахын аюул учруулснаас дээр биш үү? гэвэл, Агул Хажив нар татгалзаж өгүүлрүүн:

— Падишаг, чи Бухар, Самарканд, Мерв хотыг монголчууд хэрхсэнийг умартав уу? Тэр хотын ардууд, мөн л энэрэн уучлахыг гуйж, зэвсгээ хураалгаад, монголчууд, сайн сайн урчуудыг ялган авч, монгол нутагтаа явуулаад, бусдыг бялуугаар цохин алсан биш үү? гэвэл, Султан өгүүлрүүн:

— Юу ч болсон, монголчуудын хүссэнийг мэдэж авъя гээд, шөнө орой султан хаан Хумар Тигин, цөөн тооны бараа бологчдын хамтаар Гурганжаас гарч, Цагаадай, Өгөөдэй нарын найрлаж байсан ордонд очиж, гуйн өчих хүний ёсоор алгаа хавсарч бараалхвал, Өгөөдэй инээн асууруун:

— Чи бидэнд юу авчрав? Хотын хаалганы алтан түлхүүр хаана вэ? гэж асуувал, Хумар Тигин султан өгүүлрүүн: Дорно зүгийн эзэн Чингис хааны сүр хүчний өмнө сөгдөж бусад бегийн нэгэн адил зүтгэн үйлчлэхийг хүснэ гэвэл, Цагаадай хүйтнээр өгүүлрүүн: Бидэнд Гурганж хот хэрэгтэй. Чам шиг урвамтгай амьтан юуны хэрэг. Ард олноо орхихоор барахгүй, тэднээ эсэргүүцэхэд бэлхэн байгаа чиний өнгийг бид итгэж болох уу? Үүнийг баригтун гэхэд, олон зандалчин, Хумар Тигинийг дагагсдын хамт барин, хувцас хунарыг тайчаад, цус гаргалгүй, ууцыг хугачин, дөнгөж голтой, жалганд хаяж, амьдаар нохой цөөврийн хоол болгов.

Чингис хааны их хөвүүн Зөч хаан, цэргийн хамтаар ирэхэд Гурганж хот Монгол цэрэгт нэгэнт нягт бүслэгдсэн байв. Чулуу харвах оньснуудыг хотын хэрэмд ойртуулахын тул, хэрмийн шуудуунд гүүр тавиулахаар гурван мянган монгол, олон олзны хүмүүсийн хамт ажиллатал, гэнэт туркмен Хар Хончир тэргүүтэй морьт эрэлхэг цэргийн баг, Гурганжийн хаалганаас гаран довтолж, ажиллаж байсан Монголчуудыг хядаад, гүүр дээгүүр хүүрээр овоо босгов.

Энэхүү амжилт нь бүслэгдсэн хүмүүсийн сэтгэлийг сэргээв. Үүнд, монголчууд, хот руу бүх цэргээр хөдлөхдөө, тэр нутгаас баригдагсдыг өмнөө тууж, хэрмийн тойрсон шуудууг булуулсны дараа

хот байлдах машиныг ойртуулж дайран оров. Монголын олон чөдөр оньс, нойтон модон сум, ноцож байгаа шингэн зүйлтэй Хятадын домбонуудыг харван чулуудаж, хотын доторх модон барилга гал авалцан, их түймэр бадарч, унтрааж дийлдэхгүй болжээ.

Зөч хааны цэрэг, хотын умар зүгээс эрслэн тулалдаж, олзны хүнээр хотын умард хэрмийг газар доогуур нүхлүүлэн хот дотор дайран ороод, үхэхээр зууралдан тулж, удалгүй хотын харуулын умард цамхаг дээр их хаан хөвүүний том цагаан туг намилзанхан хийсэв.

Цагаадай, үүнийг үзээд, атаархан хорсож, цэргээ баг багаар явуулан, Гурганж хотын хэрмийг байлдуулсан боловч, хэрэм хамгаалагчид, хүний санаанд оромгүй зоригтой тулалдаж хэрэм өөд авирагчдын толгой руу буцламгай ус, халуун давирхай асгасан тул, довтлогчид, бөөн бөөнөөр шазлагдан унацгаав.

ХАР ХОНЧИР «ҮҮРД УМАРТАХЫН ЦАМХАГ»-Т ОРОВ

Хар Хончир, өвгөн Саклабтай уулзахаар, ургаа модон доорх бяцхан хаалган дээр хэдэн удаа очоод, уулзаж чадсангүй. Чингэсээр, өвгөнтэй уулзвал, урьдын адил новширч ноолорсон биш, харин эрээн судалтай дээл, хөх турбан малгай өмссөн нь огт танимгүй болжээ. Өвгөн өгүүлрүүн;

— Эрэлхэг сайн эр беги намайг уучлаарай. Би юу мэдсэн, юу хийснээ эрт бүрэн ярьж чадаагүй шүү. Шоронгийн манаач амандаа ус балгасан юм шиг дуугай байна. Нэг бол зандалчнаас айсан, нэг бол тэдэнтэй нэг биз ээ. Би түүнтэй нэлээд яриад сүүлд шоронг цэвэрлэе гэж хэлсэн чинь, түүний уурыг хүргэжээ. Би түүний гэрт өдөр бүр хоёр боорцгоор ажил хийе гэсэнд тэр баясаж, намайг өөрийн найман эхнэрийн харуулч болгож билээ. Түүний ууртай их эхнэрийг зодсонд баярлаж, энэ дээл, хуучин турбан малгайг над шагнасан... гэсэнд, Хар Хончир ундууцаж.

— Чи над юуны эхнэр, юуны дээл гэж дэмий чалчив. Би чамд таван алтан зоос өгсөн. Чи юу хийв. Хэрэгтэй бүгдийг мэдсэн үү гэвэл.

— Мэдэлгүй яах вэ. Назар-Баабай дуугай байдаг бол, түүний олон эхнэр хэрхэн дуугай байж чадах билээ. Аль хэдийн Назараас бүгдийг мэдсэн ажгуу. Би эхнэрүүдээс мэдсэн... энэ шоронгийн цамхагийн дотор талын туурганд алтан хараацайн үүр шиг хэдэн жижигхэн өрөө шавчихсан юм. Цамхгийн дундах гуалингууд өмхөрч

шал нь зоорио хүртэл цөмөрчээ гэвэл чөтгөр чамайг тэр зооринд нь унагаасай гэж Хар Хончирын хэлтэл өвгөн өгүүлрүүн: Тэр олон өрөөнд хүрэхэд тун бэрхтэй, өмхөрсөн олсоор хүлсэн модон шатаар авирах хэрэгтэй ажгуу. Урьд манаач Назар-Баабай өөрөө авирч байсан юм. Одоо айдаг болсон гэнэ билээ гэтэл... Хар Хончир асууруун:

— Тэнд хэн суудаг юм бэ? гэвэл,

— Хоресм Шагийг хилэгнүүлсэн хүн сууцгааж байна. Харин нэг өрөөнд нь нэг залуу туркмен хүүхнийг хорьжээ... гэвэл, сайн эр Хар Хончир, өвгөний мөрөөс шүүрч,

— Түүний нэрийг хэл? гэж,

— Түүний нэрийг... Гүль-Жамал хэмээлцэнэ билээ гэв.

Хар Хончир яаран өгүүлрүүн:

— Чи одоо намайг тэр хүүхэн дээр хүргэж өг гэхэд өвгөн өгүүлрүүн:

— Хай, одоо болно гэж үү. Ордны үүдний дэргэд хоёр зуун зандалчин, дэмий л уйтгарлан хэнийг дайран барих билээ гэж хүлээж байтал, харин чи шоронд шууд очиж орохыг яахин хүснэ. Чи өөрөө зооринд унана даа гэвэл, Хар Хончир хашхиран өгүүлрүүн: Дугуй, аймхай амьтан! Шорон өөд оч. Намайг тэнд хүлээ. Одоо би очиж, бүгдийг гөвшинө... гэж Хар Хончир, морио гуядаж, тоос татуулан, богино гудамж уруудан давхиж, төмрийн дархан, гуульчин, зэвсгийн дархан, хөө хуяг, ялтсан хуяг, бамбай хийх урчуудын суудаг, хотын нөгөө захад хүрэхэд тоймгүй олон алх дөшний дуу чимээ учир зүггүй тачигнаж байв.

Гэвч ажил нь урьдын адилгүй. Гагцхүү, зэр зэвсэг хийх урчууд идэвхтэй ажиллаж байв. Ер хэн, үхэх цагаа ирээд байхад гуулин төмпөн, домбо, хазаар хударга, эмээлийн сайн тоног хэрэглэх билээ дээ?

Хар Хончирыг, дархнууд цугларч, хэрэлдэн маргалдахыг үзэхэд, хэрэлдэгсэд, морьтой хар хүнийг хараад, дуугай болцгоож, бараан морьтой «сайн хар эр»-д юу хэрэгтэй юм бол? гэж харж байтал; Хар Хончир, цугларагсдын дунд орж, сэтгэл хөдлөн хэлсэн нь;

— Хүүе, та нар, төмөр гартан, зэс цээжтэн, олон урчууд, хаад, беги нар, та нарыг хэчнээн удаан доромжлох юм бэ? Хоресм Шаг Мухамед, анхнаас, та нарын хүчийг албан татвараар шавхаад, өөрөө авдар дүүрэн алттай, Ирандзугтжээ. Завшаанаа, түүний эх хорт Ийнэ, хөвүүнийхээ хойноос тонилжээ.

Одоо, биеэ хаан гэгч султан Хумар Тигийн, манай дайсныг дагаж, Гурганж хотын хэрмийг хаанаас нь эвдэхэд хялбархныг магад хэлж өгсөн биз ээ. Та нар бас, нэг шинэ султан гарч, таныг хэзээ дахин худалдах бол? гэж хэдий болтол ангалзан хүлээх вэ? Та нар аль цагийг хүлээнэ? Ордонд очицгоож, тэр бузар үүрийг хэмхчин баллая. Шоронгийн төмөр хаалгыг буулгая. Зооринд байгаа хоригдлыг суллая. Тэнд хоригдогчид, дээрэмчин, алуурчин биш, султанд буруушаагдах үнэнийг хэлэгчид бий шүү гэвэл,

— Очицгооё, очицгооё! Шоронг нураая! гэжээ. Хар Хончир өгүүлрүүн; Агт гинж салгахад хэрэгтэй алх, өрөлбө, хасуурыг авцгаа. Шоронд үхэж байгаа ах дүү нараа зооринoос гаргахад хэрэгтэй бүхнийг ав гэвэл, олон урчууд, зэвсэгчин, зэсчин, цөм алх, илд, жад барин, ордон тийш сүртэйгээр бүлэглэн явцгаав.

Зарим нэгэн зандалчин дайран уулзаж, бүлэгчдийг хөөхийг оролдоод, няц цохигдон, хөсөр унацгаав. Урчууд, ордныг эвдлэн, шоронгийн төмөр хаалгыг онгойлгоход, Хар Хончирт хэдэн хүн туслалцав. Манаач Назар-Баабай хүлээстэй зогсож, хоригдлыг би өөрийн үр хүүхэд шиг асарч байсан билээ гэж уйлан уйлан батлав. Урчууд, шоронгийн төмөр үүдийг түргэн нээж, төмөрчинтэй гүйж ирсэн Туган хашхиран өгүүлрүүн;

— Бушуухан, зооринд ор. Тэнд мөнх харанхуйгаас сохорсон миний тэнхэлгүй нөхөр үлдэв. Зарим нь хөлөө огтлуулсан учир, гарч чадахгүй шүү... гэвэл, хэдэн хүн, зоорины харанхуй нүхээр оров. Тэндээс сэгсгэр үстэй, хир буртаг болсон, хумс нь урт ургасан, бие биетэй нь холбон гинжилсэн, хөл нь тушаатай, ширэлдсэн үстэй хоригдлууд мөлхөн гарч ирэв. Олон жилийн харанхуйгаас сохрогсод толгойгоор мөргөлөн, гараар тэмтэрхийлэн, нарт ертөнцийн дор, эрх чөлөөт хүний дунд дахин гарсан зол завшаанаа итгэхгүй уйлан инээн байв. Олон, тэднийг үзээд,

— Зах зээлээр явагтун. Хоресм шаг албатаа хэрхэн захирч байсныг олон түмэн үзэг. Худалдаачдаас цэвэр өмд цамцыг шаардан ав гэв.

Хар Хончир шатаасан бамбар барин, цамхгийн дотуур алхлахад хүйтэн чийг сэнгэнэвэл айн сандарч, залбирал уншсан манаачийг өөрийн урд түлхлэн явж, салганасан муу шатаар авирав. Туган, дагаж явангуут, цамхгийн хоригдлын хаалганы цоожийг алхаар ховх цохиход,

өрөвдмөөр тамтаг болсон хувцастай, туранхай хатангир эмэгтэйчүүд туургa түшин, салганан гарч, уйлан буцацгаалаа.

Хар Хончир, дээвэр өөд гарахад, манаач, төмөр хаалганы дэргэд зогсоод, төмөр шөргөөр хамгаалсан бяцхан дөрвөлжин нүх үзэгдэж, манаач өгүүлрүүн:

— Энд ордны дотоод гэрийн нэгэн эмэгтэй нас эцэслэтэл үүрд хоригдох ял заагдаж, хадгалагдан байдаг. Энэ эхнэр Шаг Мухамедад аймшиггүй гар хүрсэн эм билээ гэвэл, Хар Хончир өгүүлрүүн;

— Юугаа хүлээсэн юм бэ чи? Онгойлго! гэвэл,

— Над битгий хилэгнэ, эрэлхэг баатар аа. Энэ хаалганы түлхүүр, Падишаг эзэнд байдаг гэвэл,

— Чингэхүл, түлхүүр чамд үгүй юү гэвэл,

— Үгүй, эзэн минь. Үгүй, дээд Аллах минь. Надад түлхүүр байхгүй гэсэнд, чингэвэл Хар Хончир манаачийг тийм бол өт хорхойдоо оч гэж түлхсэнд манаач бачимдан гасалж, доош нисэн унахдаа, нурсан яс мод дайран мөргөж, цочсон нохойн гаслан хангинах дуу гарсаар, харанхуйд алга болов. Хар Хончир, бяцхан нүхэнд ойртон шагайвал, гагцхүү нарны ташуу туссан гэрэлд хуучин хивсний тасархайн төдийхөн үзэгдсэнд, Хар Хончир сэтгэрүүн; Өнөөх хүүхэн хаана байна. Өрөө хоосон... үхэв үү гэж бачимдтал, гэнэт түүний өмнүүр сүүдэр сүүмэлзэж, бараан нүүр үзэгдэн, том хар нүд ширтэв.

Хар Хончир хуучин дууллуудаас сайхан үгс олныг хэлэхээр хэдийн бэлтгэсэн боловч, тэр нь үргэсэн зөгий мэт алга болон замхарч, дөнгөж хэлж чадсан нь:

— Би байна гэхэд, сарааλжны цаанаас аймхай сулхан дуу шивгэнэсэн нь:

— Би чамайг танья. Чи гэрэл өөд нүүрээ харуул гэвэл, Хар Хончир гэдрэг ухран, ноцож байгаа бамбараа өргөвөл,

— Би чамайг араатны хумсанд маажуулсан сорвиор танив. Хэнд ч, юунд ч дийлддэггүй өнөөх сайн эр мөн байна гэвэл, Хар Хончир өгүүлрүүн:

— Чи хаалганаас түр зайл. Одоо эндээс гарна гээд, ажиглавал, эцэж турсан охин сүүдэр зэрэглээ мэт хойш ухран цоохор хивсний дүгрэг дээр аярхан унахыг үзлээ. Нүцгэн шахам бор бие дээр нь нарны гэрэл тусаж, өмссөн нь, уранхай улаан даавуу, зүүсэн нь хэдэн утас хэлхмэл сувсны төдийхөн ажгуу. Охины том хар нүд нь сүүмгэрхэн бөгөөд намуухан харагдав.

Хар Хончирыг дагалдсан хүн өгүүлрүүн; Чи над зам тавь. Энэ хаалгыг зэвсэгчин хүн Хар Хумийн элсэн говийн баатраас түргэн онгойлгож чадна гэж, цоожийг алхаар балбаж, төмөр хаалгыг онгойлголоо. Гүль-Жамал, биеэ гараар халхлан сууж, миний бүх хувцас ялзран уналаа. Би чиний өмнө босож чадахгүй гэж. Хар Хончир ухарч, залуу дарханд өгүүлрүүн:

— Чи хүүхний өөдөөс харах хэрэггүй. Дээлээ өг. Би чамд өөр торгон дээл бэлэглэе гэж хагас эвдэрсэн нарийн шатаар цамхгийн дээвэр өөд авиран гарч үзвэл, эргэн тойрон мушгирсан утаа уугьж, гал оч хуй мэт бужигнан үүл өөд баагин дэгдэж, хотод гал түймэр дүрэлзэн шатаж, хэрмийг тойрон тоос манан дундуур морьт цэрэг баг багаар явцгаав. Алсад цамхгийн дээр Зөч хааны долоон хөлт цагаан туг хийсэж байв.

Гүль-Жамал, хөх турбан малгай, эр хүний дээл өмсөж, байдал нарийхан гуалиг хөвүүний адил, Цамхгийн талбар дээр гарч ирээд, нум мэт муруй хөмсгөө гайхан өргөж, алсыг ширтэн,

— Гурганжид юу болж байна вэ. Юун аймшигтай хүмүүс, хотын хэрмийн өмнүүр давхилдана вэ? гэвэл, Хар Хончир өгүүлрүүн;

— Байлдаан гэдэг тулгараад байна. Дайсан Гурганжийг хаажээ... Одоо бид хоёр ямагт мөр зэрэгцэн байлдана. Дайны гал, чиний гунигт нүдний нулимс биднийг нэгтгэлээ, гэсэнд Гүль-Жамал өгүүлрүүн: Би энэ аймшигт цамхагт байсаар, юм болгоныг мартаж, гагцхүү хорсон занахыг сурлаа. Би урьдын ухваргүй Гүль-Жамал биш... Чамтай хаана ч хамт, догширсон барс мэт явна... гэвэл, Хар Хончир түүний үгийг сонсолгүй, нүдээ гараараа саравчилж, утаа тоос хуйлран байгаа зүг ширтэж,

— Энэ галзуу нар юу хийчхэв. Хар! Жейхун их мөрөн эргээс хальж нааш урсаж байна. Байшинг нурааж, хүүхдийн тоглоом шиг хэмхчиж байна.

Хар, өндөр тоорой мод огтлогдсон юм шиг хуухинан сэрчигнэн унаж байна... Гүль-Жамал энэ мохдог оюут, хайргүй зэрлэгүүд, элбэг уст их мөрний[37] хүчирхэг урсгалыг мянган жил хаасан эртний даланг задалжээ... Одоо мөрөн, замдаа дайралдсаныг сүйдэлж, урсан халилан, олон хүнт бүх хотыг залгиж байна... энэ хуучин цамхгаас түргэн гүйж зайлах хэрэгтэй. Үерийн усанд нурж, биднийг дарна... гэжээ.

Монголчуудын өмнөө туусан олзны хүмүүс тасралтгүй дайрсаар, хотын ихэнх хувийг эвдсэн боловч, Гурганжийн хүмүүс, зоригтойгоор

үхэхээр зууралдан тулалдсаар бүлгээ.

Монголчууд, хотын хороодыг дараа дараагаар эзэллээ. Хээр талд байлдаж сурсан монголчуудад, барилга нь шатан нурж байгаа хотын нарийн гудамжаар явахад бэрхтэй байсан боловч, шаргуугаар давшсаар, урт сумаар хот хамгаалагчдыг мэргэнээр харван унагаана. Үүнд Гурганжийн хамгийн галзуу байлдагчид нь гар урчууд байлаа. Тэд бол монголчууд, олон урчуудын дотроос хамгийн уран, хамгийн хүчтэнийг алс нутагтаа явуулж, бусад үл тохирогчдыг ална гэж сайн мэдэх билээ.

Эмс охид, хотын хэрэм, байшингийн дээвэр дээр гарч, эцэг нөхөр, ах дүүгийн хамт тулалдаж, тэдний хэн нэг нь шархдаж унавал, эмэгтэйчүүд аймшиггүй дэргэд нь очиж шарх олохоос хамгаалан, туйпуу, шороогоор халхавч барьдаг байв.

Гурганжийг хамгаалсан нь, их Хоресм улс мөхсөний гунигт туужид нэгэн ер бусын хуудсанд бичигджээ. Бусад хотын ихэнх нь, Монголд мухар сохор итгэж, зүрхгүй сул буурай байсан тул, нэр төргүй балран үрэгджээ.

Монголчууд, Гурганжийн орчим, маш олон цэргээ алдаж, үхэгсдийн яс нь, хожим олон жил болтол, эвдэрхий барилгын хооронд уул толгой мэт овоорон хэвтсэн билээ. Чингээд, дайсан, хотын ихэнхийг эзэлж, зөвхөн гурван хороо үлдсэнд зовон зүдэж, шархадсан Гурганжийг хамгаалагчид нь бууж өгье гэж төлөөлөгч сонгож, Зөч хаанд өршөөлийн гуйн явуулбал, Чингисийн тэр хөвүүнээс хариулсан нь:

— Та нар, эртнээс юу бодсон юм бэ? Яагаад та нар, миний цэргийг хотод ойртон ирэхэд бууж өгөөгүй юм бэ? Би өчнөөн сайн шилдэг байлдагчдаа алдаад, одоо өөрийн цэргийн уур хилэнг зогсоож чадах буюу? Та нарыг хэрхэвч хайрлахгүй гэжээ.

Монголчууд, хотын автагдаагүй хэсэг рүү довтлон орж, хамгаалагчдын заримыг олзолж, заримыг цавчин алж, эд хөрөнгийг дээрэмдэв.

Цагаадай хаан, Хоресмийн сувд чимэг болсон Гурганжийг ахдаа өгөх дургүй учир, монголчууд, бүх Хоресмд ус түгээгч усны их даланг эвдлүүлсэнд, ус их хотоор дүүрч, барилга байшинг урсган эвдэв. Хотын ор суурь нь, хожим болтол олон жил усаар бүрхэгдэн байжээ. Татаарын гараас амьд гарагсад, хальсан усанд живж үхэх нь үхэж, эвдэрсэн байшинд дарагдах нь дарагдан үхэж, хэдхэн барилга үлдсэн

нь, туйпуугаар барьсан Кешки Ахчагийн хуучин ордны хагас, жич, хоёр Шаг хааны шарилын бунхан үлджээ.

Энэ мэт догширсон мөрний ус хальж, Хоресмийн бусад хотыг халин авч их мөрөн урсгалаа өөрчлөөд, монголчуудын Дал далай гэдэг Каспийн тэнгист цутган ороходоо, хойно он их л удтал, элсэн дундуур урсан цутгах бүлгээ.

Гурганжийг үхээхээр байлдан хамгаалахад Хажи Рахим, хэрэм дээр тулалдагсдын дунд байлцаж, шарх боох, эмнэх Арабын аргыг мэдэх тул, гэмтэгсдэд тусалж байсан билээ. Чингээд,

Гэнэт Жейхун мөрнийг үерлэсэнд, Хажи Рахим, Текеш Шагийн туйпуугаар барьсан өндөр бумбан оршил дээр хоёр өдөр сууж, гайхаш барагдан байтал, дэргэдүүр нь хөвж яваа онгоцны залуурчин нь Дервишийн танил өнөөх Гэрим-Гүл дархан тохиолдож, Хажи-Рахимыг завиндаа суулгаад, догшрон бургилагч усан дээгүүр хөвж, хүнд чадлаараа тусалж, онгоцондоо татаж явав. Чингээд, тэр хоёр хүн, Хар Хончир Гүль-Жамалтай уулзаж чадсангүй, нэлээд хожим, Рахим-Хажи сонсвол, Хар Хончир, элсэн цөл Хар Хумд Монголыг авлаж байсан зоригт явдал ба Хоресм-Шагд булаагдан очоод эргэж ирсэн түүний сэтгэл зүрхний малчин эмэгтэй Гүль-Жамалд хязгаарлашгүй хайртай байдгийг нь ардын үлгэрчнээс олонт сонссон билээ. Тэр үлгэрч, үлгэрээ ярихдаа алдарт, баялаг Гурганж хэрхэн үерлэн хальсан, мөрөнд автагдсаныг тодорхойлон ярьж төгсгөхдөө, догшрон бургилагч мөрний урсгалд Хар Хончир дайралдаад, Гүль-Жамалыг амьд гаргахын тул, долгиотой цөхрөлгүй тэмцсэнийг зарим хүмүүс үзсэн билээ. Чингээд, тэр хоёулаа догшин урсгалд алга болжээ... Хойно нэгэн газар уснаас гадагш хаягдсан хоёр хүүр олдсон нь Гүль-Жамал, Хар Хончир хоёр зэрэгцэн хэвтжээ. Тэр туркмен хүүхний бяцхан гарыг Хар Хончир, чийрэг алгандаа атгасан байжээ гэж үлгэрээ төгсгөхдөө «үнэн хүслийн дурлал бол-үхэхээс нааш эцэслэхгүй[38]» гэдэг байжээ. Үүнийг сонсоод, охид уяран уйлдаг ахул, тэр үлгэрчин, сэтгэлийг засаж, би зарим мэдэх хүмүүсээс, бас, сонсвол, Хар Хончир, Жейхун мөрний долгионд үхсэнгүй, харин мөрний бялхсан их уснаас хар морио унаж, усчлан гараад, Гүль-Жамалын амийг авран, элсэн цөл, Хар Хумийн гүнд Бала-Исимийн худгийн ойрх гэртээ аваачиж, амар сайхан жаргажээ гэнэ. Та нар ч түүнчлэн жаргах болтугай гэдэг билээ.

РАХИМ ХАЖИ, ЗАЛУУ БАТ ХААНЫ ДЭРГЭД

Арчгүй буурай хүүхдийг бүү доромжил
Арслангийн зулзага байж юуны магад.
(Арабын хуучин үг)

Өгүүлэх нь: Хажи-Рахим улангассан догшин монгол цэргийн хоорондуур чүү чамай гэж нэвтрэн явсаар, Зөч хааны хүрээнд хүрчээ. Дервиш малгай дээрээ шонхорт алтан пайз хадсан нь, түүний хамгаалалтаар монголчуудын их хааны харьяат баруун хойд улсын эзний цагаан гэрт хүрч ирэв. Рахим Хажийн сонссон нь: Зөч хаан бол, аймшигт Чингис хааны ахмад хөвүүн билээ. Монголын эзний шадар хүний дотроос, энэ Зөч, Чингистэй ганцаар зүрхлэн маргадаг хүн байжээ гэдэг билээ. Чингэвч мөн Чингис хаан, их хүүгээ итгэхгүй, бусадтай сэм хуйвалдуужин гэж, үргэлж хардан сэжиглэдэг учир, түүнийг хамгийн алс хязгаарын ихэнх газрыг байлдан дагуулж авах улсын эзэн болгож, захисан нь: «Монгол морины туурийн гишгээгүй өрнөд алсын бүх газрыг чамд өгье» гэсэн билээ. Үүнийг үл өгүүлэн өгүүлэх нь:

Зөч хаан, цагаан гэрийн дотор, намхан ширээн дээр суужээ. Байдал, эцэгтэйгээ адилхан, өндөр нуруутай, баавгайн аяг зантай, хүйтэн харцтай, муурын ногоон нүдтэй билээ. Урт живэртэй, нарийн хууз сахлаараа сахалгүй Монголчуудаас ондоо үзэгддэг байлаа. Урнаар сүлжсэн урт нарийхан хялгас, сахалдаа залгаж, үзүүрийг баруун чих дээгүүр унжуулжээ.

Эзний ширээний өмнө, хаад, лалын улем[39] лам нар, худалдаачин, хотын иргэд газар хүртэл бөхийн сөхөрч, их эзний өршөөлийг хүлээжээ.

Рахим-Хажи «Яа-гүү, яа хаг!» гэж чанга дуугаар давтан давтан, бараалхагчдын нуруун дээгүүр алхаж, Зөч хааны ширээ өөд шууд очоод, дулдуйгаа тулж зогсвол, Зөч хаан, Дервишийг ширтэн харж.

— Хивчагийн бөө, чи юү гуйв? гэвэл Рахим-Хажи, их сайд Махмуд Ялвачийн гарын захидал авчирснаа хэлэв. Зөч хаан өгүүлрүүн:

— Юунд саатав? Би чамайг хүлээсээр удав гэвэл,

— Би Гурганж хотод хаагдав гэвэл, Зөч асууруун:

— Чи, чингэвэл, миний дайсантай хамт байсан юм аа гэвэл,

— Тийм, би эмч хүн тул, шархтанд тусалсан гээд, дулдуйгаа онгойлгож, давирхайгаар наасан улаан тамгатай, эвхээстэй хуудас

гаргаж өгвөл, Зөч хааны бичээч хуудсыг задалж, түүнийг гайхан үзэж өгүүлрүүн:

— «Энэ хүнийг итгэ» гэж гуравхан үгийг бичиж гэсэнд Зөч өгүүлрүүн: Товч боловч, тодорхой байна. Миний хөвүүн Бат хааныг ирүүлэгтүн гэсэнд, нөхөр Багдад гүйн явж, удалгүй Бат хааны хамт ирсэнд өмнө нь есөн настай, жижиг нумтай хаан язгуурын тэмдэг болсон гурван улаан сумтай[40], хөвүүн гүйж ирэв. Тэр хөвүүн, хөтөлж явсан хоёр өвгөнөөсөө салж, Зөч хааны дэргэд очоод, сурамгайгаар сөгдөж хивс цээр духаа хүргэж, ухасхийн босоод, гялалзсан нүдээр харвал, Зөч хаан хөвүүний зүг нүдээр буландаж өгүүлрүүн: Миний хөвүүн Бат хаан энэ байна. Би бат журамт Махмуд Ялвачийг миний шинэ албат Хоресмийн иргэдтэй тэдний хэлээр ярьж бичгийг нь унших, бичихэд хөвүүнээ сургаж чадах эрдэмтэн багшийг олж өгнө үү гэж захисан билээ. Чи тийм багш болж чадах буюу? гэвэл, Рахим Хажи өгүүлрүүн,

— Би хөвүүнийг туркмен, перс, арабаар ном судар уншихыг сургаж чадна. Үүнийг баяртай хийе. Гагцхүү би лалын сүмийн имам лам нар мэт, шашны ном судрыг тайлбарлаж чадахгүй. Харин дэлхий ертөнцийг хэссэн түүх, сайн муугийн ялгавар, эх нутагтаа хайртайн ёс, хүний журам зүйг өгүүлсэн бичиг заана гэвэл, Зөч хаан өгүүлрүүн:

— Энэ сайн хэрэг. Ийм багш бол миний хөвүүний хээрийн зэрлэгийн арьсыг өвчиж, олон улсыг засахын эзэн болгоход тустай хэрэг. Бат, чи энэ шинэ багшийн үг дагаж яв. Багш, чамд миний хөвүүнийг занчих эрх олгоё гэвэл, хөвүүн буруу хараад,

— Энэ багш над, баатар эрийн түүх ярьж, дайн байлдааныг яривал, би үгийг сонсоно гэвэл,

Рахим Хажи өгүүлрүүн;

— Би чамд Ромын жанжин хоёр эвэрт Искендрийн байлдан дагуулсан явдлыг ярья. Энэ хаан, бага залуу насандаа, өөрөөсөө илүү цэрэг зэвсэг, эрдэнэсийн сантай олон хаадыг байлдан дагуулжээ гэвэл, хүү нааш харж, Дервишийг хачирхан харж байв. Зөч хаан асууруун;

— Искендер хаан, яаж чингэж ялж явсан юм бол? гэвэл

— Энэ тухай Искендрээс асуухад, хариу хэлсэн нь: «Би байлдан дагуулсан улсын ард албатыг үл дарлах билээ» гэсэн гэж хэлэлцдэг... гэвэл,

Зөч хаан, хөвүүн Батын зүг харж,

— Миний эцэг хосгүй суу зальт Чингис хаан, ертөнцийн тал хувийг байлдан дагуулав. Хоёр эвэрт Искендер нөгөө хагасыг эзэлжээ. Бат хаан, чамд байлдан дагуулах юу үлдсэн бэ? гэвэл,

Хөвүүн бодолгүйгээр, хариу хэлсэн нь:

— Би Искендерээс бүх газрыг булаана... гэжээ.

Рахим Хажи, тэр өдрөөс Зөч хааны хүрээнд сууж, түүний хөвүүн Батын багш болоод, Зөч хааныг зориуд илгээгдсэн алуурчны гарт гэнэт үхэхийг хүртэл хэд хэдэн жил Батад багшлав. Үүнийг өгүүлэх нь: Зөч хаан, ав хоморгод мордоод, нөхрүүдээс салан, буга хөөж зэгсэн дундуур далд орсны хойно арай чармайн эрж олбол, Монголын хуучин заншлаар ууцыг нь хугалсан байжээ. Нууц алуурчин алга болж олдсонгүй, зарим хүний шивнэлдэх нь: Тэдгээр алуурчныг Чингис хаан, өөрөө явуулсан гэнэ ээ. Зөчийг зэгсэн дотроос олоход, амьд байсан боловч, үг хэлэх байтугай, гараа ч хөдөлгөж чадахгүй, гагцхүү нүдээ үүрд аньтал гунигтай сүүмгэр харж хэвтсэн билээ.

Энэ үед, алдарт жанжин Сүбээдэй баатар, өрнө зүгийн аян дайнаас буцаж ирсэн билээ. Сүбээдэй баатар, хөвүүн Бат хааныг мориндоо сундалж хэлсэн нь;

— Энд чамайг, миний эзэн Зөч хааны үзсэнчлэн явдал хүлээж байна. Цэргийн сургууль сайтар сурах Хятад улсад чи надтай хамт яв. Би чамайг төрсөн хөвүүн мэт хүмүүжүүлж жанжин[41] болгоё гэжээ.

Рахим Хажи, Бат хаанаас хагацаж, дахин ганц бие цагаачин болж, Гурганж хотын усны халилганы үед алга болсон дүү Туганыг үхсэн буюу, мөрний долгион, монголчуудын илдээс амь гарсан буюу, бусад мужуудаар тэнэж яваа юм уу, өөрийн эрхтэй буюу, боол болсон уу гэж ихэд гашуудан мөрөөдөж, цаг ямагт санасаар дахин уулзах өдрийг хүлээж байв.

Рахим Хажи, олон хот хэсэн тэнэж, энэрэлгүй Монголчуудын довтлох үед Хоресмийн ардуудын өнгөрүүлсэн тэр эмгэнэлт байдлыг нүдээр үзэгсдээс асуун хэлүүлсээр, баттай үнэн явдал өгүүллийг тэмдэглэн тэмдэглэсээр, Чингис хааны тухай ном хийж, хэрхэн хүчирхэг болж, бүх ертөнцийг байлдан дагуулахыг хүссэн монголчуудын дайран өнгөрсөн газар хүн амьтан үрэгдэж, нутаг нь хоосон цөл болсныг ном болгож бичье гэж байсан билээ.

НАЙМДУГААР БҮЛЭГ : КАЛК ГОЛЫН БАЙЛДААН

ЧИНГИС ХААНЫ ЗАРЛИГ

... Тэдний байдал эрлэг мэт бөгөөд, үзмэгц айдас хүрмээр, сахалгүй, уруул оочдоо хэдэн үстэй, нүд жартгар, түргэн харцтай, дуу нарийн хурц, бие махбод нь чийрэг хүдэр, урт насалдаг улс гэжээ.
(13 дугаар зууны Армены түүхч Куракос)

Луу (1220) жилийн хавар, Сафар гэдэг (дөрвөн) сард Чингис хаан, бэрх даалгаврыг сайнаар биелүүлж шалгарсан өвгөн жанжин, өрөөсөн нүдэт Сүбээдэй баатар, залуу Зэв ноён хоёрыг дуудвал[42], тэр хоёр баатар, «орчлонг донсолгогч»-ийн торгон гэрт яаран хүрч ирээд, алтан ширээний өмнө эсгий дээр сөхрөв. Чингис хаан, зүүн хөлөө нугалан сууж, гараараа баруун өвдгөө салаавчилжээ. Түүний том маргад эрдэнэтэй дугуй гялгар малгайнаас хар үнэгний сүүл унжжээ. Муурын ногоон нүдээр бөхийн сөгдөж байгаа ялагдашгүй хоёр баатраа ажиггүй ширтэн харж, «хосгүй суу зальт» тэр намхан бүдүүн дуугаар өгүүлрүүн:

— Шар чихт нохойн хүү, Хоресм Шаг Мухамед, нууцаар цэргээ орхин явжээ, гэж туршуул над мэдэгдэв. Тэр оргосон мөрөө баллаж явсан боловч, саяхан Жейхун (Амударья) мөрнийг гатлахдаа үзэгджээ. Биеийн хамт Хоресм Шагийн зуун жилийн хураасан тоймгүй их эрдэнэсийг авч явна. Түүнийг дахин их цэрэг байгуулахаас өмнө эртхэн барьж авах хэрэгтэй... Би, та нарт хоёр түмэн морьт цэрэг өгнө. Шаг хаан байлдах уу, байх уу? гэж та нарын эргэлзэн бодмоор тийм их цэрэгтэй болбол, бүү байлд, над мэдэгд. Чингэвэл... Би Тогучар ноёныг явуулна. Тэр ганцаараа та хоёрын хавсарч дийлэхгүйг дийлнэ...

Гэвч миний энэ үг, Мухамедын бүх цэргээс хүчтэй биз ээ. Мухамедыг гинжээр оосорлож авчрахаас наашц, та нар битгий ирээрэй. Та нарт дарагдсан Шаг, бат бэх уул, харанхуй агуйд хоргодъё гэж хэдэн дагалдагсдын хамт зугтах буюу зальтай илбэчин мэт, хүн харсаар байтал, алга болох ахул, та нар, түүний нутгаар хар салхи мэт дайрч гараарай. Номхрон буусан хот бүхэнд өршөөл үзүүлж, тэнд хэдэн цэргийг үлдээн, инээхийг умартсан захирагчийг тавь. Тэмцэхийн замд хандсан хот бүхнийг дайран ав. Үнсэн товрогийг нь хийсгэ. Манай энэ үг, та хоёрт хэцүү санагдахгүй биз ээ... гэвэл, Зэв ноён босож асууруун:

— Хоресмийн Шаг Мухамед, гайхалтай нэгэн аргаар, баруун тийш биднээс зугтсаар байвал, бид хэчнээн хоног түүнийг хөөж, таны алтан өргөөнөөс холдох вэ гэвэл,

— Газар тэнгэрийн савсалганд хүрч, сүүлчийн далайг үзтэл хөө гэв.

Бөгтөр, тахир биетэй Сүбээдэй баатар аахилан сүйлж, толгойгоо дээш өргөөд сөөнгө дуугаар асууруун:

— Мухамед Шаг, загас болоод, далайн гүнд орчвол яах вэ? гэвэл,

Чингис хаан, хамраа маажин, сэжиглэсэн маягтайгаар Сүбээдэй өөд харж,

— Чингэхээс нь өмнө барьж явах хэрэгтэй. Одоо яв гэтэл, хоёр жанжин босож, үүдний зүг ухарсаар гарав.

Чингээд, хоёр жанжин, тэр өдөр хоёр түмэн монгол татар цэрэг дагуулан, баруун зүг тэр өдөртөө мордов.

«СУУ ЗАЛЬТ ЭЭЭН»-д АЙЛТГАЛ ЯВУУЛСАН НЬ

Өгүүлэх нь: Чингис хааны зарлигийг гүйцэтгэж, жанжин Зэв ноён, Сүбээдэй баатар, хоёр түмэн морьт цэргийн хамт, Хоресмийн оргосон эзэн Мухамедын мөрийг хөөж, Ираны уул, хөндийгөөр хоёр жилийн турш давхилдсан боловч юу ч олж чадсангүй. Ардын аман үгэнд эх нутгаа хаяж зугтсан Хоресм Шаг, Монголчуудын Дал Далай гэдэг далайн нэгэн арал дээр үхсэн гэнэ.

Чингэхүл, Зэв Сүбээдэй хоёр, баатар эрчүүдийн байлдааны туульсыг дуулж чадах нэгэн монгол хүнийг дуудан ирүүлж, «хосгүй, суу зальт эзэн»-д айлтгалыг гиншин дуулж, есөн[43] ес давтуулаад зүлэг нуга тунгалаг ус элбэгтэй Несеф[44] хотын дэргэдэх талд байгаа Чингис хаанд явуулав.

Монголчуудын шатаасан хотыг орхиж зайлсан өлөн оргодол бүлэглэн явж, дээрэм хийх тул, зам явахад аюултай учраас, элчийг хамгаалах гурван зуун итгэлт сайн цэрэг гаргаж одуулав. Тэр элч, замын турш Монголын хөх цэнхэр тал, ой модтой уул ба задгай галын гал улаан дөл шиг сайхан Хэрлэнгийн охидыг магтсан эртний дуу дуулсаар явсан боловч, захиж явуулсан баатрын айлтгалыг нэг ч дуулсангүй. Их хааны ордонд хүрээд, найман давхар зогссон бие хамгаалагч торгуудыг дамжин, задгай галын утаагаар биеэ ариутгаад, шар ордны алтан үүдний өмнө зогсов. Үүдний хоёр талд хун цагаан хул

хоёр сайхан морь, цул алтан шон гадаснаас цагаан дээсээр уяастай байхыг элч гайхан үзээд, сүрдэж, газар ойчив. Чингэтэл, бяртай хоёр торгууд өргөж босгоод, гэрт оруулж, Чингис хааны өмнөх хивс дээр тавив. Монголын эзэн, алт болсон өргөн ширээн дээрээ завилан суув.

Элч, эзний өмнө сөгдөж, нүдээ аниад Монголын эртний туульсыг дуулж дурсан өндөр дуугаар тогтоосон айлтгалаа дуулруун:

Сүр ихт эзний хичээнгүй цэрэг,
Сүбээдэй Зэв хоёр баатраас
Суу зальт их эзэнд
Сонсгон айлтгах үг.
Сүйрсэн Хоресм шаг агсан
Сүүлгүй үнэгний хүү Мухамед
Сүг болсон өвчтөний овоохойд
Сүүлчийн амьсгал нь тасарчээ;
Ялагдашгүй хүү Желал нь
Ираны уулсыг дамжин
Утаа униар мэт
Ул мөргүй болов.
Цааз зарлигийг чинь гүйцэтгээд,
Цаадах Кавказ руу явав,
Дайралдсан аймаг улстай
Дайн тулаан хийнэ.
Агт морьдыг амраах
Уужим хивчаг талыг нэвтэрч
Эрэлхэг чадлаа үзэлцэж
Эр цэргээ тоололцоно.
Өвдөгний дор ертөнцийг хийж
Өрнийн аймгийг довтолж
Бүх Монголын гарт
Бүрэн оруулахын тулд,
Аялан явах замаа таньж,
Алтан хүлгийн чинь бэлчээрийг эрнэ.
Цаад талын далай хүртэл биднийг
Цаглаж зогсоох хүчин байхгүй
Эцсийн далайн ногоон долгиогоор
Эмээлт морины туурыг угааж,

Цавчин огтолсон толгойгоор
Цамхаг овоо босгоно.
Босгосон овоо цамхгийн дээр
Бор хадны хэлтрэхийг тавьж,
Алдар нэрийг чинь сийлж,
Алалдан ирсэн замаар чинь буцаж,
Алтан өргөөнд чинь харихаар
Агт морины жолоог
Алс дорно зүг зална

гэж, дуугаа төгсөж, ердийн монгол хүнд хүрч болшгүй эзний цогт нүд өөд харсан боловч, мөн л сүрдээ унав. Чингис хаан, огт ажиггүй нүдээ анин, бууралтан байгаа улаан сахлаа хөдөлгөн сууж, нүцгэн хөлийн өсгийг маажин, урд нь хэвтэж байгаа элчийн ядарсан маягтайгаар харж, бодол бодсон мэт өгүүлрүүн:

— Хун галуу шиг хоолойтой юм аа чи... Чамайг шагналтай гэж түшлэгт өлгөөстэй, шар торгон хүүдийгээс тоосонд дарагдсан чихэр гаргаж, элчийн чичгэнэж байгаа аманд хийж өгүүлрүүн:

— Зэв ноён, Сүбээдэй баатар хоёрыг магтах арай болоогүй. Тэдний аян ямар болохыг үзье дээ... Манай хариу үгийг тусгай элчээр явуулна гээд хуруугаараа заан элчийг явуулж, ханатал айраг өг... хамгаалж ирсэн цэргийг сайнаар зочил гэж тушааж, маргаадар нь урагшилж хол явсан монгол цэргийн хойноос цөмийг нь явуулав. Чингээд жил өнгөрсөн боловч баруун зүг мордсон монголчуудаас огт мэдээ сураггүй тул нэгэн өдөр Чингис хаан өөрийн нарийн бичгийн дарга уйгур Исмайл Хожа-д хэдэн үг хэлж доторх үг утгыг хэн ч мэдээгүй нарийн нууц захидлыг битүүмжилж жижиг олон хонх зүүж, малгай дээрээ яаралтайн тэмдэг, өд өрөвлөг хадсан элчид өгч явуулаач гэж, Тогучар ноёныг нэгэн түмэн цэрэг дагуулан элчийг хамгаалан яв гэсэнд нь, — Чи Зэв ноён Сүбээдэй баатар хоёрыг олтол газар тэнгэрийн савсалганд хүртэл яв. Тэнд чиний нүдний өмнө энэ элч, миний захидлыг Сүбээдэй баатрын гарт өгөг. Тэд дэндүү хол явчхаад, хорсон хөдөлсөн гучин гурван улсад шахуулж байна. Одоо тэр хоёрт туслах цаг боллоо гэжээ. Тогучар, цэргээ дагуулж, газар тэнгэрийн савсалганд хүртэл явчихсан монголчуудыг эрэхээр тэр өдөртөө мордов.

СҮҮЛЧИЙН ДАЛАЙГ ЭРЭХЭЭР ЯВАВ

Өгүүлэх нь: Өвлийг ичээнд өнгөрүүлж, өвгөрсөн чанар модны үндсэн дороос хээр гарч, хаврын наранд дулаацан, зөрөг замаар заримдаа нийлэлдэн, заримдаа салалдан явж зугтан байгаа амьтан, бархиралдан нисэлдэж байгаа шувууг айлган байгаа хоёр хар могой мэт шаламгай Зэв ноён, зальтай Сүбээдэй баатрын хоёр түмэн цэрэг, заримдаа урт сур мэт гонжролдон, заримдаа нэг газар шуугилдан бөөгнөрч, айн сандарсан хот балгасын тойрон дахь тариаланг гишгэлж утаа болсон эвдэрхий балгас хуйхран шатсан хүний хүүрийг үлдээн, баруун тийш довтлов.

Чингис хааны цэргийн энэ урагшлуур баг, хойд Ираны нутгаар явж Хар хот, Шимнан хот, Кум хот, Зензан хот зэрэг хэдэн хот балгасыг сүйтгэжээ. Гагцхүү, баялаг Хамадан хотын тэргүүлэгчид, хүндэт элч нарыг явуулж дээл хувцас тэгнэсэн хоёр зуун тэмээ, нэгэн сүрэг адууны хамт бэлэг хүргэсэнд монголчууд, тэр хотыг өршөөн орхижээ. Харин, Казвин хотод сүрхий тулалдаан хийхэд хүрч, хотын хүн урт хутга барьж, үхэхээр хатгалдан тулалдсанд, тэрхүү Казвин хотыг түймэрдэн шатааж билээ.

Өвлийн хүйтэн сарыг монголчууд Рей хотын хавьд өвөлжин өнгөрүүлээд, зүг бүрээс өдий төдий хонь сайн морь нийлүүлэн, дээл хувцас ачсан тэмээтэй хөсөг тэр зүг явдаг байлаа.

Монголчуудын ийнхүү хавар болохыг хүлээж суутал, хаврын нарны илчинд Ираны уулсын бэл хажуу ногоороход, монголчууд, Азербайжаны нутгаар өнгөрөн гарж баялаг их Таврис хотын хүн үнэ ихт бэлэг барьсан тул, Монголчууд, хотод гар хүрэлгүй өнгөрч, Кавказын зүг чиглэн Арраны нийслэл Ганжад хүрээд, хотыг байлдан халдалгүй мөнгө ба хувцас нэхсэнд хүслийн ёсоор нийлүүлсэн учир, цааш Гүрж тийш замнан аялбал Гүржийн хүчирхэг цэрэг зам хөндөлсөн хаажээ. Үүнд, Сүбээдэй баатар, гол хүчний хамт өмнөх хошууч болж, Зэв ноён, таван мянган морьт цэргийг авч бүгжээ. Анхны тулалдаанд монголчууд, зоримог буруулсанд гүрж нар болгоомжлолгүй хөөж, Зэв ноёны татар цэргийн бүгсэн газар хүрсэнд, татар цэрэг, гэнэт гэзэг даран дайраад Сүвээдэйн морьт цэрэг эргэж, гүрж нарыг тал талаас нь хавчин байлдсанд, тэр тулалдаанд нэг түм гурван мянган гүрж нар алагджээ.

Гэвч, монгол цэрэг газар орон, уул хавцалтай хүн ард дайчин зүрхтэй, энэ газар гүнээ нэвтрэн орохоос болгоомжилж, олзоо дааж

ядтал ачин одов. Монгол цэргийн өгүүлэлдэх нь: Кавказын уулсын хавцалд цухалдаж байна. Адуу морь бэлчээх уудам хээр тал нутаг газрыг эрнэ гэцгээж, Шемах хотын хүнийг хүйс тэмтрэн хядаад, Ширваны Дербент хотын зүг чиглэн одов. Тэрхүү цайз бол халдашгүй уул дээр бөгөөд хойд зүг нэвтрэх сүвийг хаажээ. Зэв ноён цайзад нуугдсан Ширваны Шаг эзэнд элч явуулж, найртай сайхан эв зүйг хэлэлцэн тогтоохын учир сайн беги ноёдыг явуул гэсэнд Ширваны засаг ноён язгууртай, есөн өвгөдийг явуулбал Зэв ноён нэгэн ихэмсэг беги ноёныг бусдын нүдний өмнө цавчин алаад,

— Манай цэрэг, уулыг нэвтрэн гарахад хэрэглэх сайн газарч нарыг өг. Чингэвэл та нарыг өршөөнө. Хэрэв газарч нар муу байх ахул, та нар үүнтэй адил эцэслэнэ гэсэнд, Ширваны беги нар хүлээн дагая гэв. Чингээд, монгол цэргийг Дербентийг тойруулан уулын зөрөг замаар гаргаж, хивчаг нутаг орох зам зааж өгсөнд монголчууд, зуучилсан өвгөдийг тавиад хойд зүгийг чиглэн явав.

АЛАН ХИВЧАГИЙН НУТАГТ

Умарт Кавказад Зэв, Сүбээдэй хоёр Аланы нутагт хүрэв. Тэр газар Аланд туслахаар умард зүгийн талаас олон лесгин, черкес, хивчаг цэрэг ирцгээсэнд, монголчууд тэдэнтэй бүхэл өдөр тулалдсан боловч, хүчин адил учир, хэн ч дийлсэнгүй. Чингэхэд Зэв ноён, Хивчагийн их язгууртай хаан Контианд туршуул явуулж, Котианд нэгэн захидлыг өгөв. Тэр захидлын үг:

Маний татар хүн танай хивчагтай нэгэн аймгийн хүн билээ. Гэтэл, та нар харьтан аймагтай нийлэлдэн өөрсдийн ах дүү нарыг эсэргүүцэж байна. Алан бол та бидэнд хүний харь аймаг болно. Манай хоёр аймаг, харилцан үл түйвээх гэрээ байгуулсугай. Үүнд, бид сайн хувцас алтан эрдэнэсийг таны хүслийн ёсоор нийлүүлэн өгье. Та нар эндээс зайлагтун. Бид Аланы учрыг үүгээр олъё гэж хивчагт үнэтэй бэлэг тээсэн олон морь явуулсанд, тэдний хаад, бэлгийг хүлээн баярлаж, шөнө Аланыг сэм хаяад, умард зүг чиглэж, цэргээ дагуулан явжээ. Үүнд монгол цэрэг, Аланыг дайран сөнөөгөөд, суурин газрыг нь гал түймэр тавин алан хядсаар, шувтлан гарсанд Алангууд, Чингис хааныг бүрнээ дагасугай гэж зарим нь монгол цэрэгт хүчин нийлсэнд, Зэв Сүбээдэй хоёр нэгэнт ардаа Аланы хурц мэсийн аюулгүй болсон учир, харьяат түмэн цэргээ умар зүг хандуулан, хивчаг нутаг чиглэв.

Энэ завсар хивчаг хаад, аюулгүй амгалан тайван болов гэж, харьяат цэргийн багуудыг тус тус дагуулж, нутаг нутагтаа буцацгаасанд монголчууд тэднийг гэзэг даран хөөж хивчагийн гол гол хотлон буусан газрыг сүйтгэн, тэрслэн урвасны шанд урьд өгсөн эдээс олон давхар илүү эд олзлов. Үүнд хол нутагтай хивчаг Монголын довтолсныг сонсоод, тэмээндээ хогшил хөрөнгөө ачиж зүг бүр тарцгаан, зарим нь уултай газар, зарим нь ой модоор нуугдаж ихэнх нь Оросын нутаг руу оджээ.

Монголчууд, зугтаж байгаа хивчагийг Дон мөрний хөвөө дагуулан хөөж Хазаар далайн хөх долгионд оруулан олон хүнийг живүүлэн алж амьд үлдсэн хивчаг хүмүүсийг газар бүрээс эзэмшин авсан адуу малыг хариулах малчин зарц болгожээ.

Дараа нь Монголчууд, Хазаарын хойгт очиж хивчагийн далайн дэргэдэх Судаг гэдэг баялаг хотыг дайрав. Энэ хотод харь улсаас дээл хувцас, бөс даавуу зэргийг тээсэн олон онгоц ирдэг байсанд хивчагууд, олзлогдсон боол, хар үнэг, хэрмийн үс, жич сайн гэж нэрд гарсан хивчаг үхрийн ширээр тэр барааг арилжиж авдаг билээ.

Судаг хотын хүмүүс, Монголчууд ойртон ирж байгааг сонсоод, зугтаж, зарим нь ууланд нуугдан, зарим нь онгоцонд сууж, далайгаар дамжин Трапезунд руу явжээ.

Зэв, Сүбээдэй хоёр жанжин энэхүү хотыг дээрэмдээд хивчагийн нутагт амрахаар дахин хойш эргэв. Тэр газар бол өн сайхан бэлчээртэй, боолуудын хагалж боловсруулсан ургац сайтай тариалантай тарвас гуа ургасан ногооны хүрээлэнтэй, том биетэй үнээтэй, нарийн ноостой хоньтой ийм газар билээ.

Монгол цэрэг тэр нутгийг Онон, Хэрлэнгийн хөвөөтэй адилхан морь мал чөлөөтэй бэлчинэ, гэж магтан яривч монгол нутгаа ямар ч ондоо газраар солихгүй.

Ертөнцийг эзэлж аваад, төрсөн сайхан нутаг Хэрлэнгийн хөвөөнд эргэж буцна гэж монгол хүн бүхэн хэлэлцжээ.

Зэв Сүбээдэй хоёр жанжин өөрсдийн цэргийн хамт хивчагуудын гол хот Шаруканд төдий л удсангүй. Тэр хотод газарт суулгасан чулуун барилга, харь орны бараатай байшингууд байх ба ялангуяа, хивчагийн хаад болон нүүдэлчдийн суух эсгий гэр маш олон байжээ. Тэд нар хавар болоход талд нүүн гарч, өвөл цагт хотдоо буцаж өвөлждөг улс байжээ.

Монголчуудыг ирснээс хойш далайн цаадах худалдаачин хөл, дайнаас айж, хөдөө нутагтаа худалдаа арилжаа явуулахаа зогсов. Дээрэмдэн шатаагдсан Шарукан хот эзэнгүй болоход монголчууд, далайн булангийн зүг хандаж, тэнд салхинаас нөмөр тулд, дов толгодын хооронд дахь хонхорт хүрээ босгож буудаллав. Хүрээ бүхэнд хивчагаас булаан авсан хэдэн зуун гэр цагариглан барьж, нэгэн хүрээнд мянган цэрэг байх бөгөөд төв дунд нь үзүүртээ сэрээтэй, морины сүүл хөхлөөр хийсэн сэрээт туг босгож, мянгатын гэрийг барьжээ. Гэрийн гадна, олмыг чанга татсан морь, төмөр шонгоос уяатай бэлэн зогсож, бусад агт адууг хивчаг адуучин хариулдаг байв. Монгол цэрэг «Чингис хааны засаг»-ийн чанд нарийн хуулийг дагаж, хүрээ хуарангаа гурван давхар манаагаар хамгаалуулан, хөдөө талд Болгар, Орос, Унгарын нутаг орох гол зам дээр бас харуул, манаа зогсоно. Тэд нар талаар явсан хүнийг барин авч асуугаад, хавийн аймгуудын тухай сонин юм мэдэх хүнийг Зэв ноёнд явуулж, бусдыг нь цавчин алдаг байжээ. Олонх цэргийн хамт, хол нутгаас аян дайнд дагалцан явсан эхнэрүүд ба замд баригдсан эмэгтэйчүүд, хүүхэд явцгааж монгол бүсгүйчүүд, эр цэрэгтэй адил хувцасласан тул, ав авсаар таньж ялгахад бэрх. Заримдаа тулалдаанд оролцдог боловч, голдуу тэмээ, адуу мэдэж хуваахад оногдсон олз хадгалдаг, хөсөг тэргийг эрхэмлэдэг билээ. Мөн, гуя дээр нь тамга дарсан, олзны хүмүүсийг харгалзаж, тэднээр элдэв ажил хийлгэдэг байв.

Монгол бүсгүйчүүд, олзны хүмүүсийн хамт гүү, үнээ, ингэ сааж, буудаллах үед чулуун, ба зэс тогоонд хоол хийдэг байв.

Аян хийх үед төрсөн буюу замд олзлон авсан нялх хүүхэд, тэргэн дээр буюу заримдаа хоёр хоёрооров араг дотор сууж явах бүлгээ. Бас заримдаа бүсгүйчүүд, морин дээрээ үүрэн явдаг байжээ.

Монголчуудын хүрээ хуарангийн хажууд тэдэнтэй замд нийлэлдсэн олон омгийн цэргийн байр байх бөгөөд тэнд Туркмений алаг гэр, Тангадын банаг майхан, Белужийн хар асар, Алан буюу өөр ямар нэгэн омог ястан цэргийн майхан үзэгдэх бүлгээ. Монголчууд, тэрхүү танхай нийлмэл цэргийг түрүүнд явуулан байлдуулж, тулалдааны дараа олзлон авсан юмны үлдэгдлийг өгдөг байв.

КАЛК ГОЛ ХАВИЙН ТАТАР ЦЭРГИЙН ХҮРЭЭНД

Сүбээдэй баатрыг булингартай голын адагт, далайн хөвөөний өндөр дэнж дээр гэрээ бариулсанд, цэрэг, буудаллаж амрах цаг боллоо гэж баатрынхаа тушаалыг баяртайгаар гүйцэтгэн, хорин тэмээнд хэдэн гэр ачиж авчрав. Тэмээн дээр шовх оройтой эсгий малгай өмссөн олзны хивчаг хүүхэн, айсан царай гарган, гэр барихын үед монголчуудын дуул гэхэд нь дуу дуулж байв.

Сүбээдэй, хөмсгөө зангидан асууруун:

— Яагаад гурван гэр барьж байгаа юм бэ гэвэл,

— Нэгэнд нь та бодлоо бодно. Нөгөөд нь таны хайртай гөрөөчин ирвэсийг хийнэ. Гурав дахь гэрт дуу бүжиг мэддэг олзны хивчагийн бүсгүйчүүдийг түгжинэ, гэв. Сүбээдэй өгүүлрүүн:

— Үгүй. Хоёрдугаар гэрт ирвэс минь хүрхэрвэл хүрхэрч байг. Гурав дахь гэрт өвгөн Саклаб надад хоол хийж байг. Хивчагийн бүсгүйчүүд, аян, дайнд намайг битгий үймүүлэг. Тэднийг зуутад тарааж өгсүгэй гэв.

Саклаб, тогоо, том модон халбага авч, нарийхан урт хутгаа бүсэндээ хавчуулж, гурав дахь гэрт суув. Тэр, буурал үстэй, өндөр туранхай боол, Астрабад хотын хавьд Татарт баригдсан билээ. Цэрэг түүнийг бариад, Сүбээдэйд хэлсэн нь «энэ олзлогдсон өвгөн, орос омгийн хүн. Хоресм-Шаг Мухамедын Мирзагийн тогооч байсан. Одоо нутагтаа оргон зугтаж яваад баригдав. Энэ хүн олон хэл мэднэ. Мөн элдэв сайхан хоол хийж чаддаг юм байна. Танд бүйлс, тутарга хонины мах, үзэмтэй пилав, лисе жимстэй чилав, буурцагтай киймээ, цөцгийтэй хуймаг, халву, пахлаву хийж өгнө. Энэ өвгөнд өргөмөл залуу хөвүүн Туган бий. Тэр бол үг дуугүй хүн. Өвгөн Саклабт, хоол хийхэд тусална» гэвэл, Сүбээдэй уурлаж;

— Ганц өвгөн Саклаб хүрнэ. Ямар ч туслах хүн хэрэггүй. Хүн бүхэн тогооны дэргэд туслалцахдаа дуртай байдаг юм. Тэр Туган гэдэг хүүхдийг сэлэм жадаар зэвсэглэж, сүрэг адуун дотроос халцархай халзан морь барьж өгөөд, урагшлуур зуун цэрэгт явуул. Цэргийн эрдэм сураг. Хэрэв, сайн эр, цэрэг болох бол, удахгүй сайн морь сайн эмээл, хуягтай болно. Муу эр бол, түрүүчийн тулалдаанд алагдана. Чингэхүл, мөн тийм их гарз биш гэж хэлэв.

* * *

Үүд нь урагшаа далай өөд харсан цагаан бүрээстэй гэрийн өмнө Сүбээдэй, эмээлийн тохом дээр сууж, далайн ус, салхи, загас, долгион

дээгүүр нисэлдэн байгаа шувуу ч Монголын тал нутгийн хөх нуурынхтай адилгүйг гайхаж, бүлтийсэн нүдээрээ саарал өнгөтэй далайг харж байлаа.

Холоос нэг ижил долгион хөвөөг зүглэн, манан татсан алсад харь орны онгоцны далбаа цайран үзэгдэж, Татаарын эзэлсэн газарт ойртон ирэхээс айн зайлж яваа бололтой.

Тэр далайн булангийн хавь газар уудам сайхан талтай, саглагар өндөр өвстэй, усны олон шувуутай, цээл нууртай билээ. Эргэн тойронд хивчагаас булаан авсан мал бэлчин, үхэр нь урт эвэртэй бөгөөд, цагаан, хонь нь тарган, том сүүлтэй бөгөөд, бас л цагаан. Сүвээдэйн цэрэг, өдөр туж мах идэж, юу ч хийхгүй, персийн хивс дээр хэвтдэг байв.

Монголын мянганы ноён, хаад заримдаа начин шонхор авч, авд мордож, өөрсдийн монгол морь, замд олзлон авсан туркмен, перс, кавказ морины чадлыг үзэж уралддаг байжээ.

Калк голын дээд биед талын дунд нөгөө жанжин Зэв ноён, өргөөгөө босгожээ. Орчин тойронд нь сайхан тал ногоорон халиурч, харуулын овоо, олон овоо умрыг чиглэн цувжээ.

Чингис хаан, Зэв Сүбээдэй хоёрыг нэгэн ажилд нэг зэргээр явуулсан боловч, тэр хоёр хоорондоо эв муутай, үргэлж маргалдан, хэрэг дээрээ бие биеийн бурууг олж үзүүлэхийг оролддог байв.

Чингис хаан, ийм атаархагч хоёрыг зориуд явуулсан билээ. Ер нэг ажилд хоёр хүнийг явуулсан нь, ганц энэ удаа биш, атаархах хоёр хүн, ямагт шалгарч гарахыг оролддог юм гэжээ.

Аянд их шаламгай Зэв дандаа урагшаа тэргүүлэн орно. Түүний цэрэг нь хамгийн аюултай байдалд орж байсан удаа бий боловч, дайрч байх дайснаас аятай зайлан одно. Хэрэв тал бүрээс нь дайсан дайрч байвал, Сүбээдэй хүрч ирээд авардаг байжээ. Сүбээдэй, цэрэг мориндоо хятад төмөр хуяг өмсүүлж, хүнд морин цэргийн нягт бат жагсаалаар дайсныг дайрах бүлгээ.

Шил мэт хөдлөхгүй нүдтэй, өндөр чилгэр биетэй, хэзээ ч инээхгүй Зэв ноён, байлдааны дараа шороо тоосонд дарагдан, дээл хувцас нь цус болж, Сүбээдэйд хүрч ирдэг бүлгээ. Чингээд, задгай түлсэн галын дэргэд сууж, ямар ч алдаа хийгээгүй, зөвхөн дайсан дэндүү олон байсан гэж Сүбээдэйд тайлбарлан хэлдэг билээ. Сүбээдэй баатар Зэвийг, бас, дахин тэнхрүүлэн тусалсандаа сэтгэл тэнэгэр инээмсэглэж, чи алдаагаа цагаатгаж, надад ийм тийм гэхийн оронд шорлож шарсан хурганы мах амсаж үз. Хоресмийн Падишаг хааны

зоогийн хургатай адил саримсаг жимс шигтгэж шарсан сайхан мах шүү гэдэг билээ.

Зэв бол бардам омогтой, түргэн ууртай хүн билээ. Жаран алхам газраас гүйж яваа зурмын толгойг алдалгүй харвадаг мэргэн гавшгайн учир, түүнийг Зэв гэж нэрлэжээ. Ёстой нэр нь ондоо боловч, цэрэг даяар Зэв ноён гэдэг билээ. Тулалдааны өмнө Зэв ноён байлдах газрыг биеэр шалган үзэж, том шарга морио унаад, аюултай газрыг эргэн явдаг тул, заримдаа бие хамгаалагч торгуудууд түүнийг үхлийн амнаас арайхан авран авдаг байжээ.

Эрүүндээ бууралтсан армаг тармаг хэдэн сахалтай Сүвээдэйн овор их, өвгөн мэт. Чухам хэдэн настайг хэн ч мэдэхгүй байжээ. Залуу байхдаа мөрөө шархдуулж, булчин мах нь тасарсан тул баруун гар нь тэр үеэс эхлэн тахир болж, ганцхан солгой гараараа юм хийдэг байв.

Зүүн нүдний хөмсгийг дамжуулан нүүрээ цавчуулсан тул сохорсон зүүн нүд нь үргэлж аниастай, харин баруун нүд нь хүн бүхнийг өрөмдөн нэвт шувт харж байгаа мэт ширтэнэ.

Цэргүүд, Сүбээдэй бол, тасархай хөлтэй хөгшин үнэг шиг зальтай, хавханд орж үзсэн ирвэс мэт ууртай. Сүвээдэйн хамт явахад, ямар ч дайсан аюулгүй, хаа ч үхэхгүй гэж ярилцана.

Зэв бол, ертөнцийн захад байгаа сүүлчийн далайд хүрэх сэн гэж дандаа боддог байжээ.

Дуу дуулагч элчээр Чингис хаанд явуулах айлтгалыг Зэв зохиодог ажгуу. Сүбээдэй, гагцхүү, урамшуулан хөхиүлж, толгой дохин инээмсэглээд;

— Чи хол явж чадах юм уу? Чиний хүрээд, бөхөн гөрөөс мэт эргэж давхих газар чинь удахгүй үзэгдэх үү? би, чингээд, сүүлчийн удаа чамайг тэнхрүүлэхэд хүрэх үү? гэж хошигнох бүлгээ.

Хээр талыг сахин харж байсан туршуул, аялан явж байгаа хүнийг барьж, Зэвд авчрах бүлгээ. Зэв, умар өрнө зүгийн олон улс аймгийн байдал, агт морины тэжээл, баялаг хот балгад, бэх цайз, зэр, зэвсгийн байдал, цэрэг байлдахдаа сайн муу, адаг, сүүлчийн далай хэчнээн хол зэргийг асуудаг байжээ.

ХЭРМЭЛ ПЛОСКИНИЙН ТАТАРТ ОЛДОГДСОН НЬ

Өгүүлэх нь: Нэгэн өдөр, туршуулын цэрэг урьд үзэгдээгүй аймгийн хэдэн хүнийг Зэвд хүргэж ирлээ. Аян замын хүнийг онгоц

салаар ус гаталгаж байсан хүн билээ. Байдал, бие өндөр, мөр өргөн, том шар сахалтай, өмссөн нь хонины хуучин богино нэхий дээл, илгэн өмд, сураар сүлжсэн зөөлөн сөөхий гутал. Тэргүүнд бор шилүүсэн малгайг сүр бадруулж хазгай өмсжээ. Зэв тэднийг үзээд, та нар, юун хүн бэ? Хаанаас ирэв? гэж асуувал, бусдаас нэлээд өндөр, өргөн биетэй нэгэн хүн, хивчаг хэлээр хариулруун:

— Бид хээр талаар хэрэн явдаг учир «хэрмэл» гэдэг улс байна. Эцэг өвгөд минь, эзэн ноёдоос оргон энэ талд эрх зоригийн чөлөөг эрэн ирсэн билээ гэвэл,

— Та нар, өөрийн эздийг хүндэтгэхгүй, тэднээс оргон зайлсан бол, дээрэмчин тэнэмэл, гуйлгачин мөн биз ээ гэсэнд, бид дээрэмчид ч биш, тэнэмэл гуйлгачин ч биш, эрхээрээ явдаг дархан улс. Дур мэдэн гөрөөлдөг дархан гөрөөчин, загасчин улс байна гэвэл, Зэв асуув.

— Энэ өндөр хэрмэл чи хэн бэ гэвэл,

— Миний нэр Плоскини гэдэг. Манай хэрмэл намайг тэргүүлэгч болгосон гэвэл, Зэв, Сүбээдэйд элч довтолгож, бушуу хүрч ир, «Бидэнд хэрэгтэй хүн баригдав» гэж хэлүүлсэнд, мордсон элч нар буцаж ирээд, «Сүбээдэй баатар, ууттай шош дэргэдээ тавиад хивс дээр сууж байна. Би одоо чөлөөгүй, очиж чадахгүй» гэв гэж хариуг хэлж ирсэнд, хэрмэл Плоскини өгүүлрүүн:

— Энэ бол «хэний төлөө, хэн сэтгэл зовнивол, тэр хүндээ очих» хэрэг болжээ гэж, Зэв, бусад баригдсан хэрмэлийг хуягаар мануулан орхиод өөрөө Плоскинийн хамт цэргийг дагуулан Сүбээдэйд одов.

Огторгуйд шингэх нарны хүрэн улаан туяан дунд, Сүвээдэйн гурван гэр эрс ялгаран барайж, гэрээс дээш утаа мушгиран, цэргийн тэмдэг, адууны сүүл, хайнагийн эвэртэй урт нарийхан уурга сэрвэлзэн, Сүбээдэй, гэртээ Персийн торгон хивсэн дээр сууж байв. Задгай галын сүүдгэнэсэн гэрэлд гийгдэн суугч тэрээр цоохор хүүдийнээс шош, солгой гараар авч, хичээнгүй байдлаар хачин бөгөөд урт нарийхнаар цувуулан тавьтал, энэ хэн бэ гэж нүдээ том болгон, Плоскинийг агшин зуур хараад, шош тавьж, үргэлжлүүлэхийн хамт, Зэв ноён суу гэв.

Зэв, хивсэн дээр сууж, баатрын хийж байгаа зүйлийг төдий л хайхрамжгүйгээр нүдийг хажуу тийш болгон харна. Тэр бээр хавханд орж, хөлөө тас хазсан үнэг мэт хашир өгөн юү хийхийг тааварлан мэдэж огтхон ч чадсангүй болно.

Өндөр нуруутай, зузаан цээжтэй бөгөөд элэг рүү унжсан өргөн шаргал сахалтай, хэрмэл Плоскиний гэрийн дотоод байдлыг нүд

гүйлгэн харж, ямар нэгэн юм дотроо бодно. Тэр бээр үүдэнд хүндэтгэсэн байдлаар зогссоор байв. Зэвсэг бүхий хоёр монгол хүн, түүнийг манаж зогсоно.

Зэв, шош түргэн хөдөлгөж байгаа Сүвээдэйн гарыг барж, баригдагсдаас сонссоноо өгүүлэн, Плоскинийг газарч болгон хэрэглэхийг хэлэлцэв.

За, Хивчагийн хаад, одоо юу хийцгээж байна гэж Сүбээдэй таслан асуув.

Тэд бүгдээр айн сандарсан гэж Плоскиний хариулав. Танай Татарыг тэдний Шарукан хотод түргэлэн ирэхэд хивчагийн хаад, таран зуттаж, зарим нь Оросын хил, зарим нь намагт орсон болой.

Хэн Орост очсон бэ?

Тэдний тэргүүн баян Хотианаас эхлэн, далайн тохой хавийн хивчаг токсевичууд, бакуварсавууд, бастеевын үр садны зэрэг олон хүн зуттсан болой.

Сүбээдэй, шошоо орхиж, Плоскинийг нүд салгалгүй харж,

— Оросын цэрэг одоо хаана бий вэ? гэв.

— Үүнийг бурхнаас өөр хэн мэдэх вэ?

Сүвээдэйн үс нь арзайж, нүүр ам нь мурилзан уурсаж, нүд нь том боллоо. Тэр мэрэгдэн элэгдсэн хумстай матигар хуруугаар занган занав.

— Чи мэдэх бүхнээ хэлсүгэй. Мөрөө бүү балла. Харин би чамайг базан дор суулгаад, дээр нь 20 нөхөр суулгана. Чингэхэд чи оготно гүзээний дуу гаргаж үхнэ дээ.

— Би дуугай байх юу билээ.

— Оросын ноёд хаана вэ. Оросууд, дайнд бэлдэж байгаа эсэх. За хэлсүгэй.

— Плоскини бодох зав өг гээд, урт хөлөө алцайн зогсож өөд харав.

Сүбээдэй, хэрмэлийг сэжигтэй харцаар хоёр дахин хараад, хивсэн дээр шош нүүлгэж эхлэв. Дараагаар Сүбээдэй шивнэрүүн;

— Хээр талын хэрмэл чи сонс. Хэрэв чи хамаг бүхнийг учир бүрдүүлэн хэлбэл, чамайг шагнах болно. Нааш энэ шугам шошийг харсугай. Энэ бол Дон мөрөн, энэ урт шугам бол Днепр мөрөн... Нааш ойртон ирж, Оросуудын Киев хот хаана байгааг заасугай.

Плоскинийг нэг алхам урагшлахад монгол манаа хоёул түүнд ухасхийж, илдийг бүсний хамт салган авав. Чингэхэд тэр хэрмэл өвгөн,

болгоомжтойёо сөхрөн сууж, мөлхөн Сүбээдэйд ойртов.

— Сүбээдэй, духаа атируулан, үстэй малгайг дагзанд түлхэж, би ингэж ойлгож байна. Энэ бол манай Днепр... энэ бол Днепр мөрний адаг далайд орж байгаа нь болох ба энд Олшай бий. Эндэх энэ жижиг гол нь одоо бидний байгаа Калк гэж мэдэх хэрэгтэй... Харин хамгийн гэгээн тунгалаг та гагцхүү сонс, Днепр умраас өмнө зүг ийм эгц урсаж байгаа биш, харин булагнан тахирлаж урсдаг шүү дээ. Мөрний энд энэ Киев хот, нидэрханы тэнд хар далай бий. Тохойгоор тулж, талд Днепр дээрх Хортицын арал байгаа ба иймд Хортицын хавьд тохойн дэргэд орос цэрэг цугларч байгаа болно гээд Плоскиний шошийг хөдөлгөн, Днеприйг булан гарган, тахир болгов.

— Эндээс Киев хүртэл хэчнээн хэмжээний газар бий вэ гэж, Сүбээдэй асуув. Тэр бвээр хөхдэгээс шошийн хамт атга алтан зоос гаргаж, алган дээр сэгсрээд өөрийн хажууд тавив.

Плоскини, нүдээ гялалзуулан, хэлээр омголтой уруулыг долооно.

— Чи Киевээр яах гэв? Оросууд Киевээс явахгүй. Эндээс Киев хүртэл хол шүү дээ, зургаахан зуун мод.

— «Мод» гэдэг чинь юу вэ гэж Сүбээдэй уурсав. «Мод» гэдгийг би мэдэхгүй. Чи Киев хүртэл хэдэн морин өртөө болохыг над хэлсүгэй гэхэд нь

— хэрэв эндээс нэг мориор явбал даруй 12 хоног явж, хөтөлгөө морьтой явбал 6 хоног давхина.

— Чи одоо л надад мэдэгдэхээр ярьж байна.

— Харин Оросууд, Киевээс хээр талд шууд гардаггүй болно. Тэнд завиар «тохой» хүртэл, энэ булан хүртэл Хортицын арал хүртэл Диепрээр явна. Тэд эндээс өөр зүг эргэж «Залоз талбар» богино замаар далайн тохойд ирнэ. Энэ хооронд мориор сайн явбал бүгд гурав дөрвөн хоног явж, хөтөлгөө морьтой хоёр хоног явна.

Хоёр хоног явна гэнэ гэж Сүбээдэй гайхав. Оросууд Днепрээс нааш энэ хүртэл хоёр хоног явна гэж үү гэхэд нь манай Оросууд эндээс, энэ нугалаанаас Хортицаас нүүдэлчин хивчагийг довтолж байсан нь үлэмж шүү дээ. Хэрэв ачаа хөсөггүй явбал гурав хоног л явна.

Сүбээдэй өөртөө хэрэгтэй мэдээг олж аваад сэтгэл ханамжтай болсон бололтой. Тэр бээр өвдгөө алгаар дэлдэн инээж, айраг өг гэж тушаав. Тэр бээр зам, гол мөрний олом, Оросын цэргийн тухай ба тэд хэр зэрэг морьтой, цэргүүд нь ямар зэвсэгтэй, сайн байлддаг эсэхийг Плоскинээс асуув.

— Тэд ялангуяа, байлдааны сүх ба энгийн сүхээр зүгээргүй сайн байлдана.

— Энэ, Оросууд хэчнээн цэрэгтэй вэ. Хэрэв Киев, Чернигов, Смоленск, Галичийн зэрэг жижиг ноёд, бүх ойрын ноёд өөрсдийн цэргийг Хортицад ирүүлбэл, таван түмэн морьдтой явган цэрэг, мэргэн харваач нар, талаар таран хөдөлнө гэж монголчуудыг айлгахын тул Плоскини, Оросын цэргийн тоог зориуд нэмэгдүүлэн хэлэв. Үнэндээ тэдгээрийн тооноос нэлээд цөөхөн байжээ. Он дараалсан бичигт тодорхой тоо нь бий.

Сүбээдэй, Оросууд таван түмэн цэрэгтэй юм байжээ гээд талын довтолгоо эхлэх газар Днепр дээр Хортицад «нугалаа»-ны дэргэд таван алтан зоос тавив. Хивчагууд хэчнээн морин цэрэг гаргаж чадах вэ.

— Мөн л тавин мянган хүмүүс бараг цугларах биз ээ.

Сүбээдэй, Днеприйн энэ талд, арилшгүй бөөн хар үүл мэт хивчаг хуралдана гэж бас таван алтан зоос тавив.

Иймд бидний өөдөөс орос, хивчагийн арван түмэн цэрэг ирнэ гээд, дуугай сууж, хүйргэр Зэвийг харав. Бид, хар Ирчисээс хоресм цэрэгтэй явсныг Зэв ноён чи мэдэх биз ээ. Одоо бид «орчлонт ертөнцийг донслуулагч» Чингис хааны сайн шавь эсэхээ үзүүлнэ гэхэд нь, Плоскини, дөрвөн хөллөн зогсож, заримдаа алтан зоосыг, заримдаа бодол бодож байгаа монгол хаадыг харж, нүдэнд нь хорт санаа зэрэвхийн гэнэдүүлэн асуууруун:

— Татар цэргийн эрхэм жанжин чи, өөрийн татар байгаа тэр газарт алтан зоос хэдийг ч юунд эс тавив. Чи хэчнээн цэрэгтэйгээ тэмдэглэж үзүүлээч гэхэд нь Сүбээдэй матигар хуруудыг зангидан нударгалж, Плоскини нүүр дундуур өгөв.

— Манай татар цэрэг хэд болох нь энэ билээ. Орос хивчагийг миний хэрхэх нь энэ билээ гэж Сүбээдэй, догшин авираар өмнөө тавьсан арван алтан зоосыг хамж аваад, шоштой хүүдийдээ хийгээд, тэднийг өөрийн хэнхдэгт хийнэ. - Тараг адил иднэ гэлээ.

Плоскини гэдрэг ухрав.

— Чи миний үнэн хичээлтийн учир хааны хайр хишиг ямар нэгийг хүртээ.

Үгүй би мөнгийг хэнд ч өгдөггүй бөгөөд харин түүнийг надад хэн бүхэн авчирч өгдөг ба би түүнийг өөрийн ялагдашгүй эзэн Чингис хаанд явуулдаг болно. Гэвч чи шагнал олж хүртэж болно. Чамд хөвүүд бий юү?

— Тэнгэр ивээ. Дөрөв бий.

— Тэд хаана вэ. Хол уу?

— Донын олом дээр сууж бий.

— Тэдэнд би зуун морин цэрэг явуулж, тэднийг нэн түргэн нааш ирүүлнэ. Оросын талд тагнуулаар очиж, Оросын хэд хэчнээн цэрэг хаана байгааг үзээд ир гэж чи тэдэнд тушаасугай. Оросын жанжид юу бодож байгааг мэдээд даруй эгж ирж, бүгдийг над нарийн нягтаар хэлтүгэй. Чингэвэл, би чамайг, чиний хүүхдийг суллан тавьж, хүн бүрд атгаар алт, азаргаар адуу шагнана. Удах түдэх юү вэ. Элдвийг санаж бодох юу вэ.

Плоскини хөлөө алцайн чанга зогсож, гүнээ сүүрс алдаад, алдарт хаан, миний толгойг тас цавч, хөвүүдийг минь зүгээр орхитугай гэв. Сүбээдэй, сөөнгөтөн дугарч, зангидсан гараар хивсэн дээр цохив.

— Чи надтай ингэж ярих вий. Цэргүүд, миний хүндэт зочныг барсын гэрт аваачиж оруулаад, гурван манаа гаргасугай. Саклаб үүнийг хааны ёсоор зочлон авах тааллыг хангаж өгөх биз ээ гэхэд нь,

— Хөлийг туших уу. Ийм чоно зугтах шүү гэж цэрэг нь асуув.

— Үүнийг бат бэх төмөр гинжээр хүндлэхийг бүү март.

КИЕВТ ТҮГШҮҮРТЭЙ БОЛОВ

Та нар, эвдрэн хямарч, буруу номтныг Орос газар даллан ирүүлж эхлээд, эвдрэн хямарснаас болж хивчагт дарлуулдаг болсон биш үү. Орос газраа бодож, эрэмгий Святославич Игорийн шархыг өөрсдийн төлөө бодож, хурц сумаар уудам талын үүдийг хааж хамгаалагтун!

(«Игорийн цэргийн өгүүлэл»-ээс)

Киевийн харалдаа Днеприйн зүүн эргийн тэнд хивчаг гэнэт дайрч, салыг өглөөгүүр барьж аваад зочныг айлган сал дээр гарч, олон хүн суусан сал, ус утган хазайсан билээ. Хивчагийн өвгөн нүсэр хаан, бар цоохор мориор ирж зуугаад сайн эрс бараа бололцон нэг нь адууны сүүл, зэс хангинуураар чимсэн хааны туг барьж өмнө нь давхин, бас нэгэн хүн хэц дэлдэж, хоёр хүн, үлээгүүр үлээж, нэгэн сайн эр, зам гаргаж, хамар ам нь тачигнасан онгон морь унаж, ташууураар тас няс хийлгэж салын зүг давхиж билээ.

Чихэлдэн бөөгнөрсөн хүмүүсийн өмнө нуруундаа үүргэвчтэй, тоосонд бүрзийсэн туранхай бадарчны өгүүлэх нь: Одоо бүх хивчаг «зэрлэг тал» гэдэг хар тэнгисийн орчны талаас зугтан, хойноос нь

сахалгүй, мухар хамартай шулмын адил даахирсан гэзэгтэй татар хөөж явна гэнэ билээ. Тэнгэрийг үл шүтэгч Татаарын гагцхүү барааг харсан хүмүүс, ухаан алдан унадаг гэнэ билээ гэж ярьж эхлэв.

Буянтай бадарчин чи, учир ёс, ном судар мэдэх хүн мөн тул, Татар гэж ямар хүн байдгийг бидэнд хэлж өгнө үү гэж улс гуйж, бадарчин урт таягаа тулж зогсон өгүүлж эхэлрүүн;

— Манай улсад үзэгдэж сонсогдоогүй «Татар» гэдэг хорт улс, олноор дорно зүгээс ирж, тэдний хамт долоон хэлийн улс явж байгаа билээ. Кивчаг одоо хүртэл ойр тойрны улсыг эзлэн авч, сүйтгэн сөнөөж байснаа одоо тэдний өөрсдийн сөнөх цаг иржээ. Татар бол хивчагийг ялж хөөхөөр барахгүй, үр үндсийг нь баллаад газрыг нь эзлэх гэж яваа улс гэхэд нь,

— Тэр татар омгийн улс хаанаас гарч ирэв? гэхэд нь, Тэнгэрийн сударт тэдний тухай өгүүлснийг үзвэл: Грекийн хаан Македоны Александр, эрт урьд цагт буруу номт Гог Магог улсыг умар дорнын хооронд газрын зах Етрие цөлд үлдэн хөөсөн гэж ширээт лам Патарийн Методи бичсэн билээ. Македоны Александр тэр бээр Гог Магогийг уулсаар хааж, тогтсон хугацаа дуустал, тэнд суу гэж тушаажээ. Ширээт лам Методийн хэлснээр, тэр хугацаа дуусахад, хүрээлсэн уулс задран нээгдэж, Гог Магог улс гарч ирээд, дорноос Ефрат хүртэл, Тигрээс Понт тэнгис хүртэл, Этопиос бусад бүх газрыг эзэлнэ гэхэд нь,

— Бүх газар гэнэ? гэж сонсогч олон гайхаж, тийм бол манай газар нэгэн адил эзлэх нь ээ гэж.

Бадарчин үргэлжлэн өгүүлрүүн;

— Эргэн тойрон юу болж байгааг та нар үзэхгүй байна уу. Галав юүлэх шинж тэмдэг гарч байна. Аюулт одон гарч ирээд, сацраг нь дорно зүг нэлээд хол сацарсан нь христосын мөргөлтөнд шинэ хөнөөл учран, шинэ дайсан довтлохын тэмдэг. Гайхал Гог Магог, уулсын цаанаас гараад, бидэнд халдан ирэв. Болзсон цаг хугацаа болж, галав юүлэх цаг боллоо... гэхэд хүн сүүрсэн алдаж гаслах нь сонстов. Бадарчин эсгий малгайгаа аваад, сонсогчид, малгайд нь дүгрэг боов, жижиг хар зоос хийв.

Баруун эргээс Киевийн их ноёны цэрэг, давирхайгаар будсан завиар ирж, бөөгнөрсөн олон хүнийг хөөн тарааж, ачаа тээвэр нэвтрэх газар цэвэрлэн, хивчаг хааныг сал дээр гарч суухад туслав. Улаан торгон дээлтэй, булган дотортой, шовх оройтой улаан үнэгэн чихтэй

малгайтай, саа утсан сөөхий гуталтай хаан, «Сарвуутай» савхин бээлийтэй гараар хэрэсгэнээс атгаж, ихэмсгээр зогсож, нөгөө гараар алмаас эрдэнэ гялалзсан тахир сэлмийн бариулыг атган зогсож, бүдүүн сүрлэг хааны байдал, тайван бөгөөд, гагцхүү нүд нь Днеприйн хар ус руу гялайн, тогтворгүй гүйв. Чингэж байтал, салхи ширүүсэн, мөрний усан дээгүүр толбо мяралзаж, усны долгио хөөсрөн бумбаатав.

Хаан, их хишиг хүртээж, салч нар бүхий л хүчээр хичээнгүйлэн, атга атга цагаан мөнгө хүртлээ. Хатгамал нэмнээтэй бөгөөд тэмээнээс айн үрэгдэг шилдэг хүлэг морь, далаа хүрсэн урт эвэртэй, усны үхэр, эрэг дээр хувцсаа сольж өмсөн, өлбөнх бүчээр чимсэн бор царайтай, хар хөмсөгтэй гадаадын олзлогдсон хүүхнийг зөөж, өдөржин ноцолдов. Тэр их юм цөм Киевийн их ноён, Оросын бусад ноёдод хүргэж байтаа бэлэг байжээ.

Улс, хивчагийн хамгийн ахмад их хаан Хотион ирлээ. Тэр хаан, «зэрлэг тал»-аар дүүрсэн, хоёр зурлаа ширээтэй саран тамгатай үй түмэн адуун сүргийн эзэн гэж цугларсан хүн ярилцаж билээ.

Хотион, талын эзэн эр! Тэр ганцаар нэн их цэрэг гаргаж чадах хүн. Тэр, Киевт дэмий ирсэн хэрэг биш лав нэг хэрэгтэй ирсэн биз ээ. Хивчагийн бусад хаан, өөрсдийн бүх омгийн хамт Оросын нутаг зүтгэж, Днеприйн бүх олом, түр гүүрээр гарч, хивчаг цэрэг хуягласан морио унаж, жад бамбайгаа барьсаар усаар гаталж байна гэнэ билээ. Юу болох гэж байгаа юм бэ. Бидэнд хор санаж байгаа юм биш биз? Хивчагууд баясгалант дуугаа дуулахаа зогсож, манай тийш ирж явахдаа тэмээний буйлах адил гунигт урт аялгуу сонстох болов гэж улс хэлэлцэж билээ.

Киевийн их ноён Мстислав Романовичийн ордонд хуралдан цуглах их бага ноёдыг хүлээн сандарч байв. Оросын газар усыг хамгаалаар уриалж, тэд бүгдэд хөтөлгөө морьтой элч явуулсан байжээ.

Нэрт зочныг хүндэтгэн зочлох нь хялбар хэрэг бус бөгөөд ноён бүр, цэргийн хамт ирсэн тул, хэдий чинээ дээд ноён ахул, төдий чинээ олон дагуултай байв. Их ноёны түшмэд, Киевийн бүх талхчин, яргачнаар идээтэй боорцог, улаан буудайн талх бариулан, ноёны ордонд авчруулж байв. Киевийн ноёны хүч нь зуун жилийн урьд Мономахын үе дэхтэй адил биш. Тэр дээр үед Киевийн их ноёны эрх мэдэлд Киев, Смоленск, Суздал, Ростов, Переяславль, алс холын баялаг Новгород зэрэг Оросын бараг бүх газар нутаг харьяалагдаж, бүх ноёд захирагдаж байхад хивчагууд, гар хөдөлж чадахгүй, зах хилээр

Оросын нэр сүр дэлгэрсэн билээ. Хэдэн жил болсны дараагаар Мономах улс бутран сарниж, ноён, хот хошууг өөрийн хөвүүд, ач үрдээ хуваарилан өгсөнд Мстислав Романович, тономол бөгөөд буурай Киевийг эзэмшиж байсан билээ. Сүүлийн 25 жилд Оросын ноёдын уулга дээрэм нь Киевийн хүчийг барсан учир, Галич, Владимир Суздалийнхэн, айл зэргэлдээгийн ёс мэдэхгүй ноёдын уршгаар зэрлэг хивчаг, эртний нийслэл Киевийг дээрэмдэн шатаасан билээ. Тэр бүх гайгаар Киевийн улс буурч, өчүүхэн бага улсын зэрэгт орсон билээ.

Тэр олон удаагийн аюул сүйдлийн дараа Киевийн ард гүйцэд тэнхэрч чадсангүй, цонх, хаалга нь эвдрэн хэмхэрсэн байшин нэн олон байсан ажгуу.

Одоо, хээр талаас аюул дахин босож, аль үлэмж орлоготой хот, их хошууны төлөө насан турш өөр хоорондоо тэмцэлдэн, омогтой бардам ноёд арга буюу нэгдээд, хуучин дайсан хивчаг тусламж гуйж Киевт өөрсдөө ирээд гуньхарч, толгойгоо унжуулан, их ноёны ордны хаалганы өмнө бөөгнөрөн явган суув. Оросын ноёдыг ирэхэд хивчагууд гүйлдэн очиж, морины цулбуураас адис авч, гар сунгаж, гуйн өгүүлрүүн:

— Цэрэг байгуулж, манай нутагт очиж, биднийг хамгаалж, хорт дайсныг хөөн зайлуулахад тусална уу гэж билээ.

Ноёд тус бүр бараа бологчдын хамт их ноёны хашаанд цугларан, тус тустаа зогсож маргаад, заримдаа хааны юу ярилцаж байгааг сонсохоор ийш тийш явж, Киевийн түшмэдийг гуйвч их ноёны өргөөнд үл бараалхав.

Хивчагийн хаан Хотиан, ердийн бардам байдлаар хашаанд нэгэн адил зогсож байв. Дэргэд нь талын нар салхинд царай нь харласан шовгор юүдэн малгайтай түүний зөвлөх нар элгээ тэвэрч хүүрнэлцэн хөдлөлгүй зогсоцгоож байв. Хэрмэл өвгөн хэлмэрч, олон ноёдоос хэн ирснийг нэр усаар нь хэлж, тэр тэр, их нөлөөтэй хүчирхэг ноён гэж хаанд тайлбарлав. Хотиан, хүндэтгэвэл зохих ноёныг сонгон дэргэд нь очиж сөгдөөд, хуруугаа арайхийж газар хүргэж ёслоод, хагас бууралтсан хар сахлыг илбэн тогтмол үгээр,

— Тусламж үзүүлж өршөө! Бид бүхэн сөнөх аюулд тохиолдож байна. Хүч нийлж, сөнөх аюулыг зайлуулъя. Өчүүхэн бага бэлэглэлийг чамлалгүй, миний хүндэтгэсэн сэтгэлийг бодно уу. Би хэнийг ч марталгүй, морь мал, олзлогдсон хүүхнээр бүгдэд бэлэг барихыг хүснэ гэдэг байж.

Нар үд болох ойртсон боловч, ноёд их ноёны шуугиант хашаанд хоолойгоо сөөтөл арцан зөрөлдсөөр, Киевийн их ноёны өргөөнд хэн түрүүлэн орохыг бүгдээр харцгаав. Мстислав нэгэн хүнийг хүлээж байгаа ба Владимирт цуглахаар тэндээ хүлээж байгаа Суздалын ихэмсэг засаг ноён Юри Всеволодовичийн элчид умар зүгээс ирэхийг хүлээж байгаа биш болов уу. Хомсдон доройтсон Киевт ноёдын зөвлөгөөнд очихгүй биз ээ гэлцэв. Галичийн бүтэмжит ноён Мстислав, элч довтолгож зайлшгүй аюул тулгараад байна. Чуулганд түргэлэн ирнэ үү гэж бүгдийг уриалан зарласан мөртөө өөрөө эс үзэгдэв гэж байтал, бүгдээр нэгэн зэрэг хөдлөн, бүтэмжит Мстислав ирлээ гэж тохойгоор бие биеийг түлхэн, унгар, польш нарыг бүтэмжтэй аян довтолгоогоор ялж дийлж алдаршсан тэр ноёныг харах гэж сонирхвол, бүтэмжит Мстислав, нас өвгөн болж байгаа боловч, хөнгөн гавшгайгаар алхан орж ирээд, нэг хүн эрж байгаа юм шигээр цугларагсдыг сэргэлэн хар нүдээр хараад, унжсан урт сахлаа удтал имрэв. Тэр бээр, байлдаанд бэлхэн бөгөөд наранд гялалзагч алтан шармал дуулга, алтан тоногтой хөнгөн хөө хуяг өмсөж ширүүн явахад нь улаан нөмрөг нь намирч, Хотиан хааныг хашааны буланд байхыг хараад, түүний зүг очтол, хаан, гараа сунган, Мстиславын өөдөөс түргэлэн алхаж, мөрөө тулган, Галичийн ноёны цээжинд толгой бөхөсхийв. Хотианы цагаан юүдэн малгай тоосонд унаж, хивчаг хааны мөр чичрэхийг бүгдээр харав.

— Уйлж байна. Уйлаг гэж цугларсан хүн шивнэлдэн, хорт хивчаг, манай хэчнээн хүнийг зовоож өнчрүүлсэн билээ. Одоо өнчин өрөөсний гашуун нулимс ямар байдаг гэгчийг өөрсдөө эдэлж мэдтүгэй. Мстислав бол Хотиан хааны хүүхэнтэй ханьцан суугаад, баян хадмын төлөө чармайж байгаа биз хэмээлдэв. Цэрэг, бүтэмжит Мстислав ирснийг Киевийн ноёнд мэдэгдэвч Мстислав Романович, төрсөн дүүтэйгээ уулзаар байшингийн довжоон дээр гарахгүй, хуучин өшөө хорсол санаж байв. Мстислав, харин Хотианыг тэврэн авч түүний хамт хашааны буланд очоод, удтал зогсож, чимээгүй ярилцсан билээ.

Бүгдээр дахин хөдөлж, өндөр дуугаар,

— Суздалынхан ирэв. Их л сайхан дэмжлэг тусламж болох нь дээ. Бид, Суздалынхангүй бол, хаашаа ч хөдөлж үл чадна. Үгүй Суздалынхан биш, Ростовын залуу ноён Василко Константинович даг аа гэлцтэл өвч зэвсэгт залуу цэрэг орж ирээд, эргүүнд нь донгын шар үс цухуйж, Галичийн Мстиславын нэгэн адил зэхэж хөө хуяг, дуулга

өмсөж, бүсэндээ урт шулуун илд агсаж, хувцас төдий л гангангүй, гандсан улаан өнгөт нөмрөгтэй, булигааран чархи гуталтай, хөх ёргоор хөлийн булчин шилбийг ороож, гадуур нь өвдгөө хүртэл сураар ороосон байв. Бүх хувцас нь тоос шавар болж, мориноос сая буусан байдалтай, хөм оосортой чин хуур мөрөндөө зүүсэн, бууралтан мөр лүү нь унжсан үстэй өвгөн дагалцаж явав. Улс түүнийг сохор дуучин, алдарт Ратибор мөн ажээ. Урьд жанжин явж, хивчагийг олон удаа дарж байсанд, Рязаны ноён Глеб хорсон ядаж, торонд хийгээд, нүдийг сохолж, гурван жил хорьсон билээ. Ратибор шоронд зовж байхдаа дуу зохиож, шоронгоос гараад хот дамжин хэсүүчлэн явж, өвгөрсөн үеийн байдал, зовлон зэргийг дуулдаг болжээ. Өнөөдөр Ратибор дуулахыг бид сонсох нь ээ гэж хэлэлцэв.

Залуу ноён Василко баяртайгаар инээмсэглэн, бүгдийг тойрч, ахмад ноёдыг хүндэтгэн очив. Ноёд өөрсдөө түүнийг угтан очиж асууруун:

— Суздалынхан ирэхгүй яалаа. Чи тэдэнтэй айл зэргэлдээ биз ээ. Яагаад тэд эс ирснийг чи мэдэв үү. Суздалын агуу их ноён, чиний төрсөн авга ах, түүнийг чи ятгав уу?

— Ирэх болов уу. Энэ тухай мэдвэл зохигчид, юм хэлэхгүй байна гэж бүгд бодно.

Хуяг дуулга өмсөж, богино жад барьсан сонгомол арван цэрэг, хоёр хоёроор ноёны ордны довжоон дээр гарч ирэв. Тэд шатны гишгүүрүүдээр бууж, шатны хоёр талд Мстислав Романовичийг хүлээн зогсов. Тэр, алтан шармал бүргэдтэй таягаа тулсаар аажимхан гарч ирлээ. Түүний босоо хөмсөгтэй, хянуур нүд баяргүй бөгөөд алжаасан байдалтайгаар харж байна. Түүний үелэн ургасан буурал сахал, цээжинд байгаа загалмай, алтан гуу, хоргой дахам ба ноёнтон, гуутай бурхны дүрстэй харагдах нь цэрэг дайны явдлын төлөө санаачилга тавьснаас сүмд шөнийн хурал, мөргөлд суусан нь үлэмж болохыг гэрчилнэ. Ноён бага зэрэг доголон, шатаар буугаад, шатны эцсийн гишгүүр дээр зогсов.

Эрхэм хүндэт зочдоос нигүүлсэл өршөөлийг гуйна гэж тэр санаачилгад нэрвэгдсэн мэт гуньхралын дуугаар өгүүлэв.

Хашаан доторх бүх ноёд, нэгэн зэрэг шуугилдан өндөр дуугаар хэлрүүн:

— Биднийг дуудсаны хэрэг юү вэ. Зэрлэг половуудыг аврахын тул буюу. Тэд хэн нэгэнд дарагдвал дарагдтугай. Тэдгүй бол амрах билээ.

Тэд өөрийгөө аврах биз ээ. Бид харж байя.

Назгай хаан Хотиан, цугларсан хүмүүсийн дотроос тасран гарч, майга хөл нь бүдчин, довжооны зүг яаравчлан явав. Гараар газар шүргэж, ноёны алтан гэгээтэй хувцсанд шүргээд, хахаж цацан өгүүлрүүн,

— Бурхан эцэг чамд сөгдөнө. Урьд чи надад, мөн би чамд найртай байж билээ. Бидний эцгийн минь оронд эцэг бол. Чингис хааны хорт улсыг хөөн зайлуулахад тусал. Татар гэдэг эдгээр хортон, манай газар нутгаар чоно шиг давхилдаж байна. Өнөөдөр манай бүх газар шороог булаан аваад, маргааш танай газар ирж, Оросын газар нутгийг авна. Биднийг хамгаал. Бидэнд туслахгүй ахул өнөөдөр бид бүгдийн толгойг авч, маргааш орос ба бүгдийн толгойг авна. Бид бүгд нэгдэж, цэргийн хамтарсан хүчнээр хамгаалах хэрэгтэй болжээ.

— Бүү гуагла. Юугаа орооцолдном гэх тааламжгүй дуунууд сонстоно. Чимээгүй бай. Ярья. Замгүй хуцах юу вэ? гэж татгалзаж, бусдаас хэлсэн нь: Кивчагууд бол манай дайснууд мөн. Одоо тэд манай нутагт арга чадалгүй болжээ. Бүгдийг алаад баялгийг хураан авбал болно.

Шинэ дуу чимээнүүд, бие биетэй цохицолдон хамжааргагүй шуугианд нийлэв. Киевийн ноён арга тасран харж, гараа өргөв. Дуу чимээ улам ихдэв.

Шийдвэрлэг түргэн ноён бүтэмжит Мстислав, довжооны гишгүүр дээр гарав.

— Үнэн алдартын мөргөлтөн ноёд, шударга жанжин нар, Оросын бүх бүтэмжит хүмүүс гэж Мстислав өгүүлэв. Бид, бүгдээр Оросын ариун орны хөвүүд мөн би зээ. Хивчагтай урьд маргалдаан, дайн хийж байсан зэргийг умартъя. Бид тэднийг зодож, олзолж байсан. Тэд ч биднийг галдан шатааж, эвдэж сүйтгэж байсан билээ. Хивчаг, бид хоёрт нэгэн адил хүнд цаг тохиолдож байна. Урьд үл таних шинэ дайсан довтолж байгаа одоо үед хивчагтай байлдахаас найрамдах нь дээр юм. Хэрэв бид, хивчагаас Чингис хааны шашингүй Татарыг эсэргүүцэхэд туслахгүй ахул тэдэнд шилжиж, дайсны хүч улам их болж болно.

— Татаарууд гэдэг чинь ямар хүмүүс вэ? Хивчагаас дээр ангийн цэрэг байж болно. Тэд хэчнээн хэр юм бэ?

— Хотиан хаан, Аланы хамт тэднийг эсэргүүцэн байлджээ. Хоорондоо найрамдалтай довтолж, бэрхтэй сүрхий дайрч байлддаг

гэнэ. Тэд Оберз төмөр хаалганы цаана алс холоос ирсэн ганцхан хивчаг, Татарыг тогтоон зогсоож хүч хүрсэнгүй. Татар хивчагийн хамаг юмыг дээрэмдэн Хотиан ба мөн хивчагийн бус жанжны гэргий, адуу, мал, бүх баялгийг олзлон авчээ. Одоо Татаарууд, аргалах, агуулах газаргүй болтлоо олзлоод, зовлогод зоолсон нохой шиг болтол гудраад, баялаг эд уурс, агуулах газрыг Хазаар тэнгисийн эргийн тохойд байгуулжээ. Чингээд, ачаа тээвэргүй хөнгөнөөр Орос нутагт орж ирээр хөдөлжээ.

Хэрэв хүн намайг орос нутгийн төлөө зүтгэж байгаа биш, харин өөрийн хүргэн ядуу ноён Хотианы төлөө зүтгэж байгаа гэвэл цөм худал болно гэв.

Сайн нэр алдаршсан их ван Мстиславын үгийг цугларсан олон хүн амьсгалаа хурааж сонсов.

Цугларагсдын дотроос зарим нэгийг хэлэх нь:

— Хазаар тэнгисийн эрэг хүртэл хорь хоног явж хүрэх хол газар шүү.

Бас нэгэн хүний хэлэх нь:

— Эдгээр шургалж ирсэн зочидтой хамгийн түрүүнд бид учрахгүй, харин Киевийн ван, урьдаар тохиолдох тул, хичээвэл зохино.

Ийнхүү ван ноёдын хооронд янаг дотнын нэгдэл, нэг чиглэлийн зориг байхгүй, тэднийг эртний хорсгол, хуучны өшөө завсардуулж байгааг цугларсан олон мэдэж, эмх замхгүй үг ярилцан байна.

Гэтэл дуулах сонстоно. Хилэгнэн маргаж байгаа ноёдын уурыг намдаахын тул хоргой, саагаар чимэглэсэн хэсэг лам нар зохих цагт хүрч ирэв. Өргөн цээжтэй, дөрвөн донир сангийн бойпор барьжээ. Хэдэн шавь нар бүдүүн лааг ноцоогоод барьсан ба бас хэдэн өвгөн гэлэн төмөр загалмайг гартаа барьж тэдний хойноос том алтан овоодойтой жинхэнэ даа ламын үүргийг хүлээсэн хар сахалтай грек лам, хоёр шавийг түшиж явна. Эд, сонжуу аялгуугаар ном уншсаар саравчны өмнө ирээд, гэнэт чимээгүй болж зогсов.

Киевийн ван, даа ламын өмнө алгаа хавсарч мэхийн зогсоод, ламын салганасан гараас адис авч шивнэн хэлсэн нь:

— Гэгээн лам минь, алтан сургаалаа айлдаж хайрла. Олон ноёд, урьдын хэрүүл баруулаа орхиж, эвтэй найрамдалтай бай гэж сургаж хайрла гэвэл, их даа лам тавцан дээр гарч гурван этгээдэд ээлжлэн хандаж, ном номлох байдлаар цээжилсэн хэдэн үгийг орос хэлээр халти мөлт өгүүлэх нь:

— Дүү нар минь, хайрт хүүхэд минь ээ. Евангелид бичигдсэн тэнгэрийн зарлигийн ёсоор буянт үйлийг үйлдэж сурагтун. Тэнгэрт залбирч, буянт үйлд шамдагтун. Хэлээ богинотгож, сэтгэлээ номготгож, биеэ доромжилж, хилэнгээ дарж явагтун гэв.

Киевийн ван, толгойгоо гудайлгаж, номхон зогсоно. Галичийн ван Мстислав сэтгэлээ түгшиж, харвал ноёдын ханамжгүй нүүр ба ангайсан амнууд үзэгдэнэ. Бас даа ламын үргэлжлэн айлдах нь:

— Та нар ямар нэгэн юмаа алдвал өшөөг нэхэх хэрэггүй. Хэрэв жишигдэх хөөгдөх болбол, хүлцэж бай. Хэрэв доромжлогдвол, залбир. Наманчлал нулимс өршөөл гурван буянт үйлээр дайсныг ялдаг гэж тэнгэр заасан бүлгээ... гэвэл, Мстислав ван, дөрвөн донирын дэргэд очиж болгоомжтойгоор шивнэн өгүүлрүүн;

— Энэ өвгөн Грекийн ухаан солиорчээ. Бүгдийг хутгачхав. Наманчлал нулимсны тухай хэнд юу хэлж байгаа юм бэ. Одоо харц доордод үг хэлж байгаа биш, ван ноёдод үг хэлж байна шүү. Бушуухан ямар нэгэн магтаал ерөөлийн шүлэг уншаад өгөөч, хүн бүрд хонь өгье гэхэд өвгөн даа лам хэвээр шулганаж байтал, дөрвөн донир магтаалын шүлгийг өндөр дуугаар огцомхон эхэлбэл бүх гэлэн ба шавь нар нарийн хоолойгоор дагалдан уншив. Вангийн хиа нар, гайхсан өвгөн ламыг хүрээлж түшиглэн, ноёны ордонд оруулав. Шатны дээд гишгүүрт Ростовын залуу ван Василко авирч гараад өгүүлрүүн:

— Би алс хойноос, их Ростовоос яаравчлан ирэв. Оросын газар ус ба үнэн шашинтны төлөө, та бүхэнд үг хэлье. Киевийн ван Мстислав яаралтай элч бидэнд ирж, орос нутгийг хамгаалахын төлөө цэргийг хурдан байгуулъя гэсэн билээ.

Би цөөн дорд шадар цэргийг дагуулж ирэв. Гэтэл, бидний дотроос хамгийн хүчтэй болох Суздалын ван Юрий, Татар нар Суздалд ирэх нь үү. Эсхүл тойрч гарах нь уу гэж мэргэлсээр зүгээр сууж байна. Бас энд хүн бүр амь амиа бодох чанартай үгнүүдийг сонсов. Гэгээн лам гуай, энд дайны байдалд тохирохгүй, харин үхэхийг завдаж байгаа өвгөний гэрээс мэт наманчлал ба нүглийг дурдсан дэмий үг хэлэв. Номхон хүлцэнгүй байдлаар дайсныг буцааж чадахгүй, орон нутгийг хамгаалж ч чадахгүй гэж хэлбэл олон хүн:

— Василко зөв үг хэлж байна гэж шуугилдав.

Нэг ноёны хэлсэн нь:

— Танигдаагүй холын хорт улс, түргэн нүүдэллэн ирж айсуй. Эдгээр дайрч ирсэн зочидтой чангаар уулзаж, бүрмөсөн мохоох

хэрэгтэй. Татар нарт далавч байхгүй тул, Днепр мөрөн дээгүүр нисэж гарах уу, нисээд гаравч, бид тэднийг шигтгүүлж чадна. Тэр цагт юу болохыг бурхан үзэг.

Бас нэг вангийн хэлсэн нь:

— Тэдэнтэй илд сүхний ирээр уулзъя гэвэл, Васялко үргэлжлэн өгүүлрүүн:

— Манай толгойлсон вангууд, Мстислав Романович вангийн ордонд орж, хуучин ёсоор нэгэн хивс дээр хүрээлэн сууж, зөвлөн хэлэлцтүгэй.

Жигшүүрт дайсны өмнө нулимсаа гоожуулаад, гэмээ наманчлаад байх уу. Эсхүл эрт өвгөдийн үлдээсэн саран сүх ба хурц илдийн ирээр бэлэглэх үү. Чухам яахыг вангууд хамтран хэлэлцэж мэдье гэвэл, нэгэн хүн өгүүлрүүн:

— Василко вангийн хэлдэг зүйтэй гэв. Бас:

— Тэр зүйтэй. Тэр зүйтэй гэж зүг бүрээс хашхиралдав.

Хэн толгойлох юм бэ. Хэн их цэргийг тэргүүлэх юм гэж нэг хүн өгүүлбэл нөгөө этгээдээс нэгэн ноёны хашхирах нь:

— Би Мстислав Романовичийн гар дор яасан ч явахгүй гэвэл, бас нэг талаас хашхирах нь:

— Байлдааныг Галичийн ван Мстислав удирдаг. Түүнд аз завшаан тохиолддог тул, түүний нэр «бүтэмжит» гэж алдаршсан билээ.

Чухам хэрхэхийг хэлэлцэн тогтохоор Киевийн вангийн ордонд хорин гурван ван орж суув. Тэд удтал бодоцгоосон боловч, хэлэлцэж ер тохирсонгүй. Галичийн ван бүтэмжит Мстислав: Татаруудыг далайн буланд байхад нь дайрч ороод, эд таваарыг булааж, ноёд байтугай, дорд ардыг баяжтал хувааж авъя гэж хэлнэ. Энэ далайн булан хүртэл цөмрөн довтлох санаа олон вангийн сэтгэлд нийлэлцсэн боловч, нэгэн жанжныг томилох болоход тохирч чадсангүй. Ингэж байтал нэг хайгуулын хүний хүрч ирж;

«Гаж буруу Татар нар, Днепр мөрөнд бөөнөөр ойртож явна» гэв.

Энэ мэдээг сонсоцгоогоод, Днепр мөрний Хортиц арлын дээгүүр нэвтэрч, Татарыг эсэргүүцье гэх түргэн шийдвэрийг гаргав. Үүн дээр олон ван, тус бүр өөрийн цэргийг авч, тус тустаа явж, харилцан бие биеийн замыг бөглөхгүй гэдэг нэгэн шийдвэрийг бүгдээр зөвшөөрөв. Ямар азтай ноён, урьдаар далайн буланг хүрээд Татаарын цэргийн хүрээг эзлэн авбал, олзыг ноёд бүхэнд тэгш хуваахаар тогтов.

Бүгдээр загалмайгаас адис авч, ямар нэгэн ван, нөгөө ванг эсэргүүцэн хөдлөх бол, түүнийг бүгдээр буруушаана гэж андгайлав. Тэндээс олон вангууд харилцан бие биеийгээ үнсэлцэв. Гагцхүү Киевийн Мстислав, Галичийн Мстислав хоёр ван, уруулаар үнсэлцэх гэтэл шил шилээрээ уулзав. Тэндээс олон вангууд, хивс дээрээс боссон ба Василко ван, элдэв юмыг бодож, царайгаа барайлган байна. Тэр баргар царайгаар гарч ирэхэд, түүнийг гадна хуучин дууч Ратибор хүлээн байв. Василко ван өгүүлрүүн:

— Бидний хэрэг бүтэхгүй. Ингэж байлдаж болохгүй. Бид, Татаарын юмыг олзлохыг хүсэхгүй. Харин дайсны гарыг салганах ч чадалгүй болтол нь цохих хэрэгтэй. Хүн бүр зүг зүг тийшээ харж, эмхгүй хөдөлбөл, өөрсдөдөө зовлонг урьсан хэрэг болно гэв.

* * *

Дулаахан үдэш болов. Вангийн ордны дээгүүр гэрэлт одон гийж байна. Хашаан дотор хоол идэхэд зориулан хийсэн урт царсан ширээ байна. Ирсэн зочид, царсан сандал дээгүүр сууж, хуушуур, шарсан хунгийн махыг идэж, нам жим болов. Ноёдын дагалт нар гэрэлт бамбарыг барьж тойрон зогсоно. Улаан дээл өмсөж, саравчны үүдэнд сууж байгаа дууч Ратибор, бамбарын чичирсэн гэрэлд харагдав.

Хуурын эелдэг хөгт нийлүүлж, өвгөн дууч Ратибор, улбар нүдээ дээш мэлмэрүүлж, өчүүхэн чичрэнгүй хоолойгоор өөрийн дуртай домгийг хуурдан дуулав.

Оросын Игорь ван, хивчагтай байлдаар мордож, ноёд, завсраа хэрүүл маргаан ихтэй учраас Оросын зоригт цэрэг дэмий үрэгдээд, тэр завсрын хэрүүл нь орос нутгийн хаалгыг нээхэд хүргэсэн зэргийн эртний баатарлаг дууллыг уянгалан эгшиглэв.

Сонсогчдын нэлээд нь толгойгоо унжуулж, гараар шанааг тулж бодсон нь: Мөн тийм аюултай цаг одоо ирсэн биш үү. Одоогийн ноёдын эв нэгдэлгүй байдал нь их Оросын хэрэг. Төрсөн нутгийг хамгаалах их ажлыг завхруулахад хүргэх биш үү гэх зэргээр эргэлзэн бодож байна.

Сүбээдэй, мянганы арван ноёныг дуудав. Зэв бас арван мянгатныг авчрав. Өвгөн, залуу бүгдээр нэгэн гэрт суув. Зэв, алсад нэгэн юм харсан мэт өлийж байна.

Зэв өгүүлрүүн;

— Киев баялаг хот юм даа. Мөргөлийн сүм нь өндөр бөмбөгөр оройтой ба шижир алтаар өнгөлжээ. Бид тэр алтыг хуучиж аваад, Чингис хааны майхны дэргэд, Чингис хааны цагаан морины чинээ цул алтан морийг цутгаж хийгээд тавья гэвэл,

— Чингис хаанд, алтан морь аваачиж өргөе гэж монголчууд хашхиралдав. Тэдний нэг нь өгүүлрүүн:

— Орост олон хаан бий. Эднийг хуньс гэж өөрсдөө нэрэлдэг. Эдгээр хуньсууд, хоорондоо эвгүй, харийн ноход мэт харилцан тэмцэлдэнэ. Иймийн тул, эднийг бут цохиход төвөггүй. Тэдэнд Чингис хаан мэт хүн гарсангүй тул, тэр хуньсыг хэн ч нэгэн хашаанд оруулсангүй гэвэл, нөгөө монгол өгүүлрүүн:

— Манай их Чингис хаан мэт, удирдагч жанжин дэлхий дээр ондоо байхгүй гэнэ.

Зэв өгүүлрүүн;

— Бид энэхэн самбаанд орос нутгийг хурдан довтолж, зүг бүрээс нь шатааж, Киевийг авах хэрэгтэй гэвэл, мянганы ноёд асууруун:

— Яагаад энэхэн самбаанд гэж байгаа вэ.

Зэв өгүүлрүүн:

— Их хаанд хүргэсэн мэдээний хариу ирэхийн өмнө энэхэн самбаанд гэж байна. Монголчууд өгүүлрүүн:

— Чингис хаан, Киевийг авахыг хүлээж бай гэж тушаана. Чингис хаан, өөрөө анх Киевт орохыг хүсэх биз. Бид Бухар, Самарканд, Гурганж зэрэг том хотыг авч үзсэн тул, Киевийг эзлэхэд бэрхгүй. Бид Киевийг хурдан авах хэрэгтэй хэмээлцэнэ.

Бүгдээр Сүбээдэй баатрыг харж, энэ заль болгоомж бүрдсэн «барсын элэгдсэн хумс» юу гэж хэлэх бол гэж хүлээнэ. Сүбээдэй, ташаалдан мэхийж суугаад, хүн бүхнийг хурц нүдээрээ хатгах мэтээр ажиглаж байна.

Мянганы ноён Гимбэг өгүүлрүүн:

— Зэв ноёны хэлдэгтэй адил Оросыг дийлэх тийм хялбар хэрэг биш. Орос хивчаг хоёр нийлж, бум хүрнэ. Манайхан цөөхөн, дөнгөж хоёр түм. Түүний нэг түмэн цэрэг нь элдэв тэнэмэл зайгуул хүмүүс билээ. Хэрэв бид ухрахад хүрвэл, тэд сүрэг болжмор шиг бутран зугтах

нь магадгүй. Олон түмэн хүчирхэг цэрэгтэй Орос оронд нэвтрэн орох гэдэг аюултай хэрэг мөн билээ. Иймийн тул Киевт орох хэрэггүй. Эндээс буцаж, хүчит Чингис хааны эрхийн дор очиж орвол зохино гэвэл, Зэв өгүүлрүүн:

— Бид Хятадын их хэрмийн цаана нэвтэрч, задгай талд ороход, Хятадын цэрэг, Оросоос олон байсныг санаж байна уу.

Сүбээдэй баатрыг гараа зангахад, олон цөм дуугай болж, түүний үгийг сонсохыг хүлээв.

Сүбээдэй өгүүлрүүн;

— Хэргийг эхлэхэд Чингис хаан, урьд яаж байсныг санах хэрэгтэй. (Сүбээдэй дуугаа нам болгож, үргэлжлэн хэлэв). Хэрэв бидний оронд Чингис хаан байсан бол яах бол гэдгийг бодох хэрэгтэй. Анх залийг хэрэглэвэл зохино. Эхлээд үсийг илбэж байгаад, нүдээ анивалзуулан хумсаа тэнийлгэж, нуруугаар хэвтэхэд, сая хөдөлж, түүнийг багалзуурдан авах хэрэгтэй гэвэл, сонсогчид цөм толгой өргөж, бие биеэ харцгаагаад, их хааны гарын дор очихоор даруй буцахгүй. Нэгэнт эхэлсэн хэргийг дуусгах хэрэгтэй болсныг ухаж мэдэв. Сүбээдэй цааш өгүүлрүүн:

— Оросууд олон. Эд их хүчтэй. Иймийн тул эдэнд зам дээр унтаж байгаа царцаахайг тэмээ яаж ажиггүй гишгэдгийн адил биднийг сөнөөх чадал байна. Гэтэл, Орост эмх байхгүй. Эдний хуньсууд хоорондоо ямагт маргалдана. Тэдний цэрэг талд зүг бүр дураар бэлчиж яваа хүчит шар үхрийн адил байна. Гэвч Орост, бас өөрсдийн Зэв ноён байна. Энэ нь Мстислав баатар мөн. Мстислав баатар олон удаа байлдсан боловч, одоо болтол ялагдаж үзээгүй гэнэ.

Мстислав баатрыг аюултай газар цөмрөн ороход түүнийг тэтгэж, арчилж авдаг Сүбээдэй баатар мэт хүн Орост байхгүй ажгуу гэвэл, монголчууд өгүүлрүүн:

— Бид тэр Мстиславыг барьж аваад, Чингис хаандаа аваачиж өгнө.

Сүбээдэй баатар, нэмж өгүүлрүүн:

— Мстиславыг хэн урьдаар барьж, алтан дуулгыг хуулсан хүн, түүнийг Чингис хаанд биеэр хүргэх болно гэдгийг одоогоос батлан мэдэгдье гэв.

Удтал зөвлөлдөн, манааны цэрэгт сонсгохгүйн тул шивнэлдэн хэлэлцэв. Мянганы ноён Гимбэг буцаж, Чингис хаанд очихоор санал

гаргасны зэмлэлд даруй манлайд явах зуун цэргийн бага дарга болгож, хайгуул болгон мордуулав.

Түүний маргааш Зэв ноён, түмэн цэргээ авч, баруун зүг байлдаар одсон ба Сүбээдэй баатар морьдоо таргалуулж байгаад, эцсийг бүрмөсөн таслан цохихоор бодож Калк голын эрэг дээр үлдэв.

МОНГОЛ ЦЭРЭГ ДНЕПР МӨРНИЙ ЭРЭГТ ХҮРЭВ

Тэр жил их л дулаан хавар болж, хуурай салхи олон хоног салхилав. Хөх ногоо гандаж, наран Тэнгэрээс цоргилж шатааж байх нь бүгдийг шахан хөөж байгаа Сүвээдэйн нүдний адил байв.

Зэв ноён, цэргээ таван анги хувааж, нэгэн ангийн хоёр мянган морьт цэргийг авч, өөрөө шууд Днепр мөрөнд яаравчлан хүрсэн ба нөгөө дөрвөн анги мурилзсан дардан замаар тал дундуур нутагт тарав. Уужим талд тохиолдсон хивчагийн нүүдэлчнийг малын хамт замд оруулан тууна.

Зэв ноён, шороо тоосонд дарагдсан нэгэн зуун цэргээ тэргүүлж, наранд гялбалзан урсах өргөн Днепр мөрний эрэгт хүрч ирээд үзвэл, хар давирхай болсон онгоцнууд, хөх усан дээгүүр хөвөлзөн байна. Орчуулагч хүн, Оросын цэрэг тэр байна гэж хэлэхэд харвал, мөрний хөвөөний довын дээр гялгар дуулга өмссөн, богино жад барьсан орос цэрэг байв. Тэр орос цэргүүд, нүдээ гараар саравчлан алсыг ажиглана. Тэд алсад хивчагаас ондоо үл танигдах морьт цэрэг ирж явааг үзээд, мөрний хөвөөнд байгаа онгоцнууд дээр ирж суугаад, тэндээс яаравчлан хөвөөнөөс зайлав. Зэв ноён шовгор болд дуулгыг өмсөж, эргийн дээр морио барьж, царайгаа барайлган зогсож, үл цавчих нарийн нүдээрээ мөрний цаад эргийн дов толгодыг ажиглан харж байна. Тэнд олон хүнтэй лагерь, арлыг гозойлгосон ачаатай олон тэрэг зэрэг үзэгдэнэ. Олон зүсний адуу бэлчиж явна. Явган ба морьт цэргүүд, хээр тал дундуур зэвсгийн төмрийг гялалзуулан ийш тийш явалцана.

Хэдэн онгоц эргийн орчим эргэлдэн байна.

Сэлүүрчид, мөрний их усны хүчит урсгалтай тэмцэлдэн, чармайж сэлүүрдэнэ. Нэгэн онгоц дээр нэг хүн бархиран өгүүлрүүн: Шунахай зочид оо, та нар юу эрж ирэв. Ямар бузар салхи та нарыг хийсгэж авчрав гэвэл, энэ үгийг хоёр газарч хүн, Зэв ноёнд орчуулж хэлэв. Тэгээд газарч тэдэнд бархиран өгүүлрүүн;

— Бид та нартай байлдах гэсэнгүй. Хивчагийг нэхэж явна. Хивчагууд бол манай агтчин, малчин мөн. Тэднийг цохиж, ачаа бараа ба адуу малыг булаан авагтун. Хивчагууд, бидэнд их хор хүргэсэн ба танд бас хор хүргэсээр иржээ. Бид та нартай найрамдалтай байхыг хичээнэ. Та бидний байлдах шалтгаан байхгүй гэвэл, онгоц дээрээс хариу өгүүлрүүн:

— Тийм бөгөөс элч нараа явуул. Бид тэдэнтэй чинь ярилцаж мэдье гэв. Зэвийн үгийг хэлмэрч дамжуулан өгүүлрүүн:

— Хэнтэй ярилцах вэ. Энд чинь их ноён бий юү гэвэл, бас хариу өгүүлрүүн:

— Энд ноёд олон байна. Манай олон ноёнтой танай элч хэлэлцэж тохирох биз ээ гэнэ.

Зэв ноён, дөрвөн цэргээ нэг хэлмэрчтэй томилж, мөрний цаана гарахаар тушаав. Оросууд, хивчагуудаас эд хөрөнгийг булааж, нутгаасаа хөөж гаргагтун. Тэднийг хээр газар Татаарууд чигийг олж чадна гэж Киевийн их ванд очиж хэлэх тушаалыг өгөв.

Томилогдсон цэрэг, хөлөө хөдөлгөж, ташууураар ууцаа маажиж, Оростой ярилцах хэрэг юү билээ. Тэдэнтэй нүдэлдээд эхэлбэл дээр биш үү гэвэл, Зэв өгүүлрүүн:

— Тийм бол би ганцаар нэгэн хэлмэрчтэй очно гэвэл, тэр цэрэг нь:

— Үгүй, чи битгий яв. Чамгүй манай цэрэг яах вэ. Эхээс салсан чонын бэлтрэг адил болно. Чамайг очиход чиний арьсыг хуулж ална. Байг, бид явъя гэв. Чингээд дөрвөн цэрэг нэг хэлмэрчийн хамт мөрний хөвөөнд очвол нэгэн онгоц ойртож, тэр тавыг аваад цааш одов. Зэв, цаад эргийг удтал харж зогсов. Манан хүдэн татсан уужим зүлэг, бургас, ширэг хөхрөн харагдана.

Шөнө болоход Зэв, арьсан дээлээ нөмрөөд, овооны ойр галын дэргэд хэвтэж, Орост очсон элчээ ирэхийг хүлээнэ. Гэвч тэд эгж ирсэнгүй. Хивчагууд, тэднийг алжээ.

Эргэн тойронд түүдгийн галууд улалзана. Талын бүх байдал жигтэй байдалд учирчээ. Ямар нэгэн морьтой хүмүүс, ийш тийш давхилдаж, сүүмэлзэж байгаа галын гэрэл, хааяа бадран ноцно. Зэв, тэр шөнө унтаж чадсангүй, сэтгэлийн зовнил, хэсэг бусаг үгс, танил царай зэрэг санаанд орж заримдаа хилэгнэн, заримдаа нойрмоглон байсаар тавтай унтаж чадсангүй. Түүний өмнө хааяа сүрхий өвгөн Чингис хааны хар үнэгэн сүүл хадсан төмөр дуулга, үл цавчих муурын

нүд үзэгдэх мэт болж, заримдаа Сүбээдэй баатрын цоргисон хурц нүд, цавчилдаж байгаа илд сэлэм, үхэж байгаа хүмүүсийн татвалзаж байгаа царай харагдах мэт болон ер амарч чадсангүй.

Одоо дутаах байтугай, довтлон ирдэг Оросын баатарлаг цэрэгтэй байлдах чанга цаг тулгарав. Тэднийг ялахад хялбаргүй. Зэвийн хятад газар байлдаж олсон алдар нэрийг нэгмөсөн алдаж, аль тийшээ ч унаж болох ирмэг дээр гараад байна. Зэв ноён нэг бөгөөс, энэ тал нутагт толгойгоо орхих ба эсхүл орос хивчаг хоёрыг дийлж, Мстислав вангийн алтан дуулгыг булааж авсан их алдар, их хааны өргөөнд хэлэлцэгдэн нийтэд дуурьсах болно.

Өглөө цэрэг нь Зэвийг сэрээж өгүүлрүүн:

— Мөрний цаана юу болж байгааг харж байна уу? Орос өдий олон онгоцыг авчраад хооронд нь холбож, гүүр тавьж байна. Ачаагаа нэгэнт мөрний эрэг дээр авчирчээ. Бас тэнд морьтой явган цэрэг олон цуглажээ. (Өмнөд Оросын ноёд, дайсныг бусдын нутагт байхад нь тосож байлдахаар Киев хотод хэлэлцэж тогтсон ёсоор, энд ийм олон цэрэг хуралдаж ирсэн ажээ). Тэд, мөд наад этгээдэд нэвтэрч ирнэ. Яах билээ. Нааш ирэхийг эсэргүүцэх үү гэвэл, Зэв өгүүлрүүн:

— Эсэргүүцэх хэрэггүй. Алсаас юу болохыг ажиглаж, ухрах хэрэгтэй гэж тушаав.

ОРОС ХИВЧАГ ХОЁР ХӨДӨӨ ЧИГЛЭН ДАВШИВ

Арван гуравдугаар зууны үед байсан түүхч Ибн Эл Асир бичсэн нь:

Хивчагууд, Татарыг дарах хүсэл төрөв.
Татарыг хүч хүрэхгүйдээ айж ухарч байгаа гэж санаад шууд нэхэн байлдах болов.
Татарыг ухарсаар байхад тэд 12 өдөр хөөж байлдав гэжээ.

Зэв ноён, зээрд морио унаж, хөнгөнөөр давхисаар дов дээр гарч, чулуун хүний дүрсний дэргэд зогсов. Тэр чулуун хүний өргөн цээж, хавтгай нүүр, охор жад, гарт барьсан аяга зэргийн эртний нүүдэлчний дархан цул чулуугаар сийлж хийжээ. Он жил өнгөрөхөд, олон хүнтэй байсан тэр нутаг, цөл болж хувилсанд энэ чулуун баатар шороонд дарагдаж, эртний довтолж явсан чигт балай нүдээ хандуулсаар ажиггүй сууж байна.

Одоо түүний дэргэд, Зэв ноён, морин дээрээ тэр хөшөө мэт хөдөлбөргүй сууж, хүйтэн нүдээрээ өглөөний манангийн дундуур, ширвэлзэн ирж яваа барааг ажиглана. Агсамнасан морины зүрх намдаж, хадсан өвсний ишийг уруулаар таталж, хужирлаг шороог туурайгаараа цавчилж байхад Зэв ноён, айсуй яваа Оросын цэргээс нүдээ салгалгүй харсаар байна. Тэдний дотроос морьтой хүмүүс түрүүлжээ. Цааш нь зам дагуу үргэлжилсэн ба тал дүүрэн таржээ. Тэдний тоос, үүл мэт бүрхэж байна. Цөм богино жадыг барьжээ. Тоосон дунд хөсөг нь харагдаж байна. Оросууд их олзыг горьдож, хөсөг дээрээ зэвсэг, тогоо, талхтай шуудай зэргийг ачжээ.

Зэв ноён жолоогоо татаж, одоо явъя гэж бодов. Оросууд, овоон дээр байгаа ганц морьтой хүнийг лав харсан биз ээ. Одоо хэдэн орос, хивчаг хүмүүс баг цэргээс салж, түүнийг чиглэн айсуй. Нөгөө хэсэг цэрэг, түүний хударгаар орж, гарах замыг хөндөлдөн таслахаар давхилдан явна. Гэвч Зэвийн зээрд морь, түмэн цэргийн морьдоос түрүүлэн гардаг хурдан хүлэг билээ.

Зэв, довын нунтаг шороотой энгэр лүү алхлуулан буув. Довын хажууд явцуу амсартай их нүхийг малтсан харагдана. Эртний баатрын баялаг булшийг нээж, олз олох гэж урьд ямар нэгэн хүн үүнийг малтсан биз ээ. Энэ нь одоо өлөн чонын нүх болжээ.

Зэв, морио давирч, явдлыг хурдатгана. Нэлээд зайтай байгаа гангыг хүрэх хэрэгтэй. Тэнд нууж үлдсэн Гимбэгийн хэдэн зуун цэрэг бий. Татаарын цэргүүд, сахлаг өвсөн дотор нуугдаж байгааг ирж яваа Оросууд ба түүнээс мэхлэн дутааж яваа Зэвийг тодорхой харж байв.

Оросын морьт цэргүүд, ойртож айсуй. Тэдний морьд сайн. Бодвол шилдэг цэргээ магнайд явуулсан биз ээ. Хударгыг чиглэн яваа хэсэг хүмүүс нэлээд аюултай байна. Учир нь баруун этгээдээс тэд шахах ба зүүн этгээдэд их жалга байх тул хажуу тийш гарах газаргүй, тэр хударгаар орох гэж яваа хүн, ес бөгөөд гурав нь хоцорсхийж явна. Түрүүлсэн хэд бас цувж байхыг үзвэл, Зэвийг хүрээлэн барих гэж бодсон бололтой. Зэвийн морины хөл дороос хэсэг ятуу босож нисээд, дахин өтгөн өвсөн дор сууж далдарна. Шарилжин дотроос бор халзан туулай босож дэгдээд, урт чихээ хулмайлган давхина. Зэвийн морь хөнгөн эелдгээр давхиж, тохиолдсон судаг дээгүүр харайлган өнгөрнө.

Дайсан ойртов. Зэвд тэдний төмөр дуулганы дороос цухалзаж байгаа гандсан нүүрүүд харагдав. Энэ харагдагч хоёр Оросын нэг нь улбар царайтай, хар нүдтэй залуу бөгөөд нөгөө нь буурал сахалтай

өвгөн байна. Хоёул улаан бамбай барьжээ. Гурав дахь хүнийг үзвэл, хурц улаан дээлтэй, хар морьтой, нэгэн хивчаг бөгөөд морин дээрээ бугуйлаа хаяхад бэлтгэж байна.

Зэв, сумыг дэмий харвах гэж байдаггүй, тэр хатуу нумаа татаж, хурц сумаа мултлахад хивчаг морин дээрээс өнхрөн унав. Түүний цочсон хар морь эзэнгүй болж, улам хурдлан давхихад, гагцхүү өтгөн дэл нь салхинд үлээгдэн намирна.

Гэтэл, орос залуу ойртож ирэв. Түүний морь, Зэвийн морьтой зуузай холбож ирэхэд, орос цэрэг, Зэвийг жадаараа хатгавал, Зэвийн төмөр хуяг дээр халтиран одов. Харин Зэвийн урт сум, тэр залуугийн хоёр хар нүдний дунд онов. Эх орон, алдар нэр, сайхан нар бүгдээс салахын ёсыг хийж хагацав. Түүнийг Зэв эгж харсангүй. Өөрийн Гимбэгийн цэргийг эрж байна. Тэд, жалгаас гэнэт босож, муухайгаар хашхиралдан, Оросын бутран довтолж яваа цэрэгтэй тулж эхлэв. Оросын цэргүүд, хурдан бөөгнөрч явна. Тэдний дугараг захтай, хурц ултай бамбай жигдэрч нэгэн хэлхээ болж байв. Тэд, сая хурцатгасан гялбагар жадаа сугалж Татарыг дайран орно.

Гэвч, Оросын цэргийг ойртож ирмэгц, гэнэт морины амыг эргүүлж, хажуугаар нь сайтар харвасаар зөрж өнгөрөөд, морины бүх чадлаар буцаж дутаах гэсэн Зэвийн тушаалыг Гимбэг сайн мэдэж байна. Энэ ёсоор дутаахад, Оросууд хашхиралдан хөөв. Чингэхэд тэдний жагсаал эвдэрч дутааж байгаа Татарыг тус тус нэхэн хөөхийг хичээнэ. Оросын зарим цэргүүд хоцролгүй яваа арваад Татарыг гүйцэж цавчин алаад морийг нь сольж унаад давхина.

Зэв бие хамгаалагчдаар хүрээлүүлж байлдааны явцыг баахан ажиглаж байгаад жалгад орж оргилж байгаа сэрүүн булгаас морио услаад бүх цэрэгтээ улам зайлж дутаах хэрэгтэй гэж тушаав. Тэр цагт Гимбэгийн хэдэн морьт цэрэг ирж мэдүүлсэн нь: Дарга Гимбэг шархдаж унаад орос цэрэгт хүрээлэгдсэн боловч арай гэж дутаан гарсан. Гэтэл түүний хойноос олон орос хивчаг нэхэж одов гэжээ.

Шөнө барьж авсан орос цэргийг замчаар хэлмэрчлүүлэн, Зэв ноён өөрөө байцаавал, тэр өгүүлрүүн: Энэ оросын тэргүүний хэсэг цэрэг бөгөөд Галичийн ван, Мстислав даргалж явна. Бидний цэрэг Галич, Волейн мужийн цэргүүд бий. Тэд, Днепр мөрөнд завь онгоцоор явж, далай хүрээд, тэндээс эргэж, Хортиц аралд болзоот газраа ирээд байлдаанд оров гэнэ. Бас хэлсэн нь: — Ноёд, завсраа эвгүй тул, өөр өөрийн отрядыг авч тус тус байлдаар явна. Отряд бүрд ноён байна.

Нэгэн ерөнхий жанжин байхгүй. Галичийн Мстислав ван, байлдаанд туршлага зориг төгс тул, түүнийг жанжин болгоё гэж олон цөм хэлсэн боловч, Киевийн ван Мстислав огт зөвшөөрсөнгүй маргав. Учир нь Киевийн ван ахмад ван тул дүүмэд ванд яаж захирагдах билээ гэнэ. Ван ноёдын хэрүүлүүд, дорд цэргүүдэд ямар ч хэрэггүй. Харин хохиролтой болно. Учир нь хэрэв Татар нар ялбал, ван ноёд хурдан морио унаад дутааж амь гарна. Дорд цэргүүд цусаа урсгаж үхнэ. Бидний цэрэг, тариачны муусайн морьдыг унаж мордсон тул хол дутааж яаж чадах билээ. Татар нар биднээс могой мэт гулзалзан зайлж байна гэхэд Зэв ноён хивчагуудын тухай асуувал, тэр өгүүлрүүн; — Хивчагууд, маш олон гэж хэлэлцэнэ. Тэдний цэргүүд, Днеприйн зүүн эргийг барьж, Хортиц арлын тэнд Оросын цэрэгтэй нийлэхээр явж байгаа гэнэ. Одоо Мстиславын манлай отрядтай хивчагийн яргын цэрэг явж бий гэв.

Зэв асуууруун:

— Татаарын тухай орос юу гэлцдэг вэ гэвэл, тэр баригдсан хүн өгүүлрүүн:

— Урьд Татарыг хивчагаас дор муу байлдагч гэж ярьдаг байсан. Иймийн тул Оросын вангууд, Татаарын цэргийн хүрээг довтолж, даруйхан их олз дээрэмдэн авахыг яаравчилдаг байсан. Одоо үзвэл Татар баатар цэрэг, мэргэн харваач нар юм байна гэв.

Чингээд Зэвийн тушаасан нь: Шөнө огт гал гаргахгүй, улам зайлан дутаавал зохино. Энэ олзлогдсон хүнийг алагтун гэж тушаал өгөв.

Шөнө Оросын манлай цэргийн хонож байгаа газар, Татаарын тагнуулчин, хэлмэрч ирж яриаг нууц сонсов. Үзвэл орос цэрэг хүрээлсэн хөшигний дунд унтаж байна. Хивчагууд, ондоо хүрээнд бууж, гал түлэн түүнийгээ тойрон дуулж, бүжиглэж байна. Учир нь Татарт урьд хөөгдсөн нутагтаа буцаж ирсэндээ баярлан цэнгэж байгаа ажгуу.

Оросууд манай мянганы ноён Гимбэгийг барьж авсан гэнэ гэж тагнуулын хүн мэдэгдэж ирэв. Гимбэг дутааж, овооны дэргэдэх чонын нүхэнд нуугдаж байсныг орос олж аваад Хивчагт өгчээ. Хивчаг түүний дөрвөн мөчөөс оосорлож, дөрвөн моринд нэжгээдээр уяж тавиад, дөрвөн хэсэг тастан алжээ. Гимбэгийн толгойг чихнээс оосорлож, хивчагийн дарга ярган эмээлдээ ганзагалж явсан гэв.

ТАТАРЫН МЭХ

Зэв, Татараа дагуулж, түрэлхийлэн ирж яваа Оросоос дутааж улам холдон зайлж явав. Хаяа татаарууд түрүүлэн ирсэн хивчагтай байлдаж байсан боловч, их тулалдаан ер болсонгүй.

Өдий хол аялан хөөж явахдаа оросын цэргүүд, заримдаа өдөр бууж зүлэг газар бэлчээрлэн яваа хивчагийн үхрийг хурааж авчирна. Энэ үхрүүдийг Зэвийн тушаалаар зориуд энд авчирч, Татаарууд хариулж байгаад орос хивчагийг ойртож ирэхэд орхин дутаав.

Зэв, Оросын хүчийг цувуулан тарааж, сэрэмж муутай болгоод, буудалдаа үхрийн махыг амаараа гартал идээд, дайсны аюулыг мэдэхгүй болог гэж мэрийжээ.

Орос цэрэг, тоостой өргөн замаар хэсэг хэсгээр цувалдана. Бие биеэсээ улам улам холдож явав.

Шөнө унтахдаа сүлжмэл ханан хашаагаар хашиж, тэргээр хүрээлэн тойруулах сэрэмжлэхийг зогсжээ. Шинэ олзлогдсон оросуудын хэлэх нь цэргүүд мал их олзолсон, энэ аянд сэтгэл ханаж, «одоо харин өмсөх нэхий дээлтэй болж, үхрийн ширээр шинэ гутлыг хийнэ», «Татаарын өнөөх тоо томшгүй олон цэрэг хаана билээ. Хивчагийн үхэр нь Татараас олон байна. Татарыг ингэж хөөсөөр явж, далайн булан хүрэвч, тэдний хүрээ хуаранг олж үзэхгүй байх нь гэлцэх бүлгээ. Нэгэн баг цэрэг бусдаас илүү сайн жагсаж явав. Түүнд цэргийн журам нарийн чанд бөгөөд цэргүүд, талаар тарж явахгүй, шөнийн хоногт тэргийг дугуйлан угсруулж, зүг зүг тийш туршуул тагнуул гаргадаг байв.

Энэ бол Киевийн их ван Мстислав Романовичийн цэрэг билээ. Киевийн цэрэг бусдаас онцгой явж, хагас нь явган, хагас нь хүнд нүсэр морьтой явав. Тэд мөн заримдаа бас зогсож, хаврын ногоонд таргалан тэвээрч, хөдөө талаар тарсан малыг цуглуулахаар морьтой хүн явуулж, зэс тогоонд шөлтэй махан хоол чанаж идээд, өглөө болтол сур мэт сунаж унтдаг билээ.

Татаарууд, Оросын морьдыг татар морины адил шаламгай тэсвэртэй биш, Оросын сумыг Татаарын адил хол тусдаггүй. Гагцхүү урт ишит алман сүх барьж зууралдан тулалдахад чадалтай их тэсвэртэй, зүтгээч гэлцэнэ. Татаарууд, орос цэргийн багтай ойрхон зуур тулалдмагц дов толгодын араар нуугдан, гуу жалгаар сэм зайлж, хээр алс хол буруулан дутаах бүлгээ.

Өдөр маш бүгчим халуун, тэсгэлгүй ээх нарыг халхлах нэг ч үүл огторгуйд үзэгдэхгүй бөгөөд явах цэргийн олон баг, бөөн хар тоос босгож, хүн морь амь тэмцэн бачимдан бүлгээ. Зарим баг цэрэг, замаас гараад зүлэг дээгүүр явж, нарны ээвэрт халсан газар олны хөлд бутарч, цэргүүд дээгүүр бөөн хар үүл тоос манаран дэгджээ. Энэхүү халуун өдрүүдэд гол горхи ч ширгэж эхлээд цэргүүд «хээр талд Татаарын хойноос биднийг юунд ингэж хөөсөн юм билээ. Хивчагаас булаан авсан малыг хөөж, гэр лүүгээ буцах цаг болсон юм биш үү» гэж өгүүлдэг байжээ.

СҮБЭЭДЭЙ БААТАР ТУЛАЛДААНД БЭЛДЭЖ БАЙНА

Өгүүлэх нь: Өвгөн жанжин монголчууддаа тулалдаанд ашигтай газрыг сонгон эрсээр хоёр хоног хэсэн явав.

Хөөс цахарсан морьтой элч нар, гурван удаа давхилдан ирж, Зэв ноён ухарч байна. Урт сахалтын баг цэрэг давшиж явна. Тэднийг «Мстислав баатар» удирджээ.

Ярун хааны хивчагууд тэдний хамт явалцаж, манай мянгат Гимбэгийн толгойг Ярун хаан ганзагалж явна гэжээ.

Байлдааны өмнөх үдэш Сүбээдэй баатар, дов дээр барьсан гэртээ буцаж ирсэнд таван хөлт жанжин тугийн дэргэд бүх цэргийн мянгатын арван тугийг хатган зоож одоо бүх түмэн цэрэг цугларан хуралдаж, талд хүрээлэн бууж нижигнэн шуугинам бүлгээ.

Сүбээдэй баатар, эсгий дээр хэвтэн хамаг яс нь янгинан өвдөж, урван хөрвөн хэвтвэл гэрт задгай галын утаа уугьж унтрах шахжээ. Ис болсон дээврийн доогуур утаа дүүрч, өрхөөр гарна. Гэрийн хаяаг ихээр сөхсөн боловч, сэрүү татах салхи орохгүй, Калк голын гандсан тал газрын агаар хөдлөх салхигүй маш халуун. Монголын өвгөн жанжин унтаж ядан, хуаран хүрээний намдаж байгаа чимээг чагнаж, гэрийн ханын завсраар үзвэл тойрон суусан цэрэгт улбар туяа тусган байгаа олон галын гэрэл үзэгдэн, хэлэлцэх үгний зарим нь сонстон, сэлмийн төмрийг билүүдэх чимээ гарна.

Нэг хүн дуулруун:

Төрсөн нутаг Хэрлэн голын ногоон зүлгийг үзэхгүйеэ, цэрэг чи!
Цагаан яс дүүрсэн хөндийд чамайг эз чинь татан дагуулав

гэвэл нэгэн хүн ууртай дуугаар зандран өгүүлрүүн:

Дуугай бай. Ямар муу ёр ёрлов? гэвэл, дуу дуулахыг зогсоод, нэгэн хүн «Зогс! Хэн бэ?» гэж хашхирсанд. Сүбээдэй арай чамай гэж босож суувал олны шуугиан чимээ, морьдын төвөргөөн ойртон... нэгэн торгууд хүн орж ирээд,

Тогучар ноён ирэв. Түүний хойноос харьяат түмэн цэрэг нь дагаж явна гэвэл, Сүбээдэй баатар асууруун: Би тэднээр юу хийх билээ гэвэл,

— Ноён чамтай уулзъя гэж дов дээр гарч байна гэсэнд Сүбээдэй хоолойгоо засан ханиасаар босож, гэрээсээ гарвал, бүрэг харанхуйд түүний өмнө төмөр дуулгатай, өндөр биетэй нэгэн цэргийн хүн зогсож, мөнх тэнгэр чамайг өршөөтүгэй. Би эзний алтан өргөөнөөс тугаа, чиний тугийн дэргэд босгоё гэж шууд ирэв гэсэнд Сүбээдэй өгүүлрүүн:

— Миний замыг хөндөлдөгсөд бий. Одоо хүртэл чамгүй чадсаар ирсэн билээ гэсэнд Тогучар ноён өгүүлрүүн:

— Үүнийг монголчууд цөм мэднэ. Одоо надад чамтай ярилцах хэрэг бий гээд, хоёр жанжин гэрт орж, Тогучар ноён, Сүбээдэйтэй зэрэгцэн эсгий дээр сууж, чихэнд нь шивнэж урагшлан давшсан монгол цэргийг эрсээр баруун зүг явтугай гэж Чингис хаанаас Тогучарт тушааж явуулан, их хааны захидлыг тусгай элч авч яваа гэсэнд Сүбээдэй баатар удаанаар ханиаж, дув дуугай толгойг дохиж сэгсрэн, Тогучарын зүг бөхийж мөн чихэнд нь шивнэсэн нь:

— Би их хааны бичигт чухам юу бичсэнийг мэдэхгүй... Эзний үгийг дагахгүй байж үл болно. Богд эзэн бидэнд урагштай сайныг хүсэж байгаа биз ээ. Эсхүл эргэж буцаг гэж хүсэж магад... Чингэвэл миний цэргүүд, байлдахгүй гэх болуужин... Гэтэл, маргааш энд Оросууд хүрч ирнэ. Намайг тулалдааны өмнө зайлан явбал, тэд юу бодох вэ. Их Чингис хааны цэрэг, Оросын сахлыг хармагц морьдынхоо сүүлийг үзүүлнэ гэцгээнэ гээд Сүбээдэй дуугай болж, дахин удтал ханиан өгүүлрүүн;

— Би захидлыг үзээгүй... Би захидал гэж... юу ч сонсоогүй болъё!... Одоо би унтана. Маргааш үүрээр тахиа дугармагц би оросын өөдөөс угтан дайрна. Сүлд тэнгэр, галай тэнгэрийн зэрэг манай тэнгэр нар, намайг сум мэсийн аюулаас сахин харвал, бид хоёул тулалдааны дараа уулзаад, чи бүх цэргийн өмнө их эзний бичгийг надад өгнө биз. За дараа баяраар учиръя гэжээ. Үүнийг үл өгүүлэн, өгүүлэх нь; Сүбээдэй, шөнө хоёр удаа цогийг үлээж, хуурай гишүүг галд хийж, хөлөөс торгосон мөнгөн оосроор гэрийн хананаас уяатай алтан

тахианы зүг байн байн үзвэл, тэр тахиа эзнийг огт харахгүй, өдөө өрвийлгөн сууж, гялгар дүгрэг нүдээ нээмэгц дахин цагаан зовхио аньжээ. Чингэсээр өглөө болоход Сүбээдэй баатар, үүргэлж унтсанд тахиа гэнэт чанга дугарч, далавчийг дэрвэлзэхэд өвгөн боол Саклаб орж ирээд, гал асаавал, зэрэглээ гэрт хоёр бөө, тахианы дууг дуурайн,

«Хорь-хорь-хорь-соо» гэж хашхирав. Сүбээдэй, Саклабын зүг хянцайн харж — Энэ яах вэ гэж үзвэл, өвгөн орос боол, эсгий дээр торгон хивсийг дэвсэж, байдал маш ихэмсэг, буурал үсийг хоёр тийш хагалан самнаж, тасмаар уяад, наранд гандсан үрчгэр хүзүүндээ баавгайн шүдэн зүүлт зүүжээ. Чингээд Саклаб гадагш гарч, нэгэн тавагтай чанасан тутарга, жижиг хөшиглөсөн хонины мах авчраад, тавгийг Сүвээдэйн өмнө торгон алчуур дээр тавьж, дөрөв нугалсан хэдэн нимгэн бин тавьж,

— Гурганж хотын маягаар хийсэн улаан чинжүүтэй пилавыг чамд авчрав гэвэл,

— Чи яах гэж баавгайн шүдэн зүүлт зүүв. Орос дүү нараа үзнэ гэж баясаж байна уу?... гээд тутаргын зүг ойртон бөхийж, сэжлэн үнэрлэж, энэ чинь хортой байна. Чи үүнийг үхсэн эцэгтээ идүүл гэж шүдээ зууж хэлээд, тавгийг түлхвэл, Саклаб өгүүлрүүн:

— Би нохойноос ч дор боол. Тийм боловч, өчнөөн урт насалтал, хүнд гэм хор хийж үзээгүй гэж номхноор өчвөл, Сүбээдэй хөмсгөө зангидан буулгаж, энэ тавгийг миний хойноос аваад яв. Сүбээдэй баатар, мөргөн залбирна гээд, өвгөн жанжин, сүйлхийлэн доголсоор, гадагш гарч, гэрийн дэргэд зогсжээ.

Үдэш цэрэгтээ тушаал өгсөн.

«Өглөө, түрүүчийн тахианы дуугаар, толгодын ар талд жагс» гэсэн билээ. Одоо морин цэрэг, зүг бүр тийш давхилдаж, бүрээ хүнгэнэн, бөмбөр цохиж, морьдыг гуядан хашхиралдах цэргийн дуу сонстоно. Гэрийн өмнө задгай галын дэргэд, өндөр малгайтай, сагсгар дахтай, холбог зүүсэн хоёр өвгөн бөө сууж, жанжныг үзмэгц хэцээ цохин дэвхцэж, галыг тойрон эргэв. Сүбээдэй, сүүлчийн тушаал зааврыг өгч:

— Гэр, хивс, ширдгийг энд хаягтун. Шаламгай чи хөсөг дагаж яв. Миний гурван ирвэсийг эр тахиатай өвгөн Саклабтай авч яв. Саклабыг сайн харж яв. Тэр өнөөдөр, орос дүү нартаа оргож очих магадгүй шүү. Морь аваад ир! гэсэнд торгууд нар, морьдыг авчирсан нь: Хоёр хөтлөг, жороо морь, юм ачих зургаан морь авчрав. Тэр зургаан моринд хүнд

богц ачжээ. Хүний хэлэлцэх нь: Сүбээдэй, тэр богц дотор цуглуулсан алтаа авч явдаг юм гэдэг билээ.

Сүбээдэй, нуруу ачаан сагсгар үстэй хар хүрэн залуу морины дэргэд очоод торгуудад дохио өгмөгц хоёр хүн морины жолооноос бариад, түүнийг илж, задгай галын дэргэд авчрав. Саклаб, хажууд тавагтай цагаан будаа барьж зогсвол, Сүбээдэй, эрүүл солгой гараар цагаан будааг атгаар авч, галд өргөн хаяж уртаар аялан, залбирч мөргөн дуулруун:

Галай хаан, гал улаан эзэн минь сонс!
Хайр чулуун эцэгтэй, хатан болд эхтэй чамдаа.
Шанагаар дүүрэн шар тос
Хундагаар дүүрэн хар архи
Атгаар дүүрэн сэмж
Өргөн барьж өчин тахья
Өлзий хутаг оршуул.
Давхих морийг хурдан
Далайх гарыг чанга болго!

гэж өчин залбирахад, хоёр бөө Сүвээдэйн өчгийг давтан өгүүлж, хэцийг аажуухнаар цохиж байв. Чингээд жанжныг мөргөж дуусмагц бөө нар, Саклабын гараас, цагаан будаатай тавгийг шүүрэн авч, газар суун их чимээтэй, тамшаан зажилж маш ховдгоор идтэл, Сүбээдэй нарийхан хутгыг гаргаад, морин дээр огтолбол, морь догдлон хөдөлж, гялгар үсэн дээгүүр хар цус урсав. Сүбээдэй, морины дэлээс тас барьж, шархны цусыг сорон шимсэнд торгууд нар их тулалдааны өмнө халуун цус сорон ууж байгааг бишрэн харж, хөдлөлгүй зогсов. Чингэтэл, дов дээр төмөр дуулга, ган хуягтай, цэргийн хүн гарч ирээд, байдал, хөмсөгтөө хүртэл тоос торд дарагдаж, танихад бэрхтэй болжээ. Сүбээдэй, бараан хүрэн мориноосоо салжээ. Цус болсон нүүрт нь нарийн ажиглаач бүлтгэр нүд гялалзана. Энэ баатар чи хэн бэ гэвэл, тэр цэргийн хүн, морины шарх дээр алгаа хүргэж, цус болсон гараар Сүвээдэйн хувцсыг илж, ерөөн өгүүлрүүн:

— Эд нь хэврэг, эзэн нь мөнх болог. Тос халдаг, Тоос бүү халдаг. Би Зэв ноён байна гэвэл, Сүбээдэй асууруун:

— Оросууд хаана вэ? гэвэл, Зэв ноён өчрүүн:

— Ойрхон, бүр ойрхон! Мөд энд хүрч ирнэ. Миний зуутын цэргүүд тэдэнтэй авалцан тулалдаж, нааш дагуулан буруулж байна. Би

өөрөө гурван зуун цэргийн хамтаар Мстиславыг мөрдөн ажиглаж, амьдаар барьж авъя гэнэ. Түүний бие харьяат цэргийн хамт бусдын түрүүнд явж байна гэвэл, Сүбээдэй асуууруун:

— Чи өөрөө харин түүний саварт бүү ороорой гэж Сүбээдэй баатар жороо морио унаж мордов. Өмнө нь гурван монгол зэрэгцэн явж, дундах нь сэрээт жадтай, таван хөлт тугийг барьжээ. Сүбээдэй, дов дээрээс торгууд зуутын хүлээж байсан газар аажмаар буув.

Тэр торгуудын цаадах гандсан талаар олон морин цэрэг бөөгнөрөн цугларах нь үзэгдэх бүлгээ.

ТУЛАЛДААН ЭХЛЭВ

... Оросууд тулалдаанд орохоор завдтал, өдий төдий олон Татар дайран орж, хоёр этгээд үзэгдээгүй баатар эрэлхгээр байлдав. (Арабын Ибн Ал Асир гэдэг түүхчийн тэмдэглэл, 13 дугаар зууны үе)

Өгүүлэх нь: Калк голын гуу жалга болсон эрэг дээр эрэлхэг Мстислав Мстиславичийн Галичийн морин цэргийн баг бусдаас урьд гарч ирээд, түүний хойноос жанжин Яруны хивчаг аймгийн морин цэрэг давхилдан ирэв. Мстислав эргэн тойронд үзвэл, Татаарын орхиж буруулсан хүрээний утаа ис болсон олон гэр үзэгдэн, түлсэн галын нурам нь бас халуун хэвээр бөгөөд олонх гэрийн дотор хивс, ширдэг, ууттай амуу будааг санд мэнд хаяжээ. Нэхсэн орос цэрэг үүнийг үзээд,

— Татаарууд эндээс туулай шиг зугтав. Тэднийг бид хаана гүйцэх билээ. Үхлээ эрж, энэ халуунд хэчнээн болтол явдаг бил ээ? гэлцэнэ.

Эрэлхэг Мстислав ноён, нэг насаар цэрэг дайнд ялж, ашиг олох ахул, хэний ч төлөө байлдаж явсаар, дайн тулалдааны их туршлагатай хүн бүлгээ.

Татаарын орхисон хүрээг үзээд, асар баярласангүй, хоосон хүрээг бус, Татарыг цочмог барьж авъя гэж явсан билээ. Чингээд, харьяат баг цэрэгтээ түр амрах тушаал өгөвч, байлдаанд яаран зэхэж, хуяг дуулгыг өмс гэж, тагнуулд залуу хүргэн Данил Романовичээ түүний хайрт Волын хотынхонтой явуулбал, яаруу жанжин Ярун, харьяат хивчаг цэргээ авч, Татарыг алжаан цуцаж, хүчин доройтсон гэж бусад олны нэгэн адил санах тул, яаран, дайран орохгүй аль цагийг хүлээнэ гэж давхилдан одвол, удалгүй Данил ноёноос элч ирж, Татар их ойрхон

байна. Энэ толгод дээр тэдний хайгуулын цэрэг үзэгдэж, бидний барааг харалцан буруулж бий... Одоо бид яах билээ гэвэл, ноёд сольж унах шинэ морь ирүүл гэсэнд цэргүүд эмээлтэй гурван морь авч ирсний хоёр нь хээр зүстэй, хар дэлтэй, өргөн цээжтэй бөх сайн унгар морь ажээ. Одоо тоосонд дарагдаж, толгойг доош болгож, эцсэн байдалтай зогсоно. Гуравдугаар морь нь Мстиславын хадам эцэг Куманы хаан Хотианаас бэлэглэсэн туркмен газрын буурал толботой өндөр азарга, хивчаг хэлээр тэр азаргыг «Аткас» буюу галуу морь гэжээ. Маш догшин. Хоёр хивчаг адууч түүнийг жолооноос нь чирэгдэж, чүү чамай гэж авчирвал, Мстислав, Аткасыг унаж, амыг татсаар голын зүг бууж, цэргийг морьдоо баахан усалж, жагс гэж тушаагаад, Татарыг арга мэх хэрэглэнэ гэж огт бодсонгүй, хүчин буурайн учир буруулна биз ээ гэж амрах чөлөө өгөлгүй, нэхэж гүйцээд сарниулан даръя гэж тогтжээ. Түүний цэрэг, харьяат эзний ванг үзвэл, алтыг шарж сийлбэр гаргасан, гялалзах болд дуулга өмсөж, хун шувууны хүзүүтэй, өндөр биетэй туркмен аргамгийг унаж явах байдал шав хийсэн сайн эрийн шинжтэй, бие чийрэг, шөрмөслөг, үнэхээр, дайн байлдаанд сум илдэнд шурган ороход бахдан явж дайсныг эрэн дайрах баатар сайн эрийн шинж бүрдэж, өчнөөн төчнөөн дайн тулалдаанд хатуужилтай болсон учир, эрэлхэг Мстислав нэрийг олсон нь учиртай байжээ гэмээр үзэгдэнэ. Мстислав ноён, голын тэртээ гарч, морио усалсан бусад цэргийн хүрч ирэхийг түр хүлээж, тэнгэр бидэнд тусална. Буруу номтой Татарыг цавчин сөнөөе! Энэ хортон аймгийг бүү хайрлагтун! Урагшаа давш гэж хашхиран давшвал, бүх баг цэрэг хатиралдан хөдөлж, цэргүүд дайсантай халз тулан цавчилдана гэж зэвсгээ зэхэж явахад Мстислав өмнөө үзвэл өргөн тал газар, Орос Татаарын морьт цэрэг хар тоос бужигнуулан давхилдав. Тэр орос цэрэг бол, Мстиславын хүргэн, арван найман настай ван Данил Романовичийн харьяат Волен хотынхон байжээ.

Алтаар хатгамалласан, түүний цэнхэр туг гялалзан намисхийж, шадар цэрэг нь эзэн ван Данил юугаа хамгаалан бөөгнөрөхөд, Татар, зүг бүхнээ давхилдан дайран довтолж, авалцан тулалдаж, унан тусан, урт тахир сэлмээр цавчилдан бужигнав. Хивчаг цэрэг, Данилын цэргийн тэртээ билээ, Мстислав үзвэл, хивчаг цэрэг жанжин Яруны тугийг ганхалзуулан, олон толгодын зүг өмнөө тоос манаруулан буруулсныг үзээд, зүүн тийш чиглэж, толгодыг өнгөрөөд, хэрэв түүний цаана тулалдаж байвал, Ярун жанжны Коман цэрэгт тусалъя гэж

харьяат баг цэргээ дагуулж, нэгэн өндөр толгой дээр гараад, морины амыг татаж, цочин үзвэл, өргөн тал газар, дайсныг тосон хүлээж, Татаарын их цэргийн сүртэй нягт жагсаал жигдрэн үзэгдэж, олон морьт цэрэг чив чимээгүй хөдлөлгүй зогсох нь их л сүртэй. Төмөр дуулга, гялалзсан хуяг, гартаа барьсан тахир сэлэм нь тов тод үзэгдэн, баг багаар жигдрэн жагсаж, өргөн талыг бүрхэн цувалдсан нь хэчнээн олон цэрэг билээ.

Хорин хороо юу? Гучин хороо юу? Тавин хороо юу? Хэчнээн олон цэрэг вэ? Татаарын их цэрэг, сүүлчийн аймшигт өдрийг хүртэл хүлээсээр, энд нуугдан бүгсэн байжээ. Днепр мөрнөөс энэ хүртэл, халдан дутааж байсан, жижиг баг цэрэг бол, Татаарын арга мэх байсан аж.

Дайсны аргад ингэж орох гэж, бат журамт шадар цэргээ тулалдаанд бэлэн байгаа Татаарын тахир сэлмийн ирийн дор ингэж оруулах гэж хэцүүеэ. Амь гарах, аргалах арга юу бил ээ? Урт замаар, санаа амар цувалдсан Оросын олон баг цэрэгт яаж мэдээ хүргэж цуглуулъя? Яахин амжин завдаж үзье? «Манай орос цэрэг олон. Татараас цөөнгүй. Гагцхүү юунд Татартай адил ийм дарагдашгүй догшин сүртэй болж нийлсэнгүй вэ?

Юунд ноёд бүр биеэ дааж, өөр өөрийн цэрэгтэй тус тус явдаг билээ. Бутран сарнисан орос цэргийн олон багийг нийлүүлэх ганцхан өдрийн чөлөө олдоосой! Чингэвэл, Татарыг эзэлж болох асанж».

Одоо хожимджээ. Олон Татар урагш давшиж, эцэж цуцаагүй гурван түмэн морины түрлэгээр дайран орж, замд тохиолдсон бүхнийг үнсэн товрог болгоно. «Үхэгсдэд ичгүүргүй» гэж Мстислав шивнэж, анх удаа морио ташуурдмагц, хээр талын тэр догшин морь, өндрөөр дээшээ цоройгоод сүртэй ихээр ухасхийн харайж, дов дээрээс талын чиг давхивал довын цаанаас Команы морин цэрэг, овооролдон бөөгнөрч, давхилдан гарч ирээд, айн бархирч, морио тас гуядсаар, Мстиславын Галичийн цэргийн жагсаалыг үймүүлэн дайрч, замд тохиолдогсдыг унагаасаар цааш давхин буруулахад, Данил Романович хэнхдэгтээ хүнд шарх олж, морины дэлээс барин, чүү чамай тогтон явсныг морь нь олон комантай давхилдан авч явав.

Мстиславын өмнөөс татаарууд нягт эгнээгээр урагш давшин, баруун гарын ханцуйг мөрөндөө тултал шамлаж, тахир сэлмийг далайсаар гарч ирэхэд, өчнөөн олон морин цэрэг нэг ч дуу гаралгүй, Калк голын зүг хатиралдан чимээ имээгүй ойртох нь аймаар сүртэй.

Гагцхүү олон морины турхирах, туурайн түвэргэх, хааяа ганц нэг зэвсэг хангинах нь нэгэн зориг, нэгэн зорилтой Монголын догшин сүрт их цэргийн чимээгүй явахад сонстоно.

Татаарчууд, голыг гаталж, нөгөө эрэг дээр гарч ирэхийн хамт, бүрээний дуу хангинаж, олон цэрэг, муухай их дуугарч хашхирцгаан, орос цэргийн хүрээг дайрав. Хүрээний газар хивчаг сандран мэгдэн дутаахыг хэдийн үзсэн тул, яаран сандран тэргийг угсруулан хүрээлж, хамгааллыг бэлтгэв. Татаарууд, Оросын эхний баг цэргийн дэргэд сааталгүйгээр замд тохиолдсон ачааг дайрч, цааш дайран одоход их дардан замаар цувалдсан Оросын олон баг цэрэг морио гуядаж, буруулан дутаах хивчаг цэргийг үзэцгээв. Тэр команы дунд, эрэлхэг Мстислав, улаан нөмрөгөө салхинд хийсгэж, урт биетэй буурал азаргыг унаж, царайг барайлган давхиж явав.

Оросын зарим нь тэргийг хаяж, морин дээрээ мордоод, Днепр мөрний зүг гэдрэг буцан давхилдав. Зарим нь тэргийг угсруулан хүрээлж, Татаарын довтлогч цэргийг сүхдэн цавчиж байлдав. Үүнийг үл өгүүлэн, өгүүлэх нь:

Татаарын нэгэн хэсэг цэрэг, Киевийн ноён Мстислав Романовичийн хүрээг тойрон бүслэв. Тэр ноён, морьт явган нэгэн түмэн цэргийг дагуулан явж бусад баг цэрэгтэй огт холбоог барихгүй билээ. Чингэхэд эрэлхэг Мстислав хэрхэхийг мэдэхгүй таамаг явж «хорт салхинд туугдаж ирсэн Чингис хааны Татар»-ыг устгана гэж бардам их үг хэлж явав. Чингэсээр Киевийн цэрэг тэр гайтай өдрийн үд дунд Калк голын өндөр эрэг дээр бууж урьд адил олон тэргийг хүрээлэн угсруулсанд хажуугаар нь ухаан алдаж сандарсан коман цэрэг давхилдан өнгөрсөнд Киевийн цэрэгт байсан арван нэгэн ноёд,

— Бидний үхдэг газар энд болов! Батаар зогсоцгооё гээд хоорондоо үнсэлцэж амьсгал тасартал тулалдана гэж тангараглаж, тэргийг нягтруулж, улаан бамбайгаар халхавчлан тэрэгний дугуйн ар талд зогсоцгоож, довтлон ирсэн Татарыг харвах нь харваж, илд сүхээр цавчин тулав.

ДОГШИН ШИРҮҮН ТУЛАЛДААН БОЛЛОО

Өгүүлэх нь: Гандсан өргөн талд үүл болсон тоос хийсэж их манарсан газар нь олон хүн цавчилдан эзэнгүй морьд нааш цааш давхиж шархадсан цэргийн ёолон бархирах байлдах цэргийн уурсан

хашхиралдах дуу сонстоно. Сүбээдэй баатар зуугаад шилдэг торгуудаар хүрээлүүлэн дов толгой дээр зогсож морьт цэргийг байн байн явуулж баатрууд яаж байгаа орос цэрэг дахин ирж байна уу? Ямар нэгэн талаас аюулгүй байна уу? гэж лавлуулбал явсан элч эргэж ирэхдээ монголчууд, энд тэндгүй ялж байна. Оросууд Днепр мөрний зүг ухарч тулах нь тулж, унах нь унаж шархадсан нь эсэргүүцэн тулсаар нэг ч хүн амиа гуйхгүй нэг ч хүн бууж өгөхгүй байна гэсэнд Сүбээдэй өгүүлрүүн:

— Чонын төрөлт, чоно шиг үхэг гээд, Киевийн цэрэг тэргээр хүрээлж, харвалдан тулж байгааг сонсоод, тэр хүрээний зүг цэргийг баг багаар явуулж «тэргийг хөмрүүл. Хүрээг сэтлэн шувтал. Эргэн тойрон гал тавь» гэж тушаасанд монголчууд, Оросын халхлах цэргийг түрж, зарим нь жад шидэж, зарим нь их нумаар хатан төмөр зэвтэй, цэцэн сум харваж, багласан хуурай зэгсэнд гал асаан өнхрүүлэвч, оросУУД Урьд хэвээр тулалдан эсэргүүцэж ойртон ирсэн морин цэргийг харваж, чулуугаар цохин тулах тул, Татар, Оросыг дийлж ядав. Үүнд Монголтой нийлсэн олон аймгийн хүн, Сүвээдэйн тушаалаар явгалж, Оросын хүрээний зүг тал талаас давхихдаа тахир илд, бялуу шийдмийг хурайлан бие биедээ зориг оруулж, дуу тавин бархиралдсаар тэрэг өөд авирцгаасанд оросууд урт иштэй сүх бороохой илдээр угтан тулж дайрагчдын толгойг хагар хагар цохин унагаасанд гурав хоногийн эцэст Сүбээдэй, хэрмэлийн дарга Плоскинийг дуудаж ирүүлбэл өндөр биетэй Плоскини урьд чийрэг хүн байсан нь өлсөж царай нь харлаад хөлөө дааж ядан явахад хоёр монгол цэрэг араас нь хутгаар чичин тууж ирсэнд Сүбээдэй өгүүлрүүн: Чи орос ах дүү нартаа очиж; сүх илдийг хая гэж хэл. Тэд гэртээ харивал хариг. Бид тэдэнд гар хүрэхгүй. Чи тэднийг үгэндээ оруулдаг бол би чамайг суллана гэвэл, Плоскини хөлийн төмөр тушааны гинжийг барьсаар Оросын хүрээний зүг чиглэхэд хоёр монгол хойноос нь дагаж, Плоскинийн хүзүүнээс уясан урт сурын үзүүрийг барьж явсаар Оросын хүрээнд хүрвэл Плоскини Оросын тэрэгнээс хэдэн алхмын өмнө зогсов. Оросууд тэрэг дээр гарцгааж, хүзүүндээ дөнгө зүүсэн эцэнхий хачин хүнийг гайхан үзэцгээж, зарим нь энэ адуучин Плоскини мөн байна. Урьд Киев хотод хивчаг адууг сүргээр тууж авчирдаг юм сан. Бас хивчаг хааны хэлмэрч явсан хүн гэж таньсанд Плоскини хашхиран өгүүлрүүн; Та нарыг битгий дэмий байлд гэж Татаарын хаан Сүбээдэй баатар надаар хэлүүлсэн. Та нар түүнд бууж өгдөг бол таныг дөрвөн зүг найман

зовхис тийш тавин явуулна гэнэ. Та нар, гагцхүү дээл хувцас, тэрэг сүх, хамаг юмаа хая. Татар аян замд удаж, хэрэглэл дутсан дээрээс түүнийг их хэрэглэж байна гэсэнд Оросын талаас зарим нь Плоскинийг чи урьд бидэнд хордсон морийг худал хэлж, худалдаж байсантай адил дэмий донгосож байгаа юм биш үү. Хар худалч минь гэлцэж, зарим хуучин цэрэг хашхиран өгүүлрүүн:

— Үүний үгийг бүү сонс. Бууж өгснөөс илдээ барин Днеприйг тэмцсэн нь дээр биз ээ. Чингэвэл, зарим хагас маань гэртээ хүрч магад. Сүх илдгүй бид цөм хүүрээ хээр тавина гэвэл, Плоскини, түмэн үнэн гэж тангараглаж, зүүсэн загалмайг өгч, уйлан өгүүлрүүн:

— Татар, миний араас хутгаар чичиж байхад, би үүнээс ондоогоор хэлж болох уу гэвэл, Татаарууд толгойгоороо дохиж, гарын эрхий хурууг дээш өргөн, бидний хэлмэрч зөв хэлж байна гэж дохилцов.

Чингэсээр хуучин цэрэг, хэдий татгалзавч, Киевийн их ноён Мстислав Романович, Татарт зэвсгээ хураалга гэж тушаасанд Киевийн цэргүүд, бие биедээ салах ёс хийж, мэхэсхийн ёслолцож ганц ганцаараа цувран гарч, зэвсгийг нэгэн газар бөөгнөрүүлэн хаяад гурван өдөр ус амссангүй тул хамгийн түрүүнд усны зүг гүйцгээв. Чингээд, сүүлийн цэргүүд хүрээнээс гараад, дал мөрний хөшөөг гаргаж, тоос бужигнуулан төрсөн нутгаа үзнэ гэж баярлаж, дардан замаар явтал, Татаарууд, хойноос нь давхиж хайр найргүйгээр цавчиж эхэлсэнд элчилгүй хөндий талын дунд хэн ч амьд үлдэхгүй байна гэж бодогдож орос нутаг хол зэвсэггүй, туслах хүн ирнэ гэж горьдох горьдолгүй болжээ.

Монголчууд, Киевийн ноёнтой хамт явсан арван нэгэн ноёныг ялган гаргаж Сүбээдэй баатрын найрт урьж морин цэрэг тэднийг нягтаар бүсэлж Татаарын хүрээний зүг аваачвал Сүбээдэй баатар бие хамгаалах хэдэн зуун торгуудаар хүрээлүүлэн Киевийн хүрээний захаар өнгөрөн орос цэргийг хүйс тэмтрэн хядахыг харж явав.

Зэвсэггүй оросууд чадал мэдэн тулалдаж чулуу бөөн хуурай шороогоор чулуудаж шархдагсад Татартай барилцан авалцаж морин дээрээс нь чирч унагаан тахир сэлмийг нь булааж аваад тулалдана.

Нэгэн өндөр орос хүрээнээс тэрэгний арлыг авчирч шийдэм болгож цохилцсоор нэгэн морин цэрэг ойртсоныг цохих гэтэл морины толгойг цохисонд тэр морь гэдрэгээ цоройж монгол хүний хамт газар унасанд тэр өндөр орос илдийг булаан авч унасан хүнийг цавчин алаад

морийг унаж илдээр нь үргэлжлэн цавчилцсаар манарсан тоосонд халхлагдан үзэгдэхгүй болов.

Хүчин дааНч тэнцүүргүй тул монголчууд дийлж байв. Сүбээдэй баатар дов дээр гарч тэндээс талын зүг замаар явж байна морин цэргийг үзтэл хойд зүгээс гурван хэсэг тоос манаран гарсныг бусдаас урьд ажиглан үзэж,

— Энэ юү билээ гэж хуруугаар зааж асуувал торгуудын зарим нь,

— Тогучарын монголчууд буцаж явна биз ээ гэж зарим нь хивчагууд үхэр тууж явна гэлцэнэ... Сүбээдэй өгүүлрүүн:

— Үгүй энэ шинэ цэрэг ирж явна. Цэргийг эгүүлэх бүрээг тат. Түргэн дуудан эгүүл! Үхсэн оросын гутлыг тайлахыг зогсоо. Дахиад байлдаан болно гэвэл бүрээ хангинан тулалдаан болж байсан зарим газар жанжны бүрээн дохиог сонсоод монгол цэргийн бүрээч нарын бүрээ татсанд Монголын морин цэргийн зарим нь тулалдан байгаа оросуудыг хаяцгааж дов тийш, таван хөлт тугаа босгож морин дээрээ хүн чулуу адил хөдлөлгүй байгаа жанжин Сүвээдэйн зүг яаран давхив. Тэр завсар хойд зүгээс гурван хэсэг тоос манарч улам бүр ойртсоор тоос нь аажмаар дээшээ дэгдэж замхран үгүй болов. Сүбээдэй тэр зүг дуунгүй ширтэн дэргэд байгаа торгууд цэрэг хоорондоо аяархан хэлэлцэж - гурван баг цэрэг ирж явна. Хэрэв хивчаг бус ахул орос цэрэг байх биз ээ. Тэд одоо хулс зэгс ургасан намгийн дундуур явж байгаа. Чингээд шороо тоосгүй болов. Харав уу. Тэр гарч ирэв гэлцэв. Дэрс ургасан газрын бургас шугуйн цаанаас цагаан ба шаргал морьтой цэрэг гарч ирээд газар дороос гарч байгаа мэт улам бүр нэмэгдэн нэмэгдсээр талыг дүүрэн бүтээж нэгэн хэсэг үе жагсаалаа жигдэлж түр зогсоод нум мэт жагсаад алт гялалзсан гурвалжин хар тугийн хоёр хажуугаар хоёр гурвалжин улаан туг үзэгдэв.

Зэвсэггүй улаан нүцгэн гартай Киевийн оросуудыг дардан зам дээр цавчин хядаж байсан татаарууд, шинэ цэрэг ирснийг удтал мэдсэнгүй, цавчилдсаар яван яван баруун Днеприйн зүг ойрттол... шинэ ирсэн цэргийн дунд тал нь гэнэт ухасхийж, чих дөжрөм их дуугаар хашхиралдан давхилхилж, тулалдааны хамгийн их зууралдан байх газар чиглэн ороход цэргийн баруун гар нь тасарч, цааш баруун зүг давхилдсаар тулалдан байгаа цэргийг бүслэхээр давхилдсанд зүүн гарын цэрэг, гүйдлээр улам ширүүлсээр, хүнд аажмаар чиглэж, Сүбээдэй баатрын байсан довын зүг хандсанд өвгөн жанжин хоромхон зуур түдгэлзээд, «намайг дага» гэж хашхирч, жороо морио ташуурдаж,

дов дээрээс агшин зуур бууж, Тогучар ноёны цэрэг байсан зүг давхивал нэг ч хүнгүй Тогучар ноён, цэрэг сэлтээр байлдаанд цавчилдан орсон тул Сүбээдэй цааш давхивал, оросууд түүнийг хөөн нэхсэнгүй мурийлан тойрч, Днеприйн зүг ухран зайлсан Киевийнхнийг туслан тэнхрүүлээр зууралдан тулалдах газар давшицгаасанд Сүбээдэй баатар, морины амыг татаж зогсоод, хэдэн элч довтолгож, их замаар цувалдсан монгол цэргийг дуудан эгүүлж, шууд Калк голын эрэг дээр хүрч ирцгээ гэж зарлаж өгүүлсэн нь, Одоо дээр, ялалт манай тал дээр байна. Орос бол чоно мэт үржилтэй аймаг! Хээр талаас бас нэгэн баг орос цэрэг гарч ирээд, манай нутагтаа буцах замыг хааж болзошгүй. Морины жолоог нутгийн зүг залъя гэжээ. Зэв ноён, гурван зуун морьт цэргийг дагуулж, морь юүлж давхисаар, Днепр мөрөнд хүрч ирэв. Түүнийг дагаж явсан хэлмэрч, хэрмэл Плоскинийн шархадсан оросоос эрэлхэг Мстислав хаана вэ гэж асуувал зарим нь түүнийг галзуу буурал азаргаа унаад, хуй салхи мэт давхиж явахыг үзсэн гэнэ. Чингэж явсаар Зэв ноён, Днеприйн хөвөөнд хүрч үзвэл, нэгэн хар онгоц эргээс холдон одсонд, Мстислав ноёны улаан нөмрөг үзэгдэж, ноён онгоцны хитэгт сууж, онгоцны хойноос самрах азаргынхаа цулбуурыг барьж, үдшийн нарны гэрэлд алтан дуулга нь гялбалзан гялалзаж дарагдсан ноён «муу эрэг»-ийн зүг угтан харалгүй явахад Зэв ноён сумны сайныг авч, хатуу шар нумдаа онилоод мэхийтэл татаж харвавал, онгоцонд хүрэлгүй усанд туссанд Зэв ноён мориноос бууж, түрүүлгээ унаад толгойг барин, тэсгэлгүй хорсож, гандсан шар ногоог уурсан зууж босоод, улаан нөмрөгт ноёны онгоц холдон зайлахыг бас нэг ширтэн харж, хорслоо гаргасугай гэж тахир илдийг суга татаад, одоо нэгэнт хэрэггүй болсон, хэрмэл Плоскинийг хэдэн анги болтол тасар цавчиж алаад, хонгор мориндоо мордож, замаас холдон, үй түмэн хүн бужигналдаж, тоос манаран, сүүлийн тулалдаан болж байсан, хөдөө талын зүг давхин одов. Үүнийг үл өгүүлэн өгүүлэх нь: Калк голын дайн, урт их дардан зам дээр орос олон баатар, сайн эр, энгийн эр цэрэг их л үхжээ. Тэд бол бууж өгсөн Орост, гар хүргэхгүй гэж ам алдаж, мэхлээд, зэвсэггүй болсон, Киевийн цэргийг хядаж байсан Татараас тэр улаан гартай Киевийхнийг салгаж авъя гэсээр үхсэн билээ. Энэ тулалдаанд амиа өгсөн Ростовын баатар алтан бүст Алёша Попович, түүний залуу туслах сайн Еким Ивановичийн зэрэг Суздал, Муром, Рязан, Проны зэрэг умар зүгийн баатар сайн эрсийг орос хүн хэзээ ч мартахгүй. Их зүрх гаргаж, шувтлан байлдсан орос цэрэг, зэвсгээ хаялгүй явсаар

Днепр мөрнийг хүрсэнд тосон хүлээж байсан олон онгоц, завь тэднийг мөрний тэртээ гаргав. Татаарын үгэнд орж, сүх илдээ хаяцгаасанд бараг төлөв алагдаж, хуучин дуунд дуулдаг шиг,

Хүйлэн хөх чонын хүнс
Хар хэрээний идэш болжээ.

Холын бодлогогүй, атаа жөтөөтэй орос ноёд, өөр зууpаа эвдрэлдэн маргалдаж, хүчнээ нийлүүлэн бат чийрэг нэн их орос цэрэг болгохыг үл хүссэн дээрээс алс холын дардан их зам нь ялгуусан их зам болохын оронд нус нулимсны зам болж, баатар зоригт орос цэрэг түүнийг аль улаан цусаарaа сүрчиж, цагаан ясаарaа хучжээ.

ТАТААРУУД, ХУНИЙ ЯСАН ДЭЭР НАЙРЛАСАН НЬ

Ноёдыг барьж, хавтгай модон дор тавиад, дээр нь сууж найрласанд тэр ноёд, насан эцэс болов.
(Оросын Тройцын хийдийн судар түүхээс)

Өгүүлэх нь: Сүбээдэй баатар, Калк голын захад өндөр их овооны дээр мянгатан, зуутан ноёдоо цуглуулж, сагсгар үстэй, баргар царайтай бегийн үгээр сүлд тэнгэрийг тахив. Өвгөн бөө, шовгор малгай өмсөж, баавгайн арьс хэдрээд, хутга холбог зүүж, их хэцийг дэлдсээр дэвхцэн бүжиглэж, Татаарын үгэнд орсон гэнэн сэтгэлт Киевийн их ноён Мстислав Романович нарын 11 ноёдыг тойрон харайлахад, Татаарууд толгойг гэхэж шагшилцан, тэднийг үзэцгээхдээ «Конас Метислав» эдний дунд байдаггүй нь харамсалтайяа гэж Оросын алдарт их «Зэв ноён»-ыг үзэх сэн гэнэ.

Беги бөө дуудлагыг уншиж, ус болсон нүүртээ хэцийг тулгаж, богширго мэт жиргэн, шар шувуу мэт дуугаран, баавгай мэт хүрхэрч, хөх чоно мэт улих нь монголд дайсны дарж өгсөн сүлд тэнгэртэй үг хэлэлцэн байгаа байдлыг дүрсэлж, тэнгэр хилэгнэж байгааг та нар сонсов уу? сүлд тэнгэр дахин өлсөж, хүний махан дайлга хүсэж байна! гэж бархирна. Үүнийг түр үл өгүүлэн, өгүүлэх нь, мянга түмэн олон татар цэрэг, тал газар овоог хүрээлэн бууж, энд тэндгүй гал түлцгээж, байдсан залуу гүүг нядална. Зарим нь Оросын тэрэг сүйхнээс авсан арал, банз авчирч хүлж хаясан орос ноёдын дээр овоолоод, Татаарын гурван зуун ноён тэр банзан дээр бууж, айрагтай аяга барьж Монголыг

ивээгч догшин сүлд тэнгэрийг магтан «дэлхийг донсолгогч» улаан сахалт ялагдашгүй Чингис хааны алдрыг мандуулан магтана. Оросын их сурвалжтан ноёд, амиа зольё гэж их мөнгө эд амлавч, Татаарууд түүнийг үл хэрэгсэн, тэнгэрээс заяасан Чингис хааны өөдөөс аймшиггүй халдсан эдгээр ноёдоор сүлд тэнгэрээ тахина гэжээ. Банзны дороос няц дарагдаж байгаа орос ноёдын гаслах, ёолох, хараах дуу гарахад Монголын олон баатар нижигнэтэл инээлдэж, банз дороос гаслах гашуудах дуу намдсаар монгол цэргийн баярлан найрлах дуу тэр гашуудах чимээг даржээ.

Монгол цэргийн тэр дууны үг:

Монголын хээр тал,
Хөх Хэрлэн,
Алтан Ононыг
Санан дурдъя.
Эс дагасан аймгийн
Эчнээн олны
Тоосыг монгол цэрэг хийсгэв
Товрог болгон сөнөөв.
Үхлийн аюул түгээгч
Чингис хааны хөвүүд
Үй олон улсад, гал усны зовлонг
Чирэн учруулна бид.
Арын дөчин цөлийн элс,
Аймхай уулгарын цус бялдав...

гэж дуулцгаана.

Ийнхүү найрлатал, Тогучар ноён босож, их авд олон номтныг дуудах уриаг исгэрсэнд, тэр уриаг сонсмогц цөм нам гүм болов. Тогучар ноён, олны зүг хашхиран өгүүлрүүн,

— Их Чингис хаан бол, хар тэргүүт бүхний манлай мэргэн ухаантан мөн. Тэр бол зуун хоногийн өмнөх хэрэг, мянган жилийн цаадах явдлыг нэвт тольдоно. Чингис хаан, намайг нэг түмэн баатрыг дагуулан явуулж, Зэв ноён, Сүбээдэй баатар хоёр ялагдашгүй барс мэт жанжныг олж ир гэж, одуулав. Хаан надад захихдаа, та нарт хүргэх бэлгийн дээд бол харьтан дайсантай тулахын цагт хамсан туслах цэрэг явуулах нь бэлгийн дээд гэсэн билээ гэхэд олон монгол цөм зөв зөв гэж хашхиралдвал, Тогучар ноён өгүүлрүүн: Бид түдэн сааталгүй маш олон

улсыг өнгөрөн гарч, явсан газар бүхэндээ Монголын мохошгүй илдийн ор сорвийг үзсэн. Биднийг, Зэв Сүбээдэй хоёр алдарт баатар хаана вэ? гэж асуувал, айл гэрийн айн цочсон хүн, санд мэнд сөгдөж гараар баруун зүгийг зааж дохих бүлгээ. Бид өнөөдөр энэ тулалдааны өмнө хүрч ирээд миний түмэн цэрэг тулалдаанд шурган орсон билээ. Чингээд бид хамт хүчнээр урт сахалт оросыг түргэн дарав... гэсэнд зарим нь

— Алдар нэр чинь мандаг, Тогучар минь! Чи цагийг сайхан олж ирэв! гэжээ.

Тогучар ноён үргэлжлэн өгүүлрүүн: Дэлхийн их эзэн Чингис, та бүгдийн хойноос санаа тавьж, зарлигаа уламжлан хүргүүлэв. Тусгай элч эзний зарлигийн бичгийг авч явахад миний түмэн цэрэг түүнийг алмаас эрдэнэ мэт сахин хамгаалж, энэ газар эсэн мэнд бүрэн бүтэн хүргэж ирэв. Тэр элчийг үзэгтүн энэ байна! гэвэл, начин шонхрын өрөвлөгийг малгайдаа хадаж, хонх холбог зүүсэн, майга хөлтэй өвгөн монгол гарч Сүбээдэй баатрын өмнө очоод тийз тэмдэг дарсан бичгийг хадгалсан арьсан дугтуйг өврөөс гаргаж Сүбээдэй баатарт баривал лавын тийзийг салгаж лалын турбан малгайтай буурал сахалт өвгөн бичээч захидлыг дэлгэж аман дотроо уншаад Сүвээдэйн чихэнд шивнэн хэлбэл Сүбээдэй баатар босож хашхиран өгүүлрүүн;

Их хааны зарлиг хичээнгүйлэн сонс! гэсэнд цэргийн олон ноёд цугаар босов. Үүнийг үзээд бусад татар хүн цөм босоцгоосонд татар ноёд цөм сөгдөн мөргөсөнд хүрээний цэрэг даяар сөгдөн мөргөж толгойг өндийлгөн их хааны зарлигийг бид дагая гэж хашхирвал Сүбээдэй баатар өгүүлрүүн: Ялагдашгүй хосгүй эзний зарлиг "энэ бичгийг хүлээн авмагц морины жолоог нутгийн зүг зал. Дэлхий дахиныг байлдан дагуулах үйлсийг зөвлөх их хуралд ирэгтүн. Дээр хөх мөнх тэнгэр, доор алтан дэлхий дээр тэнгэрийн бошигт хаан бий. Одон гарагийн тохиолыг эзлэгч эзэн хүний эрхтийн тамга" гээд Сүбээдэй баатар мөргөн сөгдөн олон Монголын нурууг нэг ширвэн үзэж өгүүлрүүн: Одоо миний хэлэх үг намайг сонс! гэсэнд бүгдээр дэншээ өндийж сөгдөөд өрөөсөн гаргүй барсаа ширтэж амьсгалаа хураан сонсвол,

— Бид өнөөдөр найрлан хуримлаад маргааш өглөөний мандах улаан нарнаар эзэн богдын алтан өргөөний зүг эргэн буцна. Хожимдсон хүнийг хөвчдөн ална гэсэнд олон цэрэг тэсэлгүй

баярласандаа бархиралдан хашхирч дахин тавтай сууцгааж найр, хуримаа хийж дуу дуулалдан хашхиралдан шуугилдаж цэнгэлдэв.

Маргааш өглөө нар тахиж айраг сацан мөргөөд монголчууд мордож сүрэг малаа тууж эцэж зүдэрсэн уранхай навтархай хувцастай олзны олон хүнийг хөөн хөдлөв. Дээрэмдэн олсон их олз, хүнд шархтай Монголчуудыг ачсан олон хасаг тэрэг тал дүүрэн хяхнаж, тоос манараад, их цэргийн өмнө Сүбээдэй баатар түрүүлэн явж, уутан дотор Киевийн ноён Мстислав Романовичийн толгой түүний зүүж явсан оосортой алтан загалмай, өмсөж явсан алтан шармал болд дуулгыг авч явсандаа сэтгэл дүүрэн баярлаж, дэлхийг донсолгогч, ялагдашгүй Чингис хааны алтан ширээний өмнө эрдэнэ мэт чухаг тэр уутаа дэвшүүлэн өргөнө гэж санахдаа Сүвээдэйн сорви болсон, хир ургасан нүүр нь маасганан инээмсэглэж явав. Цэргийн сүүлд баргар царайт Зэв ноён, зуун туршуулаа дагуулан явах нь биедээ олзны эд огтгүй, гагцхүү Монголын уудам хээр тал, хөх Хэрлэн, алтан Ононыг магтсан дууг салхины шурхирах мэт гунилтай урт аялгуугаар эгшиглэн татаж явна.

Монголчууд ийнхүү аялсаар зүүн хойд зүг Ижил мөрнийг чиглэж тэндээс Уралын уулсын өмнөх захаар Хоресмийн тал газар зорьсонд хивчаг нутаг Монгол Татаарын аюулт их цэргээс ангижирч Монгол, Татаарууд анх ирсний адил гэнэт алга болжээ.

Монголын явсны сүүлээр зарим хивчаг аймаг сүйд болсон нутаг бууцандаа хүрч ирээд зарим нь унгар нутаг Дунай мөрний адаг тийш одов. Чингээд орос хивчаг ноёд татар дахин ирэхгүй гэж санаа амарч хуучин хэрүүл тэмцлээ хийсээр өдөр цагийг дайнд бэлдэлгүй өнгөрөөж Чингис хаан өмнөөс нэн сүрхий их довтлолыг баруун зүг явуулсугай гэж бэлтгэн байгааг огт мэдсэнгүй.

ЕС ДҮГЭЭР БҮЛЭГ : ЧИНГИСИЙН ЭЦЭС БОЛСОН НЬ

ЧИНГИС ХААН МОРИНЫ ЖОЛООГ НУТГИЙН ЗҮГ ЗАЛУУЛАВ

Өгүүлэх нь: Желал-Эд-Дин Султаныг их зүрх гаргаж дутаасанд Чингис хаан, түүний хойноос шалгарсан хоёр жанжин Бол ноён, Дурвай баатар хоёрыг Султаны хойноос Энэтхэг газар явуулбал тэр хоёр тус тус замаар давхин нэхэвч Султан сураг танаггүй болжээ. Үүнд монгол цэрэг явсан замдаа талан сүйтгэсээр Желал-Эд-Дин Султаны холбоотон Аграг хаан, Азам Мелигийн харьяат хотыг түймэрдэн сүйтгэж харвах дүгрэг чулуу чөдөр оньсыг сал хийж ачаад Синд мөрнөөр урсган уруудаж Мултан хотод хүрч ирээд тэр баян хотыг чулуу харвах, чөдөр оньсоор харваж эхлэвч, хотын хэрэм халдашгүй бэх бат бас туслан өмгөөлөх энэтхэг цэрэг үргэлжлэн ирж цаг улирал тэсгэлгүй халуун тул, нэхий дээл, саарь сармай өмссөн монголчууд хотыг бүслэн байлдахыг зогсож Чингис хааны зүг ууланд авиран гарлаа.

Их хааны бие халуунаас зайлж өндөр уулсын дунд үүлсээр хүрээлсэн нэгэн гацаанд цэргийн явдлыг умартан орхисон мэт сул сууж орой нь найрлан хуримлах үес перс хятад дуу дуулах дууч эмс үлгэр тууль хэлэх үлгэрчин туульчийг сонсох бүлгээ. Хятадын нийслэлээс хоёр жил явж сая хүрч ирсэн хятад бүжигчин эмс алтан өнгөт торгон хувцас өмсөж улбар ягаан афган хивс дээгүүр гүйлдэж өргөн далавчит жигүүртэн шувууны нисэхийг дуурайн урт ханцуйгаар дэвэлхийлэн дэрвэж могойг дуурайн мушгиран мурилзаж олноор хуйлран задран наадах бүлгээ. Үүнийг үл өгүүлэн, өгүүлэх нь: Чингисийн бага хөвүүн Хүлгэн, эх Хулан хатны хамт энэ газар өвчин олж торгон дэр дэвсгэр дээр дээлээр хучуулж хэвтэцгээн нэг халууцан нэг жихүүцэн даарна. Чингис хаан тэр хоёрын дэргэд өдөр бүр ирж аманд чихэр хийж хажууд суугаад өнөөдөр бие чинь хаана өвдөнө гэж асуувал Хулан хатан уйлж бүх бие өвдөнө гэж өгүүлрүүн: Энэ газрын эзэд энэ догшин газар, суусан хүнийг зовоож байна. Уулын гүн хавцлаас дэгдэн гардаг манан буданг чи үзсэн биз ээ. Тэр манан будан бол чиний цэрэгт алагдсан нялх хүүхдийн сүнс, бяцхан хүлгэн бид хоёр лав энд үхнэм зээ. Манай хөх Хэрлэн голын рашаан ус сая манай өвчнийг арилган чадна. Биднийг Монголын сайхан нутагт маань буцаа гэвэл Чингис хаан уурсаж надгүй чи ганцаар явж болохгүй. Би явъя

гэхүл дэлхийн нөгөө хагасыг бас эрхэндээ оруулах хэрэгтэй гэхэд Хулан хатан улам ихээр уйлна. Үүнд Чингис хаан өөрийн их зөвлөх Зөрчидийн Цоо мэргэний хойноос явуулбал Цоо мэргэн нэгэн их ном гартаа барьсаар ирсэнд Хулан хатан түүнийг үзмэгц номыг булаан авч хивс дээр хаяад дээрээс нь хэвтвэл Чингис хаан өгүүлрүүн: За бид одоо тэнгэрийн тааллыг мэднэ үү гэвэл Хулан хатан өгүүлрүүн: Би юу болохоо мэдэхийг хүсэхгүй цөм миний хүслээр болно. Би хүсэхдээ Хэрлэн голдоо буцах гэж байна. Манай цэргийн хүн цөм ийм хүсэлтэй гэсэнд Чингис хаан хөмсгийг нэг буулгаж нэг сөхөж эцэс сүүлдээ аргагүй хэлсэн нь, үүний өмнө миний дийлэхгүй эсэргүүцэл байсангүй. Одоо би үхлийг эрхэндээ оруулъя гэж байна. Хүний үг дагадаггүй, санаа амар Хулан хатан чи, миний дэргэд байвал, эрлэг чамд халдаж чадахгүй, чи надаас холдвол идээн доторх нууц хор, харанхуй шөнө туссан сум чиний амийг чинь авна гээд Цоо мэргэнд өгүүлрүүн: Чи мөнх наслуулахын рашаан ундыг найруулж чадах эрдэмтэн мэргэд, эмч оточ, бөө удганыг олж өгнө гэсэн биш бил үү. Тэд одоо яасан юм бэ гэвэл Цоо мэргэн өгүүлрүүн: Тэдний хойноос чадалтай хүнийг явуулсан тул удахгүй ирэх биз ээ. Чи цэргээ дагуулан маш хурдан явах тул чиний хойноос хүн гүйцэн ирж чадахгүй болжээ, гэжээ. Үүнийг үл өгүүлэн, өгүүлэх нь: Чингис хааны үзвэл, Хулан хатны өвчин улам их болж, үзэсгэлэн гуа нь хурднаа дарагдан буурч, бяцхан Хүлгэн хүү, бас эхийн хажууд бие торчгор, царай цайвар болж хэвтэх тул Чингисийн сэтгэл санаа зовж, амаргүй болов. Чингээд үхэл зовлонг байн байн дурдан ярьж, эмч оточ нараас нас уртатгах эмийг сураглан асуувал, олон хүн хувилгаан чадалтай элдэв эм унд бий гэхэд Чингис тэднээр эмийг найруулан хийлгэж өөрсдөд нь уулгаад үхэх болов уу, үгүй болов уу гэж тэдний толгойг цавчиж үздэг билээ.

Энэ завсар Цагаадайн хөвүүн, Чингисийн хайрт ач Мутгенд Балтаны цайзыг байлдахад дайсны чөдөр оньсоор харвасан жад мэт их сум туссанд Чингисийн сэтгэл ихэд гутрав. Мутген бол бүх лал газрын их хаан болох хүн билээ. Гэтэл нэгэн зэрлэг суманд тусагдаж наснаас нөгчжээ. Үүнд Чингис хаан, үхэл гэгч нэгэн хүнийг дайрвал үхээд, нэгэн хүнийг онолгүй өнгөрвөл, өтөлтөл эрүүл мэнд суудаг нь сохор ингийн тийрэх адил болзошгүй мухар сохор хэрэг мөн байна гэж мэдээд, хайрт ачаа үхсэнд тэсгэлгүй хорсож, Балтан хотыг зогсоогоор дайрна гэж тушаасанд монгол цэрэг хэрмийг эвдэж, хотод ороод, хотын олныг цөм хядав. Чингис хаан нэг ч хүнийг олзлон авч болохгүй гэж,

нэг ч амьтан бүү сууг гэж орчин тойрныг үнсэн товрог болгож, тэр газрыг «муу дов» гэжээ. Тэр цагаас хойш хүн амьтан тэнд суухыг байж газар тариалан нь зэрлэгшив.

Чингис хаан, уулын орой дээр халил эргийн зах дээр тавьсан шар асрын хажууд өдрийн турш сууж, холхийг анхаарвал, хөлийн дор ёроолгүй гүн хавцал харлаж, алсад цаст уулсын оргил, сүртэй их шил нуруу, манан будан татуулан үзэгдэх бүлгээ. Чингээд бас заримдаа Чингис хаан, сайн газарч нарыг дуудан ирүүлж, Энэтхэг Төвөдөөр дамжин монгол нутаг буцах дөт замыг асуух ажгуу.

Цэргийн хүрээнд даашгүй их олзонд дарагдсан цэргүүд нутагтаа буцахаас өөр юмыг хэлэлцэхгүй болжээ. Чингээд үүнийг догшин хаанд хэлэх зүрхтэй хүн нэг ч үгүй, хааны чухам санаа бодол ямар болж, маргааш ямар зарлиг тушаал буулгахыг мэдэх хүнгүй, цэргээ нутагтаа буц гэх үү? аян замд дахин явуулж өчнөөн төчнөөн олон улсыг өдий төдий олон жил дамжиж дайралдсан улсаа хүйс тэмтэрч, гал түймрийн утаан дундуур бас хэчнээн жил хэрэн явахаа мэдэх хүнгүй билээ.

Агт адуунд идэх өвс бэлчээр ховортой Афган уулсын хавцалд удаан байсан дээрээс, олон цэргийн дотор гомдол гардаг болов. Үүнд: Хулан хатан, хааныг нутагтаа буцах тийш хандуулж үзье гэж их зөвлөх Зөрчдийн Цоо мэргэнтэй шивнэлдэн хэлэлцээд нэгэн үлгэр зохиосон нь Цоо мэргэн арга зохиож тэр үлгэрийг зүрх ихтэй хоёр баатар нөхөр цэрэгт зааж, Чингист хэл гэсэнд тэр хоёр монгол, сургаалыг дагаж, маш гайхамшигтай чухал зүйлийг Чингист сонсгох хэрэг бий гэж бараалхахыг хүсэн гуйсанд Цоо мэргэн тэр хоёрыг Чингисийн өмнө оруулбал, тэр хоёр өгүүлрүүн: Бид ууланд төөрөөд, нэгэн сонин гөрөөс үзэв. Байдал бугын адил, өнгө ногоон, сүүл адууны адил тэргүүнд ганц эвэртэй тэр гөрөөс биднийг үзээд монгол үгээр өгүүлрүүн: Танай хаан монгол нутагтаа буцах цаг ирэв гэжээ гэсэнд Чингис хаан тэр үлгэрийг ажиггүй сонсоод, сөгдсөн хоёр баатрыг ширтэн үзэж асууруун: Та нар тэр гайхамшигт гөрөөс үзсэн өдөр айраг их уув уу гэвэл, хоёр баатар ам алдан өгүүлрүүн: Бид айраг олж ууя гэж хэдий хүсэвч, мэлцийм нүцгэн хад чулууны дунд айраг байтугай, ямааны сүүг ч олохуйяа бэрх гэж эрхий хурууг өргөж ам алдахад Чингис хаан, Цоо мэргэнээс чи тэнгэр газар далайн нууцуудыг мэдэх судар номыг мэднэ үү. Ийм гөрөөс номд гарав уу гэвэл, Цоо мэргэн, дэлхийн олон гөрөөс жигүүртэн загасны зураг бүхий ном авчирч үзээд өгүүлрүүн: Ийм

ховор гөрөөс үнэн бий. Нэр билигт гөрөөс гэнэ. Дэлхийн түмэн улсын үгийг мэднэ. Манай хоёр баатарт үг хэлсэн нь ертөнцөд хэтэрхий их цус урсгасныг заажээ. Чиний их цэрэг баруун зүгийн улсыг дагуулан байлдсаар одоо дөрвөн жил болов. Хөх мөнх тэнгэр, олон амьтны амийг таслан алах нь завсар сэггүй болов гэж билигт гөрөөсийг чамд явуулж ухуулав. Эзэн чи энэ улсын хүнийг өршөөн хэлтрүүлж, тэнгэрийн тааллыг дага. Чингэвэл, чиний буян хутаг хязгаарлашгүй болно. Тэнгэрийн тааллыг эс дагавал, хилэгнэж аянга буулгана гэж Хятад, Монголын энэ сударт тайлжээ гэж залбирал үйлдэх лам адил, маш ихэмсэг байдлаар өгүүлбэл, Чингис хаан, нэг нүдийг аньж, зөвлөхөө ширтээд сөгдөн зогсогч хоёр баатрын зүг үзэж, нэгийг ойртуулан ирүүлж, чихэнд нь үг шивнэн хэлж, хариу үг мөн шивнэ гэснийг сонсоод, нөгөө баатрыг дуудаж, мөн нэгэн адил асуугаад сэтгэл их л ханасан мэт байдал үзүүлж, хоёр баатрыг явуулахдаа, энэ хоёрт айргийг цадтал уулгагтун гэж тушааж зөвлөх сайд Цоо мэргэнд өгүүлрүүн: Энэ хоёр баатар, самбаатай сэцэн хүн мөний тул, өргөн дэвшүүлэлтэй. Би энэ хоёрыг нэг нэгээр цувуулан, билигт гөрөөс хэрхэж явсан бэ? гэж асуувал нэг нь хатирч явсан гэв. Нөгөө нь жороолж явсан гэв. Монгол хүн хэдий согтовч, гөрөөсний явахад хатирах жороолохыг осолдох ёсгүй. Би учрыг мэдэв. Манай цэрэг дайн хийхээс хаширч, нутгаа санаж байна. Тийм дээрээс, намайг заясан тэнгэр надад билигт гөрөөс явуулж, тааллаа нэвтрүүлсэнд, би дагаж, цэргийг нутгийн зүг хандуулан язгуур улсдаа буцъя гэсэнд олон цэрэг хойд өдөр нь Чингисийн чингэж тогтсоныг мэдээд, тэсгэшгүй дэвхцэн баярлаж, дуу дуулцгаан, буцах аянд зэхэв.

Чингис хаан, анханд Энэтхэг Төвөдөөр өнгөрөн гаръя гэж бодож, Дели хотод Энэтхэгийн Илдудмиш хаанд элч одуулсанд уулсын дабааны зам, цасанд дарагдсан нь зам хараахан нэвтрээгүй, Иллудмиш хаан хариуг саатуулж, цэрэг хуралдуулан татаж, Желал-Эд-Динийг жанжин болгосон билээ. Энэ завсар Монголоос мэдээ ирсэн нь насад тэрслэх Тангад улс, бас дахин бослого гаргажээ гэдэг мэдээ ирээд зөвлөх сайд Цоо мэргэн одыг шинжиж олон бөө нар мэргэлбэл, буцах замд Энэтхэгээр нэвтрэн гарахын хэрэггүй гэх тул, Чингис хаан, хуучин замаар буцахыг тогтож, зам гудасын дабааны цасыг нутгийн ардууд Чингисийн тушаалаар арилгаж хаврын эхээр монгол цэрэг нутагтаа буцах аянд мордов.

ЧИНГИС ХААН, ГУЙЛГАЧИН МЭРГЭНТЭЙ ХАРИЛЦСАН НЬ

Өгүүлэх нь: Чингис хаан, хэдийн хар Эрчиш голын эхээр нутаглах үес биеэ засаж, нас уртатгахыг хүсэж сайн эмч нарыг сураглавал, тэнгэр газрын нууцыг мэдэж мөнх насны аргыг олсон гайхамшигт мэргэн эрдэмтэн бий гэж сонссон билээ. Их зөвлөх сайд, зурхайч Цоо мэргэний хэлсэн нь: Чан Чун бол үнэхээр сайд эрдэмтэн. тэнгэр нартай хамт оршин, тогорууг хөлөглөн ниснэ. Дүрсийг хувилгаж, элдэв амьтан болж чадна. Ертөнцийн жаргалыг тэвчиж, үхэлгүйн шид, урт насны хутгийг олгогч, шидэт «их улаан»-ыг эрж, олон эрдэмтний хамт гүнээ ууланд оршино. Бясалгал үйлдэж, заримдаа хүүрийн адил хөдлөлгүй сууна. Заримдаа зоосон мод мэт, хэдэн өдөр хөдлөлгүй зогсоно. Дугарвал аянга мэт, явбал салхи мэт хурдан, үзсэн нь үлэмж, сонссон нь их, эс туулсан номгүй гэсэнд, Чингис хаан, энэ гайхамшигт өвгөнийг олсугай гэж итгэлт хэдэн сайд Лиү Жүн Лиүг барсын тэргүүтэй алтан пайз өгч явуулав. Лиү Жүн Лиү, Чан Чун эрдэмтэнд Чингисийн явуулсан захиаг авч, эрдэнэ мэт хадгалан явжээ. Чингис, бичиг үл мэдэх тул, зөвлөх сайд Цоо мэргэн бичсэн билээ.

Тэр бичгийн үг

Тэнгэр, Хятад улсыг зан их хэтэрхий хээнцэр гэж тэвчжээ. Би умард говь газрын хүн, сэтгэлд ужид самуунгүй.

Ариун хөнгөмсөг занг бахадна. Хээнцрийг тэвчиж, шулуун төвийг эрхэмлэнэ. Миний өмсөх нь ганц бөс хувцас, идэх нь нэгэн зүйл идээн. Хоолыг голох сонжихгүй идэж, хувцсыг адуучны адил өмсөнө.

Долоон насандаа би их үйлс бүтээгч дэлхийн улс бүхэнд засгаа тогтоон явуулав. Дээр эртний үес, манай татар өвгөд нүүдэл аймгийн Шан Юүй нар дэлхийг байлдан эзэлснээс нааш миний улсын адил их улс гарсангүй.

Миний тушаал эрхэм, үүрэг чухал, гагцхүү эмээх нь миний засагт нэгэн зүйл дутах болуужин гэнэ. Онгоц баривал, гол мөрнийг гаталсугай гэж сэлбүүрийг хийнэ. Дэлхий дахиныг дагуулан захирсугай гэвэл, эрдэмтнийг урьж, туслах хүнийг сонгон хэрэглэнэ. Багш чиний бие, үнэнийг эрхэмлэж, их ёсыг дагаж журамладгийг би мэдэв. Чиний эрдэм их, үзсэн нь үлэмж, хууль ёсыг гүнээ судалжээ. Уул хавцалд эртнээс нааш оршиж ертөнцөөс зайлжээ. Гэтэл, би яах бил ээ? Бид хоёрын хооронд дахь уул хөндий, алс холын учир, уулзан ул чадна. Иймийн тул, би шадар сайд Лиү Жүн Лиүг сонгож гавшгай морьтныг бэлтгэж, жууз тэрэг олов. Багш, чи, олон мянган газрыг

алс гэж бэрхшээхгүй, нааш ирнэ үү. Элсэн говийн хол ихийг бодолгүй, миний улсыг энэрэгтүн. Эсхүл, намайг өршөөн үзэж, амь насыг уртатгах арга зааж өгнө үү.

Чиний бие, их ёс төрийн мөн чанарыг мэдээд сайныг хөхиүлэн, миний хүслийг цааргалахгүй биз ээ. Миний энэ зарлиг чамд бүрнээ ойлгомжтой болов уу

гэжээ.

Лиү Жүн Лиү ийм бичгийг гартаа авч, уул говийг дамжин замнасан алс холын замд мордож, хааны тааллыг түргэн биелүүлэхийн тул, өртөө бүр дээр морь сольж, маш яаран довтолсоор, хятад нутагт хүрч, өндөр уулын нэгэн бэрх хавцлаас уранхай навсгар хувцасны тамтаг нөмөрсөн туранхай хатанги биетэй, буурал болсон өвгөнийг олж уулзав.

Тэр нь алдартай мэргэн Чан Чун байжээ.

Чингис хааны бичгийг уншаад, анхандаа түүнтэй уулзахгүй гэж эрс шууд хэлээд, дараагаар бичгийн хариу бичсэнийг Лиү Жүн Лиү тусгай элчид авхуулан, их хаанд яаравчлан хүргүүлээд, өөрөө хааны уур хилэнгээс айж, бас, Чан Чунг үгэндээ дагуулан оруулж болох бол уу? гэж тэрхүү ахлагч өвгөний дэргэд үлдэв.

Хятадын мэргэний бичсэн захидлын үг

«Ёс төрийг эрхэмлэн зорьж, гүн уулст оршин суух мөхөс Чан Чун миний бие, алс холоос ирсэн дээд зарлигийг сая хүлээн авав. Далайн зах дахь болхи хятад хүн, омог бардам тул, мунхаг ажээ. Мөхөс бие, энэ насны явдалд моходог ёс төрийг судлах үйлст огт нэвтэрсэнгүй. Зүйл бүр арга хэрэглэж зүтгээд, үхсэнгүй өтөлж, миний нэр олон улсад түгсэн боловч, явдал энгийн өтөл хүнээс юун ялгал.

Үүнийг бодоход ичингүйрнэ. Хүний нууц эчнээ сэтгэлийг хэн мэдэн төсөөлөх билээ. Энэ сонин захидлыг хүлээн аваад, ууланд нуугдъя. Эсхүл, далайд зайлсугай гэтэл, эцэстээ чиний зарлигийг дагасугай гэж тогтов. Нангиад Хятадын эрдэмтэн, зэрлэг бүдүүлэг аймгийн хүн цөм чамайг дагана. Тэнгэр, эзэн чиний биеийг баатар мэргэн төрүүлжээ.

Би бараалхъя гэж алсын замыг зорьж, бэрх цастай тэмцэн эчсүгэй гэж нэгэнт санаа шулуудав. Явах замд салхи тоос тасрахгүй,

тэнгэрийг үүл манан харанхуйлж, миний нас хөгшин, бие буурай болсон тул, хэцүү бэрхийг давж, урт замыг туулж үл чадна. Миний бие улсын эзэн чамд хүрэлцэн очиж чадавч бичиг цэргийн хэргийг яахан шийдвэрлэж чадах аж. Иймийн тул, чухам очих эсэхийн нэгийг надад зааж соёрхоно уу. Ер нь миний хатанги бие минь туранхай шүү дээ, хариуг хүлээнэ.

Луу жилийн гурван сар»

гэжээ.

Энэ захидлыг Чингис хаан хүлээж аваад, туйлын их баярлаад, хүргэж ирсэн илчийг ихэд шагнаж, хариу бичиг явуулсан нь:

«Миний гарын дор ирсэн бүхэн, надтай хамт, надаас зугтаагч бүхэн миний эсрэг болой.

Их бэрхийн эцэст он удтал амар жимэр болохын тул, би цэргийн хүчнийг хэрэглэж байна. Дэлхий дахины хамаг амьтны сэтгэл намайг дагаж, миний эрхэнд орсон цагт, сая амаршиж би зогсоно. Энэ учир, би үл дийлдэх цэргийн дунд үргэлжид сүр жавхланг гаргаж, ямагт цэрэглэж явна. Чиний бие алс замд хялбараар зорин, тогоруу шувуу хөлөглөж миний зүг нисэн ирж чадахыг би мэдэж байна.

Хээр талын урт зам хязгаргүй боловч, чиний дулдуйг үзэх цаг асар удахгүй болсон биз ээ. Иймийн тул, чиний бичгийн хариуд санаагаа ил болгож, энэ бичиг хариу явуулав. Бусад зүйлийг эс нуршив»

гэжээ.

НАМАЙГ МӨНХ БОЛГОСУГАЙ

Их хаанаас хоёр удаагийн захидлыг авч, Хятадын өвгөн эрдэмтэн, алсын аянд зорив.

Өвгөнийг Чингис хаанд Хятадаас явуулан байгаа ордны гоо сайхан дуучин, бүжигчин эмсийн хамтаар тэмээгээр явна уу гэхэд нь, эс зөвшөөрсөн тул, тусгай харгалзан хамгаалах хоёр мянган явган цэрэг, гурван зуун морьт цэргийг дагалдуулжээ. Чан Чун хорин шавь нарыг дагуулж, нэг нь өдрийн тэмдэглэлийг бичиж багшийн шүлэг өгүүллийг тэмдэглэж явав. (Чан Чуний умар зүг явсны өдрийн

тэмдэглэл нь одоо хүртэл уламжлагджээ). Чан Чуний бие, яарамгүй явж, зам гудасын хотоор буусаар явжээ. Хотын монгол даргын ёслон угтаж, ихэд зочлоход хоол идээг хэрэглэсэнгүй, гагцхүү цагаан будаа жимсээр хоол хийжээ. Чан Чуний бие, замдаа шүлэг бичиж, монгол цөл говь газрыг явж өнгөрөхдөө түүний бичсэн шүлэг нь:

1. Аль ч зүгтээ харсан
Адаг төгсгөлгүй уул,
Уулнаас ус урсан бууж
Уудам талд салхинаа чөлөөтэйеэ

«Нэн эртнээс нааш үүгээр
Нүүдэл аймгийн мал сүрэг
Нүүн цувдаг нь юу бил ээ?

Эрт балар цагийнхтай адил
Энэ газрын хүн, үхрийн мах идэж
Элдэв өмсгөл хувцас, заншил нь
Эгнэгт манайхаас өөр!
Балчир хүүхэд шиг хонгор сэтгэлтэй,
Бас бичиг үсэг мэддэггүй,
Санаа амар сэтгэл дүүрэн,
Сайхан тавтай суудаг ажим.

2. Хөндий талын замаар явахад
Хөдлөх бүр бэрх газар туулж,
Толь шиг нуур нь цэнхэрлэж,

Тойрмын хужир нь гялалзаад.
Манхан элсэн дундуур өдөржин явав ч
Магад хүнтэй дайралдахгүй цөл газар.
Хаяа жилд ганц удаа бараа нь үзэгдэж
Харь газрын хүн давшин өнгөрдөг аж.
Нүдэнд торох уул модгүй,

Нүцгэн дов толгодод өвс харагдаж,
Өвөл зунгүй нүүдэл аймгийн хүмүүс
Өмссөн нь арьс үсний төдийхөн.

Амуу тутарга ургадаггүй энэ газар,
Амьтан бүгд сүүгээр идээ хийгээд,
Эсгий туурга дээвэрт гэрээ
Энэ газрын хүн авч явдаг байна

гэжээ.

Чан Чуний бие, хоёр жил явж, Жейхун мөрөнд хүрч, Термес хотын ойролцоо гаталж гараад, тэнд Чингис хааны шадар эмчийн угтаж ирэхэд нь уулзаж, түүнд урт удаан замыг туулсан шүлгээ бэлэглэж, уулын зэрлэг миний бие, их хааны цэргийн хүрээнд ирэхдээ, чухал үг хэлэх гэж ирсэн билээ. Түүнийг дагаж гүйцэтгэвэл, дэлхий дахин энх жаргалтай болно гэжээ.

Чан Чуний тэр шүлэг нь:

Энэ найман сар гэдэг
Эртнээс алдартай билээ
Үүл сарниж,
Салхи намдаад

Шөнө цэлмэг.
Одны туяанд баяссан луу
Урд зүгт наадан тогложс,

Өндөр цонх дээрээс
Өргөн найрын чимээ сонстоод

Бат хуулийн зарчмаар
Баяр наадмаа бүгдээр хийж,

Алдарт дуучин дуугаа дуулж,
Архи сархдыг бялхаж байхад

Цуст шуламсыг номхотгож
Чөлөөт амьсгалыг олгуулах гэж

Аугаа их хааны зүг
Аймшиггүй зорьж,
Цэл буурал өвгөн гэлдэрч явна гэжээ.
Чимээгүй эргийн хөвөөгөөр

Чан Чунь, хүн амьтан дүрвэж зайлаад, эзгүйрэн хоосорсон учир, өлөн нохойн хуцах чимээ ганц нэг сонсогдож байгаа Балх хотыг дайрч, уулын замаар дөрвөн хоног явж Чингис хааны хүрээнд ирээд, өндөр эрэг дээр барьсан шар асрын өмнө ирэв.

Чан Чунь, Самарканд хот дахь төлөөний сайд, хятад монгол хэлтэй Ахай Тайшийг дагаж, догшин хаанд бараалхав. Бомбо нар, Хятадын хаанд бараалхахдаа сөгдөн мөргөдөггүй тул, Чан Чунь, хааны гэрт орохдоо бомбо ёсоор алга хавсарч, мэхийн ёслов.

Их хааны өмнө, цэл буурал толгойтой, дүгнэгэр том магнайтай, нар салхинд түлэгдсэн хүрэл өнгөтэй, яс арьс болсон өвгөн тэр бомбын зогсож байгаа байдал, олсон шаахай, нүцгэн хөлдөө углаж, уранхай дээл, туранхай биедээ өмссөн нь гуйланчийн шинжтэй боловч, «дэлхийн эзэн»-ний өөдөөс тэвдэлгүй тайвнаар хараад, хивсэн олбог дээр суужээ.

Хөх буурал сахалтай, хүрэн бор царайтай Чингис хаан, том маргад эрдэнийн жинстэй, гурван үнэгэн сүүлийг мөр хүртэл унжуулсан дугуй хар алтан малгай өмсөж, ширээн дээр завилж суув.

Тэр бээр , авралыг горьдож, ядуу дорой ясан хэлхээ болсон мэргэн өвгөнийг муурын нүд шиг ногоовтор нүдээрээ цавчилгүй ширтэн харж, уригдан ирсэн тэр айлчны адил энгийн хар олсон даавуу дээлтэй, үс сахал нь нэгэн адил цагаан ширхэг татсан цал буурал боловч, зам чиглэл нь тус бүр байжээ.

Хятадын мэргэн өвгөн, хүний хөл үймээнээс зайлж, зэлүүд газар оршин, хүнийг, үхэл зовлон, өвчин эмгэг, өтлөх хөгшрөхөөс аврах нууц арга эрж, бүх насаараа даяаныг бясалган, эрдэм ухааныг судалж, зовлонт хүн бүхэнд тусалдаг хүн байжээ.

Хаан бол, ямагт их цэргийн удирдагч бөгөөд бусад улсыг хядан устгаар цэрэг явуулж, бүх ялалт нь хэдэн түмэн хүний амь хохирсоор бүтэж байсан болой.

Чингис хааны амьд явах насны хэмжээ төгсөх шахсан тэр үед, дахин идэр залуу, эрэлхэг хүчтэй болж, дэлхийд хүчирхэг гэгдэж байсан түүний биеийг амьгүй хүүр болох буюу муу байдалд оруулахаар хааны зүг сарвайж байсан эрлэгийн гар савраас ямагт ангижирч явах эсэх явдал нь одоо гагцхүү хавцлын хатанги дорой энэ өвгөнөөс болох байжээ.

Хоёр өвгөн нэлээд дуугай байгаад, Чингис хаан асуууун,

— Замдаа чи энх сайн явж ирэв үү? Чиний буудаллаж ирсэн хотод бүгд хангалттай байв уу? гэхэд нь,

— Анхандаа над янз бүрийн хоол идээ элбэгээр өгч байлаа. Эцэс сүүлийн үед чиний цэргийн явсан газраар явж өнгөрсөн, тэр газар, тулалдааны ор мөр, гал түймэр газар бүр үзэгдэн, хоол олдоход бэрхтэй байсан гэв.

— Одоо, тэгвэл, чи юу хүссэнээ хэрэглэх болно. Өдөр бүр миний хоол дээр ирсүгэй.

— Үгүй, тийм юм хэрэггүй. Уулын зэрлэг би даяанчлан, ганцаар аглаг суухыг дурладаг гэж хэлэв. Зарц нарыг айраг авчирч өгсөнд, мэргэн өвгөн уусангүй.

Хаан өгүүлрүүн:

— Миний дэргэд, өөрийнхөө дураар аль хүссэнээ хэрэглэж суу. Одоо явж болно гэхэд.

Чан Чунь босож, хоёр алгаа хавсран, мэхийж ёслоод гарч одов.

Удалгүй монгол цэрэг, Маверанаграар дамжин гэдрэгээ хойд зүг чиглэн хөдлөв. Зам зуур Чингис хаан, мэргэн өвгөнд, жимсний дарс, амттайхан гуа, янз бүрийн идээний зүйлийг удаа дараа ирүүлжээ.

Монгол цэрэг, Жейхун голд хүрч, завь онгоц дээр тавьсан хөвөөлүүр гүүрээр шаламгайлан гараад Самаркандын зүг чиглэв.

Цэргийн амарч хонох нэгэн орой Чингис хаан, Чан Чуньд шөнө орой чухал үг хэлэлцэхийг мэдэгдэн, хүн илгээв.

Чингээд, шөнө цэргийг хүрээний дуу чимээ тасарч гагцхүү мэлхийн гууглах нь сонстож байгаа үед Ахай Тайш, Чан Чунь өвгөнийг, хөдлөлгүй зогсож байгаа манааны дэргэдүүр их хааны шар асарт дагуулж ороод харвал, хааны алтан ширээний хоёр талд, өндөр мөнгөн тавиурт бүдүүн лав лаа бариастай, Чингис хаан, цагаан илгэн бамбагар олбог дээр хоёр хөлөө завилж суугаад, нүүр нь хар үнэгэн сүүлтэй толлогодож өнгөлсөн том дугуй малгайн сүүдэрт үл харагдах бөгөөд гагцхүү хоёр нүд нь барсын нүд мэт гялалзаж, дэргэд нь монгол хятад хэл бүхий хоёр бичээч, хивсэн дээр сууж, Чан Чунь, хаан ширээний урд хивсэн олбог дээр суугаад,

— Би уулын зэрлэг хүн, хамгийн их сайхан, хамгийн дээд зэргийн сургаал «ёс төр»-ийг олон жил судалж бий. Би аглаг эзгүй, дуу чимээгүй газар сууж, элчилгүй цөл газраар тэнүүчилдэг хүн. Аглаг цөл газар зогсон бясалгаж бодох дуртай. Энд хааны асрын ойр үргэлж олон цэрэг, морь тэрэгний чимээ шуугиантайгаас миний сэтгэл төвгүй

болов. Чиний залран явах үед, миний бие заримдаа урд чинь, заримдаа хойно чинь өөрийнхөө дураар явж болох бол уу? Үүнийг зөвшөөн соёрхвол, уулын зэрлэг надад туйлын их хайр өршөөл болно гэхэд,

— Чиний хүссэн ёсоор болготугай гээд асуусан нь, — Тэнгэрийн дуу гэж чухам юу байдгийг надад хэлж өг. Ид шидэт хүмүүс, их бөө беги тэргүүтэн надад хэлэхдээ, аянга бол огторгуйд суудаг үүлний цаана суудаг тэнгэр нар хүнд, хилэгнээд хүрхрэх дуу болой гэж хэлдэг нь зөв үү? Тэд хилэгнэхдээ хүн тэдэнд өргөвөл зохих хар зүсний адгуус амьтныг өргөхгүй, өөр өнгийн амьтныг өргөсөн учраас тийнхүү хилэгнэдэг гэх бөгөөд энэ нь үнэн үү? гэхэд нь,

Чан Чуний хариулсан нь: Тэнгэр, хүнд хилэгнэхдээ, элбэг ховор өргөл өргөснөөс буюу хар зүсний бус алаг эрээн буюу цагаан хонь, морь өргөсөн гэж хилэгнэдэггүй. Чиний бөө нарыг бас зун цаг хүн, голын усанд биеэ буюу хиртэй хувцсаа угааж үл болох, мөн эсгий татах буюу мөөг цуглуулж үл болно. Хэрэв тэгвэл тэнгэр туйлын их хилэгнэж, аянга буулгаж ниргэдэг гэж дэмий донгосож байхыг сонссон. Тэнгэрийн хилэгнэх нь, хүн тэнгэрийг хүндэлсэнгүй явдалд огтхон ч хамаагүй. Харин, хүний үйлдсэн туйлын их бузар муухай гэмт хэргээс болно.

Уулын зэрлэг миний эртний номд үзсэн нь, хүн төрөлхтний гурван мянган янз бүрийн гэмт хэргийн дотроос хамгийн шившигтэй муухай хэрэг нь, эцэг эхээ хичээнгүйлэн үйлчлэхгүй явдал мөн гэсэн болно. Чиний захиргааны улс, эх эцгийг хүндэтгэдэггүйг би замдаа олон үзлээ. Өөрсдөө найрлан цэнгэж цадталаа идэцгээгээд, хөгшин эцэг эхээ өлсгөн харангадуулж байдаг байна. Ёс мэдэхгүй, энэрэх сэтгэлгүй хөвүүд охид, эцэг эхээ доромжилсон учир, үнэнийг баримтлагч тэнгэр, цахилгаан аянгаараа ниргэн, гэсгээдэг байна.

Өөрийнхөө улсыг ухаан сэхээтэй болгон засах тухай эзэн хаан минь санаагаа тавина уу гэхэд,

Чингис хаан мэргэн өвгөн хэрэгтэй зүйлийг ярьж байна гэж эх эцгийг хүндлэх тусгай хууль гаргахын тул Чан Чуний үгийг монгол-хятад, татар үгээр бичиж ав гэж бичээч нарт тушаав.

Алтан тавагт янз бүрийн хоол идээ хийж барихад, Чан Чунь, нэг атга болгосон тутарга, хуурай үзэм бага зэрэг авав. Хаан асуурууН:

— Мэргэн арш аа! Би нэгэн зүйлийг мэдэхийг эртнээс нааш хүссэн юм. Чамд хөгшнийг залуу болгох, чадал хүчингүй хүнд хүчин оруулах тийм эм бий юү? Их мөрөн голын ус тасралтгүй үргэлж

урсдагтай адил миний амьд явах насыг мөнх үргэлжлүүлэх аргыг чи мэдэх үү? Хүнийг мөнх болгож чаддаг эм чамд байна уу гэхэд, Чан Чунь, нүдээ доош буулгаад, хурууны үзүүрийг дуугүй нийлүүлэв.

Чингис хаан бас өгүүлрүүн: Хэрэв, чамд одоо тийм эмгүй ахул, түүнийг хэрхэн найруулдгийг мэдэх үү? Эсхүл, хүнийг хэрхвэл мөнх болгох нууц аргыг мэддэг, өөр нэгэн мэргэн хүн буюу илбэчийг чи хэлж өгнө үү? Хэрэв, миний биеийг мөнх настай болох тийм эм надад найруулж өгөх ахул, би чамд ер бусын гайхалтай шан хүртээнэ ээ. Чамайг, их мужийг захирагч ноён болгоно. Хормой дүүрэн алт зоос өгнө. Газар бүрийн гуа үзэсгэлэнт зуугаад охин бэлэглэнэ гэхэд, Чан Чунь, хариу үг ч хэлэхгүй, нүдээ ч дээш нь болголгүй, их хүйтэнд даарсан хүн мэт чичирч эхлэв.

Чингис хаан, түүний шуналыг хөдөлгөх гэж, бас өгүүлрүүн: Би чиний суух ууланд чинь, Хятадын богд эзэн хааны ордтой адил, дэлхий дээр хосгүй маш сайхан ордон барьж өгье. Чи, тэр гайхамшигт ордондоо дээд сургаалаа бясалгаж байгаарай. Надад залуу болох явдал ч хэрэггүй, би одоогийн байгаа шиг өвгөн буурал хэвээрээ үлдье. Гагцхүү, би өөрөө, өөрийн байгуулсан их Монгол улсын төрийн жолоог адаг хязгааргүй олон жил өөрөө барьж байхыг хүснэ, гээд дуугай болж, мэргэн өвгөний үрчгэр нүүр лүү цогтой хурц нүдээрээ эгц ширтэв. Нөгөөдөх нь бүх биеэ хураан агшааж, догшин хааныг нүдний булангаар харж өгүүлрүүн:

— Дуу чимээгүй ууланд бясалган суухыг дурлах тул, алтаар би юу хийх вэ? Өөрийнхөө биеийг засаж чадахгүй мөртөө, бүхэл мужийг засах засгийг барих чадал, надад хаана байх аж. Олзолж авсан гуа үзэсгэлэнт охидыг тэдний сэтгэлд нийлсэн залуучуудад гэргий болгон өг! Надад ордны хэрэггүй. Би чулуун дээр зогсоод, бясалгал хийж чадна.

Хятадын хамгийн алдартай эрдэмтний бичсэн бүх ном судрыг би үзэж судлаад, үзэж мэдээгүй нууц зүйлгүй болов. Би чамд ёстой зөв үнэнийг хэлж болно. Хүний хүчнийг нэмэгдүүлэх, түүний өвчнийг эдгээж, үхлээс хамгаалах арга олон бий. Харин мөнх наслахын эм байхгүй. Байх ч ёсгүй гэв.

Чингис хаан, доошоо харж, бодол бодон удтал дуугай байв. Үгийг дэвтэрт бичиж байсан бичээч нарын хулсан үзгийн чахрах чимээ ч зогсоод, гагцхүү, бүдүүн лав лааны шаржигнан шатах чимээ дуулдаж байв. Ингэж байгаад Чингис хаан өгүүлрүүн:

— Манай Монголын өвгөдийн хуучин ярианд «үнэнийг өгүүлдэг хүн, өвчнөөр үхдэггүй» гэдэг. Ер нь үнэнч хүнийг ямар нэгэн этгээд, хорон санаагаар үхэхээс нь өмнө алдаг. Ийм учраас хүн бүхэн уул мэт худал хэлэхийг хичээдэг.

Харин, мэргэн өвгөн чи, надтай уулзах гэж түмний газраас ирээд, мөнх болгодог эм байхгүй гэж үнэнийг хэлэхээсээ айсангүй. Чи бол чин сэтгэлтэй, шударга хүн ажгуу. Хэрэв, чамд хүсэх зүйл байвал, хэлсүгэй. Би түүнийг чинь гүйцэтгүүлж өгье гэв.

Чан Чунь агаа хавсарч, хааны өмнө бөхийгөөд, надад гуйх зүйл ганцхан бөгөөд түүнийгээ чамд хэлэхийн тулд би уул говь, цас элс дамжин явж ирсэн билээ. Юу вэ гэвэл:

Чи өөрийнхөө хатуу ширүүн дайныг зогсоож, бүх улсын дунд, газар бүхэнд сайн хүсэлт эв найрамдлыг тогтоосугай гэмэгц Чингис хаан, хөмсгөө зангидаж, дахин тэнийлгээд, нүүрээ буруулж, маш амьсгаадан өндөр дуугаар өгүүлж эхэлмэгц, бичээч нарын үзэг, цаасан дээгүүр дэгдэж үзэгдэв.

— Газар бүр эв найрамдлыг тогтооход, дайн байлдаан хэрэгтэй! Манай өвгөд «гагцхүү өстөн дайснаа албал, хол ойр амар тайван болно» гэдэг. Тэр үг дэмий үг бус болно. Би харин миний эртний дайсан Тангадын Бурхан хааныг дараагүй, бүх дэлхийн нэг хагас нь миний өсгийн дор ороогүй байна. Үүнийг би хүлцэж болох уу? Чи хэдийгээр мэргэн хүн боловч, чиний хүссэн юм дэмий юм байна. Ийм хүсэлтээр үүнээс хойш биднийг битгий чилээ гээд өндийж, ширээгээ гараараа чанга атгаж, догшрон уурласандаа чичирч, чархран өгүүлсэн нь: Одоо явж болно гэв.

Тэр жилийн өвөл, Чингис хаан, Самарканд хотын дэргэд өвөлжин, хотын явцуу байдлыг үл дурлах учир, монгол цэргийн хүрээнд суусан билээ.

Өвөл анхандаа туйлын их бороо орж, газар дэвтээд шаварт явахад хэцүү болов. Сүүлдээ үе үе цас орж их хүйтэн болоод адуу, шар олноор үхэж зам дагуу хэвтэв.

Мэргэн Чан Чунь, хотын захад Хоресм шагийн ордон байсан цэцэрлэгээр хүрээлүүлсэн «Хөх сарай» гэдэг хөх ордонд сууж, шүлэг бичдэг байв. Хогшил хөрөнгө, мал сүрэг, эхнэр хүүхдээ монгол цэрэгт булаалгаж, өлсгөлөн болсон нутгийн цагаач нар, бөөн бөөнөөр өвгөнд очдог байсан үүнд, Чан Чунь, Чингис хааны хайрласан хоолыг тэдэнд тараан олгож, өөрөө будаа чанаж өгдөг байв.

МОНГОЛЧУУД «ЭХ НУТАГ»-ТАА БУЦАЖ ИРСЭН НЬ

Монголчууд, эх нутаг гэж Монголын зүүн хойд хэсэг Онон, Хэрлэн голын дагуу газрыг нэрлэдэг бөгөөд, тэнд Чингис хааны ураг төрлийн хүмүүс нутаглаж байсан билээ. Чингис хаан, өөрийн цэргийн хүрээний буудаллаж байсан газрыг өөрчлөхийг хүсэж, бүх цэргийг Самаркандаас Жейхун буюу (Сердарья) мөрөн тийш хөдлөх тушаалыг өгсөнд Хоресмийн хуучин хатан бөгөөд Мухамед Шагийн эх Турхан хатан, Шагийн бүх их бага хатан, олзлогдсон угсаат бүсгүйчүүд, Чингис хааны зарлигаар монголчуудын явах замын дагуу зогсоцгоож, бүх цэрэг тэдний дэргэдүүр өнгөрч дуусах хүртэл өндөр дуугаар Хоресм улсын мөхсөнийг уйлан дуулцгааж байсан билээ.

Хонин жил (1223)-ийн эхээр Чингис хааны лагерь нь Жейхун мөрний баруун гар талын эрэг дээр байсан билээ. Тэнд Чингис хааны дуудуулсанд бардам тэрсүү зөрүүд ахмад хөвүүн Зөчөөс бусад хөвүүд Цагаадай, Өгөөдэй Толуй гурав хуралдан ирсэн билээ.

Чингис хаан, ойрын арван гурван жилийн дотор баруун зүгийн бүх улсыг адгийн далай хүртэл эзлэн авах төлөвлөгөөний тухай бүх хөвүүн, хаад, цэргийн жанжинтай зөвлөлдөн хэлэлцэв.

Чингис хааны цэргийн хүрээ, эзэн нь дүрвэж зайлсан цэцэрлэгийн дунд байжээ. Тэр цэцэрлэгт ойрын уулнаас бодон гахай олноор ирдэг байсан. Үүнд: Чингис хаан, гахай агнаж, морин дээрээс жадалж харван алахыг ихээхэн дурладаг байжээ. Нэг өдөр, нэгэн том бодонг хөөж явтал морь нь бүдэрч ойчоод, морь нь давхин явжээ. Том бодон гахай гэдрэг эргэн зогсоод, хөдлөлгүй хэвтэж байгаа Чингис хааныг харж байгаад, аажмаар явж, хулсан дотор орсонд бусад анчин тэр үед гүйцэн ирж хааны морийг авчирч өгөв.

Хаан, агнахаа зогсож, хүрээндээ эгж ирээд, Хятадын мэргэн өвгөн Чан Чунийг дуудуулж, зэрлэг бодон гахайн өмнө унасан минь мөнх тэнгэрээс шалтгаалсан зүйл бий эсэхийг тайлбарлаж өгсүгэй гэв. Чан Чуний хэлсэн нь:

— Бид бүгдээрээ өөрийнхөө амийг болгоомжлон хамгаалах ёстой. Их хааны нас өндөр болсон тул, ан гөрөөг бага шиг хийх хэрэгтэй. Тэр бузар гахай, намагт ойчоод хэвтэж байсан «дэлхийг донслуулагч» танд халдан эс дайрсан нь тэнгэрийн ивээсний тэмдэг мөн гэхэд,

Чингис хааны хариулсан нь: Би ангаа орхих гэж үү? Үгүй, үүнийг дагаж биелүүлэхэд бэрх.

Бидний монголчууд бага наснаасаа ан гөрөө хийж харваж намнахыг сурсан тул, өвгөд хүртэл тэр заншлыг орхиж чаддаггүй билээ. Гэвч, чиний үгийг би сэтгэлдээ шингээв гээд Чан Чунийг шагнаж, нэгэн сүрэг саалийн үнээ, шилдэг адуун сүргийг хөөн авчирч өг гэж зарлиг болсон боловч, мэргэн өвгөн гэдрэгээ өөрийн Хятадын ууландаа ердийн өртөөний жууз тэргээр буцаж чадна гээд бэлгийг маргаж авсангүй.

Чингээд, мэргэн өвгөн хаантай салалцах ёсыг гүйцэтгэсний дараагаар хорин шавь нарыг нэгэн баг цэрэгтэй дагуулан гэдрэг буцав. Чингис хааны шадар олон хүмүүс, лонхтой архи, сагстай ховор зүйлийн жимс авч, мэргэн өвгөнийг үдэн гаргаж өгсөн болой. Салалцан явах үед бүгдээрээ уйлж нулимсаа арчив.

Бичин жил (1224)-д Чингис хаан, цэргийг монгол нутгийн зүг жолоог нь залав.

Чингис хааны цэрэг, хөгшин барс, бүтэн үнээ идээд унжсан гэдсээ чирсээр, өтгөн хулсан доторх хэвтэр тийш аяархан явдгийн адил, асар их олзондоо дарагдан яаралгүй явав. Цэрэг бүр, хэд хэдэн ачлагын тэмээ, морь, үхэртэй байв. Цэргийн хамтаар хонин сүрэг явж, лал нараас дээрэмдэн авсан дээл хувцас, хивс, зэр зэвсэг, төмөр сав суулга зэрэг эд ачсан хасаг тэрэг чархран явав. Мөн морь тэмээ унасан, тэргэн дээр суусан Монголын зэрлэг олон аймгийн авгай, хүүхэд явалцаж, уранхай хувцастай, эцэж турсан, хөл нүцгэн олзлогдогсод, зах хязгаар нь үзэгдэхгүй цувж, аль бэлчээр сайтай газар өнжиж хонох зэргээр яарамгүй явж, зунжин, өвөлжин аялсаар, төв Азийн усгүй сайр чулуут цөл талд замын бэрхийг тэвчиж чадалгүй үхэж, арьс ширийг хуулан авсан үхэр адууны сэг, олзлогдогсдын хүүрээр зам татуулан явсаар хавар цаг Хэрлэн гол хүрч, Чингис хаан, шар асраа Буга Сочгай гэдэг газар бариулж, гавьяатан жанжин, сурвалжтан хаадыг хуралдуулан хэрэг хэлэлцэн зөвлөлдөөд, урьд өмнө үзэгдээгүй их найр наадам хийж билээ. Тэр найр наадмын сүүлээр гурав хоноод, Чингис хааны залуу гэргий Хулан хатан нас барж, амьтны ам, хааны дүү нар түүнийг хорлосон гэж хэлэлцэж билээ. Чухам үнэнийг хэн мэдэх вэ.

Дараачийн тахиа жил (1225)-д Чингис хаан уул нутагтаа сууж, Монгол улсыг соён сургаж оюун түлхүүрийн сургаалыг зарлан, засгаа тунхаглаж билээ.

ЧИНГИС ХААН, АЯНД НАС БАРАХААР ШИЙДЭВ

Чингис хаан, дагадаггүй Тангад улс, дахин самуурчээ гэдгийг сонсоод, сэтгэл амгалан сууж чадсангүй, их хаан Тангадын Бурхан хааныг залхаан цөхрүүлэх гэсэн үгээ мартсангүй тул цэрэглэх гэж зэхэж, их цэргийг өөрөө удирдан явахыг хөвүүдэд мэдэгдэж дуудуулав. Хэдэр зөрүү ахмад хөвүүн Зөчөөс бусад гурван хөвүүн нь ирцгээгээд, Мавраннагрыг жолоодон захирагч дэд хөвүүн Цагаадай, ах Зөчтэй ер нийлдэггүй тул, эцэг хөвүүдийн зөвлөн хэлэлцэхэд өгүүлрүүн:

Зөч, Хивчаг улсыг уул Монгол улсаас илүү дотно үзэж, Хересмд монгол хүнийг хивчагт хавьтуулдаггүй болов. Бас хөгшин Чингис зөнөж, хэчнээн газар орныг үгүйрүүлэн хооссруулж, хэчнээн хүнийг хайр гамгүйгээр алж талж байна гэж ичих нүүргүй ярьдаг болов. Зөч, манай эцгийг ав хийж явахад нь алаад, уул монгол улсаас салж, лалуудтай эв найрамдал байгуулах гэж байна гэхэд Чингис хаан, маш их уурлаж, Хоресмд Отчигин дүүгээ үнэнч итгэлт хүнтэй явуулж, Зөчийг ир гэж хэл гэж явуулав.

Отчигиныг явуулахдаа чихэнд шивнэн захиж, Зөч ирэхийг татгалзаж, Хоресмдаа байх гэвэл, үггүй өчиж, дуугай дохь гэж захижээ.

Зөч, эцэгтээ ирүүлсэн хариуд, өвчтэй учир явж чадсангүй хивчаг нутагт сууж байна гэжээ.

Гэтэл, үнэнч шударга хүмүүс, Чингис хаанд бичихдээ Зөч хааны бие эрүүл бөгөөд, үргэлж ав шувуу тавьж байдаг тул, их хааны нууц захиаг биелүүлэх гэж Зөчийн дэргэд хоцров гэжээ.

Цагаадай, өөрийн улсыг удирдан захирахаар хойшоо Самаркандад буцсан бөгөөд, Чингис хаан өөрийн хайрт хоёр хүү Өгөөдэй, Толуй нарын хамтаар нохой жилийн (1226) эхээр Тангадтай байлдахаар цэргийг хөдөлгөж, Онгон далан худаг гэдэг газар хүрэв.

Энд Чингис хаан, муухай зүүд зүүдэлж, өөрийн үхэх ойртсон тухай ярих болов. Ондоо баг цэрэгт байсан хөвүүдээ дуудуулав.

Маргааш өглөө үүрээр Өгөөдэй Толуй хоёр ирэв. Тэдний цай хоол идэж гүйцсэний дараа, гэрт байсан бусад хүмүүст Чингисийн хэлсэн нь;

— Би хөвүүдтэйгээ нууц зөвлөгөөнийг хийнэ. Манай аж явдлын тухай би эдэнтэй зэлүүд байж тусгай ярилцахыг хүснэ. Та нар бүгдээрээ гарцгаагтун гэв. Олон хаан ба бусад хүмүүс гарсны дараа

Чингис хаан, дэргэдээ хоёр хүүгээ суулгаж, анх тэр хоёрт аж төрөх ба улсыг жолоодох талаар сануулгыг өгч, дараад хэлсэн нь:

— Миний хөвүүд үргэлж бодож яваарай. Санамсаргүй миний эцсийн хийх байлдаан тулгарч иржээ.

Монголчуудыг ивээгч тэнгэрийн сүлдний хүчээр хөвүүд минь та нарт би, агуу их гүрнийг байгуулж өгөв. Манай улсын нутгийн хүйсээс зүг бүр явахад нэгэн жилийн газар байна. Одоо би гэрээсээ хэлье. «Дайснаа үргэлж устгаж, нөхдөө үргэлж хөхиүлж явагтун». Иймийн тулд, та нар нэгэн саналтай, нэг хүн шиг яваарай. Чингэвэл Та нар, амар мэнд явж, төрийг барьж жаргал цэнгэлтэй явах болно. Миний орыг, урьд миний гэрээсэлсэн ёсоор Өгөөдэй чи залгамжлагтун.

Миний сүүлээр Өгөөдэйг их хаан болгож зарлаад, цагаан эсгий олбог тавьж өргөмжилбөл зохино. Бүх улс ба монгол угсаатныг чийрэг бөгөөд жавхлантайгаар удирдаж миний үхсэний дараа, миний байгуулсан засгийг завхруулж гуйвуулахгүйгээр дагаж явагтун. Одоо энд миний хөвүүд Зөч, Цагаадай хоёр байгаагүй нь харамсалтай байна. Тэр хоёр намайг үгүй болсны хойно миний хүслийг зөрчин харилцан дайсагнаж, гүрний дотор самуун гаргахгүй байх болтугай!

Хүн бүр, гэртээ үхэхийг хүсдэг боловч, би дайчин алдартаа зохилдуулж, насаа байлдаанаар төгсгөхийн тул, сүүлчийн удаа дайнд мордоно. Одоо та нар явцгааж болно гэв.

Чингээд, Чингис хаан, цэргийн хамтаар цааш хөдлөн явав. Замд тохиолдсон олон хот, аймгийн эрх баригчид, дэс дараагаар дагаар орж байв. Нэгэн хаан, олон том сувдыг тавагт хийж авчирч бариад, «Бид танд дагаж оръё» гэв.

Их хаан, өөрийн нас эцэслэх ойртсоныг зөгнөж тэр сувдыг хайхарсангүй, түүнийг цэргүүдийн өмнө тал газар сацах тушаалыг өгөв. Бүх цэрэг, тэр сувдыг цуглуулж авсан бөгөөд бас олон сувд шороонд булагдаж хаягдсаныг сүүлд хүн эрж олж авч байсан билээ. Чингис хаан хэлсэн нь: Одоо над нэгэн өдөр амьд явах нь нэг тавагтай сувдаас илүү үнэтэй байна гээд санаа нь сарниж, сэтгэл нь зовсон байдалтай байх болжээ.

Тэр цагт Тангадын хааны явуулсан элчийн хүрч ирсэнд, Чингис хаан биеэр уулзсангүй, Чингисийн их зөвлөгч Елюй-Чуцайг уулзуулсанд тэр элч өгүүлрүүн.

Манай хаан, их хааныг эсэргүүцэж, хэд хэдэн удаа хөдөлсөн бөгөөд үүнээс хойш монголчууд манай оронд ямагт довтолж, хүнийг

алж, хотыг дээрэмддэг болсон билээ. Эсэргүүцээд ямар ч ашиггүйг би мэдэв. Чингээд, Чингис хаанд бид дагаар орж, хүчээ өгч, харилцан тангаргийн гэрээг тогтоож, найрамдахыг гуйна гэсэнд Елюй-Чуцайн хариулсан нь:

— Их хааны бие чилээрхэж Чингис хааны биеийг сайн болтол, Тангадын хаан хүлээж байг! гэв.

Чингис хааны өвчин, өдөр ирэх тутам хүнддэж байх тул тэр нас эцэслэхээ лавтайяа мэдэж тушаасан нь:

— Намайг үхэхэд, миний үхсэнийг бусдад өчүүхэн ч бүү мэдэгдэгтүн! Хэрэв мэдэгдвэл дайсны сэтгэл баярлан, зүрх чангарах болно. Та нар гашуудлыг хийх хэрэггүй. Тангадын хаан, бусад иргэнтэй бэлгийн юм авч, хэрмийн хаалгаар гарч ирмэгц, довтолж устгагтун! гэжээ.

Их хаан есөн давхар цагаан эсгий дээр хэвтэж, эмээлийн илгэн оломцгийг толгой дороо дэрлэж, хөлөө харавтар булган хөнжлөөр хучсан байна. Өндөр туранхай бие нь чулуу мэт хүнд болж, бүх дэлхийг донслуулсан хүн, одоо биеэ хөдөлгөж, толгойгоо өндийлгөж чадахгүйд хүрчээ. Чингис хаан хажуулдан хэвтэж, амьсгаа авах бүрд хулгана чарлах мэт нарийн дуу гарч байхыг сонсоод, тэр хулгана чухам хаана байгааг удтал мэдэж ядав. Ажиглавал, амьсгалаа үл авахад хулгана үл дуугарах учир, тэрхүү дуугарч байгаа хулгана нь түүний цээжинд байгаа өвчин мөн гэж сая мэдэв.

Их хаан эргэж, дээшээ харж хэвтвэл, дээр нь тэрэгний дугуйтай адил хэлбэртэй гэрийн тооно харагдав, тоононы нүхээр харвал, хөх тэнгэрийн дунд хар үүл тайвнаар хөвөлзөж сүрэг тогоруу огторгуйн гүнд нисэж өнгөрөхийг үзэв.

Танигдаагүй алс шинэ газарт тэдний ганганах чимээ холоос сонстов.

Хаан хамгийн захын далай хүрэхийг зорьж яваад, Энэтхэгийн хил дээр асар халуунд тэсвэрлэж чадсангүй, түүний бүх биеийг загатнасан улаан толбууд бүрхсэнд, бүх цэргээ эргүүлж, Монголын сэрүүн талд хэрхэн ирснээ санаж хэвтэв.

Одоо хааны бие нэгэнт доройтон ядарч, хөх манант уулын хөндийд аягатай ус даруй мөс болон хөлддөг Тангадын хүйтэн газар, нас эцэслэх болоод байна. Цаг мөч өнгөрөх тутам тамир барагдаж, харин эмч нар мэхлэх буюу эсхүл түүний биеийг илаарь болж, дахин морин дээр мордуулж, хөндий талын дундуур урт эвэртэй буга буюу

зэрлэг догшин хуланг агнаж чадах болгох эмийн өвсийг олж чаддаггүй буюу... гэж бодож улмаар хулан гэхэд Хулан хатан санаанд оров. Хулан гэнэ ээ. Үзэсгэлэнт, эрх дархан Хулан хатан хаана байна? Тэр одоо байхгүй! Хүнийг мөнх болгодог увдис эм байхгүй гэсэн Хятадын мэргэн өвгөний үг зөв байжээ.

Чингис хаан, хатсан уруулаа арай ядан хөдөлгөж шивнэн:

Би хөх Монголын говь талын олон улсыг хураахдаа ингэж зовсонгүй. Тэр цагт ширэн гөлөм тасарч, ширмэн дөрөө сэтрэх хэцүү бэрхшээлтэй тохиолдож байсан билээ. Гэвч одоогийн миний зовлон нь хязгааргүй байна. Манай өвөгчүүдийн «Чулуунд арьсгүй, хүнд мөнх насгүй» гэж ярьдаг нь үнэн байна... гэв.

Чингис хаан, цочмог нойронд автагдаж, түр зүүрмэглэх бөгөөд, нөгөө хулганын дуу нь улам хүчтэйгээр чарлаж хавиргаар хатгаж, амьсгалыг тасалдуулна. Чингис хаан сэргэж харвал, түүний хөлийн дэргэд хятад Елюй-Чуцай сөгдөн сууж байв.

Мөн Чингис хаан мэт өндөр туранхай энэхүү сэцэн зөвлөх, хааны өвчтэй биеэс нүдээ салгалгүй харж байхад хаан өгүүлрүүн:

— Сайн муу хийсэн үйл юү юу билээ гэвэл, Елюй Чуцай өгүүлрүүн:

— Бухар орноос чиний хэлмэрч, Махмуд Ялвач ирсэн түүний хэлэх нь, тэнд... гэмэгц

Хаан алгаа чичрүүлэн санжсанд хятад дуугай болов. Чингис хааны шивнэн хэлсэн нь: Би асууж байна. Миний энэ насанд хийсэн сайн муу үйлийг асууж байна гэхэд Елюй Чуцай бодол бодно. Ертөнцөөс хагацаж байгаа хүнд юү хэлбэл зохих вэ? гэж бодтол, үзэж өнгөрүүлсэн олон явдал, гэнэт нүдэнд жирэлзэн үзэгдэх мэт болов.

Цус нулимсаар булингартсан мөрөн голуудын урссан Азийн хөх тал, уул үзэгдэн, нурж сүйдсэн хот санаанд нь оров. Утаа болж харласан хэрэм дээр цавчигдсан өтөлсөн өвгөд, өсөж яваа багачуудын хүүр овооролдож, алсад хотыг баллаж байгаа монголчуудын шуугилдаж гасалж байгаа нутгийн ардыг алан хядаж, Засгийн цааз, Чингисийн зарлиг гэж нэг сонссон хүний мартамгүй хашхиралдах нь санаанд оров.

Ялзарсан муухай хүүрийн дунд, амьд үлдсэн цөөн хүн, намаг газар овоохойд хоргодож, өнөө маргаашийг өнгөрүүлэн цаг тутам монголчууд ирээд зовоож, цалмаар гогодон аваачихаас айж суухад тэднийг олж, эвдэрсэн балгаснаас хөөж гаргана.

Бас нэгэн үзэгдэл, нүд гялбам тодоор манасхийн үзэгдэнэ. Самарканд хотын эвдэрхий хэрмийн ойролцоо, туранхай урт хөлөө сарвайлган, нэг бүдүүн тэмээ дээшээ харж хэвтэнэ. Түүний айсан нүдний дотор амьд байгаа шинж үзэгдэнэ. Өлссөөр хатангир хар болсон хэдэн хүн, бие биеэ түлхэлцэн байж, тохой хүртэл цус болсон гараараа тэр тэмээний гэдсийг хага татаж, гэдэс дотрыг хэсэглэн аваад, даруй идэцгээж байсан санагдана. Урт чөмөглөг хөлтэй, хатангир гартай, чимээгүй хөдлөлгүй хэвтэж байгаа энэхүү «Ертөнцийг донслуулагч» нь тэрхүү тэмээтэй адил бөгөөд түүний хагас нээлттэй нүдийг үзэхэд тэмээний бачимдсан нүдний адил үхлийн өмнө тулгарч сандарсан байдал илэрхий үзэгдэнэ.

Бас тэрчлэн Чингисийн дэргэд ширээ залгамжлагчид, их цуст өвөөс хэсгийг олж хүртэхийг хүсэж, бие биеэ түлхэлцэн шахцалдаж байна.

Чингисийн дахин хэлсэн нь:

— Чи сайн муу үйлийг минь санаж олохгүй байна гэж үү? гэвэл, Елюй-Чуцай шивнэн өгүүлрүүн;

— Чи энэ насандаа их бөгөөд чичрэн донслуулагч аймшигт хэрэг олныг хийсэн билээ. Түүнийг үнэнээ р тоочин хэлж чадах хүн нь, гагцхүү чиний довтолгоо, ажил хэрэг, үгийг ном болгон бичих хүмүүс болно гэхэд,

— Миний аян явдал... хэлсэн үгийг... бичиж... чадах... хүнийг дуудуулж бичүүл... гэхэд... Елюй-Чуцай, өгүүлрүүн:

Жа, гүйцэтгэе гэв.

Гэрийн дотор чимээгүй, хааяа задгай галын шатах чимээ сонстон, өрхөөр орсон салхи, хуурай хус модны хөх утааг галын дээр мушгируулан хөөргөж байв. Үүнд; Чингисийн дахин шивнэж асуусан нь:

— Миний хийсэн хэргийн хамгийн... сайн нь... юу вэ? гэвэл,

Нас эцэслэж байгаа хүнийг тайтгаруулахыг хүсэж, Елюй-Чуцай өгүүлрүүн;

— Чиний ажлын дотроос хамгийн сайн нь чиний «засаг» гэдэг хууль. Тэр хуулийг хүндэтгэн дагаж, угсааг залгамжлагчид, бүх ертөнцийг түмэн он захирч байх болно гэжээ.

Чингис хааны өгүүлсэн нь:

— Зөв... чингэхэд... цөл говьд... амар төвшин болж,... хүүр булшны завсраар өтгөн өвс ургаж... гагцхүү монголын... адуу

бэлчээрлэх болно гээд, дахин нэмж хэлсэн нь:...Дур зоригоор явагч... хулан бэлчээрлэх болно гэв.

Хамар нь шовх болж, шанаа нь хонхойтол турсан Чингис хаан, нүдээ аньж, хөдөлгөөнгүй хэвтэнэ. Махмуд Ялвач, Хятадын эмч их бөө нар чимээгүй орж ирээд, Чингис хааны хөлийн дэргэд сөгдөн, хааныг сэргэж үг хэлэхийг хүлээн, дуугай байв. Хаан, нүдээ нээмэгц Махмуд Ялвачийг харж миний... хөвүүн Цагаадай... харьяат... баруун улсаа... хэрхэн жолоодож байна гэж асуувал,

Сайхан үзэсгэлэнт ганган улаан дээл өмсөж, толгойдоо цагаан алчуур зангидсан Махмуд Ялвач хоёр гараа бүдүүн гэдэс дээр солбиж, газар хүртэл бөхийн хэлсэн нь;

— Чиний баатарлаг хөвүүн Цагаадай хаан монгол баатрууд, харьяат улс, бүх ардууд Жейхун, Зеравшан мөрний хөвөөнд чиний эрүүл мэндийн төлөөнөө тэнгэрт мөргөж, олон жил хаан төрийг барин суухыг хүсэцгээж байна гэхэд,

— Хойд зүгийн улсыг захирч байгаа миний их хүү Зөч хаан, харьяат улсаа хэрхэн жолоодож байна? гэхэд

Махмуд Ялвач, нүүрээ гараар таглав. Монголын заншилд, өөрийн ойрхны хүмүүсийн үхсэн тухай ярихад нэгэнт тийнхүү «гэгээн сүүдэр» хүний уг нэрийг хэлэхэд эвгүй тул өөр ёгт үгээр түүний нэрийг сольж хэлдэг байсан. Иймийн тул Махмуд Ялвач хэлэв.

— Таны бошгоор хойд зүгийн улсыг эзлэхээр их довтолгоог бэлтгэж бий гэж ноёддоо зарлав гэхэд, Чингис хаан асуууруун!

— Намайг эсэргүүцэх гэж үү?

Махмуд өгүүлрүүн:

— Үгүй, хаанаас, их эзэн хаан минь, түүний жадын ирт үзүүр нь баруун зүг, Болгар, Хивчаг, Сагсин, Орос улс тийш чиглэсэн.

Гэтэл, уул довтолгоогоо хийж чадсангүй, бүх цэрэг, нутагтаа тархаж одов. Цэлмэг өдөр ниргэсэн аянга мэт, бүгдэд агуу их гашуудал тохиолдов гэхэд, тайлбарлагтун! гэвэл Махмуд өгүүлрүүн:

— Хааны гэр бүлд зориулан талд их авыг хийсэн. Үүнд таван мянган нөхөр, тал газраар хавтгайран самнаж, шагшуургын дотроос, зэрлэг гахай, чоно, хэд хэдэн барсыг хөөн гаргав. Бусад таван мянган морьт хүн нь алсын говиос бөхөн, зээр, хулан, тахийг хөөн авчрав. Үдэш орой, ангийн дараа задгай гал дүрэлзэж, найр, цэнгэл эхлэх ёстой байсан үед, цэргүүд хамгийн аюултай дайнд, харвасан суманд өртөөгүй тэргүүн баатраа хүлээвч, тэр хүн хүрч ирсэнгүй, түүнийг

ихэд эрсээр талд ганцаараа дөнгөж амьд хэвтэхийг олсон бөгөөд түүний биед нэг ч дусал цус байсангүй болой. Гэтэл, нэг ч үг хэлж чадахгүй, учрыг ухах бөгөөд хилэнт нүдээр харж байв гэхэд, Чингис хаан

—Тэр тэгээд үхсэн гэж үү? гэвэл,

— Тийм ээ. Ялалтат алдраа дурсгасан хамгийн сайн бөгөөд хамгийн дотно баатар чинь үхсэн шүү. Ямар нэгэн хорт этгээд, түүний нурууг хугалжээ гэхэд Чингис хааны нүүр барайж, гар, булган хөнжлийг хумхин базаж, шивнэн хэлсэн нь:

— Отчигин яарчээ. Их баатар, цэргийн мэргэжилтэй жанжин нэгэнт үгүй болжээ... Түүнийг орлох хүнгүй! Одоо хэн Хоресмийг захирч байна? гэхэд Махмуд өгүүлрүүн;

— Чиний залуу ач Бат хаан, цэцэн эхийн удирдлагын дор захирч байна. Тэрхүү эх нь бүх нөхдийг дуудан цуглуулж, хүүгийн хамтаар овоон дээр гарч билээ. Бат хаан, эцгийн байлдааны хээр морийг унаж, омог зориг төгөлдрөөр нөхдөдөө хашхиран өгүүлсэн нь: «Дэлхийн дөрвөн тивийг дийлсэн баатрууд сонсогтун! Та нарын сэлэм зэвэрч байна. Түүнийгээ хар билүүгээр хурцлагтун! Ба, та нарыг дагуулж, баруун зүгт их Ижил мөрнийг өнгөртөл явна. Бид аймхай улсуудын нутгаар аянга мэт довтолж, өвөг Чингис хааны төрийг дэлхийн хөвөө хүртэл тэлж өргөтгөнө. Түүнчлэн миний эцгийг алсан хорт этгээдүүдийг би эрж олоод, амьдаар нь тогоон дотор чанаж алахыг тангараглана» гэжээ гэвэл, Чингис хааны царай барайж, гүймтгий нүдээр харж, тохойгоо тулж өндийгөөд ихээхэн амьсгаадаж, арай гэж хэлсэн нь:

— Ялахын цог гялалзан байхад, хэдийгээр хүзүүндээ дөнгөтэй боловч, залуу байхад сайхан байдаг сан даа гэв. (Чингис хаан, залуудаа дайсанд баригдаж, хүзүүндээ дөнгө зүүж, гурван жил боол байсан билээ)

Чингисийн цааш хэлсэн нь: Бат хөвүүний нас балчир тул... осолдож мэднэ. Түүнийг, бас, сөнөөх болзошгүй! Батын дэргэд... миний хамгийн үнэнч... барсын элэгдсэн хумс... хашир болгоомжит Сүбээдэй баатар ямагт зөвлөхөөр байхыг... би тушаана. Сүбээдэй түүнийг... хамгаалж, байлдаанд сургана... Бат... миний ялалтыг... үргэлжлүүлж... бүх ертөнцийн дээгүүр монголын гар...ыг сунгах болно гээд Чингис хаан хажуулдан хэвтэж, зүүн нүдээ аньж, баруун нүдээр

тэр суугч хүнийг хялайж харав. Бүгдээрээ доош харж, удтал дуугай байхад (10 дугаар зууны үеийн уран шүлэгч Хусреванийн үг санагдана)

Ялж дийлсээр ирсэн
Их жанжны дэргэд
Эмч, бөө, бадарч, зурхайч
Энэ дөрвөн хүн байгаад
Эм увдис гүрэм
Элдэв зүйлээр аргалавч,
Эдгэрүүлэх чадалтай тусыг
Хэн ч хүргэж чадсангүй.

Энэ чимээгүй нам гүмийн дунд, асрын дэргэд зогсож байсан морь янцгаав. Үүнд, бүгд цочиж, хаан өөд харвал, түүний баруун нүдний гялалзах цог нь гээгдэн буурч байна.

Чингис, бүдүүн царс модыг ухаж, алтаар доторлож хийсэн авсыг, хэдийнээс бэлтгэн авч явсан болой. Шөнө хөвүүд нь, тэр авсыг нууцаар шар асрын төвд тавив. Байлдааны хөө хуяг өмссөн Чингис хааныг тэрхүү авсанд хийв. Өвчүү дээр нь тавьсан гарт нь, ирлэн хурцалсан сэлмийн бариулыг атгуулжээ.

Ган хуягаар үйлдсэн хар дуулга малгай нь буусан зовхитой зэвхий нүүрийг нь сүүдэрлэнэ.

Авсны хоёр талаар, нум сум, хутга, хэт цахиур, алтан аяга зэргийг хийжээ.

Цэргийн дарга нар, хааны тушаал ёсоор, түүний нас барсныг нууж, Тангадын их хотыг бүслэх явдлыг үргэлжлүүлэв. Тангад нар хотын их хаалгаар хүндэт бэлгээ авч гарч ирээд, найрамдахыг гуйсанд Монголчууд тэдэн дээр довтлон орж, бүгдийг бут цохиод, дараагаар нь хотын дотор цөмрөн орж, эвдэн сүйтгэв.

Чингис хааны авсыг эсгийд боож, хорин шар хөллөсөн, хоёр дугуйтай тэргэнд тавиад, Монголчууд буцах замдаа чиглэв.

Улсын эзнийг нас барсан тухай баатрууд өөрийн үндсэн ордонд очих хүртэл нэг ч хүн мэдэж, урьдаас үл яруулахын тулд, замд бүх дайралдсан хүн, малыг алж, тэнгэрийн оронд очигтун! Тэндээс манай эзэнд хичээнгүйлэн зүтгэгтүн! гэж хэлдэг байжээ.

Ард түмний уй гашуудлын үед мэргэд, хятад, хивчаг, иран, гүрж, алан ба оросуудыг ялсан Чингис хааны алдартай баатар Зэв ноёноос тунхаглан хэлсэн нь:

Нэгэн өдөр «Манай гүрнийг байгуулсан их хүн» Бурхан халдан ууланд ан хийж явсан билээ. Уулын бэлийн хээр газар нэгэн өндөр модны ёроолд амарч байсан билээ. Нас өнгөрсөн тэр хүний сэтгэлд огторгуйн үүлэнд тулсан, өндөр гуалиг хуш мод тэрхүү аглаг газар их тааламжтай санагдаж «энэ газар, өл буга бэлчилтэй, өтөлсөн миний яс тавилтай газар байна. Энэ модыг тэмдэглэн таньж авагтун» гэж түүний хэлж байсныг би сонссон билээ. Чингээд, хааны жанжид, гэрээс зарлигийн ёсоор тэрхүү уул дахь өндөр хуш мод ургасан тэр газрыг эрж олоод, тэнд Чингис хааны хүүрийг хийсэн авсыг булж оршуулсан болой. Түүнээс хойш хүүрийг оршуулсан газрыг эргэн тойрон зузаан ой мод ургаж нэвтрэн явж болохгүй болоод, хориултай тэр газрыг сахигч хууччуул ч булшинд хүрэх замыг зааж чадахгүй болжээ.

ТӨГСГӨЛ

ҮҮГЭЭР МОНГОЛЧУУД ЯВЖ ӨНГӨРСӨН АЖЭЭ

Цас бүрхсэн уул
Намайгаа харав уу, та!

Буруу номтын хатуу гарт
Боол болон хүлэгдэж,

Том ташуурт цохиулсаар
Толгой минь хавдан зовж

Гашуун нулимсыг минь үзэж,
Хайхрах хүн байхгүй

Гаслан, уйлах дуунд
Ганц уул цуурайлна.

(Хивийн боол Вамберийн дуунаас)

Жейхун их мөрнөөс зүүн зүг чиглэсэн өргөн их замаар олон зуун жилийн турш, баялаг их ачаа жин явдаг байсан нь Монголчуудын ганц ниргэлтийн сүүлээр тэр замаар явах амьтны хөл тасарч, зам гудас байсан дэлгүүр, деан хоосорч; байшингийн хаалгыг цэрэг эвдэж түлээд сэтгэл уйдам эвдэрхий балгас болжээ. Хөх ногоон цэцэрлэг нь, шуудуу сувгийг цэвэрлэж, ус татах хүнгүй болсон учраас гандан хатжээ.

Цөөвөр чонын энд тэнд хаясан хүний яс газар сайгүй үзэгдэж байгаа тоост замаар ганцаараа явж байгаа, харь газрын цув нөмөрсөн морьтой залуу хүн, хачин сонин үзэгдэж, хурдан хар араб морь нь туурайгаараа нэгэн тэгш тав тав хийж хатиран, эзэн нь хааяа нэг исгэрч явснаа,

— Хүн ч үзэгдэхгүй, тэмээ ч үзэгдэхгүй, нохой ч үзэгдэхгүй, ямар эзгүй зэлүүд цөл газар билээ гэж санаа алдаж өдрийн турш дөнгөж хоёрхон чоно, хүүр оршуулдаг хязгааргүй их газар шиг энэ чимээгүй талыг эзэн нь шиг яарамгүй зам хөндлөн гарав. Хэрэв цааш дан энэ мэт явбал хэзээ ч эцдэггүй энэ морь бид хоёр, аймшигт монгол сэлмийн ир орсон энэ олон гавал толгойн дэргэд удалгүй хэвтэнэ байх

гэж явтал өмнө нь нэг юм хөдлөх шиг болж, морь нь чихээ сортолзуулан чагнаж, хамраа тачигнуулав.

Тэр юманд ойртож ирвэл, нүд гялбам нарны гэрэл туссан тоост замын дунд хэвтэж байгаа үхдэл дээр хэсэг хөглөгөр том бүргэд овооролджээ. Исгэрэхэд их далавчаа яаралгүй дэлгэж дэвээд ойрын дов дээр суув. Шинэхэн явсан тэрэгний хоёр дугуйн хонхор мөрийн хооронд уранхай туркмен хувцастай нэгэн бүсгүй хүүхэд, шөрмөс нь татсан юм шиг аягүй байдалтай хэвтэж, эвлэг өнгө зүс нь хэвээрээ байсан боловч, бүргэд нэгэнт гэмтээж амжжээ.

Энэ бас л, монголын гар хүрчээ. Хүүхдийг хүртэл барьж, сэтгэл зоволтгүй хорьж хашиж байгаад, бахаа ханаж хаяж орхидог байна шүү гээд... ташууараа далаймагц морь нь харайн давхиж тойруу замаар гарч, морьтой хэсэг монголчууд гүйцэгдэв. Талан дээрэмдсэн эд хогшлыг ачсан чанга дугуйтай хоёр хасаг тэрэг гэлдэрч, ачаан дээр нэхий дээл, эрэгтэй хүний үнэгэн малгай өмссөн монгол бүсгүй сууж, тоос хөдөлгөж явсан үхрийг хашхиран шавдаж, тэрэгний хойноос хоёр гарыг нь ард нь хүлсэн, хагас дутуу хувцастай хатаж турсан олзлогдсон гурван эрэгтэй, нэг эмэгтэй хүн гуйван дайвалзаж явав. Хойноос нь хэлээ унжуулан аахилсан хөглөгөр том нохой шогшиж, долоо орчим настай, чихний дээр хоёр сэвлэг үстэй, монгол хүү, удаан явж байгаа үнээг хурдлан хөөж яваа үхэрчин шиг тэр олзлогдсон хүнийг бургасаар дэс дараалан шавхуурдаж

— Урагшаа-урагшаа-муу тэнэгүүд! гэж хашхирч, тэр хүүхэд том хүнээс тайлж авсан хөвөнтэй тэрлэгийг бүслүүрээсээ дээш хөөргөн бүсэлж өмсөөд, хөлдөө холхиндог том гутал өмсөж, сугарч ойчихгүй гэж өвдөгний доогуур сураар уяжээ.

Тэр хүүхэд чухал хэрэг бүтээж байгаа шинжтэй аашилж тэрэгнээс уясан аргамжиндаа татагдсаны хүчээр урагшаа дөнгөж хөдөлж байгаа эмэгтэйг нэн сүрхий ширүүлэн хөөж тэр эмэгтэйн шар тэрлэгийн хагархайгаар хүрэн улаан гүргэр хавдартай яслаг нуруу нь харагдан тэр эмэгтэйн хашхирсан нь:

— Намайг тавиад өгөөч! Миний охин Хавьч үлдэж хоцров. Түүнийг би өөрөө аваад ирье! гэхэд,

— Чамд бас ямар охин хэрэгтэй юм бэ? өөрөө олсоор чангаагдан ядаж явж бас өөр нэгэн адасга авчирна гэж гайхуулна гэнэ ээ! гэж хялман цагаан морь унаж явсан хөгшин монгол, тоос манан дотроос гарч ирээд, тэр эмэгтэйг ташууараар жанчив.

Тэр эмэгтэй урагшаа огло харайж хөсөр унав. Уяастай олс нь түүнийг татаж газар чирэв.

Тэргэн дээр сууж явсан монгол бүсгүй хашхирсан нь,

— Хөгшин нохой чи юундаа улайраад байсан юм бэ? Доголон хонь байсан ч, ядаж мах, арьс нь хэрэг болно гэж би өвөр дээрээ авах асан. Энэ муу малаас бидэнд ямар ашиг орох юм бэ? Охин нь аль эрт үхсэн, одоо өөрөө ойчоод байна. Бид төрсөн нутаг Хэрлэн гол хүртэл бас хэчнээн явж хүрнэ! Үүнийг хая, хая! гэхэд

— Амь бөхтэй юм аа, үхэхгүй! гэж уурласандаа муухай дугарч, энэ сэг ч гэсэн, энэ гурван залуу ч гэсэн манай гэр хүрч чадна. Манай айлын бусад нөхөд гэртээ хориод боол тууж явахад бид дөрөвхөн хүнийг авч явж чадахгүй байна! Муу малууд аа! Бушуухан! Урагшаа! Урагшаа! гэв.

Тэргэнд чирэгдэж яваа бүсгүйг нэгэн монгол хүний ташуураар жанчсанд олс нь тасарч, тэр шивэгчин зам дээр хаягдан хоцров. Тэрэг цаашаа өнгөрөөд өнөөх хөгшин, хялман цагаан мориныхоо амыг татан зогсоож, хэлээ шогширч гүйцэж ирсэн сайх морьтой хүнд өгүүлрүүн:

— Үхэх болов уу, амьдрах болов уу? Чи түүнийг надаас худалдаж авахгүй юү? Хямд өгнө. Ердөө л хоёрхон алтан динараас өгнө! гэхэд тэр морьтой хүн энэ чинь үхэж байгаа хүн байна. Хоёр гуулин зоосоор авъя! гэвэл,

— За аль, үнэхээр үхэж харлана байх. Тэгвэл, ямар ч үнэ хүрэхгүй гээд тэр хүнээс хоёр гуулин зоос авч гутлынхаа түрийнд хийгээд, тэргээ гүйцэхээр давхин одов.

Морьтой хүн замаас хажуу тийшээ эргэж, гандсан тал дундуур гэдрэг харалгүй давхив.

Өмнө нь эвдэрхий цагаан балгас, гайхалтай соньхон хэмхэрхий хуучин хэрэм нэг хэдэн сүр жавхлант гулдан хаалга[45] үзэгдэв. Дээр нь олон өнгийн араб үсэг үлдсэн байв. Тэр гуа сайхан барилгыг барьсан урчууд ихээхэн чадал ухаан гаргаж, хавтгай дөрвөлжин том том тоосгоор тэр гоё сайхан орд, гайхамшигт сонин хурал, сургуулийн байшин, өндөр сүм дуганыг барьсан, нэр үл мэдэгдэх ажилчид бүр ч их хөдөлмөр гаргасан байжээ.

Энэ бүгдийг монголчууд, үнсэн товрог болгожээ.

— Нэг ч боодол болов хатсан өвс, хэдэн ширхэг боорцог байгаасай. Чингэвэл, бид дахин нэг өдөр яваад, хөх ууланд хүрч хүнтэй ч уулзана, тулгатай галын дэргэд эвтэй ярих завшаан ч олдоно доо! гэж

шивнэн, тэр эвдэрхий балгасанд ойрттол, цул гулдангийн бөмбөгөр доорх том хүнд хаалга нээлттэй үзэгдэж, хаалганы модыг таваг мэт хавтгай тавтай юм хадаасаар хадаж төмөрлөсөн хаалга байжээ.

— Таньдаг хаалга байна! Урьд үүгээр бадарчин лам Хажи Рахим, тариачин Курбан Кичик, Туган хөвүүн гурав явж байсан билээ. Одоо Туган хүү миний бие, чадамгай цэрэг эр болсон боловч урьд төдий олон хүнтэй, төдий бадарч байсан тансаг ариун Бухар хотноо оронгүй аянчин шиг буух газар, идэх хоол олдохгүй нь ээ гэж явтал нь харанхуй хаалганы хөндийд морины нь туурай чимээтэй сонстож, өмнүүр нь улаан үнэг годхийж, овоотой хог дээр гарч далд оров. Туганы морь чимээ аниргүй эзгүй хотын эвдэрхий дундуур болгоомжтойгоор алхалж, хотын гол талбайд хүрвэл, урьд шуугьсан олны хуралддаг тэр газар сүр жавхлант орон байшин байдаг сан, одоо тэр талбайг хог буртаг дүүрч, төвд адууны хэлхмэл яс цайран хэвтжээ.

Оюу номин тэнгэрт жигүүрээ хөдлөлгүй дэлгэсэн элээ шувуу алгуурхнаа халин, сүмийн чулуун шатны дэргэд хүрэхэд Туганы морь зогсож; чихээ сэртэлзүүлэн тургиж гэдрэг ухрав. Морины өмнө чулуун тавцан дээр лалын шашны Коран гэдэг их судар задгай хэвтэж; борооны усанд норж үрчийсэн хуудас нь салхинд хийсэн хөдөлж байв.

«Энэ чулуун шатаар сүмд Монголчуудын хүйтэн царайлсан эзэн шар сахалт Чингис хаан хул азаргаараа орж Бухар хотын өвгөдөд тушааж хавтгай нүүрт цэргээ амаар нь гартал идүүлсэн билээ. Тэр үед талбайн дунд түүдэг гал дүрэлзэн бүхэл бүхэл хонины мах шарж байсан галын ор нь чулуун дээр одоо хүртэл үзэгдэж байна гэж бодоод Туган мориноосоо бууж цуваа дэлгээд хатсан талх үйрүүлэн морио амгайчилж цулбуурын үзүүрээс бариад шатан дээр суулаа.

Чингэтэл овоотой чулууны цаанаас нэгэн юм хөдөлсөөр эвдэрхий тоосгоны цаанаас тамир барагдсан нэгэн эхнэр өндийн гарч бошинзын тамтгаар биеийг ороосоор Туганд ойртож гараа сарвайгаад гялбалзах ховдог нүдээ талхны хальснаас зайлуулж чадахгүй ширтэв.

Туганыг хатсан талх нэгэн атгыг өгсөнд тэр эхнэр эрдэнэ олж авсан юм шиг тосож аваад ухасхийн сөгдөж талхыг омголтсон уруулдаа хүргэтэл гэнэт гараа доош буулгаж чимх чимхээр хавтгай чулуун дээр хувь тэгш хуваан тавьж гарав.

Талхны үйрмэгийг гар дээрээс аятайхан долоож аваад дуудруун:

Хүүхэд минь ээ. Нааш ир. Битгий ай. Энэ хүн манайхны сайн хүн байна аа гэхэд нь хавтгай чулууны завсар дахь хар нүхнээс нэг хойноос

нь гурван хүүхдийн сагсайсан үстэй толгой үзэгдэв.

Эвдэрхий барилгын завсраар дамжин бие биедээ зууралдсаар ойртсоныг үзвэл наранд түлэгдсэн нүцгэн туранхай бие нь хэлхмэл яс мэт гагцхүү гэдэс нь цүрдийжээ. Бас харанхуй нүхнээс хоёр хүүхэд гарсан боловч босож чадсангүй мөлхөж ирээд гараар цордгор гэдсээ тэврээд суув. Сайх эхнэр урьдчилан талх тийш сарвалзсан хүүхдийн гарыг алгадаад хүүхдийн аманд бяцхан хэсгээр ээлжлэн хийж өгөв.

Тэр эхнэрийн өгүүлсэн нь:

Хонины арьсан дээлтэй тэр аймшигтай хэрцгий хүмүүс цөмрөн ороод, баахан морьдоороо газар бүхэнд давхиж, үзсэн ажигласан бүгдийг дээрэмдэн авав. Биднийг хамгаалах гэсэн миний эрийг алсан, миний хүүхдийг барьж аваачсан, амьд эсэхийг мэдэхгүй, намайг бугуйлдан өнхрүүлж, олны инээдэм болгон шивэгчин болгож байсан билээ. Нэг шөнө завшаан болж оргон гараад энэ эвдэрхий балгасанд хүрч ирээд, орон байшингаа олсонгүй, зөвхөн овгор хог байна. Өдрийн цагт гүрвэл гүйлдэн, шөнө болоход цөөвөр ульж гэтдэг байна. Би хотын орчмоос Монголчуудын хаясан эдгээр хүүхдийг олж аваад, хамтаар идэш эрж, зэрлэг сонгино малтаж амь залгадаг. Одоо эд миний хүүхэд болжээ. Бид хамт үхэх буюу, амьдрах ч магадгүй... гэхэд нь,

Туган, үлдсэн талхаа тэр эхнэрт өгөөд, морио хөтөлж хотоос гаран одов. Туган улам цааш Самарканд тийш одов. Зам зуур жин хөсөг тохиолдсонгүй. Талын дунд энд тэнд хааяа нутгийн хүмүүс үзэгдэв. Морьтой Монголчуудын хатиран явах нь үзэгдмэгц, ажил хийж байсан нутгийн хүмүүс унаж суваг тийш мөлхцөгөөн, давхин өнгөрсөн Монголчуудын морины тоос бяцхан үүл мэт дэгдэж гүвээ давснаас хойш, сая өндийж дахин газар малтаж эхэлдэг байв.

ШУУГИАН ИХТ САМАРКАНД ХОТ АЛЬ ВЭ?

Хэд хоноод Туган, цөл газрын өндөрлөг овгор булшны газар хүрч зогсов. Түүний өмнө голын хөндий ногоорон харагдахын дунд саяхан хүртэл алдартай агсан Самарканд хотын эвдэрхий үлдэгдэл бархайж үзэгдэв. Хавтгай дээвэртэй бяцхан байшин нэг нь нөгөөгийн орчимд наалдсан боловч урьд хэдэн түмэн чадамгай ажилчны хөдөлмөрлөж байсан Маверанагрын хуучин нийслэл байсан тэр газар амьтан хүн

үзэгдэхгүй болжээ. Бороонд угаагдаж эвдэрсэн хэрэм хотын дунд хэсгээр гарсан байна.

Тэнд сүүлчийн Хоресм Шаг Мухамедын байгуулсан өндөр сүмийн отго болсон хэсэг хоёр дугараг өндөрлөг байшин үлджээ. Нэгэн доголон гуйлгачин хүн, Туганд ойртож эцэнхий гараа гарган алдарт сайн эр минь ядуу муудаа хайрла. Тулалдааны цагт чамайг тэнгэр хамгаалан сахиж, дайсны сумыг чиний эрэлхэг зүрхнээс зайлуулах болтугай гэв.

— Хот аль вэ? Хаан Султаны гэрэлт сайхан нийслэл хаана вэ? Ихэмсэг худалдаачин, эрээн зах дэлгүүр, дархнуудын алхны баясалт чимээ алин бэ? гэж Туганы өгүүлж, гуйлгачинтай ярихаас илүүгээр өөрөө өөртэйгөө шүүмжлэн хэлэлцэв.

Тэр бүгд алга болж, монголчуудын хөлд үрэгдсэн биш үү. Тэд ямар нэгэн юм үлдээдэг бил үү? Хот хаана оров? гэж чи асууна. Хүн амын нэгэн хэсгийг энэрэлгүй Монголчуудын морин цэрэг цавчин алжээ. Нөгөө хэсгийг алс тал нутагтаа хөөн явуулжээ. Бусад оршин суугчид Байцат ууланд дутаан гарсан нь олноор үхсэн гэж гуйлгачин өгүүлжээ.

— Дүрвэгчид удтал тэнэх болов уу? гэж Туган асуувал, гуйланч өгүүлрүүн:

— Хотоос цааш ба голын эхээр бага зэрэг хүмүүс ойртож, шавар ба хуурай мөчир зэргээр овоохой барьж байна. Гэвч тэд ямагт айн сүрдэж байдаг. Монголчууд өдөр бүр эргэн эрж чаддаг бөгөөд булаан авах ба хэнийг хүсвэл бугуйлдан аваачна.

Чамайг Аллах бурхан тэнгэр чиний өглөгчийн төлөө хамгаалан сахих болтугай! гэв. Туган асууруун: Хотын төвд үзэгдэх өндөрлөг байшин юу вэ? гуйланч өгүүлрүүн:

— Энэ байшингаас холуур морио эргүүлэн яв. Тэр бол шорон болой. Монголын хаад энэ сөнөсөн хотод шорон байгуулжээ. Түүний дэргэд Монголын яргачид суух бөгөөд тэд шийтгэгдэгчдийн толгойг төмөр шийдмээр бяц цохиж байдаг.

Үүнийг хэрхэн гүйцэтгэдэг болохыг би чамд хэлж өгье гэтэл, Туган хүлээж сонсолгүйгээр ташлан уруу доошлов. Туган, сөнөсөн хотын эвдэрхий хэмхэрхийнүүдийн завсраар өнгөрч, чимээ аниргүй, бурангуй дүрст хуучин хоёр өндөрлөгийн үзэгдэх хэрэм боомтод хүрэлцэн ирэв. Хэрмийг дагаж хоригдогсдын уй гашуудалт төрөл төрөгсөд газар дээгүүр суун байна.

Хаалганы дэргэд, жад бүхий харуул зогсон байгаа ба шон дээр уяатай эмээлт морьд үүрэглэн байх үзэгдэнэ.

— Чи хаашаа очно? Цаашаа бол гэж харуул хашхирав.

— Шоронгийн харгалзагчтай учрах хэрэг надад бий гэж Туган өгүүлэв.

— Чи шоронг санав уу?

— Энэ өндөрлөгийн дотор миний ах байж магад гэж Туганы өгүүлэхэд,

— Манай энэ шоронд дээрэмчин цөөнгүй, гэвч уддаггүй юм даа. Талбар дээр гангын өмнө аваачаад зулайгаар төмөр муна мөргүүлдэг юм. Ганга дотор эрэх хэрэгтэй. Чингэвэл ахынхаа биеийг олж магадгүй. Чиний ах хэн гэж нэртэй вэ? гэв.

— Түүний бие Дервиш бөгөөд ном бичдэг болой. Хажи Рахим багдад гэнэ.

— Урт үстэй мунхаг Дервиш үү? Тэр одоо хүртэл амьд уу? Бид түүнийг галзуу гэж нэрлэдэг, удаанаар хоригдсон болой.

— «Үхтэл нь мөнх хорих гэсэн үү».

— Би чамтай хэтэрхий чалчжээ. Морио уяад хашаан дотор орсугай. Шоронгийн даргаас асуу? Түүний гэр тэнд бий. Үүдний дэргэд дэгээнд өлгөөстэй хумх байх бөгөөд түүнд зургаагаас цөөнгүй дирхем хийхийг битгий март. Чингэвэл, дарга чиний үгийг сонсох болно.

— Туган, морио уяад хаалгаар дотогш оров. Шоронгийн дарга, байшингийн шат дээр зогсон байх бөгөөд ногоон шаахай ба хөвөнтэй улаан дээл өмсжээ.

Туранхай бараг нүцгэн шахам тогооч, хөлдөө төмөр гинж хангинуулан, модон дэвш дотор кевебед хонины мах хэрчиж байв. Даргын буурал сахлын үзүүр ба хумс алаг нь улаан кеннегээр будсан ажгуу. Хулсан таягаар тогоочийн дал мөрөөр цохиод ийн захиран өгүүлрүүн.

— Чинжүү нэм. Бүү залхуур. Анарын шүүс дусаа.

Туган үүдний дэргэд өлгөөстэй хумх үзээд түүнээ арван зэс дирхем хийв. Дарга хүйтэн муухай нүдээр Туганыг ширтэн харав.

— Би Сүбээдэй баатрын багийн лал цэрэг, түүний зөвшөөрлөөр төрөл төрөгсдөө эрж явнам. Миний пайз энэ гэж шувуу бичиг сийлбэрлэсэн модон хавтгай пайз оосорлон зүүснээ үзүүлэв.

Дарга пайзыг эргүүлэн үзээд эргүүлж Туганд өгөв.

— Энэхүү заяа муутны оронд хэн чамайг илгээсэн бил ээ.

— Би өөрийн төрөл болох Дервиш Хажи Рахим Али Багдадыг эрж явна. Тийм хүн байхгүй юү?

— Аллах тэнгэрт буруушаагдсан түүнтэй чи бид хоёрын танилцсан гэмээс хамгаалан сахитугай.

— Түүнийг юуны учир хорьсон бэ? Би түүнийг үнэнч хүн гэж санана.

— Сайн үнэнч хүн. Гэтэл, түүний бие тэргүүн хэргэмт имам хувилгаан Шейхи Ули-исламын шаардлагаар хамгаас өндөр Аллах бурхны алдрыг ярианда хэзээ ч дурдаагүй, хэрцгий эрх дураар хийгээд Тэнгэрийн номыг тоомсорлодоггүйн учраас хоригджээ. Түүний төгсгөл нь үхэл болно. Түүний орших орон гал болох бөгөөд тэр зүгт түүнээ зам нээлттэй гэв.

Туган бодож өгүүлрүүн:

— Түүний ял хүнд боловч, түүний хувь заяаг ямар нэгэн аргаар хөнгөтгөх замыг чи надад зааж болох болов уу?

— Үргүй юманд оролдох хэрэггүй, түүний амийг гагцхүү манай орны хүчин төгөлдөр эзэн хаан Цагаадайн дэргэдэх их түшмэл Махмуд Ялвачийн шаардлагаар хамгаалан байна.

Тэр Дервишийг ертөнцийг донсолгогч Чингис хааны аян дайн, аж явдлыг ном болгож бичихээс урьд эндээс гаргахгүй.

— Хажи Рахим, зохиолоо бичиж төгсгөвөл түүнийг тавих уу?

— Юуг хүснэм.

Хэрэв тэр өөрийн үйлдсэн нүглээ гэмшивч, зөвхөн олны өмнө талбар дээр авчирч түүнийг хэл гарыг огтлохын тул шоронгоос гаргах болно. Ийм учраас тэр «галзуу» хоёр жил турш ном зохиож үхлийнхээ цагийг холдуулахын тул дахин 30 жил бичих болно.

Туган өгүүлрүүн:

— Хажи Рахим бол миний нигүүлсгэгч багш бөгөөд намайг арабаар уншиж бичихийг сургаж, миний өлсгөлөнгөөс үхэж байхад тэжээсэн учир, би ачийг хариулах гэж өөрийн ганцхан алтан динарыг өргөхөд хайрлахгүй гэж алтан зоос харуулж, чи их дарга тул үхлийн үүднээ байгаа зол муутад энэрэл хайрыг үзүүлэн намайг тэр Хажи Рахимтай уулзуулан соёрх гэв.

— Алтан динараа надад өгөөд дараах хашаанаа орсугай. Чи тэнд өөрийн «галзуу»-тай тавтай уулзтугай гэхэд Туган, алтан зоосоо

шорongийн даргын улаан хеннегээр будсан алган дээр тавиад чулуун хаалгаар дотогш оров.

ТӨМӨР ТОРЫН ДОТОР

Нарийн хашааны гүн дэх хананд төмөр сараалж бүхий нүх харанхуйлан үзэгдэнэ. Тэнд овоо новш дотор ямар нэгэн бараан юм сүүдгэнэнэ.

Торын орчимд нарийхан хөөрөг хэрэм тийш шахаж үзэгдэх нь лули гэдэг хэрмэл омгийн эхнэр хүн мэт газар хүрэм урт хар нөмрөгт ороогджээ. Туганыг болгоомжтойгоор ойртоход тэр эхнэр толгойгоо эргүүлэх нь таньсан хүний шинжтэй бөгөөд мөнхүү түүний хархан нүд, алтлаг тунгалаг царай илт боловч урьдын адил уужим санаа уйдгүй болсон нь илэрхий. Хурднаа ширтэн хармагц нүдээ буруулав. Энэ нь сэжиглэлтгүй, Бент Занкижа байжээ.

Туганыг ойртон очиж, торын дотор үзвэл доторх хоригдогсод нуруугаа бөхийгөөд арайхан сууж,

Харанхуйгаас сэгсгэр дэл мэт орооцолдсон хар үс, ёнхойж гялбалзсан хурц нүд үзэгдэв. Эцэж турсны харгаагаар айх мэт үзэгдэлтэй болж, царай хувилсан авч, Хажи Рахим мөнийг таньжээ. Тэр Дервиш торын сараалжинд мөлхсөөр ирээд үсэрхэг нүүрээ шахаж сөөнгө хоолойгоор өгүүлсэн нь:

Миний дүү чи зохих цаг дээр иржээ. Туган аа. Ойртон ирээд, миний сүүлчийн хүсэлтийг сонсоно уу. Хар муу санаат имамууд намайг торын дотор илжлэх буюу эсхүл олныг айлгахын тулд миний чихийг огтлон, биеийг хэсэглэн цавчихыг хүсэж байна. Гэвч, тэд чөлөөт оюуныг сөнөөж, миний дүрэлзэх хорслыг унтраан чадна гэж үү? Одоо би тэдний юү хүссэнийг цөмийг бичсэн боловч, тэд уншмагц намайг ба миний тэмдэглэлийг түүдэгт хаяж шатаана. Би, тэдний адил улаан сахалт Чингисийг магтсангүй. Хоресмийн Татар дарлагчид, эхнэр хүүхдийн алуурчдыг магтсан магтаал дууг зохиосонгүй. Харин өөрийн нүдээр юү үзсэнээ үнэнээр бичлээ. Ер миний бие юү чадахаа бүрнээ хийсэн. Одоо миний хагацах сүүлчийн өдөр болжээ.

Намайг Салар голын хөвөөнд хөгшин чанар модны дор оршуулагтун. Миний багш Абу-Али-Ибен-Сина гэгч их цэцэн билигтэн хүн, хар муу санаат мохдог оюунтай имамуудын харгаагаар шоронд, ялзарсан сүрэл дээр нас нөгчсөн бил ээ. Түүний бие ертөнцийн нууц

бүхнийг мэдэх байсан боловч, гагцхүү үхлээс хэрхэн амь аврах аргыг үл мэджээ гэхэд нь Туган намдуунаар өгүүлрүүн:

Тэр нэгэн цагт цөл дотор, та бид хоёулаа олсоор хүлэгдээд айх мэт сүрхий «хар морьт» Хар Хончирын илд бидний дээр далайсан үед намайг сургаснаа чи санана уу. «Битгий гуньхар. Шөнө урт байна. Өдий байна» гэж тэр цагт чи хэлсэн биш бил үү. Чингэвэл, одоо би чамд түүний нэгэн адил «битгий гуньхар. Шөнө дуусах байтугай, эхлээгүй» гэж хэлье.

Хажи Рахим, чадал нь дахин эргэж ирсэн мэт түргэнээ өндийв. Туган үнэмшүүлэхийг хичээж, аяархнаар үргэлжлэн өгүүлрүүн;

— Ах аа! Намайг сонс. Миний хэлснийг ёсчлон гүйцэтгэ. Би чамд гурван хар үрэл өгье. Чи түүнийг залги. Чингэснээс хойш үхсэн мэт хөдлөхгүй ба өвдөхийг мэдрэхгүй болоод ийн зүүдлэх нь: Чиний бие, олон уулыг даван нисэж, ширүүн урсгалт ус, ариун үнэрт цэцгүүд бүхий хөндийд хүрнэ. Тэнд цасан цагаан морьд бэлчээрлэж, алтан шувууд уянгат хоолойгоор эгшиглэн байна. Чи тэнд арван зургаан насандаа дурласан хүүхэнтэйгээ учирч зүүдэлнэ гэв.

— Би сэрэхдээ төмөр саваануудыг дахин хэвээр мэрж байх бус уу? Надад тийм зүүд хэрэггүй гэж Дервиш өгүүлэв.

— Байз. Цааш юу болохыг сонс. Чиний гунилыг мартан цэнгэх тэр газар зүүдэнд чинь уулын хөндий бүрэлзэн өнгөрөхийн зуур, чамайг үхсэн тул чиний биеийг газарт өгвөл зохино гэж би шоронгийнхонтой ярилцана. Чингэхэд шоронгийн харгалзагчид тороо нээгээд чиний биеийг дэгээгээр дэгээдэн, цаазлагдагсдын нүхэнд өнхрүүлнэ. Эл бүгдийг тэсвэрлэж хэчнээн өвдөвч бүү уйл. Бүү хашхир. Хэрэв үүнийг зөрчвөл төмөр шийдмээр толгойг чинь хагалах болно. Нүхэн дотор хүүрүүдийн хамт хэвтэх цагт шөнө дүлийн дунд цөөвөр чононууд чиний хөлийг мэрэхээр мөлхөх тэр үед би гурван цэргийн хамтаар хүлээж байна. Чингээд, бид нар чамайг цув дотроо ороогоод хотоос цааш хүнгүй газар түргэнээр аваачна. Тэнд ухаан чинь эгж биедээ ороход би чамайг моринд нууулж өгөх бөгөөд чи дахин шинэ аж амьдралыг эхлэх газар зүүнээ буюу баруунаа одно.

— Тийм. Чи зөв хэлжээ. Шөнө өнгөрөх өдий байна. Би цагаан морины хөндийд одоход бэлэн бий. Эмт үрлээ хурдан өгнө үү гэж Хажи Рахим гараа сунгах нь бүргэдийн савар мэт хар бөгөөд хатуу байв.

Туган өнгөт хүүдий дотроос гурван хар үрлийг гаргаж Хажи Рахимд өгмөгц аваад ямар ч эргэлзээгүй залгиснаас хойш нэгэн юм шивнэн хэлж эхэлсэн нь; Цөмөөр хүнд ойлгогдохгүй аяархан байсан бөгөөд удалгүй найгалзаж хажуулдан ойчив.

Жад бүхий сахиул торд ойртон ирээд,

— Заяа муутны дэргэд удсан байж болохгүй гэж миний дарга тушаав гэв.

— Хоригдогч этгээд нэгэнт үхсэн тул чиний нарийн чанга даргын хайр хишгийг хэрэгсэхгүй болжээ гэж Туган өгүүлэхэд сахиул, итгэхгүй байдалтайгаар жадаа торд оруулж хэвтэн байгаа Дервишийг хатгаж үзээд,

— Уйлах гиншихгүй тул үнэхээр үхжээ. Одоо мунхаг «галзуу»-гийн биеийг нүхэнд хаях болно. Хэрэв та үүний хүүрийг оршуулахыг хүсвэл, өнөө шөнө олж авахын төлөө яаравчлах хэрэгтэй. Өглөө бол, нохой цөөвөр энэ амаржигчийн хүүрийг идэж дуусах тул та түүний ясыг ч цуглуулж үл чадна. Өгөөмөр элбэгийн тул баярыг хүргэе. Бид бүхний алинд ч хэзээ нэгэн цагт үхэх цаг ирнэ гэжээ.

НОМЫН СҮҮЛЧИЙН ХУУДАС

«Зоригтой тэвчээртэй хүн эхэлсэн хэргийнхээ төгсгөлийг үзнэ».
(Хажи Рахим)

Туган Бент Занкижа хоёр, эвдэрч хэмхэрсэн хотын чимээ аниргүй гудамжаар зэрэгцэн явж, Туган морио хөтөлжээ. Туурайн чимээ эзгүй байшингийн туурганд цуурайтаж, дүнгэнэн сонстож явав. Энэ хоёр хүн цуугиан ихт Гурганжид усны үерт амь алдсан Мирза Юсуфийн гэрт сууж байсан залуу насны аль хэдийн өнгөрсөн цагийг санан дурдаж, Туган өгүүлрүүн:

— Тэр өнгөрсөн хэдэн жил тэнэж явахдаа Бент-Занкижа чамайгаа санадаг байлаа гэхэд нь Занкижа өгүүлрүүн;

— Чиний өмнө чинь бага насны хань дахин үзэгдэх нь энэ аж. Миний бие, бас бүх манай газрыг донсолгогч аянгын дууг сонсон цахилгааны гилбэлгээг үзэж явав. Гэвч хүчирхэг царс ба чанар модны унах аймшигт шуурганд заримдаа өчүүхэн хулгана гэмтлийг олохгүй үлдэх байдаг. Түүнчлэн би амь гарав гэхэд нь Туган өгүүлрүүн;

— Айх мэт эл жилүүдэд чамтай юу тохиолдсоныг хэлж өг.

Занкижа өгүүлрүүн:

— Надтай юу тохиолдсоныг сонс. Монголчууд намайг Бухар хотод барин аваад, өөрсдийн хэрцгий эзэнд Хоресм сөнөсний гаслант дууг хүчээр дуулуулсанд тэдний эзэн намайг сайшааж, хятад дуучны хамтаар аян замд дуулуулахаар тушаасан билээ. Би хүнийг устгагч тэдний явсан газар бүхэнд явалцав. Нэгд: Чингис хааны нүд өвдөж; нэг сарын оронд хоёр сар үзэгдэх буюу нэг зээрийн оронд гурван зээр; талын дундуур жирэвхийн өнгөрөх мэт үзэгдэх болсонд Чингис хаан, муу заяаны сахиус шоглож байна гэж санав. Монгол бөө, Чингис хааны өмнө бөөлж, мөргөл үйлдэвч, муу заяаны сахиусыг үлдэн хөөж чадсангүй. Эмч, гар хүрч, сүртэй нүдийг нь харахаас айжээ. Гэтэл Чингис хааны цэргийн хүрээнд орсон нүдний эмч хөгшин араб Зин Заван «ертөнцийг донсолгогч»-ийг эмчлэн эдгэрүүлэхийг зориглож; удалгүй үнэхээр эдгэрүүлсэнд хэрцгий эзний сэтгэл баясаж, ямар шагнал авах хүсэлтэй вэ гэж асуув. Хөгшин эмч эрдэнийг хүссэнгүй.

Зөвхөн хуруугаараа дуучны дотроос намайг заасан билээ. Чингис хаан, намайг эмчид өгүүлэхээр тушаав. Хөгшин эмч намайг эмэгтэйчүүдийн өрөөнд хаасанд би идэр залуугийн буржгар хар үс, хацар дээрх мэнгийг дуулж бил ээ. Эмч сонсоод, намайг угалз хээтэй бүсээр зодоод; би инээхийг мартсан цэргийг дагуулаад, хөгшин эмч намайг бас сураар зодож билээ. Чингэхэд, би зугтаж, бидэнд гологдон доромжлогддог тэнэмэл аймаг, гал тахидаг лулийн эхнэрийн аяны асарт хоргодоод, тэдэнтэй адил хар бүтээлэг нөмөрч явахад минь намайг тэд дайсанд барьж өгсөнгүй. Нүдний эмч хөгшин Зин Заван гаслан шаналж, аймшигт Чингис хаанд мэдүүлж цэргээр намайг бариулж өгөхийг гуйжээ. Хаан, түүнийг сонсоод, учиргүй хилэгнэж, дэргэд байсан улс алгаар нүүрээ дарж, айн эмээн хөсөр унацгаагаад, Чингис хаан чи миний бэлгийг ямар аймшиггүй алдав? Эхнэрээ захиран байж яагаад эс чадав. Эхнэрээ захирч чаддаггүй эр миний харьяат газар амьд байж болохгүй. Үүнийг цааш нь харуул гэхэд тэр муу хөгшин эмчийг зандалчин барьж, дор нь цэцэн буурал толгойг нь тас цавчжээ. «Их аймшигтаар нас эцэс болжээ». Тэр цагаас хойш би Лули аймагт амьдран суух болов. Хажи Рахимыг тор дотор суугааг мэдээд түүнд талх, үзэм, самар аваачиж бичихэд нь тусалдаг боллоо гэхэд нь Туган асуув.

— Чи өөрөө хөл гишгэх газаргүй мөртөө түүнд тусалсан гэж үү? гэхэд нь Занкижа хэлэв.

— Гурав хоног бүрд шоронд очиж, хоол өгч байсан, талхны хамтаар Хажи-Рахимд хэдэн хуудас цэвэр цаас өгдөг байсан. Гурав хоног дотор бичсэн дуртгалаа надад нууж өгөхөд нь, би асартаа авчирч хуулж аваад Хажи Рахимд эх нооргийг буцааж гурав хоноод дахин очиж, Монголчуудыг Хоресмд халдан довтолсныг өгүүлсэн тэр зохиолын үргэлжлэлийг авдаг байсан билээ. Чингээд, Хажи Рахимын тор дотор бичсэн нэг хувийг би сийрүүлэн бичиж байлаа. Намайг бичиж сургасан ачтай Мирза Юсуфийн буян даа тэр гэвэл Туган асуууруун:

— Чи их хэрэг бүтээжээ. Хорт имамууд, Хажи Рахимын тэмдэглэлийг шатаавал, нэг хувь нь бидэнд үлдэх болно. Манай хойч ач үр Чингис хааны хорт харгис явдлыг Хажи Рахимын зохиолоос унших болно гэж ярилцсаар түргэн урсгалт булингар уст мөрний хөвөөнд хүрэв.

Лули аймгийн тортог болсон банаг майханд хүрээд хөгшин чанар модны ёроолд тасархай хивсэн дээр Бент-Занкижа баглаатай судар тавьжээ. Эвдэрхий балгас болсон Самарканд хотын дээгүүр мандсан гэрэлт сар, орох оронгүй тэнэмэлийн зохиол жигдхэн бичсэн тэр судрын шар хуудсыг гэрэлтүүлж, Бент-Занкижа хивс дээр суугаад хуудсыг сөхөж хэлсэн нь:

Хажи Рахим гал ер түлдэггүй хүйтэн торонд суусаар туйлдаа хүртэл ядарсан боловч, халуун чин сэтгэл зоригийнхоо хүчнээр ер мохож гонсойсонгүй. Арайхийж бичиж байсныг үзэв үү. Энэ хэдэн мөрийн үсэг нь гар салгалж бичсэн шинжтэй байна.

Хажи Рахимын сүүлчийн хуудсанд бичсэн үгийг сонс гэж араб эвхмэл үсгээр бичсэн судрын хуудсыг авч уншсан нь:

«Миний элэгдсэн үзэг, манай эх орны цэцэрлэг сайхан хөндийд энэрэлгүй Монголчуудын довтлон уулгалж явсан зохиолын сүүлчийн мөрийг бичив. Энэ номыг зохиогч, хичээнгүйн хумхын тоосыг хүртсэн би, номхон шударга аймгийг сөнөөгч харгис алуурчин, догшин хэрцгий Чингис хаантай тэмцэх тэмцэлд амь биеэ хайрлалгүй оролцохыг зүрхлээгүй, Хоресмийн аймтгай хүмүүсийн тухай хэлэх үг олон билээ.

Хэрэв Хоресмийнхон бүгдээр уур хилэнгийн илдийг нэгдсэн саналаар зоригтой далайж, амь бие хайргүйгээр, эх орны дайсантай догшин ширүүнээр тэмцсэн бол дээрэнгүй монгол, түүний шар сахалт

эзэн, Хоресмд хагас жил ч тогтож байж чадахгүй. Алс талдаа үүрд тонилон далд орох сон.

Монголчууд өөрсдийн муруй сэлмийн хүчнээс илүүгээр дайсны аймтгай ухрамтгай, эвгүйг ашиглаж ялжээ. Зоригт Желал-Эд-Дин, зүрх ихтэй морин цэргийн өчүүхэн багийн хүчээр Монголын дээрэмчнийг бут цохиж болохыг үзүүлжээ.

... Гэвч, миний бээрч байгаа хуруу, үзэг тогтоон барьж чадахгүй болов. Тэнүүл Дервишийн чадал тамир суларч, өдөр маш хурдан өнгөрч, хариуг авах өдөр ойртоно...

Нэгэн яруу найрагчийн шүлгээс хэдхэн мөрийг дөнгөж арай чарай гэж бичье.

Хаврын бороо мэт,
Намрын салхи мэт,
Залуу нас өнгөрөв.
Энэ ертөнцөд удтал,
Эрхэм аян жингийн дарга
Ачаагаа ачиж гүйцээд,
Аялан хөдлөхийг шаардав.

Миний бичсэн номыг унших үл таних та бүхэнд хагацах ёс хийж, захих үг минь, бардам сэтгэлт имам оморхгоос болж, дээлдээ багтахгүй болсон улемүүд намайг шашингүй гэдэг байжээ. Тэдний ойр бодол нь хортой мохоо байна. Миний мэт шашингүй болох нь тийм хөнгөн хялбар, хоосон хэрэг бус. Хүлээстэй сэтгэлгээтэн, мохоо болхи зандалчныг ялна. Дарлагдсан хөдөлмөрчин, хэрцгий хүчирхэн дарлагчийг ялна. Үнэн нь худлыг ялна гэдэг миний чин бат итгэлээс цогтой бат итгэл байхгүй дэг ээ. Үнэн ёс мандаж, хүнийг эрхэмлэн, эрх чөлөөтэй болох ёс нь манай эх орныг нийтийн жаргалтай гэгээн байдалд хүргэх эрхэм сайн цаг ирнэ гэдгийг би мэднэ. Тэр цаг ирнэ. Тэр ёсоор болно»

гэжээ.

Бент-Занкижа, гурван мөнгөн бэлзэгтэй нарийн хүрэн хуруугаа уруулдаа хүргэж баахан бодлого болоод, нум мэт хөмсгөө атируулан, тэр түүх судрын хуудсыг аятайхан засаж хураан, эрээн бөсөөр баринтаглаад, гялалзсан хар нүдээр Туганы зүг харж, шивнэн,

Одоо би Лули аймгийн гурван зоригтон залууг дуудья. Та нар цаазаар аваачсан хүнийг хаядаг нүхэнд очоод Хажи Рахимыг гаргаж үз. Шөнө урт болоод, өнгөрөх болоогүй шүү. Бид түүнийг аварч үзье гэжээ

гэсэн үүнийг Ц. Дамдинсүрэн, Д. Дашдорж, Дүгэрсүрэн, Лувсанвандан, Нацагдорж, Пэрэнлээ, Ринчен, Хорлоо, Цэвээний орчуулсныг 1944 оны VI сарын 10-наас 20 хүртэл Ц. Дамдинсүрэнтэй хуваан авч яаравчлан засаад, дараа нь 1949 оны VII сарын 5-наас VIII сарын 31 хүртэл дахин цөмийг нь уг орос эхтэй нь тулгаж, бүгд түмээд үг засаж, чадан ядан найруулсан билээ. Тэгээд, 1950 оны V сард бичээчийн дахин цохисон хувийг үсгийн мадаг ташааг хянан үзэж, гурав дахь удаагаа үзлээ би.

Ринчен.

ЗАРИМ ҮГИЙН ТАЙЛБАР

Дашинга гэж байшингийн туурга зэрэгт хөндлөн тогтоож юм тавих банз. Нэг дан ч байж болно. Хэдэн давхраар ч байж болно. Оросоор полка гэдэг даруй манай дашинга мөн. Номын санд ном тавих, дэлгүүрт бараа дэлгэн тавих нь цөм номын буюу барааны дашинга мөн.

(бусад үгийг зохих байранд нь тайлбар болгон оруулсан болно. ЦБ)

Уг номыг “Болор дуран” шалгууруар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу орно уу.



Өглөгийн эзний сонорт

Та манай номын санд хандив өргөж болно.

Таны хандивласан мөнгө:

- Хэвлэгдсэн номыг цахим хэлбэрт оруулах
- Цахимд оруулсан номыг ариутган шүүх
- Цахим технологийн тоног төхөөрөмж авах
- Цахим номын санг өргөжүүлэх
- Цахим номын сангийн чиглэлээр судалгаа хийж, сурч байгаа оюутан судлаачийг дэмжихэд зарцуулагдана.

Хандив өргөх данс "Хаан банк" 5027 8982 35 (төгрөг) ЦОГТ ОХИН ТЭНГЭР САН

Qpay

1950 оны хэвлэлийн Хэвлэн нийтлэлийн мэдээлэл

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН

В. ЯН

ЧИНГИС ХААН

СҮХБААТАРЫН НЭРЭМЖИТ УЛСЫН ХЭВЛЭХ ҮЙЛДВЭР
УЛААНБААТАР
1950

ДАМДИНСҮРЭН, ДАШДОРЖ, ДҮГЭРСҮРЭН, ЛУВСАНВАНДАН, НАЦАГДОРЖ, ПЭРЭНЛЭЭ, РИНЧИН, СОДНОМ, ХОРЛОО, ЦЭВЭЭНИИ орчуулсныг редакторласан И. РИНЧИН

Техник Редактор Ц. Содов
Хянагч Б. Хаянхярваа, Б. Лувсан

1950 оны 7 дугаар сард өрөлтөд оруулж, 8 дугаар сард 10000 ширхэг хэвлэв.

Хэмжээ, 1, 11 хэвлэлийн хуудас
2015
А 03926
За. № 674

Сүхбаатарын нэрэмжит Улсын Хэвлэх үйлдвэр,
Улаанбаатар хот. Их сургуулийн гудамж 28

Заметки

[←1]

Хоресм гэж Аму-Дарьяа голын адагт байсан эртний улс. Тэр үе, Арал тэнгэсээс Персийн булан хүртэл газар дэвсгэрийг эзэлж байсан билээ.

[←2]

(Монголын өмнөх үеэс дорно дахины зохиолчид, иймэрхүү өгүүллийг уншигчдад зориулан бичдэг журамтай байжээ).

[←3]

хар юлд гэсэн нэр

[←4]

Чалма гэж, лал нарын нэгэн зүйл малгай. Урт нарийн даавуугаар малгай буюу толгойгоо ороон, малгай мэт болгодгийг чалма гэдэг бөгөөд манайхан, тийнхүү толгойгоо ороосон лал (хуйхуй) нарыг бас Хятадаар Чантуу гэдэг байжээ.

[←5]

Хоресм шаг гэж хоресм газрын эзэн хаан. Монголд шатрын шаг гэдэг маань уулаас иран хэлээр хаан гэсэн үг

[←6]

Хуантайз гэж хаан ширээ залгамжлах хан хөвүүний цол. Оросоор принц гэдэг нь даруй Хуантайз гэдэгтэй утга нэгтэй үг. Гагцхүү, монгол хэлэнд Хятадаас, орос хэлэнд латин хэлнээс оржээ.

[←7]

Хивчаг гэж нүүдэл Турк аймгийн нэр. Днепр мөрнөөс зүүн тийш (Дундад Азид) Долоон ус гэдэг газар хүртэл нутагтай байжээ. Монгол түүх сударт Хивчагийн нэр их гардаг бөгөөд Хивчаг омгийн хүн одоо ч Дундад Азид бий.

[←8]

Хажи гэж Арабын Мека балгасанд мөргөл хийгээд ирсэн хүнийг лал нарын хүндэтгэн нэрлэх үг.

[←9]

Имам гэж лалын шашны хийдийн тэргүүлэгч лам.

[←10]

Булигаар гэж Ижил мөрөнд Кама голын нийлэх цутгалангийн тушаа байсан Ижил мөрний Булигаар улсын худалдаа үйлдвэрийн их хотын нэр байжээ. Манайхны булигаар гутал гэх зэргээр нэгэн зүйлийн боловсруулсан ширийг булигаар гэдэг нь, тэр эртний Булигаар улс хот хоёрын нэр даруй мөн бөгөөд одоогийн Болгар улс гэдэг нэр нь мөн тэр Булигаар улсын нэртэй гарал сурвалж нэгтэй.

[←11]

Дирхем гэж Арабын мөнгөн зоос, бас зэс зоос байжээ. Мөнгөн дирхем нь манай хорин мөнгөний орчим, зэс дирхем, манай хоёр мөнгөний хэртэй ханш бүхий зоос байсан билээ.

[←12]

Есдүгээр зууны үеийн кесийн шүлгээс хэлжээ.

[←13]

Абу-Али-Ибн-Сина гэгч, 11 дүгээр зууны нэрт эрдэмтэн бөгөөд Бухарт төржээ. Түүнийг шашинд сүсэггүй, мөн эрдэм ухааныг хориггүй чөлөөтэй дэлгэрүүлэх гэлээ гэж гянданд хорьсон учир нас баржээ.

[←14]

13 дугаар зууны үе Ибрахим монтесерийн шүлгээс эш татаж хэлжээ.

[←15]

Амудария, Серьдария хоёр мөрний хооронд дахь газар бөгөөд, тэр үед Туркстан гэдэг нэрийг хэрэглэхгүй байжээ.

[←16]

11 Дүгээр зууны үеийн Персийн яруу найрагч Абу-Сайд

[←17]

Мусульман шашны их лам.

[←18]

Македоны Александр.

[←19]

Алид Шафиид гэж лалын шашинтны дотор сүннит шафиид гэж хоёр шашин гарсан билээ. Бие биеийг харилцан буруушаан үздэг ажээ. Иранд шафиад буюу шиитийн шашин голлон дэлгэрч, Анатолийн Туркэд нөгөө сүннит шашин дэлгэрсэн байжээ.

[←20]

Динар гэж Арабын алтан зоос. Европт 20 дугаар зууны үед Сербчүүд динар гэдэг зоостой байжээ.

[←21]

Ангаахай самар (ЦБ)

[←22]

Аллах тэнгэр гэж лалын шашинтны тахидаг тэнгэрийн нэр. Угтаа араб үг, тэнгэр гэжээ.

[←23]

(Зохиогч хүн, Юань улсын үеийн монголчуудын малгай, чамархайн тус эвхээстэй хоёр бүч чимэгтэй байсныг зурагт үзээд, гэзэг гэж ташаарсныг тэмдэглэлтэй. Монгол орчуулгыг редакторласан Ринчин тэмдэглэв).

[←24]

Ал улаан гэж хурц сайхан улаан өнгийн нэр. Хасаг, Хиргис, Татар зэрэг Турк хэлтэн бүхний хэлэнд ал гэж мөнхүү хурц улааны нэр бөгөөд орос хэлэнд ал, алый гэж сайхан улааныг энхрийлэн нэрлэх үг болжээ.

[←25]

Тавнан гэж хаан, ноён хүний хүргэнийг нэрлэдэг үг. Хожим манжаар бас эфу гэдэг болсон байна.

[←26]

Вивангирид гэж ирээдүйд ийм тийм болно гэж бошиглон хэлэхийн нэр. Уг гарал нь санскрит үг. Согд Уйгураар уламжлан монгол хэлэнд оржээ.

[←27]

Их цэргийн хоёр үзүүр нийлэн довтолж, дайсныг хумин авахыг от довтлох гэж монголоор нэрлэдэг байжээ. Редакторын тайлбар

[←28]

Монголын алтан пайзны хэмжээ өргөн нь дөрвөн хуруу, урт нь тохой шахам байжээ. Орчуулгын редактор

[←29]

банаг майхан, хар өнгөтэй баймаар юм санжээ. Орчуулгыг засагчийн тэмдэглэл

[←30]

Агул хөвүүн гэж ноён язгуурт хөвүүнийг эрт дээр цагт нэрлэдэг байжээ. Турк хэлтний углвн, оглан гэдэгтэй гарал сурвалж нэгтэй бөгөөд Орос, Герман, Австрид энэ үг сунжирч, нэгэн зүйл морин цэргийн нэр болсон билээ. Оросоор түүнийг улан гэдэг байжээ.

[←31]

Эблис гэж, лалын шашны Коран гэдэг номд харын зүгийн нэг шулмыг нэрлэдэг байжээ.

[←32]

Зохиогч, Чингисийн зураг дахь малгайн сүлжмэл хоёр бүчийг гэзэг гэж ташаарчээ. Тэр үед Монголчууд гэзэггүй байжээ

[←33]

Фарсах гэж уртын хэмжээ. 12 фарсах нь 84 километрийн орчин газар байжээ.

[←34]

цагаан будаагаар нэрсэн архи

[←35]

Түүрэг гэж их хотын тэг дотор багтсан захын бага хот буюу хотын зах хэсгийг нэрлэдэг нэр. Жишээлбэл, Амгаланбаатар хот, даруй манай Улаанбаатарын түүрэг ажээ.

[←36]

Ина гэгч нэгэн зүйл арааатны нэр. Дуу нь хүний инээх адил.

[←37]

«Монголчууд, мөрний даланг эвдэн задалмагц, ус урсаж, бүх хотыг эвдэв. Барилга нуран, түүний орыг ус эзэлжээ.»

(Ибн Ал-Насир, 13 дугаар зуун)

[←38]

Ибн—Хазмын сургаалаас (11 дүгээр зуун)

[←39]

Улем гэж лалын шашны номын багш.

[←40]

Гурван улаан сум нь, их хааны төрлийн тэмдэг.

[←41]

1237 онд, Бат хаан буюу Оросын он дараалсан судраар «Баты» бол Сүбээдэй баатрын хамтаар гурван зуун мянган цэргийг толгойлон, Оросын газар цөмрөн орж, Оросыг Татар Монголын захиргаанд оруулжээ.

[←42]

Чингис хаан, тэр үед Бухар, Самаркандыг эзлээд, Энэтхэгийг довтлохоор завджээ.

[←43]

Монгол цэргийн удирдагчид чухал мэдээ явуулах хэрэг болоход мэдээг дуу мэт зохиож, элч хүнд цээжлүүлдэг байжээ.

[←44]

Несеф бол одоо Бухар хотын өмнө зүгт бий Бех-будн гэдэг хот.

[←45]

Гулдан хаалга гэж нэгэн зүйл хаалганы нэр. Хэрэмд дээд этгээд дугуй, шовх буюу гурвалжин хэлбэртэй үүд хаалга гаргасныг гулдан гэдэг. Тэрчлэн гүүрний гулдан гэж, гүүрний хоёр баганын хоорондох хэсгийг нэрлэдэг. Ёслолын гулдан хаалга гэж аливаа дурсгалт ялалт зэргийн явдалд зориулан чимэглэж, хээ угалз, баримал дүрс, баярын үсэг зэргээр чимсэн хаалга босгосныг нэрлэдэг байна. Гулданг оросоор арка гэдэг нь латин үг. Угтаа нум гэжээ. Дээд этгээдийг нумын хэлбэртэй анх адилшаан тийнхүү нэр өгсөн байжээ.